



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ
ХҮРЭЭЛЭН

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙ, ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙД ХОЛБОГДОХ СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЭМХЭТГЭЛ

Х БОТЬ

(2021 онд хийж гүйцэтгэсэн судалгаа)

Улаанбаатар хот
2022 он

ДАА 345
ННА 67.408
Э-807

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН АЛСЫН ХАРАА

Олон улсын жишигт нийцсэн эрдэм, шинжилгээ,
сургалт мэдээллийн үндэсний хүрээлэн болон хөгжинө.

© Хууль зүйн үндэсний хүрээлэн

Хянан тохиолдуулсан : Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.Jur.) Х.Эрдэм-Ундрах

Эмхэтгэсэн: Хууль зүйн судалгааны төв

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Эх бэлтгэгч, дизайнер Б.Заяа
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.
Хэвлэсэн хугацаа: 2022 он.

ISBN 978-9919-9964-3-7

ӨМНӨХ ҮГ



Эрхэм хүндэт уншигч та бүхний түмэн амгаланг айлтган мэндчилье.

Хууль зүйн үндэсний хүрээлэн 2021 онд гүйцэтгэсэн төлөвлөгөөт судалгаануудаа “Хувийн эрх зүйд холбогдох судалгаа (Судалгааны тайлангийн эмхэтгэл IX боть)”, “Эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын эрх зүйд холбогдох судалгаа (Судалгааны тайлангийн эмхэтгэл X боть)”, “Нийтийн эрх зүйд холбогдох судалгаа (Судалгааны

тайлангийн эмхэтгэл XI боть)”, “Зөрчлийн эрх зүйд холбогдох судалгаа (Судалгааны тайлангийн эмхэтгэл XII боть)” хэмээх дөрвөн ботиор уншигч олноо толиулж байна.


Хууль тогтоомжийн тухай хуулийн 49.3-т “Засгийн газраас хийх хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээг холбогдох төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.” хэмээн заасанчлан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 1/195 тоот албан үүргийн дагуу Хууль зүйн үндэсний хүрээлэн нь Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт тус тус хяналт, шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж байна.

2021 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө батлагдсан бөгөөд тус төлөвлөгөөнд эрх зүйн салбарт хийгдэж буй суурь судалгааны үр дүнг нэгтгэн жил бүр хэвлүүлэх зорилтыг дэвшүүлсэн билээ. Энэ хүрээнд эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын эрх зүйд холбогдох судалгааг багтаасан энэхүү судалгааны тайлангийн X ботийг эмхэтгэлээ.

Уг эмхэтгэлд манай улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоо дахь шинэ зохицуулалт болох хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухайд практикт болоод эрх зүйн зохицуулалтад тулгамдаж буй асуудлыг судалсан. Түүнчлэн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тодорхой төрлийн гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг үнэлэн дүгнэсэн ба тус ботид мал хулгайлах гэмт хэргийг онцлон тус гэмт хэргийн нөхцөл байдлыг статистик мэдээлэл, кэйс анализ, социологийн зэрэг судалгааны олон төрлийн аргуудыг хослуулан өргөн хүрээнд судалсан болно. Мөн үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мөрдөх албыг байгуулах хэрэгцээ, шаардлага бий эсэхийг тандан судалж тус албыг байгуулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон. Тус хүрээлэн нь жил бүр тодорхой нэг салбарын нэр томьёоны талаарх судалгааг

гүйцэтгэдэг уламжлалын дагуу Эрүүгийн хууль дахь бусад шинжлэх ухааны нэр томъёог судалж цаашид боловсронгуй болгох, зөрчилдөөнгүйгээр тодорхойлох саналыг дэвшүүллээ.

Энэхүү ботид эмхэтгэгдсэн судалгаа нь Монгол Улсын эрүүгийн эрх зүйн салбарт тулгамдаж буй цөөнгүй асуудлыг шинжлэх ухааны үүднээс шийдвэрлэгдэхэд зохих ёсоор хувь нэмэр оруулна гэдэгт бид бүхэн гүнээ итгэж байна.

ЗАХИРАЛ  Х.ЭРДЭМ-УНДРАХ

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	I
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	IV
НЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ХҮЛЭЭЛГЭХ ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА	1
ХОЁР. ХОХИРЛЫН САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТАНДАН СУДАЛГАА	49
ГУРАВ. ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ БУСАД ШИНЖЛЭХ УХААНЫ НЭР ТОМЪЁОНЫ СУДАЛГАА	85
ДӨРӨВ. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 17.12 ДУГААР ЗҮЙЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ /МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГ/	145
ТАВ. МӨРДӨХ АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ ТАНДАН СУДАЛГАА	227

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АИХ	Ардын Их Хурал
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АМХГ	Аймгийн мэргэжлийн хяналтын газар
БНИУ	Бүгд Найрамдах Итали Улс
БНПУ	Бүгд Найрамдах Перу Улс
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНТУ	Бүгд Найрамдах Турк Улс
БНПУ	Бүгд Найрамдах Польш Улс
БНКУ	Бүгд Найрамдах Казакстан Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНФУ	Бүгд Найрамдах Франц Улс
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОГУУХ	Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналт
ГБХТтХ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
ГҮТББ	Гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага
ДтХ	Дампуурлын тухай хууль
ЕАБХАБ	Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллага
ЕХ	Европын холбоо
ЗГ	Засгийн газар
ЗД	Засаг дарга
ЗХШХШтХ	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ЗХДЗШШ	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх
ЗЕХ	Захиргааны ерөнхий хууль
ЗХАШШ	Захиргааны хэргийн анхан шатны шүүх
ЗХШ	Захиргааны хэргийн шүүх
ЗШША	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа
ЗШШтХ	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
ИХШХШтХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ИХАШШ	Иргэний хэргийн анхан шатны шүүх
ИХ	Иргэний хууль
ИБУИНВУ	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс
ИБУТЭТОУП	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
КтХ	Компанийн тухай хууль
МСӨХДЗ	Монголын сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөл
МУ	Монгол улс
МУЕтХ	Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль
МУИХтХ	Монгол Улсын Их Хурлын тухай хууль

МҮХАҮТ	Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
МХБ	Мэргэжлийн хяналтын байгууллага
МХБ	Монголын хөрөнгийн бирж
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
НМХГ	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар
ННФ	Нээлттэй нийгэм форум
НДЗХАШШ	Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх
НШГА	Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба
НЭЗЭ	Нийтийн эрх зүйн этгээд
ОХУ	Оросын Холбооны Улс
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СӨХ	Сууц өмчлөгчдийн холбоо
СӨХЭЗБНЗОСБДӨЭХтХ	Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль
СнЗ	Сайд нарын зөвлөл
ТАТХ	Төрийн албаны тухай хууль
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨтХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТЗ	Төрийн захиргаа
ТТ	Төрийн тусгай
ТХШтХ	Төрийн хяналт шалгалтын тухай хууль
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УДШ	Улсын дээд шүүх
УИХ	Улсын Их хурал
УТХтХ	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль
УТХ	Улсын тэмдэгтийн хураамж
УША	Урьдчилан шийдвэрлэх ажиллагаа
ҮЦБ	Үнэт цаасны байгууллага
ҮЦЗЗтХ	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
ХАБҮЛЛ	Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХХША	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
ХМХА	Хилийн мэргэжлийн хяналтын алба
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
ХШЗ	Хянан шалгагчдын зөвлөл
ХШ	Хянан шалгагч
ХЭУБ	Хуулийн этгээдийн улсын бүртгэл

ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний комисс
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШШГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл
ШШГТХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
ЭХ	Эрүүгийн хууль
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ЭХХША	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ЭХШ	Эрүүгийн хэргийн шүүх
ЭХАШШ	Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
ЭИХХЦХ	Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналт
PC	Private company
LLC	Limited liability company
SARL	Société à Responsabilité Limitée
SRL	Società a responsabilità limitata
GmbH	Gesellschaft Mit Beschränkter Haftung
LS	Limited Sirket

НЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ НЬ

Судалгааг удирдсан:

ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн
хүрээлэнгийн Гэмт явдал, цагдаа судлалын
хүрээлэнгийн захирал, доктор (Sc.D),
профессор Ж.Болдбаатар

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.Jur.) Х.Эрдэм-Ундрах

Судалгааны багийн бусад гишүүд:

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M)
Г.Халиунаа

ДХИС-ийн Эрдэм шинжилгээний ажилтан,
доктор (Ph.D), профессор Т.Оюунчимэг

ДХИС-ийн эрдэм шинжилгээний ажилтан,
цагдаагийн хурандаа Н.Амарзаяа,

ДХИС-ийн докторант, цагдаагийн ахмад
Н.Сайнбаяр

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний ажилтан З.Мөнгөлжин

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний ажилтан Г.Сувд-Эрдэнэ

УДИРТГАЛ

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4-т “Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хуульт ёсыг бэхжүүлнэ” хэмээн заагаад 4.4.7-д “Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно” гэж мөн Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 77-д Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2021 онд боловсруулахаар тус тус тусгасан.

Эдгээр баримт бичигт үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайдаас тус хүрээлэнд 2021 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 1/195 дугаартай албан бичиг ирүүлж Эрүүгийн хуулийн хэрэгжилтэд улирал бүр тогтмол дүн шинжилгээ хийж байх чиглэл өгсний дагуу Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тус хуулийн хэрэгжилтийн судалгааг улирал бүр тогтмол гүйцэтгэж байхаар тусгасан билээ.

Энэхүү ажлын хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэн Дотоод хэргийн их сургуультай хамтран судалгаа гүйцэтгэж байхаар албан ёсоор харилцан тохиролцож, 2021 оны I улиралд Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх” зохицуулалтын хүрээнд дүн шинжилгээ хийхээр зорьсон юм.

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд хийгдсэн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг зохицуулахаар тусгасны дүнд нэг талаар аливаа хийдэл, зөрчлийг арилгах, нөгөөтэйгүүр хууль нь хүн, хуулийн этгээд бүрд тэгш шударгаар үйлчлэх, эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчимд нийцүүлсэн эрх зүйн шинэ орчин бүрдсэн.

Хэдийгээр хуулийн үзэл баримтлал, зүйл, хэсэгт тухайлбал, Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж заасан нь ахиц дэвшил авчирсан ч хуулийн этгээдийн нэрийн өмнөөс хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтээс зарим талаар сөргөөр нөлөөлөх магадлалтай байна. Өөрөөр хэлбэл, хууль хэрэгжиж эхлээд 3 жил гаруй хугацаа буюу 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш 2020 оныг дуусталх хугацаанд шүүхээр шийдвэрлэгдсэн энэ төрлийн 10 гэмт хэрэг¹, прокурорын байгууллагад бүртгэгдсэн² 26 гэмт хэрэг, үүнээс ажиллагаа хийгдэж байгаа 7 гэмт хэрэг байгаа нь харьцангуй бага үзүүлэлт юм.

1 Шүүхийн шийдвэрийн цахим сан.

2 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хэсэгчлэн хийсэн дүн шинжилгээний хүрээнд прокурорын байгууллагаас ирүүлсэн тоон мэдээлэл.

Иймд бид дээр дурдсан, шүүхээр шийдвэрлэгдсэн 10 гэмт хэргийн шийдвэр болон прокурорын байгууллага яллагдагчаар татсан 26 хэргийн хүрээнд дүн шинжилгээ хийхээр зорилоо.³

Дүн шинжилгээний, Эрүүгийн хуульд холбогдох хэсгийг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны баг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд холбогдох хэсгийг Дотоод хэргийн их сургуулийн судалгааны баг тус тус хариуцан гүйцэтгэсэн.

Энэхүү дүн шинжилгээ нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацааны хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх зорилготой учир онолын болоод түүхэн уламжлалын талаар дэлгэрэнгүй авч үзээгүйгээс гадна хуулийн этгээдэд зөрчлийн шийтгэл оногдуулж буй асуудлыг хөндөөгүй болно.

НЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН ОЙЛГОЛТ, ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Эрүүгийн хууль 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр шинэчлэгдэн батлагдаж, хуулийг дагаж мөрдөх хугацаа 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхэлсэн. Хууль хэрэгжиж эхэлснээс хойш 3 жил гаруй хугацаа өнгөрсөн бөгөөд хуулийг хэрэгжүүлж буй субъектүүд хуулийг хэрэглэх дадал суусаар байна.

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд ял оногдуулах бодлогыг тусгайлан зохицуулсан, гэмт хэрэгт оногдуулах хорих ялын бодлогыг уян хатан болгосон, хорихоос өөр төрлийн ялыг шинээр нэмж оруулсан, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг хуульчилсан гэх мэт дэвшилттэй зохицуулалтыг нэлээд тусгасан. Эдгээр зохицуулалтаас энэхүү судалгааны ажлын хүрээнд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг тухайлан авч үзэн, практикт хэрхэн хэрэгжиж байгаа талаар статистик мэдээлэл болон шүүхийн шийдвэрт үндэслэн дүн шинжилгээ хийхээр зорилоо.

2015 оны Эрүүгийн хуулийн үзэл баримтлалд “Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан үнэт зүйлс болох хууль ёсны ашиг сонирхлыг гэмт халдлагаас бодитой хамгаалахын тулд хувь хүнээс гадна хуулийн этгээдийг гэмт хэрэг, зөрчлийн субъектэд тооцож, хариуцлага хүлээлгэх талаар зохицуулалтыг оруулснаар олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүргээ биелүүлэх боломж бүрдэнэ” гэж тусгасан.⁴ Хуулийн этгээд, түүнд хүлээлгэх хариуцлагыг нэр томьёоны хувьд авч үзвэл, академич С.Нарангэрэл “хуулийн этгээд” гэж “(лат. Universitas personarum; англ. legal (juridical) person; legal entity; ор. юридическое лицо) иргэний эрх зүйн субъект, өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын

3 Судалгаанд Эрүүгийн хуулийн холбогдох зохицуулалтын хэрэгжилт ямар байгааг үнэлэх зорилгоор хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэн шийдвэрлэсэн шүүхийн практикт дүн шинжилгээ хийхдээ 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2020 оныг дуусталх хугацаанд эрүүгийн хэргийн шүүхээр шийдвэрлэсэн 10 шүүхийн шийдвэрийг ашиглав.

4 Шинэ Эрүүгийн хуулийн үзэл баримтлал /анхны/, http://criminalman.blogspot.com/2018/08/blog-post_30.html

нэгдэл”⁵ гэж тайлбарласан бол, доктор Д.Баярсайхан “хуулийн этгээд” гэх нэр томьёо нь латин хэлэнд “UNIVERSITATES” буюу хамтран байгуулах, хамтран бий болгох, цогц бүрдэл гэх утгыг илэрхийлдэг гээд, “Хуулийн этгээд гэх ойлголтыг танин мэдэх уг сурвалж нь Ромын эрх зүйгээс үүдэлтэй бөгөөд үүнийг иргэний эрх зүйн институт болгон авч үзэх хандлага уламжлагдаж ирсэн нь чухамдаа Ромын сонгодог эрх зүйн зарчим, үнэт зүйлстэй холбоотой юм” гэж өөрийн бүтээлдээ тэмдэглэжээ.⁶

Монгол Улсын Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт “Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ”⁷ гэж хуульчилснаас гадна хуулийн этгээд нь ашгийн төлөө болон ашгийн төлөө бус байж болно, мөн нийтийн, хувийн, холимог өмчийн байна гэж тодорхойлсон.

Дээрх тодорхойлолтуудаас үзвэл, “хуулийн этгээд” гэх ойлголт нь өөрийн өмчлөл, эзэмшилдээ хөрөнгөтэй, түүнийгээ захиран зарцуулах эрхтэй, өөрийн нэрийн өмнөөс эрх олж авч, хариуцлага хүлээдэг хүмүүсийн нэгдлийг ойлгож болохоор байна. Тэгвэл “хууль зүйн хариуцлага” гэх ойлголтын тухайд:

“Хууль зүйн хариуцлага гэж (англ. Legal responsibility; ор. юридическая ответственность) эрх зүйн хэм хэмжээнд заасан таагүй, сөрөг үр дагавар буй болгосон эрх зүйн субъектын үүрэг нийгмийн хариуцлагын төрөл” гэж академич С.Нарангэрэл тайлбарласан бол шинжлэх ухааны доктор О.Амархүү хууль зүйн хариуцлага гэдэг бол “бодит утгаараа аль нэгэн эрх зүйн эсрэг үйлдэл хийсэн этгээдэд хэрэглэж болдог, түүний хувийн эд хөрөнгийн бүтэц, зохион байгуулалтын шинж чанарт нь халдах байдлаар илэрдэг эрх зүйн санкцын хэм хэмжээг тогтоосон төрийн албадлагын арга хэмжээний нийлбэр, харин субъектив утгаараа эрх зүйн эсрэг үйлдэл хийсэн этгээдэд хэрэглэсэн төрийн албадлагын арга хэмжээг уг этгээд хүлээн авах, сахин биелүүлэх үүрэг мөн”⁸ гэж тодорхойлжээ.

Түүнчлэн хууль зүйн доктор Ч.Нямсүрэн “нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, эрх зүйн зөрчилтэй тэмцэх үндсэн арга хэрэгслийн нэг бол хууль зүйн хариуцлага юм” гээд тэрээр хууль зүйн хариуцлага гэж “гэмт халдлагаас иргэд байгууллагын аюулгүй байдлыг хамгаалах, гэмт халдлагад өртөгдсөн этгээдийн зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээж хохирлыг арилгах, эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн этгээдэд ял, зэмлэл хэрэглэх төрийн албадлагын арга хэмжээ юм”⁹ гэж тодорхойлсон.

Харин хууль зүйн доктор Д.Баярсайхан өөрийн бүтээлдээ нийгэмд хариуцлагын олон төрөл байдаг, үүнээс хууль зүйн хариуцлага онцгой байр суурьтай гээд хууль зүйн хариуцлагыг “...хууль буюу эрх зүйн хэм хэмжээг зөрчсөний төлөө гэм буруутай этгээдэд эрхийг нь хязгаарлах буюу цээрлэл үзүүлэх замаар ёс зүйн болоод эрх зүйн нөлөөлөл үзүүлж буй төрийн болон төрийн бус албадлагын арга хэрэгсэл, тэдгээрийн уялдан холбогдсон систем мөн”¹⁰ гэж тэмдэглэжээ.

5 С.Нарангэрэл, Монголын эрх зүйн англи, орос, латин хадмал эх толь бичиг, 4 дэх хэвлэл, 2015, 530 дахь тал.

6 Дам ишлэв: Д.Баярсайхан, Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага, 2013, 7 дахь тал.

7 Иргэний хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002, №7.

8 О.Амархүү, Эрх зүйн онолын арван таван сэдэв. 2008, 46 дахь тал.

9 Ч.Нямсүрэн, Эрх зүйн ерөнхий онол, 2017, 357 дахь тал.

10 Д.Баярсайхан, Эрх зүйн онол, 2010 он, 183 дахь тал.

Дээрх эрдэмтэн судлаачдын тайлбараас харахад хууль зүйн хариуцлага нь хариуцлагын төрөл дотроо нэлээд онцгой үүрэг гүйцэтгэдэг бөгөөд хууль буюу эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн аливаа этгээдэд оногдуулах цээрлэлийн арга хэмжээ гэж нийтлэг байдлаар ойлгож болохоор байна.

Хууль зүйн хариуцлагын төрлийг эрдэмтэн судлаачид эрх зүйн салбарын харьяаллаар нь иргэний, эрүүгийн, захиргааны, сахилгын гэх мэт төрөлд хувааж үздэг. Хууль зүйн хариуцлагыг өмнө зөвхөн иргэнд хүлээлгэх талаар ойлголт байсан бол дэлхий нийтээр хуулийн этгээдэд ч мөн эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь зүйтэй гэсэн хандлага төлөвшиж байгаа талаар судлаач Г.Гантөмөр, Б.Одонгэрэл нар судалгааны бүтээлдээ дурдсан байдаг. Эдгээр судлаачид хууль зүйн хариуцлагыг хувь хүн, хуулийн этгээдийн аль алинд нь хүлээлгэх нь зүйтэй гэж үзэж байна. Учир нь хуулийн этгээд нь эрх зүйн харилцаанд оролцогч, эрх үүрэг эдэлж, хариуцлага хүлээх чадвартай субъект юм.¹¹

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлын түүхэн уламжлалын талаар эрдэмтэн судлаачид¹² өөрсдийн бүтээлдээ дэлгэрэнгүй дурдсан байдаг бөгөөд зарим эрдэмтэн судлаач хуулийн этгээд гэмт хэргийн субъект болж чадахгүй гэсэн байр суурьтай байдаг бол бусад судлаачийн зүгээс хуулийн этгээдийг гэмт хэргийн субъект байх боломжтой гэж үздэг.

Судлаачид хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаарх онолын үзэл баримтлалыг анх Англо-Саксоны эрх зүйн тогтолцоотой орнуудад үүссэн гэж үзэх хэдий ч дундад зууны үед зөвхөн Англи төдийгүй эх газрын эрх зүйн тогтолцоотой орнуудад үүссэн байж болзошгүй талаар дурдаж байсан.¹³ Цаашлаад хуулийн этгээд эрүүгийн гэмт хэргийн субъект болох онолын үндэслэлийг авч үзэхдээ нэг талаас эрүүгийн хуулиар хориглосон гэмт хэргийг тухайн хуулийн этгээд өөрийн нэрээр зориуд үйлдсэн үйлдэл, нөгөө талаас гэмт хэргийн үйлдэл нь тухайн байгууллагад ашигтай, давуу байдал бий болгоход шууд чиглэсэн байдаг¹⁴ талаар тэмдэглэсэн байна.

Хуулийн этгээд гэмт хэрэг үйлдэх гэсэн ойлголт нь дэлхий дахинаа “corporate crime” (компанийн гэмт хэрэг) болон “white-collar crime” (цагаан захтны гэмт хэрэг) гэсэн нэр томъёонуудтай улбаатай томъёологдон, түүнээс дамжин хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал бий болсон. Компанийн гэмт хэрэг нь зохион байгуулалттай гэмт хэргийн нэг төрөл бөгөөд хууль ёсны дагуу байгуулагдсан хуулийн этгээдийн ашиг олох үүднээс үйлдсэн гэмт хэргүүд үүнд хамаардаг. Энэ төрлийн гэмт хэрэг нь олон улсад санхүүгийн залилан, итгэл эвдэх, албан татвараас зайлсхийх, экологи байгаль орчны эсрэг гэмт хэрэг, авлига, хээл хахуулийн гэмт хэрэг, үйлчлүүлэгчийн эсрэг, дотоод мэдээлэл худалдах, мөнгө угаах гэх мэт олон төрөлтэй.¹⁵ Эдгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, зогсоох

11 Мөн тэнд, 23 дахь тал.

12 Тухайлбал, Д.Баярсайхан, “Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага” бүтээл; Г.Гантөмөр, “Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын зарим асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэл; Б.Одонгэрэл, “Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага” хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл гэх мэт.

13 Дам ишлэв: Г.Гантөмөр, “Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын зарим асуудал”, Гэмт явдалтай тэмцэх асуудал, 2002, №2, 20 дахь тал.

14 Б.Одонгэрэл, “Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага” хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл, 2020, 37 дахь тал.

15 Мөн тэнд, 34 дэх тал.

зорилгоор улс орнуудад компанид хүлээлгэх эрүүгийн хариуцлагын асуудал урган гарсан бөгөөд зөвхөн хувь хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэсэн зарчмаас татгалзах болсон талаар мөн дурдсан байна.

Хуулийн этгээд гэмт хэргийн субъект болох талаар дэлхий нийтэд 3 чиг хандлага байдаг. Үүнд:¹⁶

- Гэмт хэрэг үйлдэх чадвартай гэж бүрэн хүлээн зөвшөөрдөг;
- Хэсэгчлэн хүлээн зөвшөөрдөг;
- Гэмт хэрэг үйлдэх чадваргүй гэж үздэг.

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал нь Англо-Саксоны эрх зүйн бүлд хамрагдах улс орнуудаас үүсэлтэй бөгөөд Ром-Германы эрх зүйн бүлд хамаарах Монгол Улсын хувьд хуулийн этгээдийг гэмт хэргийн субъектэд саяхныг хүртэл тооцдоггүй байсан. Өөрөөр хэлбэл, 2002 оны Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлагыг зөвхөн хувь хүнд хүлээлгэнэ гэсэн зохицуулалт байсан юм. Харин 2015 оны Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 5.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ”¹⁷ гэж хуульчилснаар дээрх чиг хандлагын нэгдүгээрт бичигдэж буй “хуулийн этгээд нь гэмт хэрэг үйлдэх чадвартай гэж бүрэн хүлээн зөвшөөрдөг” улс орны тоонд багтах болжээ.

ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ПРАКТИКТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Зах зээлийн нийгмийн харилцаа бүрэн төлөвшөөгүй, тогтвортой хөгжлийн орчин бий болж чадаагүй улс оронд гэмт хэргийн шинэ төрлүүд ил ба далд хэлбэрээр оршиж, гэмт хэргийн субъектын хүрээ өргөжин, гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн эрх зүйн үр ашигтай механизм бүрэлдэж амжаагүй байдагтай холбоотой хуулийн этгээдэд ял завших боломжийг бий болгодог. Байгаль орчин бохирдуулах, аж ахуйн эсрэг гэмт хэрэг, мөнгө угаах, хууль бусаар өсгөх, зах зээлд шударгаар өрсөлдөх боломжийг хааж, дангаар ноёрхох, монопол тогтоох, хууль бусаар лиценз олгох, чанар муутай барилга ашиглалтад оруулах, татвараас зайлсхийх, залилан мэхлэх зэрэг олон гэмт хэргийн субъект нь албан тушаалтан болон хуулийн этгээд хоёрын дунд эзгүйдэж, хариуцлага хүлээх этгээд нь чухам хэн болох нь тодорхойгүй байсаар хариуцлага хүлээх хугацаа өнгөрч ял завших, хариуцлагаас мултрах нөхцөл бүрддэг байна. Дээрх нөхцөл байдал Монгол Улсын хувьд ч бодит зүйл болсон билээ.¹⁸

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал 2015 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд бүрэн утгаараа хуульчлагдсан. Өөрөөр хэлбэл, нэлээд олон төрлийн буюу 31 төрлийн гэмт хэрэг энэхүү зохицуулалтад

16 Мөн тэнд, 38 дахь тал.

17 Энэхүү зохицуулалтыг 2002 оны Эрүүгийн хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт тус тус 2014 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар нэмж тусгаж байсан. Гэхдээ тус хуулийн 166¹ дүгээр зүйл “Мөнгө угаах”, 178² дугаар зүйл “Терроризмыг санхүүжүүлэх” гэсэн 2 төрлийн гэмт хэргийн тухайд л хэрэглэхээр хуульчилж байжээ.

18 Б.Одонгэрэл, “Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага”, хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл, 2020, 85 дахь тал.

хамаарахаар тусгагдсан. Уг зохицуулалт нь анх удаа 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад тусгагдсан уу гэвэл үгүй юм. Өөрөөр хэлбэл 2002 онд Эрүүгийн хууль батлагдах үедээ хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтгүй байсан хэдий ч 2014 онд тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа зөвхөн хоёр төрлийн гэмт хэргийн тухайд ийм хариуцлага хүлээлгэх асуудлыг анх хуульчилж байжээ. Харин 2015 оны Эрүүгийн хуульд өөрийн эрхлэн явуулж буй үйл ажиллагаагаар бусдад хохирол, хор уршиг учруулсан хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж байхаар нэлээд дэлгэрэнгүй зохицуулалтыг хуульчилсан. Тухайлбал, 2015 оны эрүүгийн хуульд дараах байдлаар хуульчилж байсан.

Хүснэгт 1.1. 2015 оны Эрүүгийн хууль дахь хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагатай холбогдох зохицуулалт.

Д/д	Зүйл, заалт	Зохицуулалт
1.	1.3 дугаар зүйл. Шударга ёсны зарчим	1.Ял, албадлагын арга хэмжээ нь тухайн хувь хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт нь тохирсон байна. 4.Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн бол тухайн хүнийг ялаас чөлөөлж, хуулийн этгээдэд ял оногдуулна.
2.	1.5 дугаар зүйл. Эрүүгийн хууль Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчлэх	4.Энэ хуульд заасан тохиолдолд Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд энэ хуулиар ял оногдуулна.
3.	1.8 дугаар зүйл. Хууль үйлчлэх цаг хугацаа	1.Үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцох ба оногдуулах ялын төрөл, хэмжээг тухайн гэмт хэргийг үйлдэх үед дагаж мөрдөж байсан хуулиар тодорхойлно.
4.	3.2 дугаар зүйл. Гэмт хэргийн гүйцэтгэгч	2.Хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө шийдвэр гаргаж, зөвшөөрөл өгч энэ хуульд заасан гэмт хэргийг бусдаар үйлдүүлсэн, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө энэ хуульд заасан гэмт хэргийн шинжийг өөрийн үйлдэл, эс үйлдэхгүйгээр хангасан бол гэмт хэргийн гүйцэтгэгчид тооцно. 3.Хуулийн этгээдийн гүйцэтгэх албан тушаалтан удирдлагаас өгсөн шийдвэрийг хууль бус болохыг мэдсээр байж үйлдсэн бол хамтран үйлдсэн гүйцэтгэгчид тооцно.
5.	5.1 дүгээр зүйл. Ялын зорилго	1.Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино. 4.Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.
6.	6.14 дүгээр зүйл. Өршөөл, уучлал үзүүлж ялаас чөлөөлөх	1.Гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг Өршөөл үзүүлэх тухай хуулиар, эсхүл уучлал үзүүлэх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар гэмт хэрэг үйлдсэн хүний эдлэх ялыг бүрэн болон хэсэгчлэн чөлөөлж болно
7.	7.5 дугаар зүйл. Хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ	1.Бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого, эсхүл гэмт хэргийн улмаас учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдсэн хүний хувьд ногдох хөрөнгө, орлогоос албадан гаргуулна. 5.Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого хууль ёсны дагуу хийгдсэн хэлцлийн үндсэн дээр бусдын өмчлөлд шилжсэн бол шүүх тухайн эд зүйллийг үнэлж гэмт хэрэг үйлдсэн хүний хувьд ногдох, хураан авахыг хуулиар хориглоогүй хөрөнгө, орлогоос албадан гаргуулж хохирлыг төлүүлнэ. Тухайн хөрөнгө, орлогыг гэмт хэрэг үйлдэж олсон болохыг мэдсээр байж авсан болох нь тогтоогдвол шүүх уг эд зүйл, хөрөнгө, орлогыг бусдын өмчлөлд шилжүүлсэн хэлцлийг хүчингүйд тооцож, хөрөнгө, орлогыг хураан авч хохирлыг нөхөн төлүүлнэ.

8.	9.1 дүгээр зүйл. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл	2.Хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө шийдвэр гаргаж, зөвшөөрөл өгч энэ хуульд заасан гэмт хэргийг бусдаар үйлдүүлсэн, эсхүл хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө өөрийн үйлдэл, эс үйлдэхгүйгээр энэ хуульд хуульд заасан гэмт хэргийг үйлдсэн бол энэ хуульд заасан ял оногдуулна. 3.Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн бол тухайн хүнийг ялаас чөлөөлж хуулийн этгээдэд ял оногдуулах бөгөөд энэ үйлдэлд нь өөр гэмт хэргийн шинж байвал, тэр үйлдэл, эм үйлдэхгүйгээр энэ хуульд заасан гэмт хэргийг үйлдсэн бол энэ хуульд заасан ял оногдуулна.
9.	9.2 дугаар зүйл. Хуулийн этгээдэд оногдуулах ялын төрөл	1.Гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд дараах ял оногдуулна: 1.1.торгох ял. 1.2.эрх хасах ял; 1.3.татан буулгах ял.
10.	9.3 дугаар зүйл. Торгох ял	1.Энэ хуульд заасан тохиолдолд арван мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр хуулийн этгээдэд торгох ял оногдуулна.
11.	9.4 дүгээр зүйл. Эрх хасах албадлагын арга хэмжээ	1.Энэ хуульд заасан тохиолдолд нэг жилээс найман жил хүртэл хугацаагаар хуулийн этгээдэд нэг, эсхүл хэд хэдэн төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарлах, эсхүл эрх хасах ял оногдуулна.
12.	9.5 дугаар зүйл. Татан буулгах албадлагын арга хэмжээ	1.Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдийг татан буулгах ял оногдуулна.

Гэвч Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхлэхээс өмнө 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулсан.¹⁹

Энэхүү нэмэлт, өөрчлөлт оруулах болсон үндэслэл, шаардлагыг Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулгад дараах байдлаар тусгажээ.²⁰ Үүнд:

- Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн бол тухайн хүнийг ялаас чөлөөлж, хуулийн этгээдэд ял оногдуулна” гэж заасан нь шударга ёсыг бэхжүүлэх, Эрүүгийн хуулийн зорилтыг хангах, зохион байгуулалттай гэмт хэргийг саармагжуулах, тэдгээртэй тэмцэхэд томоохон ач холбогдолтой ч хуулийн дээр дурдсан зохицуулалтаар хуулийн этгээдийг ашиглан, түүгээр дамжуулан гэмт санаагаа хэрэгжүүлсэн хувь хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх нь хууль, шударга ёсны зарчимд нийцэхгүйгээр зогсохгүй гэмт хэрэг үйлдсэн хүн эрүүгийн хариуцлагаас зайлсхийх боломж нөхцөлийг бүрдүүлж байна гэж үзэн;
- Аливаа хийдэл, зөрчлийг арилгах, хууль хүн, хуулийн этгээд бүрд тэгш шударгаар үйлчлэх, эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчимд нийцүүлэн хүн, хуулийн этгээдийн аль алинд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байх, ингэхдээ нэгэнд нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь нөгөөг нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохооргүйгээр тусгах үүднээс;

¹⁹ 2015 оны Эрүүгийн хууль болон 2017 оны 5 дугаар сард эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн харьцуулалтыг Хавсралт 1-ээс дэлгэрэнгүй үзнэ үү.

²⁰ Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, <http://mojha.gov.mn/images/files/huuliintusul/taniltuulga-eruu-20161111.pdf>.

- Түүнчлэн Санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллагын шинэчилсэн 40 зөвлөмжид ч хуулийн этгээдэд хариуцлага тооцох зохицуулалтыг тусгахдаа хэт өргөн хүрээг хамруулсан нь бизнес эрхлэгчдэд үзүүлэх дарамт, шахалтыг нэмэгдүүлэх төдийгүй, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэснээр гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх нь манай улсын мөнгө угаах гэмт хэрэг, терроризмтой тэмцэх чадавхыг сулруулах үр дагавартай, олон улсын практикт огт байдаггүй төдийгүй эрүүгийн бодлогын хувьд ч оновчтой бус зохицуулалт учир;
- Эрүүгийн хуульд авлигын гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах, албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай зохицуулалт ороогүй байгаа нь учир дутагдалтай байна. Авлигын гэмт хэргийг хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө /тендер авах, тусгай зөвшөөрөл авах гэх мэт/ үйлдэх нь түгээмэл байдаг тул эдгээр гэмт хэргүүдэд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь зүйтэй;
- Эрүүгийн хуулиар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэж заасан нь шүүхийн шийдвэрээр төрийн байгууллагад ч албадлагын арга хэмжээ хэрэглэх, татан буулгах “ял” оногдуулах боломжтой, мөн хариуцлагаас зайлсхийх зорилгоор хуулийн этгээд өөрчлөн зохион байгуулагдсан нөхцөлд эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмыг хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байх тул төрийн байгууллага, хуульд зааснаар үүсгэн байгуулагддаг нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх, гадаад улсын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрыг хуулийн этгээдийн нэгэн адил авч үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай зохицуулалт нэмэх;
- Авлига, албан тушаалын гэмт хэрэг нь цөөнгүй тохиолдолд хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, тэдгээрийн ашиг сонирхлын тулд үйлдэгддэг гэмт хэрэг болохыг хүлээн зөвшөөрч авлигын эсрэг авах арга хэмжээний талаар Улсын Их Хурал, Засгийн газраас баримталж буй бодлогод нийцүүлэх зорилгоор Эрүүгийн хуулийн 22.4 дэх хэсэгт заасан авлига өгөх гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд заавал эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг нэмэх шаардлагатай гэж үзэн хуулийн этгээдийн ашиг сонирхлын үүднээс үйлдэгддэг гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэх зорилгоор дээрх зохицуулалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Мөн дээрх нэмэлт, өөрчлөлтөөс гадна Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд “*Эрүүгийн хариуцлага*” гэх нэр томъёог хасаж, үүний оронд “*ял, албадлагын арга хэмжээ*” гэх эрүүгийн хариуцлагын хоёр бие даасан институцийг тус тусад нь тодорхойлсон нь нийтлэг онол, зарчимтай харшилсан тул “*Эрүүгийн хариуцлага*” гэх нэр томъёог нэмж тусгах” гэж заасны дагуу 2015 оны Эрүүгийн хуульд хуулийн этгээдэд “*ял оногдуулах*” гэж хуульчилсан байсныг 2017 оны нэмэлт өөрчлөлтөөр “*эрүүгийн хариуцлага хүлээлгэх*” болгон өөрчлөлт оруулсан. 2015 оны Эрүүгийн хуулийг батлахдаа хуулийн этгээдэд торгох, эрх, хасах, татан буулгах гэсэн 3 төрлийн ял оногдуулахаар зохицуулсан байсан бөгөөд 2017 оны нэмэлт, өөрчлөлтөөр зөвхөн торгох ял оногдуулахаар өөрчилсөн. Хэрэв шүүх эрүүгийн хариуцлагын зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд оногдуулсан ял дээр нэмж эрх хасах, татан буулгах, хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ хэрэглэж болохоор нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө шийдвэр гаргаж, зөвшөөрөл өгч Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийг бусдаар үйлдүүлсэн, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй үйлдэл, эс үйлдэхүйгээр Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийг үйлдсэн бол хуульд заасан ял оногдуулна” гэж заасан.²¹ Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, уг гэмт хэргийн шинж, гэмт хэргийн улмаас нийгэм, иргэдэд учруулсан хохирол, хор уршгийн хэмжээг харгалзана.²² Мөн хуулийн этгээдэд ял оногдуулах үндэслэлийг Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хуулийн этгээдэд ял оногдуулахаар заасан гэмт хэргийн шинжийг:

- Хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа шийдвэр гаргаж;
- Хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан хамтран шийдвэр гаргаж;
- Хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хийсэн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан нь ял оногдуулах үндэслэл болохоор хуульчилсан.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн 3.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө шийдвэр гаргаж, зөвшөөрөл өгч энэ хуульд заасан гэмт хэргийг бусдаар үйлдүүлсэн, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө энэ хуульд заасан гэмт хэргийн шинжийг өөрийн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан бол гэмт хэргийн гүйцэтгэгчид тооцно”²³ гэж хуульчилснаас харахад хуулийн этгээдийн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан өөрөө гүйцэтгэснээс гадна бусдаар гүйцэтгүүлсэн ч хуулийн этгээдэд ял оногдуулах талаар тусгасан байна.

Мөн Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан журмын дагуу хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргасан, зөвшөөрөл өгсөн эрх бүхий албан тушаалтныг ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй”²⁴ гэж хуульчилсан. Уг зохицуулалтыг 2015 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн шударга ёсны зарчимд “хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн бол тухайн хүнийг ялаас чөлөөлж, хуулийн этгээдэд ял оногдуулна.” гэж хуулийн этгээдэд ял оногдуулсан бол тухай хувь хүнийг ялаас чөлөөлөхөөр тусгасан байв.

Гэвч дээр дурдсан зохицуулалтаар хуулийн этгээдийг ашиглан, түүгээр дамжуулан гэмт санаагаа хэрэгжүүлсэн хувь хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх нь хууль, шударга ёсны зарчимд нийцэхгүй гэж үзэн хууль хүн, хуулийн этгээд бүрт тэгш шударгаар үйлчлэх, эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчимд нийцүүлэн уг 2 субъектын аль алинд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг байх, ингэхдээ нэгэнд нь эрүүгийн хариуцлага хүлээлгэснээр нөгөөг нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохооргүйгээр зүйл, заалтыг найруулан хуульчилсан.

21 Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016, №7.

22 Б.Амарбаясгалан, Тойм лекц: Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги, тусгай анги, эрүүгийн процессын эрх зүй, эрүүгийн хууль тогтоомжийн хэрэглээ, 2019, 87 дахь тал.

23 Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016, №7.

24 Мөн тэнд.

Энэхүү заалт Монгол Улс нь Япон, БНХАУ зэрэг Азийн зарим орны нэгэн адил давхар хариуцлагын тогтолцоог хуульчилсан улсын нэг болсныг нотлон харуулж байна. Түүнчлэн Эрүүгийн хуулийн шударга ёсны зарчмын дагуу хуульчлагдсан давхар хариуцлагын талаарх дээрх заалт нь “Double non jeopardy” буюу “нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна” гэсэн заалттай давхцаагүй зарчим болохыг Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэгт заасан зарчмын заалтаас харагдаж байна.²⁵

Мөн Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Гадаад улсын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн бол энэ хуульд заасан хуулийн этгээдийн нэгэн адил эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ”²⁶ хэмээх заалтыг 2017 оны 5 дугаар сард оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд шинээр нэмж тусгасан нь гадаадын хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг бий болгосон зохицуулалт болжээ.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн 9.7 дугаар зүйлд²⁷ хуулийн тусгай ангид заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан бол эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмыг хангах үүднээс дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- бусад хуулийн этгээдтэй нийлүүлэн нэг хуулийн этгээд үүсгэсэн бол шинээр бий болсон хуулийн этгээдэд;
- бусад хуулийн этгээдэд нэгтгэсэн бол нэгтгэж авсан хуулийн этгээдэд;
- хуваах, тусгаарлах замаар өөр хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол тухайн гэмт хэрэгт холбогдох эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүрэг, үйл ажиллагааг шилжүүлэн авсан хувь хэмжээгээр нь зохих хуулийн этгээдэд;
- хуулийн этгээд нь зохион байгуулалтын төрөл, хэлбэр, үндсэн зорилгоо өөрчлөх замаар өөрчлөгдсөн бол тухайн өөрчлөгдөн зохион байгуулагдсан хуулийн этгээдэд;
- компани нь толгой компани, түүний үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлын үүднээс гэмт хэрэг үйлдсэн бол толгой компанид.

Мөн хуулийн 9.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт тусгасан “Хэргийг хянан шийдвэрлэх явцад хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагаас зайлсхийх зорилгоор санаатайгаар татан буулгасан тохиолдолд эрүүгийн хариуцлагыг эд хөрөнгө хуваарилагдсан хувьцаа эзэмшигчдэд, үндэслэлгүйгээр аливаа хэлбэр, арга, хэрэгслээр эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхийг тухайн хуулийн этгээдээс шилжүүлэн авсан нэгдмэл сонирхолтой этгээд, эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхийг хариу төлбөргүйгээр шилжүүлсэн бусад хуулийн этгээдээс нөхөн гаргуулна” гэсэн нь мөн л эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмын илрэл юм.²⁸

25 Б.Одонгэрэл, “Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага” хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл, 2020, 92 дахь тал.

26 Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016, №7.

27 Мөн тэнд.

28 Б.Одонгэрэл, “Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага” сэдэвт хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл, 2020, 93 дахь тал.

Хуулийн 9.3-9.6 дугаар зүйлд хуулийн этгээдэд оногдуулах эрүүгийн хариуцлагын талаар хуульчилсан. Эрүүгийн хариуцлага гэх ойлголт нь өөрөө өргөн хүрээний ойлголт бөгөөд тус салбарын эрдэмтэн судлаачид ялыг эрүүгийн хариуцлагад багтдаг талаар дурдсан байдаг.

Тус хуульд хорих, зорчих эрхийг хязгаарлах, торгох, эрх хасах, нийтэд тустай ажил хийлгэх гэсэн 5 төрлийн ялыг оногдуулахаар тусгаснаас эрх хасах ял нь нэмэгдэл ял, бусад нь үндсэн ял²⁹ байхаар хуульчилсан. 2015 онд Эрүүгийн хуулийг батлахдаа хуулийн этгээдэд торгох, эрх хасах, татан буулгах гэсэн 3 төрлийн ял оноохоор заасан байсан бол, 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар эрх хасах, татан буулгах ялыг хүчингүй болгон хуулийн этгээдэд зөвхөн торгох ял оногдуулахаар зааж, шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд оногдуулсан ял дээр нэмж эрх хасах, татан буулгах, хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах гэсэн 3 төрлийн албадлагын арга хэмжээг хэрэглэж болохоор хуульчилсан байна.

Хуулийн дээрх заалтаар эрүүгийн хариуцлага гэсэн ойлголтод ял, албадлагын арга хэмжээг хамтад нь ойлгож хэрэглэхээр хуульчилсан нь харагдаж байна.³⁰

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй 31 төрлийн гэмт хэргийг (38 зүйл, заалт, хэсгийн хүрээнд) хуульд тусгасан бөгөөд эдгээр гэмт хэргээс торгох ялыг дангаар нь оногдуулахаар заасан 7 гэмт хэрэг, торгох ял дээр нэмэлтээр эрх хасах албадлагын арга хэмжээ оногдуулахаар заасан 22 гэмт хэрэг (27 зүйл, заалт, хэсэг), татан буулгах албадлагын арга хэмжээ дангаар нь оногдуулахаар заасан 3 гэмт хэрэг, торгох, эрх хасах, татан буулгах албадлагын арга хэмжээг давхар оногдуулахаар заасан 1 гэмт хэрэг байна. Дэлгэрэнгүйг доорх хүснэгтээс үзнэ үү.

Хүснэгт 1.2. Эрүүгийн хуульд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулахаар заасан гэмт хэргүүд (оногдуулах хариуцлагын төрөл, ялын хэмжээ, хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох талаарх мэдээллийг тусгав.)

Д/д	Зүйл, заалт	Эрүүгийн хариуцлага	Торгох ялын хэмжээ /нэгжээр/	Хөөн хэлэлцэх хугацаа /2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт/	
				Тухайн зүйлийн 1 дэх хэсэгт заасантай ижил хугацаагаар тогтоовол	Хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр заасан заалтын дээд хэсэгт заасан ижил хугацаагаар тогтоовол
1.	18.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	Торгох	10.000-80.000	1 жил	1 жил
2.	18.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	Торгох	20.000-120.000	3 жил	5 жил
3.	18.5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг	Торгох, эрх хасах	200.000-400.000	1 жил	12 жил
4.	18.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	Торгох, эрх хасах	100.000-400.000	1 жил	12 жил
5.	18.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	Торгох, эрх хасах	100.000-400.000	5 жил	12 жил

29 Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 5.2 дугаар зүйлд ялын төрлийг хуульчилсан.

30 Б.Одонгэрэл, “Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага”, хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл, 2020, 94 дэх тал.

31 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан.

6.	18.8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	Торгох, эрх хасах	10.000-80.000	3 жил	12 жил
7.	18.9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг	Торгох, эрх хасах	10.000-80.000	3 жил	12 жил
8.	18.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	Торгох	10.000-80.000	1 жил	1 жил
9.	18.13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	Торгох, эрх хасах	10.000-80.000	3 жил	5 жил
10.	18.18 дугаар зүйлийн 5 дахь хэсэг ³¹	Торгох, эрх хасах	40.000-200.000	3 жил	12 жил
11.	20.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг	Торгох, эрх хасах	40.000-200.000	5 жил	20 жил
12.	20.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	Торгох, эрх хасах	40.000-200.000	5 жил	12 жил
13.	20.11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг	Торгох, эрх хасах	20.000-120.000	5 жил	5 жил
14.	20.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг	Торгох, эрх хасах	200.000-400.000	5 жил	5 жил
15.	20.12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	Торгох, эрх хасах	10.000-80.000	5 жил	5 жил
16.	20.12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	Торгох, эрх хасах	20.000-120.000	5 жил	5 жил
17.	20.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	Торгох, эрх хасах	20.000-120.000	5 жил	5 жил
18.	20.14 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг	Торгох, эрх хасах	20.000-120.000	3 жил	5 жил
19.	20.14 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг	Торгох, эрх хасах	200.000-400.000	3 жил	5 жил
20.	22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	Торгох, эрх хасах	120.000-400.000	3 жил	5 жил
21.	24.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг	Торгох, эрх хасах	20.000-120.000	5 жил	5 жил
22.	24.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг	Торгох, эрх хасах	40.000-200.000	5 жил	5 жил
23.	24.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	Торгох, эрх хасах	20.000-120.000	5 жил	5 жил
24.	24.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	Торгох, эрх хасах	120.000-400.000	5 жил	5 жил
25.	24.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	Торгох, эрх хасах	20.000-120.000	5 жил	5 жил
26.	24.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	Торгох, эрх хасах	40.000-200.000	5 жил	5 жил
27.	24.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	Торгох, эрх хасах	120.000-400.000	12 жил	12 жил
28.	24.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	Торгох, эрх хасах	20.000-120.000	1 жил	5 жил
29.	24.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	Торгох	120.000-400.000	12 жил	12 жил
30.	25.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	Торгох	10.000-80.000	1 жил	5 жил
31.	25.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг	Торгох	10.000-80.000	3 жил	5 жил
32.	27.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	Торгох	10.000-80.000	5 жил	5 жил
33.	29.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	Торгох, эрх хасах	120.000-400.000	12 жил	12 жил
34.	29.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	Татан буулгах		20 жил	20 жил

35.	29.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	Татан буулгах		20 жил	20 жил
36.	29.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	Татан буулгах		12 жил	12 жил
37.	29.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	Торгох, эрх хасах	120.000-400.000	12 жил	12 жил
38.	29.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	Торгох, эрх хасах, татан буулгах	120.000-400.000	12 жил	12 жил

Зөвхөн торгох ял оногдуулахаар заасан дээрх 31 төрлийн гэмт хэргийн тухайд 2015 оны Эрүүгийн хууль батлагдсанаас хойш ойлгомжгүй байдал үүсгэж буй нэг асуудал бий. Энэ нь хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн гэмт хэргүүд дээр гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тооцох асуудал юм.

2002 оны Эрүүгийн хуулиар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн ангиллаас нь хамааруулан хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд хэмээн тоолдог байсныг 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар өөрчлөн ялын доод болон ялын дээд хэмжээнээс хамааруулан ялгамжтай байдлаар тоолохоор зохицуулж нь эрх зүйн шинэчлэлийн хүрээнд нэлээд ахиц дэвшлийг авчирсан нь сайшаалтай ч зарим гэмт хэрэг дээр гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь ойлгомжгүй байдлаар хуульчлагдсан.³² Өөрөөр хэлбэл, 2015 онд хууль батлахдаа хөөн хэлэлцэх хугацааг зөвхөн хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялтай гэмт хэрэгт хэрэглэхээр хуульчилсан нь хуулийн этгээдэд ял оногдуулах буюу торгох ялтай гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа хэрхэн тоолох нь тодорхойгүй орхигдсон.

Харин 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “...Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдэж энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан бол тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай адил байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно...” гэж нэмж хуульчилснаар зөвхөн торгох ял оногдуулахаар хуульчилсан хэргүүд буюу хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан заалтуудад гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тоолох боломжийг бүрдүүлсэн.³³

Гэсэн хэдий ч тус зохицуулалт нь хэд хэдэн асуудлыг бий болгож байна. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “...тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай адил байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно...” гэж заасан. Гэтэл энэхүү заалтыг хэд хэдэн утгаар ойлгон хэрэглэж болохоор байгаа юм. Тухайлбал, тус хуулийн 18.7 дугаар зүйл гэхэд 4 хэсгээс бүрдэж байна. 18.7 дугаар зүйлийн 1, 2, 3-т заасан зохицуулалтуудад зорчих эрхийг хязгаарлах болон хорих ял оногдуулахаар заасан буюу хөөн хэлэлцэх хугацаа тоолох боломжтой. Тэгвэл хуулийн этгээд 18.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээх боловч тухайн

32 Г.Халиунаа, Б.Ариунжаргал, Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны асуудлыг хүний эрхийн үүднээс авч үзэх нь, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, цуврал 71, 2019, №2, 55 дахь тал.

33 Г.Халиунаа, Б.Ариунжаргал, Эрүүгийн хууль дахь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа, түүнд оруулсан нэмэлт, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, цуврал 77, 2020, №2, 226 дахь тал.

гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг 18.7 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийн яг аль хэсгээр нь тоолох нь ойлгомжгүй. Өөрөөр хэлбэл, "...тухайн зүйл, хэсэгт..." гэдгийг 18.7 дугаар зүйлийн 1, 2, 3 гэж 3 янзаар тайлбарлан ойлгож болохоор байна.

2. Хэрэв тухайн зүйлийн 1 дэх хэсэгт заасантай ижил хугацаагаар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолоход гэвэл дараах асуудал үүсэж болохоор байна. Үүнд:

- Торгох ялын хэмжээ ижил хэрнээ хөөн хэлэлцэх хугацаа ялгамжтай байдлаар тоологдохоор байна. Тухайлбал, 10.000-80.000 нэгжийн торгох ялтай 8³⁴-н хэргийн хувьд 3 хэрэгт нь 1 жил, 4 хэрэгт нь 3 жил, 1 хэрэгт нь 5 жилийн хугацаагаар тус тус хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор байгаа юм.
- Торгох ялын хэмжээ нь бага хэрнээ хөөн хэлэлцэх хугацаа нь бусад хэрэгтэйгээ харьцуулахад өндөр байна.
- Нэг зүйлд заасан хэргүүдийн хувьд хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхдээ хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй үйлдсэн, үндсэн бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах торгох ялын хэмжээ өөр хэрнээ хөөн хэлэлцэх хугацаа нь ижил тоологдохоор байна.
- Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан гэмт хэрэгт тоолох гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа богино байх зэрэг асуудлыг үүсгэж болох юм.

3. Хэрэв 18.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхээр заасан байвал 18.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хөөн хэлэлцэх хугацаа тоолно буюу тухайн хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх заалтын дээд талын хэсэгт заасан хугацаагаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно гэвэл дор дурдсан асуудлууд үүсэхээр байна. Үүнд:

- Торгох ялын хэмжээ ижил хэрнээ хөөн хэлэлцэх хугацаа ялгамжтай байдлаар тоологдохоор байна. Тухайлбал, 10.000-80.000 нэгжийн торгох ялтай 8 хэргийн хувьд 2 хэрэгт нь 1 жил, 4 хэрэгт нь 5 жил, 2 хэрэгт нь 12 жилийн хугацаагаар тус тус хөөн хэлэлцэх хугацаа тоолохоор байна. Хэрвээ энэ хувилбараар зохицуулбал шударга ёсны зарчим алдагдах юм.
- Торгох ялын хэмжээ нь бага хэрнээ хөөн хэлэлцэх хугацаа нь бусад хэрэгтэй харьцуулахад өндөр байна. Жишээ нь: Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт 40.000-120.000 нэгжээр торгох ялтай хэрнээ гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа нь 20 жил байгаа бол мөн хуулийн 20.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт 200.000-400.000 нэгжээр торгохоор заасан боловч хөөн хэлэлцэх хугацаа нь 5 жил байна.
- Нэг зүйлд заасан хэргүүдийн хувьд хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхдээ хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй үйлдсэн, үндсэн бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах торгох ялын хэмжээ өөр хэрнээ хөөн хэлэлцэх хугацаа нь ижил тоологдохоор байгаа юм. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 20.11 дүгээр зүйлийн 3, 4 дэх хэсэг.

34 Эрүүгийн хуулийн 18.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 18.8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 18.9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 18.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 18.13 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт, 20.12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 25.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 25.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг.

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтын хүрээнд өнөөгийн практикт гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой шүүхээр шийдвэрлэсэн хэрэг байхгүй гэж үзэж болохоор байгаа учраас дээрх зохицуулалт асуудал үүсгэж, ойлгомжгүй байдлаар хуульчлагдсан нь илрээгүй байж болох юм. Шүүхийн шийдвэрийн цахим сангаас шүүлт хийхэд, хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр хуулийн этгээдэд хариуцлага тооцох боломжгүй гэж шийдвэрлэсэн нэг тохиолдол³⁵ байна. Энэхүү гэмт хэрэг нь Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлд заасан Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг бөгөөд прокурор тус зүйлийн 3 дахь хэсгээр зүйлчилж шүүхэд ирүүлсэн. Шүүх шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийг удирдлага болгон шийдвэрлэжээ. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт 1-5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр, 24.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт 2-8 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан нь Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт зааснаар “энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн” бол гэх зохицуулалтад хамаарагдах тул тус гэмт хэргийн тухайд дээр дурдсан ойлгомжгүй байдал үүсэхгүй байна.

2.1. Шүүхээр шийдвэрлэгдсэн гэмт хэрэгт хийсэн дүн шинжилгээ

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга мөрдөгдөж эхэлснээс хойш 2021 оны 1 дүгээр сарыг хүртэл Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр хуулийн этгээдэд холбогдох нийт 10 хэрэг шийдвэрлэгдсэн бөгөөд энэ нь жил бүр дунджаар 3 хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Нийт шийдвэрлэгдсэн хэргийн гуравны хоёрыг хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг буюу хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Хүснэгт 1.3. Эрүүгийн хэргийн шүүхээр хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэн шийдвэрлэсэн хэргийн статистик³⁶

Д/д	Огноо	Шийдвэрлэсэн хэргийн тоо	Давж заалдах гомдол гаргасан эсэх	Хяналтын шатны шүүхээр шийдвэр шийдвэрлэсэн эсэх
1.	2017 он	-	-	-
2.	2018 он	3	2	1
3.	2019 он	4	-	-
4.	2020 он	3	-	-
Нийт		10	2	-

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оноож буй эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргасан тохиолдол зөвхөн 2018 онд бүртгэгдсэн бөгөөд давж заалдах шатны шүүхэд гаргасан эхний гомдлыг шүүх ялын хэмжээнд өөрчлөлт оруулан хэвээр үлдээсэн бол, хоёр дахь хэргийг өөр шүүх бүрэлдэхүүнээр дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүх рүү буцаасан байна.

35 Шүүхийн шийдвэрийн цахим сан, <http://new.shuukh.mn/eruanhan/27256/view>.

36 Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан <https://shuukh.mn/> -аас шүүж үзэв.

Эдгээр шийдвэрийг он тус бүрээр задлан, зарим онцлог тохиолдлыг жишээ болгон авч үзье.

Хүснэгт 1.4. Шүүхийн шийдвэрийн шийдвэрлэсэн байдал

Д/д	Шийдвэрлэсэн шүүх	Зүйлчлэл	Анхан шатны шүүхийн шийдвэр	Давж заалдах шатны шүүхийн шийдвэр	Хяналтын шатны шүүхийн шийдвэр
2018 онд шийдвэрлэгдсэн гэмт хэргийн тухайд:					
1.	Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	22.5.3 Хахууль өгөх	- Үйл ажиллагаа явуулах эрх хасах; - 120,000 нэгжээр торгохоор шийдвэрлэсэн.	-	-
2.	Баянхонгор аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	24.2.3 Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох	- Байгаль орчинд учруулсан хохирлыг төлж барагдуулах, - Үйл ажиллагаа явуулах эрхийг 1 жилийн хугацаагаар хасах, - 20,000 нэгжээр торгохоор шийдвэрлэсэн.	- Байгаль орчинд учруулсан хохирлыг төлж барагдуулах шийдвэрийг хүчингүй болгож, - Үйл ажиллагаа явуулах эрхийг 1 жилийн хугацаагаар хасах, - Торгуулийн хэмжээг бууруулж 10,000 нэгжээр торгохоор шийдвэрлэсэн.	-
3.	Өмнөговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	24.2.3 Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох	- 1.10.1 Эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн.	- Өөр шүүх бүрэлдэхүүнээр дахин хэлэлцүүлэхээр буцааж шийдвэрлэсэн	Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг бүхэлд нь хүчингүй болгон, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.
2019 онд шийдвэрлэгдсэн гэмт хэргийн тухайд:					
4.	Баянхонгор аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	24.2.3 Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох	Хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулах эрхийг 1 жилийн хугацаагаар хасах, - 20,000 нэгжээр торгохоор шийдвэрлэсэн. Хувь хүнд хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ авсан.	-	-

5.	Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүх	24.3.3 Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах	34.19.1.1 Хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн.	-	-
6.	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь Сум дундын шүүхийн эрүүгийн хэргийн шүүх	24.3.3 Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах	- Үйл ажиллагаа явуулах эрхийг 1 жилийн хугацаагаар хасах, - 50,000 нэгжээр торгохоор шийдвэрлэсэн.	-	-
7.	Өмнөговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	27.9.2 Замын байгууламжийн ашиглалт, засварын аюулгүй байдлын журам зөрчих	- 10,000 нэгжээр торгохоор шийдвэрлэсэн.	-	-
2020 онд шийдвэрлэгдсэн гэмт хэргийн тухайд:					
8.	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	27.9.2 Замын байгууламжийн ашиглалт, засварын аюулгүй байдлын журам зөрчих	- 34.19.1.1 Хэргийг хэрэгсэхгүй болгож, - Иргэнд учирсан хохирлыг барагдуулахаар шийдвэрлэсэн.	-	-
9.	Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	22.5.3 Хахууль өгөх	- Үйл ажиллагаа явуулах эрхийг 3 жилийн хугацаагаар хасах, - 125.000 нэгжээр торгохоор шийдвэрлэсэн.	-	-
10.	Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүх	18.7.4 Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах	- Үйл ажиллагаа явуулах эрхийг 2 жилийн хугацаагаар хасах, - 120.000 нэгжээр торгохоор шийдвэрлэсэн.	-	-

Шийдвэрийн онцлог: Анхан болон давж заалдах шатны шүүхээр шийдвэрлэгдсэн бөгөөд оноосон хариуцлагыг хөнгөрүүлж, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх шийдвэрийг хүчингүй болгосон.

Тохиолдол 1. Баянхонгор аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.2 дугаар зүйлийн 2, 9.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 24.2 дугаар зүйлийн 3-д зааснаар “О” ХХК-д холбогдох хэргийг 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдөр хянан шийдвэрлэсэн байна.³⁷

37 Мөн тэнд, <http://new.shuukh.mn/eruanhan/30393/view>.

“О” ХХК-ийг төлөөлөн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан “С” нь Ашигт малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т заасан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохоос бусад тохиолдолд тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хориглоно” гэснийг зөрчиж тусгай зөвшөөрөлгүйгээр хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах олборлох гэмт хэрэг үйлдсэний улмаас байгаль орчинд хохирол учруулсан тул “О” ХХК-д ял оногдуулж, байгаль орчинд учирсан хохирол болон хуулийн этгээдэд хүлээлгэсэн торгуулийн ялыг уг гэмт хэргийн гүйцэтгэгч шүүгдэгч “С” төлж барагдуулахаар шийдвэрлэсэн байна. Үүнээс үзэхэд хуулийн этгээдийг хувь хүнтэй адилтган үзэж шийдвэрлэсэн нь харагдаж байна.

“О” ХХК-ийг гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, гэмт хэргийн шинж, хохирол, хор уршгийн хэмжээг харгалзан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.2 дугаар зүйлийн 2, 9.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 24.2 дугаар зүйлийн 3-т зааснаар шүүгдэгч хуулийн этгээд “О” ХХК-ийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах газрын хэвлийн нөхөн сэргээлт, эвдэрсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх эрхийг нэг /1/ жилийн хугацаагаар хасаж, 20,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байна.

Түүнчлэн 2019 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн Баянхонгор аймгийн Эрүү, Иргэний давж заалдах шатны шүүх “С” болон түүний хуулийн этгээд “О” ХХК-д холбогдох хэргийг шүүгдэгчийн гаргасан давж заалдах гомдлын дагуу хянан хэлэлцсэн.³⁸ Шүүх “С” болон түүний хуулийн этгээд “О” ХХК-нд оногдуулсан торгох ялын хэмжээнд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан өөрчлөлт оруулж, эрүүгийн хариуцлага оногдуулахдаа гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрийг харгалзан Эрүүгийн хуулийн 2.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 24.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар 10,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор өөрчлөлт оруулан шийдвэрлэсэн. Тус давж заалдах шатны магадлал нь байгаль, орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх шийдвэрийг хүчингүй болгосон төдийгүй оноосон ялын хэмжээг нэг дахин багасгаж, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлж шийдвэрлэсэн.

Шийдвэрийн онцлог: Өнөөдрийн байдлаар 3 шатны шүүхээр шийдвэрлэгдсэн ганц хэрэг.

Тохиолдол 2. Өмнөговь аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүх нь цэцэрлэгжүүлэлт, гадаад худалдаа, барилгын засвар, засал чимэглэл, фермерийн аж ахуй, газар тариалан, геологийн тойм судалгаа хийх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Э” ХХК-д холбогдох хэргийг 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хянан хэлэлцсэн.³⁹

Хуулийн этгээд “Э” ХХК нь 2014 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 01 дугаартай шийдвэрийн дагуу үүсгэн байгуулагдсан. “Э” ХХК ашиг олохын төлөө нөхөн сэргээлт хийх нэрийдлээр 2017 оны 9 дүгээр сард тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, боловсруулалт явуулсны улмаас байгаль орчинд хохирол учруулсан гэмт хэрэгт холбогдож, гэм буруутайд тооцогдсон байна.

38 Мөн тэнд, <http://new.shuukh.mn/eruudavah/7194/view>.

39 Мөн тэнд, <http://new.shuukh.mn/eruuanhan/27256/view>.

Гэмт хэргийн улмаас газрын хэвлийд учирсан хохирлыг шүүгдэгч “Э” ХХК-ийн захирал М, менежер Г нар төлж барагдуулсан байх тул төлөх төлбөргүй гэж үзэж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1-д зааснаар хөөн хэлэлцэх хугацаа дууссан тул “Э” ХХК-ийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж шийдвэрлэсэн байна.

Харин 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн Өмнөговь аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх прокурорын бичсэн эсэргүүцлийн дагуу тус хэргийг дахин хэлэлцэж, шүүхээс хэргийн бүх ажиллагаа, шийдвэрийг бүхэлд нь хянаж, “Э” ХХК-ийн захирал М, менежер Г нарыг “Э” ХХК-ийн нэрийн өмнөөс, тус компанийн ашиг сонирхлын төлөө нөхөн сэргээлт хийх нэрийдлээр тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, боловсруулалт явуулсан гэж яллах дүгнэлт үйлдсэн нь тэдний үйлдэлд хууль зүйн дүгнэлтийг зөв хийсэн эсэх, нотлох баримтуудыг үнэлж шалгасан эсэхэд эргэлзээ төрүүлж байгаа тул М, Г нар болон “Э” ХХК-д холбогдох хэргийг өөр шүүх бүрэлдэхүүнээр дахин хэлэлцүүлэхээр буцааж шийдвэрлэсэн байна.⁴⁰

2019 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим М, Г нарт холбогдох эрүүгийн хэргийг шүүгдэгчдийн өмгөөлөгчдөөс гаргасан гомдлыг үндэслэн хэргийг хянан хэлэлцэж анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг бүхэлд нь хүчингүй болгон, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна.⁴¹

Шийдвэрийн онцлог: Давхар хариуцлагын зарчмыг баримтлан шийдвэрлэсэн. Өөрөөр хэлбэл, хуулийн этгээд болон түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдэд хоёуланд нь хариуцлага тооцохоор шийдвэрлэсэн.

Тохиолдол 3. Баянхонгор аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүх Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.2 дугаар зүйлийн 2, 5.7 дугаар зүйлийн 1, 9.4 дүгээр зүйлийн 1-т заасныг журамлан, мөн хуулийн тусгай ангийн 24.2 дугаар зүйлийн 3-т заасныг үндэслэн “С” ХХК-д холбогдох хэргийг 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр хянан хэлэлцсэн.⁴²

Газрын хэвлийн нөхөн сэргээлт, эвдэрсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “С” ХХК үйл ажиллагаа явуулахдаа хууль бусаар ашигт малтмал олборлож, байгаль орчинд хохирол учруулсан. “С” ХХК-д Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн № А/157 тоот тушаалаар газрын хэвлийн нөхөн сэргээлт, эвдэрсэн газрын техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жилийн хугацаагаар олгосон байна. “С” ХХК-ийн нэрийн өмнөөс түүний хууль ёсны төлөөлөгч болох “Э” нь хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө шийдвэр гаргаж, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах олборлох гэмт хэрэг үйлдсэн нь хэрэгт цугларсан нотлох баримтаар тогтоогдсон тул шүүхээс “С” ХХК-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.2 дугаар зүйлийн 2, 5.7 дугаар зүйлийн 1, 9.4 дүгээр зүйлийн 1-т заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 24.2 дугаар зүйлийн 3-т заасныг үндэслэн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулах эрхийг 01 жилийн хугацаагаар хасаж, хорин мянган /20,000/ нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байна.

40 Мөн тэнд, <http://new.shuukh.mn/eruudavah/6965/view>.

41 Мөн тэнд, <http://new.shuukh.mn/eruuhyanal/1562/view>.

42 Мөн тэнд, <http://new.shuukh.mn/eruuanhan/30365/view>.

Мөн шүүх “С” ХХК-д эрүүгийн хариуцлага оноосон төдийгүй түүний хууль ёсны төлөөлөгч “Э”-д давхар хариуцлагын зарчмыг баримтлан тэнсэн харгалзах албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэсэн. Өөрөөр хэлбэл, шүүгдэгч “Э”-г шүүгч тусгай зөвшөөрөлгүйгээр хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг үйлдсэн, мөн “С” ХХК-ийг тусгай зөвшөөрөлгүйгээр хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцсон байна.

Шийдвэрийн онцлог: Өнөөдрийн байдлаар гадаадын хуулийн этгээдэд хариуцлага тооцохоор шийдвэрлэсэн ганц хэрэг.

Тохиолдол 4. Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь Сум дундын шүүхийн эрүүгийн хэргийн шүүх Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт холбогдуулан төмрийн хүдрийг баяжуулах, экспортлох, машин тоног, төхөөрөмж суурилуулалт, холбогдох засвар үйлчилгээ эрхлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Ж” ХХК-д холбогдох хэргийг 2019 оны 06 дугаар сарын 27-ны өдөр хянан шийдвэрлэсэн.⁴³

БНХАУ-ын иргэн “Л”-ийн шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн мэдүүлэг, хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтуудаар шүүгдэгч “Ж” ХХК-ийн хууль ёсны төлөөлөгч болох нь тогтоогдсон бөгөөд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө химийн хорт, аюултай бодисыг хууль бусаар хадгалсан гэмт хэргийг үйлдсэн хэрэгт холбогдсон.

Шүүгдэгч “Ж” ХХК нь хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдийн үйлдлээр, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө төмрийн хүдэр баяжуулан экспортлох үйл ажиллагаа явуулах явцдаа мөнгөн усны хлоридын давс хэмээх хорт бодисыг хадгалж байсан нь нотлогдсон тул Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч “Ж” ХХК-ийг төмрийн хүдэр баяжуулах үйл ажиллагаа явуулах эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж, 50,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн. Гэвч хуулийн этгээдийн хууль ёсны төлөөлөгч болох хувь хүнд хариуцлага хүлээлгээгүй шийдвэрлэсэн байна. Шүүхээр шийдвэрлэсэн энэхүү гэмт хэрэг нь гадаадын 100 хувийн хувьцаа эзэмшигчтэй хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн анхны шийдвэр болсон.

Шийдвэрийн онцлог: Хувь хүний үйлдсэн зам тээврийн ослын гэмт хэргийг хуулийн этгээдийн гэмт хэрэгтэй хамтад нь шийдвэрлэсэн.

Тохиолдол 5. Өмнөговь аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт холбогдуулан “Д” ХХК-д холбогдох хэргийн 2019 оны 8 дугаар сарын 30-ны өдөр хянан шийдвэрлэсэн байна.⁴⁴

Шүүгдэгч “Д” ХХК нь Өмнөговь аймгийн Даланзадгад сумын төвөөс Баяндалай сум руу явах чиглэлийн засмал замын засварын ажил гүйцэтгэхдээ хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө авто зам засварын аюулгүй байдлын журам зөрчсөний улмаас хүний амь нас хохироосон гэмт хэрэгт холбогдсон.

43 Мөн тэнд, <http://new.shuukh.mn/eruanhan/33538/view>.

44 Мөн тэнд, <http://new.shuukh.mn/eruanhan/34295/view>.

Шүүх хуралдаанаар “Д” ХХК нь Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэмд заасны дагуу замын тэмдэг тэмдэглэлийг стандартад заасны дагуу хэрэглээгүйн улмаас жолооч “У” нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ автомашиныг жолоодож явахдаа зам тээврийн осол гаргасан. Уг ослын улмаас тухайн тээврийн хэрэгслээр зорчиж явсан “М”, “Л”, “У” нарын эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учирч, 14 хоногтой нярай “Б”-ын амь нас хохирсон нь тогтоогдсон байна.

Шүүгдэгч “Д” ХХК-д, гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлсөн байдлыг нь харгалзан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 10,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байна. Түүнчлэн иргэн “Л”-д учруулсан эрүүл мэндийн хохирлыг төлүүлэхээр шийдвэрлэсэн.

Тус шүүхийн шийдвэрээр хуулийн этгээдийн хэргийг зам тээврийн осол гаргасан жолоочийн хэрэгтэй хамт шийдвэрлэсэн нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 20.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу “Хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тухайн хуулийн этгээдийг төлөөлөх албан тушаалтны, эсхүл хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдэл хийсэн хүний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаатай хамт явагдана” гэх хэсгийг зөрчиж байна. Иймд согтуугаар жолоо барьж зам тээврийн осол гаргасан “У”-ийн гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулсан тус хэргээс салангид явах нь зүйтэй.⁴⁵

Тохиолдол 6. Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хатуу хучилттай зам барих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Б” ХХК-д холбогдох хэргийг 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр хянан шийдвэрлэсэн.⁴⁶

“Б” ХХК нь 2017 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр Дорноговь аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт авто замын байгууламжийн засварын ажлыг хийж гүйцэтгэхдээ Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 27.4 дүгээр хэсгийн А дахь заалтыг зөрчсөний улмаас тээврийн хэрэгсэл жолоодож явсан “А” нь зам тээврийн осол гаргаж, иргэн “Н”-ын эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан гэмт хэрэгт холбогдсон.

Шүүх хуралдаанаар шүүгдэгч “Б” ХХК, түүний төлөөлөгч “Б” нар нь зам засварын ажил хийхдээ мөрдлөг болгон ажиллах Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн 216 дугаар тушаал, түүний хавсралтад зааснаар ажил, үүргээ гүйцэтгээгүй, техникийн шаардлага, стандарт нормыг зөрчсөн гэх нөхцөл байдал хэрэгт тогтоогдохгүй байгаа тул прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн шүүгдэгч “Б” ХХК-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Гэсэн хэдий ч зам тээврийн осолд орсны улмаас эрүүл мэндэд нь хүнд хохирол учирсан иргэн “Н”-д Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 498 дугаар зүйлийн 498.1-д зааснаар “Б” ХХК-ийн төлөөлөгч “Б”-ээс 5,295,500 төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсэн байна. Энэ хэргийг шийдвэрлэхдээ Тохиолдол.5-тай адил зарчмаар шийдвэрлэсэн. Өөрөөр хэлбэл, тус хэргийг хянан шийдвэрлэхэд мөн адил зам тээврийн осол

45 Б.Одонгэрэл, “Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага”, хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл, 2020, 113 дахь тал.

46 Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, <http://new.shuukh.mn/eruanhan/41810/view>.

гаргасан жолоочийн хэргийг давхар шийдвэрлэсэн байгаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 20.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн үйлдэл болж байна. Иймд цаашид хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийг төлөөлөх албан тушаалтны, эсхүл хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдэл хийсэн хүний хэргийг хянан шийдвэрлэх практик тогтоох, эсхүл гэмт хэрэгтэй холбоотой хувь хүний үйлдэлтэй хамт явагдах эсэхийг хуульчлах шаардлагатай.

Дээрх байдлаас дүгнэхэд, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс үндсэн торгох ялаас гадна эрх хасах албадлагын арга хэмжээг хэрэглэн шийдвэрлэсэн шийдвэр 60%-ийг эзэлж байна. Шүүхээр шийдвэрлэсэн нийт 10 хэргээс 2018 оны 2 хэрэгт давж заалдах шатны шүүхэд гомдол гарган хэлэлцүүлсэн. Мөн шийдвэрлэсэн хэргийн 40% нь Улаанбаатар хотод, үлдсэн хэргийг сум дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хянан хэлэлцсэн байна.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2018-2019 оны хооронд, 1 жилийн хугацаагаар эрх хасах албадлагын арга хэмжээг нэмэгдэл ял болгон оноож байсан бол 2020 онд 22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт холбогдох гэмт хэрэгт 3, 18.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт холбогдох гэмт хэрэгт 2 жилийн хугацаагаар эрх хасах албадлагын арга хэмжээг оноож шийдвэрлэсэн байна.

Түүнчлэн торгох эрүүгийн хариуцлага оноосон нийт шийдвэрээс 10,000-20,000 нэгжээр торгосон 3 хэрэг, 50 нэгжээр торгосон 1 хэрэг, 120,000 нэгжээс дээш хэмжээгээр торгосон 3 хэрэг байна. Мөн жил бүр 1 хэрэг буюу гурван жилийн хугацаанд нийт 3 хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ.

Дээрх шийдвэрүүдээс давхар хариуцлага оногдуулах зарчмын хүрээнд хуулийн этгээд болон түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдийн аль алинд нь хариуцлага хүлээлгэсэн нэг хэрэг байгаагаас харахад гэмт хэргийн субъект хувь хүн байна гэсэн чиг хандлагаас одоо болтол салж чадахгүй байгаатай холбоотой байж болох юм.

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 2017-2021 оны хооронд шийдвэрлэсэн нийт хэргийн 30%-д шүүх хуулийн этгээдэд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бусад этгээдийн гэм буруугийн талаар давхар хэлэлцсэн. Ийнхүү шүүх бусад этгээдийн гэм буруугийн асуудлыг шийдвэрлэхдээ хуулийн этгээдэд холбогдох хэргийг давхар шийдвэрлэсэн нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг буруу хэрэглэх практик тогтоох магадлалтай гэж үзэж байна.

2.2. Асуулгын анкетад хийсэн дүн шинжилгээ

Дээрх шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээнээс гадна энэхүү бүлгийн дараах хэсэгт улсын хэмжээнд эрүүгийн хэргийн шүүгчээр ажиллаж буй 3 шатны шүүхийн шүүгчдээс хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй зохицуулалтын хүрээнд асуулгын судалгаа авахад дараах үр дүн гарч байна.⁴⁷

Асуулгад эрүүгийн хэргийн нийт 104 шүүгч, үүнээс анхан шатны шүүхийн шүүгч 76, давж заалдах шатны шүүхийн шүүгч 27, хяналтын шатны шүүхийн шүүгч 1 хамрагдсан.

Судалгаанд хамрагдсан шүүгчдийн 73 хувь нь хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь зүйтэй, 25 хувь нь зарим талаараа зөв, 2 хувь нь хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь буруу гэж үзсэн бөгөөд Эрүүгийн

47 Асуулгын анкетын дэлгэрэнгүйг хавсралт 3-аас дэлгэрэнгүй үзнэ үү.

хуулийн өнөөгийн зохицуулалтаар хуулийн этгээдийн үйлдэж буй гэмт хэргийг бууруулж чадна гэж 51 шүүгч буюу 49 орчим хувь нь үзсэн байна. Харин энэхүү зохицуулалтын үйлчлэлийн үр дүнгийн талаар 39 шүүгч буюу 36 орчим хувь нь сайн хэлж мэдэхгүй байна, 15 шүүгч буюу 14 хувь нь гэмт хэргийн тоог бууруулж чадахгүй гэж тус тус хариулжээ.

Түүнчлэн хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуульд тусгагдсан хариуцлагын арга хэмжээний талаар шүүгчид дараах хариултыг ирүүлсэн.⁴⁸ Үүнд:

Хүснэгт 1.5. Шүүгчдийн хариулсан байдал №1.

Д/д	Хариуцлагын арга хэмжээ	Санал өгсөн шүүгчид	Санал өгсөн шүүгчдийн эзлэх хувь (%)
1.	Хариуцлагын төрөл болж байна	23	22
2.	Хариуцлагын төрөл цөөн байна	11	10
3.	Торгуулийн хэмжээ бага байна	21	20
4.	Торгуулийн хэмжээ өндөр байна	4	4
5.	Тодорхой санал байхгүй	32	31
6.	Бусад /шийдвэрлэгдсэн хэрэг цөөн буюу практик байхгүй учир одоогоор сайн хэлж мэдэхгүй байх г.м/	13	13

Өнөөгийн мөрдөгдөж байгаа зохицуулалтад өөр ямар төрлийн гэмт хэргийг хамруулах шаардлагатай талаарх асуулгад ирүүлсэн хариултыг багцлан харуулбал:⁴⁹

- Эдийн засгийн болон шашны хамаарал бүхий хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт;
- Хуулийн этгээдийн үйл ажиллагаа нь байгаль орчинд хор хохирол учруулсан болон бусдын эрүүл мэнд, амь нас, улс орны тусгаар тогтнолын эсрэг чиглэсэн гэмт хэрэгт;
- Нийгмийн хор аюул ихтэй гэмт хэрэгт;
- Төрийн эрх бүхий албан тушаалтнуудын хамааралтай гэмт хэрэгт;
- Төрийн бус байгууллага байгуулж иргэд, аж ахуйн нэгж, албан тушаалтныг сүрдүүлж, шантаажилдаг үйлдэлтэй гэмт хэрэгт;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал болон нийгмийн халамжийн үйлчилгээтэй холбоотой нийтийн ашиг сонирхлын эсрэг чиглэсэн гэмт хэрэгт;
- Хууль бус бүх үйлдэлд хариуцлага хүлээлгэх нь зүйтэй гэсэн байна.

Харин хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд тулгамдаж буй асуудлын талаар шүүгчдээс ирүүлсэн саналыг нэгтгэвэл:⁵⁰

- Гэмт хэрэг үйлдсэн субъектийг тодруулахад хүндрэлтэй. Дурын хүн компани, хуулийн этгээд байгуулах эрх нээлттэй бөгөөд байгаль орчны эсрэг гэмт хэргийн тухайд хувь хүнийхээ хувьд гэмт хэрэг үйлдсэн үү, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс гэмт хэрэг үйлдсэн үү гэдгийг тогтооход хүндрэл учирна. Тухайлбал, ашиглаж байгаа бүх техник хэрэгсэл нь

48 Тухайн асуулгад нийт 104 шүүгч хариулсан бөгөөд тодорхой санал өгсөн 59, тухайн хэрэг маргааныг шийдвэрлэж байгаагүй тул мэдэхгүй байна гэсэн 13, саналгүй гэж 32 шүүгч тус тус хариулжээ.

49 Тухайн асуулгад нийт 72 шүүгч хариулсан бөгөөд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд нэмэлт эрх зүйн зохицуулалт шаардлагатай гэж 46 шүүгч санал өгчээ.

50 Тухайн асуулгад нийт 67 шүүгч хариулсан бөгөөд тодорхой санал өгсөн 45, тухайн хэрэг маргааныг шийдвэрлэж байгаагүй тул мэдэхгүй байна гэсэн 5, саналгүй гэж 17 шүүгч тус тус хариулжээ.

- түрээсийнх бөгөөд хуулийн этгээд нь ганцхан захирлаас өөр ажилтан байхгүй байх тохиолдол олон байдаг;
- Аль болох шалгалтын хүрээг хувь хүнд бус хуулийн этгээдийн үйл ажиллагаа руу чиглүүлж мөрдөн шалгах шаардлагатай;
 - Эрх хасах нэмэгдэл ял үр дүнгүй байна, учир нь хуулийн этгээдийн захирал ял аваад дараа нь захирал солигдоод үйл ажиллагаа нь хэвээрээ явагдаж байдаг;
 - Мөрдөн шалгах ажиллагааг хангалттай хийхгүй байна;
 - Торгох ялын хэмжээг сонгох боломж хязгаарлагдмал байгаа нь ял шийтгэл үйлдсэн гэмт хэрэгт нь тохирсон байх зарчмыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байна;
 - Албан тушаалтны нөлөөлөл их байж болзошгүй;
 - Эрүүгийн хуулийн зохицуулалт буруу байна. Зүйл ангийн 3 ба 4 дэх хэсэг дээр хуулийн этгээдтэй холбоотой заалтыг хуульчилсан ба торгох ялтай байдаг. Гэтэл зүйл ангийн 1 ба 2 дахь хэсэгт хорих ял тусгагдсан;
 - Нэг гишүүнтэй хуулийн этгээдийн хувьд ялыг хэрэглэхэд эрүүгийн эрх зүйн онол зөрчилддөг;
 - Туршлага дутагдалтай байна;
 - Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн ашиг сонирхолд хуулийн этгээдийг ашигласан уу, эсвэл яг хуулийн этгээдийн төлөө юу гэдгийг ялгаж салгахад бэрх;
 - Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс үйлдэгдсэн хэргийг хувь хүн үйлдсэн гэх байдлаар бүрдүүлж байна;
 - Хууль хяналтын байгууллагуудыг нэгдсэн ойлголттой болгох, тэдний үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай;
 - Эрүүгийн хууль тогтоомжийг нэг мөр хэрэглэх, түүнд тавих прокурорын хяналтыг сайжруулах шаардлагатай;
 - Тамга, гэрчилгээнээс өөр зүйлгүй гүйцэтгэх захирал байгаа нь хүндрэлтэй. Тухайлбал, олон улсын тээвэр хийх тусгай зөвшөөрөлтэй компаниуд Өмнөговь аймагт олон байна. Тэдгээр компаниуд нь эрүүгийн хариуцлага хүлээх гэмт хэрэгт холбогдоогүй, тухайн компанийн нэр дээр эзэмшил бүртгэлтэй тээврийн хэрэгслийн жолооч нь авто ослын гэмт хэрэг үйлдэхэд иргэний хариуцагч, нэхэмжлэгчээр оролцдог. Гэтэл тусгай зөвшөөрлийг гадаадын компанид олгодоггүй тул Монгол Улсын иргэн компани байгуулдаг боловч, ихэнх тээврийн хэрэгсэл нь хятад иргэнийх байдаг. Хохирол гаргуулах болоход тухайн хятад иргэн хэн болох нь мэдэгддэггүй. Жолооч нар нь хятад хөтчөөс тээврийн хэрэгслээ хүлээж авсан гэдэг.

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалт хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш 3 жил гаруй хугацаа өнгөрсөн хэдий ч шүүхээр хуулийн этгээдтэй холбоотой хэрэг маргаан маш цөөн шийдвэрлэгдсэн байгаа шалтгаан нөхцөлийн талаар шүүгчдээс ирүүлсэн хариултыг багцлан үзвэл:⁵¹

51 Тухайн асуулгад нийт 104 шүүгч хариулсан бөгөөд тодорхой санал өгсөн 89, тухайн хэрэг маргааныг шийдвэрлэж байгаагүй тул мэдэхгүй байна гэсэн 10, саналгүй гэж 5 шүүгч тус тус хариулжээ.

Хүснэгт 1.6. Шүүгчдийн хариулсан байдал. №2

Д/д	Тулгамдаж буй асуудлууд	Санал өгсөн шүүгчид	Санал өгсөн шүүгчдийн эзлэх хувь (%)
1.	Хуулийг нэг мөр ойлгож, хэрэглэж чадахгүй байна	11	11
2.	Эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна	14	13
3.	Хэрэг илрүүлэлт муу, шалгахгүй байна	27	26
4.	Прокурор хяналт сайн тавихгүй байна	4	4
5.	Гэмт хэргийн гаралт цөөн байгаа нь урьдчилан сэргийлэх ажил сайн байгаагийн илрэл	2	2
6.	Өмнө нь ийм төрлийн хариуцлага хүлээлгэж байсан практик байхгүй учраас сайн хэлж мэдэхгүй байна	16	16
7.	Бусад	15	14
8.	Хариулт өгөөгүй	15	14

Шүүгчид энэхүү зохицуулалтыг цаашид боловсронгуй болгох талаар дараах саналыг ирүүлсэн. Үүнд:

- Энэ талаарх сургалтын хүрээг өргөжүүлж, ойлголтыг биелэгдэх хэмжээнд хүргэх;
- Өөрийн оронд тохирсон хариуцлагыг бий болгох, энэ талаар шүүгч нарт сургалт явуулж, тэдгээрийн санал бодлыг тусгах;
- Ялын төрөл, хэмжээг уян хатан сонголттой болгох;
- Хуулийн этгээдийн төлөөлөгчийг зөв тодорхойлох;
- Тусгайлан мөрдөн шалгах албатай болох;
- Зохицуулалтыг тодорхой болгох. Тухайлбал, нэг гишүүнтэй хуулийн этгээдийн хувьд;
- Татан буулгахгүйгээр үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ байж болно. Тухайлбал, өөрийн хөрөнгө зардлаар нийгэмд тустай зарим үйл ажиллагааг санхүүжүүлэх г.м;
- Хуулийн этгээдэд ял оногдуулахаар заасан гэмт хэргийн шинжүүдийг нарийвчлан хуульчлах;
- Компанийн тухай хуульд хариуцлагыг дэлгэрэнгүй тусгах зэрэг саналыг ирүүлжээ.

**ГУРАВ. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД
ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЛГЭХ ЗОХИЦУУЛАЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ
АСУУДАЛ, ПРАКТИКТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

3.1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хэм хэмжээ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.1 дүгээр зүйлд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино” гэж заажээ. Мөн хуулийн 20 дугаар бүлэгт хуулийн этгээдэд холбогдох хэрэгт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрхэн явуулах талаарх

зохицуулалтыг хуульчилж өгсөн байдаг.⁵²

Хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тухайн хуулийн этгээдийг төлөөлөх албан тушаалтны, эсхүл хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдэл хийсэн хүний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаатай хамт явагдана.⁵³

Хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг тухайн гэмт хэрэгт хувь хүнийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж байгаагаас үл хамааран явуулж болно.

Хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тухайн хуулийн этгээдийг дараах хүнээр төлөөлүүлж болохгүй.⁵⁴ Үүнд:

- хуулийн этгээдийн эсрэг шүүх хуралдаанд гэрчээр оролцож байгаа бол;
- хуулийн этгээдийг төлөөлөх хүн нь тухайн хэргийн яллагдагч бол.

Хэрэв яллагдагчаар татагдсан хүнээс өөр төлөөлөх хүн байхгүй бол төлөөлүүлж болохоор зохицуулсан.

Хуулийн этгээдийг төлөөлөх хүн байхгүй бол тогтоосон хугацааны дотор өөр этгээдийг хууль ёсны төлөөлөгчөөр томилохыг шүүх, прокурор, мөрдөгч хуулийн этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

Тогтоосон хугацаанд хуулийн этгээд хууль ёсны төлөөлөгчөө томилоогүй бол шүүх, прокурор хууль ёсны төлөөлөгчийг томилж болно гэж заасан байдаг ба энэ тохиолдолд ямар эрх зүйн акт гаргах, энэ нь ямар дэс дараалалтай байх талаар дэлгэрэнгүй хуульчлаагүй байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тухайн хуулийн этгээдийн улсын бүртгэл, зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл, тэдгээртэй адилтгах мэдээллийг өөрчлөхгүй байх, улсын бүртгэлээс хасахгүй байхыг шүүх, прокуророос холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

Түүнчлэн хуулийн этгээдийн хууль ёсны төлөөлөгч хуульд заасан яллагдагчийн эрх эдэлж, үүрэг хүлээхээр заасан байдаг боловч хуулийн этгээдийг яллагдагчаар тооцоход эрх үүргийг хэнд танилцуулах, хуулийн этгээдийн зохион байгуулалтын хэлбэрийг хэрхэн авч үзэх, хууль ёсны төлөөлөгчөөр томилогдсон этгээдийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдэх эсэх зэргийг нарийвчлан зааж өгөөгүй байна.

Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.1 дүгээр зүйлд “Энэ хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг яллагдагч гэнэ” гэж заасан. Гэтэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу баривчлагдсан, эсхүл яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан хүнийг сэжигтэн гэж үзэхээр хуульчилсан байдаг. Үүнээс хуулийн этгээдийг сэжигтэн гэж үзэх боломжгүй зохицуулалттай бөгөөд цаашлаад яллагдагчаар татах хууль зүйн зөрчилтэй нөхцөл байдал үүсээд байна.

52 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №23.


53 ЭХХШТХ-ийн 20.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

54 Мөн хуулийн 20.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

3.2. Хуулийн этгээдэд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан тогтоолд хийсэн дүн шинжилгээ

Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэн 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд прокурорын байгууллагаас нийт 26 хэрэгт хуулийн этгээдэд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан байна. Үүнээс 14 хэргийг шүүхэд шилжүүлж, 4 хэргийг хэрэгсэхгүй болгож, 1 хэргийн яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгож, хэрэг бүртгэлтийн хэргийг хааж, одоо ажиллагаанд 7 мөрдөн байцаалтын хэргийн үлдэгдэлтэй байна.⁵⁵

График 1.3. Прокурорын байгууллагын шийдвэрлэсэн байдал



Нийт 26 хэргийн 20 хэрэгт цагдаагийн байгууллага, 6 хэрэгт АТГ мөрдөн шалгах ажиллагаа явуулжээ.

Хүснэгт 1.7. Яллагдагчаар татсан хэргүүдийг Эрүүгийн хуулийн зүйл

Д/д	Бүртгэгдсэн гэмт хэрэг	Зүйл, заалт	Гэмт хэргийн тоо
2017 он			
1.	Хахууль өгөх	22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	2
2018 он			
2.	Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх	18.5 дугаар зүйлийн 5 дахь хэсэг	1
3.	Хууль бусаар эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх	20.14 дүгээр зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг	1
4.	Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох	24.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	3
5.	Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох	24.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	1
6.	Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох	24.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	2
7.	Хууль бусаар мод бэлтгэх	24.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	1
8.	Хууль бусаар мод бэлтгэх	24.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	1
9.	Замын байгууламжийн ашиглалт, засварын аюулгүй байдлын журам зөрчих	27.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	1

55 Дүн шинжилгээний хүрээнд прокурорын байгууллагаас ирүүлсэн тоон мэдээлэлд үндэслэн гаргав.

2019 он			
10.	Хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол болгоомжгүйгээр учруулах	11.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	1
11.	Хахууль өгөх	22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	1
12.	Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох	24.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	1
13.	Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах	24.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	1
14.	Хууль бусаар мод бэлтгэх	24.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	1
15.	Замын байгууламжийн ашиглалт, засварын аюулгүй байдлын журам зөрчих	27.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	1
2020 он			
16.	Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах	18.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	1
17.	Битүүмжилсэн, хураан авсан эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх	21.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	1
18.	Хахууль өгөх	22.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	1
19.	Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох	24.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	1
20.	Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах	24.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	1
2021 он			
21.	Хахууль өгөх	22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	1
22.	Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах	24.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг	1

Дээрх эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан гэмт хэргүүдийн зарим буюу Эрүүгийн хуулийн 11.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 18.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 18.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 20.14 дүгээр зүйлийн 1,2 дахь хэсгүүд, 24.2 дугаар зүйлийн 1,2 дахь хэсэг, 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 24.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зүйл ангиар хуулийн этгээдийг яллагдагчаар татах үндэслэлгүй байхад прокурор эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол гаргаж байгаа нь Эрүүгийн хуулийн хэм хэмжээг буруу хэрэглэсэн гэж дүгнэхэд хүргэж байна.

Мөн дээрх хэргүүдэд мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа мөрдөгч нартай утсаар холбогдож хуулийн этгээд холбогдон шалгаж байгаа хэрэгт үүсч буй хүндрэл бэрхшээлүүдийн талаар тодруулахад:

1. Хуулийн этгээдийн талаар нэгдсэн сантай болох шаардлагатай байна, ингэснээр тухайн хуулийн этгээдийн тухайд өмнө нь татвар болон бусад төрийн байгууллагаас зөрчлийн болон холбогдох хууль тогтоомжоор арга хэмжээ авч байсан эсэхийг тодруулахад цаг алдалгүй шалгах боломж бүрдэнэ;

2. Зарим хуулийн этгээд олон хувьцаа эзэмшигчтэй байдгаас хувьцаа эзэмшигч нарыг бүгдийг иргэний хариуцагчаар татах ажиллагаа маш их цаг хугацаа авч байна. Энэ асуудлыг хялбараар зохицуулах арга хэмжээ авах зэрэг санал хүсэлтийг дийлэнх нь хэлж байлаа.

Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэж мөн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд ял оногдуулахаар заасан гэмт хэргийн шинжийг хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа, эсхүл хамтран шийдвэр гаргаж, эсхүл хуулийн

этгээдийн ашиг сонирхлын төлөө хийсэн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан нь хуулийн этгээдэд ял оногдуулах үндэслэл болно” гэж тус тус заасан байдаг боловч нийт яллагдагчаар татагдсан 26 хэргээс 7 хэрэгт хуулийн этгээдийг яллагдагчаар татах үндэслэлгүй зүйл ангиар татаж байгаа нь мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй байгууллага, прокурорын байгууллагууд нь Эрүүгийн хуулийн хэм хэмжээг буруу хэрэглэж, нэгдсэн ойлголтгүй байгааг харуулж байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтыг 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад бүрэн утгаар нь тусгаснаар Монгол Улсын эрүүгийн эрх зүйн салбарт томоохон шинэчлэл болсон.

Хууль зүйн хариуцлагыг өмнө нь зөвхөн иргэнд хүлээлгэх талаар ойлголт байсан бол дэлхий нийтээр хуулийн этгээдэд ч мөн эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь зүйтэй гэсэн хандлага төлөвшиж байгаа талаар эрдэмтдийн бүтээлд дурдсан бөгөөд эдгээр эрдэмтэд хууль зүйн хариуцлагыг хувь хүн, хуулийн этгээдийн аль алинд нь хүлээлгэх нь зүйтэй гэж үзсэн байна.

Хуулийн этгээд гэмт хэргийн субъект болох талаар улс орнууд 3 чиг хандлагыг баримталж байгаа бөгөөд манай улс 2015 онд анх удаа хуулийн этгээдэд холбогдох гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага тооцохоор хуульчилсан нь “хуулийн этгээдийг гэмт хэрэг үйлдэх чадвартай гэж бүрэн хүлээн зөвшөөрдөг” улс орны тоонд зүй ёсоор багтахад хүргэсэн юм.

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг 2015 онд хуульчлахдаа зарим алдаа, дутагдал гаргасныг 2017 онд хууль хэрэгжиж эхлэхээс өмнө засаж сайжруулсан. Тухайлбал, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байх, Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийг үйлдсэн байх, гэм буруутай хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг тухайн цаг үеийн хуулиар тодорхойлох, давхар хариуцлагын тогтолцоог баримтлах, гадаадын болон дотоодын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар гэмт хэргийг үйлдсэн байх гэх мэт шинж, зарчмыг нарийвчлан тодорхой тусгасан.

Гэсэн хэдий ч 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хууль хэрэгжиж эхэлснээр Эрүүгийн хуулийн зарим зохицуулалт практикт хэрэгжүүлэхэд ойлгомжгүй, орхигдсон байсан нь илэрсэн. Үүний нэг нь хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн гэмт хэргүүд буюу зөвхөн торгох ял оногдуулахаар заасан гэмт хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацаа тоолох асуудал юм. Улмаар практикт үүссэн хүндрэлийг зохицуулахын тулд Эрүүгийн хуульд 2020 онд нэмэлт, өөрчлөлт оруулж, эдгээр гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор зохицуулсан боловч мөн л ойлгомжгүй байдлыг үүсгэсэн гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 6 дахь хэсгийг нэмж хуульчлахдаа “...тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай адил байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно...” гэж заасан. Гэтэл энэхүү заалтыг хэд хэдэн утгаар ойлгон хэрэглэж болохоор байна. Тухайлбал, тус хуулийн 18.7 дугаар зүйл гэхэд 4 хэсгээс бүрдэж байна. 18.7 дугаар зүйлийн 1, 2, 3-т заасан зохицуулалтуудад зорчих эрхийг хязгаарлах болон хорих ял оногдуулахаар заасан буюу хөөн хэлэлцэх хугацаа тоолох боломжтой. Тэгвэл хуулийн этгээд 18.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээх боловч тухайн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг 18.7 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийг яг аль хэсгээр нь тоолох нь ойлгомжгүй. Өөрөөр хэлбэл, тухайн зүйл, хэсэгт гэдгийг 18.7 дугаар зүйлийн 1, 2, 3 гэж 3 янзаар тайлбарлан ойлгож болохоор байна.

Нийгмийн хөгжлийг даган юмс үзэгдэл өөрчлөн шинэчлэгдэж байдаг төдийгүй хууль тогтоомжийн хувьд ч мөн адил өөрчлөлт, шинэчлэлийг хийж байх нь зүйн хэрэг юм. Энэ ч утгаараа аливаа хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хуулийн шинэчилсэн

найруулга хийхдээ маш сайн судалгаатай хандах шаардлагатай. Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. Гэтэл гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох асуудал нь дээр дурдсанчлан эргэлзээтэй байдлыг бий болгож байгаа тохиолдолд хуулийг буруу хэрэглэх нөхцөл үүсч болзошгүй юм.

Шүүхээс хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн гэмт хэргийн статистик үзүүлэлтийг харвал хууль хэрэгжиж эхэлснээс хойш 3 жил гаруй хугацаа өнгөрч байхад нийт 10 хэрэг шийдвэрлэгдсэн байна. Энэхүү үзүүлэлт нь харьцангуй бага тоо бөгөөд хэргийн шийдвэрлэлт яагаад ийм бага байгаа талаар практикт ажиллаж буй шүүгчдээс асуулга авахад, шинэ төрлийн гэмт хэргийн хувьд хуульчдын хуулийн хэрэглээ, нэгдсэн ойлголт хангалтгүй, мөрдөн шалгах ажиллагаа дутмаг, прокурорын хяналт сул байж болох талаар дурдсан.

Харин шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдэд дүн шинжилгээ хийх явцад Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 2017-2021 оны хооронд шийдвэрлэсэн нийт хэргийн 30%-д шүүх хуулийн этгээдэд холбогдох хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд бусад этгээдийн гэм буруугийн талаар давхар хэлэлцсэн байна. Тухайн шийдвэрлэсэн хэргүүдийн гуравны хоёр нь замын байгууламжийн ашиглалт, засварын аюулгүй байдлын журам зөрчсөний улмаас хүний эрүүл мэнд хохирсон гэмт хэрэг байсан бөгөөд шүүх бусад этгээдийн гэм буруугийн асуудал болон хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг давхар шийдвэрлэсэн нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг буруу хэрэглэж буй практик тогтож болзошгүй харагдаж байна. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 20.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хуулийн этгээдэд холбогдох эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тухайн хуулийн этгээдийг төлөөлөх албан тушаалтны, эсхүл хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдэл хийсэн хүний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаатай хамт явагдана” гэж заасныг зөрчиж байна гэж үзэж болох юм.

Судалгааны ажлын хүрээнд, эрүүгийн хэргийн шүүгчдээр анкетын асуулга бөглүүлсэн бөгөөд нийт 65 шүүгч, эдгээрийн 45 нь анхан шатны шүүхийн шүүгч, 20 нь давж заалдах шатны шүүхийн шүүгч хамрагдсан. Судалгаанд хамрагдсан шүүгчдийн дийлэнх нь урьд нь ийм төрлийн гэмт хэрэг шийдвэрлэж байгаагүй (практик тогтоогүй) тул тулгамдаж буй асуудал хийгээд цаашид эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар тодорхой саналгүй байгаа нь харагдаж байсан. Гэхдээ шүүгчдээс энэхүү гэмт хэрэгтэй холбоотой Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн талаарх асуулга авахад шинээр хуульчлагдсан учраас хууль хэрэглээний асуудал нэгдсэн ойлголтод хүрч чадаагүй, хувь хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх хандлагаасаа салаагүй, мөрдөн шалгах ажиллагаа дутуу, прокурорын хяналт сул байгаатай холбоотойгоор гэмт хэргийн илрүүлэлт хангалтгүй байна гэж үзжээ.

Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.1 дүгээр зүйлд “Энэ хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг яллагдагч гэнэ” гэж заасан, гэтэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу баривчлагдсан, эсхүл яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан этгээдийг сэжигтэн гэж үзэхээр хуульчилсан байгаа нь эрх зүйн алдаатай зохицуулалт гэж харахаар байна.

Мөн 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2020 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд прокурорын байгууллагаас эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан 26 хэрэг байгаагаас 7 хэрэгт хуулийн этгээдийг яллагдагчаар татах үндэслэлгүй зүйл ангиар татаж, 5 хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн

нь хуулийн этгээд холбогдсон гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах практик туршлага байхгүй, мөрдөгч, прокурорын мэдлэг чадвар хангалтгүй зэрэг байдалтай холбон үзэж болохоор байна.

Судалгаанд ашигласан тоо, баримт, мэдээллээс үзэхэд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг хэрэгжүүлэхэд аль ч шатанд нэгдсэн ойлголт дутмаг, туршлага дутагдаж байна.

Дээрх дүгнэлтэд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Аливаа хууль батлахдаа, ялангуяа хуулийн шинэчилсэн найруулга хийхэд маш сайн судалгаатай хандах;
- Гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдийг татан буулгахгүйгээр үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ хэрэглэх. Тухайлбал, өөрийн хөрөнгө зардлаар нийгмийн тустай зарим үйл ажиллагааг санхүүжүүлэх;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгасан яллагдагчийг тодорхойлсон хэм хэмжээнд өөрчлөлт оруулах;
- Ялын төрөл, хэмжээг уян хатан сонголттой болгох;
- Торгох ял оногдуулахаар заасан хэргүүдэд ялын хэмжээнээс хамааруулан хөөн хэлэлцэх хугацаа тоолдог байхаар хуульчлах. Өөрөөр хэлбэл, торгох ял оногдуулахаар заасан заалтуудад торгох ялын доод хэмжээг 10.000, дээд хэмжээг 400.000 хүртэл байхаар хуульчилсан байх тул хөөн хэлэлцэх хугацааг торгох ялын хэмжээнээс хамааруулан ялгамжтай тоолохоор хуульчлах. Тухайлбал, 10.000-100.000 нэгжтэй тэнцэх, 20.000-200.000 нэгжтэй тэнцэх, 120.000-400.000 нэгжтэй тэнцэх гэх мэтээр ялгамжтай байдлаар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хэдий хугацаанд тоолох талаар зохицуулах;
- Олон хувьцаа эзэмшигчтэй хуулийн этгээдийн хувьд мөрдөн шалгах ажиллагааны шуурхай байдлыг хангах зорилгоор төлөөлөх этгээдийг тодорхойлох хуулийн хэм хэмжээг бий болгох асуудлыг судалж шийдвэрлэх;
- Хуулийн этгээдийн талаарх нэгдсэн санг мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй байгууллагад бий болгох асуудлыг судалж шийдвэрлэх;
- Хуулийн этгээд холбогдсон хэргийн онцлог, анхаарах асуудлын талаар хууль хяналтын байгууллагуудын албан хаагчдад сургалт явуулах, нэгдсэн ойлголттой болгох;
- Хуулийн этгээдтэй холбоотой гэмт хэргийг шийдвэрлэх зөв практик хэвшүүлэх тал дээр анхаарах;
- Мөрдөн шалгах ажиллагаа болон прокурорын хяналтыг сайжруулах талаар анхаарч, мөрдөн шалгах ажиллагаа явуулах арга зүйн зөвлөмж боловсруулах зэрэг болно.

НОМ ЗҮЙ

I. Монгол хэл дээрх эх сурвалж

Хууль тогтоомж:

1. Иргэний хууль (2002), №7.
2. Эрүүгийн хууль (2016).
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, (2017).

Ном, өгүүлэл нийтлэл:

1. Б.Амарбаясгалан, Тойм лекц: Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги, тусгай анги, эрүүгийн процессын эрх зүй, эрүүгийн хууль тогтоомжийн хэрэглээ, 2019.
2. О.Амархүү, Эрх зүйн онолын арван таван сэдэв, 2008.
3. Д.Баярсайхан, Эрх зүйн онол, 2010.
4. Д.Баярсайхан, Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага, 2013.
5. Д.Баярсайхан, Хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага: онолын үзэл баримтлал, чиг хандлага, Эрх зүй сэтгүүл, цуврал №3, 2013.
6. Г.Гантөмөр, Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын зарим асуудал, Гэмт явдалтай тэмцэх асуудал, №2, 2002.
7. Б.Одонгэрэл, “Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага” хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл, 2020.
8. С.Нарангэрэл, Монголын эрх зүйн англи, орос, латин хадмал эх толь бичиг, 4 дэх хэвлэл, 2015.
9. Ч.Нямсүрэн, Эрх зүйн ерөнхий онол, 2017.
10. Г.Халиунаа, Б.Ариунжаргал, Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааны асуудлыг хүний эрхийн үүднээс авч үзэх нь, Хууль дээдлэх ёс сэтгүүл, цуврал 71, 2019.
11. Г.Халиунаа, Б.Ариунжаргал, Эрүүгийн хууль дахь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа, түүнд оруулсан нэмэлт, Хууль дээдлэх ёс сэтгүүл, цуврал 77, 2020.
12. Эрүүгийн эрх зүйн шинэтгэл: хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал: олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2017.

II. Цахим эх сурвалж:

1. Шинэ Эрүүгийн хуулийн үзэл баримтлал /анхных/, http://criminalman.blogspot.com/2018/08/blog-post_30.html.
2. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулга, <http://mojha.gov.mn/images/files/huuliintusul/taniltuulga-eruu-20161111.pdf>.
3. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хүрээнд 2017-2019 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, <https://www.mongolbank.mn/documents/cma/Мөнгө%20угаах%20-%20last.pdf> -.

Хавсралт 1. Эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтад оруулсан нэмэлт, өөрчлөлт

Д/д	2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга	2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн нэмэлт, өөрчлөлт
1.	1.3 дугаар зүйл.Шударга ёсны зарчим 1. Ял, албадлагын арга хэмжээ нь тухайн хувь хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт нь тохирсон байна. 4. Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн бол тухайн хүнийг ялаас чөлөөлж, хуулийн этгээдэд ял оногдуулна.	1.3 дугаар зүйл.Шударга ёсны зарчим 1.Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна. 4.Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.
Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх талаар Олон улсын санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага /цаашид “ФАТФ” гэх/-ын шинэчилсэн 40 зөвлөмжийн гуравдугаарт “хувь хүнд хариуцлага хүлээлгэсэн нь хуулийн этгээдийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй байх талаар хуульд тусгах шаардлагатай” тухай зөвлөмжийг 2017 онд өгсний дагуу Монгол Улс холбогдох хууль, тогтоомж, журмыг шинэчлэх шаардлагатай болсон.		
2.	1.5 дугаар зүйл.Эрүүгийн хууль Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчлэх 4. Энэ хуульд заасан тохиолдолд Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд энэ хуулиар ял оногдуулна.	1.5 дугаар зүйл.Эрүүгийн хууль Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчлэх 4.Энэ хуульд заасан тохиолдолд Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд энэ хуулиар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.
4.	1.8 дугаар зүйл.Хууль үйлчлэх цаг хугацаа 1. Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох ба оногдуулах ялын төрөл, хэмжээг тухайн гэмт хэргийг үйлдэх үед дагаж мөрдөж байсан хуулиар тодорхойлно.	1.8 дугаар зүйл.Хууль үйлчлэх цаг хугацаа 1.Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, гэм буруутай хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг тухайн гэмт хэргийг үйлдэх үед дагаж мөрдөж байсан хуулиар тодорхойлно.
Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд ““Эрүүгийн хариуцлага” гэх нэр томъёог хасаж, үүний оронд “ял, албадлагын арга хэмжээ” гэх эрүүгийн хариуцлагын хоёр бие даасан институцийг тус тусад нь тодорхойлсон нь нийтлэг онол, зарчимтай харшилсан тул “Эрүүгийн хариуцлага” гэх нэр томъёог нэмж тусгах” гэж заасны дагуу 2015 оны Эрүүгийн хуульд хуулийн этгээдэд “ял оногдуулах” гэж хуульчилсан байсныг 2017 оны нэмэлт, өөрчлөлтөөр “эрүүгийн хариуцлага хүлээлгэх” болгон өөрчлөлт оруулсан.		
5.	5.1 дүгээр зүйл.Ялын зорилго 1.Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино. 4.Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.	5.1 дүгээр зүйл.Эрүүгийн хариуцлагын зорилго 5.Хуулийн этгээдэд гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, гэмт хэргийн шинж, хохирол, хор уршгийн хэмжээг харгалзан энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

6.	9.1 дүгээр зүйл.Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл 2.Хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө шийдвэр гаргаж, зөвшөөрөл өгч энэ хуульд заасан гэмт хэргийг бусдаар үйлдүүлсэн, эсхүл хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө өөрийн үйлдэл, эс үйлдэхүйгээр энэ хуульд хуульд заасан гэмт хэргийг үйлдсэн бол энэ хуульд заасан ял оногдуулна. 3.Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн бол тухайн хунийг ялаас чөлөөлж хуулийн этгээдэд ял оногдуулах бөгөөд энэ үйлдэлд нь өөр гэмт хэргийн шинж байвал, тэр үйлдэл, эм үйлдэхүйгээр энэ хуульд заасан гэмт хэргийг үйлдсэн бол энэ хуульд заасан ял оногдуулна.	9.1 дүгээр зүйл.Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл 1.Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд ял оногдуулахаар заасан гэмт хэргийн шинжийг хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа, эсхүл хамтран шийдвэр гаргаж, эсхүл хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хийсэн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан нь хуулийн этгээдэд ял оногдуулах үндэслэл болно. 2.Хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө шийдвэр гаргаж, зөвшөөрөл өгч энэ хуульд заасан гэмт хэргийг бусдаар үйлдүүлсэн, эсхүл хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй үйлдэл, эс үйлдэхүйгээр энэ хуульд заасан гэмт хэргийг үйлдсэн бол энэ хуульд заасан ял оногдуулна. 3.Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан журмын дагуу хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргасан, зөвшөөрөл өгсөн эрх бүхий албан тушаалтныг ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй. 4.Гадаад улсын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар Монгол Улсын нутаг дэвсгэрт гэмт хэрэг үйлдсэн бол энэ хуульд заасан хуулийн этгээдийн нэгэн адил эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.
7.	9.2 дугаар зүйл.Хуулийн этгээдэд оногдуулах ялын төрөл 1.Гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд дараах ял оногдуулна: 1.1.торгох ял. 1.2.эрх хасах ял; 1.3.татан буулгах ял.	9.2 дугаар зүйл.Хуулийн этгээдэд оногдуулах эрүүгийн хариуцлагын төрөл 1.Гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд дараах ял оногдуулна: 1.1.торгох ял. 1.2.эрх хасах ял; 1.3.татан буулгах ял. 2.Шүүх энэ хуулийн 5.1 дүгээр зүйлд заасан зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд оногдуулсан ял дээр нэмж дараах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно: 2.1.эрх хасах албадлагын арга хэмжээ; 2.2.татан буулгах албадлагын арга хэмжээ; 2.3.хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ.
2015 оны Эрүүгийн хуулийг батлахдаа хуулийн этгээдэд торгох, эрх, хасах, татан буулгах гэсэн 3 төрлийн ял оногдуулахаар зохицуулсан байсан бөгөөд 2017 оны нэмэлт, өөрчлөлтөөр зөвхөн торгох ял оногдуулахаар болсон. Хэрэв шүүх эрүүгийн хариуцлагын зорилгыг хангахад шаардлагатай гэж үзвэл гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд оногдуулсан ял дээр нэмж эрх хасах, татан буулгах, хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ хэрэглэж болохоор нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.		

8.	9.3 дугаар зүйл.Торгох ял 1.Энэ хуульд заасан тохиолдолд арван мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр хуулийн этгээдэд торгох ял оногдуулна. 9.4 дүгээр зүйл.Эрх хасах албадлагын арга хэмжээ 1. Энэ хуульд заасан тохиолдолд нэг жилээс найман жил хүртэл хугацаагаар хуулийн этгээдэд нэг, эсхүл хэд хэдэн төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарлах, эсхүл эрх хасах ял оногдуулна. 9.5 дугаар зүйл.Татан буулгах албадлагын арга хэмжээ 1. 1.Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдийг татан буулгах ял оногдуулна.	9.4 дүгээр зүйл.Эрх хасах албадлагын арга хэмжээ 1.Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нэг жилээс найман жил хүртэл хугацаагаар хуулийн этгээдэд нэг, эсхүл хэд хэдэн төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарлах, эсхүл эрх хасах албадлагын арга хэмжээ хэрэглэнэ. 9.5 дугаар зүйл.Татан буулгах албадлагын арга хэмжээ 1.Энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдийг татан буулгах албадлагын арга хэмжээ хэрэглэнэ. 3.Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар нь гэмт хэрэг үйлдсэн бол салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгаж болно. 9.6 дугаар зүйл.Хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ 2.Хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг хэрэглэхдээ энэ хуулийн 7.5 дугаар зүйлд заасан журмыг баримтална.
2017 оны нэмэлт, өөрчлөлтөд заасны дагуу Эрүүгийн хуулийн 9.2 дугаар зүйл буюу Хуулийн этгээдэд зөвхөн торгох ял оногдуулахаар заасан, мөн эрүүгийн хариуцлагын зорилгыг хангахын тулд 3 төрлийн албадлагын арга хэмжээг хэрэглэж болохоор зохицуулсан. Мөн хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар гэмт хэрэг үйлдсэн бол энэ хуулийн этгээдийн нэгэн адил эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан.		
9.	-	9.7 дугаар зүйл.Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага гарцаагүй байх 4.Энэ зүйлд заасан хуулийн этгээд өөрчлөн байгуулагдахаас өмнө тухайн гэмт хэргийн талаар мэдсэн эсэхээс нь үл хамааран эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.
Шинээр нэмсэн.		

Хавсралт 2. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтад оруулсан нэмэлт, өөрчлөлт

Д/д	2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга	2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн нэмэлт, өөрчлөлт	2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн нэмэлт, өөрчлөлт
1.	15.5 дугаар зүйл.Хууль бусаар үр хөндөх 4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	15.5 дугаар зүйл.Хууль бусаар үр хөндөх 4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	
2.	18.2 дугаар зүйл.Валют, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшид нөлөөлөх 3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	18.3 дугаар зүйл.Татвар төлөхөөс зайлсхийх 1.Татвар төлөгч хувь хүн, хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан татвар төлөхөөс зайлсхийх зорилгоор их хэмжээний татвар ногдох орлого, эд хөрөнгө, бараа үйлчилгээг зориуд худал тодорхойлсон, нуусан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.	18.1 дүгээр зүйл.Зах зээл дэх монополь, давамгайл байдлаа хууль бусаар ашиглах 3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
3.	18.6 дугаар зүйл.Мөнгө угаах 4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	18.10 дугаар зүйл.Зориуд, зохиомлоор дампуурах 2.Хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан, үүсгэн байгуулагч зээлийн өр төлөхийг хойшлуулах, түүнийг төлөх нөхцөлийг хөнгөрүүлэх, зээлийн өрийн хүүг багасгах, төлөхгүй байхын тулд төлбөрийн чадваргүй болсон гэж харилцагч талд мэдэгдэж, дампуурлын хэрэг үүсгэх хүсэлт гаргаж зохиомлоор дампуурсны улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас	18.5 дугаар зүйл.Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх 5.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хоёр зуун мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

		нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	
4.	18.7 дугаар зүйл.Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах 4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	18.11 дүгээр зүйл.Хууль бусаар дампууруулах 1.Дампууруулах ноцтой үндэслэл бий болоогүй байхад хүчээр, хууран мэхэлж, гарцаагүй байдалд оруулж дампууруулсан; хуулийн этгээдийн талаар хуурамч мэдээлэл тарааж, гүтгэж, зориуд өр төлбөрөө өгөхгүй байж дампуурахад хүргэсэн; төрийн албан хаагч төрөөс үзүүлэх ёстой үйлчилгээг хуулийндагуу үзүүлээгүй, зохих ёсоор бүртгээгүй, тусгай зөвшөөрлийг үндэслэлгүйгээр цуцалсан, үндэслэлгүйгээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг үндэслэлгүйгээр хугацаа хоцроож олгосны улмаас хуулийн этгээд дампуурсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	
5.	18.8 дугаар зүйл.Үнэт цаасны зах зээлийн дотоод мэдээллийг хууль бусаар ашиглаж, арилжаанд оролцох 4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	18.13 дугаар зүйл.Банк хууль бусаар байгуулах, банкны төлбөрийн чадвар алдагдуулах 4.Энэ зүйлд заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	

6.	18.9 дүгээр зүйл.Үнэт цаасны зах зээлийг урвуулан ашиглах 4.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	18.14 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх 1.Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх зорилгоор нийгмийн даатгалын шимтгэл ногдох их хэмжээний орлогыг нуусан, худал мэдүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.	18.18 дугаар зүйл. Үндэсний төлбөрийн с и с т е м и й н зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааг хууль бусаар эрхлэх 5.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ
7.	20.4 дүгээр зүйл.Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар эзэмших 2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	20.4 дүгээр зүйл.Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар эзэмших 2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	20.7 дугаар зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах 5.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
8.	20.5 дугаар зүйл.Галт зэвсэг хууль бусаар бэлтгэх 2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	20.5 дугаар зүйл.Галт зэвсэг хууль бусаар бэлтгэх 3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ	

9.	20.6 дугаар зүйл.Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хамгаалахад хайнга хандах 3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	20.6 дугаар зүйл.Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хамгаалахад хайнга хандах 3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	
10.	20.8 дугаар зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах 3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	20.8 дугаар зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах 3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	
11.	21.7 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх 2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	21.7 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд саад учруулах, зайлсхийх 2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	
12.	21.8 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн нэрийг хууль бусаар хэрэглэх 2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	21.8 дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн нэрийг хууль бусаар хэрэглэх 2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	
13.		22.5 дугаар зүйл.Хахууль өгөх 3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	

14.		22.12 дугаар зүйл.Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах 1.Хуулийн этгээдийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтан хувьдаа, бусдад давуу байдал тогтоох, ашиг хонжоо олох зорилгоор хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт, хэлцэл, дүрмээр олгогдсон албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас үлэмж хэмжээний хохирол учруулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	
15.	24.5 дугаар зүйл.Хууль бусаар ан агнах 3.Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	24.5 дугаар зүйл.Хууль бусаар ан агнах 3.Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	
16.	24.8 дугаар зүйл.Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх 2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	24.8 дугаар зүйл.Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх 2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	
17.	25.3 дугаар зүйл.Соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх 2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	25.3 дугаар зүйл.Соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх 2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	

18.	25.5 дугаар зүйл.Соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах 3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	25.5 дугаар зүйл.Соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах 3.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	
19.	27.9 дүгээр зүйл.Замын байгууламжийн ашиглалт, засварын аюулгүй байдлын журам зөрчих 2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	29.8 дугаар зүйл.Террорист үйлдэл хийх 2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг албадан татан буулгана.	
20.		29.9 дүгээр зүйл.Террорист үйлдэлд бэлтгэх 2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг албадан татан буулгана.	

№	2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт	2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн нэмэлт, өөрчлөлт
1.	29.3 дугаар зүйл.Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх 2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	29.10 дугаар зүйл.Терроризмыг санхүүжүүлэх 4.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2.	29.11 дүгээр зүйл.Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх 2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.	29.11 дүгээр зүйл.Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх 2.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, хуулийн этгээдийг албадан татан буулгана.

Хавсралт 3. Анкетын асуулга

Зорилго: Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн “Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх” асуудлын хүрээнд дүн шинжилгээ хийж байгаа бөгөөд хуулийн уг зохицуулалт бодит байдал дээр хэрхэн хэрэгжиж байгаа, хэрэгжүүлэх явцад хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэхийг тогтоох зорилготой.

Асуулт 1. Таны харьяалах байгууллага, албан тушаал?

А. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч

Б. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч

В. Эрүүгийн хэргийн хяналтын шатны шүүхийн шүүгч

Асуулт 2. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь Таны бодлоор зөв эсэх?

А. Зөв

Б. Зарим талаараа зөв

В. Буруу

Асуулт 3. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй Эрүүгийн хуулийн өнөөгийн зохицуулалтаар хуулийн этгээдтэй холбоотой гэмт хэргийг бууруулж чадна гэж Та үзэж байна уу?

А. Тийм

Б. Үгүй

В. Хэлж мэдэхгүй байна

Асуулт 4. Эрүүгийн хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш 3 жил гаруй хугацаа өнгөрчээ. Гэтэл шүүхээр хуулийн этгээдтэй холбоотой хэрэг маш цөөн шийдвэрлэгдсэн байгаа шалтгаан юунд байна вэ?

.....

.....

Асуулт 5. Хуулийн этгээдэд оногдуулж буй эрүүгийн хариуцлагын төрлийн талаар Таны бодол ямар байдаг вэ? Тухайлбал, оногдуулж буй торгуулийн хэмжээ бага ... гм.

.....

.....

Асуулт 6.Хуулийн этгээдтэй холбоотой ямар гэмт хэрэгт Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэх шаарлагатай гэж Та үзэж байна вэ?

.....

.....

Асуулт 7. Таны бодлоор хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд тулгамдаж буй ямар асуудал байна вэ?

.....

.....

Асуулт 8. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг боловсронгуй болгох талаар Таны санал?

.....
.....

Бидний ажилд туслалцаа үзүүлж асуултад үнэн зөв хариулт өгсөн танд баярлалаа.

Энэхүү асуулгыг зөвхөн судалгаанд ашиглах болно.

**ХОЁР. ХОХИРЛЫН САНГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН
СУДЛАХ СУДАЛГАА**

Судалгааг удирдсан:

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.Jur.) Х.Эрдэм-Ундрах

Судалгааны багийн бусад гишүүд:

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (LL.D) С.Сүхбаатар
Эрдэм шинжилгээний ажилтан З.Мөнгөлжин

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Оршил хэсэгт "... хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж..., эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно..." хэмээн онцолж, даяар олноо зарлан тунхагласан. Түүнчлэн тус хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төр нь хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.." хэмээн зааснаар төрийн хариуцлагын механизмыг Үндсэн хуульдаа бэхжүүлэн тогтоожээ. Үндсэн хуульд ийнхүү хуульчилснаар төрөөс иргэдийн өмнө хүлээж буй үүргийн биелэлтэд үнэлэлт, дүгнэлт өгөх эрх зүйн үндэслэл бүрдсэн. Иймд төрийн зүгээс иргэдийнхээ зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх нэг хэлбэр болох гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг шийдвэрлэх, арилгах буюу нөхөн төлүүлэх асуудал эрх зүйн болоод нийгмийн өнөөгийн тулгамдсан асуудал болж байгааг энэхүү судалгааны үндэслэл болгов.

Гадаадын улс болгон өөрсдийн нийгэм, эдийн засгийн онцлог, онол, үзэл баримтлалд тулгуурлан хохирлыг төрөөс барагдуулах тухай тусгай хууль тогтоомжтой байдаг. Харин Монгол Улсад төрөөс хохирол нөхөн төлөх арга хэлбэр, зохицуулалтыг нарийвчлан тусгасан нэгдсэн хууль тогтоомж байхгүй тул эрх зүйн орчныг боловсронгуй болгох үүднээс хохирлын сангийн тухай хууль тогтоомжийг боловсруулах хэрэгцээ, шаардлага байна. Хохирлын сангийн хуулийн төслийн зорилго нь тодорхой хүрээнд хохирогчдын эрх ашгийг хамгаалах үүднээс хохирлын сангийн шалгуур үзүүлэлт, үйл ажиллагаа, удирдлагыг боловсронгуй болгож, ил тод байдал, хяналтыг сайжруулахад чиглэгдэнэ. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлд "Хууль санаачлагч хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлана" гэж заасныг удирдлага болгож Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалын дагуу Хохирлын сангийн тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тандан судаллаа.

Судалгааны зорилго

Хохирлын сангийн тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах ажлын зорилго нь хохирогчдын эрх ашгийг хамгаалах, хохирсон эрхийг нь сэргээх, хохиролд нөхөн төлбөр олгох эрх зүйн орчинг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагыг тодорхойлоход оршино. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулахад төрийн санд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, Хохирлын сангийн тухай хуулийн төслийг боловсруулах шаардлага бий эсэхийг тодруулахыг зорилоо. Түүнчлэн эерэг болон сөрөг талыг харьцуулан судалсны үндсэн дээр үр нөлөөг урьдчилан тооцож, уг асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг санал болгоход судалгааны зорилго мөн чиглэнэ.

Судалгааны арга зүй

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал"-ыг баримталж, дараах үе шатын дагуу энэхүү судалгааг гүйцэтгэв. Үүнд:

1. Асуудалд дүн шинжилгээ хийх;
2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томьёолох;
3. Тухайн асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
4. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах;
5. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх;
6. Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх;
7. Зөвлөмж боловсруулах.

Дээрх дарааллын дагуу, нэгдүгээрт “хохирлын сан”- тай холбоотой ойлголт, холбогдох харилцааг судалж, үүсэж буй асуудлыг тодорхойлохыг зорьсон. Үүний тулд Монгол Улсын болон бусад орны хууль тогтоомж, олон улсын байгууллагаас гаргасан баримт бичиг, олон улсын гэрээ, холбогдох ном сурах бичиг, өмнө нь хийгдсэн судалгаа, судалгааны тайлан, илтгэл, эрдэм шинжилгээний өгүүллийг уншиж судлан, харьцуулалт хийх болон бусад статистик мэдээллийг ашигласан бөгөөд асуудлын мөн чанар, түүний цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй нийгмийн бүлэг болон тухайн асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцлийг тус тус тодорхойлов.

Үүний дараа асуудлыг шийдвэрлэх ерөнхий зорилгоо томьёолж, тухайн зорилгод хүрэх хувилбарыг тогтоосон. Судалгааны тухайн үе шатанд, асуудлыг шийдвэрлэх хувилбаруудыг зорилгод хүрэх байдлаар нь харьцуулан дүгнэж, хамгийн оновчтой хувилбарыг сонгон авч үр нөлөөг судлав. Эцэст нь сонгон авсан хувилбарт үндэслэн дүгнэлт хийж, зөвлөмж боловсрууллаа.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллага /цаашид “НҮБ”/-д гишүүнээр элссэнээс хойш НҮБ, түүний төрөлжсөн байгууллагуудаас баталсан хүний эрхийн талаарх олон улсын 30 гаруй гэрээнд нэгдэн орж, гэрээгээр хүлээсэн үүргээ сахин биелүүлж ирсэн. Үүний дотор хохирогчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой хэд хэдэн олон улсын хэм хэмжээ бий бөгөөд тэдгээр нь хохирлыг төрөөс нөхөн төлүүлэхтэй холбоотой үндэсний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хэрэгжилтийг сайжруулахад нэн тэргүүний ач холбогдолтой юм.

ИБУТЭТОУП-д төр иргэнийхээ эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг нь сэргээх үүргийг хариуцах талаар заасан¹. НҮБ-аас 2005 онд баталсан «Олон улсын хүний эрхийн эрх зүйн их хэмжээний зөрчил, хүмүүнлэгийн эрх зүйн ноцтой зөрчлийн улмаас хохирсон этгээдийн хохирлоо нөхөн төлүүлэх эрхийн талаарх үндсэн зарчмууд»-д зааснаар буруутай этгээд нь хохирогч, түүний гэр бүл, асрамжинд байсан хүмүүст учруулсан хохирлыг шударгаар арилгах, хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг баталгаажуулах, төрөөс хохирогчийн бие махбод, сэтгэл санаа, зан суртахуунд учирсан хохирол, ажил хөдөлмөр, сургууль боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээ зэрэг алдагдсан нөхцөл, бодит болон бий болох орлого, хууль зүй, сэтгэл зүй, эмнэлэг, нийгмийн үйлчилгээний зардлыг бүрэн, шуурхай

1 Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 1966 он.

барагдуулах нөхцөл бололцоогоор хангах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэхийг оролцогч улсуудад зөвлөхийн зэрэгцээ хэрэгжүүлж ажиллахыг шаарддаг².

Мөн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор «Эрх мэдлээ урвуулан ашигласан болон гэмт хэргийн хохирогчдын талаарх үндсэн зарчмын тухай тунхаглал» батлагдсанаар дэлхийн улс орнууд өөр өөрсдийн онцлогт тохирсон хохирогчийн эрх ашгийг хамгаалах бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх эрх зүйн гол үндэслэл бий болсон³. Тус тунхаглалын 3.3-т «төрийн албан тушаалтан болон төрийг төлөөлж албан үүрэг гүйцэтгэж буй этгээд үндэснийхээ хууль тогтоомжийг зөрчиж, эрх мэдлээ урвуулан болон хэтрүүлэн ашигласан бол хохирогч төрөөс нөхөн төлбөр авах эрхтэй. Тухайн хохирлыг хариуцах Засгийн газар нь өөрчлөгдсөн тохиолдолд тухайн асуудлыг хариуцах байгууллага хохирлыг барагдуулна»⁴ хэмээн төрийн буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирлыг иргэд нэхэмжлэх эрхийг мөн тунхаглан бэхжүүлж, төр хохирлыг нөхөн барагдуулах зарчмыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн байна. Мөн тус тогтоолын хавсралт болох “Гэмт хэрэг, хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах үндсэн зарчим”-ын 14-17 дахь хэсэгт хохирогчид үзүүлэх тусламжааны асуудлыг дараах байдлаар тусгасан.⁵ Үүнд:

- “Хохирогч нь эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний хүртээмжийн болон бусад тусламжийн талаар мэдээлэл авах, тэдгээр үйлчилгээ, тусламжийг хүртэх ёстой.”;
- “Хохирогчид тусламж үзүүлэх, үйлчлэхдээ тийнхүү учирсан хохирлын шинж байдалд тохируулахад анхаарал хандуулах хэрэгтэй” хэмээн тус тус заасан нь төр иргэдийнхээ өмнө хохирлыг үнэлэх, нөхөн барагдуулах бодлого баримтлахаас гадна, тэр талаар нийтэд сурталчлан таниулж, хохирогчийн хохирлоо нөхөн төлүүлэх боломж бололцооны талаар мэдээлэл авах эрхийг хангах талаар чиглэл өгсөн гэж үзэхээр байна⁶.

НҮБ-аас энэхүү зарчим, стандартыг тогтоохдоо “гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчтой шударга харьцах”, “гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийг хамгаалалтын механизмд хамааруулах боломжоор хангах”, “мэдээлэл гаргаж өгөх эрхээр хангах, өшөө авалт, айлган сүрдүүлэлтээс хамгаалах”, “хохирогчийн эрхийг хамгаалах”, “хохирогчийн эрхийг хамгаалах албан бус механизм ажиллуулах”, “хохирол арилгуулах, нөхөн төлбөр, нийгмийн халамжийн тусламж авах эрхээр хангах” зэргийг тулгуур үндэслэл болгосон. Үүнд энэхүү судалгааны үндсэн объект болох хохирол арилгуулах асуудал багтсан байна. Уг зарчмыг дэлгэрүүлэн дүн шинжилгээ хийж үзэхэд гэмт хэргийн улмаас учирсан бие махбодийн ба сэтгэцийн гэмтэл, сэтгэл санааны хор уршиг, алдагдсан орлого, эмчилгээний төлбөр, мөн төрөөс тогтоосон нийгмийн халамжийн тогтолцооноос нөхөн төлбөр авах чиглэл,

2 Олон улсын хүний эрхийн эрх зүйн их хэмжээний зөрчил, хүмүүнлэгийн эрх зүйн ноцтой зөрчлийн улмаас хохирсон этгээдийн хохирлоо нөхөн төлүүлэх эрхийн талаарх үндсэн зарчмууд, 2005 он.

3 Эрх мэдлээ урвуулан ашигласан болон гэмт хэргийн хохирогчдын талаарх үндсэн зарчмын тухай тунхаглал, <http://www.un.org/documents/ga/res/40/a40r034.htm>.

4 Мөн тэнд.

5 Гэмт хэрэг, хүчирхийллийн хохирогчдыг хамгаалах үндсэн зарчим.

6 Эрх мэдлээ урвуулан ашигласан болон гэмт хэргийн хохирогчдын талаарх үндсэн зарчмын тухай тунхаглал, 1985. Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power <http://www.un.org/documents/ga/res/40/a40r034.htm>

хандлагыг олон улсын түвшинд тогтоожээ. Эдгээр зарчим нь хууль, олон улсын гэрээний хэм хэмжээний адил заавал дагаж мөрдөх шаардлагагүй боловч НҮБ-аас тогтоосон бусад норм, стандарттай адилтган үзэх боломжтойн зэрэгцээ уг зарчим нь гэмт хэргийн улмаас хохирсон этгээдийн эрхийг хангахад баримтлах үндсэн стандарт болж байгаа юм.⁷

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхтэй” хэмээн хохирогчийн эрх ашгийг баталгаажуулсан байна. Мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн зааж төрийн хариуцлагын эрх зүйн үндсийг шууд тусгасан юм. Харин төрийн хариуцлагын эрх зүйн ерөнхий зохицуулалтыг Үндсэн хуулийн зарчимтай уялдуулах, төрийн хариуцлагын механизмыг нэг цогц болгон хууль хэрэглэгчдэд хүргэх, албан тушаалтны учруулсан гэм хорыг зөвхөн судлах бус, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн барагдуулах зохицуулалттай холбон судалж, нэгдсэн системтэй ойлголтод хүрэх зорилгоор нэгдсэн хууль тогтоомжтой болох шаардлага тулгарч байна⁸.

Дэлхий нийтэд түлхүү хөгжөөд буй төрийн хариуцлагын эрх зүйн судлагдахуун нь төрийн зүгээс иргэдийн эрхийг хөндсөн, тэдний эрхэд халдсан үйлдлийн үр дагаврыг хэрхэн арилгах тухай онол, үзэл баримтлал бөгөөд нийтийн эрх зүйн салбар дахь хохирлыг нөхөн төлүүлэх, нөхөн олговор олгох явдал голлох байр суурийг эзэлнэ⁹. Өнөөгийн байдлаар манай улсад төрийн хариуцлагын асуудал нэгэн цогц эрх зүйн салбар болж хараахан хөгжөөгүй байгаа бөгөөд түүхэн хөгжлийн болон агуулгын үүднээс авч үзвэл өөр хоорондоо ихээхэн ялгаатай байдлаар хууль тогтоомжид тусгалаа олсон байна. Бусдын хууль бус үйлдлийн улмаас учруулсан хохирлыг төрөөс нөхөн төлүүлэхтэй холбоотой асуудлыг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн холбогдох заалтуудаар зохицуулсан. Эдгээр нь хоорондоо зөрчилтэй, харилцан уялдаагүй байгаа нь төрийн хариуцлагыг ил тод бус, хийдэл цоорхойтой болгож байгаа тухай профессор Б.Чимид онцлон тэмдэглэжээ.

Доктор (Ph.D) Ч.Нямсүрэн гэм хорыг арилгах, хохирлыг нөхөн төлөх нь агуулгын хувьд адил бөгөөд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах арга замыг 1) хохирогчид учруулсан эдийн хохирлыг гэмт хэрэг үйлдсэн болон түүнийг хариуцвал зохих гуравдагч этгээдээс нөхөн сэргээлгэх буюу төлүүлэх; 2) гэмт хэрэг үйлдсэн этгээд нь тодорхойгүй, төлбөрийн чадваргүй бол төр болон даатгалын байгууллагаас нөхөн олговор олгох гэсэн хоёр үндсэн хэлбэртэй бөгөөд хохирол арилгах нь эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх хамгийн чухал элемент төдийгүй цаашид эрх зүйн зөрчил дахин гарахаас урьдчилан сэргийлэх чухал үүрэг гүйцэтгэнэ

7 Г.Оюунболд, Нөхөн сэргээх хандлагад суурилсан эрүүгийн эрх зүйн шинэчлэл, хохирол нөхөн барагдуулах үндэсний тогтолцоо бүрдүүлэх нь, Хууль дээдлэх ёс, 2018, №1 (66).

8 Б.Батболд, Гэмт хэргийн улмаас иргэний амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах талаарх үзэл баримтлал, Хууль дээдлэх ёс, 2020, №3.

9 Мөн тэнд.

гэжээ.¹⁰ Академич С.Нарангэрэл “Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг” бүтээлдээ нөхөн олговрыг (compensation) нөхөн төлбөртэй адилхан утга агуулгатай гэж үзсэн байх бөгөөд “хуульд үндэслэн эсхүл хуулийн дагуу иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг төрөөс арилгах арга хэмжээ” хэмээн тусгайлан тодорхойлсон¹¹.

Монгол Улс НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор баталсан «Эрх мэдлээ урвуулан ашигласан болон гэмт хэргийн хохирогчдын талаарх үндсэн зарчмын тухай тунхаглал» -д тулгуурлан Монгол Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 41 дүгээр тогтоолоор “Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийг баталсан¹². Энэхүү хөтөлбөрийн хоёрдугаар бүлгийн 2.1.5-д:

Зохих сан бий болгох, иргэдийг гэмт халдлагаас хамгаалах даатгалд хамруулах гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эдгээр эх үүсвэрийг бүрдүүлж, эхний ээлжид хариуцагч нь тодорхойгүй, эсхүл төлбөрийн чадваргүй иргэдийн хохирлыг төр урьдчилан төлж, хариуцагчаар нөхөн төлүүлэх журмыг хуулиар тогтоон хэрэгжүүлж цаашид боловсронгуй болгоно;

Гэмт этгээдийн үйлдсэн хэргийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх нөхцлийг бий болгох үүднээс хоригдлыг ажлаар хангах, тэдний хийж гүйцэтгэсэн ажлын хөлсийг ижил төрөл, хэмжээний ердийн ажил, үйлчилгээний хөлс, үнэлгээний дунджаас багагүй байхаар тогтоохын зэрэгцээ тэдэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ гэж заасан.

Улмаар 2007 оноос хойш гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчдын эрхийг хангах асуудалд төрөөс анхаарал хандуулж, Монгол Улсын Их Хурлаас зарим хуулиуд, тухайлбал, 2007 оны 8 дугаар сарын 3-ны өдөр Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хууль, 2010 оны 12 дугаар сарын 2-ны өдөр Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг тус тус баталсан. Эдгээр хуульд гэмт хэргийн улмаас олноор хохирсон хохирогч болон зарим төрлийн гэмт хэргийн улмаас хохирсон хохирогч нарт учирсан хохирлыг эхний ээлжинд төр хариуцан барагдуулахаар зохицуулсан нь дэвшилттэй боловч учирсан хохирлын бодит хэмжээгээр нөхөн төлбөр олгохоор хуульчилсан, мөн цөөн хэдэн төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төр барагдуулахаар, хохирлыг зөвхөн эдийн хохирлоор хязгаарласан нь “бодит хохирлыг барагдуулах” зарчимд нийцээгүйн дээр Үндсэн хуулиар иргэнд олгосон “хохирол нөхөн төлүүлэх эрх”, “хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх” зарчмыг алдагдуулсан. Гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх, учирсан хохирлыг арилгуулах талаарх заалт холбогдох хуульд хангалттай байгаа мэт боловч эдгээр нь зөвхөн тунхаглалын шинжтэй, хэрэгжих механизм нь тодорхой бус байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлд зааснаар олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчим болон Монгол Улсын олон улсын гэрээ нь тус улсын эрх зүйн тогтолцооны нэг хэсэг бөгөөд Монгол Улс олон улсын эрх зүйн үндсэн зарчмуудын нэг болох “гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх” зарчмыг баримтлах талаар Үндсэн хуулийн мөн зүйлийн 2 дахь хэсэгт заасны хувьд, хохирогч төрөөс нөхөн төлбөр авах журмыг зохицуулах шаардлага зүй ёсны юм. Иймд дотоодын хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтыг

10 Ч.Нямсүрэн, Гэмт хэргийн виктимологи /хохирогч судлал/, 2005, 457-458 дахь тал.

11 С.Нарангэрэл, Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, 2021, 247 дахь тал.

12 <https://legalinfo.mn/mn/detail/6265/2/203225>


олон улсын гэрээнд нийцүүлэх шаардлага тулгамдаж байна. Үүнийг харгалзан, олон улсын эрх зүйн зарчмуудад хамаарах асуудал манай улсын хууль тогтоомжид хэрхэн тусгагдсан талаар дэлгэрүүлэн авч үзэхээс гадна дээр дурдсан эрхийн хэрэгжилтийн төлөв байдалд дүн шинжилгээ хийв.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн барагдуулах эрхийн хэрэгжилт

Хүснэгт 2.1. 2017, 2018 онд гэмт хэргийн улмаас учирсан хохирлын талаарх тоон мэдээ¹³ (он тус бүрээр)

Хохирогч бүгд	Иргэн	Үүнээс		Хуулийн этгээд	Учирсан хохирол бүгд (сая. төг)	Нөхөн төлүүлсэн (сая.төг)
		Нас барсан	Гэмтсэн			
2017	37,259	37,173	1,129	86	198.07 тэрбум	74.5 тэрбум
2018	33,623	33,566	938	57	193.3 тэрбум	32.4 тэрбум

График. 2.1. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлтийн хэмжээ (2018)



Монгол Улсад 2012 оноос эхэлсэн эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн үндсэн чиглэлийн нэг нь хохирогч хамгаалах, хохирол барагдуулах тогтолцоо бүрдүүлж хэрэгжүүлэх асуудал хэдий ч төдийлөн биелэлээ олохгүй байна. Тухайлбал, Монгол Улсын хэмжээнд 2017, 2018 онд бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас хохирсон иргэн, хуулийн этгээдийн талаарх тоон мэдээллийн үзүүлэлтийг харахад Монгол Улсын хэмжээнд 2017 онд гэмт хэргийн улмаас 37,173 иргэн, 86 хуулийн этгээд хохирч, үүнээс 1,129 хүн нас барж, 10,513 хүн гэмтсэн байна. Үүнээс нийт 198.07 тэрбум төгрөгийн хохирол учирснаас зөвхөн 37%-ыг барагдуулсан байна¹⁴. Харин 2018 онд 36,620 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд гэмт хэргийн улмаас 33,566 хүн, 57 хуулийн этгээд хохирч, үүнээс 934 хүн нас барж, 9,283 хүн гэмтсэн байна. Гэмт хэргийн улмаас 193.3 тэрбум төгрөгийн хохирол учирч, үүнээс 32.4 тэрбум буюу зөвхөн 14

13 Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, www.1212.mn.

14 Нээлттэй нийгэм форум, Хохирлын үндэсний тогтолцоо: Монгол Улсад гэмт хэргийн хохирлыг үнэлж, тогтоож, нөхөн төлүүлж буй нөхцөл байдал, 2020.

хувийг нөхөн төлүүлжээ¹⁵. Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйл “Хүнийг алах” гэмт хэргийн улмаас 2017 онд 191 хүн хохирч, гэмт хэргийн улмаас 529,622,715 төгрөгийн хохирол учирч 72 хувь буюу 381,562,715 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн бол 2018 онд 196 хүн хохирч, гэмт хэргийн улмаас 948,082,000 төгрөгийн хохирол учирч 78.3 хувь буюу 742,032,000 төгрөгийн хохирол нөхөн төлөгджээ¹⁶.

График. 2.2. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, нөхөн төлүүлэлтийн хэмжээ (2019, 2020)



Статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас авсан дээрх мэдээллээс харахад 2019 онд Монгол Улсын хэмжээнд гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 21%-ийг, 2020 онд 24% -ийг тус тус нөхөн барагдуулсан байна. 2017 - 2020 он хүртэлх статистик, тоон үзүүлэлтээс харвал гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлөлт үндэсний хэмжээнд ердөө 15% - 25%-тай байна.

Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журмын хэрэгжилтийн хүрээнд гүйцэтгэх баримт бичигт бодит биелэлтийг нэмэгдүүлэх, сангаас олгосон мөнгөн хөрөнгийн эргэн төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж, гүйцэтгэсэн ажлын дүнг сар бүр ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид илтгэх хуудсаар танилцуулж ирсэн. Тус журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа бөгөөд эрх зүйн зохицуулалтын хүрээнд нөхөн төлбөрийг олгох сангийн удирдлага нь орон тооны бус “Сангийн зөвлөл” байхаар журамласан байна. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн улмаас хохирол учирч, гэм буруутай этгээдээр нөхөн төлбөр гаргуулахтай холбоотой, дээрх зохицуулалтын үйлчлэлд хамаарах шинээр гүйцэтгэх баримт бичиг, хохирогчийн хүсэлтийг үндэслэн “Орон тооны бус сангийн зөвлөл”-ийн хурлыг зохион байгуулдаг. Уг хурлыг зохион байгуулахаас өмнөх шатанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас нөхөн төлбөр хуваарилах гүйцэтгэх баримт бичиг, холбогдох материалыг сангийн зөвлөлийн даргад хүргүүлсний үндсэн дээр хурлын товыг тогтоон, зохион байгуулж ажилладаг байна. Нөхөн төлбөр хуваарилсан шийдвэрийн хэрэгжилтийг дараагийн товлосон хуралд танилцуулдаг бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны арга хэмжээнд тусгаж, эрх зүйн актын биелэлтийг улирал тутам гаргаж, дээд шатны байгууллагад тайлагнаж иржээ.¹⁷ Гэвч хэрэгжилтийн түвшин хэр байгааг доорхи статистик тоо баримтаас үзье.

15 Мөн тэнд, 36 дахь тал.

16 Мөн тэнд, 32 дахь тал.

17 Монгол Улсын Сангийн яам, “Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан”- гийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнгийн талаар, 2018, <https://mof.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/>.

График 2.3. Шийдвэр гүйцэтгэсэн байдал




Тухайлбал, хүн ам олноор төвлөрсөн нийслэлд 2018 оны 1 дүгээр сарын байдлаар шүүхийн шийдвэрийн биелэлтийг авч үзвэл, нийт 12,380 гүйцэтгэх баримт бичгийн 772,943,553.9 төгрөгийн хохирлоос 488 гүйцэтгэх баримт бичгийн 64,425,163.2 төгрөгийн хохирол төлөгдсөн нь нийт төлбөрийн дөнгөж 3.9 хувийг эзэлж байна.¹⁸ Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгосон гүйцэтгэх баримт бичигт 525939,0 мянган төгрөгийн үнийн дүнтэй 133 гүйцэтгэх баримт бичгийг бүртгэлд оруулж, 182 хохирогчдод төрөөс 714701.3 төгрөгийн нөхөн төлбөр олгосон. Нөхөн төлбөр олгосон гүйцэтгэх баримт бичигт 94 төлбөр төлөгчөөс 239905,3 төгрөгийг барагдуулснаас 194281,1 төгрөгийг гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох санд эргэн төвлөрүүлсэн. Хорих ял эдэлж буй төлбөртэй ялтны судалгааг гарган холбогдох хорих ангиудын захиргаанд хөдөлмөрийн хөлсний суутгал явуулж сар бүрийн эцэст тооцоо хийж байна¹⁹. Иймд нийслэлд, сүүлийн жилүүдийн тайлангаас харахад иргэний шүүхийн шийдвэртэй хохирол нөхөн төлөгдсөн байдал нь нийт биелүүлбэл зохих гүйцэтгэх баримт бичгийн дөнгөж 2 хувийг эзэлж байгаа бөгөөд төлбөр төлөгч төлбөрийн чадваргүй, оршин суух газар тодорхойгүй зэрэг шалтгаан нөхцлийн улмаас төлбөр авагчийн хуулийн дагуу хохирлоо төлүүлэх эрхийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

Тухайлбал, нийслэлийн хэмжээнд 2018 оны 1 дүгээр сарын байдлаар шүүхийн шийдвэр биелэгдэхгүй, удааширч байгаа шалтгааныг авч үзвэл 622 гүйцэтгэх баримт бичгийн 16,311,107.5 төгрөгийг төлөх төлбөр төлөгч нь төлбөрийн чадваргүй, 567 гүйцэтгэх баримт бичгийн 8,114,406.2 төгрөгийг төлөх төлбөр төлөгчийн оршин суугаа хаяг тодорхойгүй, 7,964 гүйцэтгэх баримт бичгийн 387,600,199.1 төгрөгийг төлөх төлбөр төлөгч нь бусад буюу төлбөр авагчтай эвлэрсэн, төлбөрөө бага багаар төлж байгаа, эд хөрөнгийг нь дуудлага худалдаагаар худалдан борлуулж байгаа, өндөр насны тэтгэврээсээ төлбөрөө бага хэмжээгээр төлдөг зэрэг шалтгаанаар төлбөрөө төлөөгүй²⁰ гэсэн тоон үзүүлэлт гарчээ.

18 Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас ирүүлсэн судалгаа, мэдээлэл, 2018.

19 Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны тайлан, 2019.

20 Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын ажиллагаанд байгаа гүйцэтгэх баримт бичгийн 2018 оны 1 дүгээр сарын мэдээ, 2018.

График 2.4. Шүүхийн шийдвэр биелэгдэхгүй удааширч буй шалтгаан

Хохирол нөхөн төлүүлэлт хангалтгүй байгаа шалтгаан нөхцлүүдийг дурдвал²¹:

- Хорих ялаас хөнгөвчлөх тохиолдолд хохирлыг нөхөн төлөхөөс бусад тохиолдолд хохирлыг нөхөн төлдөггүй;
- Хоригдлыг хөдөлмөр эрхлүүлэх ажлын байр хомс;
- Хоригдлын хөдөлмөр эрхэлсний хөлсийг хоригдлын хэрэгцээний төсөвт зарцуулдаг тул үүнээс хохирлыг нөхөн төлөх боломж байдаггүй;
- Гэм буруутай этгээд зохих ял шийтгүүлээд явсан учир хохирлоо нөхөн төлүүлээгүй;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын зүгээс ч хохирол нөхөн төлүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авдаггүй;
- Хохирогчид хохирлоо хэрхэн төлүүлэхээ мэддэггүй;
- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нар хохирлын асуудалд бус гэм бурууг нотлох асуудалд анхаарлаа чиглүүлдэгтэй холбоотой ЭХХШТХ-ийг хэрэгжүүлэх явцад хохирогчийн хохирол нөхөн төлүүлэх эрх төдийлөн хэрэгждэггүй, иргэний хэргийн журмаар хохирлын нэхэмжлэлээ шийдвэрлүүлж чирэгдэхэд хүрдэг;
- Гэмт хэрэг үйлдсэн этгээд төлбөрийн чадваргүй байдаг;
- Гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд олддоггүй;
- Хохирлын хэмжээ бага хэргийг Цагдаагийн байгууллага анхаарч үздэггүй;
- Эрхээ мэддэггүй учраас гэм буруутай этгээдээс эмчилгээний зардал гэх багахан мөнгийг аваад л салдаг;
- Цагдаагийн байгууллагын хүнд суртлаас болж хохирлоо нөхөн төлүүлж чадаагүй;
- Шүүх, цагдаагийн байгууллагаар явахад цаг их зарцуулж, чирэгдэл ихтэй байсан учраас хохирлоо төлүүлэлгүй орхисон;
- Гомдол гаргаагүй учир хэргийг хаалаа гэсэн үр дүнг хувьдаа зөвшөөрсөн;

21 Хууль зүйн үндэсний хүрээлэн, "Гэмт хэргийн улмаас учирсан хохирол" судалгааны тайлан, 2007.

Сэтгэл санааны хохирлыг тооцон үздэггүйгээс хохирлоо төлүүлж чадаагүй зэрэг олон шалтгааны улмаас хохирол нөхөн төлүүлэлт үндэсний хэмжээнд хангалтгүй байна. Ихэнх тохиолдолд хохирлоо нөхөн барагдуулж чадахгүй байгаа шалтгаан нөхцөлд цагдаагийн байгууллага хохирлыг анхаарч үздэггүй, хохирлоо хэрхэн нөхөн төлүүлэх тухай иргэдийн мэдлэг мэдээлэл хомс, гэмт этгээд төлбөрийн чадваргүй, гэмт этгээдийн оршин суугаа газар олддоггүй зэрэг шалтгаантай. Энэ тохиолдолд төрөөс нөхөн олговор олгох эрх зүйн боловсронгуй орчин шаардлагатай байгааг анхаарах нь зүйтэй.

2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөн Эрүүгийн хуулийн гол үзэл санаа болох хохирогчийн эрхийг хангах, хохирол хор уршгийг арилгах үзэл баримтлал бодитоор хэрэгжихгүй байгаа бөгөөд дээр дурдсан статистик тоо баримт нь үндэсний хэмжээнд маш хангалтгүй үзүүлэлт юм²². Эрүүгийн эрх зүйн онол болон холбогдох хууль тогтоомжид гэмт хэргийн улмаас хохирсон иргэд, хуулийн этгээдийн хохирол заавал нөхөн төлөгдөх, тодорхой хэмжээгээр хохирогчийн эрх эргэн сэргээгдэх ёстой гэсэн үзэл баримтлалд суурилдаг. Өөрөөр хэлбэл хохирогч халдлагад өртсөн учраас түүнд учирсан хохирлыг заавал нөхөн төлүүлж, хохирогчийг хэвийн хэмжээнд нь эргэн оруулах нь зүй ёсны хэрэг билээ. Гэмт хэрэг үйлдсэн гэмт буруутай этгээд хохирлыг нөхөн төлөх үүрэг нь зайлшгүй хэдий ч бодит байдалд хохирол барагдуулалт нь хангалттай хэмжээнд хүрдэггүй. Энэ тухай “Хүний эрхийн үндэсний форум-2021”-д Улсын дээд шүүхийн шүүгч Ч.Хосбаяр «Хүний эрх ба шүүх эрх мэдэл» сэдвээр илтгэл танилцуулахдаа “Шүүхийн шийдвэр, үндэслэл нь цаасан дээр байдаг бол биелэлт, хэрэгжилт нь хүний эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд шууд тусдаг. Шүүх шударга ёсыг тогтоосон ч энэ нь биеллээ олохгүй бол зөвхөн цаасан дээр үлдэж, шүүгчийн нөр их хөдөлмөрөөр тогтохгүй, хууль сахиулагч, прокурорын хичээл зүтгэл бүгд талаар болно» хэмээн үзэж буйгаа илэрхийлсэн²³. Иймд хохирол нөхөн төлүүлэх тогтолцоо муу байх нь иргэдийн эрх зүйн тогтолцоонд итгэх итгэлд маш муугаар нөлөөлж байгаа тул гэмт хэргийн хохирогчийн эрх ашгийг хамгаалах үүргийг хангах үүднээс төрөөс хохирлыг шаардлагатай тохиолдолд зайлшгүй барагдуулах боловсронгуй тогтолцоо ус агаар мэт дутагдаж буйг шүүгч, судлаачид онцлон тэмдэглэж байна.

НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс Монгол Улсын Засгийн газарт гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг бэхжүүлэхтэй холбоотой хэд хэдэн зөвлөмж өгсөн. Үүний дагуу Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолын хавсралтаар “НҮБ-ын хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-нд тусгаснаар “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах нөхөн төлбөрийн зардлыг улсын төсөвт тусгаж байх, эрүү шүүлт тулгах гэмт хэргийн хохирогчдод нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх зохицуулалт бий болгож, холбогдох шийдвэрийг үндэслэн хохирогчдын хохирлыг барагдуулах”²⁴ гэж заасан. Гэвч тус төлөвлөгөөний хэрэгжилт нь статистик, тоо баримтаас харахад тун хангалтгүй байгааг дурдах нь зүйтэй. Улмаар Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссоос 2018 онд УИХ-д өргөн барьсан «Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 дахь илтгэл»-д хохирол нөхөн

22 Нээлттэй нийгэм форум, “Гэрч, хохирогчийн хамгаалалт” бодлогын судалгааны тайлан 2019.

23 <https://ikon.mn/n/2emv?fbclid=IwAR36gwiaN-BDfMdxOnkVdMwJUxZmH9T7qBSvhhAlyPED52n55kgScp1ijD8>.

24 НҮБ-ын хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө, <http://www.mfa.gov.mn/old/wp-content/uploads/>.

төлүүлэх эрхийн асуудлыг нэг бүлэг сэдэв болгон хөндөж, тус эрхийн хэрэгжилттэй холбоотой 4 санал хүргүүлсний дотор “төр хариуцах төлбөрийн тухайн жилд шаардагдах зардлыг улсын төсөвт тусгах, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан хохирлыг тухай бүрт нь олгодог байх”²⁵ шаардлагыг тавьсан боловч бодит хэрэгжилтэд ахиц гарахгүй байна.

1.1 Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

Дээр дурдсан нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд дараах асуудал голлон анхаарал татаж байна. Үүнд:

- Төрөөс хохирогчдын хохиролд нөхөн төлбөр өгөх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ;
- Төрийн сангаас хохирол нөхөн төлүүлэхтэй холбоотой шийдвэрийг хэн, хэрхэн авч хэрэгжүүлж буй байдал;
- Хууль тогтоомжид тусгагдсан зохицуулалтын хэрэгжилт;
- Хохирлын сангийн хамрах хүрээ;
- Хохирлын сангаас нөхөн төлбөр авах эрх бүхий этгээд, тавигдах шалгуур;
- Хохирлын сангийн зохион байгуулалт, хяналт;
- Нөхөн төлбөр олгох гэмт хэргийн төрөл, ангилал.

Эдгээр асуудлыг харгалзан судалгааны цар хүрээг өргөн хүрээнд авч үзэх нь тохиромжтой юм.

1.2 Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох²⁶

Дээр тодорхойлсон цар хүрээтэй холбоотойгоор дараах нийгмийн бүлэг, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байна гэж үзлээ.

Хүснэгт 2.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөн байгаа нийгмийн бүлэг, иргэд

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
1 Хохирогч	Эрүүгийн эрх зүйн онол болон холбогдох хууль тогтоомжид гэмт хэргийн улмаас хохирсон иргэд, хуулийн этгээдийн хохирол заавал нөхөн төлөгдөх, тодорхой хэмжээгээр хохирогчийн эрх эргэн сэргээгдэх ёстой гэсэн үзэл баримтлалаар зохицуулагдсан байдаг. Өөрөөр хэлбэл хохирогч халдлагад өртсөн учраас түүнд учирсан хохирлыг заавал нөхөн төлүүлж, хохирогчийг хэвийн хэмжээнд нь оруулах явдал зүй ёсны юм. Гэмт хэрэг үйлдсэн гэмт буруутай этгээд хохирлыг нөхөн төлөх үүрэг нь зайлшгүй хэдий ч бодит байдалд хохирол барагдуулалт нь хангалттай хэмжээнд хүрдэггүй. Хохирлоо нөхөн төлүүлэх, нөхөн сэргээх эрхийг хуульчлан баталгаажуулсан боловч хэрэгжилтийн түвшин тун хангалтгүй байгаа нь хохирогчдын эрх зөрчигдөхөд хүргэж байна.

25 Хүний эрхийн үндэсний комисс, Хохирол нөхөн төлүүлэх эрхийн хэрэгжилтийн зарим асуудал» сэдвээр өглөөний уулзалт зохион байгууллаа, <https://nhrcm.gov.mn/>.

26 Аргачлалын 3.1.2- т “эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд”- ийг тодорхойлохоор заасан. Харин тус судлах зүйлийн хүрээнд “аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд”- ийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөөгүй тул энэхүү судалгааны 1.2 дахь хэсгийн нэршлээс эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөхгүй бүлгийг хассан болно.

		Түүнчлэн хохирол барагдуулах үндэсний тогтолцоог боловсронгуй болгож сайжруулан, хохирогчдын эрхийг сэргээхтэй холбоотой харилцааг зохицуулах утгаараа тэдгээрийн эрх ашиг хөндөгдөнө.
2	Хохирогчийн гэр бүлийн гишүүд	Хохирогчийн ар гэр шууд болон шууд бусаар давхар хохирол амсаж байдаг тул тэдний эрх ашгийг сэргээхтэй холбоотойгоор эрх зүйн орчныг сайжруулах, хохирлыг нөхөн барагдуулахтай холбоотой харилцааг зохицуулах тул хохирогчийн гэр бүлийн гишүүдийн эрх ашиг мөн хөндөгдөнө.

1.3 Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

А. Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх эрхийн хэрэгжилтийн асуудал

Гэмт хэргийн улмаас хүний амь бие, эрүүл мэндэд хохирол учирч, түүнийг нөхөн барагдуулахад шударга ёсны мөн чанар нь нийгмийн харилцаанд оролцогчид хуулийн өмнө эрх тэгш байх явдлаар илэрдэг. Ханс Кельзен “хүний эрх чөлөөг баталгаажуулсан нийгмийн тогтолцоо шударга ёсны үндэс мөн. Шударга ёс бол нийгэм дэх аз жаргал” хэмээн тодорхойлсон байна.²⁷

Гэвч төрөөс зөвхөн тухайлан заасан гэмт хэргийн улмаас учирсан хохиролд нөхөн төлбөр олгож, мөн хохирогчдод харилцан адилгүй нөхөн төлбөрийг олгож байна. Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журмын зорилго нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 213.2-т заасан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, хүнд гэмтэл учирсан хохирогчид нөхөн төлбөр олгохтой холбогдсон харилцааг зохицуулахаар заасан. Гэвч Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 132 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журам”-д зааснаар 2011 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогчид нэг удаа нөхөн төлбөр олгохоор заасан. Тухайлбал, хүнийг санаатай алах, бусдын бие махбодод хүнд гэмтэл санаатай учруулах, хүн хулгайлах, хүнийг барьцаалах, хууль бусаар хорих, хүн худалдаалах, хүчиндэх, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, зандалчлах, терроризм, эрүү шүүлт тулгах зэрэг 8 төрлийн гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн болон хүнд гэмтэл учирсан (хүчингүй болсон 2002 оны Эрүүгийн хуулийн заалт) хохирогчид олгох нөхөн төлбөрийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 213.2 дахь хэсэгт хуульчилжээ.

2019 онд Ерөнхий сайдын өгсөн чиглэлийн дагуу Засгийн газрын тусгай сангуудад шалгалт хийсэн байна²⁸. Гэмт хэргийн хохирлын төлбөрт олгосон дээрх мөнгийг зардлын ангиллаар нь нарийвчлан авч үзвэл²⁹:

- Хүнийг санаатай алах гэмт хэргийн хохирогч болсон 52 хүний оршуулгын зардалд 205.4 сая төгрөг олгохоор тооцсоноос 22.6 сая төгрөгийг нөхөн олгож 182.8 сая төгрөгийг олгоогүй;
- Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэргийн нөхөн төлбөрт 5 хүний эмчилгээний зардалд 10.6 сая төгрөг олгохоор тооцсоноос 1.2 сая төгрөгийг нөхөн олгож, 9.0 сая төгрөгийг төлөөгүй;

27 Мөн тэнд, 37 дахь тал.

28 http://www.buzznews.mn/news/156/single/22277?fbclid=IwAR25oouf0C6uJR0Ck5uD1nHnneKujRMx2ZjJj matelyP0yW31VdUdA0n_xc

29 Монгол Улсын Сангийн яам, Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнгийн талаар, 2018, <https://mof.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/>.

- Хүчиндэх гэмт хэргийн нөхөн төлбөрт 6 хүний эмчилгээний зардалд 17.3 сая төгрөг олгохоор тооцсоноос огт төлөгдөөгүй зэргээр дээрх 3 төрлийн гэмт хэргийн хохирлын нөхөн төлбөрт нийт 63 хүнд 233.3 сая төгрөг олгохоор тооцсоноос 23.9 сая төгрөгийг нөхөн олгож, үлдсэн 209.4 сая төгрөгийг олгоогүй байна.
- Хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын нөхөн төлбөрийг сангаас олгож байгаа ба нөхөн төлбөрийн хэмжээг хохирогч нас барсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөр олгох асуудлын хүрээнд холбогдох зардал гараагүй байна.

Нөхөн төлбөр хүсэх өргөдлийн маягтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас авах бөгөөд хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх тухай шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр болон гүйцэтгэх хуудсын хуулбар, өргөдөл гаргагч иргэний баримт бичгийн хуулбар болон хохирлыг ялтан буюу түүний хууль ёсны төлөөлөгч барагдуулаагүй, эсвэл дутуу барагдуулсныг нотлох баримтыг хавсаргах ёстой. Гэвч дээрх тохиолдлуудад иргэд төрөөс нөхөн төлбөр авах боломжийн талаар мэддэггүйн улмаас төрөөс хохирол барагдуулах тогтолцоо харилцан адилгүй явагдаж, зөвхөн өргөдөл гаргасан иргэнд нөхөн олгож иржээ. Гэмт хэргийн улмаас хүний амь бие, эрүүл мэндэд хохирол учирч түүнийг нөхөн барагдуулахад шударга ёсны зарчмыг баримтлах учиртай. Шударга ёсны мөн чанар нь нийтийн харилцаанд оролцогчид эрх тэгш хандах явдлаар илэрдэг. Гэвч гэмт хэргийн улмаас нөхөн төлбөр авах сангаас хохирогчид эрх тэгш байдлаар нөхөн төлбөр авч байгаа эсэх нь эргэлзээтэй байна.

Б. Хяналтын механизмын асуудал

Гэмт хэргийн хохирогчид олгох нөхөн төлбөрийн хэмжээ нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тодорхойлогдох бөгөөд гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийг шүүхийн шийтгэх тогтоолоор гэм буруутай болох нь тогтоогдсон этгээдээр санд буцаан төвлөрүүлэхээр хуульчилсан байдаг. Торгох ялын төлбөрийн 60 хувийг санд төвлөрүүлж байгаа ч шүүхийн шийдвэрээр тогтоогдсон торгох ялын төлбөрийг бүрэн хэмжээгээр төвлөрүүлж төсөвт оруулахаар зааж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, нөхөн төлбөр олгох ажлын явц, үр дүнг хагас жил тутам Засгийн газарт тайлагнах, нөхөн төлбөр олгоход шаардагдах хөрөнгийг ХЗДХ-ийн сайдын төсвийн багцад жил бүр тусган санхүүжүүлэхээр заасан байна. Гэвч тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, нөхөн төлбөр олгох ажлын явц, болон ялын төлбөрийг төсөвт бүрэн хэмжээгээр төвлөрүүлж чадаж байгаа эсэхэд тавих хяналт хангалтгүй байна гэж ээлжит хяналтаар тогтоогджээ³⁰. Мөн “Хохирогчид нөхөн төлбөр олгох үйл ажиллагаатай холбоотой маргаан үүссэн тохиолдолд уг маргааныг хянан шийдвэрлэх хүртэлх хугацаанд тухайн хохиролтой холбоотой нөхөн төлбөр олгох ажлыг түдгэлзүүлнэ” гэж заасан боловч энэ талын хяналт, үнэлэлт дүгнэлт байхгүй байгаа тухай судлаачид мөн онцлон тэмдэглэсэн байна³¹.

30 http://www.buzznews.mn/news/156/single/22277?fbclid=IwAR25oouf0C6uJR0Ck5uD1nHnneKujRMx2ZjJjmatelyP0yW31VdUdA0n_xc.

31 Монгол Улсын Сангийн яам, Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнгийн талаар, 2018, https://mof.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/6_.

Тухайлбал: 2016 онд Гэмт хэргийн нөхөн төлбөрт 600.0 сая төгрөг олгохоор төлөвлөж 237.2 сая төгрөг зарцуулж өмнөх оны шилжих үлдэгдлийг эргүүлэн татаж авснаар 931.0 сая төгрөгийн эх үүсвэртэй, 2017 онд үндсэн үйл ажиллагааны орлогоор 1,341.9 сая сая төгрөг төлвлөрүүлж 174.5 сая төгрөг олгож 1,167.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар тухайн хохирлын мөнгөн дүнг бүрэн, хэсэгчлэн олгох зэргээр харилцан адилгүй хуваарилж байна. 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар төрөөс хохирлоо авч чадаагүй байгаа 43 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын 7,159,845.295 төгрөг байна³². 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 31524 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд үүнээс хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг 10299 гэмт хэрэг байгаа нь нийт гэмт хэргийн 32.7 хувийг эзэлж байна. Ийм төрлийн гэмт хэргийн улмаас 162,346.6 сая төгрөгийн хохирол учирчээ. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчдод төрөөс нөхөн төлбөр олгох журмын дагуу 2012-2020 оны хооронд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 19 удаагийн тушаалаар, шүүхийн шийдвэрээр хохирсон нийт 305 гэмт хэргийн хохирогч, төлбөр авагчид 1,285,274,685 төгрөгийн хохирлын төлбөрийг нөхөн төлбөр олгох сангаас олгоод байгаа ч энэ нь хуульд заасан 10 төрлийн гэмт хэргийн зөвхөн 4 төрлийн гэмт хэргийн хохирогчдод олгогдсон байна. Үүнийг дэлгэрүүлж үзвэл³³:

- Хүн алах /10.1 дүгээр зүйл/ гэмт хэргийн 282 хохирогчийн 1300603796 төгрөгийн нөхөн төлбөр;
- Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах /11.1 дүгээр зүйл/ гэмт хэргийн 29 хохирогчийн 316.592.636 төгрөгийн нөхөн төлбөр;
- Хүчиндэх /12.1 дүгээр зүйл/ гэмт хэргийн 25 хохирогчийн 73.502.068 төгрөгийн нөхөн төлбөр;
- Дээрэмдэх /17.2 дугаар зүйл/ гэмт хэргийн 2 хохирогчийн 6,356,937 төгрөгийн нөхөн төлбөрийг тус тус олгосон байна.

Дээрх байдлаас дүгнэж үзэхэд нэг талаас төлөвлөгөө гүйцэтгэлийн үзүүлэлтүүд их хэмжээний зөрүүтэй байгаа нь төсвийн төлөвлөлттэй холбоотой боловч нөгөө талаас шүүхээс нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэсэн гэмт хэргийн хохирогчдод төлбөрийг бүрэн олгодоггүйтэй холбоотой байна³⁴. Хүний зөрчигдсөн эрхийг сэргээх асуудал нь эрх зүйн харилцаанд юу юунаас илүү чухал зүйл билээ. Гэвч гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо барагдуулж, хор уршгаа нөхөн төлүүлж чадахгүй байгаа нөхцөл байдал хэвээр байна.

В. Бодит хохирлыг барагдуулах асуудал

Иргэдийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас учирсан материаллаг болон сэтгэл санааны хохирлыг нөхөн барагдуулах нь төр, нийгмийн чухал чиг үүрэг юм. НҮБ-аас батлан гаргасан дээр дурдсан баримт бичгүүдэд зааснаар, буруутай этгээд нь хохирогч, түүний гэр бүл, асрамжинд байсан хүмүүст учруулсан хохирлыг шударгаар арилгах, хохирлоо нөхөн төлүүлэх эрхийг баталгаажуулах, төрөөс

32 Хүний Эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 дахь илтгэл, 2018.

33 Б. Батболд, Гэмт хэргийн улмаас иргэний амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах талаарх үзэл баримтлал, Хууль дээдлэх ёс, 2020, №3.

34 Монгол Улсын Сангийн яам, Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүнгийн талаар, 2018, <https://mof.gov.mn/exp/ckfinder/userfiles/files/>.

хохирогчийн бие махбод, сэтгэл санаа, зан суртахуунд учирсан хохирол, ажил хөдөлмөр, сургууль боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээ зэрэг алдагдсан нөхцөл, бодит болон бий болох орлого, хууль зүй, сэтгэл зүй, эмнэлэг, нийгмийн үйлчилгээний зардлыг бүрэн, шуурхай барагдуулах нөхцөл бололцоогоор хангах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэхийг оролцогч улсуудад зөвлөхийн зэрэгцээ хэрэгжүүлэн ажиллахыг шаарддаг³⁵. “Нөхөн төлбөр” нь хууль бус үйлдлийн үр дүнд учирсан хохирлыг мөнгөн хэлбэрээр барагдуулах явдал бөгөөд нөхөн төлбөрийг материаллаг болон сэтгэл санааны хохирлыг нөхөн барагдуулах хэлбэрээр олгож болдог³⁶. Эндээс сэтгэл санааны хохирлыг арилгуулах тухайд зохицуулалтгүй байгааг онцлох нь зүйтэй.

Хүний эрүүл мэндэд учирсан хохирлыг нөхөн барагдуулахад тодорхой хэмжээ, хязгаарлалт тогтоосон байдаг. Тухайлбал, хөдөлмөрийн чадвараа бүтэн, эсхүл хагас алдсаны улмаас олж болох байсан ашгаа алдсан болон эрүүл мэндэд учирсан хохирлыг эмчлүүлэх зардлыг хохиролд тооцдог байна. Монгол Улс хүний амь нас хохирсон тохиолдолд оршуулгын зардал, хүний эрүүл мэндэд хохирол учирсан тохиолдолд эмчилгээний зардал тогтоох зэргээр хязгаар тавьдаг. Тодруулбал, гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн хүнд гэмтэл учирсан хохирогчийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан дор дурдсан хохиролд нөхөн төлбөр олгоход зарцуулна гэсний дагуу, гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30 дахин нэмэгдүүлсэнтэй, хохирогчийн бие махбодод хүнд гэмтэл учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нөхөн төлбөр олгохоор заасан бөгөөд зөвхөн “хохирогчийн эмчилгээний зардал, оршуулгын зардал; хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого”-ыг тус тус хуульчлан зохицуулсан байна. Энэ нь гэмт хэргийн улмаас хохирсон хохирлыг хангалттай хэмжээнд, шударгаар нөхөн барагдуулах зарчимд бүрэн нийцээгүй гэж дүгнэж болох юм³⁷. Энэ тухай “Хүний эрхийн үндэсний форум-2021”-д Улсын Дээд шүүхийн шүүгч Ч.Хосбаяр «Хүний эрх ба шүүх эрх мэдэл» сэдвээр тавьсан илтгэлдээ, гэмт хэргийн улмаас эрх нь хөндөгдсөн хохирогчийн эрхийг нөхөн сэргээх тогтолцоог цогцоор нь бүрдүүлэх ёстой хэмээн үзэж буйгаа илэрхийлсэн. Тодруулбал, «Хохирогчийн сэтгэл санаа, бие махбод, эрүүл мэндийн хохирлыг барагдуулах арга механизмыг судалж, өөрийн улс орны нөхцөл байдалд тохирсон хохирлыг тогтоох арга зүй, хохирогчид үйлчлэх үйлчилгээ, нийгмийн халамж дэмжлэг, туслалцаа, хохирлыг барагдуулах санг багтаасан хохирогчийн эрхийг хамгаалах тогтолцоо бүрдүүлж, гэмт хэргээр хөндөгдсөн эрхийг нөхөн сэргээх тогтолцоог цогцоор нь бүрдүүлэх нь зүйтэй гэжээ. Тэдгээрээс юуны өмнө, эдийн бус хохирол, бие эрхтэн, амь насны үнэлгээг тогтоох аргачлал, арга зүйг боловсруулж, гэмт хэргийн улмаас нас барсан иргэний оршуулгын зардлыг төлснөөр, эд эрхтнээсээ хагацсан иргэнд протезын төлбөр гаргуулснаар хүний амь нас, эд эрхтний нөхөн төлбөр дуусаж, гэмт хэргийн хохирол, хор уршиг арилсанд тооцсоор байх нь шударга ёсонд яав ч нийцэхгүй» хэмээн

35 НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт, хэлэлцүүлэг (UPR), 2014 оны 9 дүгээр сар,

36 Б.Батболд, Гэмт хэргийн улмаас иргэний амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах талаарх үзэл баримтлал, Хууль дээдлэх ёс, 2020, №3.

37 Нээлттэй нийгэм форум, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дөчин тавдугаар бүлгийн хэрэгжилт. Судалгааны тайлан, 2021 он, ISBN: 978-9919-9742-7-5.

онцолсон. Иймд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс шаардлагатай тохиолдолд нөхөн барагдуулахдаа бодит хохирлыг үнэлж барагдуулах хэрэгцээ, шаардлага тулгамдаж байна.

А. Хууль тогтоомжийн уялдаа холбоо, нэгдсэн зохицуулалтын асуудал

Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 дахь илтгэл”-д шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу төрийн байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад учирсан хохирлыг төрөөс тухай бүр олгох, холбогдох төсвийг нэмэгдүүлэх, гарсан шүүхийн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэх, буруутай албан тушаалтанд оногдуулах хариуцлагыг тодорхой болгох шаардлагатай байгаа талаар дурджээ³⁸. Тухайлбал, Комисс 2006 оноос эхлэн Иргэний хуульд заасны дагуу олон улсын гэрээгээр баталгаажуулсан зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, эдийн болон эдийн бус гэм хорын хохирлыг арилгуулах, буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр 38 иргэнийг төлөөлөн нийт 3,416,469,295 төгрөгийн нэхэмжлэлийг шүүхэд гаргажээ. Үүнээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтны хууль зөрчсөн ажиллагааны улмаас иргэдэд учруулсан хохирлыг төрөөр нөхөн төлүүлэхээр 27 иргэнийг төлөөлж нийт 2,776,200,674 төгрөгийн нэхэмжлэлийг гаргасан бөгөөд шүүхээс 450,755,172 төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргуулж, нэр бүхий иргэдэд олгохоор тус тус шийдвэрлэжээ. Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг авч үзвэл төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг Засгийн газрын нөөц сангаас гаргуулах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах төрийн сангууд тусдаа байгааг анхаарах нь зүйтэй. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол болон шүүхийн өмнөх болон дараах үйл ажиллагааны явцад учирсан хохирлыг нөхөн төлөх сангийн тогтолцоо үүссэн. Энэ нь хохирогчдод ялгаатай хандах байдлыг бий болгож, хуулийн өмнө бүгд эрх тэгш байх зарчмыг зөрчиж буй явдал юм.

Түүнчлэн гадаад улсын туршлагаас харахад төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаа болон гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нэг сангаас барагдуулдаг тогтолцоотой байна. Гэвч Монгол Улсад хууль тогтоомжийн нэгдмэл байдал дутмагаас болж тус тусдаа хууль тогтоомжоор зохицуулж байна. Тухайлбал, залилан зэрэг гэмт хэргийн улмаас учирсан хадгаламж, зээлийн хоршооноос хохирсон хохирогчд Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хуулиар зохицуулж, төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас үүссэн хохирлыг Засгийн газрын нөөц сангаас гаргуулж буй практик байгаа бөгөөд, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийг баримтлан Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас “Зарим төрлийн гэмт хэргийн хохирогчид төрөөс нөхөн төлбөр олгох журам”-д зааснаар төлбөрийг барагдуулж байна. Мөн бусдын хууль бус үйлдлийн улмаас учруулсан хохирлыг төрөөс нөхөн төлүүлэхтэй холбоотой асуудлыг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Иргэний хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн холбогдох заалтуудаар зохицуулжээ. Төрөөс нөхөн олговор олгох тухай тусгай зохицуулалт байгаа хэдий ч хангалттай хэмжээнд тодорхой,

38 Хүний эрхийн Үндэсний Комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 17 дахь илтгэл, 2018.

ойлгомжтой, системчлэлтэй эсэх, тус тусын эрх зүйн харилцааны онцлогт нийцсэн эсэхэд анхаарал хандуулах нь зүйтэй юм. Энэ талаар төрийн хариуцлагын тогтолцоо хараахан эрх зүйн цогц салбар болж хөгжөөгүй байгаа бөгөөд түүхэн хөгжлийн болон агуулгын үүднээс авч үзвэл өөр хоорондоо ихээхэн ялгаа бүхий хууль тогтоомжид тусгалаа олсон байна. Эдгээр нь зөрчилтэй, харилцан уялдаагүй байгаа нь төрийн хариуцлагыг ил тод бус, хийдэл цоорхойтой болгож байгаа тухай профессор Б. Чимид онцлон тэмдэглэжээ. Төр нь хохирогчдын хохирлыг барагдуулах үүргийг олон улсын хэм хэмжээгээр, үндэсний хууль тогтоомжоор хүлээснийг Монгол Улс хэрхэн биелүүлж буйд дүн шинжилгээ хийвэл, хууль тогтоомжийн уялдаа холбоо байхгүй, нэгдсэн зохицуулалтгүй, тусгайлсан хууль тогтоомжгүй байгаа нь анхаарал татаж байна. Нэгдсэн уялдаа холбоог хангасан зохицуулалт хийгдсэнээр нийгмийн хөгжлөөс гадуур орхигдож, эрх ашиг нь хөндөгдөж буй бүлгийн эрхийг хангах, хэрэгжүүлэх арга хэмжээ, байгууллагын эрх, үүрэг, зохион байгуулалтыг нарийвчлан зохицуулах боломж бүрдэх учиртай.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Хуулийн төслийг боловсруулах зорилго нь 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилго, үзэл баримтлал, Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хохирогч хохирлоо нөхөн төлүүлэх эрх, шударга ёсны зарчим, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар боловсронгуй болгосон зарчимд нийцүүлэн явуулах нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

Зорилго: “Хохирогчийн эрх ашгийн баталгаат байдлыг хангах”;

Зорилт 1: “Хохирогчийн эрхийг сэргээх, нөхөн барагдуулах талаарх харилцааг зохицуулах”;

Зорилт 2. “Хохирлын сангийн тухай хяналт, зохицуулалтын механизмыг хангах”;

Зорилт 3. “Төрөөс нөхөн төлбөр авах эрх бүхий хохирогчийн шалгуур үзүүлэлт, хууль, эрх зүйн орчныг тодорхой болгох”;

Зорилт 4. “Хохирол нөхөн төлүүлэх үйл явц түргэн, шуурхай хийгдэж, дуусгавар болох зохицуулалтыг бий болгох”.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУДЫГ ТОГТООЖ, ТЭДГЭЭРИЙГ ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 5.1 дүгээр зүйлд зааснаар асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, эерэг болон сөрөг талыг харьцуулан үзэх ажлын хүрээнд дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх зорилгыг биелүүлэхэд чиглэсэн хувилбаруудыг тогтооно.

Аргачлалын дээрх зүйлд зааснаар асуудлыг шийдвэрлэх дор дурдсан хувилбарууд байна:

5.1.1. “тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах;

5.1.2. хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;

5.1.3.зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх;

5.1.4.төрөөс санхүүгийн интервенц хийх;

5.1.5.төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;

5.1.6.захиргааны шийдвэр гаргах;

5.1.7.хууль тогтоомжийн төсөл боловсруулах.

Хүснэгт 2.3. Асуудлыг зохицуулах хувилбаруудын харьцуулсан нь.

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдсан асуудал арилахгүй үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч хуулийг нарийн тодорхой болгоогүйгээс хохирогчдын эрх ашгийг хөндсөн сөрөг үр дагавар ихэснэ.	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Хохирогчдын эрхийг хуулиар хамгаалахад нөлөөлөх ч асуудлыг шийдвэрлэн зорилгод хүрэх боломжгүй.	Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж буй шалтгаан, нөхцлийг арилгахгүй.	Үр дүн сөрөг
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Төрөөс зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглах зохицуулалт хийх боломжгүй.	Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж буй шалтгаан, нөхцлийг арилгахгүй.	Үр дүнд хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Төрөөс интервенц хийх шаардлагагүй.	Тодорхой хэмжээний зардал гарна. Асуудлыг үүсгэж буй шалтгаан, нөхцлийг арилгахгүй.	Үр дүнд хүрэхгүй
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Энэ нь бүхий л аж ахуй эрхлэгчид хамааралтай. Тодорхой холбоод үүнийг шийдвэрлэх боломжгүй.	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгаан, нөхцлийг арилгаж, бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
6	Захиргааны шийдвэр гаргах	Иргэний үндсэн эрхийг хуулиар л хамгаалах боломжтой учир захиргааны шийдвэр гарган хамгаалах боломжгүй.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгаан, нөхцлийг арилгахад нөлөөлж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилго, зарчмыг зөрчсөн хуулийн хийдлийг засах боломж бүрдэнэ. Үр ашигтай зохицуулалт бий болгох боломжтой.	Зардал гарах боловч асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэх гол гарц болно.	Үр дүнтэй

Энэхүү дүгнэлтийг хийхдээ тухайн хувилбаруудыг сонгосноор зорилгод хүрэх байдал, хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үр өгөөжийн харьцаа зэрэг үзүүлэлтээр харьцуулан судалсан болно. Дээр дурдсан Аргачлалын 5.1.1-5.1.6-д заасан хувилбаруудын агуулгаас харахад эдгээрийн аль нь ч энэхүү тайлангийн Хоёр дахь хэсэгт заасан асуудлыг шийдвэрлэх зорилтод хүрэх хувилбар биш байна. Учир нь одоогийн хууль тогтоомжид тухайн асуудлыг зохицуулсан хэм хэмжээ байгаа хэдий ч уг асуудал үүсэх болсон шалтгаан, нөхцөл, тухайн харилцааг

тусгайлан зохицуулсан цогц буюу нэгдмэл “хууль тогтоомжийн төсөл боловсруулах” буюу Аргачлалын 5.1.7-д заасан хувилбараар зорилтод хүрэх боломжтой гэж үзэж байна.

Аргачлалын 5.4.1-д, тухайн асуудал нь хүний салшгүй эрхэд буюу Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан хүний эрхийг хязгаарлах бол хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгоно гэж заасан. Асуудал нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “... эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх эрхтэй” гэж заасан хүний салшгүй эрхийг хөндөж байх тул хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгоно. Үндсэн хууль болон ЭХХШТХ, Эрүүгийн хуулийн зорилго, зарчимд нийцэхгүй байх нь эрүүгийн эрх зүйн тогтолцоонд сөрөг үр дагавар бий болгож, иргэдийн үндсэн эрх зөрчигдөж, шүүхэд итгэх итгэлийг ихээр эвдэх эрсдэл дагуулна. Энэ тохиолдолд хуулийн төсөл боловсруулах нь зүйтэй юм.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу сонгон авсан зохицуулалтын хувилбарын үр нөлөөг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлсэн болно.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг үнэлгээний тайлангийн хавсралт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Хүний эрхэд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй бөгөөд харин ч хүний эрхийг хангах, эрхээ эдлэх боломж, нөхцлийг бүрдүүлнэ.

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Улсын төсөвт дарамт үзүүлэх эрсдэлтэй.

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Гэмт хэргийн хохирол, хор уршгийг шударгаар барагдуулах, шаардлагатай тохиолдолд төрөөс хохирлыг төлүүлэх нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх төдийгүй, нийгмийн эмзэг бүлгийн хохирогчдын эрхийг хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал үр нөлөөтэй³⁹. Мөн судлаачид онцлохдоо “иргэдийн эрүүгийн эрх зүйн тогтолцоо, шүүх, шударга ёсонд итгэх итгэл сайжрахаас гадна хохирогчдыг өрөвдөх, хайрлах, хүн чанартай байх, зовлонг нь ойлгох нинжин сэтгэлийн бэлэг тэмдэг болох учиртай хэмээн онцлон тэмдэглэдэг. Улмаар нийгмийн, иргэдийн эв нэгдлийг хангах маш чухал асуудал” хэмээн үзэх хандлага байгааг дурдах нь зүйтэй⁴⁰. Мөн хохирогчдын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд итгэх итгэл сайжирснаар цагдаагийн байгууллагад хандах хандлага ихэсэж, хэрэг бүртгэлтийн үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлөх төдийгүй, нуугдмал гэмт хэргийг

39 Үндэсний статистикийн хороо, Гэмт хэргийн хохирогчийн өнөөгийн байдалд хийсэн баримтын судалгаа, 2014, https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Victimization_survey.pdf&ln=Mn.

40 Miers, D., Offender and state compensation for victims of crime: Two decades of development and change. *International Review of Victimology*, 2014, 20(1), pp.145-168.

нээн илрүүлэхэд чухал үр нөлөөтэй хэмээн судлаачид онцолдог.⁴¹

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчинд ямар нэгэн шууд ба шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай бүрэн нийцэж байна.

ТАВ. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ⁴²

Орчин үед дэлхий нийтийн техник технологийн өндөр хөгжилтэй уялдан хүн амын төвлөрөл, үйлдвэржилт, даяарчлал асар хурдацтай явагдаж, улмаар хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаа, эд хөрөнгийн эрсдэл маш ихээр үүсэж, гэмт хэрэг гаралтын түвшин ихэсэж байна. Үүнтэй холбогдуулан хүний эрхийг хангах, түүний зөрчигдсөн эрхийг сэргээх үүднээс гэмт хэргийн улмаас учирсан хохирол, гэм хорыг арилгах асуудал, түүнийг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн тогтолцоо дэлхий дахинаа улам боловсронгуй болон хөгжиж байна. Хохирлын хэмжээг бодитой тогтоох, нөхөн барагдуулах нийтлэг аргыг боловсруулахад тухайн улс орны онцлог, эдийн засгийн байдал, гэмт хэрэг гаралтын түвшин чухал байр суурийг эзэлж байна. Олон улсын жишгээс харахад байгалийн давагдашгүй гамшигт үзэгдэл, террорист, дайн, бослого үймээн зэрэг гэмт этгээд нь тодорхойгүй, олох боломжгүй олон удаагийн нөхцөл байдлын улмаас төрөөс хохирогчдыг дэмжих, нөхөн олговор олгох зэрэг үндэсний тогтолцоог улам боловсронгуй болгох шалтгаан нөхцөл үүссэн байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг зайлшгүй тохиолдолд төрөөс нөхөн барагдуулах хариуцлагыг Үндсэн хуулиар болон олон улсын эрх зүйн түвшинд баталгаажуулсан байна. Өөрөөр хэлбэл, онолын түвшинд үзэхэд төр нь гэмт хэргийн гаралтыг зогсоох, бууруулах, иргэдийн амар амгалан, аюулгүй байдлыг хамгаалах үүргийг хүлээсэн болохынхоо хувьд хохирогчдын эрх ашгийг сэргээх, нөхөн төлбөр барагдуулах тодорхой хэмжээний хариуцлагыг заавал үүрэх ёстой гэсэн чиг хандлагыг олон улсын түвшинд баримталж байна. Иймд төрөөс хохирогчдын эрх ашгийг нөхөн сэргээхтэй холбоотойгоор төрөөс зайлшгүй тохиолдолд барагдуулах тухай тусгай хууль тогтоомжтой бөгөөд гэмт хэргийн хохирогч нарт туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн болон төрийн байгууллагыг байгуулж, төрөөс дэмжлэг үзүүлдэг. Олон улсын түвшинд төрөөс хохирол барагдуулах сангийн эх үүсвэрийг гэмт этгээдээс татан авч санхүүжүүлэх, эсхүл татвар төлөгчдийн мөнгөөс буюу улсын төсвөөс санхүүжүүлэх гэсэн хоёр үндсэн загвар байгаа юм.

Олон улсын жишгээс үзэхэд гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэхтэй холбоотой хууль тогтоомжуудыг “Crime victim aid”, “Crime victim relief fund”, “Crime victims benefit payment law” гэх мэтчилэн, хохирогчдод үзүүлэх “тусламж” гэдэг утгаар нь нэрлэж байгаа бол, нөгөөтэйгүүр “Victim compensation act”, “Law on crime victims fund”, “Violence victims compensation act” гэх зэрэг хохирогчдын “нөхөн төлбөр” гэсэн шууд утгаар нэрлэж буй чиг хандлага байгааг

41 HALDANE, J., & Harvey, A. (1995). The Philosophy of State Compensation. Journal of Applied Philosophy, 12(3), 273–282, <http://www.jstor.org/stable/24354130>

42 Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хохирлын сангийн тухай харьцуулсан судалгааны тайлан.

бас дурдах нь зүйтэй. Иймд зорилго, зохицуулалтын онцлог, ямар харилцааг зохицуулж байгаагаас хамааран нэр томъёог зохистой, зөв утгаар нь хэрэглэх нь зүйд нийцнэ. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулах хууль тогтоомжийг боловсруулахдаа “нөхөн төлбөр” гэсэн нэр томъёог хэрэглэх нь зүйтэй юм. Академич С.Нарангэрэл “Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг” бүтээлдээ “нөхөн олговор”-ыг “нөхөн төлбөр”-тэй адилхан утга агуулгатай гэж үзсэн. Нөхөн олговор гэдэг (compensation) нь “хуульд үндэслэн эсхүл хуулийн дагуу, иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг төрөөс арилгах арга хэмжээ” хэмээн, өөрөөр хэлбэл хохирлыг төрөөс барагдуулж буй хэлбэр хэмээн төрд хамааруулан онцлон тодорхойлжээ. Иймд хууль тогтоомжийг боловсруулахдаа “Хохирлын сан” гэж нэрлэх бус харин “Нөхөн төлбөрийн сан” гэж томъёолох нь зүйтэй байж болох юм.

Хохирлын сангийн тогтолцоо нь тухайн улс орны онцлог, эдийн засгийн боломж, үндэсний сэтгэхүйгээс шууд хамааралтай байгааг онцлох нь зүйтэй. Монгол Улсад 2012 оноос эхэлсэн Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн үндсэн чиглэлийн нэг нь хохирогч хамгаалах, хохирол барагдуулах тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх явдал билээ. Гэмт хэргийн хохирол, хор уршгийг шударгаар барагдуулах, шаардлагатай тохиолдолд төрөөс хохирлыг төлүүлэх нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх төдийгүй нийгмийн эмзэг бүлгийн хохирогчдын эрхийг хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал үр нөлөөтэй⁴³. Иймд Монгол Улс нь байгалийн гамшгийн эрсдэлт үзэгдэл болон гэмт хэргийн гаралт бага, харьцангуй тайван орон болохын хувьд төрөөс олгох нөхөн төлбөрийн хамрах хүрээ, хэмжээ мөн харьцангуй бага боловч нөхөн олговрын үндэсний тогтолцооны эрх зүйн зохицуулалт болон практик ажиллагаа нь гадаадын хөгжингүй улс орнуудаас ихээхэн хоцрогдмол байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын хууль тогтоомжид гэмт хэргийн хохирогчийн эрх зүйн байдал олон улсын стандартад зарим талаар дөхөж очсон боловч, ихэвчлэн тунхаглалын шинжтэй, хохирол нөхөн төлүүлэх механизм, зохион байгуулалт, эдийн засгийн баталгаа, бааз суурь байхгүйн улмаас хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн хэвээр байна.

Мөн гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх, учирсан хохирлыг барагдуулах эрх зүйн зохицуулалт хангалттай мэт боловч тунхаглалын шинжтэй учраас хэрэгжих механизм нь тодорхой бус байна. Олон улсын эрх зүйн стандарт, үндсэн зарчмуудтай харьцуулан үзэхэд гэмт хэргийн хохирогчийн төрөөс нийгмийн халамж тусламж авах, эрх бүхий байгууллагаас мэдээлэл авах эрх дотоодын хэм хэмжээнд тодорхой тусгагдаагүйгээс хамаарч, төрөөс нөхөн төлбөр авах, нөхөн олговор олгох асуудал олон улсын жишгээс хол хоцорчээ. Өөрөөр хэлбэл, хүн, хуулийн этгээд гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо барагдуулж, хор уршгаа нөхөн төлүүлж чадахгүй байсаар байна. Тус сангаас эмчилгээний болон оршуулгын зардал, хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг л олгохоор заасан нь гэмт хэргийн хохирогчийн хохирлыг хангалттай хэмжээнд, шударгаар нөхөн барагдуулах зарчимд бүрэн нийцээгүй гэж дүгнэж болох юм⁴⁴.

43 Үндэсний статистикийн хороо, Гэмт хэргийн хохирогчийн өнөөгийн байдалд хийсэн баримтын судалгаа, 2014, https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Victimization_survey.pdf&In=Mn.

44 Нээлттэй нийгэм форум, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Дөчин тавдугаар бүлгийн хэрэгжилт, судалгааны тайлан, 2021.

Монгол Улсад гэмт хэргийн улмаас хохирогчийн эрхийг хангах чиглэлээр эрх зүйн зохицуулалт, түүнийг хэрэгжүүлэх арга барил шинэчлэгдээгүй, тодорхой аргачлал, журмуудыг шинээр батлан хэрэгжүүлээгүй, мөн хууль сахиулагчдын хуучин хэвшмэл хандлагаас шалтгаалж гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчийн эрхийг хангах, түүнийг нөхөн сэргээх байдал хангалтгүй байна. Иймд хууль тогтоогчийн үзэл санаа буюу хохирогчийн эрхийг хангахад ахиц дэвшил гаргах, хохирол, хор уршгийн төрөл хэмжээг үнэлж, түүнийг барагдуулах байдалд ахиц гаргах хуулийн зорилт үндсэндээ хэрэгжээгүй гэж үзэж болохоор байна⁴⁵.

Энэхүү судалгаанаас дүгнэвэл, эх газрын эрх зүйн тогтолцоо болон англи-саксоны эрх зүйн тогтолцооны онцлогоос үл хамааран гадаадын улс орнууд төрөөс хохирлыг барагдуулах тухай нийтлэг асуудлуудад анхаарлаа хандуулж байна. Энэ нь ямар гэмт хэргийн улмаас хохирсон хохирлыг нөхөн төлүүлэх, ямар нөхцөлд ямар хохирогчдод нөхөн төлбөр олгох, хамрагдах боломж хэр вэ гэсэн үндсэн асуултуудад хариулахыг эрэлхийлж, өөр өөр байдлаар ялгаатай зохицуулсан байна. Тухайлбал, Европын Холбооны орнуудын хувьд “санаатай хүч хэрэглэсэн гэмт хэрэг”, “бэлгийн хүчирхийлэл”-д холбогдох гэмт хэргийн улмаас хохирогчдод нөхөн төлбөр олгохоор зохицуулсан байгаа ч эд хөрөнгөтэй холбоотой гэмт хэргийг оруулаагүй байгаа нийтлэг зохицуулалтыг онцлох нь зүйтэй.

Гэмт хэргийн төрлөөр ангилснаас гадна, мөн төрөөс нөхөн төлбөр авахад зохимжгүй (undeserving victims), (inappropriate) хохирогчдыг нарийвчлан тодорхойлсон байна. Тухайлбал, гэмт этгээд рүү дайрч зүй зохисгүй үйлдэл хийсэн, зодоон цохионд сайн дураараа оролцсон, түрэмгий, заналхийлсэн үйлдэл хийсэн, эсхүл гэмт хэргийн үйл явдлыг өдөөн хатгасан, нөлөөлсөн тохиолдолд нөхөн төлбөр авах харилцаанд “нөхөн төлбөр хүртэх эрхгүй хохирогч” хэмээн үзэж, хохирогчдод тодорхой шалгуур тавьсан байгааг хууль тогтоогч анхааран үзэж, хууль тогтоомждоо шинээр тусгах нь зүй ёсны юм.

Харин эрх зүй өндөр хөгжсөн зарим улс оронд гэм буруутай этгээдээс хохирлыг нэхэмжилж барагдуулах, гэм буруутай этгээд тогтоогдоогүй бол эд хөрөнгө, бие эрхтэн, сэтгэл санаанд учирсан хохирлыг төрөөс нөхөн төлж барагдуулдаг тогтолцоог өөрийн орны онцлогт тохируулан баталгаажуулсан байна. Хохирлын сангийн тогтолцоог бүрдүүлэхэд хохирогч төр хоёрыг холбон зуучлах байгууллага буюу хохирогчид зөвлөгөө өгдөг, өргөдлийг хүлээн авдаг цагдаагийн байгууллагаас гадна, хохирогчийг дэмжих алба, төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран ажилладаг болсноор хохирол нөхөн барагдуулах тогтолцоо, түүний хамрах хүрээ өргөсөж, үр дүнгээ өгөх ач холбогдолтой байна. Тухайлбал, гадаад орнуудын туршлагаас авч үзвэл, төрөөс нөхөн олговор олгох тухай мэдээллийг анхан шатны нэгж болох цагдаагийн байгууллага хариуцан ажиллах, өргөдлийн маягтыг хохирогчдод өгөх, төрөөс нөхөн олговор авах боломжийн талаар таниулан сурталчлах, хохирогчдод чиглэл өгөх зэрэг олон талт чиг үүргийг ногдуулсан хандлага ажиглагдаж байна. Тус өргөдлийн шаардлагыг хангасан гэж үзвэл Хохирол нөхөн барагдуулах зөвлөлд, Хохирлын нөхөн олговрын албанд дамжуулан өгдөг бөгөөд өргөдлийг хянан хэлэлцэж эцсийн байдлаар дүгнэлт гаргадаг тусгай чиг үүрэг бүхий хараат бус байгууллага байдаг. Зарим улсад тусгай байгууллага, тухайлбал БНСУ-д Прокурорын байгууллагын дэргэд тусгай чиг үүрэг бүхий Хохирол нөхөн төлүүлэх алба ажиллаж асуудлыг шийдвэрлэдэг. Ингэснээр өргөдөл гомдол түргэн шуурхай шийдвэрлэгдэх үндэс болж байгаа төдийгүй ихэнхи тохиолдолд хэрэг

45 Мөн тэнд, 15 дахь тал

гарсан өдрөөс эхлэн хохирлыг нөхөн төлөх гэмт этгээдийн боломж бололцоог судлан, хэрэв гэмт этгээд олдохгүй зэрэг шалтгаан байгаа тохиолдолд анхан шатны нэгж болох цагдаагийн байгууллагаас өргөдлийн маягтыг авч, цаг алдалгүй зохих шийдвэр гаргах эрх бүхий байгууллагад дамжуулан өгдөг нь сайшаалтай юм.

Харин манай Монгол Улсад шүүхийн шийдвэр гарсны дараа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас өргөдлийн маягтыг авдаг нь ялгаатай зохицуулалт юм. Төрөөс нөхөн олговрыг олгох талаар хамгийн сүүлийн шатанд шийдвэрлэдэг нь хохирогчийн эрх ашгийг зөрчих нөхцлийг бүрдүүлж байна. Мөн иргэд хаанаас маягтыг авах, хаана өгөх, хэн хариуцах тухай нарийвчилсан мэдээлэл дутмаг байхаас гадна төрөөс хохирлыг барагдуулах тухайд хяналт тавьж, хохирогчдыг чиглүүлж өгөх субъект тодорхойгүй. Өөрөөр хэлбэл, хохирлыг төрөөс барагдуулах тухай хүсэлтийг зуучлан холбох байгууллага байхгүй. Улмаар иргэд төрөөс нөхөн олговор авах боломжийн талаар мэдлэг, мэдээлэлгүйгээс болж зохих байгууллагад хүсэлт, өргөдөл өгдөггүй байх сул тал гарч байна.

Иргэдийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас учирсан материаллаг болон сэтгэл санааны хохирлыг нөхөн барагдуулах нь төрийн болон нийгмийн чухал чиг үүрэг юм⁴⁶. Гэвч Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаар зөвхөн хохирогчийн эмчилгээний зардал, оршуулгын зардал; хөдөлмөрийн чадвараа алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг нөхөн олгохоор хязгаарлан зохицуулсан нь сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрийг орхигдуулж, бодит хохирлыг тооцохгүй байх нөхцлийг бүрдүүлсэн байна. Гэвч гаднын жишгээс харвал, тухайлбал, БНСУ-д дээр дурдсан төлбөрөөс гадна тэжээгчээ алдсаны тэтгэмж, сургалтын төлбөр, сэтгэл зүйн эмчилгээний төлбөрийг тооцон төрөөс олгох нөхөн олговортоо багтааж буй нь бодит хохирлыг бүрэн хэмжээгээр олгох эрх зүйн орчинг бүрдүүлсэн байна.

Мөн олон улсын чиг хандлагаас харвал гэмт хэргийн улмаас учирсан хохирол болон шүүхийн өмнөх болон дараах үйл ажиллагааны явцад учирсан хохирлыг нэг сангаас төлбөрийг нөхөн олгох тал дээр эрх зүйн нэгдмэл байдлыг хангасан байна. Гэвч Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг авч үзвэл төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг засгийн газрын нөөц сан, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хохирлыг барагдуулах төрийн сангууд тусдаа байгааг анхаарах нь зүйтэй.

Мөн Монгол Улсад төрөөс нөхөн олговор олгох тухай тусгай чиг үүрэг бүхий тогтмол үйл ажиллагаа явуулдаг тусгай эрх бүхий байгууллага байхгүй буюу зөвхөн ерөнхий чиг үүрэг бүхий Аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шүүхийн шийдвэр гарсны дараа өргөдлийг өгөхөөр хуульчлан зохицуулсан байна. Энэ нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хариуцуулсан төдий боловч тэр чиглэлээр дагнан, тогтвортой үйл ажиллагаа явуулдаггүйн улмаас өргөдлийг хянан хэлэлцэх хугацааг удаашруулж, хүнд сурталд автагдах, хохирогчдыг залхаах, нөхөн олговор олгох хугацааг удаашруулах зэрэг олон асуудлыг дагуулж буйг дурдах нь зүйтэй. Аймаг, нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар өргөдлийг хянан хэлэлцэж, зохих шийдвэрийг ХЗДХЯ-нд хүргүүлснээр ХЗДХ-ийн сайд эцэслэн шийдвэрлэдэг байдал нь хүнд суртлыг дагуулж, хугацаа алдах эрсдэл үүсгэж байна.

46 Б.Батболд, Гэмт хэргийн улмаас иргэний амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулах талаарх үзэл баримтлал, Хууль дээдлэх ёс, 2020, №3.

Гадаад улсад төрөөс хохирол нөхөн төлүүлэх зөвлөлөөс гарсан шийдвэртэй санал нийлэхгүй тохиолдолд хохирогч нь дээд шатны байгууллага болох Нөхөн олговрын ерөнхий зөвлөлд давж заалдах эрхийг хуульчлан зохицуулсан байдаг. Энэ нь тусгай чиг үүрэг бүхий байгууллага асуудлыг шуурхай авч хэлэлцэх боломжийг агуулж байна. Харин Монгол Улсад хохирогч холбогдох асуудлаар давж заалдах эрх, түүнийг шийдвэрлэх эрх бүхий байгууллагын тухайд Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журмын 7.1-д “Өргөдөл гаргагч нь нөхөн төлбөр олгох ажиллагаатай холбоотой гомдлоо шүүхэд гаргаж болно” хэмээн тодорхойгүй, ойлгомжгүй байдлаар тусгасан нь хохирогчийг залхаах, мухардалд оруулах нөхцлийг үүсгэж байна гэж дүгнэв.

Мөн Монгол Улсын хувьд төрөөс нөхөн олговор олгох зохицуулалтын хамрах хүрээ нь хэт хязгаарлагдмал бөгөөд хохирогчид гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо ямар тохиолдолд төрөөс барагдуулах, ямар үндсэн шалгуур тавигдаж байгаа эсэх нь тодорхойгүй буюу тогтсон стандартгүй байна. Нөхөн олговор олгохгүй байх үндэслэлийг Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох журмын 7.1-д “Өргөдөл гаргагч нь хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, эсхүл гэм буруутай этгээд болон түүний хууль ёсны төлөөлөгч хохирлыг бүрэн барагдуулсан бол нөхөн төлбөр олгохоос татгалзаж өргөдөл гаргагчид хариу мэдэгдэнэ” хэмээн заасан нь судлагдсан орнуудын хууль тогтоомжтой адил нийтлэг зохицуулалттай хэдий ч хэт ерөнхий байна. Өөрөөр хэлбэл, нөхөн олговор олгохыг татгалзах үндэслэлүүдийг нарийвчлах, хамрах хүрээг ил тод байдлаар өргөжүүлэх шаардлагатай. Хохирлын нөхөн олговрыг олгохоос ямар тохиолдолд татгалзах, ямар тохиолдолд бүтэн болон хэсэгчлэн олгох тухай стандарт шалгуурыг журамлан тогтоогоогүй нь олон нийтэд хардлага төрүүлэх, нийгэмд тодорхойгүй байдал үүсгэх, хохирогчдод эрх тэгш хандах зарчмыг зөрчих нөхцлийг бий болгож байна. Түүнчлэн шийдвэр гаргагч эрх бүхий этгээд зөвхөн өөрийн дотоод үзэмжээр хохирол барагдуулах тухай шийдвэр гаргах нөхцлийг үүсгэж буйг дурдах нь зүйтэй. Мөн гадаад орнуудын хууль тогтоомжид шийдвэр гарснаас хойш тодорхой хоногийн дотор нөхөн олговрыг хохирогчид шилжүүлнэ гэж нарийвчлан заасан байдаг бол манай улсад тэр хугацааг хуульчлан заагаагүй нь тодорхойгүй байдал үүсгэх хандлагатай байна.

Олон улсын жишгийг харахад, тухайлбал, БНСУ-д нөхөн олговрыг ямар нөхцөлд олгох, олгохгүй байх тухай нарийвчлан зохицуулсан нь хохирогчдод эргэлзээ төрүүлэхгүй байх, шийдвэр гаргалтыг хөнгөвчлөх нөхцлийг бүрдүүлж байгаа юм. Мөн тус хуулиар төрөөс нөхөн олговор авах эрх бүхий этгээдийг нарийвчлан тогтоожээ. Тухайлбал, нөхөн олговор авах эрх бүхий субъектүүдийг ерөнхийлөн заасан байгаа бөгөөд гэр бүлийн гишүүдийг эрэмбэ дарааллаар нь ангилснаас гадна эхийн хэвлийд бүрэлдэж буй үр хөврөл хүртэл нөхөн олговор авах эрхтэйг заасан нь онцлог юм. Мөн нөхөн олговор авах хүсэлт гаргасан этгээд нь нийгмийн зан суртахууны хэм хэмжээг зөрчсөн буюу гэмт хэрэгт холбогдож байсан, шалгагдаж байгаа эсэхийг урьдчилан тогтоодог бөгөөд гэмт хэргийг мэдээлэх үүргээ биелүүлээгүй байх зэрэг түүхтэй байвал нөхөн олговрыг олгохгүй байхаар хуульчилжээ. Мөн төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг барагдуулна гэхээсээ илүү эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх явцад үүссэн хууль бус, буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулна хэмээн нарийвчлан тусгасан нь онцлог юм.

Харин Монгол Улсад зөвхөн “Эрүүгийн хуульд заасан зарим гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн хууль ёсны төлөөлөгч, хүнд гэмтэл учирсан

хохирогчид нөхөн төлбөр олгоход зарцуулна” хэмээн хуульчилсан. Гэвч ЭХХШТХ 45.2-р зүйлийн 1 дэх хэсэгт “Хүнийг хууль бусаар ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлгасан, албадан эмчлэх арга хэмжээ хэрэглэсэн, эрүүдэн шүүсний улмаас учирсан хохирлыг мөрдөгч, прокурор, шүүгчийн гэм бурууг үл харгалзан төр хариуцан арилгана.” хэмээн заасан нь төрөөс өөрт учирсан хохирлоо шаардах, нөхөн төлүүлэх эрхийг зохицуулж, улмаар уг эрхийг хангах үүргийг төрд хариуцуулсан тул тус сангаас нөхөн олговор олгох үндэслэлтэй. Гэвч аль сангаас төлбөрийг барагдуулах нь тодорхойгүй, хэрэгжүүлэх тухайд хууль зүйн зохицуулалтгүй бөгөөд тухайн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хохирлын сангаас олгохоор хуульчлан зохицуулаагүй байна. Иймд тус сангаас хохирлыг барагдуулах хүрээ хэт хязгаарлагдмал байгаа төдийгүй ЭХХШТХ болон Хохирлын сангийн тухай хуулийн нийцлийг хангах шаардлагатай.

Мөн зөвхөн гэмт этгээд буруутай нь нотлогдож шүүхийн ял шийтгэл авсан тохиолдолд сангаас нөхөн олговор олгохоор заасан нь хэрэв гэмт этгээд олдоогүй, тодорхойгүй тохиолдолд хэрхэх тухай зохицуулалт байхгүй байна. Гадаад орны хууль тогтоомжид гэмт этгээд нь олдоогүй, эсхүл сэтгэцийн өвчтэй тохиолдолд төрөөс нөхөн олговор олгодог сайн жишиг байна. Монгол Улсад гэм буруутай гэдэг нь нотлогдоогүй буюу цагаатгагдсан, гэмт этгээд тодорхой бус тохиолдол гарвал хохирогч хохирч үлддэг тул энэ тохиолдолд учирсан хохирлыг төрөөс хөнгөвчлөх нь Эрүүгийн хууль болон ЭХХШТХ-ын үзэл баримтлал, тавьсан зорилго, зорилтод хүрэх алхам болох учиртай. Мөн гэмт этгээд бүрэн нотлогдохгүй байх тохиолдолд хохирогчийн хохирлыг гаргуулах, хохирогчийн гомдлыг тайлах үүднээс зайлшгүй хэн нэгнийг яллах, гүтгэх, хэлмэгдүүлэх зэрэг эрсдэл харьцангуй багасах нөхцөл үүсэх бөгөөд улмаар шүүгч болон прокурорын байгууллагын үйл ажиллагаа хуулийн дагуу, хараат бус явагдах нөхцөл бүрдэнэ.

Хохирлын сангийн тогтолцооны маш чухал хүчин зүйл нь санхүүжилтийн эх үүсвэр юм. Үүнээс шалтгаалж хохирлын сангийн хэв маяг шинэчлэгдэн өөрчлөгдөж, улс орон болгон өөр өөр төрлийн хохирлын сангийн тогтолцоо, санхүүжилтийн загвартай байгааг энэхүү харьцуулсан судалгаанаас харагдаж байна. Гэмт хэргийн хохирогчдод нөхөн төлбөр олгох журамд “... гэм буруутай этгээдээр буцаан төвлөрүүлнэ” гэж заасан нь бусад улсын хууль тогтоомжоос ялгаатай буюу онцлог юм. Харин Казахстан улсын гэмт этгээдээс хохирлын санд буцаан төвлөрүүлэлт хийх зохицуулалттай төсөөтэй байна. Энэ тохиолдолд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төрөөс нөхөн барагдуулж байна гэж үзэхэд тохиромжгүй бөгөөд гэмт этгээд шууд бус замаар хохирлыг нөхөн барагдуулж байна гэж үзэж харин болох юм. Зарим тохиолдолд буюу Япон улс хохирлын санд хандив, тусламж өгөх нээлттэй байдлаар санхүүжилтийн эх үүсвэрийг хуульчлан зохицуулсан онцлогтой байгааг дурдах нь зүйтэй. Харин хөгжингүй улсуудын хууль тогтоомжйн хувьд цэвэр улсын төсөв буюу улсын татварын мөнгө, төсвийн орлогоос хохирлын сангийн санхүүжилтийг олгодог нийтлэг жишиг байна.

Монгол Улсад хүний амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаанд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэхдээ зөвхөн нотлох баримтад тулгуурлаж байгаа тул эмчилгээ, оршуулга, тээврийн зардлын баримт зэрэг хохирогчийн цуглуулсан нотлох баримтыг харгалзан хохирлын хэмжээг тогтоож байна. Харин олон улсад хохирогчийн оролцоогүйгээр Татварын алба зэрэг холбогдох төрийн байгууллагаас шууд мэдээлэл авсны үндсэн дээр орлого, цалин, олж болох байсан орлогыг

тогтоосноор хүнд суртлын эсрэг, цаг хугацаа хэмнэсэн сайн жишиг байгааг дурдах нь зүйтэй.

Мөн гадаад улсын туршлагаас авч үзэхэд төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаа болон гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нэгдмэл нэг сангаас барагдуулдаг байна. Гэвч Монгол Улсад хууль тогтоомжийн нэгдмэл байдалгүйгээс болж тус тусдаа хууль тогтоомжоор зохицуулдаг. Тухайлбал, хадгаламж, зээлийн хоршооноос хохирсон хохирогчдод нөхөн төлбөр өгөх асуудлыг Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хуулиар зохицуулж, төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас үүссэн хохирлыг Засгийн газрын тусгай сангаас, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангаас тус тус төлбөр барагдуулж байна. Иймд хууль тогтоомжийн уялдаа холбоо байхгүй, нэгдсэн зохицуулалтгүй байгааг онцолж, цаашид анхаарах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрэв.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Аргачлалын 9-д заасны дагуу энэхүү үнэлгээний тайлангийн 5 дахь хэсгийн “Зохицуулалтын хувилбаруудын харьцуулсан дүгнэлт”, 6 дахь хэсгийн “Олон улсын болон бусад улсын хууль, эрх зүйн зохицуулалттай харьцуулсан байдал” зэрэг судалгааны үр дүнг харьцуулсны үндсэн дээр дараах зөвлөмжийг боловсрууллаа.

Хохирлын сангийн хуулийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах хүрээнд үндэсний хэмжээнд хохирол нөхөн барагдуулах түвшин хангалтгүй байгааг тодруулж, хохирогчдын эрх ашгийг хамгаалах, хохирлыг төрөөс барагдуулах боломжийг бүрдүүлэх чиглэлээр түлхүү анхаарах шаардлагатайг онцлов.

Холбогдох хуулийн төсөлд дараах зүйлийг зайлшгүй тусгах нь зүйтэй. Үүнд:

- Хохирлын сангийн хамрах хүрээ;
- Хохирлын сангийн санхүүжилт;
- Хохирлын сангаас нөхөн төлбөр авах эрх бүхий этгээд;
- Хохирлын сангаас нөхөн төлбөр авах эрх бүхий хохирогчийн гэр бүлийн гишүүний хамрах хүрээ, ангилал;
- Хохирлын сангаас нөхөн төлбөр гаргахтай холбогдуулан төлбөр төлөх гэмт этгээдэд тавигдах шалгуур;
- Хохирлын сангаас нөхөн төлбөр авах эрх бүхий этгээдэд тавигдах шалгуур;
- Хохирлын сангийн зарцуулалт;
- Хохирлын сангийн зохион байгуулалт зэрэг багтана.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хавсралт 1

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт	Тайлбар	
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Бүх төрлийн хохирогчдод төрөөс нөхөн төлбөр олгох боломжгүй тул зөвхөн тухайлан заасан хохирогч, субъектэд хамааралтай юм. Энэ нь онцгой тохиолдолд үйлчлэх тул ялгаварлан гадуурхсан гэж үзэх боломжгүй юм.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ялгаварлан гадуурхсан зохицуулалт агуулаагүй.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний эрх зүйн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Энэхүү хуулийн төсөл нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэх зохицуулалт шинээр бий болгоогүй ч олон улсын болон үндэсний эрх зүйн хэм хэмжээнд нийцэж байгаа болно.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Эрүүгийн хуулийн зохицуулалт олонхи, цөөнх гэж ялгахгүй тэгш үйлчилнэ. Бүх төрлийн хохирогчдод төрөөс нөхөн төлбөр олгох боломжгүй тул онцгой тохиолдолд үйлчлэх, зөвхөн тухайлан заасан хохирогч, субъектэд хамааралтай тул эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн гэж үзэх боломжтой.
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл нь иргэдийн үндсэн эрхээ эдлэх боломжийг бүрдүүлж байгаа тул эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй иргэд байхгүй юм.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээнд заасан хохирогчийн хохирлоо барагдуулах эрх, Үндсэн хуулийн зарчим хангагдах нөхцөл бүрдэх учир хүний эрхийг хамгаалах хүрээнд томоохон дэвшил гарна.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байна.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Гэмт этгээдийн үүрэх хариуцлагыг төр хэсэгчлэн хүлээж байгаа тул хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага тусгагдаагүй.

2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх, хууль ёсны зарчмыг бэхжүүлэх зорилготой байна. Иймд хууль ёсны байх зорилгод нийцсэн.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Тус хуулийн хамрах хүрээнд хязгаарлалт тогтоох шаардлагатай.
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Тодорхой төрлийн хохирогчид, түүний гэр бүлийн гишүүдийг тодорхойлно.
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Дээр дурдсан этгээдүүдийг эмзэг байдлын зэргээр нь тодорхойлох.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Хохирогчдын эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн.
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Дээрх үндэслэлээр
Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Шаардлагагүй
4.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Шаардлагагүй
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Шаардлагагүй

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хавсралт 2

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Нэмэлт зардал гарахгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хавсралт 3

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Хүний эрх төдийгүй, нийгмийн эмзэг бүлгийн хохирогчдын эрхийг хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэхэд чухал үр нөлөөтэй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллагад ямар нэг үүрэг хүлээлгээгүй, үйл ажиллагаанд нь сөргөөр нөлөөлөхгүй. Хүний эрх зөрчих нөхцлийг хязгаарлаж байгаа.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эерэгээр нөлөөлөх болно. Иргэний журмаар нэр төр, алдар хүндээ хамгаалуулахад шууд бусаар эерэг нөлөө үзүүлж байна.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж насралт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Гэмт хэргийн хохирогчид эрүүгийн эрх зүйн тогтолцоонд итгэх итгэл зайжирснаар цагдаагийн байгууллагад хандах хандлага ихсэж, хэрэг бүртгэлтийн үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлж, гэмт хэргийн илрүүлэлт сайжирна.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хавсралт 4

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

ГУРАВ. ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ БУСАД ШИНЖЛЭХ УХААНЫ НЭР ТОМЬЁОНЫ СУДАЛГАА

Судалгааг удирдсан: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.Jur.) Х.Эрдэм-Ундрах

Судалгааны багийн бусад гишүүд:

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (LL.D) С.Сүхбаатар

Эрдэм шинжилгээний ажилтан Х.Буянбат

Эрдэм шинжилгээний ажилтан Р.Хатансайхан

Эрдэм шинжилгээний ажилтан О.Энххүслэн

Эрдэм шинжилгээний ажилтан Х.Санчир

УДИРТГАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд¹ хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх, нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх, үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих, хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх, жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх зэрэг асуудлыг хуульчилсан байдаг.

Энэхүү зохицуулалт нь хууль зүйн техникийн ерөнхий дүрмийн нэг болох эрх зүйн логик зүй тогтлыг хангах дүрмийн нэр томъёог нэгдмэл байдлаар ойлгох агуулгад үндэслэдэг. Нэр томъёог нэгдмэл байдлаар ойлгох нь нэг баримт бичигт нэр томъёог өөр өөр утгаар зөрчилдүүлэн хэрэглэхгүй байх санааг агуулдаг бөгөөд хэрэв энэ дүрмийг зөрчсөн бол уг хууль зүйн баримт бичиг нь хэрэглэгчдийг төөрөгдүүлдэг².

Мөн хууль зүйн нэр томъёоны талаар зөв тодорхойлж, хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд тухайн нэр томъёоны талаар тал бүрээс нь судалж хүлээн зөвшөөрөгдөхүйц тодорхойлолтыг бий болгох нь чухал байдаг. Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаан нь эрүүгийн хуулийн түүхэн уламжлал, хөгжлийн чиг хандлага, гэмт хэрэг, ялын тухай, эрүүгийн эрх зүйн харьцуулсан судлал зэрэг өргөн ойлголтыг өөртөө багтаахын зэрэгцээ эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, криминологи, криминалистик, эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй, иргэн, хөдөлмөр, эдийн засгийн г.м салбар эрх зүйн болон бусад шинжлэх ухаантай нягт хөгжиж ирсэн юм³. Тиймээс эдийн засгийн шинжлэх ухааны нэр томъёог судлах нь Эрүүгийн хуулийн холбогдолтой зүйл, заалтуудыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх үндэс болно.

Иймд 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга буюу одоогийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулийн бусад шинжлэх ухааны нэр томъёо агуулагдсан зохицуулалтыг нэг мөр ойлгох, хэрэгжүүлэхэд болон дээр дурдагдсан шалтгаануудын улмаас Эрүүгийн хуулийн бусад шинжлэх ухааны нэр томъёог судлах хэрэгцээ, шаардлага бий болоод байна. Тиймээс тус судалгаагаар Эрүүгийн хуулийн бусад шинжлэх ухааны нэр томъёог судалж тухайн нэр томъёог нэг мөр ойлгох, хэрэгжүүлэх үүднээс тодорхойлолтыг боловсруулж, саналыг гаргасан юм.

Судалгааны объект буюу судалсан нэр томъёонууд

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга буюу одоогийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулиас бусад шинжлэх ухааны дараах нэр томъёог сонгон судлав.

Эдийн засгийн шинжлэх ухааны нэр томъёонууд:

1. Валют
2. Мөнгө угаах

Байгалийн шинжлэх ухааны нэр томъёонууд:

1 Хууль тогтоомжийн тухай хууль, 2015.

2 Т.В.Кашанина, Хууль зүйн техник, Орч. С.Гэрэлмаа, Д.Отгончимэг, Н.Тунгалаг, 2016, 104 дахь тал

3 Ж.Эрдэнэбулган, "Хууль зүйн нэр томъёоны судалгаа, хэрэглээ" сэдэвт улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, 2016, 99 дэх тал.

1. Гойд ашиг шимт мал

2. Тусгай хамгаалалттай газар

Нийгмийн шинжлэх ухааны нэр томьёонууд;

1. Садар самуун

2. Төрийн нууц

Анагаахын шинжлэх ухааны нэр томьёонууд:

1. Мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөт бодис

2. Халдварт өвчин

Хүн ам зүйн шинжлэх ухааны нэр томьёонууд:

1. Орон байр

2. Гэр бүлийн таагүй орчин

Сэтгэл зүйн шинжлэх ухааны нэр томьёонууд:

1. Сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан

2. Дураараа аашлах

Техникийн шинжлэх ухааны нэр томьёонууд:

1. Хор хөнөөлт программ хангамж

2. Галт зэвсэг, галт хэрэгсэл

Судалгааны арга зүй

Дээрх судалгааны ажлыг гүйцэтгэхдээ үгийн үндсийг тодорхой үндэслэлтэй гаргахын тулд шинжлэх ухааны гременивтик арга, түүхэн талаас нь түүхчлэх арга, тухайн үгийн агуулгыг илүү тодорхой болгохоор харьцуулалтын арга, холбогдох зүйл заалт, үгийн утга агуулгыг ойлгох үүднээс утга зүйн аргуудыг тус тус хэрэглэнэ.

ҮНДСЭН ХЭСЭГ

I.Эдийн засгийн шинжлэх ухааны нэр томьёо

1.“Мөнгө угаах” гэх нэр томьёоны тухайд

“Мөнгө угаах” гэх нэр томьёог хэл шинжлэлийн үүднээс “хууль зөрчиж олсон бохир мөнгийг гүйлгээнд оруулж өөрийн болгон арвижуулах” гэж тодорхойлсон байна⁴.

Хууль зүйн талаас: 2015 оны Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлийн 1-т болон 2002 оны Эрүүгийн хуулийн 166¹ дүгээр зүйлийн 1-т зааснаар “Мөнгө угаах” гэдгийг гэмт хэргийн түвшинд дараах байдлаар тайлбарлажээ.

Хүснэгт 3.1. Эрүүгийн хуулиуд дахь зүйл, заалтуудын харьцуулсан нь №1

2015 оны Эрүүгийн хууль	2002 оны Эрүүгийн хууль
Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах , гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан	Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуух, далдлах , гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эсхүл эд хөрөнгийн эрхийг нуусан, далдалсан

“Мөнгө угаах” гэдэг нь хууль бусаар олсон мөнгө, эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж, түүний гарал, үүслийг нуун далдалж, уг эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж түүний гарал, үүслийг нуун далдалж, уг эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хууль ёсных болгох зорилгоор гүйлгээнд оруулах өргөн хүрээтэй шат дамжлага бүхий үйл ажиллагаа юм. Мөнгө угаах үйл ажиллагаа нь үндсэндээ гурван үе шаттайгаар явагддаг. Нэг дэх үе шат нь хар болон бохир мөнгийг хууль ёсны бизнесд оруулах явдал. Хоёр дахь шатанд олон тооны үйлдэл хийсний дараа уг мөнгөний анхны эх сурвалж бүдгэрч танигдахгүй болох ба ул мөр арилна. Гурав дахь үе шатанд уг мөнгө шинээр хууль ёсны эх сурвалжтай болно⁵.

Эрх зүйн толь бичигт тухайн нэр томьёог англиар money laundering, оросоор отмывание денежных средств гэж орчуулсан ба “гэмт хэргийн улмаас олж авсан мөнгө буюубусадэдхөрөнгийгхуульёсныболгохзорилгоорхөрвүүлэхүйлажиллагаа. Хууль бус ажиллагаанаас олсон орлогыг тээвэрлэх, шилжүүлэх, хөрвүүлэх, хувиргах ба хууль ёсны дагуу олж авсан бусад мөнгө, хөрөнгөтэй нийлүүлэх замаар эдгээр орлогын мөн чанар, эх үүсвэр, зарцуулалт, шилжилт хөдөлгөөн, өмчлөлийн талаарх мэдээллийг нуун далдлах төөрөгдүүлэх үйл ажиллагаа юм. Мөнгө угаах нь дараах үе шаттай: байршуулах(хууль бус ажиллагаанаас олсон мөнгийг тээвэрлэх, шилжүүлэхэд хялбар бөгөөд хүний анхаарал хамгийн бага татах актив хөрөнгөнд хөрвүүлэн санхүүгийн системд шилжүүлэх); давхардуулах(олон тооны санхүүгийн гүйлгээний тусламжтайгаар хөрөнгө, мөнгөний гарал үүслийг нуун далдлах);

4 Монгол хэлний их тайлбар толь, <https://mongoltoli.mn/search.php?opt=1&word=%D0%BC%D3%A9%D0%BD%D0%B3%D3%A9+%D1%83%D0%B3%D0%B0%D0%B0%D1%85>.

5 Монгол Улсын Дээд шүүх, Ханнс-Зайделийн сан, “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар”, 2013, 429 дэх тал.

интеграци (гарал үүслийг нь хангалттай далдалж нуусан хөрөнгө мөнгийг хууль ёсны үйл ажиллагаанд оруулах, санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах)⁶” гэж мөнгө угаах гэх нэр томьёог тодорхойлсон байна.

Мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэлээр зүйлчлэгдсэн хэргийн тухайд дараах төрлийн гэмт хэргүүд үйлдэгдэж байна.

“Р.Б, Д.Б, Н.Д нар нь 2020 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн 16 цагийн үед Баянзүрх дүүргийн 27 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 95 дугаар худгийн гадна байрлуулсан 29-38 УНИ улсын дугаартай тээврийн хэрэгслээс хамт явж байсан Болдоо гэгч нь хохирогчийн гар цүнхийг хулгайлж 1.509.100 төгрөгийн хохирол учруулж “бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан” гэмт хэргийг үйлдэж олсон эд хөрөнгийг гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж түүнийг ашигласан, түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдалсан гэмт хэргийг үйлдсэн.”⁷

“Х.Э нь хохирогч Б.Мөнхзулын өмдний арын халааснаас Г.С нь 400.000 төгрөгийн үнэ бүхий Айфон-7 загварын гар утсыг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар хулгайлан авсан буюу гэмт хэргийн замаар олсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж бусдад худалдан борлуулсан.”⁸

Хууль зүйн шинжлэх ухааны хувьд тухайн нэр томьёог авч үзвэл “мөнгө угаах нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг эвдээд зогсохгүй эдийн засгийн хямралд хүргэдэг нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл юм. Энэ хэргийн улмаас олон улсын тавцанд дотоодын банк, санхүүгийн байгууллагуудын нэр хүнд унах, банк, санхүүгийн байгууллагаар дамжин хийгдэж байгаа гадаад гүйлгээг саатуулан шалгах, тэдгээртэй харилцахаас татгалзах хүртэлх арга хэмжээ авдаг нь эдийн засагт сөрөг нөлөөтэй юм. НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, Авилгын эсрэг НҮБ-ын конвенцод заасан агуулгаар гэмт хэргийн шинжийг тодорхойлсон. УИХ-аас 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг баталж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн үндсийг бүрдүүлж, 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай хуулиар шинээр гэмт хэрэг болгон хуульчилсан⁹” гэж тодорхойлсон.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын 6 дугаар зүйлд мөнгө угаах гэмт хэргийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Тус конвенцод оролцогч улс бүр дотоодын хууль тогтоомжийн үндсэн зарчимд нийцүүлэн дараах үйлдлүүдийг санаатай үйлдсэн тохиолдолд гэмт хэрэг болгон хуульчлахаар зохицуулсан.

6 С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, 2007, 288 дахь тал.

7 Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, 2021 оны 08 сарын 24 өдрийн Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн дугаар 2021/ШЦТ/584 тогтоол, https://shuukh.mn/single_case/58966?daterange=2021-01-01%20-%202021-12-14&id=1&court_cat=2&bb=1

8 Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, 2021 оны 08 сарын 05 өдрийн Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн дугаар 2021/ШЦТ/457 тогтоол, https://shuukh.mn/single_case/57513?daterange=2021-01-01%20-%202021-12-14&id=1&court_cat=2&b=1

9 С.Гантулга, Б.Энхболд, “Эрүүгийн эрх зүй Тусгай анги сурах бичиг”, (2018), 223 дахь тал

- Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн.
- Гэмт хэргийн улмаас олсон орлого гэдгийг мэдсээр байж түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан, хувиргасан.
- Гэмт хэргийн улмаас олсон орлого гэдгийг мэдсээр байж эд хөрөнгө олж авах, эзэмших, ашиглах.
- Гэмт хэрэг үйлдэхэд оролцох, хамтрах, хуйвалдаан хийх, завдах, туслах, өдөөх, хөнгөвчлөх, зөвлөгөө өгөх.
- Тус гэмт хэргийг хуульчилж хэрэглэх, хэрэгжүүлэх зорилгоор оролцогч улс бүр хамгийн өргөн хүрээний гэмт хэрэгт тухайн зохицуулалтыг хэрэглэхийг эрмэлзэнэ¹⁰.

ФАТФ-аас 2003 онд 40 зөвлөмж, стандарт гарсны нэг нь “Тус гэмт хэргийг хуульчилж хэрэглэх, хэрэгжүүлэх зорилгоор оролцогч улс бүр хамгийн өргөн хүрээний гэмт хэрэгт тухайн зохицуулалтыг хэрэглэхийг эрмэлзэнэ” гэх заалтын тайлбар, шаардлага байна. Үүнд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц, 1988 (Венийн конвенц) болон Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, 2000 (Палермогийн конвенц)-оор зохицуулсан тухайн асуудлыг хэрхэн тайлбарлах талаар дараах байдлаар тодорхойлсон байна.

“Улс орон бүр мөнгө угаах гэмт хэргийг өргөн хүрээний, ноцтой гэмт хэргийн хувьд хэрэглэх ёстой ба үүнийг бүх гэмт хэрэгт хэрэглэх үү, ноцтой гэмт хэрэгт хэрэглэх үү, ялын босгыг үндэслэн хэрэглэх үү гэдгийг сонгох арга хэрэгтэй. Улс орон бүр тус аргыг хэрэглэхдээ байж болох доод хэмжээг үндэсний хууль тогтоомжийн ноцтой гэмт хэрэг гэх ойлголтод хамааруулах, хорих ялын дээд хэмжээг 1 жилээс дээш тогтоосон гэмт хэрэгт хамааруулах, хорих ялын доод хэмжээг 6 сараас дээш тогтоосон гэмт хэрэгт хамааруулах гэсэн аргуудыг хэрэглэх ёстой. Аль ч аргыг сонгосон тодорхой төрлийн хэд хэдэн гэмт хэргүүд заавал орох ёстой. Мөн дотооддоо үйлдэгдсэн мөнгө угаах гэмт хэргийг зөвхөн тусгайлан хуульчилж зохицуулж болно. Мөн дотоодын хууль тогтоомж, зарчмаар тухайн хүний үйлдсэн өөр гэмт хэргийг, мөнгө угаах гэмт хэрэгтэй хамааралгүй байдлаар зохицуулах боломжтой.”¹¹

Дээрхээс дүгнэвэл хууль зүйн талаас Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцод зааснаар нэгдсэн байдлаар ойлгож байгаа хэдий ч өргөн хүрээгээр тухайн гэмт хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуульд тусгаагүй байгаа нь харагдаж байна. Мөн тус гэмт хэргийн зүйлчлэлээр зүйлчлэгдсэн тохиолдол нь мөн тус шалгуурт нийцэхгүй байгаа нь харагдаж байна.

10 United Nations Convention against Transnational Organized Crime, Article 6, General Assembly Resolution 55/25 of 15 November 2000, https://www.unodc.org/documents/middleeastandnorthafrica/organised-crime/united_nations_convention_against_transnational_organized_crime_and_the_protocols_thereto.pdf

11 FATF Standarts; FATF 40 Recommendations, 2003, <https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/FATF%20Standards%20-%2040%20Recommendations%20rc.pdf>.

Эдийн засгийн шинжлэх ухааны талаас: Эдийн засгийн шинжлэх ухааны хувьд тухайн нэр томьёог тодорхойлбол “мөнгө угаах /Money laundering/ буюу илт хууль бусаар олсон хөрөнгийг мэдсээр байж олж авсан, хувиргасан, шилжүүлсэн, эсхүл хууль ёсны байдалтай болгохын тулд эх үүсвэрийг нь халхавчилсан, нуун далдалсан, өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг шилжүүлсэн, бодит шинж чанар, хэлбэр, байршлыг нь өөрчилснийг ойлгоно¹²” гэж тодорхойлсон байна.

Мөн мөнгө угаах гэдгийг хар тамхины наймаа, террорист үйл ажиллагаа зэрэг ноцтой гэмт хэргээс олсон их хэмжээний мөнгийг хууль ёсны эх сурвалжаас олсон мэт харагдуулах үйл явц¹³ гэж тодорхойлсон.

Эдийн засаг болон мөнгө угаах гэмт хэргийн хоорондын харилцаа холбооны хувьд бодит эдийн засагтай зэрэгцэн байдаг далд эдийн засагтай холбогддог. Далд эдийн засаг нь үл үзэгдэх, далд, зэрэгцэн орших, хууль бус, албан бус шинж чанартай. Өмнө нь эмх замбараагүй шинж чанартай, судлахад хүндрэлтэй элементүүдийг үгүйсгэдэг байсан. Харин одоо далд үйл ажиллагаа дэлхийн эдийн засагт илэрч байгаа тул үүнийг үл тоомсорлож болохгүй. Гэвч олон улсын гэмт хэргийн бүлэглэлүүдийн үйл ажиллагааны талбар, даяаршлын үр дүнд бий болсон технологийн дэвшлийн улмаас эдгээр үйл явдлын бодит байдал нь улс орнуудын хянах боломжоос давсан. Гэмт хэргийн бүлгүүд даяаршсан зах зээл дээрх байгууламжуудыг ашиглах талаар зарим муж улсуудаас илүү сайн мэддэг байгаа нь олон улсын байгууллагууд өөрсдийн хөтөлбөрөө дэлхийн далд эдийн засгийн янз бүрийн хэлбэрт нийцүүлэхэд хүргэсэн. Өндөр хөгжилтэй зарим орнуудад далд эдийн засаг тасралтгүй хөгжиж байгаа бөгөөд үүний эсрэг тэмцсээр байна. Тухайлбал, орлогоо нэмэгдүүлэх зорилгоор залилан мэхлэх, зэвсэг, хар тамхины наймаа, терроризм, авлига, мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгдэж байна¹⁴. Үүнээс гадна мөнгө угаах нь мөнгөний эрэлт, нийлүүлэлт, хөгжлийн түвшин, цалингийн хуваарилалт, татварын орлого, санхүүгийн байгууллага зэрэгт сөргөөр нөлөөлдөг¹⁵.

Эдийн засгийн шинжлэх ухааны зүгээс мөнгө угаах гэмт хэргийг тодорхойлсон байдлыг дүгнэвэл өмнөх хэсэгт дүгнэсэнтэй ижил өргөн хүрээний буюу дэлхийн, улсын эдийн засагт хохирол учруулдаг, зохион байгуулалттай бүлэг үйлддэг талаар тодорхойлогдсон байна. Тиймээс дараах саналыг гаргаж байна.

Мөнгө угаах гэх нэр томьёоны тухайд Монгол Улсын Эрүүгийн хуульд зохицуулсан болон хэрэглэж байгаа байдлыг өргөн хүрээнд тодорхойлж ойлгох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл тус нэр томьёог өргөн хүрээнд, ноцтой гэмт хэргийн хувьд, гэмт хэргийн бүлэглэл үйлдсэн тохиолдолд гэх хүрээнд ойлгох ёстой.

12 Монгол банк, Дэлхийн банк, Эдийн засаг, санхүүгийн нэр томьёоны тайлбар толь, 2015.

13 Edward R. Raupp, Ph.D, Danna Vance Raupp, Dictionary of Economic Terms, 2018, p.210.

14 Rădulescu Dragoş Lucian, The Concept of Money Laundering in Global Economy, International Journal of Trade, Economics and Finance, Vol.1, No.4, December, 2010.

15 Sanction scanner, What Are The Negative Effects of Money Laundering on The Economy?, <https://sanctionscanner.com/blog/negative-effects-of-money-laundering-on-the-economy-132>

2. “Валют” гэх нэр томъёоны тухайд

“Валют” гэх нэр томъёог хэл шинжлэлийн үүднээс “Гадаадын мөнгөний нэгжээр илэрхийлдэг банкны данс, төлбөрийн баримт бичиг, мөнгөн тэмдэгт” гэж тодорхойлсон байна¹⁶.

2002 оны Эрүүгийн хуульд “Валютын ханш” гэх томъёог ашиглаагүй. Түүнчлэн, уг хуулийн 175.1-д “Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх” гэмт хэргийн хүрээнд “валют”, “валютын үнэт зүйл” гэх нэр томъёог ашигласан.¹⁷ Харин 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар “Валютын ханш” гэх нэр томъёог 1 удаа хэрэглэсэн. Тодруулбал, 2015 оны Эрүүгийн хуулийн 18.2 дугаар зүйд “Валют, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшид нөлөөлөх” гэмт хэргийн обьектив шинж болгон “Валютын ханш” гэх нэр томъёог хэрэглэсэн.¹⁸ Өөрөөр хэлбэл 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар “Валют, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшид” нөлөөлөхийг үйлдлийг эдийн засгийн эсрэг гэмт хэрэг болгон шинээр хуульчилсан.

Валютын ханш болон валют гэх нэр томъёоны тухайд эрх зүйн болон эдийн засгийн толь бичгүүдэд тодорхойлсоор иржээ. Академич С.Нарангэрэлийн эрх зүйн толь бичигт валют гэдгийг (лат. *valere*; итал. *valuta*; англ. *currency*)¹⁹ нэгдүгээрт тухайн улсын мөнгөний тогтолцоог бүрдүүлдэг мөнгөний нэгж, хоёрдугаарт улсын мөнгөний тогтолцооны хэв шинж (алтан Валют, мөнгөн Валют, цаасан Валют), гуравдугаарт гадаад улсын мөнгөн тэмдэгт (гадаад валют), дөрөвдүгээрт гадаадын мөнгөний нэгжээр илэрхийлэгдсэн, олон улсын төлбөр тооцоонд ашиглагддаг эргэлтийн болон төлбөрийн зээлийн хэрэгслүүд (гадаад валют), тавдугаарт засгийн газар хоорондын валют-зээлийн байгууллагад адил хэрэглэгддэг улс хоорондын мөнгөний нэгж, зургаадугаарт Монгол Улсад валютын, гадаад валют, улс хоорондын худалдаа, эдийн засгийн харилцааны төлбөрт хэрэглэгдэж буй тооцооны нэгж, мөнгөжсөн алт болон валютын үнэт зүйлс. Монгол Улсад Валютын төрөл нь: 1. үндэсний валют-эргэлтэд байгаа төлбөрийн чадвар бүхий Монгол Улсын мөнгөн тэмдэгт төгрөг, түүгээр илэрхийлэгдсэн бөгөөд олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг үнэт цаас, төлбөрийн хэрэгсэл; 2. гадаад валют- эргэлтэд байгаа төлбөрийн чадвар бүхий нэг буюу хэд хэдэн улсын мөнгөн тэмдэгт, тэдгээрээр илэрхийлэгдсэн бөгөөд олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг үнэт цаас, төлбөрийн хэрэгсэл; 3. мөнгөжсөн алт- олон улсын жишигт хүргэн цэвэршүүлж, олон улсын санхүүгийн аль нэг төвд хадгалуулж байгаа, гадаадын валютаар борлуулахад бэлэн болсон алт; 4. валютын үнэт зүйлс- мөнгөжсөн алттай адилтгах үнэт металл, эрдэнийн чулуу байна гэж тайлбарласан байна²⁰.

Харин валютын ханш гэдгийг (англ. *Rate of exchange*; ор. Валютный курс)- нэг улсын мөнгөний нэгжээр илэрхийлэгдсэн нөгөө улсын мөнгөний нэгжийн үнэ ба валютын ханш нь үндэсний валютыг олон улсын валютын нэгжтэй (жишээ нь евро) харьцуулж хэрэглэдэг гэж тодорхойлсон²¹. Эдийн засгийн эрх зүйн толь бичигт валют гэдгийг нэгдүгээрт улс орны мөнгөний нэгж, түүний хэв маяг /алтан, мөнгөн,

16 Монгол хэлний их тайлбар толь, <https://mongoltoli.mn/search.php?opt=1&word=%D0%B2%D0%B0%D0%BB%D1%8E%D1%82#>.

17 Эрүүгийн хууль, 2002.

18 Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, 2017.

19 S.Narangerel, English-Mongolian jurisprudence dictionary, 2005, 274 дэх тал.

20 ХЗДХЯ, Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь, 2021, 65 дахь тал

21 С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, 2007, 102 дахь тал

цаасан/, хоёрдугаарт олон улсын тооцоонд ашигладаг гадаад улсын мөнгөн тэмдэгт, гуравдугаарт үндэсний тооцооны нэгж, төлбөрийн хэрэгсэл, дөрөвдүгээрт Монгол Улсын үндэсний валют, гадаад валют, улс хоорондын худалдаа, эдийн засгийн харилцааны төлбөрт хэрэглэгдэж буй тооцооны нэгж, мөнгөжсөн алт болон валютын үнэт зүйлс гэж, валютын ханш гэдгийг (русс: валютные курс, англ: course of exchange, rate of exchange) тухайн улсын мөнгөний гадаадын валют, олон улсын валютын нэгжээр илэрхийлэгдэх “үнэ хэмжээг тайлбарлажээ”. Өөрөөр хэлбэл худалдан авах өртөг ба бусад хүчин зүйлсээр тодорхойлогддог үндэсний ба гадаадын валютын харьцаа юм. Валютын ханшинд худалдан авах чадвар, төлбөрийн баланс, зээлийн хүү, валютын захын үйл ажиллагаа, олон улсын зах зээл дээр тухайн валютад итгэх итгэлийн түвшин, валютын ханшинд хийх төрийн зохицуулалт зэрэг хүчин зүйлсүүд нөлөөлдөг. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг Монгол банк валютын зах зээл дээр арилжааны банкуудын худалдсан, худалдаж авсан гадаад валютын ханшинд үндэслэн тус улсын гадаад худалдаанд зонхилон хэрэглэж байгаа тогтвортой ханш бүхий чөлөөтэй хөрвөдөг аль нэг гадаад улсын валютын тухайн үеийн ханштай жишин тогтоож нийтэд зарлана. Ингэхдээ ханш нь чөлөөтэй бөгөөд бодитой байх, төгрөгийн тогтвортой байдал болон үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжлийг хангах зарчмыг баримтална.

Валютын зохицуулалтын тухайд төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Төгрөг, юаний своп хэлцлийн журам, Валютын своп, форвард хэлцлийн журам зэрэг хууль, журмууд болон Монголбанкны ерөнхийлөгчийн тушаалуудаар²² зохицуулагддаг. Валют гэдгийг 1994 оны “Валютын зохицуулалтын тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 1-т зааснаар Монгол Улсын үндэсний валют, гадаад валют, улс хоорондын худалдаа, эдийн засгийн харилцааны төлбөрт хэрэглэгдэж буй тооцооны нэгж, мөнгөжсөн алт болон валютын үнэт зүйлсийг хэлнэ гэж тодорхойлсон. Мөн тухайн хуулийн 3 дугаар зүйлийн 2-т зааснаар үндэсний валютыг эргэлтэд байгаа төлбөрийн чадвар бүхий Монгол Улсын мөнгөн тэмдэгт-төгрөг, түүгээр илэрхийлэгдсэн бөгөөд олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг үнэт цаас, төлбөрийн хэрэгсэл гэж, гадаад валютыг эргэлтэд байгаа төлбөрийн чадвар бүхий нэг буюу хэд хэдэн гадаад улсын мөнгөн тэмдэгт, тэдгээрээр илэрхийлэгдсэн бөгөөд олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг үнэт цаас, төлбөрийн хэрэгслийг хэлнэ. Гадаад валютыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрснөөр чөлөөтэй хөрвөдөг гэж, мөнгөжсөн алтыг олон улсын жишигт хүргэн цэвэршүүлж, олон улсын санхүүгийн аль нэг төвд хадгалуулж байгаа, гадаад валютаар борлуулахад бэлэн болсон алтыг гэж, валютын үнэт зүйл гэдгийг мөнгөжсөн алттай адилтгах үнэт металл, эрдэнийн чулууг хэлнэ гэж тус тус тодорхойлсон байна.

Үүнээс гадна 2009 оны “Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай” хуулийн 3.1.5-т зааснаар гадаад валютыг гадаадын мөнгөн тэмдэгт, гадаадын валютыг хэлнэ гэж тодорхойлсон байна. Харин тухайн хуулиудад валютын ханш гэх нэр томьёоны талаар тайлбарласан тодорхойлолт байхгүй байна. Монголбанкны гарын авлагад тухайн нэр томьёоны талаар валют гэдэг нь гадаад, дотоод төлбөр тооцоонд хэрэглэгдэж байгаа аль нэг улсын мөнгөн тэмдэгтийг хэлнэ гэж тодорхойлоод үндэсний валют гэдэгт тухайн улсын албан ёсны мөнгөн тэмдэгт, гадаад валют гэдэгт гадаад улс орны эрх бүхий байгууллагаас гаргасан мөнгөн

22 Валют зохицуулалтын талаар эрх зүйн актууд, <https://www.mongolbank.mn/listlawsandregulationsdb.aspx?id=4>.

тэмдэгт хамаарахаар тайлбарласан. Мөн тухайн гарын авлагад валютын ханшийн талаар дараах байдлаар тайлбарласан байна. Валютын ханш гэдэг нь аль нэг улсын валютыг өөр нэгэн улсын валютаар илэрхийлсэн үнэ юм. Өөрөөр хэлбэл тухайн улсын нэгж валют өөр улсын валютын хэдэн нэгжтэй тэнцэхийг харуулдаг үзүүлэлт юм. Жишээ нь: АНУ-ын 1 ам.доллар = 2427 төгрөг гэх мэт. Валютын ханш буюу гадаад валютын үнэ уг валютын эрэлт, нийлүүлэлтээр тодорхойлогдоно. Жишээлбэл, гадны орон руу аяллаар явах үед хэрэглээний бараа бэлэг дурсгалын зүйлс, хоол хүнс, зочид буудлын төлбөр бусад бүтээгдэхүүн худалдан авахад гадаад валют зайлшгүй хэрэг болдог. Энэ нь гадаад валютын эрэлтийг бий болгож буй нэг жишээ юм. Монгол Улсад гадаадын жуулчид ирж ам.доллар эсвэл евро зэрэг гадаад валютаа солиулан бараа бүтээгдэхүүн худалдан авч байгаа нь эсрэгээрээ валютын нийлүүлэлтийг нэмэгдүүлж буй жишээ болно²³. Валютын ханш гэдгийг эрүүгийн эрх зүйн сурах бичигт тодорхойлохдоо үндэсний мөнгөн тэмдэгтийн бусад орны мөнгөн тэмдэгттэй харьцуулсан үнэ юм гэж тодорхойлоод валютын ханш нь байнгын хөдөлгөөнд оршин байдаг ба ингэснээр тухайн орны эдийн засаг өөрөө өөрийгөө тэнцвэржүүлэх боломжийг олгодог. Валютын ханшид зохиомлоор нөлөөлөх нь гадаад зах зээлийн гэнэтийн өөрчлөлтийн дотоод эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг ихэсгэж, эдийн засгийн тогтворгүй байдлыг бий болгох, экспортын болон дотоод үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг бууруулах замаар урт хугацааны эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлдөг²⁴ гэж тайлбарласан юм.

Дээрх тодорхойлолт, тайлбаруудаас гадна гадаад улсуудын тухайн нэр томьёог тайлбарласан тодорхойлолтыг судалж үзэх нь зүйтэй байна. Гадаад улсуудын эрх зүйн толь бичигт валют гэдгийг тодорхой улсад хэрэглэгддэг цаасан болон зоосон хэлбэртэй мөнгө²⁵, валютын ханш гэдгийг нэг валютын ханш бусад валютын ханштай харьцах харьцаа²⁶ гэж тус тус тодорхойлсон. Мөн өөр эрх зүйн толь бичигт валютыг гараас гарт эргэлддэг арилжааны хэрэгсэл болох зоосон мөнгө, банкнаас гаргасан цаасан мөнгө болон бусад цаасан мөнгө²⁷ гэж, валютын ханшийг худалдаачдын дунд нэг улсад нөгөө улсын үнэт цаасыг зарах үнийг ойлгоно гэж²⁸ тус тус бичжээ. Эдийн засгийн толь бичигт харин валютыг засгийн газраас гаргасан цаасан мөнгө, зоос²⁹, валютын ханш гэдгийг нэг улсын мөнгөн тэмдэгтийг өөр улсын мөнгөн тэмдэгтээр солих ханш буюу үнэ³⁰ гэж нэр томьёог тодорхойлсон.

2014 оноос эхлэн технологийн дэвшилтэд тулгуурлан үүссэн виртуал валют буюу виртуал хөрөнгийг валютад тооцох асуудал маргаан дагуулж байна. Сүүлийн жилүүдэд виртуал хөрөнгийн зах зээлд эзлэх хэмжээ огцом нэмэгдэж шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнесийн загварууд мөн виртуал валют хоорондын шилжүүлэг идэвхитэй үргэлжилж байна.

23 Монголбанк, Валютын ханш Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан гарын авлага, 2020, 5-6 дахь тал.

24 С.Гантулга, Б.Энхболд, Эрүүгийн эрх зүй Тусгай анги, 2018, 213 дахь тал.

25 PH.Collin, Dictionary of law, 2004, P.81.

26 PH.Collin, Dictionary of law, 2004, P.113.

27 Black's Law Dictionary, <https://thelawdictionary.org/currency/>.

28 The free dictionary by Farlex, <https://legal-dictionary.thefreedictionary.com/Rate+of+exchange>.

29 Edward Robert Raupp and Danna Vance Raupp, Dictionary of Economic term, 2018, P.66.

30 Edward Robert Raupp and Danna Vance Raupp, Dictionary of Economic term, 2018, P.102.

Виртуал хөрөнгө гэдэг нь дижитал хэлбэрээр арилжих, шилжүүлэх боломжтой бөгөөд төлбөр, тооцоо мөн хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглаж болох үнэ цэнэ бүхий дижитал буюу тоон хэлбэртэй хөрөнгө юм.³¹ Улс орнуудын криптовалютын зохицуулалтыг дэмжигчид, хөгжүүлэгчид, дундыг баримталсан, эсрэг байр суурь бүхий, хориглосон гэсэн 5 төрөл хуваан үздэг. Тодруулбал, Япон улс нь криптовалютыг хөгжүүлэгч улс орон бөгөөд 2017 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэглээний татвараас чөлөөлж, төлбөр тооцооны нэг хэрэгсэл гэж хуулийн дагуу хүлээн зөвшөөрсөн.³² (Австрали, Канад, Украин, ОХУ, Шинэ Зеланд мөн адил төлбөрийн хэрэгсэл гэж хүлээн зөвшөөрсөн.) БНХАУ, Исланд, Болив зэрэг улсуудад криптовалютыг төлбөр тооцооны хэрэгсэл болгон ашиглахыг хориглосон. Харин Колумб, Бельги, Польш, Энэтхэг зэрэг улс орнууд криптовалютыг төлбөр тооцооны хэрэгсэлээр болгон зохицуулах талаар хуульчлаагүй байна.

Манай улсын хувьд Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд Монгол Улсын газар нутагт төлбөр тооцоог төгрөгөөр гүйцэтгэхээр заасан. Татварын ерөнхий хуульд цахим хөрөнгөөс татвар авах зохицуулалт тусаагүй, Авлигын эсрэг хуульд болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд хөрөнгө орлогын мэдүүлэгт виртуал хөрөнгийг бүртгүүлэх шаардлага тавиагүй байна.³³ Түүнчлэн, дэлхийн 81 улс крипто валютыг хүлээн зөвшөөрсөн байдаг. Үүний үр дүнд тус орнуудын гадаад хөрөнгө оруулалт нэмэгдэж, дижитал өрсөлдөх чадвар өсч байгаа эерэг үзүүлэлтүүд гардаг байна.³⁴ гэжээ. Үүнээс үзвэл манай улсад виртуал хөрөнгө буюу криптовалютын эрх зүйн зохицуулалтын талаар хууль тогтоогч хэлэлцэж байна.

II. Байгалийн шинжлэх ухааны нэр томьёо

1. “Гойд ашиг шимт мал” гэх нэр томьёоны тухайд

Гойд хэмээх үгийг Монгол хэлний их тайлбар тольд “онц, тасархай, гоц”³⁵ хэмээн тайлбарласан бол мөн тольд “ашиг шим” гэдгийг “үр өгөөж, хэрэгцээт зүйл”³⁶ гэсэн утгатай гэж тайлбарлажээ. Дээрхээс дүгнэвэл гойд ашиг шимт мал гэдэг нь бусад малаас гоц тасархай буюу маш их үр өгөөж, хэрэгцээтэй мал хэмээн ойлгогдохоор байна.

Хууль зүйн үүднээс тодорхойлох нь

1992 онд шинэ Үндсэн хууль батлагдсантай холбоотой 1996 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн хуулиар мал хулгайлах гэмт хэргийг шинээр Эрүүгийн хуулийн 123¹ зүйлд бие даасан гэмт хэрэг байдлаар хуульчлан зохицуулж байсан. Тус

31 Виртуал хөрөнгө: Криптовалютын зохицуулалт, Хүртээмжтэй санхүү, Дугаар 15, 2020, 7-9 дэх тал.

32 Мөн тэнд.

33 Монгол банк, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажлын тайлан, <https://mojha.gov.mn/wp-content/uploads/2021/01/VASP-%D2%AF%D1%80-%D0%BD%D3%A9%D0%BB%D3%A9%D3%A9%D0%BD%D0%B8%D0%B8%CC%86-%D1%81%D1%83%D0%B4%D0%B0%D0%BB%D0%B3%D0%B0%D0%B0-final.pdf>.

34 Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийн ажлын хэсэг хуралдаан, 2021.08.12, <http://parliament.mn/n/jrzon>.

35 Монгол хэлний их тайлбар толь, <https://mongoltoli.mn/dictionary/detail/24537>.

36 Мөн тэнд.

зүйлийн 3-дахь хэсэгт гойд “ашиг шимт мал”-ыг хулгайлах үйлдлийг уг гэмт хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүн байхаар заажээ. Энэ нь бидний одоогийн судалснаар “ашиг шимт мал” гэх нэр томъёог хуульд ашигласан хамгийн анхны тохиолдол юм.

123¹. Мал хулгайлах

3. Энэ хэргийн улмаас хохирогч амьдралын эх үүсвэрээсээ салсан, нийтэд учирсан гамшигт байдлыг далимдуулж буюу машин механизм ашиглаж, эсхүл айлын хотноос болон гойд ашиг шимт мал, хурдан жороо морь хулгайлсан, хохирогчийг тохуурхан даажигнаж үйлдсэн бол дөрвөөс арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

1997 онд Улсын дээд шүүх уг нэр томъёог биологи, аж ахуйн ашигтай аль нэг буюу хэд хэдэн шинж чанараараа тухайн үүлдэр, омог хэвшлийн мал сүргийн дотроос ашиг шимийн онцгой давуу чанар, хамгийн өндөр үзүүлэлтээр шалгарсан Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуульд зааснаар баталсан журмын дагуу сонгон шалгаруулж улсын бүртгэлд бүртгэн баталгаажуулж гэрчилгээ олгосон малыг хамааруулж ойлгоно³⁷ хэмээн тайлбарласан байдаг. Энд өгүүлж буй Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль нь 1993 онд батлагдан хэрэгжиж байсан хууль юм. Харин 2001 оны 6 сарын 7-ны өдөр уг хуулийн шинэчлэн найруулга батлагдсан бөгөөд тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-дахь хэсэгт «гойд ашиг шимт мал» гэж “тухайн үүлдэр, омог, хэвшлийн малын стандартыг бүрэн хангахын зэрэгцээ үржил, ашиг шимийн нэг буюу хэд хэдэн чанараар онцгой давуу болох нь баталгаажсан малыг”³⁸ хэмээн заажээ.

2015 оны Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 2.6-д “гойд ашиг шимт малыг хулгайлж үйлдсэн бол” гэх диспозици тусгагдсан байдаг. Тухайн зохицуулалтын хамгийн гол тодруулах зүйл бол “гойд ашиг шимт мал” гэх нэр томъёо юм. Тухайн нэр томъёог тодруулахын тулд бусад эрх зүйн хэм хэмжээг ашиглах нь зүйтэй. 2017 оны Малын генетик нөөцийн тухай³⁹ хуулийн 4.1.9-т “гойд ашиг шимт мал” гэж үүлдэр, омгийн мал сүргээс үржил, ашиг шимийн нэг буюу хэд хэдэн чанараар онцлог давуу болох нь баталгаажсан малыг хэлнэ хэмээн тодорхойлсон байдаг. Харин “гойд ашиг шимт мал”-ыг хэрхэн шалгаруулах талаар тус хуулийн 15.4-т “Малын үндэсний генийн санд үржүүлгийн бүтээгдэхүүн байршуулах, бүртгэх, зарцуулах, хяналт тавих болон гойд ашиг шимт мал шалгаруулах журам, энэ хуулийн 15.1-д заасан үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааны бүтэц, орон тоог малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж зааснаар Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд тухайн журмыг батлахаар хуульчлагджээ.

2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын А-346 тоот тушаалын хавсралтаар тухайн хуулийн зохицуулалтын дагуу “Гойд ашиг шимт мал шалгаруулах журам”-ыг баталсан байна. Уг журмын зорилт нь ашиг шимийн гарц, чанар, удам зүйн үнэлгээ, эрүүл мэндээр баталгаажсан шилмэл мал болон ашиг шимийг нь ашигладаг тэжээвэр амьтныг олон нийт, мал үржүүлэгчдэд сурталчлан таниулж, стандартын шаардлага хангасан хээлтэгч, хээлтүүлэгчийг аж ахуйн нэгж, иргэдэд борлуулах, малчид, мал үржүүлэгчдийн хөдөлмөр бүтээлийг үнэлж, урамшуулахад оршдог байна. Энэхүү журмаар дараах онцлог зохицуулалт хийжээ.

37 Монгол Улсын Дээд Шүүхийн мэдээлэл, 1997, № 2, 3 дахь тал.

38 МУ-ын Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, 2001.

39 Төрийн мэдээлэл эмхэтгэл, №03, 2018.

Гойд ашиг шимт мал шалгаруулах үйл ажиллагааг сум, дүүрэгт Хөдөө аж ахуйн тасаг, аймаг, нийслэлд Хүнс, хөдөө аж ахуйн газар, улсын хэмжээнд Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулах

Гойд ашиг шимт малыг шалгаруулах ажлын хэсгийг холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөлөл, мэргэжилтнийг оролцуулан сум, аймаг, нийслэлд тухайн шатны Засаг дарга, улсад Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн (Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд) тус тус байгуулах

Ноос, ноолуурын чиглэлийн ашиг шимт малын шалгаруулалтыг хавар, бусад ашиг шимийн чиглэлийн мал, амьтны шалгаруулалтыг намар зохион байгуулах

Шалгарсан гойд ашиг шимт шилмэл малыг улсын үржлийн дэвтэрт бүртгэж, гэрчилгээ олгох

Гойд ашиг шимт мал шалгаруулах үзэсгэлэн худалдаанд хурдны чиглэлийн адуунаас бусад мал, тэжээвэр амьтныг оролцуулах

Сум, дүүрэгт шалгарсан гойд ашиг шимт мал, амьтан тэдгээрийн төл нь аймаг, нийслэлийн, аймаг, нийслэлд шалгарсан малыг улс, бүсийн гойд ашиг шимт малыг шалгаруулах үзэсгэлэн худалдаанд оролцуулах

Ашиг шимийн үзүүлэлт нь “Мал ангилах заавар”-т заасан цөм сүргийн малд тавих шаардлагаас илүү үзүүлэлттэй байх

Адууны төрөлд 12, тэмээ 6, үхэр 18, хонь 25, ямаа 10, сарлаг 5, гахай 7, шувуу, жижиг амьтан 3 тус тус гойд ашиг шимт малаар шалгаруулах

Амьдын жин, ноос, ноолуурын гарцаар тэмээг 6, үхрийг 5, ямааг 4, гахайг 2 настайд нь, сүүний гарцаар үнээг 6, ингийг 8 настайд нь тус тус улсад шалгаруулах

Судалгааны хүрээнд хүрээнд мэргэжилтэнтэй ярилцлага хийсэн юм. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Малын генетик нөөцийн хэлтсийн Малын нөхөн үйлдвэрлэл, үржүүлэг, селекцийн асуудал хариуцсан мэргэжилтэн П.Баясгалантай ярилцлага хийсэн бөгөөд дараах тайлбарыг өгсөн.⁴⁰ Дэлгэрүүлбэл:

“Гойд ашиг шимт мал шалгаруулах үйл ажиллагаа явагдсан хамгийн сүүлийн арга хэмжээ нь 2019 оны “Шилмэл мал-2019” арга хэмжээ бөгөөд үүнээс хойш зохион байгуулагдаагүй байна. Гойд ашиг шимт мал шалгаруулах үйл ажиллагаа нь сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсад нийтдээ жилдээ 10 орчим л зохион байгуулагддаг. Түүний шалтгаан нь бэлчээр муу, ган, хүний болон малын халдварт өвчин зэргээс хамаарч байна. Бид аймаг болон сумдад жил болгон гойд ашиг шимт мал шалгаруулах үйл ажиллагаа явуулах зөвлөмжийг удаа дараа хүргүүлдэг. Мөн гойд ашиг шимт мал нь бүгд хувийн дугаартай, өндөр шалгаруулалтаар орж дүгнэгдэж гойд ашиг шимт мал хэмээх цолыг хүртдэг тул тэр бүр бэлчээрт яваад байдаггүй.”

Улсын хэмжээнд жилдээ ойролцоогоор 10 орчим зохион байгуулагддаг ч 2015 оноос хойш гойд ашиг шимт мал шалгаруулах үйл ажиллагаа зохион байгуулагдаагүй байна. Монгол Улс 2020 оны байдлаар нийт 67,068,486 малтай байх тоон мэдээ⁴¹ байх ба гойд ашиг шимт мал нь түүний 0,001 хувийг эзэлж байгаа нь гойд ашиг шимт мал нь мал хулгайлах гэмт хэргийн объект болох эрсдэл бага, тухайн төрлийн гэмт хэрэг үйлдэгдээгүй байх магадлалтай байна.

40 Малын нөхөн үйлдвэрлэл, үржүүлэг, селекцийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас, 2021.

41 Нийт малын тоо 2020 оны байдлаар, “Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1001_021V1&BAG_select_all=0&BAGSingleSelect=_0&TYPE_OF_LIVESTOCK_select_all=0&TYPE_OF_LIVESTOCKSingleSelect=_01&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2020&viewtype=table

2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулиар дээрх заалтууд нэмэгдсэн. Улсын их хурлын гишүүн Х.Болорчулууны 2020 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлалд “Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 12 дугаар сарын 3-ны өдөр батлан гаргасан Малын генетик нөөцийн тухай хуулийн 4.1.7-д “цөм сүрэг”, 4.1.9-д “гойд ашиг шимт мал”-ыг тусгайлан заасан бөгөөд дээрх малын генетик нөөц, удам зүйн үнэлгээ, хянан магадалгаа хийх, баталгаажуулах асуудлыг зохицуулсан. Мал, мах, малын гаралтай түүхий эдийн үнэ ханш зах зээлд тогтмол хэлбэлзэж байдаг ба цөм сүрэг, гойд ашиг шимт малын эдийн засгийн үнэлгээ нь харилцан адилгүй тогтоогддог болно” гэж тухайн зохицуулалтын үзэл санааг тусгасан байдаг. Үүнээс гадна тухайн үед Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг ажлын хэсгийн гишүүн Х.Нямбаатар “мөн хурдан удмын адуу зэрэг өндөр ашиг шимтэй малыг хулгайлсан бол хүндрүүлэх нөхцөлд тооцогдоно”⁴² гэх санааг илэрхийлж байжээ.

Гэтэл гойд ашиг шимт мал шалгаруулах журмын 3.1-д “Гойд ашиг шимт мал шалгаруулах үзэсгэлэн худалдаанд хурдны чиглэлийн адуунаас бусад мал, тэжээвэр амьтныг оролцуулах бөгөөд...” гэж зааснаас үзвэл дээрх нэр бүхий Улсын Их Хурлын гишүүний илэрхийлсэн санаа нь гойд ашиг шимт малд хамаарахааргүй зохицуулагдсан байна.

Улсын их хурлын гишүүн Х.Болорчулууны 2020 оны Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлалд цөм сүрэг болон гойд ашиг шимт малыг эдийн засгийн үнэлгээ нь харилцан адилгүй тогтоогддог гэж тодорхойлсон хэдий ч цөм сүргийг Эрүүгийн хуулийн 17.12 буюу мал хулгайлах гэмт хэрэгт хуульчлаагүй. Цөм сүрэг гэдэг нь 2017 оны “Малын генетик нөөцийн тухай хууль”-ийн 4.1.7-д зааснаар тухайн үүлдэр, омгоос ашиг шимийн хэмжээ, чанараар давуу хэсгийг сонгон үржүүлж байгаа сүрэг малыг хэлдэг. Хуулийн болон журмын тодорхойлолтоор цөм сүрэг нь гойд ашиг шимт малнаас бага ашиг шимт чанарыг агуулах нь харагдаж байгаа бөгөөд тооны хувьд шалгаруулж, баталгаажуулах үйл ажиллагаанд оролцохгүй учир их байхаар харагдаж байна. Гэхдээ ашиг шимт байдлын хувьд хоёулаа энгийн мал буюу үржлийн болон хэрэгцээний малаас дээгүүр байна. Тиймээс тухайн цөм сүргийн ангиллын малыг хулгайлж үйлдсэн байхыг Эрүүгийн хуульд оруулах үзэл баримтлал байгаа хэдий ч хуульд дээрх зохицуулалтыг тусгаагүй учир тухайн зохицуулалтыг тусгавал үүлдэр, омгоос ашиг шимийн хэмжээ, чанараар давуу малыг хулгайлсан тохиолдолд гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнээр зүйлчилж тухайн төрлийн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэхэд үр нөлөөтэй байж болох юм.

Түүнчлэн шүүхийн шийдвэрийн практикаас үзэхэд 2020 оны 1 дүгээр сарын 16-ны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар нэмэлт орж хуульчлагдсан “17.12.2.6 буюу мал хулгайлах гэмт хэргийг гойд ашиг шимт малыг хулгайлж үйлдсэн” гэх гэмт хэргийн зүйлчлэлээр шийдэгдсэн шүүхийн шийдвэр гараагүй байна.⁴³ Тухайн гэмт хэргийн зүйлчлэлээр шүүхээр хэрэг шийдэгдээгүй шалтгаан нь дараах хүчин зүйлийн нөлөөтэй байна. Үүнд:

42 Х.Нямбаатар, Хурдан удмын адуу хулгайлсан бол хүндрүүлэх нөхцөл болно, 2020, <https://www.polit.mn/a/77974>.

43 Монгол Улсын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр “Мал хулгайлах” гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл 2020, Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан.

- Өмнөх судалгаанд тодорхойлсончлон Монгол Улсын нийт малын 0,001 хувь нь гойд ашиг шимт мал байгаа нь тухайн малыг гэмт хэргийн шууд объект болох эрсдэлийг бууруулж байна.
- Мөн мэргэжилтний хэлснээр малчид тухайн малыг бүртгэлжүүлж бэлчээрт гаргахгүй байгаа нь үүний нэг шалтгаан нөхцөл болж байна.
- Цөм сүргийн талаар хуульчлаагүй нь энгийн малаас ялгарах ашиг шимт малыг хулгайлж буй нөхцөлийг шүүхээр шийдвэрлэхэд мал хулгайлах гэмт хэргийн энгийн бүрэлдэхүүнээр зүйлчилж байна гэх мэт.

Цагдаагийн алба хаагчдаас уг зүйл, заалттай холбоотой дараах асуулгыг авахад доорх үр дүнг үзүүлэв.

Асуулга 1. Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэгт заасан “Гойд ашиг шимт мал” хэмээх ойлголтыг Та хэрхэн ойлгож байна вэ? Уг зүйл, заалтаар хэрэг бүртгэлийн хэрэг нээн, ажиллагаа явуулахад хүндрэл бэрхшээл тулгардаг эсэх, тийм бол ямар?”

Хүснэгт 3.2. Асуулгад хариулсан байдал №2

Д/д	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1.	Үгүй	21	28.3
2.	Тийм	34	46
3.	Мэдэхгүй	19	25.6

Асуулгад 74 алба хаагч хамрагдсан бөгөөд 46 хувь нь Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэгт заасан зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг гэж хариулсан байна. Энэхүү хариулт нь хамгийн их хувийг эзэлж байгаа бөгөөд тухайн хариултаас үзэхэд тус зохицуулалт нь практикт хэрэгжих тал дээр асуудалтай болох нь харагдаж байна.

Асуулга 2. “Гойд ашиг шимт мал” хэмээх ойлголтод хурдан морийг багтаах шаардлагатай эсэх талаар та юу гэж бодож байна вэ?”

Хүснэгт 3.3. Асуулгад хариулсан байдал №3

Д/д	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Шаардлагатай	60	56.1
2	Шаардлагагүй	47	43.9
Нийт		107	100

Асуулгад 107 алба хаагч хамрагдсанаас 56 орчим хувь нь хурдан морийг гойд ашиг шимт малд хамааруулах нь зүйтэй гэж үзсэн бол 44 хувь нь шаардлагагүй гэж хариулсан байна. Тухайн асуултаас шаардлагатай гэж үзсэн хариултыг багцлан үзвэл:

1. Хурдан морь бол гойд ашиг шимт мал гэдэгт орно, бүх морьд хурдан байдаггүй;
2. Тодорхой хуульчилж өгөх нь ЭХХША-г хөнгөвчилнө;
3. Өндөр үнээр зарагддаг учраас;
4. Морины үнэлгээ өндөр хохирлын хэмжээ өндөр байх тул оруулах ёстой;
5. Хурдан морь нь цол, шагналтай байдаг тул гэх мэт.

Харин шаардлагагүй гэж үзсэн хариултыг багцлан үзвэл:

1. Малыг тухайн үеийн зах зээлийн үнэ ханшаар нь тооцох нь зөв;

2. Тухайн хүн хурдан удамтай морь гэдгийг гаднаас нь хараад мэдэх боломжгүй;
3. Бүх мал ашиг шимтэй байдаг;
4. Гэмт хэргийн үйлдэл адил;
5. Гойд ашиг шимт гэдэг нь хөдөө аж ахуйн хөгжилд цаашлаад монгол малын үүлдэр угсаа сайжруулалтад хамаарах ёстой;
6. Таван хошуу малын л нэг учир;
7. Хурдалсан эсэх асуудлыг тогтооход хүндрэлтэй;
8. Адуугаа алдсан хүн бүр хурдны удамтай, тийм угшилтай гэх мэт тайлбарладаг болохоор шаардлагагүй;
9. Хурдан морийг зөвхөн өөрийнх нь амжилтаар тогтоож байх, хурдан удмын гүү, түүний унага гэх ойлголт нь ирээдүйд гарах ашиг шимийг тодорхойлох нь учир дутагдалтай юм гэх мэт шалтгааныг дурдсан байна.

Эрүүгийн хуулийн 17.12.2.6 буюу мал хулгайлах гэмт хэргийг гойд ашиг шимт малыг хулгайлж үйлдэх үйлдлийн тухайд гойд ашиг шимт малыг шалгаруулах үйл ажиллагаа тогтмол хийгддэггүй. Үүний улмаас гойд ашиг шимт малын нийт малын дунд эзлэх хувийн жин бага байх, тухайн асуудлын улмаас зохицуулалт нь хуулийн үзэл баримтлалд нийцээгүй байх буюу мөн цөм сүргийг тухайн хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчлаагүй байх, хурдны чиглэлийн адуу гойд ашиг шимт малд хамаарагдахгүй байх гэх мэт хэрэгжилтийн үр дагавартай холбоотой асуудлууд бий болоод байна.

Түүнчлэн практикт ажиллаж буй хууль сахиулагч буюу цагдаагийн алба хаагчдын хувьд тухайн эрх зүйн зохицуулалтыг хэрэглэхдээ нэг утгаар ойлгодоггүй буюу гойд ашиг шимт мал шалгаруулах журмыг мэдэхгүй байгаагаас гойд ашиг шимт мал бусад малаас юугаараа онцлог давуу талтай болохыг нарийн тодорхойлохгүй байх гэх мэт дутагдлуудыг бий болгож байна.

2.“Тусгай хамгаалалттай газар” гэх нэр томьёоны тухайд

2002 оны Эрүүгийн хуульд “Тусгай хамгаалалттай газар нутаг” гэх нэр томьёог 4 удаа хэрэглэсэн. Тодруулбал, 2002 оны Эрүүгийн хуулийн 210.3-д “Ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих”, 210.8-д “Усны тухай хууль тогтоомж зөрчих”, 211.2-д “Ойн тухай хууль тогтоомж зөрчих”, 214.2-д “Хууль бусаар ашигт малтмал хайх” зэрэг гэмт хэргийн объектив шинж болгон “Тусгай хамгаалалттай газар нутаг” гэх нэр томьёог хэрэглэсэн.⁴⁴ Харин 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар Тусгай хамгаалалттай газар нутаг ” гэх нэр томьёог 2 удаа хэрэглэсэн. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 24.5.1-д “Хууль бусаар ан агнах”, 24.6.1-д “Хууль бусаар мод бэлтгэх” гэмт хэргийн объектив шинж болгон “Тусгай хамгаалалттай газар нутаг” гэх нэр томьёог хэрэглэсэн⁴⁵

Монгол оронд онцгой ач холбогдол бүхий газар нутгийг дээр үеэс дархан цаазтай болгож төрийн мэдэлд авч байжээ. Үүний тодорхой жишээ бол 1778 онд дархан цаазтай болгосон Богд хаан уул юм. “Халх журам” зэрэг хууль цаазын сурвалж бичгүүдэд нэлээд олон тооны газрыг онголох тухай заалт бий. Түүнчлэн 100 гаруй хошууны нутаг тус бүрт 2-5 дархалсан газар байсан баримт бий. Ардын

44 Эрүүгийн хууль, 2002.

45 Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, 2017.

засгийн жилүүдэд дархан цаазтай газрууд нэлээд байгуулагдаж, эрх зүйн журам нь улам нарийсан тогтоогджээ. Дархан цаазтай буюу онголсон газар нутгийн зэрэгцээгээр сүүлийн үед “тусгай хамгаалалттай газар нутаг” хэмээх ойлголт бий болжээ.⁴⁶

Олон улсад “Тусгай хамгаалалттай байгалийн бүс нутаг нь байгаль хамгаалах, шинжлэх ухаан, соёл, гоо зүй, амралт, эрүүл мэндийн онцгой ач холбогдолтой байгалийн цогцолбор, объект байрладаг газар, усны гадаргуу, тэдгээрийн дээгүүр агаарын орон зай юм. Төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр эдгээр нутаг дэвсгэрийг эдийн засгийн ашиглалтаас бүрэн буюу хэсэгчлэн хасаж, тусгай хамгаалалтын дэглэм тогтоодог. Тусгай хамгаалалттай байгалийн газар нутаг нь үндэсний өвийн объектод хамаарна” гэжээ.⁴⁷

Манай улсын хувьд “Тусгай хамгаалалттай газар нутаг” хэмээх нэр томьёог 1994 оны Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль⁴⁸, 2002 оны Газрын тухай хуулиар тус тус тайлбарласан.⁴⁹ Гэвч 1994 оны Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон 2002 оны Газрын тухай хуулийн нэр томьёо зөрүүтэй байна. Тодруулбал, 2002 оны Газрын тухай хуулиар Монгол Улсын газрын нэгдмэл санг 6 ангилан үзсэн.⁵⁰ Уг 6 ангиллын нэг болох Улсын тусгай хэрэгцээний газарт “Улсын тусгай хамгаалалттай газар” багтахар хуульчилсан. Харин 1994 оны Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар “Улсын тусгай хамгаалалттай газар нутаг” хэмээн нэр томьёог хэрэглэсэн байна. Эрүүгийн хуульд “Улсын тусгай хамгаалалттай газар нутаг” гэх нэр томьёог ашигласан. Өөрөөр хэлбэл, “Улсын тусгай хамгаалалттай газар”, “Улсын тусгай хамгаалалттай газар нутаг” гэсэн ялгаатай нэр томьёог хэрэглэсэн. Түүнчлэн “Газрын тухай багц хуулийн төсөлд “Улсын тусгай хамгаалалттай газар” гэх нэр томьёог ашигласан.⁵¹

Академич С.Нарангэрэлийн Эрх зүйн толь бичигт тусгай хамгаалалттай газар гэдгийг (англ. Specially guarding natural territories) Монгол Улсын газрын нэгдмэл сангийн бүрэлдэхүүн хэсэг. Монгол Улсад байгалийн онцгой үзэсгэлэнт иж бүрдэл, хэв төрхийг хадгалсан ба өөрийн улсад болон дэлхийд ховордсон зарим ургамал, ан амьтантай, түүх соёлын дурсгалт бүхий газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авдаг⁵² хэмээн тайлбарлажээ. Түүнчлэн, 1994 оны Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар “Тусгай хамгаалалттай газар нутаг”-ийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг хэмээн ялган үзсэн.

1. Улсын тусгай хамгаалалттай газар нутаг

Газар нутгийг тусгай хамгаалалтад авч хамгаалах нь дэлхий нийтийн хэмжээнд байгаль орчны доройтлыг хязгаарлан зогсоож, байгалийн жам ёсны шүтэлцээт харьцааны нөхцөлийг хангах сонгодог хэлбэр болохын хамт хүн төрөлхтний байгаль, түүх, соёл, шинжлэх ухааны давтагдашгүй их өвийг үе дамжуулан

46 Т.Сэнгэдорж, С.Энхмэнд, С.Энхсаруул, Экологийн эрх зүй, газрын эрх зүй, 2015, 169 дэх тал.

47 <https://wwf.ru/en/regions/the-caucasus/development-of-system-of-especially-protected-natural-territories/>.

48 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, 1994.

49 Газрын тухай хууль, 2002.

50 Газрын тухай хуулийн 10.1 дүгээр заалт.

51 Газрын тухай багц хуулийн төсөл, <https://mcud.gov.mn/forum/12>.

52 С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, 2007, 445 дахь тал.

үлдээх, байгаль экологийн тэнцвэрт байдлыг хангаж, улмаар улс орнууд байгаль орчиндоо зохицон хөгжих үзэл санааг баталгаажуулах үндсэн аргуудын нэг билээ. 1993 онд Монгол Улс Биологийн олон янз байдлыг хамгаалах конвенцод нэгдэн орсноор өөрийн орны болон бүс нутгийн байгаль экологийн тэнцлийг хангахад онцгой үүрэгтэй газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах асуудалд өндөр ач холбогдол өгөх болсон.⁵³ Улсын тусгай хамгаалалттай газар нутгийг дархан цаазат газар, байгалийн цогцолбор газар, байгалийн нөөц газар, дурсгалт газар хэмээн 4 ангилсан.⁵⁴ Манай улсын хувьд 102 байршилд нийт 107 улсын тусгай хамгаалалттай газар нутаг байна. Энэ нь манай улсын нийт нутаг дэвсгэрийн 19.8% эзлэх бөгөөд 30,969.22 мян.га эзэлдэг.⁵⁵

А. Дархан цаазат газар

Байгалийн бүс, бүслүүрийн онцлог, хэв шинжийг төлөөлж чадах унаган төрхөө хадгалсан байдал, шинжлэх ухааны онцгой ач холбогдлыг нь харгалзан байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг дархан цаазат газар гэнэ.⁵⁶ Дархан цаазат газар нь онгон, хамгаалалтын, хязгаарлалтын гэсэн 3 бүсэд хуваагдана.⁵⁷ Монгол улсын хувьд нийт улсын тусгай хамгаалалттай газрын 44.6% буюу 13 798 660.47 га газрыг дархан цаазат газар эзэлнэ. Одоогоор 22 байршилд 15 газрыг дархан цаазат газар болгосон.⁵⁸

Б. Байгалийн цогцолбор газар

Байгалийн унаган төрхөө харьцангуй хадгалсан, түүх, соёл, шинжлэх ухааны болон танин мэдэхүй, экологийн хүмүүжилд ач холбогдол бүхий улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн цогцолборт газар гэнэ.⁵⁹ Байгалийн цогцолборт газар нь онцгой, аялал, жуулчлалын, хязгаарлалтын гэсэн 3 бүсэд хуваагдана.⁶⁰ Монгол улсын хувьд нийт улсын тусгай хамгаалалттай газрын 43.3% буюу 13,496,699.08 га газрыг байгалийн цогцолбор газар эзэлнэ. Одоогоор 37 байршилд 34 газрыг байгалийн цогцолбор газар болгосон.⁶¹

Г. Байгалийн нөөц газар

Байгалийн тодорхой хэв шинж, аль нэгэн нөөц, баялгийг хамгаалах, хадгалах, нөхөн сэргээх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг байгалийн нөөц газар гэнэ.⁶² Байгалийн нөөц газрыг байгалийн иж бүрдлийн нөөц газар, биологийн нөөц газар, байгалийн түүхэн олдворын нөөц

53 Тусгай хамгаалалттай газар, <http://mpa.gov.mn/news/885>.

54 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 3 дугаар зүйл, 1994..

55 Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн сан, <https://www.eic.mn/spa/>.

56 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 7 дугаар зүйл, 1994.

57 Мөн тэнд.

58 Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн сан, <https://www.eic.mn/spa/>.

59 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 13 дугаар зүйл, 1994.

60 Мөн тэнд.

61 Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн сан, <https://www.eic.mn/spa/>.

62 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 19 дүгээр зүйл, 1994 он, <https://legalinfo.mn/mn/detail/479>, Сүүлд үзсэн огноо 2021.12.14

газар, геологийн нөөц газар, усны нөөц газар гэсэн 5 төрөлд хуваан үздэг.⁶³ Монгол улсын хувьд нийт улсын тусгай хамгаалалттай газрын 11.5% буюу 3,569,789.78 га газрыг байгалийн нөөц газар эзэлнэ. Одоогоор 31 байршилд 45 газрыг байгалийн нөөц газар болгосон.⁶⁴

Д. Дурсгалт газар

Байгалийн өвөрмөц тогтоц, түүх, соёлын ул мөрийг уламжлагдан хадгалагдсан байгалийн байдлаар нь өвлөн үлдээх зорилгоор улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийг дурсгалт газар гэнэ.⁶⁵ Дурсгалт газрыг байгалийн дурсгалт газар, түүх, соёлын дурсгалт газар, дэлхийн болон үндэсний соёлын дурсгалт газар гэсэн 3 төрөл хуваан үздэг.⁶⁶ Монгол улсын нийт улсын тусгай хамгаалалттай газрын 0.3 буюу 104 071.55 га газрыг дурсгалт газар эзэлнэ. Одоогоор 12 байршилд 13 газрыг дурсгалт газар болгосон.⁶⁷

2. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг

1994 оны Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлд “Аймаг, нийслэл, сум, дүүрэг өөрийн нутаг дэвсгэрт байгаа тодорхой газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авч болно” гэж хуульчилсан. Уг хуулийн дагуу 1994 оноос эхлэн 2021 оныг хүртлэх хугацаанд 2798 газрыг орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг болгосон. Үүнээс 974 нь Аймаг, нийслэлийн тусгай хамгаалалттай газар нутаг бол үлдсэн 1824 сум дүүргийн тусгай хамгаалалттай газар нутаг байна.⁶⁸ Оноор авч үзвэл 1996 онд хамгийн бага буюу 1 газрыг орон нутгийн тусгай хамгаалалтанд авсан бол 2015 онд хамгийн их буюу 556 газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан байна. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн тоогоор хамгийн их Хэнтий аймаг бөгөөд нийт 2,784,365.44 га 489 газрыг орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг болгожээ. Харин Баянхонгор аймаг хамгийн га газрыг буюу 10,849,488.88 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан.⁶⁹

Түүнчлэн, нийт 2798 орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн 1416 зөрчилгүй орон нутгийн хамгаалалттай газар байна. Харин 1103 орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг хууль, эрх зүйн зөрчилтэй, 717 орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг газар зүйн байршил давхацсан зөрчилтэй байна.⁷⁰ Хууль, эрх зүйн зөрчлийн үндсэн шалтгаан нь нэгдүгээрт Тусгай хамгаалалтад байлгах хугацаа дууссан, хоёрдугаарт Тусгай хамгаалалтад байлгах жил тодорхойгүй зэрэг юм. Тодруулбал, орон нутгийн тусгай хамгаалалтад байлгах хугацаа дууссан газар нутаг 228, орон нутгийн тусгай хамгаалалтад байлгах жил дууссан газар нутаг 875 байна. Өөрөөр хэлбэл, Хөвсгөл аймаг орон нутгийн тусгай хамгаалалттай 160

63 Мөн тэнд

64 Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн сан, <https://www.eic.mn/spa/>.

65 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 22 дугаар зүйл, 1994.

66 Мөн тэнд.

67 Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн сан, <https://www.eic.mn/spa/>.

68 Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн сан, <https://eic.mn/spalocal/index.php>.

69 Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн сан, https://eic.mn/spalocal/localspa_stat.php.

70 Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн сан, 2021.

газар нутагтай хэдий ч түүний 145 газар нутгийн орон нутгийн тусгай хамгаалалтад байлгах жил дууссан байна. Ийнхүү орон нутгийн тусгай хамгаалалтад байлгах жил дууссан газраас Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 24.5.1, 24.6.1-д заасан гэмт хэргийг үйлдсэн нөхцөлд гэмт хэрэг тооцох эсэх нь тодорхойгүй байна.

Дүгнэн үзвэл, Эрүүгийн хуульд хэрэглэсэн “тусгай хамгаалалттай газар нутаг” гэх нэр томьёо нь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийг хамруулсан ойлголт юм. Энэ нь манай улсын газрын бүрэлдэхүүний нэг бөгөөд газрын тухай хуулийн дагуу улсын тусгай хэрэгцээний ангилалд хамаарч байна. Гэвч 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 24.5.1, 24.6.1-д хуульчилсан нэр томьёо, 2002 Газрын тухай хуулийн 16.1.1-д заасан нэр томьёо хоорондоо ялгаатай байна. Түүнчлэн орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн 39 хувь нь хууль эрх зүйн зөрчилтэй байна.

Дээрхээс дараах хоёр саналыг дэвшүүлж байна. Нэгдүгээрт, “Тусгай хамгаалалттай газар”, “Тусгай хамгаалалттай газар нутаг” хэмээн хууль тогтоомжид ялгаатай нэр томьёо хэрэглэснийг нэг мөр болгох, хоёрдугаарт орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хууль эрх зүйн зөрчил үүссэн газар нутагт эрүүгийн хууль үйлчлэх эсэхийг хуульчилах шаардлагатай.

III. Нийгмийн шинжлэх ухааны нэр томьёо

1. “Төрийн нууц” гэх нэр томьёоны тухайд

2002 оны Эрүүгийн хуульд “Төрийн нууц” гэх нэр томьёог 4 удаа хэрэглэсэн. Тодруулбал, мөн хуулийн 79.1-д “Эх орноосоо урвах”, 80.1-д “Тагнуул хийх”, 87.1-д “Төрийн нууц задруулах”, 88.1-д “Төрийн нууц мэдээ, баримт бичиг, эд зүйлийг үрэгдүүлэх” зэрэг гэмт хэргийн объектив шинж болгон “Төрийн нууц” гэх нэр томьёог хэрэглэсэн. Харин 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар “Төрийн нууц” гэх нэр 7 удаа хэрэглэсэн. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 19.4.1, 19.4.2-д “Гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах”, 19.10-д “Тагнуул хийх”, 19.11.1-д “Төрийн нууцыг хууль бусаар олж авах”, 19.12-д “Төрийн нууцыг задруулах”, 19.13-д “Төрийн нууцыг үрэгдүүлэх” гэмт хэргийн объектив шинж болгон “Төрийн нууц” гэх нэр томьёог хэрэглэсэн⁷¹

Олон улсын тайлбар тольд state secret буюу төрийн нууц гэж засгийн газраас шийдвэр гаргасан нууцалсан мэдээлэл гэж тайлбарласан.⁷² Түүнчлэн ОХУ болон БНХАУ-д тус тусдаа “Төрийн нууцын тухай хууль байдаг. Тодруулбал, ОХУ-ын Төрийн нууцын тухай хууль 1993 онд батлагдсан. Тус хуулиар ОХУ-д төрийн нууцыг (орос. Государственная тайна; Государственная тайна) нь ОХУ-ын Албан ёсны нууцын тухай хуульд батлагдсан тодорхойлолтын дагуу цэрэг, гадаад бодлого, эдийн засаг, тагнуул, төрийн хамгаалалтад байдаг мэдээлэл юм. Үүнийг тараах нь улсын аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй сөрөг тагнуул, шуурхай, мөрдөн байцаах болон бусад үйл ажиллагаа гэж тайлбарлажээ.⁷³ Харин БНХАУ-ын Төрийн нууцын тухай хуулиар “Төрийн нууц гэдэг нь төрийн аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд амин чухал ач холбогдолтой, хуульд заасан журмын

71 Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, 2017.

72 <https://www.macmillandictionary.com/dictionary/british/state-secret>.

73 LAW OF THE RUSSIAN FEDERATION NO. 5485-1 OF JULY 21, 1993 ON STATE SECRETS, https://www.wto.org/english/thewto_e/acc_e/rus_e/wtaccrus58_leg_125.pdf.

дагуу тодорхой хугацаанд хязгаарлагдмал тооны хүнд даатгасан асуудлыг хэлнэ” гэжээ.⁷⁴

Манай улсын хувьд 2016 оныг хүртэл “Төрийн нууц” гэх нэр томьёог (англ. State secret, ор. Государственная тайна), улсын батлах хамгаалах, гадаад бодлого, эдийн засаг, шинжлэх ухаан, техник-технологи тагнуул, сөрөг тагнуул, гүйцэтгэх ажилтай холбоотой бөгөөд задруулбал төрийн аюулгүй байдал хохирол учруулахуйц мэдээллийг төрөөс тусгайлан хамгаалсан мэдээ сэлт⁷⁵ тайлбарлаж байна.

Энэ нь 1995 оны Төрийн нууцын тухай хууль, 2004 онд батлагдсан Төрийн нууцын жагсаалттай холбоотой. Харин 2017 оны Төрийн болон албаны нууцын тухай хуулиар “Төрийн нууц”-ыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамруулсан, задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдалд, үндэсний ашиг сонирхолд аюул, занал хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг ойлгоно хэмээн хуульчилсан.⁷⁶ Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн Дугаар 247 тогтоолоор “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-ыг баталсан.⁷⁷ Төрийн болон албаны нууцын тухай хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээллийг авч үзвэл, 1. Төрийн бодлогын хүрээнд 9, 2. Эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологийн хүрээнд 4, 3. Батлах хамгаалах хүрээнд 15, 4. Тагнуул, сөрөг тагнуул, хууль сахиулах ажлын хүрээнд 18, 5. Мэдээллийн аюулгүй байдлын болон бусад хүрээнд 14 мэдээллийг төрийн нууцад хамааруулсан байна.⁷⁸

Харин Монгол Улсын Засгийн газраас 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн Дугаар 247 тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтаас харвал, Монгол Улсын Их Хурлын Тамгын Газар 31, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар 16, Засгийн газрын хэрэг эрхлэх газар 32, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Стратегийн судалгааны хүрээлэн 33, Гадаад харилцааны салбар 19, Батлан Хамгаалах салбар 78, Хууль зүй, Дотоод хэрэг, хууль сахиулах салбар 56, Банк, санхүүгийн салбар 21, Байгаль орчин, аялал жуулчлалын салбар 10, Барилга, хот байгуулалтын салбар 14, Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын салбар 9, Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар 11, Зам, тээврийн салбар 10, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар 10, Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбар 12, Эрүүл мэндийн салбар 10, Эрчим хүчний салбар 12, Авилгатай тэмцэх газар 20, Төрийн аудитын байгууллага 6, Сонгуулийн ерөнхий хороо 5, Санхүүгийн зохицуулах хороо 4, Үндэсний статистикийн хороо 5, Цөмийн энергийн комисс 6, Төрийн албаны зөвлөл 7, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбар 9, Мэргэжлийн хяналтын байгууллага 5, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 7, Үндэсний хөгжлийн газар 5, Тагнуулийн байгууллага, төрийн тусгай хамгаалалтын газар 60, онцгой байдлын салбар 13, Стандарт, хэмжил зүйн газар 4, Монгол Улсын үндсэн хуулийн цэц, шүүх, прокурорын байгууллага 13, Аймаг нийслэлийн засаг даргын тамгын

74 Laws of the People's Republic of China, <http://www.asianlii.org/cn/legis/cen/laws/gsssl248/>.

75 С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, 2007, 432 дахь тал

76 Төрийн болон албаны нууцын тухай хууль, 2016.

77 Монгол улсын засгийн газрын тогтоол, дугаар 247, 2017, <https://legalinfo.mn/mn/detail/12878>.

78 Глоб интернэшнл төв, Азийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Мэдээлэлтэй байх эрхийг хязгаарлаж буй хууль тогтоомжийн дүн шинжилгээ, 2019.

газар 17 гэх нийт 570 мэдээллийг төрийн нууцад хамруулан үзжээ.⁷⁹

1995-2004 оны хооронд Төрийн нууцын тухай хуулиар 22 мэдээллийг нууцад хамааруулан үзсэн бол 2004-2017 оны хооронд Төрийн нууцын жагсаалтаар 60 болон төрийн нууцын тоо нэмэгдсэн. Харин 2016 оны Төрийн болон албаны нууцын тухай хууль болон, Монгол Улсын Засгийн газраас 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн Дугаар 247 тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтаар төрийн нууц 570 мэдээллийг хамруулдаг болсон.

Үүнээс 2016 оны Төрийн болон албаны нууцын тухай хууль болон, Монгол Улсын Засгийн газраас 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн Дугаар 247 тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалттай холбогдуулан “Төрийн нууц” хэмээх нэр томъёоны цар хүрээ өргөжсөн байна. Тодруулбал, 2016 оны Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5.1.7-д “төрийн болон албаны нууц хамгаалах ажилтан”-ыг тайлбарласан. Гэвч төрийн болон албаны нууц хамгаалах ажилтан нь 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 19.12.1, 19.13.12-д заасан “итгэмжлэгдэн хариуцсан, албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд”-ийг алинд хамаарах нь тодорхойгүй байна. Эрүүгийн хуулийн төсөөтэй хэрэглэхийг хориглодог. Энэ ч утгаар итгэмжлэгдэн хариуцсан, албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээдэд хэнийг хамааруулах талаар нарийвчлан хуульчлах нь зүйтэй. Түүнчлэн Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 27.1.5-д “итгэмжлэн хариуцуулсан” гэх нэр томъёог ашигласан. Харин Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 19.4.2-д “итгэмжлэгдэн хариуцсан” гэх ялгаатай нэр томъёог ашигласан.

Иймд, 2016 оны Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбогдуулан 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын нэр томъёоны нэг мөр байдлыг бий болгох саналыг гаргаж байна.

2. “Садар самуун” гэх нэр томъёоны тухайд

“Садар самуун” гэх нэр томъёог хэл шинжлэлийн үүднээс “шалиг, завхай” гэж тодорхойлсон байна⁸⁰.

2002 оны Эрүүгийн хуулийн 123.1-т “садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлсийг бэлтгэсэн, тараасан, борлуулсан, нийтэд үзүүлсэн, энэ зорилгоор улсын хилээр нэвтрүүлсэн бол” гэж заасан харин шинэчлэн найруулсан эрүүгийн хуулийн 16.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “хүүхдэд садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг зориуд үзүүлсэн, өгсөн, сурталчилсан; хүүхдээр садар самуун үйлдэл хийлгэсэн; хүүхдэд биеэ үнэлэх, бэлгийн харьцаанд орохыг санал болгосон бол” мөн 16.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэсэн, борлуулсан, тараасан, хадгалсан бол” гэж нарийвчлан хуульчилжээ.

79 Монгол улсын засгийн газрын тогтоол, дугаар 247, 2017, <https://legalinfo.mn/mn/detail/12878>.

80 Монгол хэлний их тайлбар толь, <https://mongoltoli.mn/search.php?opt=1&word=%D1%81%D0%B0%D0%B4%D0%B0%D1%80+%D1%81%D0%B0%D0%BC%D1%83%D1%83%D0%BD>

Хүснэгт 3.4. Эрүүгийн хуулиуд дахь холбогдох зүйл заалтуудыг харьцуулсан нь №2

2002 оны Эрүүгийн хууль	Шинэчлэн найруулсан 2015 оны Эрүүгийн хууль
123.1.Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлсийг бэлтгэсэн, тараасан, борлуулсан, нийтэд үзүүлсэн, энэ зорилгоор улсын хилээр нэвтрүүлсэн бол	16.8 зүйлийн 1 дэх хэсэгт Хүүхдэд садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг зориуд үзүүлсэн, өгсөн, сурталчилсан; хүүхдээр садар самуун үйлдэл хийлгэсэн; хүүхдэд биеэ үнэлэх, бэлгийн харьцаанд орохыг санал болгосон бол 16.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэсэн, борлуулсан, тараасан, хадгалсан бол

“Садар самуун” гэх ойлголтын тайлбар:

Хууль зүйн талаас: Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 3.1.1-т “садар самууныг сурталчлах” гэж бэлгийн дур хүслийг өдөөх зорилгоор хурьцал үйлдэхийг болон хүний бэлэг эрхтнийг илтээр хэвлэл, ном зохиол, кино, дүрс, дуу авианы бичлэг болон бусад хэлбэрээр уншуулах, сонсгох, үзүүлэхийг мөн 3.1.2-т “садар самуун явдал” гэж биеэ үнэлэх, бусдын биеийг үнэлүүлэх, эсхүл эдгээр үйлдэлд бусдыг татан оролцуулах, түүнчлэн садар самууныг сурталчлахыг,”⁸¹ гэжээ. Эрх зүйн эх толь бичигт садар самуун явдал гэж биеэ үнэлж явалдах, түүнд бусдыг уруу татах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, зуучлах, түүнчлэн садар самууныг сурталчлах. Садар самууны зүйлс гэж МУ-д хурьцлын ажлыг нарийвчлан ба илэн далангүй бодит байдлаар дүрсэлсэн буюу түүний янз бүрийн илрэл, хэлбэрийг харуулсан ба уран сайхан ба шинжлэх ухааны үнэ цэнэ байхгүй зохиол, хэвлэл, дүрслэл, компьютерын программ, кино, дүрс ба дуу авиа бичлэг, телевизийн ба радио нэвтрүүлгийг ойлгоно.⁸²

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбарт садар самуун гэдэгт биеэр үйлдсэн бэлгийн шинж чанартай үйлдлүүд хамаарна. (Тухайлбал, хүүхдийн бэлэг эрхтнийг ил гаргаж гараараа оролдох, гар үйлдэл хийх, садан самуунд уруу татагч өөрийн бэлэг эрхтнээ хүүхдээр хүчээр оролдуулах, бэлэг эрхтнээ хүрэлцүүлэх гэх зэрэг ердийн хурьцал үйлдэхээс бусад бэлгийн шинж чанартай үйлдлүүд хийх, мөн амаар болон шулуун гэдсээр хурьцал үйлдэх, бэлгийн үйлдлүүдийн сэдэв бүхий ичгүүр сонжуургүй яриа ярих). Үүнд бас өсвөр насны хүүхдийг порно сэтгүүл, эд зүйлс, сексийн сэдэвт бүдүүлэг зохиолуудтай танилцуулах, насанд хүрээгүй хүүхдүүдийг хооронд нь хурьцал үйлдэхэд өдөөн хатгах зэрэг үйлдлүүд орно⁸³ гэж тодорхойлжээ. Сургалтын Эрүүгийн хууль номд садар самуун гэж уран сайхны болоод шинжлэх ухааны үндэслэлээс гадуурх хурьцлын ажлыг нарийвчлан ба илэн далангүй бодит байдлаар дүрсэлсэн буюу түүний янз бүрийн илрэл, хэлбэрийг харуулах байдал⁸⁴ гэжээ.

Хүүхдийн эрхийн тухай конвенцын 34 дүгээр зүйлд Оролцогч улсууд хүүхдийг бэлгийн замаар ашиглан мөлжих бүхий л хэлбэрээс хамгаалах үүрэг хүлээнэ. Энэ зорилгоор оролцогч улсууд дараах зүйлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үндэсний, хоёр талт болон олон талт шаардлагатай бүх арга хэмжээг авна:

81 Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, 1998, 3 дугаар зүйл.

82 С.Нарангэрэл, Эрх зүйн толь бичиг, 2007, 382 дахь тал.

83 Монгол Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, 2010, 327 дахь тал.

84 Т.Золбоо, Сургалтын эрүүгийн хууль, 2017, 102 дахь тал.

- (a) хүүхдийг бэлгийн хууль бус аливаа ажиллагаанд татан оролцуулах буюу шахалт үзүүлэх;
- (b) хүүхдийн биеийг үнэлүүлэх буюу бэлгийн хууль бус бусад ажиллагаанд ашиглан мөлжих
- (c) хүүхдийг садар самуунд үзүүлбэр болон түүнийг сурталчилсан материалд ашиглах⁸⁵ гэж заажээ.

Социологийн талаас: Pornography гэж бэлгийн дур хүсэл бий болгох зорилготой ном зохиол, кино, хөшөө, зураг мөн бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр бэлгийн зан үйлийг харуулсан дүрслэл юм. Pornography болон erotica-гийн ялгаа нь субъектив ба нийгмийн стандартаас хамааран өөрчлөгдөж байдаг. Pornography гэх үг нь Грекийн porni (бие үнэлэгч) мөн graphein (бичих) гэсэн үгнээс гаралтай ба энэ үг нь анх бие үнэлэгчдийн амьдралыг харуулсан аливаа урлагийн ба уран зохиолын бүтээл гэж тодорхойлжээ.⁸⁶

Япон улсын Хүүхдийн бие үнэлэлт, хүүхдийн порнографтай холбоотой үйлдлийг зохицуулах, шийтгэх ба хүүхдийг хамгаалах тухай хуулийн гуравдугаар зүйлд хүүхдийн порнографыг тодорхойлжээ.

(3) Энэ хуульд заасан “Хүүхдийн порнограф” гэх нэр томъёо нь гэрэл зураг, дуу бичлэг хураах хэрэгсэлд багтах электрон болон соронзон дуу бичлэг эсвэл хүүхдийн зургийг харуулсан дараах хүний харах мэдрэхүйгээр таних боломжтой хэрэгслүүд:

- (i) Хүүхэд хоорондох эсвэл хүүхэдтэй бэлгийн харьцаанд орж буй аливаа дүрслэл эсвэл бэлгийн харилцаатай төстэй аливаа зан үйл;
- (ii) Бэлгийн дур хүслийг өдөөсөн хүүхдийн бэлэг эрхтний аливаа дүрслэл, бэлэг эрхтэнд аливаа хүн хүрэх эсвэл хүүхэд өөр хүний бэлэг эрхтэнд хүрэх эсвэл;
- (iii) Бэлгийн дур хүслийг өдөөсөн биеийн тодорхой хэсгүүдийг (бэлэг эрхтэн эсвэл тэдгээрийн эргэн тойрон дахь хэсэг, өгзөг эсвэл цээж) харуулсан хүүхдийн нүцгэн эсвэл хагас нүцгэн аливаа дүрслэл.⁸⁷

1. Канадын эрүүгийн хуулийн Ёс суртахууны эсрэг гэмт хэргийн 163.1-т хүүхдийн порнограф нь:

(a) Электроник эсвэл механик аргаар хийсэн зураг, кино, бичлэг эсвэл бусад дүрслэл;

(i) Арван найман насанд хүрсэн хүн эсвэл арван найман наснаас доош гэж дүрслэгдсэн хүн ил бэлгийн харьцаанд орсон эсвэл орсон гэж дүрсэлсэн эсвэл;

(ii) Бэлгийн дур хүслийг өдөөх зорилготой арван найман насанд хүрээгүй хүний бэлэг эрхтэн эсвэл шулуун гэдэс хэсгийг харуулсан дүрслэл;

(b) Бэлгийн дур хүслийг өдөөх зорилготой энэ хуулийн дагуу гэмт хэрэгт тооцогдох арван найман насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орохыг дэмжсэн аливаа бичмэл материал, дүрс бичлэг эсвэл дуу дүрсний бичлэг;

85 Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1990, 34 дүгээр зүйл.

86 <https://www.britannica.com/topic/pornography>.

87 Act on Regulation and Punishment of Acts Relating to Child Prostitution and Child Pornography, and the Protection of Children, Act No. 52 of May 26, 1999, Article 2.

(с)Бэлгийн дур хүслийг өдөөх зорилготой энэ хуулийн дагуу гэмт хэрэгт тооцогдох арван найман насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орохыг тодорхойлсон аливаа бичмэл материал; эсвэл;

(d)Бэлгийн дур хүслийг өдөөх зорилготой энэ хуулийн дагуу гэмт хэрэгт тооцогдох арван найман насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцааг харуулсан аливаа дуу бичлэгийн дүрслэл, танилцуулга, тайлбар юм.

Хүүхдийн порнографтай холбоотой дээрх үйлдлийг дараах байдлаар гэмт хэрэг болгон хуульчилжээ.

Хүүхдийн порнограф хийх

2.Хүүхдийн порнограф сурталчилсан, хэвлэсэн, нийтэлсэн, нийтлэх зорилготой аливаа хүн яллах дүгнэлтийн үндэслэлтэй гэмт хэрэгт гэм буруутай бөгөөд 14 жилээс илүүгүй хугацаагаар хорих ял, хамгийн багадаа нэг жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгүүлнэ.

Хүүхдийн порнограф түгээх

3.Хүүхдийн порнограф дамжуулах, түгээх, түгээх, худалдах, сурталчлах, экспортлох зорилгоор худалдах, сурталчлах, импортлох, экспортлох эсвэл дамжуулах зорилготой байгаа хүн бүр яллах дүгнэлтийн үндэслэлтэй гэмт хэрэгт гэм буруутай бөгөөд 14 жилээс илүүгүй хугацаагаар хорих ял, хорих ялын доод хэмжээ болох нэг жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгүүлнэ

Хүүхдийн порнографыг эзэмших

4.Хүүхдийн порнограф эзэмшиж буй хүн бүр яллах дүгнэлтийн үндэслэлтэй гэмт хэрэгт гэм буруутай мөн 10 жилээс дээшгүй хорих ял ба хамгийн багадаа 1 жил хорих ялаар шийтгүүлэх эсвэл хялбаршуулсан ажиллагааны журмаар ял шийтгүүлэх гэмт хэрэг болох нэг өдрөөс доошгүй ба 2 жилээс дээшгүй жилээр хорих ял мөн хамгийн багадаа 6 сар хорих ялаар шийтгүүлэх

Хүүхдийн порнографт нэвтрэх

4.1 Хүүхдийн порнографт нэвтрэх буй хүн бүр яллах дүгнэлтийн үндэслэлтэй гэмт хэрэгт гэм буруутай бөгөөд 10 жилээс дээшгүй хорих ял ба хамгийн багадаа 1 жил хорих ялаар шийтгүүлэх эсвэл хялбаршуулсан ажиллагааны журмаар ял шийтгүүлэх гэмт хэрэг болох нэг өдрөөс доошгүй ба 2 жилээс дээшгүй жилээр хорих ял мөн хамгийн багадаа 6 сар хорих ялаар шийтгүүлэх⁸⁸

Монгол Улсын Садар самуунтай тэмцэх тухай хуулийн 3.1.1-т “садар самууныг сурталчлах” гэж бэлгийн дур хүслийг өдөөх зорилгоор хурьцал үйлдэхийг болон хүний бэлэг эрхтнийг илтээр хэвлэл, ном зохиол, кино, дүрс, дуу авианы бичлэг болон бусад хэлбэрээр уншуулах, сонсгох, үзүүлэхийг гэж заасан нь дутмаг тодорхойлолт гэж үзэж байна. Садар самуун гэсэн ойлголтыг судлаачид өөр өөрөөр тайлбарласан байгаа нь садар самуун гэж юуг ойлгож байгааг тайлбарласан тогтсон нэг ойлголтод хүрч чадаагүй байгааг харуулж байна. Мөн эрүүгийн хуульд байх тус “Садар самуун” гэх нэр томъёог гадаад улсуудад өөр нэр томъёогоор тодорхойлж зохицуулж байна.

88 Criminal Code (R.S.C., 1985, c. C-46) Part V, Sexual Offences, Public Morals and Disorderly Conduct 163.1.

IV. Анагаахын шинжлэх ухааны нэр томьёо

1. “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис” гэх нэр томьёоны тухайд

Хууль зүйн талаас: Тухайн нэр томьёо нь 2002 оны Эрүүгийн хуульд тухайн байдлаараа ороогүй ба “мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм”, “мансууруулах бодис” гэх байдлаар томъёологджээ. Харин 2015 оны Эрүүгийн хуульд тус нэр томьёог 6.2 дугаар зүйлийн 2, 12 дугаар зүйлийн 2.3, 20.7 дугаар зүйл, 20.8 дугаар зүйл, 20.9 дүгээр зүйл, 20.10 дугаар зүйлүүдэд тус тус оруулсан байна. Мөн үүнээс гадна 2002 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” хууль болон Монгол Улсын нэгдэн орсон гэрээнүүд болох 1988 оны 12 дугаар сарын 20-ны “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенц”, 1961 оны 3 дугаар сарын 25-ны “Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц”, 1971 оны 2 дугаар сарын 21-ний “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц”-уудад тус нэр томьёог тусгасан байна.

“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д зааснаар “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис”-ийг донтуулах болон сэтгэцэд бусад хүчтэй нөлөөлөл үзүүлдэг, “Мансууруулах эмийн тухай” 1961 оны НҮБ-ын Конвенц, “Сэтгэцэд нөлөөт бодисуудын тухай” 1971 оны НҮБ-ын Конвенцын жагсаалтад заасан, хууль тогтоомжийн дагуу Монгол Улсад хяналтад байлгавал зохих эм, байгалийн болон нийлэгжүүлсэн бэлдмэлийг хэлнэ гэж тодорхойлсон байна⁸⁹. Харин эрх зүйн толь бичгүүдэд дараах байдлаар тус тус тайлбарласан байна. Академич С.Нарангэрэлийн эрх зүйн толь бичигт тухайн нэр томьёог мансууруулах бодис гэх нэр томьёогоор тодорхойлсон ба хүний төв мэдрэлийн системд донтуулах болон сэтгэцэд хүчтэй нөлөө үзүүлдэг байгалийн ба ургамлын буюу нийлэг гаралтай бодис, бэлдмэл, эм, ургамал⁹⁰ гэж тодорхойлсон байна. Олон улсын эрх зүйн толь бичигт мансууруулах эмийг дунд зэргийн тунгаар хэрэглэхэд мэдрэхүйг мохоож, өвдөлтийг намдааж, гүн нойронд хүргэдэг боловч хэт их тунгаар увал ухаан алдах, ухаан алдах, таталт өгөх зэрэг үр дүнд хүргэдэг эм, физиологийн хувьд донтуулдаг, хар тамхины шинжтэй эсэхээс үл хамааран донтуулдаг мансууруулах бодистой төстэй хязгаарлалтад хамаарах эм⁹¹ гэж, харин сэтгэцэд нөлөөт бодисыг тухайн нэршлээр нь тайлбарласан байна.

Олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд тухайн нэр томьёог мөн тайлбарласан байна. 1988 оны 12 дугаар сарын 20-ны “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийн эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенц”-ын 1 дүгээр зүйлийн n хэсэгт мансууруулах эм гэдгийг Мансууруулах эмийн тухай 1961 оны нэгдсэн конвенц болон нэмэлт өөрчлөлт оруулсан уг конвенцын I жагсаалт, II жагсаалтад орсон байгалийн болон нийлэг аливаа бодисыг хэлнэ гэж, 1 дүгээр зүйлийн r хэсэгт сэтгэцэд нөлөөлөх бодис гэж 1971 оны конвенцын I, II, III, IV жагсаалтад орсон байгалийн буюу нийлэг аливаа бодис эсхүл байгалийн аливаа материалыг хэлнэ гэж тус тус тодорхойлсон. Өөрөөр хэлбэл Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан шиг нэг нэр томьёогоор бус хоёр өөр төрлийн нэр томьёо гэдгийг тус конвенцод дурджээ. Мөн тухайн хоёр нэр томьёоны хамрах хүрээ, зохицуулалт нь

89 С.Гантулга, Б.Энхболд, Эрүүгийн эрх зүй Тусгай анги сурах бичиг, 2018, 313 дахь тал.

90 С.Нарангэрэл, “Эрх зүйн эх толь бичиг”, 2007, 275 дахь тал.

91 Merriam-Webster legal dictionary, <https://www.merriam-webster.com/dictionary/narcotic>.

ч бас өөр байна.

1961 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн “Мансууруулах эмийн тухай нэгдсэн конвенц”-д каннабис болон каннабисын давирхай, кока навчны кокаин, героин, кодеин, неркодэйн гэх мэтчилэн нийт 2 бүлэг бүхий 140 гаруй мансууруулах эмийг жагсаалт байдлаар баталж тус мансууруулах эмийг гагцхүү анагаах ухааны болон эрдэм шинжилгээний хэрэглээгээр хязгаарлах, түүнээс бусад хэрэглээг хориглох, хяналт тавих, хэрэгжүүлэх тухай зохицуулсан⁹².

Харин 1971 оны 2 дугаар сарын 21-ний “Сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай конвенц”-д этрифтамин, теноциклидин, зифефрол, фентиллин, амобарбитал, катин, лефетамин, мазиндол гэх сэтгэцэд нөлөөлөх бодисыг жагсаалт болгон оруулсан байна. Тус конвенцын зорилго нь сэтгэцэд нөлөөлөх зарим бодисыг урвуулан хэрэглэсний улмаас үүсэж байгаа олон нийтийн эрүүл мэнд, нийгмийн асуудлыг сэтгэл зовнин тэмдэглэж, тийм бодисыг урвуулан хэрэглэх, түүнээс үүсдэг хууль бус эргэлтээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх бөгөөд тухайн конвенцоор сэтгэцэд нөлөөлөх бодисыг хязгаарлах, хориглох, хяналт тавих, хэрэгжүүлэх асуудлыг зохицуулдаг байна⁹³.

Мөн гадаад улсуудын эрх зүйн зохицуулалтад буюу Холбооны бүгд найрамдах Герман улсын Эрүүгийн хууль⁹⁴, Бүгд найрамдах Солонгос улсын Эрүүгийн хууль⁹⁵, Япон улсын Эрүүгийн хуульд⁹⁶ дээрх хоёр нэр томьёог нэгэн зэрэг хэрэглэж зохицуулаагүй байна.

Анагаахын шинжлэх ухааны талаас: Анагаахын шинжлэх ухааны талаас мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис гэдэг нэр томьёог мөн тусад нь авч үздэг байна. Мансууруулах эмийг “narcotic drug”, сэтгэцэд нөлөөт бодисыг “psychotropic substance” гэсэн утгаар нь ойлгож, орчуулсан ба дараах байдлаар тайлбарладаг байна. Хавдар судлалын зүгээс мансууруулах эмийг “дунд зэргийн болон хүнд хэлбэрийн өвдөлтийг эмчлэхэд хэрэглэдэг бодис юм. Мансууруулах эм нь морфин, кодеин зэрэг опиаттай адил боловч опиум буюу хар тамхинаас гаргаж авдаггүй. Тэд төв мэдрэлийн систем дэх опиоид рецепторуудтай холбогддог. Мансууруулах эмийг одоо опиоид гэж нэрлэдэг болсон.”⁹⁷ гэх байдлаар тайлбарласан бол сэтгэцэд нөлөөлөх бодисыг “тархины үйл ажиллагаанд нөлөөлж, сэтгэлийн байдал, ухамсар, бодол санаа, мэдрэмж, зан төлөвт өөрчлөлт оруулдаг мансууруулах бодис эсвэл бусад бодис. Сэтгэц нөлөөт бодисын жишээнд алкоголь, кофеин, никотин, марихуан болон зарим өвдөлт намдаах эмүүд орно. Героин, LSD, кокаин, амфетамин зэрэг олон хууль бус хар тамхи нь сэтгэцэд нөлөөт бодис юм.”⁹⁸ гэж тодорхойлсон байна. Мөн өөр төрлийн анагаахын шинжлэх ухааны толь бичигт сэтгэцэд нөлөөлөх бодисыг “Таашаалыг өгдөг бодисын хэрэглээтэй эсвэл өвдөлтийг намдаадаг,

92 Convention on Narcotic Drugs, 1961, <https://undocs.org/en/ST/CND/1/Add.1/Rev.8>.

93 Convention on psychotropic substances, 1971, https://www.unodc.org/pdf/convention_1971_en.pdf.

94 German Criminal Code, 1998, https://www.gesetze-im-internet.de/englisch_stgb/englisch_stgb.html.

95 Korean criminal act, 2013, https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=28627&lang=ENG.

96 Japanese penal code, 1907, http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=&vm=02&id=1960.

97 National cancer institution, Dictionary of cancer terms, <https://www.cancer.gov/publications/dictionaries/cancer-terms/def/narcotic>.

98 National cancer institution, Dictionary of cancer terms, <https://www.cancer.gov/publications/dictionaries/cancer-terms/def/psychotropic-substance>.

бие махбодын хамаарал, хүлцлийг үүсгэдэг, ижил үр дүнд хүрэхийн тулд тунгаар хэрэглэх хандлагатай бодис, жоргүй сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх нь «нийгмийн» эсвэл тохиолдлын шинжтэй, эсвэл илэн далангүй донтолт болж хувирдаг, донтуулах чадвартай кокаин/»хагарал», амфетамин, опиат, никотин, спирт, бензодиазепин, барбитурат, каннабис, галлюциноген, кофеин, эмчилгээний эм буюу эмнэлзүйн орчинд зохистой ажиллах чадварыг сайжруулдаг бодис⁹⁹ гэж, сэтгэцэд нөлөөлөх бодисыг “Опиум эсвэл опиумтай төстэй нэгдлээс гаргаж авсан морфин, героин зэрэг мансууруулах бодис нь өвдөлтийг намдаадаг, ихэвчлэн нойрыг хүргэдэг, ухамсрыг өөрчилдөг, донтуулдаг¹⁰⁰” гэж тус тус тайлбарласан байна. Мансууруулах эмийн хувьд дараах эмийг нийтлэг хэрэглэдэг байна.

- Кодеин
- Фентанил
- Гидрокодон
- Гидроморфон
- Меперидин
- Морфин
- Оксикодон
- Трамадол¹⁰¹

Харин хамгийн түгээмэл хэрэглэдэг сэтгэцэд нөлөөлөх дараах бодисууд байдаг байна.

- Xanax (alprazolam)
- Zoloft (sertraline)
- Celexa (citalopram)
- Prozac (fluoxetine)
- Ativan (lorazepam)
- Desyrel (trazodone HCL)
- Lexapro (escitalopram)
- Cymbalta (duloxetine)
- Wellbutrin XL (bupropion HCL XL)
- Effexor XR (venlafaxine HCL ER)¹⁰²

Анагаахын шинжлэх ухааны хувьд мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөлөх бодисыг өөр өөрөөр авч үздэг бөгөөд тухайн хоёр бодисын хэрэглэгдэх байдал, зориулалт, үйлчлэл болон төрлүүд нь өөр байдаг байна.

Эцэст нь дүгнэвэл “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис” гэх нэр томъёог хууль зүйн шинжлэх ухааны хувьд олон эрх зүйн зохицуулалтаар зохицуулж тайлбарласнаас гадна анагаахын шинжлэх ухааны зүгээс мөн тайлбар өгсөн байна. Олон улсын эрх зүйн баримт бичиг болон анагаахын шинжлэх ухааны хувьд

99 Medical dictionary by Farlex, <https://medical-dictionary.thefreedictionary.com/psychotropic+substances>.

100 Medical dictionary by Farlex, <https://medical-dictionary.thefreedictionary.com/narcotic+drug>.

101 Pain medications - narcotics, <https://medlineplus.gov/ency/article/007489.htm>.

102 Good therapy, Most frequently prescribed psychotropic drugs, <https://www.goodtherapy.org/drugs/psychotropic-medication.html>.

“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис” гэх нэр томьёог нэг байдлаар биш тусад нь салгаж ойлгож, зохицуулж байгаа нь харагдаж байна. Учир нь мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөт бодис хоёр нь хэрэглэгдэх байдал, зориулалт, үйлчлэл, эрх зүйн зохицуулалт, хяналт, үр дагавар зэргээр хоорондоо ялгаатай. Үүнийг олон улсын эрх зүйн баримт бичиг болон анагаахын шинжлэх ухааны зүгээс тогтоож, зохицуулсан байна. Тиймээс “Мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодис” гэх нэр томьёог салгаж мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөт гэсэн утгаар нь ойлгож, зохицуулах нь зүйтэй.

2. “Халдварт өвчин” гэх нэр томьёоны тухайд

Хэл шинжлэлийн талаас: Монгол хэлний их тайлбар тольд “халдах” гэдгийг “өвчний бусдад дамжиж халдах нь: өвчний халдвар (хүн, амьтны биед өвчний нян орж үржих нь), шарын халдвар (шар өвчин халдах нь), тахлын халдвар (тахал өвчин халдах нь), халдвар судлах баг (эрүүл ахуй, халдвар судлалын төхөөрөмж бүхий автомашин эзэмшиж хээрийн нөхцөлд ажилладаг мэргэжлийн хамт олон)”¹⁰³ хэмээн тайлбарласан байх бол Монсудар хэвлэлийн газраас эрхлэн гаргасан Монгол хэлний тайлбар тольд “халдвар” гэх үгийг “өвчний бусдад дамжиж халдах нь”¹⁰⁴ гэж тайлбарлажээ.

Хэдийгээр анагаахын шинжлэх ухааны үүднээс тайлбарлах нь илүү оновчтой боловч хэл шинжлэлийн үүднээс “халдварт өвчин” гэх үгийн тайлбарыг авч үзэх шаардлагатай гэж үзлээ. Тус үгийг Монгол хэлний тайлбар тольд “бичил биетнээр үүсдэг халдварлан тардаг өвчин”¹⁰⁵ хэмээн тодорхойлсон байна.

Хууль зүйн талаас: Өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж буй Эрүүгийн хуулийн дараах зүйл, заалтуудад “халдварт өвчин”, “бэлгийн замын халдварт өвчин”, “дархлал хомсдолын вирус” гэх нэр томьёог хуульчилсан байна. Үүнд:

12.1 дүгээр зүйл. Хүчиндэх

2. Энэ гэмт хэргийг:

2.5. хохирогчид **бэлгийн замын халдварт өвчин халдааж;**

...бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

12.5 дугаар зүйл. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох

2. Энэ гэмт хэргийн улмаас:

2.2. **бэлгийн замын халдварт өвчин** халдаасан бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

15.6 дугаар зүйл. Бусдын амь насанд аюул учруулж болзошгүй халдварт өвчин, дархлал хомсдолын вирус халдаах

1. Бусдын амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй **халдварт өвчний** үед эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тогтоосон хорио цээр, хязгаарлалтын дэглэм, холбогдох бусад журам, заавар, шаардлагыг зориуд санаатайгаар зөрчиж халдварт өвчин тархах нөхцөл бүрдүүлсэн, эсхүл бусдад халдаасан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Бусдын амь насанд аюул учруулж болзошгүй **халдварт өвчин, дархлал хомсдолын вирусыг** бусдад зориуд халдаасан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

103 Монгол хэлний их тайлбар, <https://mongoltoli.mn/dictionary/detail/104422>.

104 Монсудар хэвлэлийн газар, Монгол хэлний тайлбар толь, 2018, 477 дахь тал.

105 Монгол хэлний их тайлбар, <https://mongoltoli.mn/dictionary/detail/104450>.

Бэлгийн замын халдварт өвчин гэх нэр томъёоны хувьд, судлаач С.Гантулга, Б.Энхбаяр нар өөрсдийн хамтын бүтээл болох “Эрүүгийн эрх зүй, тусгай анги” сурах бичигтээ “бэлгийн замын халдварт өвчин” гэж “бэлгийн замаар нэг хүнээс нөгөөд дамжих халдвар юм”¹⁰⁶ хэмээн тайлбарласан байна.

Мөн түүнчлэн судлаач С.Гантулга, Б.Энхбаяр нар ЭХ-ийн 15.6 дугаар зүйлийг дээр дурдсан бүтээлдээ тайлбарлахдаа “халдварт өвчин” гэдгийг “халдварт шавж болоод бусад төрлийн дамжуулагчид амьсгалдаг агаар, уудаг ус, гишгэж явдаг газар, шороогоор дамжин эсвэл шууд хавьтлаар хүн ба амьтнаас хүний бие махбодод орж үүсгэдэг өвчнийг хэлнэ. Халдварлах үедээ амь биед аюултай байдалд хүргэсэн буюу ердийн явцаараа үхэлд хүргэж болох халдварт өвчин хамаарна. Тухайлбал, шувууны ханиад, сарс, эбола”¹⁰⁷ хэмээн тайлбарласан байдаг.

Дархлал хомсдолын вирусын тухай Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт “хүний дархлал хомсдолын вирус” гэж зөвхөн хүний биеийн дархлалын эсүүдийг сонгомлоор гэмтээдэг вирус /ретровирус/-ыг ойлгоно хэмээн тодорхойлсон байх бол мөн зүйлийн 3.1.2-дахь хэсэгт “дархлалын олдмол хомсдол” буюу ДОХ-ыг “хүний дархлал хомсдолын вирусын нөлөөгөөр хүний биеийн дархлалын эсүүд гэмтэж, дархлалын тогтолцоо алдагдсанаар өвчин, эмгэг илрэхийг ойлгоно.” хэмээн тодорхойлжээ.

БНСУ нь халдварт өвчний тодорхойлолтыг Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, хяналт тавих тухай хуулийн 2.1 дүгээр зүйлд “Халдварт өвчин гэж 1~5 дугаар зэрэглэлийн халдварт өвчин, шимэгч хорхойн гаралтай, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын тандалтад байдаг, биологийн зэвсэг болгон ашигладаг халдварт өвчнүүд болон бэлгийн замын болон зоонозын, эмнэлгийн тусламж үйлчилгээний явцад халдварлан дамждаг өвчнүүдийг хэлнэ”¹⁰⁸ гэж тодорхойлоод зогсохгүй мөн хуулийн 2.2~2.12 дугаар зүйлд болон Эрүүл мэнд, халамжийн яамны сайдын баталсан халдварт өвчний тухай журмын 1 дүгээр зүйлд¹⁰⁹ халдварт өвчнийг хор аюулын хэмжээг нь шалгуур болгон ангилан тодорхойлсон байна.

Бусад шинжлэх ухааны үүднээс тодорхойлох нь

Халдварт өвчин (infectious disease, communicable disease)

Оксфордын анагаахын товч тайлбар тольд халдварт өвчнийг “нэг хүнээс нөгөөд дамжих бүхий л өвчин. Энэ нь бие махбодтой шууд харьцах, халдвартай бичил биетнийг авсан объекттой нийтлэг харьцах, өвчин тээгчээр дамжуулан, эсвэл ханиалгах эсвэл амьсгалын замаар халдвар бүхий дуслыг агаарт тараах зэргээс үүдэлтэй байж болно.”¹¹⁰

106 С.Гантулга, Б.Энхбаяр нар, Эрүүгийн эрх зүй, тусгай анги, 2018, 62 дахь тал.

107 Мөн тэнд, 148 дахь тал.

108 БНСУ-ын Засгийн газрын харьяа эрх зүйн практик мэдээллийн цахим хуудас, <https://m.easylaw.go.kr/MOM/SubCsmOvRetrieve.laf?langCd=700109&csmSeq=1598&ccfNo=1&cciNo=1&cnpCIsNo=1>.

109 Мөн тэнд.

110 Oxford concise medical dictionary, www.oxfordreference.com.

Харвардын Их Сургуулийн Эрүүл мэндийн хэвлэх газраас эрхлэн хэвлүүлсэн Анагаахын шинжлэх ухааны тольд эрүүл мэндийн нэр томьёо номд халдвар гэх үгийг “хүний бие махбодод бактери гэх мэт өвчин үүсгэх аюултай организмын өсөлт”¹¹¹ хэмээн тайлбарлаад, халдварт өвчнийг “хүнээс хүнд халдварладаг бактери, вирус болон бусад эмгэг төрүүлэгч бичил биетүүдээс үүдэлтэй аливаа өвчин”¹¹² хэмээн тодорхойлсон байна.

Мэд тэрмсийн Анагаахын шинжлэх ухааны тольд халдварт өвчнийг тодорхойлохдоо “өвчин (томуу, хумхаа, менингит, галзуу, татран гэх мэт) өвчин үүсгэгч бодис, бичил биетүүд (бактери, вирус, эгэл биетэн, мөөгөнцөр гэх мэт) хүний биед нэвтэрч, тэнд төлжиж, үржихийг хэлнэ.”¹¹³

Дээр дурдаж буй вирусын тухайд, тамхины цоохортох өвчнийг судлах явцад судлаач Мартинус Бэйринк эрүүл тамхийг өвчлүүлж байгаа шингэнийг “халдвартай амьд шингэн” хэмээн 1898 онд нэрлэжээ. Тэрээр халдвартай амьд шингэнд агуулагдаж, өвчлүүлж байгаа тэр зүйлийг вирус хэмээн нэрлэжээ. “Virus” гэдэг үг нь эртний Египетээс гаралтай үгсийн санд нэвтэрсэн бөгөөд нэг талаар могойн хор, нөгөө талаар эрэгтэй хүний үрийн шингэн гэсэн утгаар хэрэглэдэг байсан байна¹¹⁴.

Ханиадыг олон төрлийн вирус үүсгэдгийн дотроос хамгийн гол үүсгэгч нь хүний риновирус байдаг /Рино гэдэг нь Грекээр rhino хамар гэсэн утгатай./ Риновирус ханиадтай хүний хамраас гоожсон салслаг шингэнээр дамжин эрүүл хүмүүст дамждаг. Энэ вирус гол төлөв агаар дуслын замаар дамжин халдварлаж, хүний хамар, хоолой, уушгины салст бүрхүүлийн эсүүдэд үрждэг. Ханиад хүрсэн хүний биеийн зовиурууд нь риновирустэй огт холбоогүй, харин бидний дархлааны системтэй холбоотой байдаг.

Вирус дамжсан эсүүд цитокин хэмээх бодис ялгаруулдаг, тэдгээр бодисуудыг дархлалын систем илрүүлэн эсүүд рүү довтлон устгадаг тул хүний хамар, хоолой, уушгины салст бүрхэвчүүд гэмтэн, гэмтсэн хэсгүүдээс ихээхэн хэмжээний салслаг шингэн ялгардаг. Ханиад хүрсэн хүн бүрэн эдгэрнэ гэдэг нь дархлааны тогтолцооны эсүүд риновирусыг устгахыг хэлнэ. Хүн төрөлхтөн одоогоор цагаан цэцэг өвчин болон үхрийн мялзан гэдэг вирусээр үүсгэгддэг 2 өвчнийг бүрэн устгаад байна.¹¹⁵

Бэлгийн замын халдварт өвчин (ISSTD буюу sexually transmitted disease)

Оксфордын анагаахын товч тайлбар тольд “бэлгийн замын халдварт өвчин”-г “бэлгийн замаар дамжих аливаа өвчинг хэлнэ. Бэлгийн замаар дамжих халдварт өвчинд ДОХ, тэмбүү, заг хүйтэн, хламидийн зарим халдвар, бэлэг эрхтний герпес, зөөлөн шарх зэрэг орно.”¹¹⁶ хэмээн тайлбарлажээ.

Дархлал хомсдолын вирус (HIV буюу human immunodeficiency virus)

Хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ) нь дархлааны системийг онилон, эрүүл дархлаатай хүмүүсийн тэмцэж чадах олон халдвар, зарим төрлийн хорт хавдраас хүний биеийн дархлааны хамгаалалтыг сулруулдаг. Энэхүү вирус нь

111 Harvard Health Publishing, Medical Dictionary of Health Terms: D-I, <https://www.health.harvard.edu/d-through-i#I-terms>.

112 Мөн тэнд, <https://www.health.harvard.edu/a-through-c#C-terms>.

113 MedTerms Medical Dictionary A-Z, <https://www.medicinenet.com/infection/definition.htm>.

114 Карл Циммэр, Вирусын ертөнц, 2019, 32 дахь тал.

115 Мөн тэнд, 56 дахь тал.

116 Oxford concise medical dictionary, www.oxfordreference.com.

дархлааны эсийг устгаж, үйл ажиллагааг нь муутгадаг тул халдвар авсан хүмүүс аажмаар дархлалын хомсдолд ордог.¹¹⁷

Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр ХДХВ нь дэлхийн нийтийн эрүүл мэндийн томоохон асуудал хэвээр байгаа бөгөөд одоогийн байдлаар 36.3 сая [27.2–47.8 сая] хүн уг вирусийн халдвараар нас барсан байна. Өнгөрөгч 2020 оны эцсийн байдлаар ХДХВ-ийн халдвартай 37.7 сая [30.2-45.1 сая] хүн амьдарч байгаа бөгөөд тэдний гуравны хоёроос илүү хувь нь (25.4 сая) ДЭМБ-ын Африкийн бүсэд бүртгэгдсэн байна. 2020 онд 680 000 [480 000-1,0 сая] хүн ХДХВ-ийн халдвартай холбоотой шалтгаанаар нас барж, 1,5 сая [1,0-2,0 сая] хүн ХДХВ-ийн халдвар авчээ.¹¹⁸

ХДХВ-ийн халдварыг эмчлэх арга одоогоор байхгүй. Гэсэн хэдий ч ХДХВ-ийн халдвараас үр дүнтэй урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, тусламж үзүүлэх, тэр дундаа оппортунист халдвараас сэргийлэх хүртээмж нэмэгдэж байгаатай холбогдуулан ХДХВ-ийн халдвар нь ХДХВ-ийн халдвартай хүмүүст урт удаан, эрүүл амьдрах боломжийг олгодог эрүүл мэндийн архаг хэлбэр болж байна.

ХДХВ-ийн халдварын эцсийн үе шат нь дархлалын олдмол хомсдол (ДОХ) бөгөөд эмчилгээ хийлгээгүй тохиолдолд тухайн хүнээс шалтгаалж олон жил дамжин үргэлжилдэг. ДОХ нь тодорхой хорт хавдар, халдвар эсвэл бусад хүнд хэлбэрийн урт хугацааны эмнэлзүйгээр илэрдэг.

Эндээс дүгнэвэл, Манай улсад “халдварт өвчин”, “бэлгийн замын халдварт өвчин” гэх нэр томъёог хууль, бусад эрх зүйн акт, УДШ-ийн тайлбарт тодорхойлж, тайлбарлаагүй байна. Харин “дархлал хомсдолын вирус” гэх нэр томъёог Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт тодорхойлсон байна.

“Дархлал хомсдолын вирус” гэх нэр томъёог Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт зөвхөн хүний биеийн дархлалын эсүүдийг сонгомлоор гэмтээдэг вирус /ретровирус/-ыг ойлгоно хэмээн тодорхойлсон байгаа нь хэт явцуу агуулгаар тодорхойлсон гэж үзэж болохоор байна. Учир нь ДЭБ-ийн тодорхойлолтод дурдахдаа уг вирусыг дархлааны системийг онилон, эрүүл дархлаатай хүмүүсийн тэмцэж чадах олон халдвар, зарим төрлийн хорт хавдраас хүний биеийн дархлааны хамгаалалтыг сулруулдаг хэмээн тайлбарласан нь тухайн вирусын онцлох шинжийг тун оновчтой тайлбарласан байгаа юм.

Харин “халдварт өвчин”, “бэлгийн замын халдварт өвчин” гэх нэр томъёонуудыг хууль болон бусад эрх зүйн актад тайлбарлаагүй байх тул анагаахын шинжлэх ухаанд уг тодорхойлолт нийцэж буй эсэхийг тогтоох боломжгүй байна.

Ийнхүү хууль болон эрх зүйн актад тодорхойлоогүй байгаа нь одоогоор практикт асуудалгүй мэт боловчиг цаашид шинэ төрлийн халдварт өвчнүүд гарч буй үед хариу арга хэмжээ авах, эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашгийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зэрэг олон үйл ажиллагаанд тодорхойгүй байдал бий болгох эрсдэлтэй юм.

117 Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагын ХДХВ, ДОХ-ын мэдээ, <https://www.who.int/news-room/fact-sheets/detail/hiv-aids>.

118 Мөн тэнд.

Иймд халдварт өвчин гэж ямар өвчнийг ойлгох тухай, ямар өвчнүүд багтах, тухайн өвчнүүдийг ангилан авч үзэж тодорхойлсон эрх зүйн акт, албан ёсны тайлбар гаргах шаардлагатай байна.

V. Хүн ам зүйн шинжлэх ухааны нэр томьёо

1. “Орон байр” гэх нэр томьёоны тухайд

“Орон байр” гэх нэр томьёог хэл шинжлэлийн үүднээс “амьдран суухад зориулсан сууц” гэж тодорхойлсон байна¹¹⁹.

Хууль зүйн талаас: Орон байр гэх нэр томьёо нь 2002 оны Эрүүгийн хууль болон 2015 оны Эрүүгийн хууль аль алинд нь зохицуулагдсан нэр томьёо юм. 2002 оны Эрүүгийн хуульд 137 дугаар зүйлийн 137.1 “Иргэнд хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж орон байранд нь хууль бусаар нэвтрэх, дур мэдэн орж суух, орон байрнаас гаргах, нэгжлэг хийх зэргээр орон байрны халдашгүй байдлыг зөрчсөн бол...”, 145 дугаар зүйлийн 145.2-т “Энэ гэмт хэргийг давтан бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, машин механизм, тусгайлан бэлтгэсэн багаж хэрэгсэл хэрэглэж буюу орон байр, агуулах саванд нэвтэрч үйлдсэн, энэ хэргийн улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан, олон тооны мал хулгайлсан бол...” гэх мэтээр орон байр гэх нэр томьёог зохицуулсан байна. Мөн үүнээс гадна Монгол Улсын Дээд шүүхийн 2007 оны 5 дугаар сарын 29-ний дугаар 28 “Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай” тогтоолд “Мөн зүйлийн 145.2 дахь хэсэгт заасан “орон байр” гэдэгт хүн байнга буюу түр амьдрахад зориулагдсан төрөл бүрийн орон сууц, байшин, гэр, урц, зочид буудал, амралт сувиллын газар, зуслангийн байр, майхан зэргийг ойлгоно. Орон байр нь хөдөлгөөнтэй, түр шинжтэй байж болно” гэж тайлбарласан байна.

Одоо дагаж мөрдөж буй Эрүүгийн хууль буюу 2015 оны Эрүүгийн хуульд 13.6 дугаар зүйлийн 1-т “Оршин суугчийн зөвшөөрөлгүйгээр орон байранд нэвтэрч хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхэд халдаж дураараа авирласан бол...”, 2-т “Энэ гэмт хэргийг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн, эсхүл эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж хүний орон байранд нэвтрэн орсон, нэгжлэг хийсэн, эд хөрөнгө хураан авсан...”, 13.8 дугаар зүйлийн 1-т “Оршин суугчийн зөвшөөрөлгүйгээр орон байранд, эсхүл гадна талаас орон байрны доторх орчны гэрэл зураг авч, эсхүл дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийж олон нийтэд тараасан, эсхүл бусдад дамжуулсан...”, 3-т “Эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж орон байранд, гадна талаас орон байрны доторх орчны гэрэл зураг авсан, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийсэн бол...”, 17.1 дүгээр зүйлийн 2.1-т “...хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч...” гэх мэтээр орон байр гэх нэр томьёог зохицуулсан байна. Мөн 13.6 дугаар зүйлийн аутентик тайлбарт “Энэ хуульд заасан “орон байр” гэж хүн байнга, түр амьдрахад зориулагдсан төрөл бүрийн орон сууц, байшин, гэр, урц, зочид буудал, амралт сувиллын газар, зуслангийн байр, майхан зэргийг ойлгоно” гэж тодорхойлсон байна.

119 Монгол хэлний их тайлбар толь, <https://mongoltoli.mn/search.php?opt=1&word=%D0%BE%D1%80%D0%BE%D0%BD+%D0%B1%D0%B0%D0%B9%D1%80>.

Үүнээс гадна эрх зүйн сурах бичгүүдэд орон байр гэх нэр томьёог дээрх 2002 оны Эрүүгийн хуулийн тус хэсгийг тайлбарласан Улсын Дээд шүүхийн тогтоол болон 2015 оны Эрүүгийн хуулийн аутентик тайлбартай адил байдлаар тайлбарласан байна.^{120 121}

Эрх зүйн толь бичиг орон байр гэдэг нэр томьёог тодорхой байдлаар мөн тайлбарласан байна. Академич С.Нарангэрэлийн эрх зүйн толь бичигт орон байр гэх нэр томьёо байдаггүй, харин орон байрны халдашгүй байдлын талаар тайлбарласан байна. Орон байрны халдашгүй байдал гэдгийг (англ. the sanctity/inviolability of the home; ор. Неприкосновенность жилища) үндсэн хуулиар баталгаажуулсан хүний хувийн үндсэн эрхийн нэг; орон байранд тэнд оршин суугчдын хүсэл зоригоос гадуур хэн ч нэвтрэн орох ёсгүй болохыг харуулна. Орон байрны халдашгүй байдлын үндсэн хуулийн гол баталгаа нь нэгжлэгийг зөвхөн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч үндэслэл бүхий тогтоол гаргаж прокуророор батлуулах ба уг ажиллагаа эхлэхийн өмнө холбогдох этгээдэд уншуулж сонсгоно. Орон байранд дур зоргоороо нэвтрэн орох бүх тохиолдол нь гагцхүү нийгмийн аюулгүй байдал, түүнчлэн хүмүүсийн амь нас, эрүүл мэндэд заналхийлсэн ноцтой ба илэрхий аюулыг зайлуулах нөхцөлд хийгдэнэ. Орон байрны халдашгүй байдлын баталгааг онц байдал буюу дайны байдлын үед хязгаарлаж болно. Орон байрны халдашгүй байдлыг Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд баталгаажуулжээ. Иргэнд хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж орон байранд хууль бусаар нэвтрэх, дур мэдэн орж суух, орон байрнаас гаргах, нэгжлэг хийсэн нь иргэдийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг болно¹²² гэх байдлаар тайлбарласан. Орон байрыг гадаад улсын эрх зүйн толь бичигт “Орон сууц” гэж хүний амьдрах зориулалтаар ашиглаж, ашиглаж байгаа болон ашиглахаар төлөвлөж буй аливаа барилга, байгууламж, үйлдвэрлэсэн орон сууц, зөөврийн байшин, эсхүл түүний нэг хэсгийг хэлэх бөгөөд үүнд хамааран ашиглагдаж буй аливаа байшин, дагалдах хэрэгсэл орно. Зөвхөн улирлын чанартай амралтын зориулалтаар ашигладаг аливаа үйлдвэрлэсэн гэр эсвэл зөөврийн байшинг багтаана.¹²³ “Орон сууц” гэж хүн байгаа эсэхээс үл хамааран шөнийн цагаар оршин суудаг хүн байнга эсвэл завсарлагатай байрлаж байгаа барилга байгууламж¹²⁴ гэх мэтээр тайлбарласан байна.

Гадаад улсуудын эрх зүйн зохицуулалтад орон байр гэдгийг хуулийн зохицуулалтад тайлбарлаж зохицуулаагүй байна. Тухайлбал, Бүгд найрамдах Солонгос улсын Эрүүгийн хуулийн 330 дугаар зүйлд “оршин суугаа газар, харуул хамгаалалттай орон сууц, усан онгоц, усан онгоц, эзэлсэн өрөөнд шөнийн цагаар нэвтэрч бусдын эд хөрөнгийг хулгайлсан бол...” гэж зохицуулсан ба ямар нэг тайлбаргүй, Холбооны бүгд найрамдах Герман улсын Эрүүгийн хуулийн 224 дэх хэсгийн 1-ийн 3-т “Хувийн байранд нэвтэрч орох, эсхүл хувийн байранд нэвтрэх, нуугдах зэрэгт ихэвчлэн ашиглагддаггүй хуурамч түлхүүр эсвэл бусад хэрэгслийг ашиглан хулгай хийх...” гэж байдлаар зохицуулсан ба ямар нэг тайлбаргүй тус тус байна.

120 Монгол Улсын Дээд шүүх, Ханнс-Зайделийн сан, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, 2013, 352 дахь тал

121 С.Гантулга, Б.Энхболд, Эрүүгийн эрх зүй Тусгай анги сурах бичиг, 2018, 87 дахь тал

122 С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, 2007, 356 дахь тал

123 According to N.C. Gen. Stat. § 160A-442

124 United States v. Adams, 2009 U.S. App. LEXIS 25866 (9th Cir. Or. Nov. 25, 2009)

Нийгмийн шинжлэх ухааны талаас: Орон байр гэх нэр томьёог судлахын тулд эхлээд хувийн халдашгүй байдал, орон байрны халдашгүй байдлын талаар судлах нь зүйтэй. Учир нь орон байр гэх нэр томьёотой холбоотой гэмт хэргийн тухайд хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг, болон тухайн объекттэй холбоотой гэмт хэргүүд байдаг.

Орон байрны халдашгүй байдлын талаар Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-т зохицуулж, тус эрхийг хамгаалсан. Иргэдийн орон байрны халдашгүй эрх гэдэг бол тухайн этгээдийн хууль ёсоор амьдран сууж буй гэр, байшин, өрөө, тасалгаанд хамаардаг. Иймд орон байрны халдашгүй эрх гэдгийг орон байрны өмчлөх эрхээс ялгаатай үзэх ёстой. Жишээ нь бусдын өмчийн орон сууцыг өөр этгээд хөлслөн сууж байгаа бол орон байрны халдашгүй эрх тухайн үед хөлсөөр суугчид хадгалагдана. Зочид буудалд сууж буй хүн ч гэсэн тухайн тасалгаандаа орон байрны халдашгүй байдлыг хадгалдаг юм¹²⁵.

Мөн үүнээс гадна орон байрны халдашгүй байдлын талаар онолын чухал тайлбарыг Америкийн нэгдсэн улсын Дээд шүүхийн шүүгч Харлан Katz v. United States хэргийг шийдвэрлэхдээ хийсэн юм. Katz v. United States хэргийн тухайд “Холбооны мөрдөх товчооны мөрдөгчид Катзыг утасны бүхээгт утсаар ярьж байхад гаднаас нь чагнах төхөөрөмж тавьсан. Дүүргийн шүүх утасны яриаг Катзын эсрэг нотлох баримтаар ашигласан. Улмаар түүнийг АНУ-ын мужуудаар утсаар бооцооны мэдээлэл дамжуулсан хэргээр ял сонсгосон. Үүний дагуу тэрээр цахим төхөөрөмж ашиглан олж авсан нотлох баримтыг Америкийн нэгдсэн улсын Үндсэн хуулийн дөрөв дэх нэмэлт, өөрчлөлтийн эрхийг зөрчсөн гэж үзэн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргахаар болжээ¹²⁶” гэх товч агуулгатай байна. Америкийн нэгдсэн улсын Үндсэн хуулийн дөрөв дэх нэмэлт, өөрчлөлтийн хувьд “Ард түмний бие, орон байр, бичиг баримт, эд зүйлд үндэслэлгүй нэгжлэг, хураан авахаас хамгаалсан байх эрхийг зөрчиж болохгүй байх эрх”-ийг баталгаажуулж өгсөн байдаг. Америкийн нэгдсэн улсын Дээд шүүхийн шүүгч Харлан тус хэргийг шийдэхдээ хүний хувийн халдашгүй байдлыг дараах байдлаар тайлбарласан юм. Ингэхдээ утасны бүхээгт тухайн хүн өөрийн хувийн орон зайг мэдэрч, субъектив төсөөлөлтэй байсан, нийгмийн зүгээс тухай үйлдлийг хүлээн зөвшөөрсөн учир орон байртай адилтган чагнах төхөөрөмж тавьсныг тухайн хүний эрхийг зөрчсөн гэж үзэж ийнхүү зөвшөөрөлгүй тагнасан нь буруу юм гэж үзсэн. Ерөнхийдөө Америкийн нэгдсэн улсын Дээд шүүх Америкийн нэгдсэн улсын Үндсэн хуулийн дөрөв дэх нэмэлт, өөрчлөлт нь тухайн хүний байгаа орон байрыг бус тухайн хүнийг хамгаалдаг гэж үзсэн. Гэхдээ хүмүүст ямар хамгаалалт өгөх талаар асуудал тулгарна. Энэ нь орон байр гэдгээс эх үндэстэй байх ёстой. Өмнөх шийдвэрүүдээс үзвэл орон байрны халдашгүй байдал нь хоёр шаардлага биелснээр бий болохоор дүгнэгдэж байна. Нэгдүгээрт хүн хувийн халдашгүй байдлаа мэдрэх субъектив төсөөлөл бий болох, хоёрдугаарт нийгэм үүнийг үндэслэлтэй гэж ойлгох гэсэн хоёр шалгуур үүнд хамаарч байна. Тийм учраас тухайн хүний гэр нь хувийн халдашгүй байдлыг хадгалах орчин болдог хэдий ч үзэсгэлэн гэх мэт зүйлийг гаргахад энэхүү шинжээ алддаг байна. Өөрөөр хэлбэл нээлттэй хэн нэгэнтэй ярилцах үед тухайн хүн үүнийг хувийн нууц гэж бодохгүй бөгөөд хувийн халдашгүй байдлын төсөөлөл

125 Г.Совд, Н.Жанцан, Ж.Амарсанаа, С.Жанцан, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, 2000, 113 дахь тал

126 U.S. Reports: Katz v. United States, 389 U.S. 347, 1967, <https://privacylibrary.ccnlud.org/case/katz-vs-united-states>

байхгүй байх ба энэ үед хувийн халдашгүй байдал яригдахгүй юм¹²⁷.

Дээрх байдлаас дүгнэвэл орон байр гэх нэр томьёо нь орон байрны халдашгүй байдлаас эхтэй ойлголт учир тухайн агуулгаас гажиж болохгүй байна. Тиймээс дээрх онолын тодорхойлолт болон нэрлэн заасан 2 шаардлагад нийцэх ёстой. Монгол Улсын Эрүүгийн хуульд орон байр гэх нэр томьёог тайлбарлахдаа тоочиж орон байрны төрлүүдийг заасан байгаа нь үүний агуулгыг гаргаж, зохистой зохицуулахгүй байна.

Эцэст нь дүгнээд үзвэл орон байр гэх нэр томьёог Монгол Улсын Эрүүгийн хуульд аутентик тайлбараар тоочсон байдлаар тайлбарлаж зохицуулсан. Тайлбарласан эрдэм, шинжилгээний бүтээлүүд буюу онол болон гадаад улсуудын эрх зүйн зохицуулалтуудад тоочсон, ерөнхий байдлаар зохицуулсан янз бүр байна. Орон байр гэх нэр томьёо нь нийгмийн шинжлэх ухааны талаас онолын хувьд тайлбарлагдах ойлголт учир тухайн нэр томьёог тоочсон байдлаар бус ерөнхий байдлаар зохицуулж онолын дагуу ойлгох нь зүйтэй байна.

2. “Гэр бүлийн таагүй орчин” гэх нэр томьёоны тухайд

Хэл шинжлэлийн талаас нь: Гэр бүлийн таагүй орчин гэх ойлголтын тайлбарлах шаардлагатай үг нь таагүй гэх үг юм. Таагүй хэмээх үгийг Монгол хэлний их тайлбар тольд “тав тухгүй, тохьгүй, таа муутай, тааламжгүй, таалсан шинжгүй”¹²⁸ гэж тайлбарласан байх бол Монсудар хэвлэлийн газраас эрхлэн хэвлүүлсэн Монгол хэлний тайлбар тольд “тухгүй, тохьгүй, тав тухгүй байх, тааламжгүй, сэтгэлд нийцгүй”¹²⁹ гэж тайлбарласан байна.

Хууль зүйн талаас нь: Гэр бүлийн таагүй орчин гэх нэр томьёо нь Эрүүгийн хуулийн дор дурдсан зүйлүүдэд хуульчлагдсан байна. Энэ нь:

13.13 дугаар зүйл. Албадан хөдөлмөрлүүлэх

1. Бусдад хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, эсхүл хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, **гэр бүлийн таагүй орчин**, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулж цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

15.3 дугаар зүйл. Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах

3. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, **гэр бүлийн таагүй орчин**, амьдрал ахуйн бусад хүнд байдал, биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж эрхшээлдээ байгаа хүний эсрэг үйлдсэн, эсхүл энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

127 U.S. Reports: Katz v. United States, 389 U.S. 347, 1967, p.361, <https://tile.loc.gov/storage-services/service/lil/usrep/usrep389/usrep389347/usrep389347.pdf>

128 Монгол хэлний их тайлбар толь, https://mongoltoli.mn/search.php?ug_id=82788&opt=1&word=%D0%A2%D0%90%D0%90

129 Монсудар хэвлэлийн газар, Монгол хэлний тайлбар толь, 2018, 130 дахь тал.

16.1 дүгээр зүйл. Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах

1. Арван найман насанд хүрсэн хүн хүүхдэд амлалт өгч, хууран мэхэлж; хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, **гэр бүлийн таагүй орчин**, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулж гэмт хэрэг үйлдэхэд татан оруулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

16.4 дүгээр зүйл. Хүүхдээр гуйлга гуйлгах

1. Хүүхдэд амлалт өгч, хууран мэхэлж; хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, **гэр бүлийн таагүй орчин**, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулж байнга гуйлга гуйлгасан бол хоёр зуун дөчин цагаас дөрвөн зуун наян цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Хууль дахь тус нэр томьёоны тухай хууль тогтоогчийн зүгээс аутентик тайлбар, Шүүхийн тухай хуулийн 22.9-т зааснаар Улсын дээд шүүх хуулийг зөв хэрэглэх талаар гаргасан албан ёсны тайлбарыг тус тус гаргаагүй байна.

Судлаач С.Гантулга, Б.Энхбаяр нар өөрсдийн хамтын бүтээл болох “Эрүүгийн эрх зүй, тусгай анги” сурах бичигтээ ЭХ-ийн 13.13 дугаар зүйлийн 1-дэх хэсгийн “хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулсан” гэх шинжийг тайлбарлахдаа гэр бүлийн таагүй орчин гэдгийг гэр бүлийн хүчирхийлэл, эрсдэлт нөхцөлд амьдардаг, төрөл садан, асран хамгаалах хүнгүй гэж¹³⁰ тайлбарласан байна. Мөн тус бүтээлд ЭХ-ийн 15.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдал, биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж эрхшээлдээ байгаа хүний эсрэг үйлдсэн”¹³¹ гэдгийг, 16.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулж”¹³² гэдгийг, 16.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулж”¹³³ гэдгийг ижил агуулгаар тайлбарласан байх бөгөөд ийнхүү тайлбарлахдаа гэр бүлийн таагүй байдлыг “гэрээсээ дайжсан, тэнүүлчлэн амьдардаг, эцэг эхийн хараа хяналтгүй, гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг, амьжиргааны доогуур, гэр оронгүй зэрэг эмзэг байдал” хэмээн тодорхойлсон байна. Харин судлаач Т.Золбоо “Сургалтын Эрүүгийн хууль” бүтээлдээ ЭХ-ийн 13.13 дугаар зүйлийн 1-дэх хэсгийг тайлбарлахдаа гэр бүлийн таагүй орчин гэдгийг хохирогчид тохиолдсон хүнд нөхцөл байдал¹³⁴ хэмээх агуулгаар тодорхойлжээ.

2020 онд Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн профессор багш нар Нээлттэй нийгэм форумтай хамтран “Бага насны хүүхдийг алах болон хүчиндэх гэмт хэрэгт ял оногдуулж буй байдалд хийсэн дүн шинжилгээ” бодлогын судалгааны ажлыг гүйцэтгэсэн бөгөөд энэхүү судалгааны ноцтой баримт, үндэслэл шалтгааны талаар Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн дэд профессор, цагдаагийн дэд хурандаа С.Гантулга тус судалгааныхаа тухай ярилцлагадаа гэр бүлийн таагүй орчин гэдгийг “гэр бүл салалт, гэр бүлийн

130 С.Гантулга, Б.Энхбаяр нар, Эрүүгийн эрх зүй, тусгай анги, 2018, 104 дэх тал.

131 Мөн тэнд, 142 дэх тал.

132 Мөн тэнд, 155 дахь тал.

133 Мөн тэнд, 160 дахь тал.

134 Т.Золбоо, Сургалтын Эрүүгийн хууль, 2017, 89 дэх тал.

тогтворгүй байдал, хүүхдэд тавих хараа хяналт сул байдал, гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээний архидалт, гэр бүлээс гадуурх бэлгийн харьцаа”¹³⁵ гэж тайлбарласан байна.

Судлаач О.Өнөрцэцэг “Хүүхдийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, өнөөгийн байдал” өгүүлэлдээ гэр бүлийн таагүй орчинг “Эцэг эх нь байнга архи уудаг, хүүхдийн хажууд ёс суртахуунгүй үлгэр дуурайл үзүүлэх, хэрэлдэх, зодолдох, бусдыг доромжлох, гэмт хэрэг үйлдэх, зодох, харгис хэрцгий хандах”¹³⁶ байдлаар бий болдог гэж тодорхойлжээ.

Эндээс дүгнэвэл, Гэр бүлийн таагүй орчин гэх ойлголтыг хууль, эрх зүйн акт болон албан ёсны тайлбарт огт тайлбарлаагүйгээр зогсохгүй онолын түвшинд ч тодорхой тайлбарласан зүйл үгүй байна. Мөн түүнчлэн онолын тодорхойлолтууд хоорондоо агуулгын хувьд тааламжгүй, сөрөг гэх утга бүхий ижил төстэй байгаа ч зарим судлаач хэт дэлгэрэнгүй тайлбарласан байна.

Ийнхүү нэгдсэн буюу албан ёсны тайлбар байхгүй байгаа нь уг нэр томьёог практикт нэг мөр ойлгож эрүүгийн хуулийг хэрэглэхэд сөрөг үр дагавар бий болгох эрсдэлтэй.

Ийм учир Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар уг нэр томьёог тайлбарлах эсхүл УДШ албан ёсны тайлбар гаргах шаардлагатай байна.

VI.Сэтгэл зүйн шинжлэх ухааны нэр томьёо

1.“Сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан” гэх нэр томьёоны тухайд

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлд 1.Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.¹³⁷ Эрүүгийн хуулийн 13.2 дугаар зүйлд Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хууран мэхэлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй байдлыг ашиглаж эрхшээлдээ оруулан авч явсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ¹³⁸ гэж хуульчилжээ.

“Сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан” гэх ойлголтын тайлбар:

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбарт сэтгэл мэдрэлийн үйл ажиллагаа нь түр сарнисан гэдэгт хэвийн байдалд буцаж орох сэтгэцийн өвчин буюу өөрөөр хэлбэл тодорхой хугацаа өнгөрсний дараа эдгэрч болох сэтгэцийн өөрчлөлт юм. Үүнд эмгэг согтолт, сэтгэцийн эмгэг цочирдол, ухамсарт ухаан бүрийтэн балартах

135 “С.Гантулга, Гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг нуугдмал шинжтэй байгаа нь гэмт хэрэг давтан үйлдэгдэх шалтгаан болж байна” ярилцлага, ДХИС-ийн албан ёсны цахим хуудас, <https://www.uia.gov.mn/news-details/108>.

136 О.Өнөрцэцэг Хүүхдийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, өнөөгийн байдал Шинэ толь №72, 2011.

137 Монгол Улсын Эрүүгийн хууль, 2015, 12.1 зүйл

138 Монгол Улсын Эрүүгийн хууль, 2015, 13.2 зүйл

байдал хамаарах юм¹³⁹ гэж тодорхойлжээ. Эрх зүйн эх толь бичигт сэтгэцийн түр сарнил гэж харьцангуй удаан бус үргэлжилдэг, эмчлэгдснээр дуусгавар болдог сэтгэл мэдрэлийн өвчин. Дараах өвчин хамаарагдана. Үүнд, эмгэг согтолт, эмгэг сэтгэл цочирдол, сэтгэцийн ямар нэгэн өвчинтэй холбоогүй илрэх ухамсарт ухаан бүрийтэн балартах байдал.¹⁴⁰ Сургалтын эрүүгийн хууль номд сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан гэдгийг хохирогч субъектын үйлдлийн учир холбогдлыг ойлгоогүй эсвэл сэтгэхүйн болон бие бялдрын хувьд эсэргүүцэл үзүүлэх боломжгүй байдал¹⁴¹ гэж тодорхойлжээ.

Мөн сэтгэцийн үйл ажиллагаа түр сарнисан гэдэгт сэтгэцийн хэвийн байдалд буцаж орох сэтгэцийн түр зуурын солиорол буюу өөрөөр хэлбэл эдгэрч болох байдлыг ойлгоно. Тухайлбал, сэтгэл мэдрэлийн үйл ажиллагаа түр сарнихад хүргэдэг сэтгэцийн үйл ажиллагааны түр зуурын эмгэг өөрчлөлтүүдэд гэнэт эхэлдэг, богино хугацаатай үргэлжилдэг, эхэлсэн шигээ гэнэт арилдаг, клиникийн хувьд үлдэц согог өгөлгүй бүрэн эдгэрдэг, янз бүрийн шинж тэмдгээр илэрдэг, янз янзын шалтгаантай сэтгэцийн эмгэг байдлуудыг хамааруулан авч үздэг. Үүнд дараах сэтгэц эмгэгийн шинжүүд хамаарна. Хордлого, халдвар, бие махбодын өвчний шалтгаант шинж тэмдгийн солиорлууд, эмгэг согтолт, сэтгэлийн эмгэг цочирдол, эмгэг нойрмог байдлууд, сэтгэлийн шалтгаант хурц солиорол нэртэй түр зуурын солиорлуудыг өөртөө багтаасан онцгой байдлууд, гадна төрөлт хүчин зүйлээр сэдэгдэн үүсдэг, ихэнх тохиолдолд ухаан балартах байдлаар клиник нь илэрдэг гадна төрөлтөд органик солиорлууд, завсрын тархины эмгэгээр нөхцөлдөн үүсдэг, ухаан баларталт ба хөдөлгөөний хүрээний өөрчлөлтөөр клиник нь илэрдэг пароксизм өөрчлөлтүүд¹⁴² гэж тодорхойлжээ.

Хуулийн толь бичигт сэтгэл мэдрэлийн өвчин /mental disorder/ Хэвийн үеийг бодвол чадавх муутай болгож буй үргэлжийн эсвэл түр зуурийн хүний сэтгэцийн үйл ажиллагаан дахь өөрчлөлт¹⁴³ гэж тодорхойлжээ. Америкийн сэтгэц мэдрэлийн холбооноос гаргасан сэтгэцийн эмгэгийн оношлогоо, статистикийн гарын авлагад сэтгэл мэдрэлийн өвчинг тодорхойлохдоо:

1. Хувь хүнд тохиолддог эмнэлзүйн ач холбогдол бүхий зан үйлийн эсвэл сэтгэл зүйн синдром эсвэл хэв маяг;
2. Одоо байгаа зовлон(зовиуртай байгаа шинж тэмдэг) эсвэл хөгжлийн бэрхшээл(өөрөөр хэлбэл нэг буюу хэд хэдэн чухал үйл ажиллагааны хэсэг гэмтэх) эсвэл нас барах, өвдөх, тахир дутуу болох эсвэл эрх чөлөөгөө алдах зэрэгт эрсдэл мэдэгдэхүйц нэмэгддэг;
3. Хувь хүний зан үйл, сэтгэл зүй, биологийн эмгэгийн илрэл;
4. Энэ хазайлт, зөрчилдөөн нь хувь хүний үйл ажиллагааны доголдлын шинж тэмдэг биш л бол хувь хүн ба нийгмийн хоорондын зөрчилдөөн (жишээ нь, улс төр, шашин, бэлгийн гэх мэт) сэтгэцийн эмгэг биш юм;

139 Монгол улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим, ХБНГУ-ЫН Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, “Эрх зүйн боловсрол” академи, Монгол улсын эрүүгийн хуулийн тайлбар, 2010, 81 тал

140 С.Нарангэрэл, Эрх зүйн толь бичиг, анхын хэвлэл, 2007, 405 тал

141 Т.Золбоо, Сургалтын эрүүгийн хууль, 2017, 76 тал

142 Н.Одонтуул, Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд хийсэн судалгаа, Гэмт явдалтай тэмцэх асуудал 2020 №01 (71), 65-66 дахь тал.

143 Bloomsbury Publishing Plc, Dictionary of law, 2004, p191.

5. “Сэтгэцийн эмгэг” гэсэн ойлголтын тодорхой хил хязгаарыг хангалттай тодорхойлсон тодорхойлолт байдаггүй;
6. Сэтгэцийн эмгэгийн тухай ойлголт (анагаах ухаан, шинжлэх ухааны бусад олон ойлголтуудын нэгэн адил) бүх нөхцөл байдлыг хамарсан үйл ажиллагааны тогтвортой тодорхойлолтгүй байдаг.¹⁴⁴

Дээрхээс үзвэл Монгол Улсын Эрүүгийн хуульд тусгагдсан “сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан” гэх нэр томъёог гадаад, дотоодын хууль зүйн толь бичиг болон судлаачид янз бүрээр тодорхойлсон байна.

Монгол Улсын Эрүүгийн хуульд тусгагдсан “сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан” гэх нэр томъёо нь сэтгэц мэдрэлийн буюу сэтгэл зүйн шинжлэх ухааны үүднээс тайлбарлавал “сэтгэцийн өвчин” гэх нэр томъёонд хамаарах ойлголт болох нь харагдаж байна. Учир нь сэтгэц мэдрэлийн буюу сэтгэл зүйн шинжлэх ухааны үүднээс сэтгэцийн тус эмгэгийг сэтгэцийн өвчинд хамаарна хэмээн тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл тус нэр томъёонууд нь хоорондоо давхардлыг бий болгож байгаа нь харагдаж байна. Тиймээс тус нэр томъёоны давхардлыг “сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан” гэх нэр томъёог “сэтгэцийн өвчин” гэх нэр томъёонд шингээн давхардлыг арилгах нь зүйтэй юм.

2. “Дураараа аашлах” гэх нэр томъёоны тухайд

Хэл шинжлэлийн талаас: “Аашлах” гэдгийг Монгол хэлний их тайлбар тольд “элдэв авир байдал гаргах”¹⁴⁵ хэмээн тайлбарлаад дураар аашлахыг “хүнээс айж ичихгүй, өөрийн дураар загнах”¹⁴⁶ гэж тайлбарлажээ.

Хууль зүйн талаас: “Дураар аашлах” гэж 1961 оноос 2002 оны ЭХ-уудад заасан захиргааны журмын эсрэг гэмт хэргийн нэгэн төрөл байлаа. Тухай үеийн ЭХ-д тус гэмт хэргийг өөртөө үнэхээр байгаа буюу байна гэж үзсэн эсхүл бусадтай маргаж байхдаа хуулиар тогтоосон журмыг зөрчиж эрхээ дураараа хэрэгжүүлснээс ААН, байгууллага, иргэнд бага бус хэмжээний хохирол учруулсан гэмт үйлдэл гэж үздэг байв. Харин 2015 оны шинэчлэн найруулсан ЭХ-д уг гэмт хэргийг тусгай ангийн авлигын гэмт хэргийн бүлэгт байршуулж, нийтийн албан тушаалтан өөрт олгогдоогүй албан тушаалын бүрэн эрхийг бусдын нэрийн өмнөөс хэрэгжүүлсэн, ашигласны улмаас бусдын эрх ашигт ноцтой хохирол учруулсан гэж тодорхойлжээ. Үүнийг Академич С.Нарангэрэл дураар аашлах гэмт хэргийг албан тушаалын гэмт хэрэг болгон хувиргасан хэмээн дүгнэжээ.¹⁴⁷

144 Cambridge University Press, What is a mental/psychiatric disorder? From DSM-IV to DSM-V, 2010, <https://www.cambridge.org/core/journals/psychological-medicine/article/what-is-a-mentalpsychiatric-disorder-from-dsmiv-to-dsmv/DC3CC7DA2C4507D8F0D3110392B219A9#>.

145 Монгол хэлний их тайлбар толь, https://mongoltoli.mn/search.php?ug_id=577&opt=1&word=%D0%90%D0%90%D0%A8%D0%9B%D0%90%D0%A5#.

146 Мөн тэнд, https://mongoltoli.mn/search.php?opt=1&ug_id=579.

147 С.Нарангэрэл, Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь, 2021, 131 дэх тал.

Хүснэгт 3.6. Эрүүгийн хуулиуд дахь холбогдох зүйл заалтуудыг харьцуулсан нь №3

2002 оны Эрүүгийн хууль	2015 оны Эрүүгийн хууль
236 дугаар зүйл. Дураараа аашлах 236.1. Дураараа аашлах, өөрөөр хэлбэл өөртөө үнэхээр байгаа буюу байна гэж үзсэн, эсхүл бусадтай маргаж байхдаа хуулиар тогтоосон журмыг зөрчиж эрхээ дураараа хэрэгжүүлснээс аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд бага бус хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.	22.11 дүгээр зүйл. Дураараа аашлах 1. Нийтийн албан тушаалтан өөрт олгогдоогүй албан тушаалын бүрэн эрхийг бусдын нэрийн өмнөөс хэрэгжүүлсэн, ашигласны улмаас бусдын эрх ашигт ноцтой хохирол учирсан бол нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Дээрх харьцуулсан хүснэгтээс харвал 2002 оны ЭХ дахь дураараа аашлах гэмт хэрэг, 2015 оны ЭХ-дахь дураараа аашлах гэмт хэрэг хоорондоо зөвхөн нэр ижил, агуулга тэс өөр байна.

2002 оны Эрүүгийн хуулийн 236 дугаар зүйл дэх дураараа аашлах гэмт хэргийн “өөртөө үнэхээр байгаа гэж итгэсэн” гэдэгт өөрт нь хууль тогтоомжоор олгогдсон эрх хамаарах боловч энэ эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын эрх эрх чөлөөнд халдсанаар энэ гэмт хэргийн бүрэлдэхүүн хангагддаг.

“Өөртөө байна гэж үзсэн” гэдэгт энэ гэмт хэргийн субъектэд ийм эрх байхгүй боловч ийм эрх байх ёстой гэж үзсэнийг хэлнэ гээд дараах байдлаар тайлбарласан байна:

1. Уг дураар авирлагч этгээдэд өөрт нь олгогдсон эрхийг түүнийг эдлэх талаарх хуулиар тогтоосон журмыг зөрчиж хэрэгжүүлсэн байдаг;
2. Өөртөө байгаа гэж үзсэн боловч бодит байдал дээр түүнд хамаарахгүй эрхийг хэрэгжүүлсэн байдаг. Энэ ихэвчлэн бодит байдлын андуурал байна;
3. Бусадтай маргаж байгаа эрхийг хууль бусаар дураараа хэрэгжүүлсэн байдаг.¹⁴⁸

2015 оны Эрүүгийн хуулийн 22.11 дүгээр зүйлд заасан Дураараа аашлах гэмт хэргийг судлаач С.Гантулга, Б.Энхболд нар “Эрүүгийн эрх зүй, тусгай анги” сурах бичигтээ “өөрт олгогдоогүй албан тушаалын бүрэн эрхийг бусдын нэрийн өмнөөс хэрэгжүүлсэн, ашигласан гэж өөрийн буюу бусад албан газрын дээд албан тушаалын чиг үүрэг, эрх мэдэлд хамаарагдах үйл ажиллагааг дур мэдэн явуулсан, хамтын шийдвэр гаргах ёстой асуудлыг дур мэдэн бие дааж шийдвэрлэсэн, эрх мэдлээ хууль, дүрэмд заасан тусгай нөхцөл бүрдээгүй байхад хэрэгжүүлсэн, хуулиар зөвшөөрөгдөөгүй огт хийх ёсгүй үйл ажиллагаа явуулсан байхыг ойлгоно”¹⁴⁹ хэмээн тайлбарласан байна.

Дээр дурдсан шинжлэх ухааны тайлбаруудыг харвал 2002 оны ЭХ дахь дураараа аашлах гэмт хэрэг, 2015 оны ЭХ-дахь дураараа аашлах гэмт хэргүүд нь агуулгын хувьд адилтгах аргагүй болох нь батлагдаж байна. Харин 2015 оны ЭХ 22.11 дүгээр зүйлд заасан дураараа аашлах гэмт хэрэг нь 2002 оны ЭХ-ийн 264

148 Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, 576 дахь тал.

149 С.Гантулга, Б.Энхбаяр нар, Эрүүгийн эрх зүй, тусгай анги 2018, 400 дэх тал.

дүгээр зүйлд заасан төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх гэмт хэрэгтэй агуулгын хувьд ижил, төстэй байна.

**Хүснэгт 3.7. Эрүүгийн хуулиуд дахь холбогдох зүйл
заалтуудыг харьцуулсан нь №4**

2002 оны Эрүүгийн хууль	2015 оны Эрүүгийн хууль
264 дүгээр зүйл. Төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 264.1.Төрийн албан тушаалтан албан үүргийн хувьд хуулиар олгогдсон эрх мэдлээ хэтрүүлснээс аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхолд үлэмж хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. 264.2.Энэ хэргийг давтан, эсхүл хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас их буюу онц их хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасч хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	22.11 дүгээр зүйл.Дураараа аашлах 1.Нийтийн албан тушаалтан өөрт олгогдоогүй албан тушаалын бүрэн эрхийг бусдын нэрийн өмнөөс хэрэгжүүлсэн, ашигласны улмаас бусдын эрх ашигт ноцтой хохирол учирсан бол нийтийн албанд томилогдох эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Дээрх хүснэгтээс төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх гэмт хэргийн бүрэлдэхүүнийг 2015 оны ЭХ-д “дураараа аашлах” гэж нэрлээд түүнийг нийтийн албан тушаалтан өөрт олгогдоогүй албан тушаалын бүрэн эрхийг бусдын нэрийн өмнөөс хэрэгжүүлсэн, ашигласны улмаас бусдын эрх ашигт ноцтой хохирол учирсан гэж тодорхойлсон болох нь ойлгомжтой байна. Энэ тухай С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган нар “1961 оноос хойш хагас зуу гаруй жил тогтвортой хэвшиж ирсэн дураар аашлах гэсэн нэр томьёог ингэж гэнэт өөрчилснөөрөө ЭХ-ийн тогтсон нэр томьёог будлиантуулсан”¹⁵⁰ хэмээн дүгнэжээ.

Бусад шинжлэх ухааны үүднээс тодорхойлох нь

Дураараа аашлах хэмээх нэр томьёо нь англи хэлнээ “arbitrariness” хэмээх үгээр орчуулагдахаар байна. Энэхүү үгийг Кембрижийн тольд урьдаас төлөвлөсөн төлөвлөгөө эсвэл шалтгаанаар нөхцөлдөөгүй боломжид тулгуурласан чанар, өөрийн эрх мэдлийг шударга бус, хязгаарлалтгүйгээр ашиглах¹⁵¹ гэж тайлбарласан байх бол Коллинсийн тольд дээрх үгийг ямар нэгэн зарчим, төлөвлөгөө, тогтолцоонд үндэслэлгүйгээр үйлдэл, дүрэм, шийдвэрийг дур зоргоороо тайлбарлах, үүнээс болж түүнээс бусдад шударга бус мэт санагдах¹⁵² гэж тайлбарлажээ.

Зарим улс оронд дур зоргоороо авирлахыг хориглосон заалтыг үндсэн хуульдаа тусгасан байна. Үүний нэгэн жишээ нь Швейцарын Холбооны Улс бөгөөд Швейцарын Холбооны Үндсэн хуулийн 9-р зүйлд “хүн бүр төрийн эрх баригчдаас

150 С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган нар, Монгол Улсын эрүүгийн эрх зүй: үзэл баримтлал, уламжлал, сургамж, 2019, 209 дэх тал.

151 Cambridge Dictionary, <https://dictionary.cambridge.org/dictionary/english/arbitrariness>.

152 Collins online dictionary, <https://www.collinsdictionary.com/dictionary/english/arbitrary>.

үнэнч шударга байдал хийгээд дур зоргын бус байхыг шаардах эрхтэй”¹⁵³ хэмээн заасан байх ба энэ нь онолын хувьд гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас хэдий ардчилсан шийдвэр байсан ч дур зоргоороо үйл ажиллагаа явуулахыг хориглосон агуулгатай.

Түүнчлэн ОХУ-ын Эрүүгийн хуулийн 330 дугаар зүйлд дураараа аашлахыг гэмт хэрэг гэж үздэг боловч энэ нь «хуульд заасан журмын эсрэг үйлдлүүд» гэсэн агуулгатай байна.¹⁵⁴

330 дугаар зүйл. Дураараа аашлах

1. Дураараа аашлах буюу зөвшөөрөлгүй, хууль тогтоомж болон бусад зохицуулалтын эрх зүйн актад заасан журмыг зөрчиж, тухайн үйлдлийн хууль зүйн үндэслэлийн талаарх иргэн, хуулийн этгээдийн маргаан үүссэн үед дураараа авирлаж, дураараа үйлдэл үйлдэж бусдад их хэмжээний хохирол учруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэгээс хоёр сар хүртэл хугацаагаар хөдөлмөрийн хөлс, эсхүл бусад орлогын хэмжээгээр торгох, эсхүл нэг сараас хоёр сар хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, 180 цагаас 240 цаг хүртэл хугацаагаар, нэг жилээс хоёр жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурваас зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ялаар шийтгэнэ.

2. Тухайн гэмт хэргийг хүч хэрэглэх, эсхүл заналхийлж үйлдсэн бол гурван жил хүртэл хугацаагаар эрх хязгаарлах, дөрвөөс зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ.⁵³⁵

Дүгнэвэл, Дураараа аашлах (arbitrariness) хэмээх ойлголт нь эрх, хууль ёсны ямар нэг үндэслэлгүйгээр эрх мэдлийг өөрийн хүслээр хэтрүүлэх гэсэн агуулгатай байна.

Харин манай улсын Эрүүгийн эрх зүйд дураараа аашлах хэмээх ойлголт нь өөрт хууль тогтоомжоор олгогдсон эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын эрх эрх чөлөөнд халдсан, эрх байхгүй боловч ийм эрх байх ёстой гэж бодит байдлыг андууран итгэж хуулиар тогтоосон журмыг зөрчих агуулгатай бөгөөд энэ утгаараа хэрэглэгдэн нэгэнт тогтсон уламжлалтай байжээ. Гэтэл энэ уламжлалт ойлголтыг мөн урьд нь тогтсон байсан өөр ойлголтоор буюу эрх мэдлээ хэтрүүлэхтэй сольж өөрчилсөн байна. Энэ нь манай улсын Эрүүгийн эрх зүйн уламжлалд харш, нийцэхгүй зохицуулалт болжээ.

153 Federal Constitution of the Swiss Confederation, <https://fedlex.data.admin.ch/filestore/fedlex.data.admin.ch/eli/cc/1999/404/20210101/en/pdf-a/fedlex-data-admin-ch-eli-cc-1999-404-20210101-en-pdf-a.pdf>.

154 The Criminal Code Of The Russian Federation, <http://www.russian-criminal-code.com/PartIII/SectionX/Chapter32.html>.

VII. Техникийн шинжлэх ухааны нэр томьёо

1. “Хор хөнөөлт программ хангамж” гэх нэр томьёоны тухайд

Хүснэгт 3.8. Эрүүгийн хуулиуд дахь холбогдох зүйл заалтуудыг харьцуулсан нь №5

2002 оны Эрүүгийн хууль	Шинэчлэн найруулсан 2015 оны Эрүүгийн хууль
229 дүгээр зүйл Нянтай программ зохион бүтээх, 229.1. Компьютерын мэдээллийг зөвшөөрөлгүйгээр устгах, хаах, өөрчлөх болон хуулбарлах зорилгоор компьютерын программ зохион бүтээх, программд өөрчлөлт оруулах, нянтай программыг тусгайлан зохион бүтээх, түүнийг мэдсээр байж ашигласан, тараасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.	26.3 дугаар зүйл. Хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах 1.Цахим төхөөрөмжид хадгалагдаж байгаа мэдээллийг зөвшөөрөлгүйгээр устгах, гэмтээх, өөрчлөх, хуулбарлах, мэдээлэл олж авах, программ хангамж, мэдээлэл хадгалагдаж байгаа төхөөрөмж, сүлжээг ашиглах боломжгүй болгох, хэвийн үйл ажиллагааг алдагдуулах зориулалттай хор хөнөөлт ийг тусгайлан зохиосон, зориудаар ашигласан, санаатай тараасан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2015 оны Эрүүгийн хуульд хор хөнөөлт программ хангамж гэж заасан нь 2002 оны Эрүүгийн хуульд заасан “нянтай программ” гэсэн нэр томьёотой харьцуулахад илүү өргөн ойлголтыг агуулсан байна гэж үзэж байна.

“Хор хөнөөлт программ хангамж” гэх ойлголтын тайлбар

Хууль зүйн талаас: 2002 оны Эрүүгийн хуулийн 229.1-т заасан Нянтай программыг Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбарт нянтай программ гэдэг нь харилцаа холбооны сүлжээгээр дамжин нэг системээс нөгөөд шилжиж, цахим тооцооны машинд нэвтрэх чадвартай бөгөөд бусад программуудад аяндаа нийлж, тэдгээрийг асаахад файлууд болон каталогуудыг эвдэх, тооцооны дүнг буруу болгох, санамжийг бохирдуулах, арилгах зэрэг хүсээгүй янз бүрийн үйлдлүүдийг хийж чаддаг программыг хэлнэ¹⁵⁵ гэж тодорхойлжээ. Эрүүгийн эрх зүй тусгай анги сурах бичигт хор хөнөөлт программ бол идэвхтэй үржиж, холбогдсон программыг өөрчлөн хэвийн үйл ажиллагааг нь алдагдуулах чадвартай нэг төрлийн программ юм. Үүнээс гадна, эдгээр программ нь бусад программд нэвтрэн орж, тааламжгүй үр дагавар /файл, каталогийг гэмтээх, мэдээллийг өөрчлөх, устгах г.м/ болгодог.¹⁵⁶

Программ гэдэг нь тооцоолон бодох машин болон компьютерын бусад төхөөрөмжийг ашиглан тодорхой үр дүнд хүрэхэд зориулагдсан янз бүрийн мэдээлэл болон командын нийлбэр цогц юм.¹⁵⁷

Эрүүгийн эрх зүй тусгай анги сурах бичигт өргөн тархсан хор хөнөөлт программуудад:

155 Монгол улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, 2010, 563 дахь тал.

156 С.Гантулга, Б.Энхболд, Эрүүгийн эрх зүй тусгай анги, 2018, 496 дахь тал.

157 Erdenetsetseg, Комьютерын мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 2011, https://teacher-erka.coo.mn/46443/kompyutyeriin-medeellin-ayulgui-baidlyn-esreg-gemt-herег.html?#_ftn30.

1. Өт. Эдгээр нян программын файлыг өөрчилдөггүй бөгөөд компьютерын санамжид нэвтрэн орж бусад компьютерын хаягийг тогтоон тэдэнд нянгийн хувиудыг илгээнэ;
2. Паразит. Программын файлыг зайлшгүй өөрчилдөг нян;
3. Аюултай нян. Ийм нянг гол төлөв сонирхогч бий болгодог. Алдаа мадаг ихтэй байдаг тул ийм нянг тусгай программаар илрүүлэхэд хялбар байдаг;
4. Үл үзэгдэгч. Тэдгээр нь нэлээд боловсронгуй бөгөөд нянгийн эсрэг программаар илэрдэггүй. Учир нь халдварласан файлыг нээхэд уг нянгууд нэн даруй холдон, хаахад дахин халдваржуулж эхэлдэг байна;
5. Хий үзэгдэл. Уг нянгуудыг илрүүлэх маш төвөгтэй. Ийм нянгууд нь программыг халдваржуулах явцдаа кодоо байнга сольж байдаг онцлогтой. Тиймээс дараа дараагийн халдварлагдсан программуудад аливаа шинж байдлыг тогтоож болдоггүй учраас нянгийн эсрэг программ үр дүнгээ өгдөггүй;
6. Логик бөмбөг. Программын кодыг санаатай өөрчлөх замаар урьдаас тооцоолсон ямар нэгэн нөхцөл бүрдүүлэхэд, жишээлбэл, тодорхой хугацаа болоход тооцоолон бодох машины программ буюу системийн заримыг юмуу бүхлээр нь ажиллагаагүй болгохыг хэлнэ. Логик бөмбөг бол анхнаасаа программын нэгэн хэсэг бөгөөд өөр программд шилждэггүй онцлогтой. Харин нян бол программ бөгөөд компьютерын сүлжээгээр ч дамжих чадвартай.¹⁵⁸

Европын мэдээлэл сүлжээний аюулгүй байдлын агентлагийн гарын авлагад Malware гэх үг нь malicious softWARE буюу хор хөнөөлт программ хангамж гэсэн үгний товчлол юм гэж тодорхойлжээ. Хор хөнөөлт программ хангамж /malware/ нь таны зөвшөөрөлгүйгээр таны компьютерт нэвтрэн орох зориулалттай бүтээгдсэн дайсагнасан эсвэл халдлагат программ юм.¹⁵⁹

Тухайн программ нь хор хөнөөлт программ байхын тулд дараах хоёр шалгуурт нийцсэн байх ёстой:

1. Дайсагнасан эсвэл халдлага;
2. Таны зөвшөөрөлгүй таны компьютерт орсон байх

Хор хөнөөлт программ нь дата эсвэл файл устгах, бусад компьютерт халдах, эсвэл таны зөвшөөрөлгүй бусад үйлдлүүдийг хийдэг. Сүүлийн жилүүдэд программистууд хамгийн олон давтамжтай хэрэглэгддэг хор хөнөөлт программ хангамжийг мэдээ мэдээлэл хулгайлах, бусад компьютерыг доголдуулах эсвэл залилан үйлдэхэд ашигладаг байна. Жил ирэх тусам хор хөнөөлт программ хангамж нь улам их ихсэж байгаа бөгөөд удаашрах төлөвгүй байна. Программистууд байнга шинэ хор хөнөөлт программ хангамж бүтээж байдаг учир хор хөнөөлт программ хангамжийг бүрэн устгах боломжгүй юм.¹⁶⁰

Хор хөнөөлт программ хангамж нь дотроо хэд хэдэн төрөлтэй байдаг байна. Олон төрлийн хор хөнөөлт программ хангамж хэд хэдэн ангилалд багтдаг ба

158 С.Гантулга, Б.Энхболд, Эрүүгийн эрх зүй тусгай анги, 2018, 498 дахь тал.

159 European Network and Information Security Agency (ENISA), Malicious software: train the trainer reference guide, 2010, p.12.

160 European Network and Information Security Agency (ENISA), Malicious software: train the trainer reference guide, 2010, p.12.

системээс системээсрүү шилжихдээ өөрчлөгддөг байна. Хор хөнөөлт программ хангамж нь үргэлж хувьсаж байдаг ба холимог хувилбарууд тогтмол бүтээгдэж байна.

Хор хөнөөлт программ хангамжийн төрөл:

1. Virus
2. Worm

Virus нь нэг файлаас нөгөө файлууд өөрийгөө хуулбарлан компьютерт халддаг программ хангамж юм. Virus нь ихэвчлэн файл, санах ой, хард диск, эсвэл бусад дата хадгалах хэрэгслийн хооронд өөрийгөө хуулбарладаг. Virus нь аль хэдийн халдварлагдсан файл хуулбарлах эсвэл боловсруулах үед тархдаг.

Worm нь сүлжээгээр дамжин тархдаг программ хангамж ба оршин буй файл эсвэл программ хангамж руу холбогдох шаардлагагүй байдаг. Worm нь ихэвчлэн оршин буй үйлдлийн систем эсвэл хэрэглээний программийн сул талыг ашиглан тархдаг.¹⁶¹

3. Trojan horse
4. Backdoors

Trojan horse нь Trojan-ы дайны алдарт Trojan horse-ийн түүхээс сэдэвлэн нэрлэжээ. Trojan horse-ийн түүхэнд гардаг шиг тухайн программ хангамж нь гаднаа хор хөнөөлгүй мэт харагдахаар бүтээгдсэн байдаг байна. Зарим тохиолдолд тухайн программ хангамж нь аль хэдийн оршин буй файл эсвэл үйлдлийн системийн нэрийг ашигладаг. Trojan horse нь нэр шигээ адил дотроо аюултай чадварууд нуудаг.

Backdoor программ нь хэвийн нэвтрэх үйл явцыг тойрон гарч халдагч эсвэл довтлогчийг систем рүү нэвтрүүлэн оруулдаг. Хэрэглэгчид ихэвчлэн системрүү орохын тулд хэрэглэгчийн нэр ба нууц үг оруулан нэвтрэх шаардлагатай байдаг. Харин Backdoor нь энэ үйл явцыг хийх шаардлагагүй болгодог. Зарим backdoor программыг асуудал шийдэхэд бүтээгдсэн байдаг боловч компьютерт нэмснээр халдагчид нууц үг шаардлагагүйгээр эсвэл мэдэгдэхгүйгээр систем рүү нэвтрэн ороход боломжтой болгодог. Backdoor нь шинэ программ суулгаснаар эсвэл оршин буй программыг өөрчилснөөр тухайн системрүү нэвтрэн орохоор хийгдсэн байдаг. Backdoor программ хангамжийг халдагч, virus эсвэл worm суулгасан байж болно.¹⁶²

5. Spyware
6. Keystroke loggers

Spyware нь virus, worm, эсвэл программ зөөвөрлөх(интернетээс программ суулгах, хор хөнөөлтэй цахим хуудас руу нэвтрэх) бусад арга ашиглан тархаж болдог. Үндсэн зорилго нь таны компьютер дээр юу хийж байгааг хянан өөр систем рүү мэдээлэх. Spyware нь таны юу бичиж байгаа, интернет дээр ямар цахим хуудас руу орж байгаа эсэх мөн ямар контент үзэж байгааг мэдээлэх боломжтой. Эдгээр нь банкны мэдээлэл, нууц үг мөн бусад нууц ба хувийн мэдээлэл орно. Adware мөн spyware нь интернет рүү мэдээлэл илгээснээр таны компьютерыг доголдуулах боломжтой.

161 European Network and Information Security Agency (ENISA), Malicious software: train the trainer reference guide, 2010, p.14.

162 European Network and Information Security Agency (ENISA), Malicious software: train the trainer reference guide, 2010, p.16.

Keystroke loggers нь хэрэглэгчийн keyboard дээр бичиж байгаа бүх зүйлсийг бичиж авдаг программ хангамж эсвэл техник хангамж юм.¹⁶³

7. Botnets

8. Rootkits

Botnet нь “робот сүлжээнүүд” гэсэн үг ба хор хөнөөлт программ хангамжийн шинэ хувьсал бөгөөд өргөн тархсан байдаг. Botnet нь бусад компьютерт халддаг программ хангамжаас (zombie эсвэл robot гэж нэрлэдэг) бүрддэг ба алсын зайны системээр удирдаж болдог. Эдгээр botnet-ийг олон төрлийн даалгавар гүйцэтгэхэд ашигладаг ба хэрэглэгчийн компьютерт халдаж буй программ нь алсын зайны системээс юу хийх талаар зааварчилгаа авах хүртлээ хүлээдэг аж. Алсын зайны систем нь халдварт өртсөн системээс мэдээлэл цуглуулах эсвэл олсон компьютерт халдах гэсэн зааварчилгаа өгөх боломжтой. Зарим botnet нүүд нь олон сая системээс бүрдсэн байдаг.

Rootkit нь халдагч эсвэл довтлогчийг илрүүлэлтээс нуугдахад тусалдаг программ хангамжийн цуглуулга юм. Тэдгээр нь файл нуух, системд халдагч байгааг нуун дарагдуулах эсвэл болж буй ямарваа нэгэн үйл явдлыг нуун дарагдуулдаг. Rootkit нь холимог хэрэгслүүд ба эдгээрт backdoors, keyloggers ба халдагч хэрэгтэй гэж бодсон бусад хэрэгслүүд ордог.¹⁶⁴

Хор хөнөөлт программ хангамж гэх ойлголтыг нэг мөр болгож албан ёсны хуулийн тайлбар шаардлагатай байна. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбарт нянтай программ гэсэн нэр томьёог тайлбарласан боловч хор хөнөөлт программ хангамж гэсэн нэр томьёотой холбоотой тайлбар байхгүй байна. Мөн 2002 оны Эрүүгийн хуульд заасан нянтай программ гэх нэр томьёо дутагдалтай байсан ба хор хөнөөлт программ нь өөрөө өргөн хүрээтэй ойлголт буюу хор хөнөөлт программ хангамжийн төрөл дотор нян хамаардаг байна. Тиймээс хор хөнөөлт программ хангамж гэх нэр томьёог өмнөх 2002 оны эрүүгийн хуульд заасан нянтай программ гэх нэр томьёоноос өргөн хүрээнд авч үзэж, ойлгох нь зүйтэй.

2. “Галт зэвсэг, галт хэрэгсэл” гэх нэр томьёоны тухайд

“Галт зэвсэг” гэх нэр томьёог хэл шинжлэлийн үүднээс “дарь, шатагч хольц, хийн даралтын хүчийг ашигласан зэвсэг” гэж тодорхойлсон¹⁶⁵ бол “Галт хэрэгсэл” гэх нэр томьёог “гранат, дэлбэлэх цэнэг, мина, тийрэлтэт сум гэх мэт зүйл” гэж тайлбарласан¹⁶⁶ байна.

Хууль зүйн талаас: 2002 оны Эрүүгийн хуульд галт зэвсэг болон галт хэрэгсэл гэх нэр томьёог 56 дугаар зүйлийн 56.1.9, 179 дүгээр зүйлийн 179.1, 185 дугаар зүйл, 186 дугаар зүйл, 187 дугаар зүйл, 188 дугаар зүйл, 281 дүгээр зүйл, 282 дугаар зүйл, 283 дугаар зүйлд тус нэр томьёо тусгагдсан байна. Мөн 2010 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн Улсын Дээд шүүхийн дугаар 14 “Эрүүгийн хуулийн

163 European Network and Information Security Agency (ENISA), Malicious software: train the trainer reference guide, 2010, p.17.

164 European Network and Information Security Agency (ENISA), Malicious software: train the trainer reference guide, 2010, p.18.

165 Монгол хэлний их тайлбар толь, <https://mongoltoli.mn/search.php?opt=1&word=%D0%B3%D0%B0%D0%BB%D1%82+%D0%B7%D1%8D%D0%B2%D1%81%D1%8D%D0%B3>.

166 Монгол хэлний их тайлбар толь, <https://mongoltoli.mn/search.php?opt=1&word=%D0%B3%D0%B0%D0%BB%D1%82+%D1%85%D1%8D%D1%80%D1%8D%D0%B3%D1%81%D1%8D%D0%BB>.

21 дүгээр бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” тогтоолд “Хуулийн 185, 186, 187, 188 дугаар зүйлүүдэд заасан “галт зэвсэг /ангийн буунаас бусад/...” гэдгийг Галт зэвсгийн тухайн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д зааснаар ойлгоно. Дээрх зүйлүүдэд заасан “...байлдааны галт хэрэгсэл...” гэж ангийн буунаас бусад буунд хэрэглэдэг бүх төрлийн сумнууд, тийрэлт, шидэлтийн хүчээр байнд хүрч дэлбэрэлтийн хүчээр байг устгах зориулалт бүхий зэвсгийн зүйлсийг хэлнэ.” гэж тодорхойлсон. 2015 оны Эрүүгийн хуульд галт зэвсэг болон галт хэрэгсэл гэх нэр томъёог 4.1 дүгээр зүйл, 7.5 дугаар зүйл, 11.1 дүгээр зүйл, 18.5 дугаар зүйл, 19.7 дугаар зүйл, 20.3 дугаар зүйл, 20.4 дүгээр зүйл, 20.5 дугаар зүйл, 20.6 дугаар зүйл, 23.1 дүгээр зүйл, 29.8 дугаар зүйл, 29.9 дүгээр зүйлд тусган хуульчилсан байна. Үүнээс гадна 2015 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн “Галт зэвсгийн тухай” хуульд “галт зэвсэг гэдгийг даринь шаталтаас үүссэн өндөр даралтын хүчээр сумны хошуу болон үрэл гол төмрөөс шидэгдэж амьд болон бусад биетийг гэмтээх, хөнөөх, устгах зориулалт бүхий буудлагын хэрэгслийг;” гэж тайлбарласан байна.

2002 оны Эрүүгийн хуулийн тайлбарт “Галт зэвсэг” гэдэгт дарьны тэсрэлт болон бусад цэнэгээс хүч авч байг тодорхой зайд сумаар онох зориулалттай хийгдсэн зэвсгийг ойлгоно. Түүнд хууль тогтоогч ангийн буунаас бусад албаны болон байлдааны бүх төрлийн зэвсгийг хамааруулжээ” гэж тодорхойлсон байна. Мөн үүнд галт хэрэгсэл гэх нэр томъёоны тодорхойлолт ороогүй байх ба харин байлдааны галт хэрэгсэл гэх нэр томъёог тайлбарлажээ. “Байлдааны галт хэрэгсэл” гэдэгт ангийн буунаас бусад буунд хэрэглэдэг бүх төрлийн сумнууд тийрэлт, шидэлтийн хүчээр байндаа хүрч дэлбэрэлтийн хүчээр байгаа устгах зориулалт бүхий эх бууны сум, нисэх онгоцны бөмбөг, явган цэргийн болон танк эсэргүүцэх гранат, байлдааны пуужин, цэргийн инженерийн болон явган цэргийн мина зэрэг галт зэвсгээр буудахад хэрэглэдэг бусад зүйлүүд орно. Мөн гадны хүчин зүйлийн үйлчлэлээр тодорхой нөхцөлд тэсрэлт үүсэх шинж чанар бүхий мина, торпед зэргийг ч энэ ойлголтонд хамааруулж ойлгож болно” гэх байдлаар тайлбарласан байна¹⁶⁷.

Монгол Улсын эрх зүйн толь бичигт галт зэвсгийн талаар тодорхойлсон ч гэсэн галт хэрэгсэл гэх нэр томъёоны талаар огт тодорхойлолт өгөөгүй байна. Академич С.Нарангэрэлийн толь бичигт галт зэвсэг гэдгийг (англ. firearm; ор. Огнестрельное оружие) даринь шаталтын хийн даралтаар сумны хошуу буюу үрлийг гол төмрөөр их хурдтай гаргаснаар сумны хошуу нь хүний амь бие, эрүүл мэндэд хохирол учруулах, ан агнах бусад зүйлийг хөнөөх чадвар бүхий хэрэгсэл гэж тодорхойлжээ¹⁶⁸. Харин гадны эрх зүйн толь бичигт галт зэвсэг гэдгийг “буу болон бууны төрлийн буудахад зориулагдсан зүйлс¹⁶⁹”, “Дарьны үйлчлэлээр сумыг урагш түлхэх хэрэгсэл¹⁷⁰” гэж тус тус тодорхойлсон бол галт хэрэгслийг “холбооны хуулиар сум нь ямар ч галт зэвсэгт ашиглах зориулалттай сумны хайрцаг, гал авалцуулах хэрэгсэл, сум эсвэл дэлбэрэгч нунтаг юм. Холбооны хуулиар «хуяг цоолох сум» үйлдвэрлэх, борлуулахыг хориглодог¹⁷¹” гэж тодорхойлсон байна.

167 Монгол Улсын Дээд шүүх, Ханнс-Зайделийн сан, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, 2013, 476 дахь тал.

168 С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, 2007, 128 дахь тал.

169 Bloomsbury, Dictionary of law fifth edition, 2007, p.112.

170 Black's law dictionary: revised fourth edition, west publishing co, 1968, p.761.

171 US Legal dictionary, <https://definitions.uslegal.com/a/ammunition/>.

Дээрхээс үзвэл хууль зүйн хувьд галт зэвсэг гэх нэр томьёоны талаар олон төрлийн тодорхойлолт байдаг бөгөөд ерөнхийдөө төстэй байна. Харин галт хэрэгсэл гэх нэр томьёоны талаар хууль зүйн тодорхойлолт төдийлөн байдаггүй байна.

Техникийн шинжлэх ухааны үүднээс: Галт зэвсэг судлалын үүднээс галт зэвсэг гэдгийг “гол төмөр болон дарьны шаталтын үйлчлэлээр сумыг түлхэх зориулалт бүхий хэрэгсэл. Мөн үүнийг “зэвсэг, буу, гар буу, урт буу, револьвер гэх” гэж тодорхойлсон байна. Харин галт хэрэгсэл гэдгийг “нэг буюу хэд хэдэн хонгио, дэлбэлэг, сумаас бүрдсэн хайрцаг, багцыг ойлгоно. Гурван үндсэн төрөл нь rimfire, centerfire, shothell юм.¹⁷²” гэж тодорхойлсон байна.

Галт зэвсгийн дараах төрлүүд байдаг гэж нийтлэгээр үздэг байна.

- Гар буу(1 удаагийн буудалттай болон хагас автомат)
- Револьвер(дугуй хэлбэрийн цэнэглэх дайзтай)
- 1 удаагийн буудлагатай урт галт зэвсэг(задардаггүй)
- Задардаг галт зэвсэг (жишээ нь смүтбор, винтов буюу рифл, хосолсон, богино болон урт галт зэвсэг)
- Давтаж бууддаг галт зэвсэг (смүтбор, винтов буюу рифл)
- Хагас автомат урт галт зэвсэг (смүтбор, винтов буюу рифл)
- Бүрэн автомат галт зэвсэг (Довтолгооны винтов буюу рифл, мачин ган, үтэн автомат гар буу)
- Хошуугаар цэнэглэх галт зэвсэг¹⁷³ гэх мэт.

Мөн дараах галт хэрэгсэл байдаг гэж нийтлэг байдлаар үздэг байна.

- Гэр(гууль, никель эсвэл гангаар хийгдсэн гэр)
- Тэсрэх бодисыг асаахад ашигладаг цохилтот нунтаг эсвэл нэгдэл агуулсан таг, хоолой, хавтан
- Дарь/шатагч бодис(Бууны дарь)
- Бууны сум¹⁷⁴

Шүүх баллистикийн хувьд дараах судалгааны объектууд байдаг гэж үздэг. Энэхүү объектууд нь галт зэвсэг болон галт хэрэгслийг агуулсан ойлголт байна.

Бага оврын гар ажиллагаатай, хагас болон бүрэн автомат загварын галт зэвсгүүд; (Винтов, карабин, гар буу, револьвер, ангийн буу, автомат АКМ, ПМ), мөн түүнчлэн гар хийцийн болон засварласан галт зэвсгүүд г.м

Сум хэрэгсэл: (сум, хонгио, хушуу, үрэл, бялт, дарь, жийргэвч г.м)

Сум болон тэсрэх бодис хийхэд хэрэглэсэн багаж, хэрэгсэл (хошуу, үрэл, хавчаар г.м)¹⁷⁵

172 Tn Courts: Firearm definition, https://www.tncourts.gov/sites/default/files/docs/firearmshandout_1.pdf.

173 Table 1: types of firearms ,Updated 7 January 2021, <https://www.gov.uk/government/publications/deactivated-firearms-implementing-regulation-eu-20152403/table-1-types-of-firearms>.

174 Gunvault:Types of Ammunition, <https://gunvault.com/types-of-ammunition/>.

175 Б.Баяр, Криминалистик, 2014, 224 дэх тал.

Дээрхээс үзвэл галт зэвсэг болон галт хэрэгсэл гэх нэр томьёонууд нь дотроо олон төрлүүдтэй нарийн тодорхойлогдсон техникийн ойлголт болох нь харагдаж байна.

Эцэст нь дүгнэвэл Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан “галт зэвсэг” гэх тодорхойлолт нь галт зэвсэг судлалын зүгээс тодорхойлбол ач холбогдолтой, нийцсэн тайлбар болох нь харагдаж байна. Харин галт хэрэгсэл гэх нэр томьёоны тухайд түүнийг хэрхэн ойлгох талаар ямар нэгэн хууль зүйн тайлбар төдийлөн байдаггүй нь ажиглагдлаа. Тиймээс галт зэвсэг судлалын үүднээс галт хэрэгслийг тодорхойлсон тайлбарыг судлаж түүний дагуу тайлбарлаж, ойлгох нь зүйтэй байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга буюу одоогийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулийн бусад шинжлэх ухааны нэр томьёо агуулагдсан зохицуулалтыг нэг мөр ойлгох, хэрэгжүүлэхэд болон дээр дурдагдсан шалтгаануудын улмаас Эрүүгийн хуулийн бусад шинжлэх ухааны нэр томьёог судлах хэрэгцээ, шаардлагаар тухайн судалгааг хийсэн билээ. Ингэж судлахдаа Эрүүгийн хууль дахь эдийн засгийн шинжлэх ухааны нэр томьёо, байгалийн шинжлэх ухааны нэр томьёо, нийгмийн шинжлэх ухааны нэр томьёо, анагаахын шинжлэх ухааны нэр томьёо, хүн ам зүйн шинжлэх ухааны нэр томьёо, сэтгэл зүйн шинжлэх ухааны нэр томьёо, техникийн шинжлэх ухааны нэр томьёонуудаас тус тус хоёр нэр томьёог сонгон судалсан юм. Тус сонгосон нэр томьёонуудын хувьд судалгааны явцад ойлголтыг нэр мөр болгох, ойлголтыг нэг мөр болгон хуульчлах, давхардал, хийдлийг арилгах ёстой, хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж буй дараах асуудлууд байна. Мөн энэхүү асуудлуудыг шийдвэрлэх арга замуудыг хамтад нь авч үзье.

- “Мөнгө угаах” гэх нэр томьёо нь Монгол Улсын Эрүүгийн хуульд зохицуулсан болон хэрэглэж байгаа байдлын хувьд явцуу байдлаар тодорхойлогдож байна. Тиймээс энэхүү нэр томьёог өргөн хүрээнд, ноцтой гэмт хэргийн хувьд, гэмт хэргийн бүлэглэл үйлдсэн тохиолдолд гэх байдлаар өргөн хүрээнд ойлгож, тодорхойлох нь зүйтэй.
- “Валют” гэх нэр томьёоны хувьд эдийн засгийн шинжлэх ухаанд хууль зүйн шинжлэх ухаанд тодорхойлсноос илүү өргөн хүрээнд нарийвчилж тодорхойлсон байна. Мөн ойрын үед криптовалютыг валют гэж тооцох талаар туршлага ихээхэн болж буй тул дээрх зүйлүүдийг харгалзан тус нэр томьёог ойлгож, тодорхойлох нь зүйтэй.
- “Гойд ашиг шимт мал” гэх нэр томьёоны тухайд гойд ашиг шимт малыг шалгаруулах үйл ажиллагаа тогтмол хийгддэггүй байна. Үүний улмаас улмаас гойд ашиг шимт малын нийт малын дунд эзлэх хувийн жин бага байх, тухайн асуудлын улмаас зохицуулалт нь хуулийн үзэл баримтлалд нийцээгүй байх буюу мөн цөм сүргийг тухайн хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчлаагүй байх, хурдны чиглэлийн адуу гойд ашиг шимт малд хамаарагдахгүй байх гэх мэт хэрэгжилтийн үр дагавартай холбоотой асуудлууд бий болоод байна. Түүнчлэн практикт ажиллаж буй хууль сахиулагч буюу цагдаагийн алба хаагчдын хувьд тухайн эрх зүйн зохицуулалтыг хэрэглэхдээ нэг утгаар ойлгодоггүй буюу гойд ашиг шимт мал шалгаруулах журмыг мэдэхгүй байгаагаас гойд ашиг шимт мал бусад малаас юугаараа онцлог давуу талтай болохыг нарийн тодорхойлохгүй байх гэх мэт дутагдлуудыг бий болгож байна.
- “Тусгай хамгаалалттай газар” гэх нэр томьёоны хувьд Эрүүгийн хуульд болон Газрын тухай хуульд өөр өөр байдлаар тодорхойлогдсон байна. Тиймээс “Тусгай хамгаалалттай газар”, “Тусгай хамгаалалттай газар нутаг” хэмээн хууль тогтоомжид ялгаатай нэр томьёо хэрэглэснийг нэг мөр болгох шаардлагатай байна. Мөн орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газар нутгийг Эрүүгийн хуулийн тус нэр томьёонд хамаарах эсэхийг тогтоох шаардлагатай байна.

- “Төрийн нууц” гэх нэр томьёо нь зөрчил, давхардал, хийдэлгүй хэдий ч Эрүүгийн хуульд ашигласан “итгэмжлэгдэн хариуцсан” гэх нэр томьёо нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн зохицуулалттай зөрчилдөж байна. Тиймээс энэхүү зөрчлийг нэг мөр болгож шийдвэрлэх хэрэгтэй байна.
- “Садар самуун” гэх Монгол улсын Садар самуунтай тэмцэх тухай хуулийн 3.1.1-т «садар самууныг сурталчлах» гэж бэлгийн дур хүслийг өдөөх зорилгоор хурьцал үйлдэхийг болон хүний бэлэг эрхтнийг илтээр хэвлэл, ном зохиол, кино, дүрс, дуу авианы бичлэг болон бусад хэлбэрээр уншуулах, сонсгох, үзүүлэхийг гэж заасан нь дутмаг тодорхойлолт гэж үзэж байна. Садар самуун гэсэн ойлголтыг судлаачид өөр өөрөөр тайлбарласан байгаа нь садар самуун гэж юуг ойлгож байгааг тайлбарласан тогтсон нэг ойлголтод хүрч чадаагүй байгааг харуулж байна. Мөн эрүүгийн хуульд байх тус “садар самуун” гэх нэр томьёог гадаад улсуудад өөр нэр томьёогоор тодорхойлж зохицуулж байна. Тиймээс тус ойлголтыг нийтлэг байдлаар ойлгож буй тодорхойлолтод тулгуурлан ойлгож, тодорхойлох шаардлагатай байна.
- “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис” гэх нэр томьёоны хувьд тус нэр томьёог хууль зүйн шинжлэх ухааны хувьд олон эрх зүйн зохицуулалтаар зохицуулж тайлбарласнаас гадна анагаахын шинжлэх ухааны зүгээс мөн тайлбар өгсөн байна. Олон улсын эрх зүйн баримт бичиг болон анагаахын шинжлэх ухааны хувьд “мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис” гэх нэр томьёог нэг байдлаар биш тусад нь салгаж ойлгож, зохицуулж байгаа нь харагдаж байна. Учир нь мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөт бодис хоёр нь хэрэглэгдэх байдал, зориулалт, үйлчлэл, эрх зүйн зохицуулалт, хяналт, үр дагавар зэргээр хоорондоо ялгаатай. Үүнийг олон улсын эрх зүйн баримт бичиг болон анагаахын шинжлэх ухааны зүгээс тогтоож, зохицуулсан байна. Тиймээс “мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодис” гэх нэр томьёог салгаж мансууруулах эм болон сэтгэцэд нөлөөт гэсэн утгаар нь ойлгож, зохицуулах нь зүйтэй.
- “Халдварт өвчин” гэх нэр томьёоны хувьд “халдварт өвчин”, “бэлгийн замын халдварт өвчин” гэх нэр томьёонуудыг хууль болон бусад эрх зүйн актад тайлбарлаагүй байх тул анагаахын шинжлэх ухаанд уг тодорхойлолт нийцэж буй эсэхийг тогтоох боломжгүй байна. Ийнхүү хууль болон эрх зүйн актад тодорхойлоогүй байгаа нь одоогоор практикт асуудалгүй мэт боловч цаашид шинэ төрлийн халдварт өвчнүүд гарч буй үед хариу арга хэмжээ авах, эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашгийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зэрэг олон үйл ажиллагаанд тодорхойгүй байдал бий болгох эрсдэлтэй юм. Иймд халдварт өвчин гэж ямар өвчнийг ойлгох тухай, ямар өвчнүүд багтах, тухайн өвчнүүдийг ангилан авч үзэж тодорхойлсон эрх зүйн акт, албан ёсны тайлбар гаргах шаардлагатай байна.
- “Орон байр” гэх нэр томьёоны тухайд Монгол Улсын Эрүүгийн хуульд аутентик тайлбараар тоочсон байдлаар тайлбарлаж зохицуулсан. Тайлбарласан эрдэм, шинжилгээний бүтээлүүд буюу онол болон гадаад улсуудын эрх зүйн зохицуулалтуудад тоочсон, ерөнхий байдлаар зохицуулсан янз бүр байна. Орон байр гэх нэр томьёо нь нийгмийн шинжлэх ухааны талаас онолын хувьд тайлбарлагдах ойлголт учир тухайн

- нэр томьёог тоочсон байдлаар бус ерөнхий байдлаар зохицуулж онолын дагуу ойлгох нь зүйтэй байна.
- “Гэр бүлийн таагүй орчин” гэх нэр томьёог хууль, эрх зүйн акт болон албан ёсны тайлбарт огт тайлбарлаагүйгээр зогсохгүй онолын түвшинд ч тодорхой тайлбарласан зүйл үгүй байна. Мөн түүнчлэн онолын тодорхойлолтууд хоорондоо агуулгын хувьд тааламжгүй, сөрөг гэх утга бүхий ижил төстэй байгаа ч зарим судлаач хэт дэлгэрэнгүй тайлбарласан байна. Ийнхүү нэгдсэн буюу албан ёсны тайлбар байхгүй байгаа нь уг нэр томьёог практикт нэг мөр ойлгож эрүүгийн хуулийг хэрэглэхэд сөрөг үр дагавар бий болгох эрсдэлтэй. Ийм учир Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар уг нэр томьёог тайлбарлах эсхүл УДШ албан ёсны тайлбар гаргах шаардлагатай байна.
 - “Сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан” гэх нэр томьёо нь сэтгэц мэдрэлийн буюу сэтгэл зүйн шинжлэх ухааны үүднээс тайлбарлавал “сэтгэцийн өвчин” гэх нэр томьёонд хамаарах ойлголт болох нь харагдаж байна. Учир нь сэтгэц мэдрэлийн буюу сэтгэл зүйн шинжлэх ухааны үүднээс сэтгэцийн тус эмгэгийг сэтгэцийн өвчинд хамаарна хэмээн тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл тус нэр томьёонууд нь хоорондоо давхардлыг бий болгож байгаа нь харагдаж байна. Тиймээс тус нэр томьёоны давхардлыг “сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан” гэх нэр томьёог “сэтгэцийн өвчин” гэх нэр томьёонд шингээн давхардлыг арилгах нь зүйтэй юм.
 - “Дураараа аашлах” (arbitrariness) хэмээх ойлголт нь эрх, хууль ёсны ямар нэг үндэслэлгүйгээр эрх мэдлийг өөрийн хүслээр хэтрүүлэх гэсэн агуулгатай байна. Харин манай улсын Эрүүгийн эрх зүйд дураараа аашлах хэмээх ойлголт нь өөрт хууль тогтоомжоор олгогдсон эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын эрх эрх чөлөөнд халдсан, эрх байхгүй боловч ийм эрх байх ёстой гэж бодит байдлыг андууран итгэж хуулиар тогтоосон журмыг зөрчих агуулгатай бөгөөд энэ утгаараа хэрэглэгдэн нэгэнт тогтсон уламжлалтай байжээ. Гэтэл энэ уламжлалт ойлголтыг мөн урьд нь тогтсон байсан өөр ойлголтоор буюу эрх мэдлээ хэтрүүлэхтэй сольж өөрчилсөн байна. Энэ нь манай улсын Эрүүгийн эрх зүйн уламжлалд харш, нийцэхгүй зохицуулалт болжээ.
 - “Хор хөнөөлт программ хангамж” гэх нэр томьёоны хувьд хор хөнөөлт программ нь өөрөө өргөн хүрээтэй ойлголт буюу хор хөнөөлт программ хангамжийн төрөл дотор өмнөх хуульд тодорхойлсон нянтай программ хамаардаг байна. Тиймээс хор хөнөөлт программ хангамж гэх нэр томьёог өмнөх 2002 оны эрүүгийн хуульд заасан нянтай программ гэх нэр томьёоноос өргөн хүрээнд авч үзэж, ойлгох нь зүйтэй.
 - “Галт зэвсэг, галт хэрэгсэл” гэх нэр томьёоны тухайд Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан “галт зэвсэг” гэх тодорхойлолт нь галт зэвсэг судлалын зүгээс тодорхойлбол ач холбогдолтой, нийцсэн тайлбар болох нь харагдаж байна. Харин галт хэрэгсэл гэх нэр томьёоны тухайд түүнийг хэрхэн ойлгох талаар ямар нэгэн хууль зүйн тайлбар төдийлөн байдаггүй нь ажиглагдлаа. Тиймээс галт зэвсэг судлалын үүднээс галт хэрэгслийг тодорхойлсон тайлбарыг судлаж түүний дагуу тайлбарлаж, ойлгох нь зүйтэй байна.

Эцэст нь дүгнэвэл, 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад тусгагдсан дээрх нэр томъёоны хувьд ойлголтын дутмаг, зөрүүтэй байдал, давхардал, зөрчил, хийдэл гэх мэт асуудлууд бий болж байгаа нь харагдаж байна. Тиймээс дээрх асуудлуудыг шийдвэрлэх нь шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

I. Монгол хэл дээрх эх сурвалж

Хууль тогтоомж:

1. Эрүүгийн хууль, 2015.
2. Эрүүгийн хууль, 2002.
3. Хууль тогтоомжийн тухай хууль, 2015.
4. Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн дугаар 2021/ШЦТ/584 тогтоол, 2021.08.24, МУШШЦСан.
5. Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн дугаар 2021/ШЦТ/457 тогтоол, 2021.08.05, МУШШЦСан.
6. Валют зохицуулалтын талаар эрх зүйн актууд.
7. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, 1994.
8. Газрын тухай хууль, 2002.
9. Газрын тухай багц хуулийн төсөл, 2021.
10. Төрийн болон албаны нууцын тухай хууль, 2016.
11. Монгол улсын засгийн газрын тогтоол, дугаар 247, 2017.
12. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, 1998.
13. Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1990.
14. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, 2001.

Ном, өгүүлэл нийтлэл:

1. Т.В.Кашанина, Хууль зүйн техник, Орч. С.Гэрэлмаа, Д.Отгончимэг, Н.Тунгалаг, 2016.
2. Ж.Эрдэнэбулган, Хууль зүйн нэр томьёоны судалгаа, хэрэглээ сэдэвт улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, 2016.
3. Монгол банк, Дэлхийн банк, Эдийн засаг, санхүүгийн нэр томьёоны тайлбар толь, 2015.
4. Монгол хэлний их тайлбар толь.
5. Монгол Улсын Дээд шүүх, Ханнс-Зайделийн сан, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, 2013.
6. С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг, 2007.
7. С.Гантулга, Б.Энхболд, Эрүүгийн эрх зүй Тусгай анги сурах бичиг, 2018.
8. S.Narangerel, English-Mongolian jurisprudence dictionary, 2005.
9. ХЗДХЯ, С.Нарангэрэл, Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь, 2021.
10. Монголбанк, Валютын ханш Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан гарын авлага, 2020.
11. Виртуал хөрөнгө: Криптовалютын зохицуулалт, Хүртээмжтэй санхүү Дугаар 15, 2020.

12. Монгол банк, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажлын тайлан.
13. Т.Сэнгэдорж, С.Энхмэнд нар, Экологийн эрх зүй, газрын эрх зүй, 2015.
14. Глоб интернэшнл төв, Азийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Мэдээлэлтэй байх эрхийг хязгаарлаж буй хууль тогтоомжийн дүн шинжилгээ, 2019.
15. Т.Золбоо, Сургалтын эрүүгийн хууль, 2017.
16. Г.Совд, Н.Жанцан нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, 2000.
17. Н.Одонтуул, Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд хийсэн судалгаа, Гэмт явдалтай тэмцэх асуудал №01 (71), 2020.
18. Эрдэнэцэцэг, Комьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 2011.
19. Б.Баяр, Криминалистик, 2014.
20. Монгол Улсын Дээд Шүүхийн мэдээлэл, № 2, 1997.
21. Төрийн мэдээлэл эмхэтгэл, №03, 2018.
22. Монгол Улсын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр “Мал хулгайлах” гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, 2020.
23. Монсудар хэвлэлийн газар, Монгол хэлний тайлбар толь, 2018.
24. Карл Циммэр, Вирусын ертөнц, 2019.

II. Гадаад хэл дээрх эх сурвалж

1. Edward R. Raupp, Ph.D, Danna Vance Raupp, Dictionary of Economic Terms, Blue Impala Press, 2018
2. Rădulescu Dragoș Lucian, The Concept of Money Laundering in Global Economy, International Journal of Trade, Economics and Finance, Vol.1, No.4, December, 2010.
3. PH.Collin, Dictionary of law, 2004.
4. Edward Robert Raupp and Danna Vance Raupp, Dictionary of Economic term, 2018.
5. United States v. Adams, 2009.
6. Bloomsbury Publishing Plc, Dictionary of law, 2004.
7. European Network and Information Security Agency (ENISA), Malicious software: train the trainer reference guide, 2010.
8. Bloomsbury, Dictionary of law fifth edition, 2007.
9. Convention against Transnational Organized Crime, 2000.
10. Fatf standarts: Fatf 40 recommendations, 2003.
11. The Russian Law on state secrets, 1993.
12. Laws of the people's republic of china, on
13. Act on regulation and punishment of acts relating to child prostitution and child pornography, and the protection of children, act no. 52, 1999.

14. Criminal code, 1985.
15. Convention on narcotic drugs, 1961.
16. Convention on psychotropic substances, 1971.
17. German criminal code, 1998.
18. Korean criminal act, 2013.
19. Japanese penal code, 1907.
20. U.S. reports: katz v. united states, 389 u.s. 347 (1967).

III. Цахим эх сурвалж

Монгол хэлээр

1. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийн ажлын хэсэг хуралдаан, 2021.08.12.
2. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн сан.
3. Тусгай хамгаалалттай газар, <http://mpa.gov.mn/news/8856>.
4. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийн сан, <https://eic.mn/spalocal/index.php>.
5. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан:нийт малын тоо, 2020.
6. Х.Нямбаатар, Хурдан удмын адуу хулгайлсан бол хүндрүүлэх нөхцөл болно”, 2020, <https://www.polit.mn/a/77974>.
7. “С.Гантулга, Гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэг нуугдмал шинжтэй байгаа нь гэмт хэрэг давтан үйлдэгдэх шалтгаан болж байна” ярилцлага, ДХИС-ийн албан ёсны цахим хуудас, <https://www.uia.gov.mn/news-details/108>.
8. О.Өнөрцэцэг, Хүүхдийн гэмт хэргийн шалтгаан нөхцөл, өнөөгийн байдал, Шинэ толь №72, 2011.

Гадаад хэлээр:

1. Sanction scanner, What Are The Negative Effects of Money Laundering on The Economy?, <https://sanctionscanner.com/blog/negative-effects-of-money-laundering-on-the-economy-132>.
2. The free dictionary by Farlex, <https://legal-dictionary.thefreedictionary.com/Rate+of+exchange>.
3. <https://wwf.ru/en/regions/the-caucasus/development-of-system-of-especially-protected-natural-territories/>.
4. <https://www.macmillandictionary.com/dictionary/british/state-secret>.
5. <https://www.britannica.com/topic/pornography>.
6. Merriam-Webster legal dictionary, <https://www.merriam-webster.com/dictionary/narcotic>.
7. National cancer institution, Dictionary of cancer terms, <https://www.cancer.gov/publications/dictionaries/cancer-terms/def/narcotic>.

8. Pain medications – narcotics, <https://medlineplus.gov/ency/article/007489.htm>.
9. Good therapy, Most frequently prescribed psychotropic drugs, <https://www.goodtherapy.org/drugs/psychotropic-medication.html>.
10. Cambridge University Press, What is a mental/psychiatric disorder? 2010, <https://www.cambridge.org/core/journals/psychological-medicine/article/what-is-a-mental-psychiatric-disorder-from-dsmiv-to-dsmv/DC3CC7DA2C4507D8F0D3110392B219A9#>.
11. Black's law dictionary: revised fourth edition, 1968.
12. Courts: Firearm definition, https://www.tncourts.gov/sites/default/files/docs/firearmshandout_1.pdf.
13. Types of firearms, <https://www.gov.uk/government/publications/deactivated-firearms-implementing-regulation-eu-20152403/table-1-types-of-firearms>, 2021.
14. БНСУ-ын Засгийн газрын харьяа эрх зүйн практик мэдээллийн цахим хуудас, <https://m.easylaw.go.kr/MOM/SubCsmOvRetrieve.laf?langCd=700109&csmSeq=1598&ccfNo=1&cciNo=1&cnpClsNo=1>.
15. Oxford concise medical dictionary, www.oxfordreference.com.
16. Harvard Health Publishing, Medical Dictionary of Health Terms: D-I, <https://www.health.harvard.edu/d-through-i#I-terms>.
17. MedTerms Medical Dictionary A-Z, <https://www.medicinenet.com/infection/definition.htm>.
18. Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллагын ХДХВ, ДОХ-ын мэдээ, <https://www.who.int/news-room/fact-sheets/detail/hiv-aids>.
19. Federal Constitution of the Swiss Confederation, <https://fedlex.data.admin.ch/filestore/fedlex.data.admin.ch/eli/cc/1999/404/20210101/en/pdf-a/fedlex-data-admin-ch-eli-cc-1999-404-20210101-en-pdf-a.pdf>.

**ДӨРӨВ. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 17.12 ДУГААР ЗҮЙЛИЙН
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ
/МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГ/**

Судалгааг хянасан:	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн зөвлөх Хууль зүйн ухааны доктор (Ph.D) Р.Оюунбадам
Судалгааг удирдсан:	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Хууль зүйн ухааны доктор (Dr.Jur.) Х.Эрдэм-Ундрах
Судалгааны багийн бусад гишүүд:	Эрдэм шинжилгээний ахлах ажилтан (LL.M) Г.Халиунаа Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Х.Буянбат Эрдэм шинжилгээний ахлах ажилтан О.Энххүслэн

УДИРТГАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4-т “Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хуульт ёсыг бэхжүүлнэ.” хэмээн заагаад 4.4.7-д “Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно.” гэж, мөн УИХ-аас баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 77-д “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг 2021 онд боловсруулахаар тус тус заасан.

Эдгээр баримт бичигт үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайдаас тус хүрээлэнд 2021 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 1/195 тоот албан бичгээр Эрүүгийн хуулийн хэрэгжилтэд улирал бүр тогтмол дүн шинжилгээ хийж байхаар чиглэл өгсний дагуу Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд энэхүү хуулийн судалгааг улирал бүр тогтмол гүйцэтгэж байхаар тусгасан.

Энэхүү ажлын хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2021 оны II улиралд Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлд заасан “Мал хулгайлах” гэмт хэргийн зохицуулалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхээр зорьсон юм.

Малын хулгайтай тэмцэх төрийн эрүүгийн бодлогыг бататгах, Эрүүгийн хуулийг Үндсэн хуульд нийцүүлэх зорилгоор 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар мал хулгайлах гэмт хэргийн шинж, тухайн гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийг Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан ердийн хулгайн гэмт хэргээс тусад нь бие даасан гэмт хэрэг болгон тус хуулийн 17.12 дугаар зүйлд хуульчилсан.

Өнөөдрийн байдлаар Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлд 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар тус тус 2 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлснээс хойш 1 жилийн хугацаа өнгөрөхөд буюу 2018 онд мал хулгайлах гэмт хэрэг улсын хэмжээнд 1096 бүртгэгдсэн нь 2017 оноос 195 (21.6%)-аар өссөн байх¹ бөгөөд энэ нь улсын хэмжээнд үйлдэгдсэн нийт гэмт хэргийн гурван хувийг дангаараа эзэлж байлаа. Харин 2019 онд мөн өссөн дүн үзүүлж улсын хэмжээнд мал хулгайлах гэмт хэрэг 1809 буюу өмнөх оноос 20 орчим хувиар², 2020 онд 1041 буюу өмнөх оноос 11.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Иймд бид Эрүүгийн хуулийн тус зохицуулалтын хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гэмт хэргийн өсөлт, бууралтад нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлэх, мөн тулгарч буй хүндрэлтэй асуудлыг олж тогтоохыг зорьсон бөгөөд энэ хүрээнд шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн тухайн гэмт хэргийн талаарх тоон мэдээлэлд үндэслэн мөн холбогдох алба хаагч, мэргэжилтэнтэй ярилцлага хийх, алба хаагчдаас анкетын асуулга авах замаар уг гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийлээ.

1 Үндэсний статистикийн хороо, Гэмт хэргийн статистик 2018, 26 дахь тал.

2 Үндэсний статистикийн хороо, Гэмт хэргийн статистик 2019, 25 дахь тал.

НЭГ. МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ОНЦЛОГ

Манай эриний тооллын 8 дугаар зуунд монголын нутаг дээр оршин байсан эртний улсууд болох Түрэгийн эзэнт гүрэн Нирун (Жужан) улсын ял шийтгэлийн бодлогыг хэрэглэж мал хулгайлсан гэмт хэргийг бусад хулгайн гэмт хэргээс ялган хүнд гэж үзэж алах хүртэл ялыг оногдуулдаг байв. Харин 11 дүгээр зуунд Хамаг Монголын ханлиг нь морь болон тэмээ хулгайлсан үйлдлийг хүндээр шийтгэж алах ял оногдуулдаг байсан бол 13 дугаар зуунд Чингис хааны Их засаг хуулийн эрүүгийн цаазад адуу хулгайлсан хүн алах ялтай хэмээн онцгойлон заасан нь адууг өнөөгийн ойлголтоор стратегийн зэвсгийн хэмжээнд үзэж, хулгайлсан морь олдвоос тэр морийг уул эзэнд нь эргүүлэн өгөхдөө тэр морины адил зүсмийн есөн морины хамт олгож, хэрэв тийнхүү нэмж олгох хөрөнгөгүй бол оронд нь үр хүүхдийг нь авдаг, харин үр хүүхэд үгүй бол хонь адил алах тухай зааж мал хулгайлсан хүнийг харсан ч мэдсээр байж мэдээлээгүй бол гэмт хэрэг гэж үздэг байжээ. Мөн түүнчлэн боол бусдын малыг хулгайлсан бол ташуурдаж шийтгээд боолын эзнийг давхар шийтгэдэг байв. 1240 онд Өгэдэй хааны нэгэн зарлигт монголчуудын амьдралын эх үүсвэр болох хонь, адуу, үхрийг үндсэн хөрөнгө хэмээн дурдсан байдаг.³

Их Монгол Улсын үед Их Засаг хуулиар мал хулгайлах, тэр дундаа морь хулгайлахыг нарийн бөгөөд хатуу ялаар шийтгэхээр зохицуулж байжээ. Мал хулгайлах гэмт хэргийн санкц нь “есөөр торгох” гэх ял байсан ба мөн нүдийг нь ухах, гарыг нь тасчих гэх мэт бие эрхтнээс хагацаах ялыг оноохоор зохицуулжээ.

Юань улсын үед мал хулгайлах гэмт хэрэгтэй холбоотой зохицуулалтыг Их Засаг хууль зааснаас уламжлан авч илүү нарийвчилсан зохицуулалттайгаар хуульчилсан байна. Ял шийтгэлийн хувьд гэмт хэргийг хэд дэх удаа үйлдсэн эсэхээс хамааран хүндрүүлэхээр зохицуулсан байх бөгөөд дух, хүзүү зэрэг хүний биеийн ил харагдах хэсгүүдэд гэмт хэрэг үйлдсэн тухай бичиж шивэх, хамрыг огтлох, цаазлах ялаар шийтгэдэг байсан нь ялын цээрлүүлэх шинжийг чухалчилж байсныг харуулж байна.

Улс төрийн бутралын үеийн эх сурвалжуудад Алтан ханы цааз, Хутагтай сэцэн хунтайжийн шашны цааз, Халхын цааз эрхэмжийн бичиг буюу Халхын үйсэн дээр бичсэн цааз, Монгол Ойрадын Их Цаазуудад мал хулгайлах гэмт хэргийг өмнөх үеийн хуулиудаас дэлгэрэнгүй, ахуйн өвөрмөц байдалтай уялдуулсан нарийвчилсан зохицуулалтуудыг хийж байжээ. Мөн ялын хувьд зөвхөн “ес” болон бод малаар торгох ялаар шийтгэдэг байсан нь онцлог юм.

Манжийн эрхшээлийн үеийн хуулиудад мал хулгайлах гэмт хэргийн зохицуулалт улам боловсронгуй болж мал хулгайлах гэмт хэргийн тухай ойлголт, уг гэмт хэргийн субъектийн тухай ойлголтыг хуульчлан гэмт хэргийн материаллаг эрх зүйн хэм хэмжээг тодорхойлоод зогсохгүй уг гэмт хэргийг илрүүлэх процесс ажиллагааны тухай ч нарийвчлан зохицуулж байлаа. Ялын хувьд түүхийн өмнөх бүх үед байсан торгох ялыг халж ташуурдах, цөлөх, хөвчдөн алах гэсэн илүү хүнд ял шийтгэхээр зохицуулснаараа онцлог.

Олноо Өргөгдсөн Монгол Улсын эхний жилүүдэд тусгайлан эрх зүйн акт гаргаж мал хулгайлах гэмт хэргийн зохицуулалтыг өмнөх хуулиудын алах болон цөлөх ялыг өөр төрлийн хөнгөн ялаар буюу дөнгөлөх ялаар солих байдлаар ашиглаж байгаад Зарлигаар Тогтоосон Монгол Улсын Хууль Зүйлийн бичиг нь Монгол цаазын бичиг

3 И.М.Майский, Орчин үеийн монгол: Автономит монгол XX зууны гараан дээр, 1959, 36 дахь тал.

болон ялангуяа Гадаад Монголын Хууль Зүйлийн Бичгийн олон зохицуулалтаас ялын төрлийн хувьд ташуурдах, цөлөх, цаазлах ялыг хэмжээний хамт шууд авч хэрэглэсэн ч зарим талаар онцлог зохицуулалттай байжээ.

1921-1990 оны үед түүхийн өмнөх үеүд шиг мал хулгайлах гэмт хэргийг бие даасан гэмт хэрэг хэмээн үзэж тусгайлан зохицуулсангүй. Зөвхөн 1942 оны Эрүүгийн хуулийн 8-р бүлгийн эд хөрөнгийн эсрэг гэмт хэргийн тухай 173-р зүйлийн 4.5 дахь хэсэгт мал хулгайлсан хэргийг тусгайлан зааж байснаас бусдаар энэ үеийн эрүүгийн хуулиудад мал хулгайлах гэмт хэргийг бие даасан гэмт хэргийн хэмжээнд үзэж зохицуулж байсангүй.

Дээрхээс монголчууд мал хулгайлах гэмт хэрэгтэй урт хугацааны туршид тэмцсээр ирсэн нь харагдаж байна. Мал хулгайлах гэмт хэргийг зохицуулж ирсэн түүхэн уламжлалыг нэгтгэн дүгнэвээс, монгол нутаг дахь эртний улсуудын үеэс эхлэн мал хулгайлах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалт түүхийн урт хугацааны туршид хохирогчийн хохирлыг барагдуулах зорилготой торгох ялаас уг гэмт хэргийн материаллаг болоод процессын эрх зүйн зохицуулалтыг хуульчлах хүртэл хэмжээнд боловсронгуй болсоор 1921 он хүрчээ. Гэсэн хэдий ч 1921-1990 оны социалист эрх зүйн тогтолцооны үеийн Эрүүгийн хуулиудад мал хулгайлах гэмт хэргийг бие даасан гэмт хэргийн хэмжээнд үзэж, зохицуулж байгаагүй. 1992 оны Монгол Улсын Үндсэн Хуулийн Тавдугаар зүйлийн 5-д “Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна”⁴ хэмээн зааснаар тухайн үед хүчин төгөлдөр хэрэгжиж байсан Эрүүгийн хуульд холбогдох өөрчлөлтийг Үндсэн хуульд нийцүүлэх зорилгоор оруулсан.

Үндсэн хуулийн дээрх заалтын хүрээнд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, арга хэлбэр, энэ талаар төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулах зорилготой мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай”⁵ хуулийг мөн батлан хэрэгжүүлж байна.

Эрүүгийн бодлого нь Үндсэн хуулийн агуулгаас урган гарч, эрх зүйт төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэгийн хувьд Үндсэн Хуулийн Тавдугаар зүйлийн 5-д заасныг эрүүгийн бодлогод тусгах зайлшгүй шаардлагатай хэмээн үзсэний учир 1996 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр тухайн үеийн хүчин төгөлдөр хэрэгжиж байсан Эрүүгийн хуульд “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиар “Мал хулгайлах” гэмт хэргийн тухай бие даасан зүйл хэсэг бүхий 123¹ дүгээр зүйлийг нэмсэн. Үүнээс өмнө БНМАУ-ын 1942 оны Эрүүгийн хуульд мөн мал хулгайлах гэмт хэргийг бие даасан зүйлийн хэмжээнд тусгаж байсан түүхтэй.

2002 оны Эрүүгийн хуулиар мал хулгайлах гэмт хэргийг ердийн хулгайн гэмт хэргийн адилаар Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлд⁶ зааснаар зүйлчилж, олон тооны мал хулгайлсан тохиолдолд мөн зүйлийн 145.2 дахь хэсэгт зааснаар хүндрүүлэн зүйлчлэхээр хуульчилж, тухайн гэмт хэргийг үйлдсэн хүнд эд хөрөнгийг

4 Монгол Улсын Үндсэн Хуулийн дээрх заалтыг нэрт эрдэмтэн Г.Совд тэргүүтэй судлаачид “Монголын эдийн засаг, ард түмний аж амьдралын уламжлалт онцлог хэв шинж, хүн амын аж ахуй эрхлэн хөтлөх заншил зэрэг амьдралын өвөрмөц олон талт асуудлыг тусгасан заалт юм” хэмээн үзэж тайлбарласан байна.

5 Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №23 2004.

6 Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №5 2005.

хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар зааж байжээ.

Харин 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөн 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар мал хулгайлах гэмт хэргийн шинж, тухайн гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийг Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан ердийн хулгайн гэмт хэргээс тусад нь бие даасан гэмт хэрэг гэж үзэн 17.12 дугаар зүйлд хуульчилсан юм. Одоогийн байдлаар уг зүйлд 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн⁷, 2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн⁸ хуулиудаар тус тус нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Ийнхүү хуульчилсныг Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төслийн ажлын хэсгийн ахлагч УИХ-ын гишүүн Х.Нямбаатар "...малын хулгайтай тэмцэх төрийн эрүүгийн бодлогыг бататгаж өгсөн сайн талтай. Монгол Улсыг мал аж ахуйн орон гэж үздэг, мал сүрэг төрийн хамгаалалтад байна гэж Үндсэн хуульд заасантай уялдаад малын хулгайг бие даасан зүйл анги болгож зохицуулахаар болсон" хэмээн тайлбарлажээ.⁹

Мал хулгайлах гэмт хэргийн шинж, тухайн гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийг Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан хулгайлах гэмт хэргээс тусад нь бие даасан 17.12 дугаар зүйл болгож хуульчилсан нь шинэ гэмт хэрэг гэж үзэх эсэх дээр УДШ 2019 оны 03 дугаар сарын 29-ний №153 тогтоолдоо шинэ гэмт хэрэг хэмээн үзэхгүй гэсэн байх ба "...Учир нь "Олон тооны мал хулгайлах" гэсэн хулгайлах гэмт хэргийн хүндрүүлэх шинж нь 2002 оны Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.2 болон 2015 оны Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн аль алинд нь хуульчлагдсан бөгөөд 2015 оны Эрүүгийн хуульд олон тооны мал хулгайлсан үйлдэлд хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар хүндрүүлж өөрчилсөн байна." гэж тайлбарлажээ.

2002 оны Эрүүгийн хуулийн 145.1-д буюу гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнд бага бус хэмжээний хохирол учирсан байхыг шаарддаг байсан бол шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тодорхой хохирлыг зааж өгөлгүй, "Бусдын малыг хулгайлсан" хэмээн зөвхөн үйлдлийг үндсэн бүрэлдэхүүнд хуульчилжээ. Ингэснээр мал хулгайлах гэмт хэргийг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг байхаар хуульчлан тодорхойлсон юм.

Ийнхүү хэлбэрийн бүрэлдэхүүнтэйгээр хуульчилсан нь уг гэмт хэргийн объектод холбоотой бөгөөд Үндсэн хуульд "Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна"¹⁰ хэмээн заасан үндэсний эрх ашгийг гэмт халдлагаас хамгаалах зорилготой. Малыг үндэсний эрх ашиг хэмээн тодорхойлж объектод зааж өгсөн ч гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнд тодорхой малын тоог

7 Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, <https://www.legalinfo.mn/additional/details/3112?lawid=11634>.

8 Эрүүгийнхуульдөөрчлөлт оруулахтухай, <https://www.legalinfo.mn/additional/details/3679?lawid=11634>

9 Мал хулгайлсан л бол тоо харгалзахгүйгээр хорих ял эдлүүлэх хууль батлагдлаа (2020.01.24) <https://vip76.mn/content/65745>.

10 Монгол Улсын Үндсэн хууль, 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг.

буюу хохирлын хэмжээг заах боломжийг хязгаарлаагүй бөгөөд тийн зохицуулаагүй нь хууль тогтоогч энэ гэмт хэргийг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байхаар хуульчилж мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд өмнөх хуулийн зохицуулалтаас хүндрүүлэх бодлого баримталсныг харуулж байна.

Мал хулгайлах гэмт хэргийг хохирол үл шаардах хэлбэрийн бүрэлдэхүүнтэйгээр хуульчилсанд практик дахь нөхцөл байдал нөлөөлсөн байж болох юм.

ЦЕГ-аас 2010 онд гаргасан “Мал хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөл, анхаарах зарим асуудал” сэдэвт судалгааны ажлын тайланд өгүүлснээр тухайн үед дараах нөхцөл байдал тогтоогдож байжээ:

- Малын хулгайн гэмт хэрэг үйлдээд Эрүүгийн хуулийн 145.1 дэх хэсэгт зааснаар хөнгөн гэмт хэргээр зүйчлэгдэж, яллагдагчаар татагдсан этгээд нь хохирлоо барагдуулснаар хэрэг нь хэрэгсэхгүй болдог;
- 6 сарын дараа дахин мал хулгайлж баригдвал хохирогчдоос хулгайлсан малаа хэд дахин төлж хэрэгсэхгүй болдог.¹¹

Үүссэн нөхцөл байдлыг дүгнэн үзэж цагдаагийн байгууллагаас “энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хэргийг эвлэрсэн, хохирлоо бүрэн барагдуулсан үндэслэлээр хэрэгсэхгүй болгодоггүй байх хуулийн зохицуулалт бий болгох” тухай саналыг гаргаж байжээ.

Уг тайланг гаргасан 2010 оноос хойш мал хулгайлах гэмт хэргийн гаралт жил ирэх тусам, тасралтгүй өсөж байсан нь Үндэсний статистикийн хорооны Гэмт хэргийн статистикаас харагдаж байна.

График 4.1. Мал хулгайлан гэмт хэргийн 2009-2015 оны статистик мэдээ¹²



Дээрхээс үзвэл, 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлд мал хулгайлах гэмт хэргийг хуульчлахдаа хохирол үл шаардах, хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг байхаар хуульчилсан нь гэмт хэргийн аюулын шинж, хэр хэмжээ, тархац, шүүн таслах ажиллагааны практик, тухайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилт зэрэг олон хүчин зүйлийг харгалзан хийсэн шинжлэх ухааны үндэслэл бүхий зохицуулалт болжээ.

Мөн 2002 оны Эрүүгийн хуулийн 145.1-д санкцын хувьд торгох, албадан ажил хийлгэх, баривчлах гэсэн төрлүүдтэй байсан бол шинэ хуулиар нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих гэсэн ялын төрлүүдтэй байхаар хуульчилжээ. Ийнхүү торгох ялын оронд зорчих эрхийг хязгаарлах, хорих гэсэн

11 ЦЕГ, Монгол Улс дахь 2010 оны гэмт хэргийн байдал, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам, 2011, 142 дахь тал

12 Үндэсний статистикийн хороо, Гэмт хэргийн статистик, 2018, 26 дахь тал.

хүний эрх, эрх чөлөө, халдашгүй байдлыг хязгаарлахад чиглэсэн ял санкцид шинээр орж ирсэн нь дээр дурдсанчлан өмнөх хуулийн зохицуулалтыг хүндрүүлсэн гэж үзэх үндэслэлтэй.

Түүнчлэн ялын хэмжээний хувьд зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байгаа нь илүү хүндрүүлсэн байна. Энэ нь хуулийн үзэл баримтлалд дурдсан Эдийн засгийн гэмт хэрэг, Авлигын гэмт хэрэг, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт оногдуулах ялын бодлого хэт сул байгааг залруулж ялын бодлогыг чангатгах зорилгын хүрээнд ийнхүү зохицуулагдсан гэж үзэж болно.

2002 оны Эрүүгийн хуулийн 145.2-т олон тооны мал хулгайлсан тохиолдолд мөн зүйлийн 145.2 дахь хэсэгт зааснаар хүндрүүлэн зүйлчлэхээр хуульчилж, тухайн гэмт хэргийг үйлдсэн хүнд эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар хуульчилж байсан бол шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт бусдын олон тооны малыг хулгайлсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр хүндрүүлэх бүрэлдэхүүн болж хуульчлагджээ. Мөн санкцын хувьд сонгох бус, зөвхөн хорих ялыг зааж өгсөн.

Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг нь гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болохын хувьд үндсэн бүрэлдэхүүнээс хүнд ял оногдуулахаар заах нь зайлшгүй хэрэг билээ. Гэсэн ч хүндрүүлэн зохицуулахдаа хууль тогтоогч зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх ялын хэмжээг нэмэгдүүлэхийн оронд огт тусгалгүй орхиж, зөвхөн хорих ялаар шийтгэхээр заасан нь хорих ялаас харьцангуй хөнгөн ялын төрлүүдийг сонгох боломжгүй болгож, хуулийн үзэл баримтлалд дурдсан ялын бодлогыг чангатгах зарчимд нийцүүлсэн нь харагдаж байна.

2002 оны ЭХ-ийн 145 дугаар зүйлд хүндрүүлэх бүрэлдэхүүнд зааж байсан зохион байгуулалттай бүлэг үйлдсэн, хохирогчийг амьдралын эх үүсвэрээс нь салгасан буюу их хэмжээний хохирол учирсан, гамшгийг далимдуулж үйлдсэн байх, булаах, дээрэмдэх, уулгалан довтлох гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд, онц аюултай гэмт хэрэгтэн, гэмт бүлэглэл үйлдсэн, энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан байх гэсэн шинжүүдийг шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд тусгаагүй юм. Эдгээр шинжүүд нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн хувьд ач холбогдолгүй болсон, нийтлэг байдлаар хулгайлах гэмт хэргийн хүндрүүлэх шинжийг хамт заасан зэрэг нь учир дутагдалтай байх бөгөөд мал хулгайлах гэмт хэргийг бие даасан гэмт хэрэг байдлаар хуульчлахад уг гэмт хэргийн бүрэлдэхүүнд зөвхөн тухайн гэмт хэргийн онцлог шинж, практик болон бусад судалгаагаар тогтоогдсон шинжүүдийг бүрэлдэхүүнд хуульчлах шаардлагатай байсан гэж үзэж байна.

Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон”, “зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн” гэх шинжүүдийг онц хүндрүүлэх шинж болгон хуульчилсан байх ба санкцын хувьд зөвхөн хорих ялаар шийтгэхээр зааж өмнөх хэсгээс ялын хэмжээг нэмэгдүүлэн таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар тогтоосон.

ЦЕГ-аас гаргасан “Мал хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөл, анхаарах зарим асуудал сэдэвт” судалгааны ажлын тайланд өгүүлснээр тухайн үед дараах нөхцөл байдал тогтоогдсон байна¹³:

- Бүлэг зохион байгууллалтын хэлбэрт шилжиж, гэмт хэргийн бүлэглэлийг бий болгож, мал, мах, түүхий эдийн гарал үүслийн гэрчилгээг хуурамчаар үйлдэх;
- Гэмт хэрэг үйлдэх үедээ автомашин, галт зэвсэг ашиглаж газар орны байдлыг судлан машинтай явж хулгайлах, малын бэлчээрт хүрч зарим хэсэг нь малыг тууварлах;
- Хулгайлсан мал, мах, түүхий эдээ борлуулах ченжийг урьдаас судалж тогтоох, мөнгийг урьдчилан авах, хулгайлсан зүйлээ хаана, хэзээ уулзаж өгөх зэргээр үгсэн тохиролцож гэмт хэрэг үйлддэг нарийн зохион байгуулалттай сүлжээнд орсон.

Дээрх байдлыг үнэлэн “Малын хулгайн гэмт хэрэг нь нууц далд зохион байгуулалттай бизнесийн хэлбэрт шилжиж хүмүүсийн амжиргааны орлогын эх үүсвэр болоход хүрсэн байна¹⁴” гэсэн дүгнэлтийг хийжээ.

Хууль тогтоогч Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон”, “зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн” гэх шинжүүдийг онц хүндрүүлэх шинж болгон хуульчилсан нь практикт судалгаанд тулгуурлан аюулын шинж, хэр хэмжээг харгалзан үзэж хуульчилсан зохицуулалт болжээ.

Мөн хуульд аутентик тайлбар буюу хуульчилсан тайлбар хийсэн нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн үзэл баримтлалын “Мөн хуулийг Улсын Дээд шүүхийн тогтоолоор тайлбарлаж, төсөөтэй хэрэглэдэг байдлыг эцэс болгож, зөвхөн хуулиар тайлбарладаг байх эсхүл хуулийн зүйл, заалт, хэсгийн доор хууль зүйн техник ашиглан бичих замаар хуулийн нэр томъёог тайлбарлан хэрэглэх боломжийг хуулийн төсөлд тусгана.” гэсэнд нийцүүлэн хуульчилсан байна.

Өмнө нь “мал”, “олон тооны мал” гэх ойлголтуудыг “Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай” УДШ-ийн 2006 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 28 дугаар тогтоолоор тайлбарлан хэрэглэж байсан юм. “Мал”, “олон тооны мал” гэх ойлголтуудыг ийнхүү хуульд тайлбарласнаар өмнөх хуулийн зохицуулалтаас илүү нарийвчилсан бөгөөд боловсронгуй болж мал хулгайлах гэмт хэргийг цогц байдлаар хуульчилж чадсан хэмээн үзэх үндэслэлтэй.

13 ЦЕГ, Монгол Улс дахь 2010 оны гэмт хэргийн байдал, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам, 2011, 135 дахь тал.

14 Мөн тэнд.

ХОЁР. МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ТООН МЭДЭЭЛЭЛД ХИЙСЭН АНАЛИЗ

Монгол Улсын Статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн¹⁵ 2.6.1.3-д “хүн ам, нийгмийн салбарын захиргааны статистикийн мэдээллийн хамрах хүрээ, чанар, захиргааны мэдээллийг албан ёсны статистикт ашиглах хэрэгцээг нэмэгдүүлэх”, 2.6.1.11-т “гэмт хэргийн олон улсын ангиллыг үндэсний онцлогт тохируулан боловсруулж, мөрдүүлэх” хэмээн тус тус заасныг хууль сахиулах, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагууд хэрэгжүүлэх үүрэгтэй. Тус хөтөлбөр өдгөө нэгэнт хэрэгжиж дууссан учир дараах үр дүнд хүрсэн байх ёстой. Үүнд:

1. Үндэсний статистикийн системийн байгууллага, нэгжийн гаргасан салбарын мэдээлэл, хөгжлийн бодлоготой уялдсан, хамралт, нарийвчлал, хүртээмж, чанар сайжирна.
2. Чиг үүргийн яамдын статистикийн чадавх сайжирч, мэдээллийн сан, ажилтнуудын дүн шинжилгээний чадварыг сайжруулснаар эдийн засгийн болон ядуурал, байгаль орны статистикийн дүн шинжилгээний ажил өргөжиж, илүү нарийвчилсан мэдээллээр хангагдана.
3. Харилцаа холбооны болон мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлснээр статистикийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, дамжуулах, тархаах, хадгалах үйл явц сайжирна.

Судалгааны энэ хэсэгт дараах байгууллагаас ирүүлсэн тоон мэдээлэл болон шүүхийн шийдвэрийн цахим сангаас түүвэрлэсэн шүүхийн шийдвэрт анализ хийв. Үүнд:¹⁶

- Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны статистик мэдээллийн хэлтсийн тайлан мэдээ;¹⁷
- Шүүхийн ерөнхий зөвлөлийн тайлан мэдээ;¹⁸
- Мал хулгайлах гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр;¹⁹
- Тус зүйл ангиар шийтгэгдсэн этгээдүүдийн талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас гаргасан дэлгэрэнгүй судалгаа²⁰ зэрэг болно.

Эдгээр байгууллагаас ирүүлсэн тоон мэдээлэлд анализ хийх нь дээр дурдсан хөтөлбөрийн хэрэгжилттэй холбогдох нь дамжиггүй бөгөөд тодорхой хэмжээнд үнэлэлт, дүгнэлт хийхийг зорилоо.

15 УИХ-ын 2017 оны 38 дугаар тогтоолоор баталсан, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №26.

16 Эдгээр мэдээллийг судалгааны хүрээнд 2021 оны 6 дугаар сард холбогдох байгууллагуудаас гаргуулан авсан болно.

17 2017 оны 7 сарын 1-нээс 2021 оны 5 сарын 31-ний өдөр хүртэлх хугацааны мал хулгайлах гэмт хэргийн талаар дэлгэрэнгүй судалгаа.

18 Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр “Мал хулгайлах” гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн талаарх 2020 оны дэлгэрэнгүй мэдээлэл.

19 Шүүхийн шийдвэрийн цахим сан дахь 2017 оны 7 сарын 1-нээс 2021 оны 6 сарын 20 хүртэлх хугацаанд анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн шүүхийн шийдвэрүүд.

20 Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.12 дугаар зүйл ангиар шийтгэгдсэн хоригдол болон хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн этгээдүүдийн судалгаа (2017-2021 оны 5 дугаар сарын байдлаар).

2.1. Цагдаагийн байгууллагын тоон мэдээлэлд хийсэн анализ

Цагдаагийн байгууллагаас гаргасан мал хулгайлах гэмт хэрэгт хамаарах мэдээлэлд гэмт хэргийн тоо, гэмт хэргийн илрүүлэлт, гэмт хэрэг үйлдэгдсэн гараг, цаг, газар, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлт, хулгайлагдсан малын төрөл, гэмт хэрэгт холбогдогчийн нарийвчилсан мэдээлэл зэрэг хамаарч байна. Эдгээр мэдээллийг тус бүрт нь дэлгэрүүлэн авч үзье.

Хүснэгт 4.1. 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн мал хулгайлах гэмт хэргийн тоон мэдээ

№	Нутаг дэвсгэр	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021.05.31
Орон нутаг						
1	Баян-Өлгий	5	23	13	27	18
2	Говь-Алтай	3	13	24	9	2
3	Завхан	13	38	51	41	25
4	Увс	26	48	53	22	22
5	Ховд	16	39	56	35	8
6	Архангай	33	91	162	102	25
7	Баянхонгор	28	51	101	66	7
8	Булган	15	37	117	52	22
9	Орхон	9	7	8	7	5
10	Өвөрхангай	18	54	83	66	14
11	Хөвсгөл	41	106	101	74	22
12	Говьсүмбэр	7	7	12	10	0
13	Дархан-Уул	9	14	35	15	2
14	Дорноговь	12	34	32	21	9
15	Дундговь	1	21	29	18	9
16	Өмнөговь	2	10	18	26	0
17	Сэлэнгэ	22	43	88	60	20
18	Төв	66	143	201	123	15
19	Дорнод	36	101	133	64	38
20	Сүхбаатар	9	68	149	86	29
21	Хэнтий	47	120	287	145	72
Нийслэл						
22	Баянгол	0	0	0	0	0
23	Баянзүрх	8	23	15	10	1
24	Сүхбаатар	17	5	1	0	0
25	Сонгино-хайрхан	9	27	66	27	3
26	Хан-Уул	6	17	15	13	0
27	Чингэлтэй	1		0	0	0
28	Багануур	6	10	11	5	0
29	Багахангай	1	1	0	0	0
30	Налайх	5	10	19	8	0
Нийт дүн		451	1096	1809	1041	346

Дээрх хүснэгтээс харвал, орон нутгийн хэмжээнд 2017 онд мал хулгайлах гэмт хэргийн үйлдэгдсэн тоо Дундговь аймагт хамгийн бага буюу 1 бүртгэгдсэн бол Төв аймагт хамгийн их буюу 66 бүртгэгдсэн байна. Харин 2018 онд Орхон аймагт хамгийн бага буюу 7, Төв аймагт хамгийн их буюу 143, 2019 онд Орхон аймагт хамгийн бага буюу 8, Хэнтий аймагт хамгийн их буюу 287, 2020 онд Орхон аймагт хамгийн бага буюу 7, Хэнтий аймагт хамгийн их буюу 145, 2021 оны эхний 5 сарын байдлаар Говьсүмбэр болон Өмнөговь аймагт бүртгэгдээгүй, Хэнтий аймагт хамгийн их буюу 72 тус тус бүртгэгдээд байна. Орон нутгийн хувьд дундаж үзүүлэлтээр тухайн гэмт хэрэг хамгийн бага бүртгэгддэг аймаг нь Орхон аймаг байх бөгөөд хамгийн их бүртгэгддэг аймаг нь жил бүр харилцан адилгүй байна.


Харин нийслэлийн хувьд хотжилттой холбоотойгоор тухайн гэмт хэрэг огт бүртгэгдээгүй дүүргүүд байгаа хэдий ч захын хорооллууд хамаарах дүүргүүдэд тодорхой хэмжээгээр гэмт хэрэг үйлдэгддэг байна. Гэсэн хэдий ч нийслэлд үйлдэгдэж буй энэ төрлийн гэмт хэргийн гаралтыг орон нутагтай харьцуулахад харьцангуй цөөн бүртгэгдсэн бөгөөд тухайлбал, 2017 онд тухайн гэмт хэргийн үйлдэгдсэн тоо Сүхбаатар дүүрэгт хамгийн их буюу 17 байсан бол 2018 онд Баянзүрх дүүрэгт 23, 2019 онд Сонгинохайрхан дүүрэгт 66, 2020 онд Сонгинохайрхан дүүрэгт 27, 2021 оны эхний 5 сарын байдлаар Сонгинохайрхан дүүрэгт 3 бүртгэгдсэн байна. Эдгээр мэдээллээс харахад нийслэлийн хэмжээнд Сонгинохайрхан дүүрэгт уг гэмт хэрэг хамгийн их бүртгэгдэж байна.

Хүснэгт 4.2. 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх мал хулгайлах гэмт хэргийн илрүүлэлтийн хувь

№	Аймаг	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх
1	Баян-Өлгий	57.1	55.0	58.3	80.0	53.3
2	Говь-Алтай	100	38.5	47.8	75.0	100
3	Завхан	58.8	67.7	65.0	64.7	62.5
4	Увс	43.4	26.1	37.7	21.4	42.1
5	Ховд	22.9	39.3	44.7	57.9	0.0
6	Архангай	42.0	42.9	42.6	46.6	42.1
7	Баянхонгор	30.8	31.7	30.3	40.0	0.0
8	Булган	57.1	24.2	57.9	32.6	45.5
9	Орхон	23.1	14.3	75.0	33.3	25.0
10	Өвөрхангай	55.0	33.3	31.5	39.5	41.7
11	Хөвсгөл	42.2	41.9	27.7	65.7	23.1
12	Говьсүмбэр	33.3	28.6	0.0	33.3	0.0
13	Дархан-Уул	34.6	14.3	57.6	28.6	50.0
14	Дорноговь	53.3	37.9	42.3	83.3	42.9
15	Дундговь	64.3	52.6	55.2	83.3	85.7
16	Өмнөговь	100	66.7	69.2	89.5	0.0
17	Сэлэнгэ	35.5	48.6	38.3	44.9	53.3
18	Төв	39.0	38.3	37.1	52.9	33.3
19	Дорнод	23.7	37.0	40.3	42.0	9.4
20	Сүхбаатар	85.7	64.1	49.2	52.6	29.2
21	Хэнтий	35.8	29.5	49.0	42.7	53.1
22	Нийслэл	13.0	17.6	12.1	15.4	0.0
23	Нийт	39.0	37.8	41.1	48.3	40.1

Нэг талаас нийт дүнгээр харахад гэмт хэргийн илрүүлэлт жил ирэх тутам тодорхой хувиар өссөн дүнтэй байгаа нь сайшаалтай ч, нөгөөтэйгүүр хэрэг үйлдэгдсэн газар тус бүрийн илрүүлэлт 100 хувьд хүрч чадахгүй байгаа нь эрх зүйн орчин хангалтгүй байна уу, эсхүл хэрэг илрүүлэх арга техник нь тохирохгүй байна уу зэрэг шалтгаан нөхцөлтэй холбоотой байж болох юм. Тухайлбал, Говь-Алтай, Өмнөговь аймгуудад 2017 онд хэргийн илрүүлэлт 100 хувь гэж бүртгэгдэж байсан бол 2018, 2019 онд уг үзүүлэлт огцом буурсан, 2020 оноос тодорхой хэмжээгээр нэмэгдсэн байх жишээтэй, гэтэл зарим газарт гэмт хэргийн илрүүлэлт тогтмол 20-40 хувьтай буюу жил бүр ойролцоо түвшинтэй байна.

График 4.2. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн мал хулгайлах гэмт хэргийн тоон мэдээллийг улирлаар ангилсан байдал.



Мал хулгайлах гэмт хэрэг хамгийн их үйлдэгддэг улирал нь 2016 оноос бусад жилд 1 ба 4 дүгээр улирал байна. Харин 2017 оныг эс тооцвол мал хулгайлах гэмт хэрэг хамгийн бага гардаг улирал нь 3 дугаар улирал буюу 7, 8, 9 дүгээр сар байна.


Хүснэгт 4.3. 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдийн анх удаа болон давтан үйлдлийн талаарх тоон мэдээлэл

№	Гэмт хэрэг	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх
1.	Мал хулгайлах гэмт хэрэг анх удаа үйлдсэн этгээд	45	175	302	307	76
2.	Урьд бусад төрлийн гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдэж байсан этгээд	87	287	337	30	98

Мал хулгайлах хэргийг үйлдэж байсан этгээд дахин уг гэмт хэргийг үйлдсэн талаар тусгайлан бүртгэсэн тоон мэдээлэл цагдаагийн байгууллагын мэдээлэлд байхгүй ба анх удаа мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдийн тооны хувьд 2020

онд хамгийн их буюу 307, 2017 онд хамгийн бага буюу 45 байна. Харин урьд бусад төрлийн гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдэж байсан этгээдийн тооны хувьд 2018 онд хамгийн их буюу 287, 2020 онд хамгийн бага буюу 30 байна. Үүнийг графикаар харуулбал:

График 3. Анх удаа болон дахин гэмт хэрэг үйлдсэн этгээдийн мэдээлэл



Хүснэгт 4.4. Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэгдсэн цаг /Гэмт хэргийн тоо/

№	Цаг	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх
1	06-14	102	141	264	148	54
2	14-19	149	191	271	173	74
3	19-22	101	141	231	146	60
4	22-06	549	623	1043	574	158

2017 онд нийт үйлдэгдсэн гэмт хэргийн 60.9 хувь, 2018 онд 56.8 хувь, 2019 онд 58.2 хувь, 2020 онд 55.1 хувь, 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 45.6 хувь нь 22-06 цагийн хооронд үйлдэгдсэн байна. Дээрхээс харахад шөнийн цагаар²¹ буюу 22-06 цагийн хооронд мал хулгайлах гэмт хэрэг хамгийн их үйлдэгддэг болох нь харагдаж байна. Харин энэ төрлийн гэмт хэрэг хамгийн бага үйлдэгддэг цаг нь ихэвчлэн 19-22 цаг байна.

Хүснэгт 4.5. Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэгдсэн газар /Гэмт хэргийн тоо/

№	Газар	2018 он	2019 он	2020 он	2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар
1	Бэлчээр ²²	1603	1011	515	181
2	Хөдөө хээр ²³	689	496	336	101
3	Бусад газар	510	264	165	49

21 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.30 дахь хэсэгт шөнийн цагийг тодорхойлсон.

22 Бэлчээр гэдэгт малчдын байнгын хариулгатай газрыг ойлгоно.

23 Хөдөө хээр гэдэгт малчдын суурьшлын бүсээс хариулгагүй хээр газрыг хэлнэ.

Дээрх тоон мэдээллээс харвал, мал хулгайлах гэмт хэрэг хамгийн их үйлдэгддэг газар нь бэлчээр бөгөөд нийт гэмт хэрэг үйлдэгдсэн газрын 50-иас дээш хувийг эзэлж байгаа бол хөдөө хээр газарт дунджаар 30 орчим хувь нь, эдгээрээс бусад газарт дунджаар 15-20 орчим хувь нь үйлдэгдэг байна.

График 4.4. 2018 оноос хойш өнөөгийн байдлаар Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэгдсэн газар /Гэмт хэргийн тоо/





График 4.5. 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх мал хулгайлах гэмт хэргийн улмаас учирсан хохирлын болон нөхөн төлүүлэлтийн хэмжээ, сая төгрөгөөр



Дээрх графикаас харахад, хохирлын хэмжээ 2018 оноос эхлэн буурсан байх бөгөөд 2019 онд хохирлын 36.1 хувийг нөхөн төлүүлж, 6.6 хувийг битүүмжилсэн бол, 2020 онд 45.5 хувийг нөхөн төлүүлж, 14.1 хувийг битүүмжилсэн, 2021 оны 5 дугаар сарын байдлаар 31.5 хувийг нөхөн төлүүлж, 9 хувийг битүүмжилсэн байна.



График 4.6. 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх хулгайлагдсан малын төрлөөр ангилсан тоон мэдээлэл

График 6 дээрхээс дүгнэвэл, 2019 онд адуу хамгийн их хулгайлагдсан буюу нийт хулгайлагдсан малын 35 орчим хувь, тэмээ хамгийн бага хулгайлагдсан буюу 0.2 хувийг эзэлж байсан бол, 2020 онд хонь хамгийн их хулгайлагдсан буюу 40 орчим хувийг, тэмээ хамгийн бага хулгайлагдсан буюу 0.8 хувийг, 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хонь хамгийн их хулгайлагдсан буюу 56 хувийг, тэмээ хамгийн бага хулгайлагдсан буюу 0.4 хувийг эзэлж байна. Энэхүү тоон мэдээллээс харвал, хамгийн бага хулгайлагддаг мал нь тэмээ бол, хамгийн их хулгайлагддаг мал нь ихэвчлэн хонь байна.²⁴

График 4.7. Мал хулгайлах гэмт хэрэгт холбогдогчийн тоон мэдээлэл

24 Аймаг бүрээр тухайн үзүүлэлтээр дэлгэрэнгүй жагсаасан мэдээллийг хавсралтаас үзнэ үү.

Мал хулгайлах гэмт хэрэгт холбогдогчийн тоон мэдээллийг үзүүлсэн дээрх графикаас харвал 2019 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаан дахь уг гэмт хэрэгт хамгийн олон хүн холбогдсон жил байжээ. Харин 2002 оны Эрүүгийн хууль хэрэгжиж байх хугацаанд 2013, 2014, 2015 онд хамгийн олон хүн мал хулгайлах гэмт хэрэгт холбогдсон байх бөгөөд 2015 оноос дээрх үзүүлэлт буурсаар 2018 оноос ахин өсөж эхэлсэн ч 2020 онд буурсан байна.

Хүснэгт 4.6. Мал хулгайлах гэмт хэргийн холбогдогчийн нас, хүйсийн байдал

Насны бүлэг	15 хүртэл		16-17		18-24		25-29		30-34		35-39		40-44		45-49		50-54		55-59		60-аас дээш	
Хүйс	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм
2019 он	11		28		214	1	290	2	262	12	189		113	5	42		20	1	11		4	
2020 он	1		9		168	1	239	7	170	2	162	2	74	1	32	3	22	1	3		2	
2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх			11		41	1	58		62		32		22	1	15		6		3		2	
Нийт	12		48		423	3	587	9	494	14	383	2	209	7	89	3	48	2	17		8	

Дээрхээс харахад, 18-34 насныхан мал хулгайлах гэмт хэргийн холбогдогчоор хамгийн их бүртгэгдсэн байх бөгөөд жил бүр дээрх насны ангиллуудаас 60-65 хувийг энэ насныхан эзлэж байгаа бол хүйсийн байдлаар нь харьцуулан үзвэл эрэгтэй 98 хувийг, эмэгтэй 2 хувь орчмыг эзэлж байна.

Хүснэгт 4.7. Мал хулгайлах гэмт хэргийн холбогдогчийн боловсролын түвшин

Боловсролын түвшин	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 оны 5 сарын 31
Бага боловсрол	415	457	359	422	396	240	40	150	253	234	75
Бүрэн бус дунд боловсрол	283	419	449	470	432	209	44	211	375	247	71
Бүрэн дунд боловсрол	220	195	224	257	274	158	27	193	296	277	57
Тусгай дунд	7	13	8	19	14	12	1	15	26	13	3
Дээд боловсролтой	4	11	12	15	12	3	5	8	15	19	8
Боловсролгүй	203	151	204	201	155	88	20	88	240	146	40

Дээрхээс харахад, боловсролын түвшингээр тус гэмт хэрэгт холбогдсон холбогдогчийн хамгийн их хувийг 2019 онд бүрэн дунд болон бүрэн бус дунд боловсролтой холбогдогч 25-31 хувь, 2020 онд мөн л бүрэн дунд болон бүрэн бус дунд боловсролтой холбогдогч 25-30 хувь, 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар бага болон бүрэн бус дунд боловсролтой холбогдогч 30 орчим хувийг тус тус эзлэж байна.

Хүснэгт 4.8. Мал хулгайлах гэмт хэргийн холбогдогчийн нийгмийн байдал

Нийгмийн байдал	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 оны 5 сарын 31
Эрхэлсэн тодорхой ажилгүй	565	611	633	719	591	344	252	300	585	435	98
Малчин	538	549	552	551	592	316	328	335	541	452	135
Сургууль завсардсан	2		-	-	1	-			1	-	-

ТББ-ын ажилтан		4	3	1	4	1	2	1	2	1	-
Тэнэмэл	2	1	-	1	7	5	1	2	-	-	-
Хугацаат цэргийн албан хаагч		1	-	2	-	1			4	1	-
Оюутан		11	6	7	7	3		9	4	-	1
Хоригдол	1	3	1	1	2	1		1	5	2	-
Төрийн албан хаагч	3	3	2	4	6	3	4		9	4	3
Сурагч	9	14	13	27	6	3	2	1	12	-	6
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	10	40	36	61	59	27	19	14	20	31	11
Хувийн хэвшилд ажиллагч	2	9	10	11	9	6		2	20	10	-

Дээрхээс харахад, уг гэмт хэрэгт холбогдогчийн нийгмийн байдлын хувьд малчин болон эрхэлсэн тодорхой ажилгүй хүмүүс дийлэнх хувийг эзэлж байна. Тухайлбал, 2019, 2020 онд 45-49 хувь, 2021 оны 5 дугаар сарын байдлаар мөн л тус ангилалд багтаж буй холбогдогч нар 39-53 хувийг эзэлж байна. Харин бусад ангиллын хувьд уг гэмт хэрэгт холбогдох нь харьцангуй цөөн байна.

Хүснэгт 4.9. Мал хулгайлах гэмт хэргийн холбогдогчийн гэмт хэрэг үйлдсэн байдал

№	Гэмт хэрэг үйлдсэн байдал	2019 он	2020 он	2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх
1	Согтуугаар	71	57	21
2	Галт зэвсэг ашиглаж	4	5	2
3	Цагдаагийн байгууллагаар шалгагдаж байх үедээ	-	-	-
4	Олон тооны мал хулгайлж (ЭХ.17.12.2.1)	161	314	126
5	Бүлэглэж (ЭХ.17.12.2.2)	642	564	127
6	Улсын хилээр нэвтрүүлж (ЭХ.17.12.2.3)	-	-	-
7	Машин механизм ашиглаж (ЭХ.17.12.2.4)	25	27	3
8	Ноцтой хохирол, хор уршиг учруулж (ЭХ.17.12.2.5)	-	-	-
9	Гойд ашиг шимт малыг хулгайлж (ЭХ.17.12.2.6)	-	-	-
10	Байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон (ЭХ.17.12.3.1)	-	-	-
11	Зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн (ЭХ.17.12.3.2)	6	-	-

ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны дүн шинжилгээ, судалгааны хэлтсийн тайланд дурдсанаар 2016-2018 онд нийт мал хулгайлах гэмт хэрэгт сэжиглэгдсэн шалгагдсан этгээдүүдийн 1004 буюу 50.6 хувь нь бүлэглэн, 109 буюу 5.4 хувь согтуугаар, 53 буюу 2.6 хувь нь цагдаагийн байгууллагад шалгагдаж байх үедээ гэмт хэрэг үйлдсэн байх бөгөөд 351 нь тээврийн хэрэгсэл ашиглан үйлдсэн байна²⁵.

Хүснэгт 9 дэх тоон мэдээнээс харахад, мал хулгайлах гэмт хэргийг согтуугаар, олон тооны мал хулгайлж, бүлэглэж үйлдсэн үйлдэл хамгийн их бүртгэгдсэн байх бөгөөд тухайлбал, 2019 онд бүлэглэж үйлдсэн үйлдэл нийт бүртгэгдсэн мал

25 Мал хулгайлах гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн судалгааны ажлын тайлан, 2020.

хулгайлах гэмт хэргийн 71 орчим хувийг, олон тооны мал хулгайлсан үйлдэл 18 орчим хувийг тус тус эзэлж байсан бол 2020 онд бүлэглэж үйлдсэн үйлдэл 58 хувь, олон тооны мал хулгайлсан үйлдэл 33 хувийг эзэлж байна. Түүнчлэн 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар мөн дээрх 2 үйлдэл нийт бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнх хувийг эзэлжээ.

2.2. Шүүхийн тоон мэдээлэлд хийсэн анализ

Судалгааны энэ хэсэгт мал хулгайлах гэмт хэргийн зүйл, анги тус бүрээр шүүхээр шийдвэрлэгдсэн шийдвэрийн статистик мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ хамаарна. Эдгээр мэдээллийг зүйл, заалт бүрээр нь дэлгэрүүлэн авч үзье.

Хүснэгт 4.10. 2020 оны Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр “Мал хулгайлах” гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн тоон мэдээлэл²⁶

Шүүхийн шийдвэрийн зүйл, хэсэг	Шүүхээр шийдвэрлэгдсэн байдал
17.12.1. Мал хулгайлах (энгийн бүрэлдэхүүн)	290
17.12.2.1. Олон тооны мал хулгайлж үйлдсэн	68
17.12.2.2. Бүлэглэж үйлдсэн	12
17.12.2.3. Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн	0
17.12.2.4. Машин механизм ашиглаж үйлдсэн	12
17.12.2.5. Ноцтой хохирол, хор уршиг учруулж үйлдсэн	0
17.12.2.6. Гойд ашиг шимт малыг хулгайлж үйлдсэн	0
17.12.3.1. Байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон	7
17.12.3.2. Зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн	0
17.12 дугаар зүйл буюу “Мал хулгайлах” гэмт хэргээр зүйлчлэгдсэн нийт	389

Хүснэгт 4.11. 2020 онд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэсэн байдал.²⁷

№	Эрүүгийн хуулийн бүлэг, зүйл	Хянан шийдвэрлэсэн хэргийн тоо	Холбогдогчийн тоо	Хуулийн этгээд
3.	17.12.1	290	485	0
4.	17.12.2.1	68	123	0
5.	17.12.2.2	12	26	0
6.	17.12.2.3	0	0	0
7.	17.12.2.4	12	22	0
8.	17.12.2.5	0	0	0
9.	17.12.2.6	0	0	0
10.	17.12.3.1	7	17	0
11.	17.12.3.2	0	0	0
12.	Нийт	389	673	0

2020 онд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр Эрүүгийн хуулийн 17.12.2.3 буюу улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн, 17.12.2.5 буюу ноцтой хохирол, хор уршиг учруулж үйлдсэн, 17.12.2.6 буюу гойд ашиг шимт малыг хулгайлж үйлдсэн, 17.12.3.2 буюу зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн гэх үндэслэлээр шүүхээр

26 Шүүхийн ерөнхий зөвлөлийн тайлан мэдээ.

27 Монгол Улсын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр мал хулгайлах гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл.

шийдвэрлэгдсэн шийдвэр бүртгэгдээгүй бол тус гэмт хэргийн энгийн бүрэлдэхүүн болох 17.12.1-ээр хамгийн их буюу нийт бүртгэгдсэн шийдвэрийн 37.2 хувь нь шийдвэрлэгдсэн байна.

Хүснэгт 4.12. 2017-2020 оны Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр “Мал хулгайлах” гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн талаарх мэдээлэл²⁸

Шүүхийн шийдвэрийн зүйл, хэсэг	Шүүхийн шийдвэрийн цахим сан (хуучин хувилбар)	Шүүхийн шийдвэрийн цахим сан (шинэ хувилбар буюу хуучинтайгаа давхцаагүй шийдвэрүүд)	Нийт	Тайлбар
17.12.1. Мал хулгайлах	770	26	796	-
17.12.2.1. Олон тооны мал хулгайлж үйлдсэн	139	76	215	2020 оны 01 дүгээр сарын 06-наас 17.12.2 нь 17.12.2.1 болж.
17.12.2.2. Бүлэглэж үйлдсэн	-	15	15	2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр орж ирсэн.
17.12.2.3. Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн	-	-	-	2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр орж ирсэн.
17.12.2.4. Машин механизм ашиглаж үйлдсэн	-	14	14	2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр орж ирсэн.
17.12.2.5. Ноцтой хохирол, хор уршиг учруулж үйлдсэн	-	-	-	2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр орж ирсэн.
17.12.2.6. Гойд ашиг шимт малыг хулгайлж үйлдсэн	-	-	-	2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр орж ирсэн.
17.12.3.1. Байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон	5	3	8	-
17.12.3.2. Зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн	-	-	-	-

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2017-2020 оны хооронд шийдвэрлэсэн шийдвэрийг судалж үзэхэд өмнөх хэсэгтэй мөн адил Эрүүгийн хуулийн 17.12.2.3 буюу улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн, Эрүүгийн хуулийн 17.12.2.5 буюу ноцтой хохирол, хор уршиг учруулж үйлдсэн, 17.12.2.6 буюу гойд ашиг шимт малыг хулгайлж үйлдсэн, Эрүүгийн хуулийн 17.12.3.2 буюу зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн гэх зүйлээр зүйчлэн шийдвэрлэгдсэн шүүхийн шийдвэр цахим санд байршаагүй байна. Харин Эрүүгийн хуулийн 17.12.1 дэх хэсгээр шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр нийт цахим санд байршсан шийдвэрийн 76 орчим хувийг, Эрүүгийн хуулийн 17.12.2.1 дэх хэсгээр шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр нийт цахим санд байршсан шийдвэрийн 21 орчим хувийг тус тус эзэлж байна.

28 Шүүхийн шийдвэрийн цахим сангаас шүүлт хийсэн мэдээлэл

2.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тоон мэдээлэлд хийсэн анализ

Аливаа гэмт хэргийн нэгдсэн тоо бүртгэлийн судалгаанд эрүүгийн хариуцлагын судалгаа чухал байр суурь эзэлдэг. Энэ хэсэгт мал хулгайлах гэмт хэрэгт хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтнуудын судалгааг²⁹ авч үзсэн болно.

Хүснэгт 4.13. Мал хулгайлах гэмт хэрэгт хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтнуудын судалгаа (2017-2021 оны 05 дугаар сарын байдлаар)

№	Он	Ялын төрөл		Нийт шийтгүүлсэн ялтны тоо
		Нийтэд тустай ажил хийлгэх ял	Зорчих эрхийг хязгаарлах ял	
1	2017	17	Шийтгүүлсэн ялтан байхгүй байна	17
2	2018	73		73
3	2019	140		140
4	2020	173		173
5	2021 оны 5 дугаар сарын байдлаар	20		20
Дүн		423		423

2021 оны 5 дугаар сарын байдлаар мал хулгайлах гэмт хэрэгт хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтнуудын тухайд зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтан байхгүй тул хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн ялтнууд нь зөвхөн нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтууд байна. 2017 онд нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн хамгийн бага буюу 17 байсан бол 2020 онд хамгийн их буюу 173 ялтан уг ялаар шийтгүүлсэн байна.

График 4.8. Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтны тоо



Юун түрүүнд бид энэхүү судалгааг дээрх 3 байгууллагын тоон мэдээллээр хязгаарлахыг анхнаасаа зориогүй болохыг хэлэх нь зүйтэй. Тус гурван байгууллагаас гадна прокурорын байгууллагын мэдээллийг оруулахаар төлөвлөсөн боловч УПЕГ-аас бидэнд холбогдох мэдээллийг өгөхөөс татгалзсан болно. Татгалзах болсон шалтгаанаа хариу албан бичигтээ дурдаагүй.

Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсэгт “Яам, Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллага, нутгийн захиргааны байгууллага чиг үүргийнхээ дагуу статистикийн үйл ажиллагааг эрхэлнэ. Яамд бүтэцдээ салбарын статистикийн үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэх нэгжтэй байна.” гэж заагаад 4-р зүйлийн 5 дахь хэсэгт заасан статистикийн үйл ажиллагаанд “статистикийн

29 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.12 дугаар зүйл ангиар шийтгэгдсэн хоригдол болон хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн этгээдүүдийн судалгаа.

мэдээлэл нь нийтэд хүртээмжтэй, хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд ил тод байх” зарчим баримталж ажиллах ёстой тухай хуульчилжээ.

Гэвч прокурорын байгууллага нь гэмт хэргийн тухай болон хэргийн холбогдогч, хохирогчтой холбоотой тоон мэдээллийг УИХ, Ерөнхийлөгчийн тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд л явуулдаг. Бусад төрийн байгууллагаас ирүүлсэн албан бичгийн дагуу эрүүгийн хэрэгтэй холбоотой шаардлагатай тоон үзүүлэлт, судалгааг гарган хүргүүлдэг хэмээдэг боловч тун хязгаарлагдмал байна. Энэ нь нууцад үл хамаарах тоон мэдээллийг хууль тогтоомжийн төлөв байдал, хандлага, хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх, эрдэм шинжилгээний зөвлөмж, аргачлал боловсруулах, хууль тогтоомжийн төсөлд шинжлэх ухааны санал, дүгнэлт өгөх чиг үүрэг бүхий үндэсний хэмжээний байгууллагад гаргаж өгөхөөс татгалзаж байгаагаас харагдаж байна.

ШЕЗ-өөс мал хулгайлах гэмт хэрэгтэй холбоотой тоон мэдээлэл хүсэхэд хариу ирүүлэхдээ хугацаа хоцроодог, статистик хариуцсан мэргэжилтэнтэй хамтран ажиллахад үл ойлголцох, ойлголтын зөрүү гарах зэрэг хүндрэл бэрхшээл гарсны улмаас зөвхөн 2020 онд анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн мэдээллийг авсан. ШЕЗ-өөс Шүүхийн захиргааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.8, 18.1.9-д заасныг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааны болон шүүн таслах ажиллагааны жил бүрийн тайланг Монгол Улсын Ерөнхийлөгчид танилцуулах, бүх шатны шүүхэд хүргүүлэхээр эмхэтгэн нийтийн хүртээл болгодог ч тус тайланд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бүх гэмт хэргээр ангилсан дэлгэрэнгүй тоон мэдээлэл бус цөөн хэдэн төрлийн гэмт хэргийг онцолсон байдаг.

ШШГЕГ-аас ирүүлсэн “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.12 дугаар зүйл ангиар шийтгэгдсэн хоригдол болон хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн этгээдүүдийн судалгаа”-нд цагдаа болон шүүхэд бүртгэгдээгүй, гэмт хэргээр ял шийтгүүлж буй тухай хэд хэдэн алдаатай мэдээлэл байсан бөгөөд тэдгээрийг залруулахаар хандсан ч эргэж хариу өгөөгүй болно. Иймд бид тус байгууллагын мэдээллийг нягталсны дараа судалгаанд ашигласан.

Цагдаагийн байгууллага дээр дурдсан байгууллагуудаас мэдээллийн сангийн бүрдүүлэлт сайтай, нээлттэй, мэдээлэл авахад төвөг чирэгдэл бага боловч “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал”, ЦЕГ-ийн албан ёсны цахим хаягт байршдаг мэдээлэл болон тус байгууллагад албан бичиг хүргүүлсний үндсэн дээр авсан мэдээлэл дэх зарим тоон үзүүлэлт хоорондоо зөрж байгаа нь судалгааны явцад тогтоогдсон. Иймд тус байгууллагад албан бичгээр илгээн хандаж авсан тоон мэдээллийг зөв хэмээн үзэж судалгаандаа ашиглав. Мөн түүнчлэн мэдээллийн сангийн арвин бүрдүүлэлтийн ангилалтыг дахин хийх шаардлагатай байна. Тухайлбал, гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлах, урьдчилан сэргийлэх бодлого боловсруулахад гэмт хэргийн гаралтыг улирлаар ангилсан мэдээлэл хагас жилийн нэгтгэсэн мэдээнээс илүү чухал ач холбогдолтой. Мөн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын тоон мэдээллийг газар нутгийн байдлаар ангилахаас илүүтэйгээр тодорхой гэмт хэргээр ангилах нь илүү ач холбогдолтой.

ГУРАВ. МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Судалгааны хүрээнд нийслэл болон орон нутгийн хэмжээнд ажиллаж буй цагдаагийн алба хаагчдыг хамруулан (нийслэл, 19 аймгийн нийт 110 цагдаагийн алба хаагч хамрагдсан) асуулгын аргаар практик судалгаа хийсэн бөгөөд энэхүү анкетын асуулгын үр дүнд үндэслэн мал хулгайлах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалтад тулгамдаж буй асуудлыг илрүүлэхийг зорьсон болно.

3.1. Эрүүгийн хуулийн 17.12.1 дүгээр зүйл буюу мал хулгайлах (энгийн бүрэлдэхүүн) гэмт хэргийн тухайд

Мал хулгайлах гэмт хэргийн энгийн бүрэлдэхүүнийг Эрүүгийн хуулийн 17.12.1-д “Бусдын малыг хулгайлсан бол зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж хуульчилсан. Тухайн зохицуулалттай холбоотой яригддаг нэг асуудал нь түүний хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой асуудал юм. Эрүүгийн хуулийн 17.12.1-д зааснаар тухайн гэмт хэргийг үйлдвэл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэгддэг санкцтай. Харин Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд зааснаар гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь ойлгомжгүй байдал үүсгэж байна. Энэ зүйлд дараах байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тодорхойлдог.

Хүснэгт 4.14. Хөөн хэлэлцэх хугацаа тооцож буй байдал

Ялын интервал	Хөөн хэлэлцэх хугацаа
12 жилээс 20 жил	20 жил
8 жилээс 15 жил	10 жил
5 жилээс 12 жил	10 жил
2 жилээс 8 жил	5 жил
1 жилээс 5 жил	5 жил
6 сараас 5 жил	Тодорхойгүй байна.
6 сараас 3 жил	3 жил
6 сараас 2 жил	3 жил
6 сараас 1 жил	3 жил
1 сараас 1 жил	1 жил
1 сараас 6 сар	1 жил
1 сараас 3 сар	1 жил

2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар оруулсан нэмэлт, өөрчлөлт нь хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь тодорхойгүй байсан 50 асуудлыг засаж сайжруулах боломжийг бүрдүүлсэн хэдий ч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тоолох нь эргэлзээтэй хэвээр байгаа юм. Учир нь тус зохицуулалтууд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь заалтад заасан “...хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээ найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон...” гэсэн заалтад мөн 2020 оны 1 сарын 10-ны өдрийн хуулиар Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.5-д “...энэ хуулийн тусгай ангид

хорих ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон,” гэж өөрчлөн хуульчилсан заалтад ч тохирохгүй байна. Өөрөөр хэлбэл, дээрх 3 зохицуулалт нь одоог хүртэл эрх зүйн хийдэлтэй хэвээр байна.³⁰

Үүнээс болж гэмт хэрэг үйлдсэн хүн ял завших, гэмт хэрэг дахин үйлдэх гэх мэт сөрөг үр дагавар гарах боломжтой юм.

Цагдаагийн алба хаагчдаас уг гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой дараах асуулгыг авахад доорх үр дүнг үзүүлэв.

Хүснэгт 4.15. Асуулга 1. Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт 6 сараас 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан нь хуулийн 1.10 дугаар зүйлийн дагуу хөөн хэлэлцэх хугацааг тогтоосонтой тохирдоггүй. Та уг гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хэдий хугацаагаар, хэрхэн тооцдог вэ?

Д/д	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	5 жилээр тооцно	14	56
2	3 жилээр тооцно	1	4
3	1 жилээр тооцно	4	16
4	Мэдэхгүй	4	16
5	Тодорхойгүй	2	8
Нийт		25	100

Уг асуулгад 57 алба хаагч хариулт өгсөн бөгөөд үүнээс тодорхой хариулт өгсөн 25 алба хаагч байна. Тухайн анкетын судалгааны үр дүнгээс харахад Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 1 буюу мал хулгайлах гэмт хэргийн энгийн бүрэлдэхүүний хөөн хэлэлцэх хугацааг цагдаагийн алба хаагчид янз бүрээр тодорхойлж байгаа нь харагдаж байна. Иймд уг зохицуулалтыг нэг мөр болгон шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай.

Хүснэгт 4.16. Асуулга 2. Ийнхүү уг гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тодорхой биш байдлаас практикт хүндрэл, бэрхшээл үүсдэг үү? Үүсдэг бол тэр талаар дэлгэрэнгүй хариулна уу?”

Д/д	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1.	Үүсдэггүй	14	36.8
2.	Мэдэхгүй	7	18.4
3.	Ямар нэгэн шалтгаанаар үүсдэг	4	10.5
4.	Гэмт хэрэг үйлдэх сэдэл бий болгодог	4	10.5
5.	Хуулийн хийдэлтэй	3	7.9
6.	Холбогдогчид ашигтай байдал үүсгэдэг	2	5.3
7.	Хөөн хэлэлцэх хугацаа удаан байх нь буруу	1	2.6
8.	Ял завших боломж бүрдүүлдэг	1	2.6
9.	Дураараа тайлбарладаг	1	2.6
10.	Мөрдөн шалгах ажиллагааг хүндрүүлдэг	1	2.6
Нийт		38	100

30 Г.Халиунаа, Б.Ариунжаргал, Эрүүгийн хууль дахь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Хууль дээдлэх ёс сэтгүүл №2, 2021, 222-230 дахь тал.

Уг асуулгад 57 алба хаагч хариулт өгсөн бөгөөд үүнээс тодорхой хариулт өгсөн 38 алба хаагч байна. Дээрхээс харахад, уг гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тодорхой биш байгаагаас болж хүндрэл бэрхшээл үүсдэггүй гэж хамгийн олон алба хаагч хариулсан хэдий ч мэдэхгүй, гэмт хэргийн сэдэл бий болгодог гэх мэт хариулт мөн өндөр хувьтай хариулсан байгаа нь тухайн асуудлаас болж практикт ямар нэг хүндрэл бэрхшээл тодорхой хэмжээгээр үүсгэдэг гэж үзэж болохоор байна.

Хүснэгт 4.17. Асуулга 3. *Ийнхүү уг гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тодорхой биш байдал нь гэмт хэрэгтэнд ял завших боломж бий болгох эсэх талаар та юу гэж бодож байна вэ?*

Д/д	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1.	Тийм	26	56.5
2.	Үгүй	7	15.2
3.	Мэдэхгүй	8	17.4
4.	Санаа байхгүй	2	4.3
5.	Маргаантай	1	2.2
6.	Хөөн хэлэлцэх хугацаа байх ёсгүй	1	2.2
Нийт		46	100

Уг асуулгад 57 алба хаагч хариулт өгсөн бөгөөд үүнээс тодорхой хариулт өгсөн 46 алба хаагч байна. Тухайн асуулгын үр дүнгээс уг гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тодорхой биш байгаа нь гэмт хэрэгтэнд ял завших боломж бий болгож байгаа гэсэн үзүүлэлтийг 56.5%-тай тодорхойлсон. Энэ нь тухайн хөөн хэлэлцэх хугацаа тодорхой биш байдлаас үүдэн ял завших боломж бий гэдэг сөрөг үр дагавар байгааг илэрхийлж байна.

Дээрхээс харахад, асуулгад оролцогсдын 57 орчим хувь нь ял завшуулах сөрөг үр дагавар байна гэж хариулсан нь уг зохицуулалт практикт хэрэгжихдээ асуудал дагуулж байгааг илэрхийлж буй хэрэг юм.

2002 оны Эрүүгийн хуульд хөөн хэлэлцэх хугацааг тооцохдоо гэмт хэргийн ангилалд тулгуурласан зохицуулалттай байсан.³¹ Тухайн зохицуулалтын хувьд гэмт хэргийн ангилалд тулгуурласан тул ямарваа нэгэн гэмт хэргийн ялын интервалыг орхигдуулаагүйгээрээ давуу талтай байв.

Харин 2015 оны шинэчилэн найруулсан Эрүүгийн хууль батлагдахад хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тооцох талаар томьёолохдоо хуулийн 1.10-т зааснаар “энэ хуульд нэг жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн, энэ хуульд найман жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар ялын дээд хэмжээг тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн, энэ хуульд арван хоёр жил хүртэл хорих ял оногдуулахаар ялын дээд хэмжээг тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван хоёр жил өнгөрсөн, энэ хуульд арван хоёр жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар ялын дээд хэмжээг тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин жил өнгөрсөн”³² гэх мэтчилэн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргүүдийн оногдуулах ялын дээд хэмжээнд тулгуурлан хуульчилж байжээ.

31 Эрүүгийн хуулийн 72.1-д зааснаар “хөнгөн гэмт хэрэг үйлдсэнээс хойш зургаан сар өнгөрсөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн, хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван таван жил өнгөрсөн, онц хүнд гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин таван жил өнгөрсөн” байна.

32 Монгол Улсын Их Хурал Хууль зүйн байнгын хороо, Эрүүгийн хуулийн хувийн хэрэг/Шинэчилсэн найруулга/ Боть VI, 2015, 118 дахь тал.

Энэхүү зохицуулалт нь 2017 оны 5 дугаар сарын 11-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар өөрчлөгдөж дараах хэлбэртэй болсон байна:³³

- Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн;
- Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн;
- Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг арван таван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш арван хоёр жил өнгөрсөн;
- Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг арван хоёр жилээс дээш, хорих ялын дээд хэмжээг хорин жил хүртэл тогтоосон ба бүх насаар хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэнээс хойш хорин жил өнгөрсөн гэх мэтчилэн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргүүдийн ялын интервалын доод хэмжээ болон дээд хэмжээнд тулгуурлан тогтоодог болсон.

Түүнчлэн 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр тус зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт орсон ба дараах нэмэлт оруулсан байна.

- Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн.³⁴

2002 оны Эрүүгийн хууль болон 2015 оны Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлт орохоос өмнө нь хөөн хэлэлцэх хугацааг тооцоход 6 сараас 5 жилийн хорих ялын интервалтай гэмт хэргүүдэд ямар нэгэн эргэлзээ үүсгэхээргүй хууьчилж байжээ. Тухайлбал, 2002 оны Эрүүгийн хуулиар тухайн гэмт хэрэг нь хуулийн 145.1, 145.2, 148.1-д заасан хөнгөн болон хүндэвтэр ангиллын гэмт хэргүүд байх тул тэдгээрийн хөөн хэлэлцэх хугацааг хуулийн 72.1-д зааснаар тооцоход хүндрэл үүсдэггүй байжээ. 2015 оны Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлт орохоос өмнө хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.2-т зааснаар “энэ хуульд зааснаар найман жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар ялын дээд хэмжээг тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш 5 жил өнгөрсөн” буюу 6 сараас 5 жилийн хорих ял оногдуулахаар заасан тухайн гэмт хэргүүдэд 5 жилийн хөөн хэлэлцэх хугацааг ялын интервалын дээд хэмжээнд нь үндэслэн тооцох боломжтой байжээ.

Гэтэл 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар өөрчлөн найруулсан 1.10 дугаар зүйлийн 1.1 буюу “Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хэмжээг нэг жил, түүнээс бага

33 Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, (Эцсийн найруулга), 2017, 7 дахь тал

34 Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, (Эцсийн найруулга), 2020, 1 дэх тал

хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн”, мөн зүйлийн 1.2 буюу “Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн” гэх зохицуулалтуудаар тухайн 6 сараас 5 жилийн хорих ялын интервалтай гэмт хэрэгт хэрхэн хөөн хэлэлцэх хугацааг тооцох нь эргэлзээтэй, ойлгомжгүй болсон юм.

Өмнө дурдсанчлан 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар дээрхтэй ижил алдааг засч, хуулийн 1.5-д “энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн” гэх зохицуулалтыг нэмэлтээр оруулсан. Энэ нь тухайн хуулийн үзэл баримтлал болох “Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолох зохицуулалтыг зөрчлийн хугацаа тоолох зохицуулалттай уялдуулах, улмаар зарим гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолох зохицуулалтыг боловсронгуй болгох³⁵” гэх агуулгад нийцжээ. Тус нэмэлт, өөрчлөлтийн үр дүнд 50 гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг эргэлзээгүй тооцох боломж бий болсон. Тиймээс үүнтэй адил 17.1.1.Хулгайлах, 17.2.1.Дээрэмдэх, 17.12.1.Мал хулгайлах гэмт хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацааг тооцох зохицуулалт дутагдаж байна. Мөн энэхүү нэмэлтээр Эрүүгийн хуульд ийм нэмэлт оруулах хэрэгцээ, шаардлага байгаа тухай Монголын Хуульчдын Холбооны ерөнхийлөгч Ж.Хунан нь 2018 оны 08 сарын 21-ны өдөр хуулийн төсөлд гаргасан саналдаа ийнхүү өгүүлжээ:

“Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг 1.10 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт ялгамжтай тогтоосон нь тодорхойгүй байдлыг бий болгож байна. Хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.1 “хорих ялын дээд хэмжээг нэг жил түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш 1 жил өнгөрсөн”, 1.2 “хорих ялын доод хэмжээг жил, дээд хэмжээг 8 жил түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш 5 жил өнгөрсөн” хугацаанд хянан хэлэлцэхээр заасан. Хооронд нь завсрын хугацаа гарч, тухайн хэргүүдийн хөөн хэлэлцэх хугацааг хэрхэн тооцох нь тодорхойгүй байна. Тухайлбал, 11.7 дугаар зүйлийн 2 дахь заалтад заасан гэмт хэрэгт 6 сараас 2 жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан. Энэ гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааны алийг авах нь эргэлзээтэй байна. Төстэй заалтуудаас дурдвал, 17.1.1, 17.2.1, 17.3.1, 22.10.1 з.м.”³⁶

Түүнчлэн мал хулгайлах гэмт хэргийн энгийн бүрэлдэхүүн нь дээрх хуулийн хийдэлд хамаарч байх тул шүүхээс түүнийг хэрхэн шийдвэрлэж байгаа талаар дүн шинжилгээ хийх нь зүйтэй. Тиймээс 2017 оноос 2021 оны шүүхийн шийдвэрүүдээс хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой дүгнэлт гаргасан мал хулгайлах гэмт хэргийн энгийн бүрэлдэхүүнийг буюу Эрүүгийн хуулийн 17.12.1-ийг шийдсэн анхан шатны шүүхийн шийдвэрүүдийг сонгох нь зүйтэй гэж үзэж дараах шүүхийн шийдвэрийг авч үзлээ.

35 Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2019, 4 дэх тал.

36 Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд бусад яамд, холбогдох байгууллагаас ирүүлсэн саналын товчоон, 42 дахь тал.

Хүснэгт 4.18. шүүхийн шийдвэрийн харьцуулалт. №1

№	Шүүхийн шийдвэрийн нэр	Гэмт хэргийн товч утга	Гэмт хэрэг үйлдсэнээс хойш өнгөрсөн хугацаа	Шүүхээс хөөн хэлэлцэх хугацааны талаар гаргасан дүгнэлт
1.	Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 11 сарын 29-ний дугаар 190	Д.Г нь 2017 оны 11 дүгээр сарын үед Увс аймгийн Зүүнговь сумын нутгаас хохирогч Ж.Б-ын эзэмшлийн 1 тооны даага хулгайлж 270.000 төгрөгний хохирол учруулсан	1 жил	“Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт “энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн” гэж зааснаар тухайн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байна.”
2.	Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 12 сарын 11-ний дугаар 200	Шүүгдэгч Б.Б нь 2018 оны 10 дугаар сарын 03-наас 04-нд шилжих шөнө Увс аймгийн Өлгий сумын 2 дугаар багийн нутгаас хохирогч Д.Ц-ийн 3 тооны бог мал буюу ямааг хулгайлж 137.000 төгрөгний хохирол учруулсан	2 сар 7 хоног	“Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт “энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн” гэж зааснаар тухайн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байх тул эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байна.”
3.	Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 12 сарын 24-ний дугаар 02	Х.М нь 2018 оны 9 дүгээр сарын 09-нөөс 2018 оны 9 дүгээр сарын 10-нд шилжих шөнө тус аймгийн Наранбулаг сумын нутаг Сэжүүр гэх газраас хохирогч Х.С-ийн 5 тооны ямаа хулгайлж 256.000 төгрөгний, хохирогч Я.З-ын 9 тооны ямаа хулгайлж 438.000 төгрөгний хохирол, нийт 694.000 төгрөгний хохирол учруулсан	3 сар 14 хоног	“Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт “энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн” гэж зааснаар тухайн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байх тул түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байна.”

4.	Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 01 сарын 17-ний дугаар 06	А.А нь 2017 оны 9 дүгээр сард Увс аймгийн Тэс сумын 9 дүгээр багийн нутаг "Их голын хөвөө" гэх газраас хохирогч Ө.О-ийн 1 тооны тэмээ хулгайлж бусдад 680.000 төгрөгний хохирол учруулсан	1 жил 4 сар	"Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт "энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн" гэж зааснаар тухайн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байх тул эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байна."
5.	Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 03 сарын 19-ний дугаар 34	Л.У нь 2018 оны 12 дугаар сарын 16-ны шөнө Увс аймгийн Улаангом сумын 9 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах Ерөнхий боловсролын 6 дугаар сургуулийн хашаанаас хохирогч Л.Ц-ийн 1 тооны адуу /хар зүсмийн эмээл хазаартай/, адууны сээр хавс мах зэргийг хулгайлж 810.000 /найман зуун арван мянга/ төгрөгний хохирол учруулсан	3 сар 3 хоног	"Л.У Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.12 дугаар зүйлийн 1-д заасан "Мал хулгайлах" гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон бөгөөд тэрээр хэрэг хариуцах чадвартай, тухайн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байх тул түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байна."
6.	Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 06 сарын 05-ны дугаар 617	О.Б, Т.Б нар нь Г.Г-тэй бүлэглэн, давтан үйлдлээр машин механизм, тусгайлан бэлтгэсэн багаж хэрэгсэл хэрэглэж: - 2017 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 361-ийн гарам гэх газраас иргэн Б.Э-ийн өмчлөлийн хээлтэй хүрэн зүсмийн байцан гүүг хулгайлан авч, 1.280.000 төгрөгийн, - 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Төв аймгийн Аргалант сумын нутаг Цагаан хөтөл гэх газраас иргэн Б.Д-ийн өмчлөлийн хул, хээр зүсмийн 2 тооны гүүг хулгайлан авч, 3.780.000 төгрөгийн, - 2017 оны 04 дүгээр сарын 11-ээс 12-нд шилжих шөнө Төв аймгийн Аргалант сумын Хөшөөт 2 дугаар багийн нутаг дэвсгэр Дугуй булаг гэх газраас иргэн С.М-ийн өмчлөлийн хар халтар зүсмийн азаргыг хулгайлан авч, 3.600.000 төгрөгийн,		"2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.12 дугаар зүйлийн 1-д зааснаар оногдуулж болох хорих ялын доод хэмжээ 6 сар, дээд хэмжээ 5 жил байх нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан "хөөн хэлэлцэх хугацаа"-г хэрэглэх, тайлбарлахад эргэлзээ, маргаантай асуудал үүсгэхгүй буюу гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны хувьд шүүгдэгч нарыг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэлгүй болох нь дараах үндэслэлтэй. 1. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн зохицуулалтаас үзэхэд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гагцхүү хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын оногдуулж болох доод эсхүл дээд хэмжээг нийтлэг шалгуур болгон ялгамжтай тогтоосон байх ба хөөн хэлэлцэх хугацааны ялгамжтай байдлын тусгай буюу нарийвчилсан шалгуур нь тухайн гэмт хэрэгт оногдуулж болох хорих ялын дээд хэмжээ болох нь илэрхий байна.

	- 2017 оны 04 дүгээр сарын 12-ноос 13-нд шилжих шөнө Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 361-ийн Тахир соёотын баруун энгэрийн жалганаас иргэн С.Г-ийн өмчлөлийн 14 настай хонгор азаргыг хулгайлан авч, 2.700.000 төгрөгийн хохирол тус тус учруулсан. О.Б, Т.Б нар нь Т.Д, Т.Б нартай бүлэглэн, давтан үйлдлээр машин механизм, тусгайлан бэлтгэсэн багаж хэрэгсэл хэрэглэж: - 2017 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 03-ны өдрийн хооронд Төв аймгийн Баянхангай сумын 1 дүгээр багийн “Өвгөнтийн ар” гэх газраас иргэн Т.Г-ын өмчлөлийн цагаан хонгор зүсмийн морь, хул зүсмийн гүү зэрэг 2 тооны адууг хулгайлан авч, 9.551.340 төгрөгийн хохирол учруулсан. Г.Г нь О.Б, Т.Б нартай бүлэглэн, давтан үйлдлээр машин механизм, тусгайлан бэлтгэсэн багаж хэрэгсэл хэрэглэж: - 2017 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 361-ийн гарам гэх газраас иргэн Б.Э-ийн өмчлөлийн хээлтэй хүрэн зүсмийн байцан гүүг хулгайлан авч, 1.280.000 төгрөгийн, - 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Төв аймгийн Аргалант сумын нутаг Цагаан хөтөл гэх газраас иргэн Б.Д-ийн өмчлөлийн хул, хээр зүсмийн 2 тооны гүүг хулгайлан авч, 3.780.000 төгрөгийн, - 2017 оны 04 дүгээр сарын 11-нээс 12-нд шилжих шөнө Төв аймгийн Аргалант сумын Хөшөөт 2 дугаар багийн нутаг дэвсгэр Дугуй булаг гэх газраас иргэн С.М-ын өмчлөлийн хар халтар зүсмийн азаргыг хулгайлан авч, 3.600.000 төгрөгийн,	2 жил 1 сар 23 хоног	Тухайлбал, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1.1, 1.2-т зааснаар хөөн хэлэлцэх хугацааны ялгамжийн хувьд хорих ялын оногдуулж болох дээд хэмжээ нь 1 жил, түүнээс доош бол 1 жил, харин хорих ялыг 1 жилээс дээш хэмжээгээр оногдуулж болохоор бөгөөд дээд хэмжээ нь 8 жил дотор багтаж байгаа бүхий л тохиолдолд 5 жил гэж ойлгох үндэслэлтэй юм. 2. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4-т: хөөн хэлэлцэх хугацааг ялгамжтай тогтоох шалгуур болгон хорих ялын доод, дээд хэмжээг заахдаа хорих ялын доод, дээд хэмжээний дунд нь “таслал”(,) хэрэглэсэн байгаа нь гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тогтоох, тоолоход Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын интервал “ямар төрөл, хэлбэр”-ээр хуульчлагдсан байх нь хамааралгүй, гагцхүү хөөн хэлэлцэх хугацааны тусгай шалгуур нь хорих ялын оногдуулж болох дээд хэмжээ болох үндэслэл, утга агуулгыг давхар илэрхийлж байна. Тодотговол, Эрүүгийн хуулиар хөөн хэлэлцэх хугацааны тухайн зохицуулалтад таслал хэрэглэснээр “таслал” бүхий хэсэг бүр тус тус ялгаатай, нарийвчилсан утга агуулгыг илэрхийлж байгаа учраас Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4-т зааснаар хөөн хэлэлцэх хугацааг тоолоход хорих ялын интервал Эрүүгийн хуулийн тусгай ангид заавал “1 жилээс 8 жил, 5 жилээс 15 жил, 12 жилээс 20 жил” гэж туйлын тодорхой хуульчлагдсан байх ёстой гэж ойлгох боломжгүй, харин “таслалгүй” бол тухайн интервалын зохицуулалтын утга эсрэгээр хувирч ойлгогдох боломжтой. Тийм учраас Эрүүгийн хуулийн тусгай ангид “хорих ялын интервал” ямар төрөл, хэлбэрээр хуульчлагдсан байх нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлд зааснаар хөөн хэлэлцэх хугацааг ялгамжтай тогтоосон шалгуурт хамааралгүй буюу нөлөөлөхгүй гэж үзнэ.
--	--	-----------------------------	--

	- 2017 оны 04 дүгээр сарын 12-ноос 13-нд шилжих шөнө Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах 361-ийн Тахир соёотын баруун энгэрийн жалганаас иргэн С.Г-ийн өмчлөлийн 14 настай хонгор азаргыг хулгайлан авч, 2.700.000 төгрөгийн хохирол тус тус учруулсан. Т.Д, Т.Б нар нь О.Б, Т.Б нартай бүлэглэн тээврийн хэрэгсэл ашиглан : - 2017 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 03-ны өдрийн хооронд Төв аймгийн Баянхангай сумын 1 дүгээр багийн "Өвгөнийн ар" гэх газраас иргэн Т.Г-ийн өмчлөлийн цагаан хонгор зүсмийн морь, хул зүсмийн гүү зэрэг 2 тооны адууг хулгайлан авч, 9.551.340 төгрөгийн хохирол учруулсан	3. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1.1-д "хорих ялын дээд хэмжээг 1 жил, түүнээс доош" гэж заасан тул хорих ялын тус хэмжээнээс өөр хэмжээг шалгуур болгон хөөн хэлэлцэх хугацааг ялгамжтай тогтооход хорих ялын интервалын хувьд "хорих ялыг 1 жилээс дээш хэмжээгээр оногдуулж болохоор байх" шаардлагыг хангасан байх нь ойлгомжтой асуудал болно. Тийм учраас Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1.2-т "хорих ялын доод хэмжээг 1 жилээс дээш" гэж заасан нь техникийн шинжтэй энгийн ойлголтод хамаарч байх ба энэ нь Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээ нь заавал "1 жилээс дээш" байхаар туйлын тодорхой хуульчлагдсан байх утга агуулгыг илэрхийлэхгүй, харин хорих ялын интервалын хувьд хорих ялыг 1 жилээс дээш хэмжээгээр оногдуулж болохоор байх шаардлага, утга агуулгыг илэрхийлсэн байх тул Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлд зааснаар хөөн хэлэлцэх хугацааг ялгамжтай тогтоосон шалгуурт эргэлзээ, маргаан бүхий байдал үүсгэхгүй гэж үзнэ. Энд дээр дурдсан 1, 2-т заасан үндэслэл нэгэн адил хамаарна. 4. Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын "1 жилээс 8 жил, 5 жилээс 15 жил" гэсэн интервал огт хуульчлагдаагүй байгаа нь Эрүүгийн хуулийн ерөнхий анги дахь хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтын талаарх дээрх 1, 2, 3-т заасан үндэслэлийг давхар батлах хууль зүйн үндэслэл болж байна. 5. Дээрх үндэслэлүүдийн хүрээнд дүгнэхэд: Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1.2-т заасан "тусгай ангид хорих ялын доод хэмжээг 1 жилээс дээш, дээд хэмжээг 8 жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон" гэдэгт Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаар тухайн гэмт хэрэгт 1 жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болохоор, гэхдээ дээд хэмжээ нь 8 жилээс хэтрэхгүй байх шалгуурт нийцэх хорих ялын харилцан адилгүй доод, дээд хэмжээ бүхий интервалын бүх төрөл, хэлбэрүүд хамаарна гэж үзнэ."
--	---	--

7.	Баян-Өлгий аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 09 сарын 17-ны өдрийн дугаар 178	А.А, М.Ж нар нь 2019 оны 04 дүгээр сарын 02-ноос 03-нд шилжих шөнө Баян-Өлгий аймгийн Алтай сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэр “Хар нуур” гэх газарт байрлах малын хашаанаас иргэн Ж.Д-ын нас бие гүйцсэн, 12 тооны эх ямааг хулгайлсан	1 жил 5 сар 14 хоног	“Гэмт хэрэг үйлдсэн хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах хүртэл тоолох бөгөөд хөөн хэлэлцэх хугацааг зохицуулсан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт “Энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн бол яллагдагчаар татаж болохгүй” гэж зааснаас үзэхэд шүүгдэгч М.Ж, А.А нарын үйлдсэн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нэг жил биш, таван жил байна. Тодруулбал: Шүүгдэгч нар нь 2019 оны 4 дүгээр сарын 02-ны өдрөөс 03-нд шилжих шөнө Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан мал хулгайлах гэмт хэрэг /зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ялтай/ үйлдсэн байх ба тэдний үйлдсэн гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т заасны дагуу таван жил байх бөгөөд уг хугацаа 2024 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 24 цагт дуусгавар болохоор байна.”
8.	Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 10 сарын 23-ны дугаар 156	Ч.Б нь Увс аймгийн Тэс сумын нутаг дэвсгэр “Тасархайн өвдөг” гэх газраас 2019 оны 11 дүгээр сарын 06-07-нд шилжих шөнө 1 тооны, 2019 оны 11 сарын 08-09-нд шилжих шөнө 2 тооны нийт 3 тооны үхэр хулгайлж хохирогч Б.Б-т 2'200'000 төгрөгийн хохирол учруулсан	11 сар 16 хоног	“Ч.Б-ын үйлдэлд тухайн зүйлд заасан хүндрүүлэн зүйлчлэх нөхцөл байдал тогтоогдоогүй, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т заасан хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байх тул шүүгдэгчийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцох үндэслэлтэй гэж дүгнэв.”

Дээрх шүүхийн шийдвэрүүдээс³⁷ дүгнэхэд Увс аймгийн сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх голчлон хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой дүгнэлт өгсөн байна. Мөн гэмт хэрэг үйлдсэнээс хойш өнгөрсөн хугацааг авч үзвэл хамгийн бага нь 2 сар 7 хоног, хамгийн их нь 2 жил 1 сар 23 хоног байна. Шүүхээс хөөн хэлэлцэх хугацааны талаар гаргасан дүгнэлтийн агуулгыг ерөнхийд нь авч үзвэл дараах агуулгаар тайлбарлан хэргийг шийдвэрлэж байна:

37 Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэгт “энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг нэг жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш таван жил өнгөрсөн” гэж зааснаар тухайн хэргийг шийдвэрлэхдээ тухайн зүйл, хэсгийг баримталж 5 жил өнгөрсөн байж хөөн хэлэлцэх хугацаа дуусахаар шийдвэрлэдэг.

- Хорих болон зорчих эрхийг хязгаарлах ялын оногдуулж болох доод эсхүл дээд хэмжээг нийтлэг шалгуур болгон ялгамжтай Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн зохицуулалтад зохицуулсан. Ийнхүү ялгамжтай байдлаар оногдуулж байгаа тусгай, нарийвчилсан шалгуур нь хорих ялын дээд хэмжээ гэж үзсэн.
- Хорих ялын интервал ямар байдлаар хуульчлагдсан нь гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаанд хамааралгүй гэж үзсэн. Учир нь Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.1-1.5-д заасан хорих, зорчих эрх хязгаарлах ялын доод, дээд хэмжээ нь таслал “,”-аар тусгаарлагдаж өөр утга санааг илэрхийлдэг учир өмнөхийн адил хорих ялын дээд хэмжээг шалгуур болгох нь зүйтэй гэж тодорхойлсон.
- Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1.2-т “хорих ялын доод хэмжээг 1 жилээс дээш” гэж заасан нь техникийн шинжтэй энгийн ойлголтод хамаарч байх ба энэ нь Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээ нь заавал “1 жилээс дээш» байхаар туйлын тодорхой хуульчлагдсан байх утга агуулгыг илэрхийлэхгүй, харин хорих ялын интервалын хувьд хорих ялыг 1 жилээс дээш хэмжээгээр оногдуулж болохоор байх шаардлага, утга агуулгыг илэрхийлсэн.
- Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын “1 жилээс 8 жил, 5 жилээс 15 жил” гэсэн интервал огт хуульчлагдаагүй байгаа нь хөөн хэлэлцэх хугацааг хорих, зорчих эрх хязгаарлах ялын интервалаар тодорхойлох ёсгүй гэдгийн жишээ гэж үзсэн.
- 1 жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулж болохоор, гэхдээ дээд хэмжээ нь 8 жилээс хэтрэхгүй байх шалгуурт нийцэх хорих ялын харилцан адилгүй доод, дээд хэмжээ бүхий интервалтай гэмт хэргүүдэд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг хамаарна.
- Тухайн шүүхийн шийдвэрийн үндэслэлүүдийг харахад одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн зохицуулалттай нийцэхгүй байгаа нь харагдаж байна. Хорих болон зорчих эрх хязгаарлах ялын дээд хэмжээ нь гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тооцох үндэслэл болдог, “,”-аар тусгаарлагдсан байгаа нь ялын дээд хэмжээ болон доод хэмжээг ялгаж авч үзсэн, 1 жилээс дээш гэдэг нь техникийн шинжтэй ойлголт гэсэн тайлбар нь хууль зүйн техник, Эрүүгийн хуулийн тодорхой байх буюу “lex certa” зарчимтай зөрчилдөж байна. Таслал нь Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”³⁸-д дараах нөхцөлд бичигдэхээр зохицуулагдсан.
- Өгүүлбэрийн зэрэгцсэн гишүүн хэд хэдэн үг, хоршоо үгээс бүтсэн бөгөөд таслал тавихгүй бол утга бүрхэгдэх тохиолдолд хооронд нь таслал тавина.

38 <https://www.legalinfo.mn/annex/details/7334?lawid=11993>.

- Өгүүлбэрийн зарим дэд гишүүн нь дараагийн үгтэй шууд холбогдохгүй, нэг буюу хэдэн үгийг алгасч өөр үгтэй холбогдох тохиолдолд таслал тавина.
- Нийлмэл өгүүлбэрийн өгүүлэхүүн нь үйлт нэр буюу нэр үгийн аймгийн үг байгаа тохиолдолд дараагийн үгийн тодотгол мэт ойлгогдох тул таслал тавина.
- Өгүүлбэрийн төгс өгүүлэхүүний дараа дэд гишүүн орвол хооронд нь таслал тавина.
- Зүйлийн нэг хэсэг дотор орсон хэд хэдэн үйлдэл нь бие даасан цогц үйлдэл биш тохиолдолд тэдгээрийн хооронд таслал тавина. Хуулийн зүйлийн нэг хэсэгт хэд хэдэн үйлдэл, шаардлагыг хооронд нь таслалгүйгээр бичсэн тохиолдолд тэдгээр үйлдлийг бүгдийг хийх, шаардлагуудыг нэгэн зэрэг бүгдийг хангасан байх ёстой гэж ойлгогдоно. Харин таслалтайгаар бичсэн тохиолдолд аль нэг үйлдлийг хийх эрх олгосон буюу аль нэг шаардлагыг хангаж болно гэж ойлгогдоно.
- Хуулийн төслийн эх бичвэрт таслал тавихдаа агуулгыг сайтар ойлгож хэрэглэнэ. Тухайлбал, хуулийн төслийн зүйлийн нэг хэсэг дотор хэд хэдэн үйлдэл орсон бөгөөд эдгээр нь бүхэлдээ нэг цогц ажиллагааг илэрхийлж байгаа бол үйлдэл хооронд таслал тавихгүй.
- Таслал нь хуулийн төслийн эх бичвэрийн утга агуулгыг тодорхойлоход чухал үүрэгтэй болохыг анхаарах нь зүйтэй. Хуулийн төслийн эх бичвэрт таслал хэрэглэсний дараа зай авч дараагийн үгийг бичнэ.

Тухайн таслал “,” авах тохиолдлуудаас “Хуулийн төслийн эх бичвэрт таслал тавихдаа агуулгыг сайтар ойлгож хэрэглэнэ” гэх агуулгаар авч үзвэл “хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил” гэсэн нь ялын интервалаар хязгаарласан буюу нэг нэгээр нь өөрсдийг нь хязгаарласан зүй тогтол байхаар ажиглагдаж байна. Учир нь нэг жилээс дээш гэх үгийг тусад нь авч үзвэл түүнээс дээш орших бүх ял тухайн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтад хамаархаар болох үр дагавар үүснэ.

Тиймээс ялын дээд хэмжээ, доод хэмжээ нь интервалаар хуульчлагдсан тул хоёулаа нийлж нэг утга санааг илэрхийлэхээр байна.

Мөн үүнээс гадна Эрүүгийн хуулийн тодорхой байх буюу “lex certa” зарчимтай зөрчилдөж байна. Энэ зарчим нь Эрүүгийн хуульд ямар үйлдэл гэмт хэрэг болох, түүний урьдчилсан нөхцөл байдлыг тодорхой, хоёрдмол утгагүй заахаас гадна гэмт хэрэгт хүлээлгэх ялын төрөл, түүний хугацааны дээд, доод хэмжээг тодорхой заана гэсэн утгыг агуулна³⁹. Тийм учраас тухайн “хорих ялын доод хэмжээг нэг жилээс дээш, дээд хэмжээг найман жил” гэсэн зохицуулалтыг тухайн байгаа тодорхой агуулгаар нь харах нь зүйтэй буюу ялын интервалаар нь тодорхойлох ёстой.

Дараагийн асуудал нь “1 жилээс 8 жил, 5 жилээс 15 жил” гэх интервал Эрүүгийн хуулийн тусгай ангид хамаарх гэмт хэргийн интервалд тусгагдаагүй гэж шүүх үзээд тиймээс хөөн хэлэлцэх хугацааг тооцох үндэслэл нь ялын дээд болон доод хэмжээнд үндэслээгүй гэж үзсэн. Гэхдээ Эрүүгийн хуулийн тусгай ангийн гэмт хэргүүдийн 8 жилээс 15 жил, 5 жилээс 12 жил, 2 жилээс 8 жил, 1 жилээс 5 жил гэх интервалууд нь дээрх хөөн хэлэлцэх хугацаа тооцох ялын интервалуудад бүгд хамаарч тухайн гэмт хэргүүдийн ялын интервалыг шингээж, хийдэлгүй байхаар дээрх байдлаар

39 Т.Золбоо, Гэмт хэргийн бүтээц, 2016, 30 дахь тал

зохицуулсан байгаа нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн гэмт хэргийн ялын дээд болон доод хэмжээнд үндэслэсэн байх агуулгыг илэрхийлж байна.

Энэдээс дүгнэвэл, Эрүүгийн хуулийн 17.12.1-ээр зүйлчлэгдсэн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тооцохдоо шүүхүүд өөр өөрсдийн байр сууринаас тайлбарлан хэрэглэж байгаа нь эргээд хүний эрхийг зөрчихөд хүргэж болох юм.

3.2. Эрүүгийн хуулийн 17.12.2.1 буюу Мал хулгайлах гэмт хэргийг олон тооны мал хулгайлж үйлдэх үйлдлийн тухайд

2002 оны Эрүүгийн хуулиар мал хулгайлах гэмт хэргийг ердийн хулгайн гэмт хэргийн адилаар Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлд зааснаар зүйлчилж, олон тооны мал хулгайлсан тохиолдолд мөн зүйлийн 145.2 дахь хэсэгт зааснаар хүндрүүлэн зүйлчлэхээр хуульчилж, тухайн гэмт хэргийг үйлдсэн хүнд эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан байв. 2004 оны 5 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль”⁴⁰ батлагдсантай холбоотой Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “тээврийн” гэсний өмнө “тээврийн болон бусад” гэж, хуулийн 145-р зүйлийн 2 дахь хэсэгт “олон тооны мал” гэсэн үгийг тус тус нэмж өөрчлөлт оруулсан байна.

Харин 2015 оны Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Энэ гэмт хэргийг: 2.1.олон тооны мал хулгайлж; 2.2.бүлэглэж; 2.3.улсын хилээр нэвтрүүлж; 2.4.машин механизм ашиглаж; 2.5.ноцтой хохирол, хор уршиг учруулж; 2.6.гойд ашиг шимт малыг хулгайлж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэж хуульчилсан. Мөн олон тооны мал хулгайлсан гэж хуулийн аутентик тайлбарт тайлбарласнаар “олон тооны мал” гэдэгт найман бог, хоёр бод, түүнээс дээш малыг ойлгох ба богийг бодод шилжүүлэхдээ нэг бодыг дөрвөн богоор тооцохоор зохицуулсан байна. Энэ нь 2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр орж ирсэн зохицуулалт ба нэмэлт, өөрчлөлт орохоос өмнө “олон тооны мал” гэж хорин дөрвөн бог, найман бодоос дээш малыг ойлгоно. Богийг бодод шилжүүлэхдээ нэг бодыг гурван богоор тооцно.” гэж тайлбарлаж байсан. Өмнө нь “мал”, “олон тооны мал” гэх ойлголтуудыг “Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай” УДШ-ийн 2006 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 28 дугаар тогтоолоор тайлбарлан хэрэглэж байсан юм. “Мал”, “олон тооны мал” гэх ойлголтуудыг ийнхүү хуульд тайлбарласнаар өмнөх хуулийн зохицуулалтаас илүү нарийвчилсан бөгөөд боловсронгуй болжээ.

2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн Эрүүгийн хуульд оруулсан өөрчлөлтөөр “олон тооны мал” гэх ойлголтод хамаарах малын тоог цөөрүүлж өөрчилснийг хуулийн үзэл баримтлалд “...гэмт-хэрэг үйлдэгчдийн ашиглаж буй бага оврын тээврийн хэрэгсэлд дөрвөөс илүү бод мал ачих боломжгүй байдаг учир хүндрүүлж үзэх нөхцөл байдлаар ял шийтгэх боломжгүй байдаг бөгөөд улмаар мал хулгайлах гэмт хэрэг үйлдэгчдэд ижил хэмжээний хохирол бүхий бусад төрлийн хулгайлах гэмт хэргээс харьцангуй хөнгөн ял, шийтгэл оногдуулж байгаа нь шударга бус бөгөөд гэмт хэрэгтнийг өөгшүүлэх, давтан хэрэг үйлдэх нөхцөл бүрдүүлж байгаа”⁴¹ хэмээн тайлбарлажээ.

40 Төрийн мэдээлэл эмхэтгэл, № 23 2004.

41 Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, баталсан УИХ-ын гишүүн Х.Болорчулуун.

Гэмт хэргийн бүрэлдэхүүн нь тодорхой төрлийн нийгэмд аюултай хэргийн шинжийг улс орны хэмжээгээр нэг мөр, нэгдмэл ойлгож хэрэглэх боломжийг олгодог⁴² учир гэмт хэргийн бүрэлдэхүүнд аливаа өөрчлөлт оруулахын тулд үндэслэл болох судалгаа нь мөн улс орны хэмжээнд хийгдсэн байх шаадлагатай. Гэвч төслийн үзэл баримтлалд дурдсанаар хууль санаачлагч өөрийн цахим хаягаар авсан санал болон 2019 оны 04 дүгээр сарын 10-наас 05 дугаар сарын 01-ний хооронд Дорнод аймгийн Булган, Гурванзагал, Сэргэлэн, Хэрлэн, Чойбалсан сумд зохион байгуулагдсан давхардсан тоогоор 550 гаруй иргэдийн оролцсон уулзалт хэлэлцүүлэгт иргэдээс бичгээр болон амаар гаргасан саналыг⁴³ л үзэл баримтлалд хавсаргасан байна.

Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн аутентик тайлбар нь төслийн үзэл баримтлалд дурдсан “өөгшүүлэх, давтан хэрэг үйлдэх нөхцөл бүрдүүлж байгаа” гэдгийг хангалттай нотлох баримтыг төсөл санаачлагч гаргаагүй ч уг дэвшүүлсэн саналын талаар авч үзэх шаардлагатай.

“Монгол Улсын Гэмт хэргийн цагаан ном 2018”-д дурдсанаар цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн мал хулгайлах гэмт хэргийг урьд ял шийтгэгдсэн этгээд үйлдсэн тохиолдол 2017 онд 57 байсан бол 2018 онд 101 болж нэмэгдсэн⁴⁴. Гэвч энэхүү урьд ял шийтгэгдсэн этгээд гэдэгт ямар гэмт хэргийн улмаас ял шийтгэгдсэн тухай мэдээлэл байхгүй байна. Мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээд өмнө нь энэхүү гэмт хэргийг үйлдсэн, эсвэл бусад төрлийн өмчийн эсрэг гэмт хэрэг үйлдэж байсан нь Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн хэрэгжилт, үр дүнг тодорхойлох ёстой гэж үзэж байна.

Иймд Хуульд “олон тооны мал” гэх ойлголтод хамаарах малын тоог “хорин дөрвөн бог, найман бодоос дээш” гэж, “нэг бодыг дөрвөн богоор” хэмээн заасан нь гэмт этгээд хэргийг давтан үйлдэх шалтгаан болсон гэж үзэх үндэслэл хангалттай тогтоогдохгүй байна.

Цагдаагийн алба хаагчдаас уг зүйл, заалттай холбоотой дараах асуулгыг авахад доорх үр дүнг үзүүлэв.

Хүснэгт 4.19. Асуулга 15. “2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар энэ зүйлд заасан “олон тооны мал” гэж 24 бог, 8 бодоос дээш малыг ойлгодог байсныг 8 бог, 2 бод, түүнээс дээш малыг ойлгохоор, богийг бодод шилжүүлэхдээ 1 бодыг 3 богоор тооцдог байсныг 4 богоор тооцдог болгож цөөрүүлэн өөрчилсөн нь зөв үү, та юу гэж бодож байна вэ?”

Д/д	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1.	Зөв	27	64.3
2.	Буруу	7	16.7
3.	Мэдэхгүй	8	19
Нийт		42	100

42 С.Нарангэрэл, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги, 1999, 110 дахь тал

43 Хууль, тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн тайлан, <http://forum.parliament.mn/projects/10696>

44 Монгол Улс дахь Гэмт хэргийн цагаан ном, 2018

Уг асуулгад 110 алба хаагчаас 42 нь хариулт өгсөн бөгөөд үүнээс “Зөв” гэж хариулсан 27, “Буруу” гэж хариулсан 7, “Мэдэхгүй” гэж хариулсан 8 байна. Тиймээс практикт тухайн нэмэлт, өөрчлөлт нь эерэг үр дагавар бүхий зохицуулалт болсон гэж үзэж болохоор байна.

Хүснэгт 4.20. Асуулга 16. Дээрх өөрчлөлт нь гэмт хэргийн гаралтад хэрхэн нөлөөлж байгаа вэ? Уг хэсгийн хэрэгжилтийг та хэрхэн үнэлэх вэ?”

Д/д	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1.	Сайнаар нөлөөлж байгаа	44	67.7
2.	Мэдэхгүй байна	10	15.4
3.	Байхгүй	8	12.3
4.	Муугаар нөлөөлж байгаа	3	4.6
Нийт		65	100


Уг асуулгад 110 алба хаагчаас 70 нь хариулт өгсөн бөгөөд асуулгад оролцогсдын дийлэнх нь сайнаар нөлөөлж байна гэж хариулснаас харахад тухайн зохицуулалтыг практик дахь хууль хэрэгжүүлэгч цагдаагийн алба хаагчид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон бусад байдлаар сайн үр нөлөө бүхий зохицуулалт хэмээн эерэгээр үнэлжээ.

Гэвч цагдаагийн байгууллагын тоон мэдээнд мал хулгайлах гэмт хэргийг олон тооны мал хулгайлж үйлдсэн хэрэг 2019 онд 161 бүртгэгдэж байсан бол ЭХ-д оруулсан өөрчлөлт хэрэгжиж эхэлсэн 2020 онд 314 бүртгэгдсэн нь 95 хувиар нэмэгдсэн дүн байна. Үүгээр зогсохгүй 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар олон тооны мал хулгайлсан хэрэг 126 бүртгэгдсэн нь оны нэгдүгээр хагасын тоо гэхэд өндөр үзүүлэлт юм.

Дээрх өсөлтийг “олон тооны мал” гэх ойлголтод хамаарах малын тоог цөөрүүлсөнтэй холбоотой хэмээн тайлбарлаж болох ч 2020 онд мал хулгайлах 1041 хэрэг бүртгэгдэж, өмнөх оноос 768 (42.5%)-аар буурсан атал зөвхөн уг хүндрүүлэх нөхцөл байдлаар үйлдсэн тоо өссөн, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт удаа дараа улс орон даяар шилжиж хөл хорио тогтоосон, үүнтэй холбоотойгоор авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоодын шалгалт сайжирсан зэргийг анзааралгүй орхиж болохгүй.

“Олон тооны мал” гэх ойлголтод хамаарах малын тоог цөөрүүлсэн нь ялын бодлогыг чангатгах зорилготой ч гэмт этгээдийн нэг удаагийн үйлдлээр хулгайлах малын тоо нэмэгдэх эрсдэлтэй. Иймд уг өөрчлөлт хэрэгжиж эхэлснээр хулгайлагдсан малын тоо хэрхэн өөрчлөгдсөнийг шалгах шаардлагатай байна. Үүний тулд мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдийн тоо, бүртгэгдсэн тус гэмт хэргийн тоо, хулгайлагдсан малын тоог харьцуулах юм.

График 4.9. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн тоо, гэмт хэргийн тоо, хулгайлагдсан малын тоог харьцуулсан нь



Дээрх графикаас харвал 2013-2016 оны хооронд хулгайлагдсан малын тоо тогтмол өссөн, гэмт хэргийн тоо буурсан, гэмт хэрэгт холбогдогчийн тоо 2014 онд өсөж, 2016 онд огцом буурсан байна. Энэ нь ЭХ-ийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхлэхээс өмнө нэг удаагийн үйлдлээр хулгайлах малын тоо тогтвортой буурч байсныг илтгэж байна. Харин 2017 онд буюу шинэчлэн найруулсан ЭХ хэрэгжиж эхэлсэн жил бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өсөж, хулгайлагдсан малын тоо, уг гэмт хэрэгт холбогдогчийн тоо буурсан байгаа нь гэмт этгээд олон тооны мал хулгайлахаас зайлсхийснийг харуулж байна.

2018 онд өмнөх оноос гэмт хэргийн тоо, малын тоо, холбогдогчийн тоо аль аль нь өссөн дүнтэй бол, 2019 онд хулгайлагдсан малын тоо буурч, гэмт хэрэг болон уг гэмт хэрэгт холбогдогчийн тоо өссөн байгаа нь мөн л нэг удаагийн гэмт хэргээр хулгайлах малын тоо буурсан буюу гэмт этгээд олон тооны мал хулгайлахаас зайлсхийснийг харуулж байна.

Харин 2020 онд хулгайлагдсан малын тоо өмнөх оноос 4262-оор буюу 33 орчим хувиар өсөж, бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оноос 42 хувиар, тухайн гэмт хэрэгт холбогдогчийн тоо 24 хувиар тус тус буурчээ. Энэ нь гэмт этгээдийн нэг удаагийн гэмт хэргээр хулгайлах малын тоо огцом өссөнийг илтгэж байна.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа тодорхой тоо баримт, судалгаанд хангалттай үндэслэлгүй, тус өөрчлөлт хэрэгжиж эхэлсэн үеэс холбогдох хэсэгт зааснаар үйлдэгдсэн гэмт хэрэг огцом өссөн, гэмт этгээдийн нэг гэмт хэргээр хулгайлах малын тоо мөн огцом өссөн зэргээс 2020 оны Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар өөрчилсөн Эрүүгийн хуулийн 17.12.2.1 дэх хэсгийн хэрэгжилт хангалтгүй хэмээн дүгнэж байна.

3.3.Эрүүгийн хуулийн 17.12.2.2 буюу мал хулгайлах гэмт хэргийг бүлэглэж үйлдэх үйлдлийн тухайд

Мал хулгайлах гэмт хэргийг бүлэглэж үйлдэх арга хэлбэр, орчин үеийн чиг хандлага өөрчлөгдөж байгаа талаар өмнө дурдсан билээ. Тус зүйл, заалтын хүрээнд холбогдох шүүхийн шийдвэрийг дор авч үзье.

Хүснэгт 4.21. Шүүхийн шийдвэрийн харьцуулалт №2

Д/д	Гэмт хэргийн зүйл анги	Шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолын дугаар	Шийдвэрлэсэн он, сар, өдөр	Шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт хууль тайлбарласан байдал	Оногдуулсан ялын төрөл, хэмжээ
1.	17.12.2.1.	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх 2021/ШЦТ/ 04	2021.01.15	Шүүгдэгч Ж.Ц, Г.О, Э.З нарыг бүлэглэж буюу гэмт үйлдэлдээ санаатай нэгдэж, бусдын олон тооны малыг хулгайлах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй.	Тус бүр 1 жил хорих
2.	17.12.2.1.	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх Дугаар 03	2021.01.14	шүүгдэгч Б.Э нь өөрийн үхэр биш, ах нь хүний мал хулгай хийсэн гэдгийг мэдсээр байж үхрүүдийг нядалж, Замын-Үүд суманд зарж борлуулах ажлыг гардаж гүйцэтгэсэн байх тул шүүгдэгч нар нь энэ гэмт хэргийг санаатай нэгдэж буюу бүлэглэж, гүйцэтгэсэн гэж үзэх үндэслэлтэй	Тус бүр 1 жил хорих
3.	17.12.2.1.	Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан	2021.01.14	Шүүгдэгч Т, Б, Б нар нь ярилцаж тохиролцоод бусдын малыг хулгайлах гэмт хэргийг үйлддэг, нийтдээ 25 тооны бод малыг үргэлжилсэн	Т, Б нарт тус бүр 2 жил хорих ял, шүүгдэгч Б-т 2 жил

Шүүхийн шийдвэрүүдээс үзвэл, гэмт хэрэгт бүлэглэх гэдгийг шүүх нийтлэг байдлаар “гэмт хэргийг хоёр, түүнээс олон хүн санаатай нэгдэж үйлдсэн бол бүлэглэн гүйцэтгэх гэнэ” хэмээх ойлголтоор тайлбарласан байх ба ийнхүү зүйчлэхдээ гэмт хэргийг гүйцэтгэгчдийн үйлдлийг нэгтгэн зүйлчилж гүйцэтгэгч тус бүрийн гэмт хэргийг үйлдэхэд гүйцэтгэсэн үүрэг, оролцоог харгалзан ялыг ялгамжтай оногдуулсан нь эрүүгийн эрх зүйн онолд нийцүүлж, тайлбарлан хэрэглэсэн байгааг харуулж байна.

Цагдаагийн алба хаагчдаас уг зүйл, заалттай холбоотой дараах асуулгыг авахад доорх үр дүнг үзүүлэв.

Хүснэгт 4.22. Асуулга 1 “Мал хулгайлах гэмт хэргийг бүлэглэн үйлдэх гэдэгт та юуг ойлгож байна вэ?”

Д/д	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1.	Бүлэглэн хулгайлах	78	32.5
2.	Хулгайн мал, махыг тээвэрлэх, худалдан борлуулах	57	23.8
3.	Ашиг орлогоо хуваах	54	22.5
4.	Хулгайн малыг нядлах, төхөөрөх	41	17.1
5.	Бүгд орно	8	3.3
6.	Үр дагаврыг мэдсээр байж хамтран оролцсон	1	0.4
7.	Бод малыг хулгайлахад заавал хамтран оролцох шаардлагатай	1	0.4
Нийт		240	100

Уг асуулгад 110 алба хаагчаас 105 нь хариулсан бөгөөд давхардсан байлаар бүлэглэн хулгайлах, хулгайн мал, махыг тээвэрлэх, худалдан борлуулах, ашиг орлогоо хуваах, хулгайн малыг нядлах, төхөөрөхөд хамтарч оролцсоныг ойлгохоор дийлэнх нь хариулсан байна.

Хүснэгт 4.23. Асуулга 19 “Мал хулгайлах гэмт хэргийг бүлэглэн үйлдэхэд бусад төрлийн гэмт хэргийг бүлэглэн үйлдэхээс ялгаатай эсэх, ялгаатай бол ялгагдах тодорхой шинжийг дурдана уу?”

Д/д	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1.	Урьдчилж тохирч зохион байгуулалтад орох	12	28.6
2.	Ашиг олох зорилгоор	9	21.4
3.	Ялгаагүй	8	19
4.	Худалдан борлуулж, мөнгө угаадаг	4	9.5
5.	Гарал үүслийн гэрчилгээ гаргадаг	3	7.1
6.	Үйлдлийг хялбарчлах зорилгоор бүлэглэдэг	3	7.1
7.	Махны ченжтэй бүлэглэдэг	1	2.4
8.	Давтамжаа ихэсгэхийн тулд	1	2.4
9.	Тээвэрлэх замаар бүлэглэдэг	1	2.4
Нийт		42	100

Уг асуулгад 110 алба хаагчаас 42 алба хаагч тодорхой хариулт өгсөн байна. Үүнээс “Урьдчилж тохирч зохион байгуулалтад орох” гэж хариулсан 12, “Ялгаагүй” гэж хариулсан 8, “Ашиг олох зорилгоор” гэж хариулсан 9, “Худалдан борлуулж, мөнгө угаадаг” гэж хариулсан 4, “Гарал үүслийн гэрчилгээ гаргадаг” гэж хариулсан 3, “Үйлдлийг хялбарчлах зорилгоор бүлэглэдэг” гэж хариулсан 3, “Махны ченжтэй бүлэглэдэг” гэж хариулсан 1, “Давтамжаа ихэсгэхийн тулд” гэж хариулсан 1, “Тээвэрлэх замаар бүлэглэдэг” гэж хариулсан 1 цагдаагийн алба хаагч тус тус байна.

Эрүүгийн хуулийн 3.7 дүгээр зүйлийн 1-д буюу “Гэмт хэргийг хоёр, түүнээс олон хүн санаатай нэгдэж үйлдсэн бол бүлэглэн гүйцэтгэх гэнэ.” гэж заасан бүлэглэн гүйцэтгэх үйлдлийг Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйл буюу мал хулгайлах гэмт хэргийн хувьд шүүхийн практикт нэгдмэл байдлаар ойлгож байна. Харин цагдаагийн алба хаагч буюу хууль сахиулагчийн мөрдөн шалгах ажиллагааны практикийн тухайд гэмт хэргийг бүлэглэн гүйцэтгэх арга, хэлбэр нь орчин үед олон янзын аргаар үйлдэгдэж байгаа нь харагдаж байна.

3.4. Эрүүгийн хуулийн 17.12.2.3 буюу Мал хулгайлах гэмт хэргийг улсын хилээр нэвтрүүлж үйлдэх үйлдлийн тухайд

Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн гэдэг хүндрүүлэх нөхцөл нь 2002 оны Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйлийн 123.1 буюу Садар самуун сурталчлах гэмт хэрэг, 188 дугаар зүйлийн 188.1 буюу Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах буюу хордуулах, цацраг идэвхт, тэсэрч дэлбэрэх бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх гэмт хэрэг, 193 дугаар зүйлийн 193.1 буюу Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг үйлдвэрлэх, бэлтгэх журам зөрчих гэмт хэрэг, 205 дугаар зүйлийн 205.1 буюу Байгаль орчныг бохирдуулах гэмт хэргийн зохицуулалтуудад тус тус хуульчлагдсан байсан.

Харин 2015 оны Эрүүгийн хуульд тухайн нөхцөл нь 13.1 дүгээр зүйлийн 2.3 буюу Хүн худалдаалах гэмт хэрэг, 17.12 дугаар зүйлийн 2.3 буюу мал хулгайлах гэмт хэрэг, 18.4 дүгээр зүйлийн 1 буюу Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент, ашигтай загварын гэрчилгээ эзэмшигчийн эрхийг зөрчих гэмт хэрэг, 18.16 дугаар зүйлийн 1 буюу Барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгчийн эрхийг зөрчих гэмт хэрэг, 18.16 дугаар зүйлийн 1 буюу Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчих гэмт хэрэг, 20.7 дугаар зүйлийн 1 буюу Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг, 20.11 дүгээр зүйлийн 1 буюу Аюултай хог хаягдал, химийн хорт, аюултай бодисыг хаях гэмт хэрэг, 24.3 дугаар зүйлийн 1 буюу Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах гэмт хэргүүдэд тус тус хульчлагджээ.

Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн гэдэг нөхцөлийг тодорхойлсон олон тодорхойлолтууд бий. 2003 оны 07 дугаар сарын 09 - ний Улсын дээд шүүхийн “Эрүүгийн хуулийн 175 дугаар зүйлийг тайлбарлах тухай” 24 дүгээр тогтоолд тодорхойлсноор “Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн” гэдэгт зохих зөвшөөрөлгүйгээр, гаалийн үзлэгээс гадуур, хилийн боомтгүй газраар, эсхүл гаалийн үзлэгээс нуун далдлах, тухайн эд зүйлийн нэр, төрөл, тоо хэмжээ, хэлбэр дүрс, баглаа боодлыг өөрчлөх, түүнчлэн гаалийн баримт бичиг болон гаалийн лац ломбыг хуурамчаар үйлдэх, засварлах, гаалийн мэдүүлэгт бичихгүй орхих буюу худал бичих зэрэг аргаар энэ зүйлд тухайлан заасан эд зүйлсийг улсын хилээр эсвэл Монгол Улсын Гаалийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “...гаалийн хяналтын талбайн хил нь тухайн хэсэгтээ гаалийн хилд тооцогдоно” гэсэн заалтад хамаарах гаалийн хяналтын талбайн хилээр гаргасан, оруулсан, дамжин өнгөрүүлсэн үйлдэл /эс үйлдэхүй/ хамаарна гэж тус тус тайлбарласан байдаг. Үүнээс хууль бусаар гэдэг шинжид хамаарах тодорхойлолт нь одоогийн хуулийн тухайн зохицуулалтаас ялгаатай байна.

Харин 2015 оны Эрүүгийн хуульд “Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн” гэдгийг өөрөөр тодорхойлж байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 18.4 дүгээр зүйлийн 1 буюу Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент, ашигтай загварын гэрчилгээ эзэмшигчийн эрхийг зөрчих гэмт хэрэгт “Улсын хилээр нэвтрүүлсэн” гэдэгт эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр үйлдвэрлэсэн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент, ашигтай загварын бүтээгдэхүүнийг Монгол Улсын хилээр зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй гаргахыг ойлгоно⁴⁵. Тухайн тодорхойлолтоос авч үзвэл, Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 2.3-т заасан гэмт хэрэг нь бусдын малыг хулгайлж, тухайн малыг Монгол Улсын хилээр зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй гаргах агуулгатай болж байна.

2008 оны Гаалийн тухай хуулийн 3.1.1-т зааснаар “бараа” гэж гаалийн хилээр нэвтрүүлэх ачаа, тээш, эд юмс, валют, валютын үнэт зүйл, улс хоорондын шуудангийн илгээмж, бүх төрлийн эрчим хүч, мал, амьтан, ургамал зэрэг хөдлөх эд хөрөнгө болон энэ хуулийн 3.1.5-д зааснаас бусад тээврийн хэрэгслийг хэлнэ гэснээр Эрүүгийн хуульд тодорхойлсон мал нь бараа гэх тодорхойлолтод хамааран нийтлэг процессыг дамжин улсын хилийг нэвтэрдэг байна.

2002 оны Эрүүгийн хууль үйлчилж байхад 145.2 дугаар зүйлээр тухайн гэмт хэрэг зүйлчлэгдэж байх үед тухайн төрлийн гэмт хэрэг их гардаг байсан байна. Тухайлбал, Хятад, Турк, ОХУ руу мал, мах гаргах үйл ажиллагаатай уялдан

45 С.Гантулга, Б.Энхболд, Эрүүгийн эрх зүй Тусгай анги, 2018, 218 дахь тал

зарим аймагт мал хулгайлах гэмт хэрэг үйлдэгдэх хандлага байна. Хил давуулан мал хулгайлах гэмт хэргийг зонхилон адуу хулгайлах гэмт хэрэг эзэлж байгаа ба ялангуяа улсын алдар цолтой уяач, бөхчүүд нь энэ төрлийн гэмт хэрэгт холбогдож хурдан удмын үржил сайтай адууг бусад хүмүүсээр хулгайлуулан, зарж борлуулдаг мэдээлэл байна.⁴⁶

“Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн” гэх үндэслэлийг 2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр Эрүүгийн хуульд нэмсэнээс хойш өнөөг хүртэл 17.12 дугаар зүйлийн 2.3-аар шийдвэрлэгдсэн шүүхийн шийдвэр байхгүй байна.

Харин 2020 оны 01 дүгээр сарын 16-наас хойш тухайн гэмт хэрэг үйлдэгдээгүй талаар шалтгаан нөхцөлийг Шинэ төрлийн коронавирусын халдварын эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдтэй холбоотой гэж таамаглаж байна. Тухайлбал, 2020 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн “Хилийн зарим боомтыг түр хаах, нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах тухай” Монгол Улсын Засгийн газрын дугаар 39 тогтоолоос хойш шат дарааллан улсуудтай хилээ хаасан ба 2021 оны 06 сарын 01-нээс хилээ зарим улсуудтай нээж эхэлсэн. Тухайн нөхцөл байдал нь улсын хил нэвтрүүлж мал хулгайлах гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлж буй томоохон шалтгаан, нөхцөлүүдийн нэг гэж үзэж болох юм.

Мөн үүнээс гадна малыг амьдаар нь экспортод гаргах 2014 оны 282 дугаар тогтоол /Ерөнхий сайд Н.Алтанхуяг/, 2015 оны 474 дүгээр тогтоол /Ерөнхий сайд Ч.Сайханбилэг/, 2017 оны 142 дугаар тогтоол /Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат/, 2017 оны 284 дүгээр тогтоолыг 2019 оны 07 сарын 03-ны Засгийн газрын шийдвэрээр цуцалсан байна⁴⁷. Түүнчлэн үржлийн мал амьтныг тарифын бус хязгаарлалттай нэвтрүүлэх барааны жагсаалтад хамааруулан үзсэн⁴⁸. Гаалийн тухай хуулийн 3.1.14-т зааснаар “тарифын бус хязгаарлалт” гэж Монгол Улсын хилээр бараа нэвтрүүлэхийг хориглох, эсхүл эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, тоон хязгаарлалт тогтоох болон бусад арга хэмжээг хэлнэ. Дээрх хязгаарлалтын дагуу 2019 онд нийт 171 адуу, 200 хонийг амьдаар нь экспортод гаргасан байна⁴⁹. Үүнээс дүгнэвэл, тухайн зохицуулалтууд нь мал хулгайлах гэмт хэргийг улсын хил нэвтрүүлэн үйлдэхээс урьдчилан сэргийлсэн алхмууд гэж үзэж болохоор байна.

Хуулийн дагуу улсын хил нэвтрүүлэхэд дээрх шалтгаан, нөхцөл хамаардаг бол хууль бусаар улсын хил нэвтрүүлэхийн тухайд цагдаагийн байгууллага урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхой хэмжээнд хэрэгжүүлж байна. Тухайлбал, 2021 оны эхний хагас жилд ОХУ-тай хил залгаа оршдог Баян-Өлгий, Булган, Дорнод, Завхан, Сэлэнгэ, Увс, Хөвсгөл, Хэнтий аймаг дахь Цагдаагийн газруудтай, үйлдэгдсэн хил дамнасан мал хулгайлах гэмт хэргүүдийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх арга тактикийг боловсронгуй болгох хүндрэл бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх зорилгоор 2021 оны 3 дугаар сарын 22-ны өдөр цахим хурал зохион байгуулж дэд дарга, цагдаагийн дэд хурандаа Э.Товуудорж

46 Монгол улсын цагдаагийн ерөнхий газар мэдээлэл, судалгааны төв, Монгол улс дахь 2010 оны гэмт хэргийн байдал, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам: Мал хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөл, анхаарах зарим асуудал сэдэвт судалгааны ажлын тайлан”, 2011, 137 дахь тал

47 Ч.Ариунболд, Малыг амьдаар нь экспортод гаргахгүй нийтлэл, 2019.07.03.

48 Монголын гааль: Хориглосон, хязгаарласан барааны жарсаалт, <https://customs.gov.mn/2012-03-14-03-21-37/inspection/2014-03-24-06-16-45>.

49 Манай улс өнгөрсөн онд 171 адуу, 200 хонийг амьдаар нь экспортолжээ, 2020.04.09, <http://eagle.mn/r/70983>.

алба хаагчдад үүрэг чиглэл өгч, танилцуулгыг албаны даргад хүргүүлсэн⁵⁰ гэх мэт урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Мал хулгайлах гэмт хэргийг үйлдэхдээ малыг улсын хилээр хуулийн дагуу болон хууль бусаар нэвтрүүлэх аль ч үйлдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь хэрэгжихдээ зөвхөн тухайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс гадна бусад нөхцөл байдлын улмаас хамаарах зохицуулалтаар тухайн гэмт хэргээс урьдчилан сэргийлж байгаа нь ажиглагдаж байна.

Эндээс Эрүүгийн хуулийн 17.12.2.3 нь бусад хууль тогтоомжтой уялдаж тухайн төрлийн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх сайн үр дүнг үзүүлж байна хэмээн дүгнэж болох юм.

3.5. Эрүүгийн хуулийн 17.12.2.4 буюу Мал хулгайлах гэмт хэргийг машин механизм ашиглаж үйлдэх үйлдлийн тухайд

Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 2.4-т мал хулгайлах гэмт хэргийг машин механизм ашиглаж үйлдсэн гэх хүндрүүлэх шинжийг хуульчилсан. Үүнийг онолын үүднээс тодорхойлохдоо машин механизм ашиглаж мал хулгайлахыг гэмт хэрэг үйлдэх арга болгож, машин техник хэрэглэснийг гагцхүү үүнд хамааруулна гэж үзсэн.⁵¹ УДШ энэ шинжийг тайлбарлахдаа “...үйлдлийг хөнгөвчлөх, түргэтгэх, эд хөрөнгө байгаа газарт түргэн очиж буцах, хамгаалалт бэхэлгээг эвдлэх, биеэр авч явж чадахгүй эд хөрөнгөд хүрэх” хэмээн тайлбарласан байдаг.

Машин механизм гэдэгт хүн, ачаа тээвэрлэх зориулалттай бүх төрлийн автомашин, мотоцикл, трактор, өөрөө явагч бусад машин болон өргөх буулгах, ухах малтах, түрэх, цоолох, зүсэх зориулалттай машин, механизмууд хамаарна.⁵²

2002 оны Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсэгт заасан “машин механизм” гэдгийг УДШ 2006 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 28 дугаар тогтоолд тайлбарлахдаа хүн, ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автомашин, мотоцикл, трактор, өөрөө явагч бусад машин болон өргөх, буулгах, ухах, малтах, түрэх, цоолох, зүсэх зэрэг зориулалттай машин механизмууд хамаарна гэж, “Машин механизмыг хэрэглэсэн” гэдгийг бусдын эд хөрөнгийг хулгайлах үйлдлээ хөнгөвчилж түргэтгэх, хамгаалалт, бэхэлгээг эвдэх, биеэр авч чадахгүй эд хөрөнгөд хүрэх, зөөж тээвэрлэх зорилгоор урьдчилан бэлтгэж ашигласныг ойлгохоор заажээ. Харин хулгайлах үйлдэл төгссөний дараа түүнийг зөөж тээвэрлэх, хэргийн газраас зайлуулах зэрэгт машин механизм ашигласныг энэ ойлголтод хамааруулахгүй⁵³ гэж тайлбарласан байдаг.

50 Эрүүгийн цагдаагийн албаны хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс 2021 оны эхний хагас жилд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний танилцуулга, 2021.06.25.

51 С.Нарангэрэл, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Тусгай анги, 1998, 122 дахь тал.

52 С.Гантулга, Б.Энхболд, Эрүүгийн эрх зүйн тусгай анги, сурах бичиг, 2018) 204 дэх тал.

53 Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай, УДШ-ийн 2006 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 28 дугаар тогтоол.

Тиймээс машин механизмыг гэмт этгээд өөрийн үйлдлийг хөнгөвчлөх, түргэтгэх, эд хөрөнгө байгаа газарт түргэн очиж буцах, хамгаалалт бэхэлгээг эвдлэх, биеэр авч явж чадахгүй эд хөрөнгөд хүрэхэд ашигладаг бөгөөд ингэснээр уг үйлдэл нь хор уршгийн хувьд үндсэн бүрэлдэхүүнээс илүү болж хүндрүүлэн зүйчлэх шаардлагыг бий болгож байдаг.

Иймд машин механизм гэх ойлголтыг практикт хэрхэн хэрэглэж байгааг тодорхойлох, судлах шаардлагатай байх тул шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх болон анкетын асуулгын аргаар цагдаагийн алба хаагчдаас судалгаа авсан бөгөөд дараах үр дүнг үзүүлсэн.

Хүснэгт 4.24. Шүүхийн шийдвэрийн харьцуулалыг №3

Д/д	Гэмт хэргийн зүйл анги	Шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолын дугаар	Шийдвэрлэсэн он, сар, өдөр	Шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт хууль тайлбарласан байдал	Оногдуулсан ялын төрөл, хэмжээ
1.	17.12.2.4	УДШ Дугаар 04	2020.12.23	Шүүгчдэгчийн өмгөөлөгч мотоциклийг машин механизм биш хэмээн үзэж гомдол гаргасныг харгалзан үзэж “...малыг хулгайлах гэмт хэргийг үйлдэх явцад техник хэрэгсэл /мотоцикл/-ийг ашигласан эсэх хэргийн үйл баримтыг сэргээн тогтоож, анхан шатны шүүх шүүгчдэгч нараас хуулийн зохицуулалтын агуулгад нийцэж буй эсэхэд эрх зүйн зөв дүгнэлт өгөх нь зүйтэй.” гэж үзсэн ч тайлбар хийгээгүй байна.	Давж заалдах шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаасан
2.	17.12.2.1	Увс аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Магадлал Дугаар 54	2020 оны 12 сарын 18 өдөр	Шүүгчдэгч нар нь Улаангом сумын төвөөс 190 гаруй км орчим зайд байрлах хэргийн газар /тэмээ бэлчээрлэж байсан нутаг/-т Ц.Ш-ийн эзэмшлийн УВЗ улсын дугаартай мотоциклыг ашиглан очихоор урьдчилан тохиролцож, уг тээврийн хэрэгслийг ашиглан хэргийн газарт очсоныг “гэмт үйлдлээ хөнгөвчилж түргэтгэх, хэргийн газар хүрэх зорилгоор уг тээврийн хэрэгслийг ашигласан байхад шүүх “хэргийн газарт мотоциклоор хүргүүлсэн үйлдлийг машин механизм ашигласан гэж үзэхгүй” гэж Эрүүгийн хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн байна.	Анхан шатны шүүхэд буцаасан
3.	17.12.2. 117.12.2. 217.12.2.4	Хэнтий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн Шийтгэх тогтоол 2021/ШЦТ/68	2021 оны 03 сарын 25 өдөр	Шүүгчдэгч нар нь гэмт хэрэг үйлдэхдээ benny маркийн мотоцикл болон 37-91 БРА улсын дугаартай приус-10 маркын автомашиныг мал байгаа газарт түргэн очих, малыг туух, махыг нь ачиж, зөөвөрлөх зэрэгт ашигласан болох нь тогтоогдсон бөгөөд тухайн гэмт хэргүүдийг үйлдэхдээ машин, механизм ашигласан гэж үзэх үндэслэлтэй байна.	1 жил 6 сар хорих

Дээрх шүүхийн шийдвэрүүдээс үзвэл “машин механизм ашиглаж” гэх үйлдлийн шинжийг анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхүүд ижил утгаар буюу “үйлдлийг хөнгөвчлөх, түргэтгэх, эд хөрөнгө байгаа газарт түргэн очиж буцах, хамгаалалт бэхэлгээг эвдлэх, биеэр авч явж чадахгүй эд хөрөнгөд хүрэх” хэмээн тайлбарладаг онолын ойлголтод нийцүүлэн тайлбарлажээ.

Харин машин механизм гэдэгт юуг ойлгох тухайд практикт хэргийн оролцогчдын зүгээс өөрөөр тайлбарлаж буй жишээ хэд хэд байна. Үүний нэг нь:

Хэнтий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 2021/ШЦТ/46 дугаартай шийдвэр. Шүүгдэгчийн өмгөөлөгч нь Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1.2.2 дахь заалтад “автомашин” гэж мотоцикл, трактор, өөрөө явдаг машин механизмаас бусад механикжсан тээврийн хэрэгслийг ойлгоно гэж заасан байх тул мотоциклийг машин механизм гэж үзэх үндэслэлгүй гэжээ.

Шүүх шүүгдэгчийн өмгөөлөгчийн дээрх дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй үндэслэлээ “Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.4 дэх заалтад заасан “машин механизм” гэсэн ойлголт нь Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1.2.2 дахь заалтад заасан “автомашин” гэсэн ойлголтоор хязгаарлагдахгүй бөгөөд хүн, ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автомашин, мотоцикл, трактор, өөрөө явагч бусад машин болон хүний хөдөлмөрийн хөнгөвчилсөн үйлдэл хийх зориулалттай бүх төрлийн машин механизмууд хамаарна.” хэмээн тайлбарласан нь машин механизм ашиглаж үйлдэх шинжийн гол утга болох гэмт этгээд гэмт үйлдлээ хөнгөвчлөх, хялбарчлах зорилготой байх шинжийг шалгуур болгосон байгаа нь эрүүгийн эрх зүйн онолд суурилсан үндэслэл бүхий тайлбар болжээ.

Мөн цааш нь шүүх “шүүгдэгч нь мотоцикл ашиглан хохирогч Д.Б-гийн адуу тууж явсан гэж мэдүүлэг өгсөн нь мотоциклийг өөрийн үйлдлээ хөнгөвчлөх зорилгоор ашигласан гэж үзэх үндэслэлтэй байна.” хэмээгээд “шүүгдэгч Б.У-ийг бусдын малыг хулгайлсан гэмт хэргийг машин механизм ашиглаж үйлдсэн гэм буруутайд тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй байна” гэж дүгнэжээ. Мотоциклыг ашиглах нь адууг хулгайлахдаа тууж явах зорилготой байсныг шүүх нотлох баримтаар тогтоож энэхүү үйлдлийг өөрийн үйлдлийг хөнгөвчилж байгаа явдал хэмээн тайлбарласан нь онолын дагуу тайлбарыг хийснийг харуулж байна.

Цагдаагийн алба хаагчаас уг зүйл, заалттай холбоотой дараах асуулгыг авахад доорх үр дүнг үзүүлэв.

Хүснэгт 4.25. Асуулга 12 “Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 2.4 дэх хэсэгт заасанчлан “машин механизм” ашиглан мал хулгайлсан тохиолдолд ялыг хүндрүүлэхээр хуульчлах шаардлага байна уу?

Д/д	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1.	Шаардлагатай	95	91.3
2.	Шаардлагагүй	9	8.7
Нийт		104	100

Уг асуулгад 110 цагдаагийн алба хаагчаас 104 нь хариулсан ба “шаардлагатай” гэж 91 хувь буюу судалгаанд оролцогсдын дийлэнх олонх үзсэн байна. Уг асуулгыг цааш нь нарийвчлан “Шаардлагатай бол яагаад?” гэж асуухад:

Хүснэгт 4.26. Нарийвчилан асуултад хариулсан байдал

Д/д	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1.	Үйлдлээ хөнгөвчлөх зорилготой учраас	12	25.5
2.	Зохион байгуулалттай, урьдаас төлөвлөсөн байдаг учраас	12	25.5
3.	Гэмт хэрэг илрүүлэхэд хэцүү	5	10.6
4.	Ихэвчлэн машин механизм ашиглаж үйлддэг	5	10.6
5.	Улсын орлого болгож хохирлыг барагдуулах	4	8.5
6.	Эд мөрийн баримт болгох зорилгоор	2	4.3
7.	Хохирол их учруулдаг	2	4.3
8.	Урьдчилан сэргийлэх зорилгоор	2	4.3
9.	Гэмт хэргийн гаралт багасна	1	2.1
10.	Давтан гэмт хэрэг үйлдэхгүй	1	2.1
11.	Үйлдлийн арга нь ноцтой	1	2.1
Нийт		47	100

95 цагдаагийн алба хаагчаас 83 нь хариулсан ба үүнээс тодорхой хариулт өгсөн 47 алба хаагч байна.

Хүснэгт 4.27. Асуулга 13 “Гэмт этгээд машин механизм ашиглан гэмт хэрэг үйлдэхдээ ихэнх тохиолдолд ямар төрлийн автомашин механизм ашиглан үйлддэг вэ?”

Д/д	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1.	Ачааны автомашин	80	49.4
2.	Суудлын автомашин	56	34.6
3.	Мотоцикл	24	14.8
4.	Бүх машин механизмыг ашиглана	4	2.5
Нийт		162 (давхардсан тоогоор)	100

106 алба хаагч хариулт өгсөн ба давхардсан тоогоор 56 нь “суудлын автомашин”, 80 нь “ачааны автомашин”, 24 нь “мотоцикл”, 4 нь “бүх машин механизмыг ашигладаг” гэсэн хариултыг тус тус өгсөн.

Үүнээс үзэхэд мал хулгайлах гэмт хэргийг машин механизмыг ашиглаж үйлдэхийг шүүхийн хувьд нэгдмэл байдлаар эрүүгийн эрх зүйн онолд нийцүүлэн хэрэглэж байгаа нь харагдаж байх хэдий ч практикт хэргийн оролцогчид болон хууль сахиулах байгууллагын өөр өөрөөр тодорхойлдог тохиолдлууд ажиглагдаж байна.

3.6. Эрүүгийн хуулийн 17.12.2.5 буюу мал хулгайлах гэмт хэргийг ноцтой хохирол, хор уршиг учруулж үйлдэх үйлдлийн тухайд

2016 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлд “Ноцтой хохирол, хор уршиг учруулж” гэж хүндрүүлэх бүрэлдэхүүнд хохирол заасан шинжийг нэмсэн байх бөгөөд уг шинжийг Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “хохирогчийн

амьдралын эх үүсвэр болсон эд хөрөнгийн эрхэд, эсхүл улс орон, хүн амын аюулгүй байдалд ач холбогдол бүхий эрхэд хохирол, хор уршиг учирсныг ойлгоно.” хэмээн тайлбарласнаас үзвэл энэхүү шинж нь 2002 оны Эрүүгийн хуулийн 145.3-т заасан “хохирогчийг амьдралын эх үүсвэрээс нь салгасан буюу их хэмжээний хохирол учирсан” хэмээх хүндрүүлэх шинжтэй адил агуулгатай байна. Энэ нь хуучин зохицуулалтыг ахин нэмсэн, шинэчлэхээс ухарсан хэрэг гэхээс илүүтэй уг гэмт хэргийн зохицуулалтыг нарийвчлан зохицуулсан эерэг үр дүнтэй зохицуулалт юм.

Харин уг зохицуулалтын практик хэрэгжилтийн талаар авч үзвэл, 2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш өнөөгийн байдлаар шүүхээр шийдвэрлэгдсэн тохиолдол гараагүй байна. Үүний шалтгаан нь Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эд хөрөнгийн эрхэд, эсхүл улс орон, хүн амын аюулгүй байдалд ач холбогдол бүхий эрхэд хохирол, хор уршиг учирсныг ойлгоно.” гэх шалгуурт мал хулгайлах гэмт хэрэгт өртөгдсөн объект буюу малын тоо толгой хүрэхгүй байна гэж таамаглаж байна.

Монгол Улсын хэмжээнд 2020 оны байдлаар малтай өрхийн тоон үзүүлэлтийг авч үзвэл 11 хүртэл малтай өрх 12618, 11-30 малтай өрх 20487, 31-50 малтай өрх 16840, 51-100 малтай өрх 32411, 101-200 малтай өрх 51185, 201-500 малтай өрх 67958, 501-999 малтай өрх 30327, 1000-1499 малтай өрх 8454, 1500-2000 малтай өрх 1195, 2001-ээс дээш малтай өрх 549 байна⁵⁴. Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн аутентик тайлбар буюу “олон тооны мал” гэж найман бог, хоёр бод, түүнээс дээш малыг ойлгоно. Богийг бодод шилжүүлэхдээ нэг бодыг дөрвөн богоор тооцно.” гэснийг ашиглан тооцвол 30 хүртэлх малтай 33105 өрх нь тухайн гэмт хэргийн хохирогч болох магадлалтай байна. Энэ нь нийт малтай өрх буюу 242024 өрхийн 13,8% байна. Үүнээс гадна 2020 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрх нь 181050⁵⁵ буюу нийт малтай өрхийн 74,8% байгаа нь тухайн гэмт хэргийн хохирогч болох магадлалтай хүмүүсийн тоог бууруулж байна.

Тиймээс мал хулгайлах гэмт хэргийг ноцтой хохирол, хор уршиг учруулж үйлдэхийн хувьд тухайн зохицуулалтын хэрэгжилтийн үр нөлөө сайн байна. Энэ нь тухайн практик нөхцөл байдалтай холбоотой болох нь тодорхойлогдож байна.

3.7. Эрүүгийн хуулийн 17.12.2.6 буюу мал хулгайлах гэмт хэргийг гойд ашиг шимт малыг хулгайлж үйлдэх үйлдлийн тухайд

2015 оны Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 2.6-д “гойд ашиг шимт малыг хулгайлж үйлдсэн бол” гэх диспозици тусгагдсан байдаг. Тухайн зохицуулалтын хамгийн гол тодруулах зүйл бол “гойд ашиг шимт мал” гэх нэр томьёо юм. Тухайн нэр томьёог тодруулахын тулд бусад эрх зүйн хэм хэмжээг ашиглах нь зүйтэй. 2017 оны Малын генетик нөөцийн тухай⁵⁶ хуулийн 4.1.9-т “гойд ашиг шимт мал”

54 Малчин өрхийн тоо, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, малын тооны бүлэглэлтээр, улс, бүс, аймаг, нийслэлээр, жилээр”, https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1001_044V1&13999001_select_all=0&13999001SingleSelect=_T2_T3_T4_T6_T5_T8_T7_T9_T10_T11&SOU select_all=0&SOU SingleSelect=_0&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2020&viewtype=table

55 Малчин өрхийн тоо, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороогоор, жилээр”, https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1001_027V1&BAG select_all=0&BAG SingleSelect=_0&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2020&viewtype=table

56 Төрийн мэдээлэл эмхэтгэл, №03 2018

гэж үүлдэр, омгийн мал сүргээс үржил, ашиг шимийн нэг буюу хэд хэдэн чанараар онцлог давуу болох нь баталгаажсан малыг хэлнэ хэмээн тодорхойлсон байдаг.

Харин “гойд ашиг шимт мал”-ыг хэрхэн шалгаруулах талаар тус хуулийн 15.4-т “Малын үндэсний генийн санд үржүүлгийн бүтээгдэхүүн байршуулах, бүртгэх, зарцуулах, хяналт тавих болон гойд ашиг шимт мал шалгаруулах журам, энэ хуулийн 15.1-д заасан үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааны бүтэц, орон тоог малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэж зааснаар Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд тухайн журмыг батлахаар хуульчлагджээ.

2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын А-346 тоот тушаалын хавсралтаар тухайн хуулийн зохицуулалтын дагуу “Гойд ашиг шимт мал шалгаруулах журам”-ыг баталсан байна. Уг журмын зорилт нь ашиг шимийн гарц, чанар, удам зүйн үнэлгээ, эрүүл мэндээр баталгаажсан шилмэл мал болон ашиг шимийг нь ашигладаг тэжээвэр амьтныг олон нийт, мал үржүүлэгчдэд сурталчлан таниулж, стандартын шаардлага хангасан хээлтэгч, хээлтүүлэгчийг аж ахуйн нэгж, иргэдэд борлуулах, малчид, мал үржүүлэгчдийн хөдөлмөр бүтээлийг үнэлж, урамшуулахад оршдог байна. Энэхүү журмаар дараах онцлог зохицуулалт хийжээ.

- Гойд ашиг шимт мал шалгаруулах үйл ажиллагааг сум, дүүрэгт Хөдөө аж ахуйн тасаг, аймаг, нийслэлд Хүнс, хөдөө аж ахуйн газар, улсын хэмжээнд Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулах
- Гойд ашиг шимт малыг шалгаруулах ажлын хэсгийг холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөлөл, мэргэжилтнийг оролцуулан сум, аймаг, нийслэлд тухайн шатны Засаг дарга, улсад Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн (Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд) тус тус байгуулах
- Ноос, ноолуурын чиглэлийн ашиг шимт малын шалгаруулалтыг хавар, бусад ашиг шимийн чиглэлийн мал, амьтны шалгаруулалтыг намар зохион байгуулах
- Шалгарсан гойд ашиг шимт шилмэл малыг улсын үржлийн дэвтэрт бүртгэж, гэрчилгээ олгох
- Гойд ашиг шимт мал шалгаруулах үзэсгэлэн худалдаанд хурдны чиглэлийн адуунаас бусад мал, тэжээвэр амьтныг оролцуулах
- Сум, дүүрэгт шалгарсан гойд ашиг шимт мал, амьтан тэдгээрийн төл нь аймаг, нийслэлийн, аймаг, нийслэлд шалгарсан малыг улс, бүсийн гойд ашиг шимт малыг шалгаруулах үзэсгэлэн худалдаанд оролцуулах
- Ашиг шимийн үзүүлэлт нь “Мал ангилах заавар”-т заасан цөм сүргийн малд тавих шаардлагаас илүү үзүүлэлттэй байх
- Адууны төрөлд 12, тэмээ 6, үхэр 18, хонь 25, ямаа 10, сарлаг 5, гахай 7, шувуу, жижиг амьтан 3 тус тус гойд ашиг шимт малаар шалгаруулах
- Амьдын жин, ноос, ноолуурын гарцаар тэмээг 6, үхрийг 5, ямааг 4, гахайг 2 настайд нь, сүүний гарцаар үнээг 6, ингийг 8 настайд нь тус тус улсад шалгаруулах

Судалгааны хүрээнд хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Малын генетик нөөцийн хэлтсийн Малын нөхөн үйлдвэрлэл, үржүүлэг, селекцийн асуудал хариуцсан мэргэжилтэн П.Баясгалантай ярилцлага хийсэн бөгөөд дараах тайлбарыг өгсөн:⁵⁷

“Гойд ашиг шимт мал шалгаруулах үйл ажиллагаа явагдсан хамгийн сүүлийн арга хэмжээ нь 2019 оны “Шилмэл мал-2019” арга хэмжээ бөгөөд үүнээс хойш зохион байгуулагдаагүй байна. Гойд ашиг шимт мал шалгаруулах үйл ажиллагаа нь сум, дүүрэг, аймаг, нийслэл, улсад нийтдээ жилдээ 10 орчим удаа зохион байгуулагддаг. Түүний шалтгаан нь бэлчээр муу, ган, хүний болон малын

57 Малын нөхөн үйлдвэрлэл, үржүүлэг, селекцийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй хийсэн ярилцлагаас, 2021.06.30.

халдварт өвчин зэргээс хамаарч байна. Бид аймаг болон сумдад жил болгон гойд ашиг шимт мал шалгаруулах үйл ажиллагаа явуулах зөвлөмжийг удаа дараа хүргүүлдэг. Мөн гойд ашиг шимт мал нь бүгд хувийн дугаартай, өндөр шалгаруулалтаар орж дүгнэгдэж гойд ашиг шимт мал хэмээх цолыг хүртдэг тул тэр бүр бэлчээрт яваад байдаггүй.”

Улсын хэмжээнд жилдээ ойролцоогоор 10 орчим зохион байгуулагддаг ч 2015 оноос хойш гойд ашиг шимт мал шалгаруулах үйл ажиллагаа зохион байгуулагдаагүй байна. Монгол Улс 2020 оны байдлаар нийт 67068486 малтай байх тоон мэдээ⁵⁸ байх ба гойд ашиг шимт мал нь түүний 0,001 хувийг эзэлж байгаа нь гойд ашиг шимт мал нь мал хулгайлах гэмт хэргийн объект болох эрсдэл бага, тухайн төрлийн гэмт хэрэг үйлдэгдээгүй байх магадлалтай байна.

2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулиар дээрх заалтууд нэмэгдсэн. 2020 оны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлалд “Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 12 дугаар сарын 3-ны өдөр батлан гаргасан Малын генетик нөөцийн тухай хуулийн 4.1.7-д “цөм сүрэг”, 4.1.9-д “гойд ашиг шимт мал”-ыг тусгайлан заасан бөгөөд дээрх малын генетик нөөц, удам зүйн үнэлгээ, хянан магадлагаа хийх, баталгаажуулах асуудлыг зохицуулсан. Мал, мах, малын гаралтай түүхий эдийн үнэ ханш зах зээлд тогтмол хэлбэлзэж байдаг ба цөм сүрэг, гойд ашиг шимт малын эдийн засгийн үнэлгээ нь харилцан адилгүй тогтоогддог болно.” гэж тухайн зохицуулалтын үзэл санааг тусгасан байдаг. Үүнээс гадна тухайн үед Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн ажлын хэсгийн гишүүн Х.Нямбаатар “Мөн хурдан удмын адуу зэрэг өндөр ашиг шимтэй малыг хулгайлсан бол хүндрүүлэх нөхцөлд тооцогдоно”⁵⁹ гэх санааг илэрхийлж байжээ.

Гэтэл гойд ашиг шимт мал шалгаруулах журмын 3.1-д “Гойд ашиг шимт мал шалгаруулах үзэсгэлэн худалдаанд хурдны чиглэлийн адуунаас бусад мал, тэжээвэр амьтныг оролцуулах бөгөөд...” гэж зааснаас үзвэл дээрх нэр бүхий Улсын Их Хурлын гишүүний илэрхийлсэн санаа нь гойд ашиг шимт малд хамаарахааргүй зохицуулагдсан байна.

Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулууны 2020 оны Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлалд цөм сүрэг болон гойд ашиг шимт малыг эдийн засгийн үнэлгээ нь харилцан адилгүй тогтоогддог гэж тодорхойлсон хэдий ч цөм сүргийг Эрүүгийн хуулийн 17.12 буюу мал хулгайлах гэмт хэрэгт хуульчлаагүй. Цөм сүрэг гэдэг нь 2017 оны 12 дугаар сарын 14-ний “Малын генетик нөөцийн тухай хууль”-ийн 4.1.7-д зааснаар тухайн үүлдэр, омгоос ашиг шимийн хэмжээ, чанараар давуу хэсгийг сонгон үржүүлж байгаа сүрэг малыг хэлдэг. Хуулийн болон журмын тодорхойлолтоор цөм сүрэг нь гойд ашиг шимт малнаас бага ашиг шимт чанарыг агуулах нь харагдаж байгаа бөгөөд тооны хувьд шалгаруулж, баталгаажуулах үйл ажиллагаанд оролцохгүй учир их байхаар харагдаж байна. Гэхдээ ашиг шимт байдлын хувьд хоёулаа энгийн мал буюу үржлийн болон хэрэгцээний малаас дээгүүр байна. Тиймээс тухайн цөм сүргийн ангиллын малыг

58 “Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: Нийт малын тоо 2020 оны байдлаар”, https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=dt_nso_1001_021v1&bag_select_all=0&bagsingleselect=_0&type_of_livestock_select_all=0&type_of_livestocksingleselect=_01&yearly_select_all=0&yearlysingleselect=_2020&viewtype=table.

59 Х.Нямбаатар, Хурдан удмын адуу хулгайлсан бол хүндрүүлэх нөхцөл болно, 2020.01.10, <https://www.polit.mn/a/77974>.

хулгайлж үйлдсэн байхыг Эрүүгийн хуульд оруулах үзэл баримтлал байгаа хэдий ч хуульд дээрх зохицуулалтыг тусгаагүй учир тухайн зохицуулалтыг тусгавал үүлдэр, омгоос ашиг шимийн хэмжээ, чанараар давуу малыг хулгайлсан тохиолдолд гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнээр зүйлчилж тухайн төрлийн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэхэд үр нөлөөтэй байж болох юм.

Түүнчлэн шүүхийн шийдвэрийн практикаас үзэхэд 2020 оны 1 дүгээр сарын 16-ны Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар нэмэлт орж хуульчлагдсан “17.12.2.6 буюу мал хулгайлах гэмт хэргийг гойд ашиг шимт малыг хулгайлж үйлдсэн” гэх гэмт хэргийн зүйлчлэлээр шийдэгдсэн шүүхийн шийдвэр гараагүй байна.⁶⁰ Тухайн гэмт хэргийн зүйлчлэлээр шүүхээр хэрэг шийдэгдээгүй шалтгаан нь дараах хүчин зүйлийн нөлөөтэй байна:

- Өмнөх судалгаанд тодорхойлсончлон Монгол Улсын нийт малын 0,001 хувь нь гойд ашиг шимт мал байгаа нь тухайн мал гэмт хэргийн шууд объект болох эрсдэлийг бууруулж байна.
- Мөн мэргэжилтний хэлснээр малчид тухайн малыг бүртгэлжүүлж бэлчээрт гаргахгүй байгаа нь үүний нэг шалтгаан нөхцөл болж байна.
- Цөм сүргийн талаар хуульчлаагүй учир энгийн малаас ялгарах ашиг шимт малыг хулгайлж буй нөхцөлийг шүүхээр шийдвэрлэхэд мал хулгайлах гэмт хэргийн энгийн бүрэлдэхүүнээр зүйлчилж байна гэх мэт.

Цагдаагийн алба хаагчдаас уг зүйл, заалттай холбоотой дараах асуулгыг авахад доорх үр дүнг үзүүлэв.

Хүснэгт 4.28. Асуулга 8 Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэгт заасан “Гойд ашиг шимт мал” хэмээх ойлголтыг Та хэрхэн ойлгож байна вэ? Уг зүйл, заалтаар хэрэг бүртгэлийн хэрэг нээн, ажиллагаа явуулахад хүндрэл бэрхшээл тулгардаг эсэх, тийм бол ямар?”

Д/д	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1.	Үгүй	21	28.3
2.	Тийм	34	46
3.	Мэдэхгүй	19	25.6

Асуулгад 74 алба хаагч хамрагдсан бөгөөд 46 хувь нь Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэгт заасан зохицуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг гэж хариулсан байна. Энэхүү хариулт нь хамгийн их хувийг эзэлж байгаа бөгөөд тухайн хариултаас үзэхэд тус зохицуулалт нь практикт хэрэгжих тал дээр асуудалтай болох нь харагдаж байна.

Хүснэгт 4.29. Асуулга 9 “Гойд ашиг шимт мал” хэмээх ойлголтод хурдан морийг багтаах шаардлагатай эсэх талаар та юу гэж бодож байна вэ?”

Д/д	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Шаардлагатай	60	56.1
2	Шаардлагагүй	47	43.9
Нийт		107	100

60 Монгол Улсын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр “Мал хулгайлах” гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, 2020, Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан.

Асуулгад 107 алба хаагч хамрагдсанаас 56 орчим хувь нь хурдан морийг гойд ашиг шимт малд хамааруулах нь зүйтэй гэж үзсэн бол 44 хувь нь шаардлагагүй гэж хариулсан байна. Тухайн асуултаас шаардлагатай гэж үзсэн хариултыг багцлан үзвэл:

1. Хурдан морь бол гойд ашиг шимт мал гэдэгт орно, бүх морьд хурдан байдаггүй;
2. Тодорхой хуульчилж өгөх нь ЭХХША-г хөнгөвчилнө;
3. Өндөр үнээр зарагддаг учраас;
4. Морины үнэлгээ өндөр хохирлын хэмжээ өндөр байх тул оруулах ёстой;
5. Хурдан морь нь цол, шагналтай байдаг тул гэх мэт.

Харин шаардлагагүй гэж үзсэн хариултыг багцлан үзвэл:

1. Малыг тухайн үеийн зах зээлийн үнэ ханшаар тооцох нь зөв;
2. Хурдан удамтай морь гэдгийг гаднаас нь хараад мэдэх боломжгүй;
3. Бүх мал ашиг шимтэй байдаг;
4. Гэмт хэргийн үйлдэл адил;
5. Гойд ашиг шимт гэдэг нь хөдөө аж ахуйн хөгжилд цаашлаад монгол малын үүлдэр угсаа сайжруулалтад хамаарах ёстой;
6. Таван хошуу малын л нэг учир;
7. Хурдалсан эсэх асуудлыг тогтооход хүндрэлтэй;
8. Адуугаа алдсан хүн бүр хурдны удамтай, тийм угшилтай гэх мэт тайлбарладаг болохоор шаардлагагүй;
9. Хурдан морийг зөвхөн өөрийнх нь амжилтаар тогтоож байх, хурдан удмын гүү, түүний унага гэх ойлголт нь ирээдүйд гарах ашиг шимийг тодорхойлох нь учир дутагдалтай юм гэх мэт шалтгааныг дурдсан байна.

Эрүүгийн хуулийн 17.12.2.6 буюу мал хулгайлах гэмт хэргийг гойд ашиг шимт малыг хулгайлж үйлдэх үйлдлийн тухайд гойд ашиг шимт малыг шалгаруулах үйл ажиллагаа болон зохион байгуулалтын улмаас гойд ашиг шимт малын нийт малын дунд эзлэх хувийн жин бага байх, тухайн асуудлын улмаас зохицуулалт нь хуулийн үзэл баримтлалд нийцээгүй байх буюу мөн цөм сүргийг тухайн хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчлаагүй байх, хурдны чиглэлийн адуу гойд ашиг шимт малд хамаарагдахгүй байх гэх мэт хэрэгжилтийн үр дагавартай холбоотой асуудлууд бий болоод байна. Түүнчлэн практикт ажиллаж буй хууль сахиулагч буюу цагдаагийн алба хаагчдын хувьд тухайн зохицуулалтыг хэрэглэхдээ нэгдмэл байдлаар тухайн зохицуулалтыг ойлгохгүй байх, гойд ашиг шимт мал шалгаруулах журмыг мэдэхгүй байх, гойд ашиг шимт малыг тодорхойлохгүй байх гэх мэт дутагдлыг бий болгож байгаа бөгөөд үүнээс болж тухайн хэргийг шийдвэрлэхэд ихээхэн хүндрэл практикт учирч байна. Дээрх шалтгаанаас болж шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн практик огт байхгүй үр дүн гарч байна.

3.8. Эрүүгийн хуулийн 17.12.3.1 буюу мал хулгайлах гэмт хэргийг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон гэх онц хүндрүүлэх бүрэлдэхүүний тухайд

Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 3.1 буюу мал хулгайлах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүний байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон гэх шинж нь практикт хэрэглэх, тайлбарлахад хүндрэл дагуулдаг учир энэхүү асуудлыг зайлшгүй судлах шаардлагатай. Тус зүйл, заалтын хүрээнд холбогдох шүүхийн шийдвэрийг дор авч үзье.

Хүснэгт 4.30. Шүүхийн шийдвэрийн харьцуулалт №4

Д/д	Гэмт хэргийн зүйл анги	Шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолын дугаар	Шийдвэрлэсэн он, сар, өдөр	Шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт хууль тайлбарласан байдал	Оногдуулсан ялын төрөл, хэмжээ
1.	17.12.2.1	Баянхонгор аймаг дахь Сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, Дугаар 309	2020.09.21	Шүүгдэгч Х.М нь 8 удаагийн үйлдлээр 3 үхэр, 11 тооны адуу, 50 тооны ямаа хулгайлж бусдад 16.050.000 төгрөгийн хохирол учруулсан байна. Шүүх прокурорын газраас шүүгдэгч Х.М ыг мал хулгайлах гэмт хэргийн байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон буюу Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 3.1-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг шүүх Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 2 болгон хөнгөрүүлэн зүйлчилж шийдвэрлэсэн байх ба үндэслэлээ: "...малын хулгайн гэмт хэрэг үйлдэж байгаа этгээд гэмт хэрэг үйлдэж үүнээс ашиг олох зорилгоо өөрийн амьдралын хэвшил болгож, гэмт хэрэг үйлдэх замаар амьдрах боломжийг эрэлхийлж байгааг мөрдөн шалгах ажиллагааны явцад бодитой нотолж чадаагүй" гэж тайлбарлажээ.	4 жил хорих
2	17.12.2.1	Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, Дугаар 786	2019.10.16	Г.С.Х нь бусадтай бүлэглэн нийт 17 удаагийн үйлдлээр бусдын олон тооны малыг хулгайлсан байна. Багануур дүүргийн прокурорын газраас шүүгдэгч Г.С.Х-ыг бүлэглэн мал хулгайлах гэмт хэргийг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон буюу Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.1 дэх заалтад заасан гэмт хэргийг үйлдсэн гэж яллах дүгнэлт үйлдсэн ч шүүх бусдын олон тооны малыг хулгайлсан буюу Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн гэж хэргийн зүйлчлэлийг хөнгөрүүлэн өөрчилж шийдвэрлэсэн. Ийн шийдсэн үндэслэлээ: "...Г.С.Х нь гэмт хэрэг үйлдэж олсон мал, орлогыг өөрийн гэр бүлийнхээ хэрэгцээнд зарцуулж байсан эсэхийг тогтоосон баримт байхгүй, зөвхөн гэмт хэргийн замаар олсон орлого нь амьдралын эх үүсвэр нь болж байсан гэж үзэх боломжгүй" гэжээ.	4 жил 6 сар хорих

3.	17.12.3.1	2020/ ШЦТ/311	2020.10.01	Шүүх иргэн У-г дараах гэмт хэргүүдийг үйлдсэн гэж үзсэн байна: • 2019 оны 02 дугаар сарын 23-наас 24-нд шилжих шөнө Э-тай бүлэглэн Дорнод аймгийн Баянтүмэн сумын 3 дугаар багийн нутаг “Энгэрхашаат” гэх газарт бэлчээрт байсан хохирогч М.Гангамөрөнгийн 4 тооны үхэр хулгайлж 4.400.000 төгрөгийн хохирол учруулсан, • 2019 оны 05 дугаар сарын 01-нээс 02-нд шилжих шөнө С, Б нартай бүлэглэн Дорнод аймгийн Баянтүмэн сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэр “Цайдамын нуур” гэх газарт бэлчиж байсан хохирогч Г.Азжавхлангийн 1 тооны улаан халзан зүсмийн хязаалан насны эр үхэр хулгайлж 1.200.000 төгрөгийн хохирол учруулсан, • 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Н, Э нартай бүлэглэн Дорнодаймгийн Хэрлэн сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэр “Айргийн энгэр” гэх газарт бэлчиж байсан хохирогч Ч.Нармандахын үхрээс 1, мөн тус газар бэлчээрт байсан хохирогч Ж.Отгонбаатарын үхрээс 1, нийт 2 тооны үхэр хулгайлж 2.200.000 төгрөгийн хохирол учруулсан, • 2019 оны 05 дугаар сарын 21-нээс 22-нд шилжих шөнө Э, С, Х нартай бүлэглэн Дорнод аймгийн Баянтүмэн сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэр “Цайдамын нуур” гэх газарт бэлчиж байсан хохирогч Г.Азжавхлангийн адуунаас ухаа, хүрэн зүсмийн зөв талын гуян дээрээ хуучин монгол “А” тамгатай 2 тооны адуу хулгайлж 2.000.000 төгрөгийн хохирол учруулсан, • 2019 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Дорнод аймгийн Баянтүмэн сумын 2 дугаар багийн нутаг “Ямаатын ам” гэх газарт бэлчиж байсан хохирогч Д.Алтангэрэлийн 6 тооны адууг хулгайлж 4.500.000 төгрөгийн хохирол учруулсан.	5 жилээр хорих
----	-----------	------------------	------------	--	----------------

Дээр дурдсан зарим шүүхийн шийдвэрт “байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон” хэмээх шинжийг учруулсан хохирол буюу хулгайлсан малын тоо, үйлдлийн тоо, болон давтамжаас үл хамааран “гэмт хэрэг үйлдэж, ашиг олох зорилгоо өөрийн амьдралын хэвшил болгож, гэмт хэрэг үйлдэх замаар амьдрах боломжийг эрэлхийлсэн”, “гэмт хэрэг үйлдэж олсон мал, орлогыг өөрийн гэр бүлийнхээ хэрэгцээнд зарцуулж байсан, зөвхөн гэмт хэргийн замаар олсон орлого нь амьдралын эх үүсвэр нь болж байсан” гэх шинж заавал байх ёстой гэж үзсэн нь уг шинжийг “Гэмт хэрэг тогтмол үйлдэж, түүнээс олсон хууль бус орлогоороо өөрийгөө болон гэр бүл, бусдыг тэжээн тэтгэж амьдралын эх үүсвэр болгосон байдал” хэмээн тодорхойлдог онолын ойлголтод нийцүүлэн хуулийг тайлбарласан байна. Гэвч шүүхийн практикт уг шинжийг нэгэн адилаар тайлбарладаггүй болох нь дээр дурдсан шүүхийн шийдвэрээс харагдаж байна. 2020/ШЦТ/311 дугаартай шийдвэрт иргэн У-г хулгайн гэмт хэргийг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон гэж шүүх үзсэн байх боловч үндэслэлээ тайлбарлаагүй байна.

Эндээс үзвэл, иргэн У нь 5 удаагийн үйлдлээр нийт 8 адуу 7 үхэр буюу 15 тооны мал хулгайлжээ. Энэ нь өмнө дурдсан шүүхийн шийдвэрүүд дэх иргэн Г.С.Х-ын 17 удаагийн үйлдлээр мал хулгайлсан, иргэн Х.М-ын 8 удаагийн үйлдлээр 3 үхэр, 11 тооны адуу, 50 тооны ямаа хулгайлснаас харьцангуй бага байх бөгөөд, мөн шүүх гэмт хэргээс олсон хууль бус орлогоороо өөрийгөө болон гэр бүл, бусдыг тэжээн тэтгэж амьдралын эх үүсвэр болгосон эсэх тухай дүгнэлт, тайлбар хийлгүй Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйл 3.1 дэх хэсгээр зүйчилж 5 жилээр хорих ял оногдуулж эрх зүйн байдлыг дордуулан шийдвэрлэсэн байна.

Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйл 3.1 дэх хэсэгт заасан “байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон” хэмээх мал хулгайлах гэмт хэргийн онц хүндрүүлэх бүрэлдэхүүний шинжийг шүүхийн практикт эрүүгийн эрх зүйн онолд үндэслэн тайлбарлаж байгаа сайн жишээ бий боловч зөвхөн үйлдлийн тоо, давтамжийг онцлон амьдралын эх үүсвэр болгосон байх шинжийг харгалзалгүй шийдсэн нь учир дутагдалтай байна.

Иймд Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйл 3.1 дэх хэсэгт заасан “байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон” хэмээх мал хулгайлах гэмт хэргийн онц хүндрүүлэх бүрэлдэхүүний шинжийг нэгэн утгаар тайлбарлан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзэж байна.

Цагдаагийн алба хаагчдаас уг зүйл, заалттай холбоотой дараах асуулгыг авахад доорх үр дүнг үзүүлэв.

Хүснэгт 4.31. Асуулга 10 Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан “байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон” хэмээх ойлголтыг Та хэрхэн ойлгож байна вэ? Уг зүйл, заалтаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээн, ажиллагаа явуулахад хүндрэл бэрхшээл тулгардаг эсэх, тийм бол ямар?”

Д/д	Хариулт	Тоо	Хувь
1.	Үгүй	19	22.6
2.	Тийм	21	28.3
3.	Мэдэхгүй	12	16.2
4.	Ойлголтын талаар дурдсан	22	29.7

Асуулгад 74 алба хаагч хамрагдсан бөгөөд 28 хувь нь хүндрэлтэй байдаг гэж хариулсан бол 23 орчим хувь нь ямар нэг хүндрэлгүй хэрэгждэг гэжээ. Гэвч судалгаанд хамрагдагсдын 16 хувь уг зохицуулалтыг хэрэглэх шаардлага үүсч байгаагүй учир мэдэхгүй гэж хариулсан байна. Тухайн хариултаас харахад хүндрэлтэй байдаг гэх хариулт өгсөн нь их байгаа тул практикт Эрүүгийн хуулийн 17.12.3.1-тэй холбоотой асуудал байдаг гэж дүгнэх үндэслэлтэй юм.

Хүснэгт 4.32. Асуулга 11 Мал хулгайлах гэмт хэргийг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон гэдгийг тодорхойлоход гэмт хэрэг үйлдсэн тоо болон давтамж чухал уу, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон орлого, түүний зарцуулалтын зориулалт чухал уу?

Д/д	Хариулт	Тоо	Хувь
1.	Аль аль нь чухал	26	35.6
2.	Давтамж	33	45.2
3.	Орлого	14	19.1

Асуулгад 73 алба хаагч хамрагдсан бөгөөд 45.2 хувь нь гэмт хэрэг үйлдсэн давтамж буюу тоо нь чухал гэж хариулсан бол, 19.1 хувь нь гэмт хэрэг үйлдэж олсон орлого, түүний зарцуулалт нь чухал гэж үзжээ. Харин судалгаанд хамрагдагсдын 36 орчим хувь нь аль аль үзүүлэлт чухал хэмээн хариулсан байна. Тухайн асуулгын үр дүнд давтамж буюу тоо чухал гэж хариулсан хариулт нь хамгийн их байгаа нь өмнөх хэсэгт дурдагдсан шүүхийн практиктай ижил байх бөгөөд практикт дийлэнхдээ тухайн байдлаар тодорхойлогддог гэх дүгнэлтийг хийж болохоор байна.

Мал хулгайлах гэмт хэргийг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон гэх үйлдлийн тухайд шүүхийн болон хууль сахиулагч буюу цагдаагийн алба хаагчийн хууль хэрэглэж буй ойлголт нь ихэнхдээ ижилхэн буюу тухайн үйлдлийн тоо, давтамж чухал гэх тодорхойлолтоор шийдэгдэж байна. Гэвч бусад тохиолдолд шүүх болон цагдаагийн алба хаагчид өөр байдлаар ойлгож хуулийг хэрэглэж байгаа нь тухайн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт сөргөөр нөлөөлж байна. Мөн түүнчлэн цагдаагийн алба хаагчдийн судалгаанаас үзэхэд мөрдөн шалгах ажиллагаанд тухайн зохицуулалт нь бэрхшээл учруулдаг нь түүний практик хэрэгжилтийн үр дагаварт сөргөөр нөлөөлж байна.

3.9. Эрүүгийн хуулийн 17.12.3.2 буюу Мал хулгайлах гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдэх гэх онц хүндрүүлэх бүрэлдэхүүний тухайд

1996 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн хуулиар мал хулгайлах гэмт хэргийг шинээр Эрүүгийн хуульд хуульчилсан ба ингэхдээ зохион байгуулалттай бүлэг этгээд үйлдвэл хүндрүүлэхээр заажээ. Энэ нь бусад эд хөрөнгө хулгайлах гэмт хэрэгт хэрэглэх ялтай харьцуулбал илүү хүнд ял оногдуулах болсон нь энэ төрлийн гэмт хэрэгтэй хийх тэмцэлд чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон нь хулгайлах бусад төрлийн гэмт хэргээс тусгаарлаж тусад нь 123¹ зүйлд хуульчилж өгснөөс эхэлсэн гэж хэлж болох юм.

123¹. Мал хулгайлах

1. Бусдын малыг хулгайлсан бол гурваас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг давтан буюу урьдчилан тохиролцсон бүлэг этгээд үйлдсэн, эсхүл хээлтэй болон нялх төлтэй эх мал хулгайлсан бол дөрвөөс зургаан жил хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3. Энэ хэргийн улмаас хохирогч амьдралын эх үүсвэрээсээ салсан, нийтэд учирсан гамшигт байдлыг далимдуулж буюу машин механизм ашиглаж, эсхүл айлын хотноос болон гойд ашиг шимт мал, хурдан жороо морь хулгайлсан, хохирогчийг тохуурхан даажигнаж үйлдсэн бол дөрвөөс арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг этгээд буюу онц аюултай гэмт хэрэгтэн үйлдсэн, эсхүл олон тооны мал хулгайлсан бол таваас хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: малыг ашиглан шамшигдуулахдаа энэ хуулийн 124, 125, 126, 127, 130 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн бол эдгээр зүйлийг хэрэглэнэ. Эрүүгийн хуулийн 131 дүгээр зүйл нь малыг хулгайлах гэмт хэрэгт хамаагүй.

Харин 2002 оны Эрүүгийн хуульд мал хулгайлах гэмт хэрэг нь бие даасан гэмт хэрэг биш. Эд хөрөнгө хулгайлах гэмт хэргийн зохицуулалтад багтдаг байсан учир зохион байгуулалттай гэмт бүлэг тухайн гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд тухайн зүйл заалтын хүндрүүлэх нөхцөлөөр зүйлчлэгддэг байв.

145.3.Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн, эсхүл энэ хэргийн улмаас хохирогчийг амьдралын эх үүсвэрээс нь салгасан буюу их хэмжээний хохирол учирсан, түүнчлэн гамшгийг далимдуулж үйлдсэн бол эд хөрөнгийг хурааж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Харин одоо хүчин төгөлдөр дагаж мөрдөж буй Эрүүгийн хуулийн 17.12.3.2 буюу мал хулгайлах гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн гэдгийг дараах байдлаар хуульчилжээ.

17.12 дугаар зүйл. Мал хулгайлах

1.Бусдын малыг хулгайлсан бол зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Зохион байгуулалттай гэмт бүлэг гэдгийг тодорхойлбол Эрүүгийн хуулийн 3.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар гэмт хэрэг байнга үйлдэж ашиг олох зорилгоор урьдчилан нэгдсэн гурав, түүнээс олон хүний тогтвортой нэгдлийг зохион байгуулалттай гэмт бүлгийг ойлгодог. Зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулсан, удирдсан хүнийг зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулсан, удирдсан үйлдэлд нь ба зохион байгуулалттай гэмт бүлгийн бусад гишүүний үйлдсэн гэмт хэргийн гүйцэтгэгчид тооцож ял оногдуулах ба зохион байгуулалттай гэмт бүлгийн гишүүнийг зохион байгуулалттай гэмт бүлэгт элссэн үйлдэлд ба өөрийнх нь үйлдсэн гэмт хэрэгт ял оногдуулах тухай уг зүйлийн 2 болон 3 дахь хэсгүүдэд хуульчилжээ.

Хууль тогтоогч Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон”, “зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн” гэх шинжүүдийг онц хүндрүүлэх шинж болгон хуульчилсан нь практик дахь судалгаанд тулгуурлан аюулын шинж, хэр хэмжээг бодитой үнэлсэн зохицуулалт болсон гэж дүгнэж байна.

ЦЕГ-аас гаргасан “Мал хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөл, анхаарах зарим асуудал сэдэвт судалгааны ажлын тайлан”-д өгүүлснээр тухайн үед дараах нөхцөл байдал тогтоогдсон байна⁶¹ :

- Бүлэг зохион байгуулалтын хэлбэрт шилжиж, гэмт хэргийн бүлэглэлийг бий болгож, мал, мах, түүхий эдийн гарал үүслийн гэрчилгээг хуурамчаар үйлдэх
- Хулгайлсан мал, мах, түүхий эдээ борлуулах ченжийг урьдаас судалж тогтоох, мөнгийг урьдчилан авах, хулгайлсан зүйлээ хаана, хэзээ уулзаж өгөх зэргээр үгсэн тохиролцож гэмт хэрэг үйлддэг нарийн зохион байгуулалттай сүлжээнд орсон.

Дараах нөхцөл байдлыг үнэлэн “Малын хулгайн гэмт хэрэг нь нууц далд зохион байгуулалттай бизнесийн хэлбэрт шилжиж хүмүүсийн амжиргааны орлогын эх үүсвэр болоход хүрсэн байна” гэсэн дүгнэлтийг хийжээ.

61 ЦЕГ, Монгол Улс дахь 2010 оны гэмт хэргийн байдал, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам, 2011, 135 дахь тал.

Харин шүүхийн практикийг авч үзвэл, өмнөх бүлэгт тодорхойлсноор тухайн зохицуулалт батлагдсанаас хойш тухайн зүйл, ангиар зүйлчлэгдэж шийдэгдсэн тохиолдол бүртгэгдээгүй байна. Энэ нь дээр дурдсан практикийн байгууллага буюу Цагдаагийн ерөнхий газрын тайлангаас зөрж байгаа бөгөөд нийгэмд тухайн зүйл, ангиар зүйлчлэгдэх ёстой гэмт хэрэг гарсаар байгааг харуулж байна. Энэхүү асуудал нь тухайн хуулийн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт сөргөөр нөлөөлж байна.

ДӨРӨВ. МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ЯЛЫН БОДЛОГО

Шинэчлэн найруулсан ЭХ-ийн 5.2 дугаар зүйлд торгох ял, нийтэд тустай ажил хийлгэх ял, зорчих эрхийг хязгаарлах ял, хорих ял, эрх хасах ял гэсэн 5 ялын төрлийг, мөн хуулийн 7.2 дугаар зүйлд үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ гэсэн 3 албадлагын арга хэмжээний төрлийг хуульчилжээ.

Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан бүх гэмт хэрэгт хорих ял оногдуулахаар байсан нь хуулийн үзэл баримтлал, дэвшүүлсэн зорилттой нийцэхгүй байсан тул 2017 онд хуулийг хэрэгжиж эхлэхээс өмнө зарим төрлийн нийгэмд учруулах хор аюул багатай гэмт хэргүүдэд хорих ял оногдуулахгүй байх, үүнтэй холбогдуулан хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэгт нийтэд тустай ажил хийлгэх ялыг өргөн хэрэглэх бололцоог бүрдүүлэх зорилгоор нийтэд тусгай ажил хийх ялыг оногдуулах боломж нөхцөлийг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар нэмэгдүүлсэн юм.

Эрүүгийн хууль 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэхэд тус хуулийн 17.12 дугаар зүйлийн хувьд хорих, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх гэсэн ялын төрлүүдийг оногдуулахаар хуульчилсан байв.

4.1. Зорчих эрх хязгаарлах ял

Зорчих эрх хязгаарлах ял нь 2015 оны шинэчлэн найруулсан ЭХ-иар Монголын эрүүгийн эрх зүйд шинээр орж ирсэн ялын төрөл юм. ЭХ-ийн 5.5 дугаар зүйлд зааснаар энэхүү ялыг гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг хязгаарлахыг ойлгодог. Энэхүү ялын хэмжээ нь Эрүүгийн хуульд зааснаар 1 сараас 5 жил хүртэл хугацаатай байна.

Гэвч энэхүү ялыг гүйцэтгэх техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах үүднээс хэрэгжилтийг хоёр удаа хойшлуулсан байдаг. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаар “Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилтийг хангах арга хэмжээний тухай” 106 дугаар тогтоолыг баталснаар уг тогтоолын дагуу 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус ял хэрэгжиж эхэлсэн.

Мал хулгайлах гэмт хэргийн хувьд ЭХ-ийн 17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт 6 сараас 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ялыг оногдуулахаар хуульчилсан нь эрүүгийн хууль дахь зорчих эрхийг хязгаарлах ялыг хамгийн урт хугацаагаар оногдуулахаар зохицуулсан гэмт хэрэг байна. Мөн түүнчлэн дээр

дурдсанчлан уг ялын хэрэгжилтыг хойшлуулсан хугацаанд уг ялыг мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулаагүй байна.

4.2 Хорих ял

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд дурдсанаар 2002 оны Эрүүгийн хууль хэрэгжиж байх үед нэг жилийн хугацаанд нийт ял шийтгүүлж байсан этгээдүүдийн 90 шахам хувьд нь хорих ялыг оногдуулж байжээ.⁶² Үүнийг академич С.Нарангэрэл 2002 оны ЭХ-ийн санкцыг зөвхөн хорих ял бүхий туйлын тодорхой болгосон, сонгох санкцыг багасгасан, хорихоос өөр төрлийн ялын үр нөлөөг дээшлүүлж чадаагүйтэй холбон тайлбарласан байна⁶³.

2013 онд зохион байгуулагдсан “Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт, чиг хандлага” олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд дурдсанаар хорих ял эдлээд гарсан хүмүүсийн 30 орчим хувь нь дахин гэмт хэрэг үйлддэг, анхан шатны эрүүгийн шүүхийн ял оноосон тогтоолын 45-аас 48 хувьд нь ялын нөхцөл, хэмжээ өөрчлөгддөг зэрэг нь ялын бодлого бүхэлдээ өөрчлөгдөх шаардлагатай болсныг харуулж байна⁶⁴ хэмээн дүгнэж байжээ. Тийнхүү өөрчлөхдөө ялын бодлогод хүмүүнлэгийн хандлагыг тусгах замаар хорихоос өөр төрлийн ялын төрлийг олшруулах, олон сонголттой болгох⁶⁵ шаардлагатай гэж судлаачид үзэж байв.

Дээрх нөхцөл байдал, шаардлагаар нөхцөлдөн батлагдсан 2015 оны Эрүүгийн хууль нь гэмт хэрэгт оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын асуудлын хувьд зарчмын шинжтэй, томоохон өөрчлөлт орсон бөгөөд хорих ялыг шоронд биечлэн эдлэх явдлыг багасгахад анхаарч, хүмүүнлэг ёсны хандлагыг бий болгоход дорвитой алхам боллоо хэмээн судлаачид үнэлсэн байна.

Гэвч хорих ялын хэмжээний хувьд авч үзвэл 1986 оны ЭХ-д 6 сараас 10 жил хүртэл⁶⁶, 2002 оны ЭХ-д 1-15 жил байхаар тус тус тогтоож байсан бол 2015 оны шинэчлэн найруулсан ЭХ-д хорих ялын хэмжээ 6 сараас 20 жил хүртэл байхаар хуулийн 5.6 дугаар зүйлийн 3-т тогтоосон байгаа нь өмнөх хуулиудаас илүү уртасгасан зохицуулалт болсон байна. Академич С.Нарангэрэл ийнхүү зохицуулсныг хорих ялыг хавтгайруулан хэрэглэхэд хүргэх сөрөг талтай хэмээн үзжээ⁶⁷.

Мал хулгайлах гэмт хэргийн хувьд хорих ялын хугацаа үндсэн бүрэлдэхүүн буюу 17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 6 сараас 5 жил, хүндрүүлэх бүрэлдэхүүн буюу уг зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 2 жилээс 8 жил, онц хүндрүүлэх бүрэлдэхүүн буюу уг зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар 5 жилээс 12 жил байхаар хуульчилсан байна. Энэ нь ЭХ-ийн 2.6 дугаар зүйлд зааснаар мал хулгайлах

62 Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, 2013, 19 дэх тал.

63 С.Нарангэрэл, Ж.Эрдэнбулган, Монгол Улсын Эрүүгийн Эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж, 2019, 258 дахь тал.

64 Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт, чиг хандлага олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл 1, 2013.


65 Д.Баярсайхан, Эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын шинэтгэлийн асуудлууд, 2019, 103 дахь тал.

66 Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. 2011, 442 дахь тал.

67 С.Нарангэрэл, Ж.Эрдэнбулган, Монгол Улсын Эрүүгийн Эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж, (2019, 260 дахь тал.

гэмт хэрэг нь үндсэн бүрэлдэхүүний хувьд хорих ялын дээд хэмжээг 5 жилийн хугацаагаар оногдуулахаар заасан тул хөнгөн гэмт хэрэг, харин хүндрүүлэх болон онц хүндрүүлэх бүрэлдэхүүний хувьд хорих ялын доод хэмжээг хоёр жил, таван жилийн хугацаатайгаар оногдуулахаар заасан байх тул хүнд гэмт хэрэг байна.

График 4.10. Мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн ялтнуудын тоог ялын төрлөөр ангилсан тоон мэдээлэл



2019 онд ЭХ-ийн 17.12 дугаар зүйлийн дагуу шинээр ял шийтгэгдсэн нийт 297 ялтны 157 нь буюу 52.8 хувь нь хорих ялаар шийтгэгдсэн байсан бол 2020 онд нийт 479 ялтны 306 нь буюу 63.8 хувь нь хорих ялтаар шийтгэгдсэн байна. Эндээс харвал мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс хорих ялыг түлхүү оногдуулж байжээ. Мөн түүнчлэн 2020 онд хорих ялаар шийтгэгдсэн ялтны нийт ялтны тоонд эзлэх хувь өмнөх оноос даруй 11 пунктээр өссөн нь 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн “Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиар ЭХ-ийн 17.12 дугаар зүйлээс нийтэд тустай ажил хийлгэх ялыг халсан, зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжиж эхлээгүйтэй холбоотой байж болох юм.

4.3 Нийтэд тустай ажил хийлгэх ял

ЭХ-ийн 5.4 дүгээр зүйлийн 1-т нийтэд тустай ажил хийлгэх ял гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэх хэмээн хуульчлан тодорхойлжээ. Энэхүү ялын онолын үндэслэл нь хүнд биш гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр нийгэмд ашиг тустай ажил хөдөлмөрт татан оруулах замаар засан төлөвшүүлэх зорилготой байдаг.⁶⁸

Нийтэд тустай ажил хийлгэх ял нь цаашид боловсронгуй болж хөгжих ялын төрөлд багтдаг бөгөөд орчин үед нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэглээ ач холбогдол үлэмж дээшилсэн нь энэ ялын хэрэглээ нэмэгдэж, тухайн ялын төрлийн алтернатив нөхцлийг оновчтой тогтоох явдал зайлшгүй болж олон улс орны өргөн дэмжлэгийг олж байгаа ажээ.⁶⁹ Мөн түүнчлэн судлаачид энэхүү ялыг манай улсад үр нөлөөтэй хэрэгжүүлж чадвал ялтны хувьд ч, тухайн нутаг орны хувьд ч ашиг

68 Ц.Мөнхбат, Нийтэд тустай ажил хийлгэх ял: Уламжлал, харьцуулалт, шинэчлэл хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл, 2021, 22 дахь тал.

69 Д. Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, 2011, 150 дахь тал.


тусаа өгөхүйц үр өгөөжтэй ял хэмээн үздэг⁷⁰.

Гэвч манай улсын практикт нийтийн ашиг сонирхолд тустай ямар ажлыг нийгэмд ашигтай ажил гэх нэгдсэн ойлголт тогтоогүй, энэхүү ажлын жагсаалт одоог хүртэл байхгүй, энэ талаар Улсын Дээд шүүх холбогдох тайлбар гаргаагүй, шүүхийн шийдвэр гүйцэтгэгчдийн ажлын ачаалал хэт их зэрэг шалтгаануудын улмаас ялын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байгаа тухай хэд хэдэн судалгаанд өгүүлжээ.

2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс Эрүүгийн хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэхэд хуулийн 17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт 240 цагаас 720 цагийн нийтэд тустай ажил хийлгэх ялыг оногдуулахаар заасан байсан ч 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн хуульчилсан юм. Уг “Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийн 3 дугаар зүйлд заасанчлан ЭХ-ийн 17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл” гэснийг хассан байна. Ийнхүү энэ гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний сонгох санкцаас нийтэд тустай ажил хийлгэх ялыг хасах болсон үндэслэлийг хуулийн үзэл баримтлалд “...шүүхийн практикаас харахад дээрх зүйлийн дагуу цөөн тооны мал хулгайлсан этгээдэд хорихоос өөр төрлийн буюу нийтэд тустай хөдөлмөр эрхлэх шийтгэл хүлээлгэх нь түгээмэл бөгөөд ялын энэ төрлөөр шийтгэгдсэн гэмт этгээдүүдийн дийлэнх нь малчинд учруулсан хохирлоо нөхөн төлөлгүй, гэм буруугаа хүлээн зөвшөөрөхгүй өнгөрч, малаа алдсан иргэд хохирч үлдсээр байна. Хорихоос өөр төрлийн ял шийтгэж байгаа тохиолдолд Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлийн дагуу гэмт этгээд ял хөнгөрүүлэх зорилгоор гэм буруугаа хүлээн зөвшөөрч, хохирол барагдуулах нөхцөл хангагдахгүй байна.” хэмээн тайлбарлажээ.

Хууль санаачлагч ийнхүү нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагыг шүүхийн практикт үндэслэсэн гэж бичсэн байгаа ч төслийн хавсралтад иргэдээс авсан саналыг хавсаргаснаас өөр баримт байхгүй байна. Иймд уг ялын хэрэгжилтэд тодорхой хэмжээнд (мал хулгайлах гэмт хэрэгт оногдуулсан хүрээнд) үнэлэлт дүгнэлт өгөх шаардлагатай гэж үзлээ.


График 4.11. Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтны тоон мэдээлэл



70 С.Нарангэрэл, Ж.Эрдэнбулган, Монгол Улсын Эрүүгийн Эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж, 2019, 257 дахь тал.

Мал хулгайлах гэмт хэрэг үйлдэж нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтны тоон мэдээллийг авч үзвэл 2018 онд өмнөх оноос 4 дахин, 2019 онд өмнөх оноос 2 дахин өссөн бол 2020 онд 33 ялтнаар нэмэгдсэн байна. Эндээс мал хулгайлах гэмт хэрэг үйлдэж нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтны тоо уг ялыг оногдуулдаг байсан жилүүдэд тасралтгүй өсөж байсан нь харагдаж байна.

График 4.12. Хорих ялаар шийтгүүлсэн ялтны тоо, нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтны тоог харьцуулсан нь



2019 онд шинээр ЭХ-ийн 17.12 дугаар зүйлээр ял шийтгэгдсэн ялтнуудын 52.8 хувийг хорих ялаар, 47.1 хувийг нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгэгдсэн ялтнууд эзэлж байсан бол 2020 онд нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгэгдсэн ялтны нийт ялтны тоонд элзэх хувь 36.1 хувь болж буурсан байна.

Нийтэд тустай ажил хийлгэх ялыг ЭХ-ийн 17.12 дугаар зүйлээс халахаас өмнө мал хулгайлах гэмт хэрэг үйлдэж нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн ялтан, хорих ялаар шийтгүүлсэн ялтны тоотой ойролцоо байгаа нь дээрх тоон мэдээллээс харагдаж байна.

ШШГЕГ-т нийслэлийн болон орон нутгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ял эдэлж байгаа ялтнуудын Эрүүгийн хуулийн аль зүйлээр шийтгэгдэж байгаагаар нь ангилсан тоон мэдээлэл байдаггүй ч мал хулгайлах гэмт хэрэг нь дийлэнхдээ орон нутагт үйлдэгддэг учир дээрх нийтэд тустай ажил хийлгэх ялыг орон нутгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт гүйцэтгэсэн гэж үзэж болохоор байна.

Судлаачдын үзэж буйгаар орон нутагт нийтэд тустай ажил хийлгэх ялыг гүйцэтгэхэд ял эдлүүлэх ажлын байр байхгүй, эсхүл нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага хяналт тавих боломжгүй үед нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн этгээдийг аймгийн төвд ял эдлүүлж байгаа практик нэгэнт тогтсон байх бөгөөд ийнхүү ял эдлүүлэх явцад дараах хүндрэл гарч байна:

- Хөдөө сум, багт оршин суух ялтнууд аймгийн төвд ял эдлэх тохиолдолд амьдран суух гэр оронгүй;
- Мөнгө санхүүгийн хувьд ихээхэн хэмжээний зарлага гардаг;
- Өдөрт гүйцэтгэх ажлын биелэлтийн хугацаа бага учраас доод тал нь 3 сараас доошгүй хугацаагаар ар гэрээсээ хол байх шаардлагатай;
- Хүн бүл цөөтэй малчин хүмүүс ар гэртээ санаа зовдгоос ялыг хэлбэр төдий эдэлдэг⁷¹. гэх мэт

Судалгааны хүрээнд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нараас нийтэд тустай ажил хийлгэх ялын талаар дараах асуулгыг авахад доорх үр дүнг үзүүлсэн болно.

Хүснэгт 4.33. Асуулга 17 2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйл буюу “Мал хулгайлах” гэмт хэргийн зохицуулалтад оруулсан өөрчлөлтөөр нийтэд тустай ажил хийлгэх ялыг хассан нь зөв гэж Та үзэж байна уу?

Д/д	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Тийм	83	79.8%
2	Үгүй	21	20.2%
Нийт		104	100%

Тухайн асуулгад оролцсон нийт 110 цагдаагийн алба хаагчаас 104 нь хариулт өгсөн ба үүнээс 83 цагдаагийн алба хаагч “Тийм” гэж хариулсан бол 21 цагдаагийн алба хаагч “Үгүй” гэж хариулсан байна.

Хүснэгт 4.34. “Тийм бол яагаад?” гэх асуултад хариулсан байдал.

Д/д	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Хорих ял оногдуулж, ялын бодлогыг чангалах нь зүйтэй	27	52.9%
2	Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой	15	29.4%
3	Ялын хэрэгжилт үр дүнгүй, орон нутагт үр дүнгүй	7	13.7%
4	Ял завших боломжийг бүрдүүлдэг	1	2%
5	Нийтэд тустай ажил хийлгэх ялын хяналт муу	1	2%
Нийт		51	100%

Тухайн асуултад асуулгад оролцсон нийт “Тийм” гэж хариулсан 83 цагдаагийн алба хаагчийн 53 нь хариулт өгсөн бөгөөд оновчтой хариулсан 51 байна. Үүнээс “Хорих ял оногдуулж, ялын бодлогыг чангалах нь зүйтэй” гэж үзсэн 27, “Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой” гэж үзсэн 15, “Ялын хэрэгжилт үр дүнгүй, орон нутагт үр дүнгүй” гэж үзсэн 7, “Ял завших боломжийг бүрдүүлдэг” гэж үзсэн 1, “Нийтэд тустай ажил хийлгэх ялын хяналт муу” гэж үзсэн 1 тус тус байна.

Хүснэгт 4.35. “Үгүй бол яагаад?” гэх асуултад хариулсан байдал.


Д/д	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Нийгэмшүүлэх, ухамсар суулгах хэрэгтэй	3	27.3%
2	Ялын олон төрөл байх ёстой	3	27.3%
3	Хохирол барагдуулахад хэрэгтэй	2	18.2%

71 Д.Алтанцэцэг, Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилтэд тулгамдаж байгаа асуудал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилт, цаашид анхаарах асуудал сэдэвт Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 2019, 156 дахь тал.

4	Олон нийтэд зарлах	1	9.1%
5	Хөдөлмөр эрхлүүлэх нь зүйтэй	1	9.1%
6	Хорих ялтай нэг төрлийн ял	1	9.1%
Нийт		11	100%

Тухайн асуултад асуулгад оролцсон нийт “Үгүй” гэж хариулсан 21 цагдаагийн алба хаагчийн 20 нь хариулт өгсөн бөгөөд оновчтой хариулсан 11 байна. Үүнээс “Нийгэмшүүлэх, ухамсар суулгах хэрэгтэй” гэж 3, “Ялын олон төрөл байх ёстой” гэж 3, “Хохирол барагдуулахад хэрэгтэй” гэж 2, “Олон нийтэд зарлах” гэж 1, “Хөдөлмөр эрхлүүлэх нь зүйтэй” гэж 1, “Хорих ялтай нэг төрлийн ял” гэж 1 цагдаагийн алба хаагч тус тус хариулжээ.

График 4.13. Нийслэлийн болон орон нутгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт нийтэд тустай ажил гүйцэтгэх ялаар шийтгэгдсэн ялтны тоо



2017 онд Улсын хэмжээнд нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгэгдсэн ялтнуудын ялын 66.4 хувийг, 2018 онд 55.9 хувийг, 2019 онд 46.7 хувийг, 2020 онд 50.1 хувийг тус тус орон нутгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт гүйцэтгүүлсэн байх бөгөөд уг ялаар шийтгэгдсэн нийт этгээдийн 51.8 хувийн ялыг орон нутгийн шийдвэр гүйцэтгэх газарт гүйцэтгүүлсэн байна.

Нэг шийдвэр гүйцэтгэгч нийтэд тустай ажил гүйцэтгэх ялтай этгээдээс гадна торгох, эрх хасах зэрэг бусад ялын биелэлтэд хяналт тавьж байгаагаас ажлын ачаалал ихсэж “Шийдвэр гүйцэтгэгч 7 хоног тутам ялтны ажлыг биечлэн шалгаж, ажлын байрыг шалгасан тэмдэглэлд ялтан болон нийтэд тустай ажлыг хийлгэж буй байгууллагын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна⁷²” гэсэн заалт практикт хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайд нарын хамтарсан 2017 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн А/247, А/167, 303 дугаар тушаалаар баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг нормативыг тогтоох тухай журамд Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэх орон нутгийн шийдвэр гүйцэтгэгч 120 гүйцэтгэх баримт бичиг хариуцахаар заасан байхад 2019

72 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017, 163 дугаар зүйлийн 163.8 дахь хэсэг.

оны эхний хагас жилийн байдлаар нэг шийдвэр гүйцэтгэгч 336 гүйцэтгэх баримт бичигт ажиллагаа хийж байгаа нь тогтоосон нормативаас 2 дахин их ачаалалтай ажилласныг харуулж байна⁷³.

Энэхүү нэмэлт өөрчлөлт нь хууль санаачлагчдын үзэл баримтлалд дурдсанаар мал хулгайлах гэмт хэргийн эсрэг шийдвэртэй тэмцэл явуулан, гэм буруутай этгээдэд хуульд заасан ялыг шударгаар оногдуулж, учирсан хохирлыг шуурхай, бодитой арилгах урьдчилсан нөхцлийг бүрдүүлэх зорилготой. Гэсэн ч өөрчлөлтийн үндсэн агуулга нь ялыг хүндрүүлж, хорих ялын хэмжээг нэмэгдүүлснээр хязгаарлагдсан байна.

Ийнхүү нийтэд тустай ажил хийлгэх ял эдлүүлэх явцад тодорхой хүндрэл гарч байсан нь уг ялыг халах үндэслэл болохгүй. Харин ШШГБ уг ялыг эдлүүлэх ажиллагаанд учирч буй асуудал, бэрхшээлийг арилгахад чиглэсэн арга хэмжээг авах ёстой юм.

4.4 Ялын үр нөлөө

Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1-т зааснаар эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршдог билээ.

Эрүүгийн хуульд заасан ялын зорилго хангагдсан байх нь эрүүгийн хуулийн гэмт хэрэгтэй тэмцэх үүргээ биелүүлсэн эсэхийг тогтоох гол шалгуур юм. Гэмт хэргийн улмаас зөрчигдсэн эрхийг сэргээх, шударга ёсыг тогтоох ялын зорилго хангагдсан байх нь тухайн ял үр нөлөөтэй байгааг илтгэдэг. Харин зөрчигдсөн эрхийг сэргээх ялын зорилго нь юуны өмнө гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулснаар хангагдана.

Ялын урьдчилан сэргийлэх тусгай зорилгод ял шийтгүүлэгсдэд зан суртахууны шаналал, гачигдал учруулах тодорхой хязгаарлалтыг хэрэгжүүлэх замаар хүрнэ.⁷⁴ Энэхүү зорилго нь айлган эмээлгэж, хүмүүжүүлэх явдлаас гол төлөв бүрэлддэг. Ял эдэлж байгаа этгээд ихэвчлэн ялын агуулгаас эх үүсвэртэй шаналал, гачигдал дахин амсахгүйн тулд гэмт хэрэг шинээр үйлдэхээ больдог. Үүний тулд урьдчилан сэргийлэлт нь ялаар дамжуулан хүмүүжүүлэх бололцоог буй болгодог ач холбогдолтой.

Гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдэж төрийн цээрлэл амссан этгээд дахин шинээр гэмт хэрэг үйлдэхгүй байх нь ялын зорилго хангагдаж ялтнуудад эерэг нөлөөлөл үзүүлснийг нотлох нэг чухал шалгуур юм.⁷⁵ Харин гэмт хэрэг үйлдэж ялын цээрлэл амссан хүмүүс дахин шинээр гэмт хэрэг үйлдэж байгаа нь ялын нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх зорилго биелэгдэхгүй байгаагийн⁷⁶ илрэл болдог. Иймд мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэмт хэрэг давтан үйлдсэн байдлыг авч үзье.

73 Б.Жаргалмаа, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилт, чиг хандлага, Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2019, 209 дэх тал.

74 139


75 С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн Эрх зүйн онол, ялын тухай сургааль, 2014, 147 дахь тал.

76 Мөн тэнд, 147 дахь тал.

4.4.1 Давтан гэмт хэрэг үйлдэж буй байдал


Мал хулгайлах хэргийг үйлдэж байсан этгээд дахин уг гэмт хэргийг үйлдсэн тоон мэдээлэл цагдаагийн байгууллагын мэдээлэлд бүртгэгддэггүй ба анх удаа Мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдийн тоо 2020 онд хамгийн их буюу 307, 2017 онд хамгийн бага буюу 45 байна. Харин урьд бусад төрлийн гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдэж байсан этгээдийн тоо 2018 онд хамгийн их буюу 287, 2020 онд хамгийн бага буюу 30 байна.

График 4.14. 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх урьд гэмт хэрэг үйлдэж байсан этгээд мал хулгайлах гэмт хэргийг үйлдсэн тоон мэдээлэл



Цагдаагийн байгууллагын статистикт дурдсанаар, мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн нийт этгээдийн 2017 онд 65.9 хувийг, 2018 онд 62.1 хувийг, 2019 онд 52.7 хувийг, 2020 онд 8.9 хувийг, 2021 оны 5 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар 56.3 хувийг тус тус урьд гэмт хэрэг үйлдэж байсан этгээд эзэлж байна.

График 4.15. 2019 болон 2020 онд ЭХ-ийн 17.12 дугаар зүйлээр шийтгэгдэж шинээр хорих ангид ирсэн хоригдлыг урьдах ял, шийтгэлийн байдлаар нь ангилсан тоон мэдээлэл⁷⁷




77 ШШГЕГ, 2017-2020 оны ял, албадлагын арга хэмжээ болон цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний харьцуулсан тоон судалгаа, 2021, 13 дахь тал

Тэнсэж хяналт тогтоолгож байсан хоригдлын тоо 2019 онд нийт хоригдлын 5 хувийг эзэлж байсан бол 2020 онд шинээр хоригдсон хоригдлын 16.9 хувь болж нэмэгдсэн байна.

Хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлж байсан хоригдлын нийт хоригдлын тоонд элзэх хувь 2019 онд 4.4 хувь байснаас 2020 онд 14.4 хувь болж, хорих ял эдлээд суллагдаж байсан хоригдлын нийт хоригдлын тоонд элзэх хувь 16.5 хувь байснаас 2020 онд 26.1 хувь болж тус тус өссөн байна. Харин анх удаа шийтгүүлсэн хоригдлын нийт хоригдлын тоонд элзэх хувь 2019 онд 73.8 хувь байснаас 2020 онд 42.4 хувь болж буурчээ.

График 4.16. 2020 онд Монгол Улсын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр ЭХ-ийн 17.12 дугаар зүйлээр ял оногдуулсан этгээдүүдийн давтан гэмт хэрэг үйлдсэн байдлын тоон мэдээлэл



Монгол Улсын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр мал хулгайлах гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн талаарх дэлгэрэнгүй мэдээлэлд дурдсанаар, 2020 онд Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлээр нийт 389 хэрэгт 673 хүн шийтгэгдсэнээс 454 хүн буюу 67.4 хувь нь анх удаа гэмт хэрэг үйлдсэн бол, 134 хүн буюу 19.9 хувь нь 2 дахь удаагаа, 86 хүн буюу 12.7 хувь нь 3 ба түүнээс дээш удаагаа гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн хүн байна.

2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр ЭХ-д орсон нэмэлт өөрчөлт хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн 2020 онд Мал хулгайлах гэмт хэргийн тоо өмнөх оноос 768-аар буюу 42.5 хувиар буурсан хэдий ч урьд ял шийтгэгдэж байсан этгээдүүд тус гэмт хэргийг үйлдсэн тоон мэдээлэл өссөн байна. 2020 онд Ковид-19 цар тахалтай тэмцэх үүднээс Монгол Улс Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдалд шилжиж, хөл хориог нийслэл Улаанбаатар хотод 10 сарын туршид 97 хувьтай хэрэгжүүлсэн⁷⁸ бөгөөд хөдөө орон нутгаас хотыг чиглэх хөдөлгөөнд хяналт шалгалтыг чангатгасан. Гэсэн хэдий ч урьд ял шийтгэгдэж байсан этгээдүүд мал хулгайлах гэмт хэргийг үйлдсэн тоо өссөн байгаа нь анхаарал татаж байна.

Ийнхүү тус гэмт хэргийг давтан үйлдэгсдийн тоо өссөн нь ялын нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх зорилго биелэгдэхгүй байгааг харуулж байна.

Судалгааны хүрээнд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нараас гэмт этгээд энэ гэмт хэргийг давтан үйлдэх шалтгаан нөхцлийг тодруулах зорилгоор дараах асуулгыг авахад доорх үр дүнг үзүүлсэн болно.

78 Монгол улс-2020 онд, <https://montsame.mn/mn/read/247649>.

Хүснэгт 4.36. Асуулга 2. Таны бодлоор мал хулгайлах гэмт хэргийг давтан үйлдэх шалтгаан, нөхцөл юу вэ?

Уг асуулгад нийт 87 оролцогч хамрагдсан бөгөөд шалгаан нөхцөлийн талаар ирүүлсэн хариултыг багцлан үзвэл:

Д/д	Шалтгаан, нөхцөл	Тоо	Хувь
1.	Орлогын эх үүсвэргүй, амьжиргааны түвшин доогуур, ажилгүйдэл өндөр байгаатай холбоотой	21	24.1
2.	Шунахайн сэдлээр, амар хялбар аргаар ашиг олох зорилготой холбоотой	23	26.4
3.	Ялын бодлого сул, махны ченж нарын үйл ажиллагаанд тавих эрх зүйн зохицуулалт дутмаг	25	28.7
4.	Малаа хариулгагүй орхидог байдалтай холбоотой	10	11.4
5.	Мөрдөн шалгах процесс ажиллагаа дэндүү нуршуу удаашралтай, прокурор шүүхийн шатанд маш их уддаг учир дахин гэмт хэрэг үйлдэж хэргийн шийдвэрлэлт удааширдаг	8	9.1

Асуулгад хамрагдагсдын 28 гаруй хувь нь эрх зүйн зохицуулалт дутмаг, ялын бодлого сул байгаатай холбоотойгоор, 26 гаруй хувь нь шунахайн сэдлээр, амар хялбар аргаар ашиг олох зорилготой холбоотой уг гэмт хэргийг давтан үйлддэг гэж хариулсан байна. Түүнчлэн амьжиргааны түвшин доогуур, орлогогүй байгаа нь уг гэмт хэргийг давтан үйлдэхэд нөлөөлж байна гэж үзжээ.

4.4.2 Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлсэн байдал


Гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, шударга ёсыг тогтоох ялын зорилго нь хангагдсан байх нь тухайн ял үр нөлөөтэй байгааг илтгэдэг. Зөрчигдсөн эрхийг сэргээх ялын зорилго нь юуны өмнө гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулснаар хангагдана.⁷⁹

Төрөөс хамгаалагдаж буй иргэн, нийгмийн эрх, ашиг сонирхол гэмт хэргийн халдлагад өртөж, зөрчигдсөн үед түүнийг нөхөн сэргээх үүргийг төр хүлээсэн. Зөрчигдсөн эрхийг сэргээхийн мөн чанар бол гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял завшуулалгүйгээр, хохирогчийн эрхийг хуулиар хамгаалсаар байгаагаа гэмт буруутай этгээдэд ял шийтгэх замаар илэрхийлж байгаад оршино. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял завшуулбал түүний үйлдсэн гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрх сэргээгдэхгүй бөгөөд гэм буруутай этгээдэд ял оногдуулж байгаа нь хэрэв хэн нэгэн дахин энэ мэтээр гэмт хэрэг үйлдвэл ийм байдлаар ял шийтгэнэ, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээж, хуулиар хамгаалсан буйг баталж байгаа явдал юм.⁸⁰

79 С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн Эрх зүйн онол, ялын тухай сургааль, 2014, 147 дахь тал.

80 Мөн тэнд, 134 дэх тал.


График 4.17. 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх мал хулгайлах гэмт хэргийн улмаас учирсан хохирлын болон нөхөн төлүүлэлтийн хэмжээ (сая,төг)



Дээрхээс харахад, хохирлын хэмжээ жил ирэх тусам буурсан үзүүлэлтэй байгаа бөгөөд 2019 онд хохирлын 36.1 хувийг нөхөн төлүүлж, 6.6 хувийг битүүмжилсэн бол, 2020 онд 45.5 хувийг нөхөн төлүүлж, 14.1 хувийг битүүмжилсэн, 2021 оны 5 дугаар сарын байдлаар 31.5 хувийг нөхөн төлүүлж, 9 хувийг битүүмжилсэн байна.

Мал хулгайлах гэмт хэргийн улмаас 2016-2018 онд иргэн, байгууллага, аж ахуй нэгжид 8.5 тэрбум төгрөгийн хохирол учирсны 3.5 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж 1.8 тэрбум төгрөгийн хохирлыг битүүмжилсэн байна.

График 4.18. Нөхөн төлүүлэлт, битүүмжлэл, төлөгдөөгүй хохирлын нийт хохиролд эзлэх хувь



Мал хулгайлах гэмт хэргийн улмаас учирсан нийт хохиролд эзлэх төлөгдөөгүй хохирлын хэмжээ ЭХ-ийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлсэн 2017 онд огцом өсөж 2020 он хүртэл өссөн байгаа нь дээрх графикаас харагдаж байна. Харин хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдан хэрэгжиж эхэлсэн 2020 онд 16 орчим хувиар буурчээ.

Мал хулгайлах гэмт хэргийг шалгах эрх бүхий цагдаагийн алба хаагчид хэрэг илрүүлэх, шалгах, гэм бурууг тогтоох нотлох, хэргийг зүйчлэх ажиллагаанд анхаарлаа хандуулж, хохирогчийн хуульд заасан эрхийг тайлбарлах, хэрэгжүүлэх, хохирол нөхөн төлүүлэх боломжийг бүрдүүлэх ажиллагаа хангалтгүй байгаа нь дунджаар нийт учирсан хохирлын 39.1 хувийг нөхөн төлүүлсэн тоон мэдээнээс харагдаж байна. Мөн түүнчлэн цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн байгууллагын тоон мэдээлэлд битүүмжилсэн хөрөнгийг цааш хэрхсэн тухай мэдээлэл тодорхойгүй байна.

Судалгааны хүрээнд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нараас авсан бидний судалгаанд уг гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлүүлэлтийн хэмжээ бага байгааг судалгаанд оролцогчид мал хулгайлах гэмт хэрэг үйлдэгсэд ихэвчлэн орлогогүй, эрхэлсэн тодорхой ажилгүй, малчид голдуу байгаа нь төлбөрийн чадамжгүй гэх шалтгаанаар учирсан хохирлыг барагдуулдаггүйтэй холбоотой гэжээ.

Эндээс зөрчигдсөн эрхийг сэргээх ялын зорилго нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулсан эсэхтэй шууд хамаатай байдгийн хувьд ЭХ-ийн 17.12 дугаар зүйлд зохицуулсан мал хулгайлах гэмт хэргийн зөрчигдсөн эрхийг сэргээх ялын зорилго бүрэн хангагдаж чадаагүй хэмээн дүгнэлээ.

ДҮГНЭЛТ, САНАЛ

1. Прокурорын байгууллага Статистикийн тухай хуулийн 4-р зүйлийн 5 дахь хэсэгт заасан “статистикийн мэдээлэл нь нийтэд хүртээмжтэй, хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд ил тод байх” зарчимд үйл ажиллагаагаа нийцүүлээгүй байна.
2. ШШГЕГ-ын “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.12 дугаар зүйл ангиар шийтгэгдсэн хоригдол болон хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн этгээдүүдийн судалгаа”-нд цагдаа болон шүүхэд бүртгэгдээгүй гэмт хэргээр ял шийтгүүлж буй тухай хэд хэдэн алдаатай мэдээллийг гаргаж өгсөн.
3. ЦЕГ-ын “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал”, ЦЕГ-ийн албан ёсны цахим хаягт байршдаг мэдээлэл, тус байгууллагад албан бичиг илгээн авсан мэдээлэл дэх зарим тоон мэдээлэл хоорондоо зөрүүтэй байгаа нь судалгааны явцад тогтоогдсон.
4. ЦЕГ, ШШГЕГ, ШЕЗ урьд ял шийтгэгдэж байсан тухай мэдээллийг ямар гэмт хэрэг үйлдэж байсан талаар бүртгэлгүй, зөвхөн гэмт хэрэг үйлдсэн гэх ерөнхий байдлаар бүртгэж байгаа нь учир дутагдалтай буюу ач холбогдол багатай байна. Иймд урьд ял шийтгэгдэж байсан тухай мэдээллийг бүртгэхдээ үйлдсэн гэмт хэргийн төрлөөр нь бүртгэдэг болох шаардлагатай байна.
5. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нөхөн төлөлтийн, тэр дундаа битүүмжилсэн эд хөрөнгийг хэрхсэн тухай мэдээллийг ШШГЕГ тогтмол гаргах шаардлагатай.
6. Эрүүгийн хуулийн 17.12.1-ээр зүйлчлэгдсэн гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг тооцохдоо шүүхүүд өөр өөрсдийн байр сууринаас тайлбарлан хэрэглэж байгаа нь эргээд хүний эрхийг зөрчихөд хүргэх эрсдэлтэй. Иймд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар дээрх хийдлийг арилгах зайлшгүй шаардлагатай.
7. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа тодорхой тоо баримт, судалгаанд хангалттай үндэслэлгүй, тус өөрчлөлт хэрэгжиж эхэлсэн үеэс холбогдох хэсэгт зааснаар үйлдэгдсэн гэмт хэрэг огцом өссөн, гэмт этгээдийн нэг гэмт хэргээр хулгайлах малын тоо мөн л огцом өссөн зэргээс 2020 оны Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар өөрчилсөн Эрүүгийн хуулийн 17.12.2.1 дэх хэсгийн хэрэгжилт хангалтгүй хэмээн дүгнэж байна.
8. Эрүүгийн хуулийн 3.7 дүгээр зүйлийн 1-д “Гэмт хэргийг хоёр, түүнээс олон хүн санаатай нэгдэж үйлдсэн бол бүлэглэн гүйцэтгэх гэнэ.” гэж заасан бүлэглэн гүйцэтгэхийг Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйл буюу мал хулгайлах гэмт хэргийн хувьд шүүхийн практикт нэгдмэл байдлаар ойлгож байна. Харин цагдаагийн алба хаагч буюу хууль сахиулагчийн мөрдөн шалгах ажиллагааны практикийн тухайд гэмт хэргийг бүлэглэн гүйцэтгэх арга, хэлбэр нь орчин үед олон янзын аргаар үйлдэгдэж байна.
9. Мал хулгайлах гэмт хэргийг үйлдэхдээ малыг улсын хилээр хуулийн дагуу болон хууль бусаар нэвтрүүлэх аль ч үйлдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь хэрэгжихдээ зөвхөн тухайн гэмт хэргээс урьдчилан

- сэргийлэх арга хэмжээнээс гадна бусад нөхцөл байдлын улмаас хамаарах зохицуулалтаар тухайн гэмт хэргээс урьдчилан сэргийлж байгаа нь ажиглагдаж байна. Эндээс Эрүүгийн хуулийн 17.12.2.3 дахь нь бусад хууль тогтоомжтой уялдаж тухайн төрлийн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх сайн үр дүнг үзүүлж байна.
10. Мал хулгайлах гэмт хэргийг машин механизмыг ашиглаж үйлдэхийг шүүхийн хувьд нэгдмэл байдлаар эрүүгийн эрх зүйн онолд нийцүүлэн хэрэглэж байгаа нь харагдаж байх хэдий ч практикт хэргийн оролцогчид болон хууль сахиулах байгууллагын алба хаагчид хоорондоо адилгүйгээр ойлгож байна. Иймд УДШ албан ёсны тайлбар гаргах, эсхүл хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан нэгмөр болгох шаардлагатай бөгөөд энэ нь уг нэр томъёоны нэгдмэл агуулгыг хангах арга юм.
 11. Мал хулгайлах гэмт хэргийг ноцтой хохирол, хор уршиг учруулж үйлдэхийн хувьд тухайн зохицуулалтын хэрэгжилтийн үр нөлөө сайн байна. Энэ нь тухайн практик нөхцөл байдалтай холбоотой байна.
 12. Эрүүгийн хуулийн 17.12.2.6 буюу мал хулгайлах гэмт хэргийг гойд ашиг шимт малыг хулгайлж үйлдэх үйлдлийн тухайд гойд ашиг шимт малыг шалгаруулах үйл ажиллагаа болон зохион байгуулалтын улмаас гойд ашиг шимт малын нийт малын дунд эзлэх хувийн жин бага байх, тухайн асуудлын улмаас зохицуулалт нь хуулийн үзэл баримтлалд нийцээгүй байх буюу мөн цөм сүргийг тухайн хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчлаагүй байх, хурдны чиглэлийн адуу гойд ашиг шимт малд хамаарагдахгүй байх гэх мэт асуудлууд бий болоод байна. Ийм учир холбогдох журмыг хуульд нийцүүлэх арга хэмжээг авах нь зүйтэй. Түүнчлэн практикт ажиллаж буй цагдаагийн алба хаагчид тухайн зохицуулалтыг хэрэглэхдээ нэгдмэл байдлаар ойлгохгүй байх, гойд ашиг шимт мал шалгаруулах журмыг мэдэхгүй байх, гойд ашиг шимт малыг тодорхойлохгүй байх гэх мэт дутагдлуудыг гаргаж байна. Иймд юун түрүүнд Эрүүгийн хуулийн дээрх зохицуулалтын тухай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарт зүй ёсоор ойлгуулах, таниулах арга хэмжээ зохион байгуулах шаардлагатай.
 13. Мал хулгайлах гэмт хэргийг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон гэх үйлдлийн тухайд шүүхийн болон хууль сахиулагч буюу цагдаагийн алба хаагчийн хууль хэрэглэж буй ойлголт нь ихэнхдээ ижилхэн буюу тухайн үйлдлийн тоо, давтамж чухал гэх тодорхойлолтоор шийдэгдэж байна. Гэвч бусад тохиолдолд шүүх болон цагдаагийн алба хаагчид өөр байдлаар ойлгож хуулийг хэрэглэж байгаа нь тухайн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт сөргөөр нөлөөлж байна. Мөн түүнчлэн цагдаагийн алба хаагчдаас авсан судалгаанаас үзэхэд мөрдөн шалгах ажиллагаанд тухайн зохицуулалт бэрхшээл учруулдаг байна. Мөн түүнчлэн шүүхийн практикийг авч үзвэл тухайн зохицуулалт батлагдсанаас хойш тухайн зүйл, ангиар зүйлчлэгдэж шийдэгдсэн тохиолдол бүртгэгдээгүй байна. Энэ нь дээр дурдсан практикийн байгууллага буюу Цагдаагийн ерөнхий газрын тайлангаас зөрж байгаа бөгөөд нийгэмд тухайн зүйл, ангиар зүйлчлэгдэх ёстой гэмт хэрэг гарсаар байгааг харуулж байна. Энэхүү асуудал нь тухайн хуулийн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт сөргөөр нөлөөлж байна.

14. Мал хулгайлах гэмт хэргийн хувьд ЭХ-ийн 17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт 6 сараас 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ялыг оногдуулахаар хуульчилсан нь эрүүгийн хууль дахь зорчих эрхийг хязгаарлах ялыг хамгийн урт хугацаагаар оногдуулахаар зохицуулсан гэмт хэрэг байна. Мөн түүнчлэн дээр дурдсанчлан уг ялын хэрэгжилтийг хойшлуулсан хугацаанд уг ялыг мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс оногдуулаагүй байна.
15. Мал хулгайлах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд шүүхээс хорих ялыг түлхүү оногдуулсан байх бөгөөд 2020 онд илүүтэй өссөн нь 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн “Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиар ЭХ-ийн 17.12 дугаар зүйлээс нийтэд тустай ажил хийлгэх ялыг халсан, зорчих эрхийг хязгаарлах ял хэрэгжиж эхлээгүйтэй холбоотой байж болох юм.
16. Орон нутагт нийтэд тустай ажил хийлгэх ялыг гүйцэтгэхэд ял эдлүүлэх ажлын байр байхгүй, эсхүл тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага хяналт тавих боломжгүй үед нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн этгээдийг аймгийн төвд ял эдлүүлж байгаа практик нэгэнт тогтсон байх бөгөөд ийнхүү ял эдлүүлэх явцад тодорхой хүндрэл гарч байсан нь уг ялыг халах үндэслэл болохгүй. Харин ШШГБ уг ялыг эдлүүлэх ажиллагаанд учирч буй асуудал, бэрхшээлийг арилгахад чиглэсэн арга хэмжээг авах ёстой байжээ.
17. 2020 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль нь хууль санаачлагчдын үзэл баримтлалд дурдсанаар мал хулгайлах гэмт хэргийн эсрэг шийдвэртэй тэмцэл явуулан, гэм буруутай этгээдэд хуульд заасан ялыг шударгаар оногдуулж, учирсан хохирлыг шуурхай, бодитой арилгах урьдчилсан нөхцлийг бүрдүүлэх зорилготой ч өөрчлөлтийн үндсэн агуулга нь ялыг хүндрүүлж, хорих ялын хэмжээг нэмэгдүүлснээр хязгаарлагдсан байна.
18. Мал хулгайлах гэмт хэргийн ялын нэг тухайд бүрчилсэн урьдчилан сэргийлэх зорилго биелэгдэхгүй байна.
19. Мал хулгайлах гэмт хэргийн зөрчигдсөн эрхийг сэргээх ялын зорилго нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг барагдуулсан эсэхтэй шууд хамаатай байдгийн хувьд ЭХ-ийн 17.12 дугаар зүйлд зохицуулсан мал хулгайлах гэмт хэргийн зөрчигдсөн эрхийг сэргээх ялын зорилго бүрэн хангагдаж чадаагүй хэмээн дүгнэлээ.

НОМ ЗҮЙ

I. Монгол хэл дээрх эх сурвалж

Хууль тогтоомж:

1. Монгол улсын Үндсэн хууль, 1992.
2. Эрүүгийн хууль, 1942.
3. Эрүүгийн хууль, 2002.
4. Эрүүгийн хууль, 2015.
5. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 1996.
6. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 2017.
7. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 2020.
8. Зөрчлийн тухай хууль, 2017.
9. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017.
10. Гаалийн тухай хууль, 2008.
11. Статистикийн тухай хууль, 1997.
12. Малын генетик нөөцийн тухай хууль, 2017.
13. Мал хулгайлах хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль, 2004.
14. Оросын холбоон улсын Эрүүгийн хууль, 1996.
15. Бүгд найрамдах Хятад ард улсын Эрүүгийн хууль, 1997.
16. Холбооны бүгд найрамдах Герман улсын Эрүүгийн хууль, 1998.
17. Гойд ашиг шимт мал шалгаруулах журам, ХХААХҮСА 346 тоот тушаал, 2020.10.22.
18. Улсын дээд шүүхийн 2019 оны 03 дугаар сарын 29-ний №153 тогтоол.
19. Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн зарим хэсэг, заалтыг тайлбарлах тухай, Улсын дээд шүүх, №28, 2006.05.29.

Ном, өгүүлэл нийтлэл:

1. Үндэсний статистикийн хороо, Гэмт хэргийн статистик 2018.
2. Үндэсний статистикийн хороо, Гэмт хэргийн статистик 2019.
3. ЦЕГ, Монгол Улс дахь 2010 оны гэмт хэргийн байдал, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам, 2011.
4. ЦЕГ, Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал, 2013.
5. ЦЕГ, Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал, 2014.
6. ЦЕГ, Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал, 2015.
7. ЦЕГ, Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал, 2016.
8. ЦЕГ, Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, 2017.

9. ЦЕГ, Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, 2019.
10. ЦЕГ, Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал, 2020.
11. Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны статистик мэдээллийн хэлтсийн 2017 оны 7 сарын 1-нээс 2021 оны 5 сарын 31 хүртэлх хугацааны мал хулгайлах гэмт хэргийн талаар дэлгэрэнгүй судалгаа, 2021.
12. Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол улсын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр “Мал хулгайлах” гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, 2020.
13. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Эрүүгийн хуулийн тусгай аннгийн 17.12 дугаар зүйл ангиар шийтгэгдсэн хоригдол болон хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн этгээдүүдийн судалгаа
14. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2016.
15. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд бусад яамд, холбогдох байгууллагаас ирүүлсэн саналын товчоон.
16. Монгол Улсын Их Хурал Хууль зүйн байнгын хороо, Эрүүгийн хуулийн хувийн хэрэг/Шинэчилсэн найруулга/ Боть VI, 2015.
17. Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал.
18. С.Нарангэрэл, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: Ерөнхий анги, 1999.
19. С.Нарангэрэл, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: Тусгай анги, 1998.
20. С.Нарангэрэл, Ж.Эрдэнбулган, Монгол Улсын Эрүүгийн Эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж, 2019.
21. Монгол Улс дахь Гэмт хэргийн цагаан ном, 2018.
22. С.Гантулга, Б.Энхболд, Эрүүгийн эрх зүй Тусгай анги, 2018.
23. Монгол улсын цагдаагийн ерөнхий газар мэдээлэл, судалгааны төв, Монгол улс дахь 2010 оны гэмт хэргийн байдал, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам: Мал хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөл, анхаарах зарим асуудал сэдэвт судалгааны ажлын тайлан, 2011.
24. Ч.Ариунболд, Малыг амьдаар нь экспортод гаргахгүй, 2019.
25. Эрүүгийн цагдаагийн албаны хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс 2021 оны эхний хагас жилд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээний танилцуулга, 2021.
26. Шилмэл мал -2019” арга хэмжээний товч тайлан, 2019.
27. Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт, чиг хандлага сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл 1, 2013.
28. Д.Баярсайхан, Эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын шинэтгэлийн асуудлууд, 2019.
29. Д.Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, 2011.
30. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал, 2011.
31. Ц.Мөнхбат, Нийтэд тустай ажил хийлгэх ял: уламжлал, харьцуулалт, шинэчлэл хууль зүйн ухааны докторын зэрэг горилсон бүтээл, 2021.

32. Д.Алтанцэцэг, Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилтэд тулгамдаж байгаа асуудал. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилт, цаашид анхаарах асуудал”, Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2019.
33. Б.Жаргалмаа, Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх арга зам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хэрэгжилт, чиг хандлага”, Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2019.
34. С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн Эрх зүйн онол, ялын тухай сургааль, 2014.
35. ШШГЕГ, 2017-2020 оны ял, албадлагын арга хэмжээ болон цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний харьцуулсан тоон судалгаа, 2021.

II. Цахим эх сурвалж:

1. Монгол улсын шүүхийн цахим сан <http://new.shuukh.mn/>, <http://old.shuukh.mn/>.
2. Хууль, тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн тайлан, <http://forum.parliament.mn/projects/10696>.
3. Монголын гааль: Хориглосон, хязгаарласан барааны жагсаалт, <https://customs.gov.mn/2012-03-14-03-21-37/inspection/2014-03-24-06-16-45>.
4. Манай улс өнгөрсөн онд 171 адуу, 200 хонийг амьдаар нь экспортолжээ, 2020, <http://eagle.mn/r/70983>.
5. Малтай өрхийн тоо, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, малын тооны бүлэглэлтээр, улс, бүс, аймаг, нийслэлээр, жилээр, https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1001_044V1&13999001_select_all=0&13999001SingleSelect=_T2_T3_T4_T6_T5_T8_T7_T9_T10_T11&SOUM_select_all=0&SOUMSingleSelect=_0&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2020&viewtype=table.
6. Малтай өрхийн тоо, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороогоор, жилээр”, https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1001_027V1&BAG_select_all=0&BAGSingleSelect=_0&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2020&viewtype=table.
7. Малтай өрхийн тоо, Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, Нийт малын тоо 2020 оны байдлаар, https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_1001_021V1&BAG_select_all=0&BAGSingleSelect=_0&TYPE_OF_LIVESTOCK_select_all=0&TYPE_OF_LIVESTOCKSingleSelect=_01&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2020&viewtype=table.
8. Монгол улс-2020 онд, Monsame, <https://montsame.mn/mn/read/247649>.

Зорилго: Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 1/195 тоот албан үүргийн дагуу хууль зүйн үндэсний хүрээлэнгээс Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх судалгааны ажлын хүрээнд Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйл буюу Мал хулгайлах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, хэрэгжүүлэх явцад хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэхийг тогтоох зорилгоор дараах асуулгаар анкетын судалгаа хийж байгаа болно.

Таны харьяалах байгууллага, албан тушаал?

Аймаг/ Нийслэл:

Сум/ Дүүрэг:

Харьяалагдах нэгж:

Албан тушаал:

1. Мал хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг та юу гэж үздэг вэ?
Таны хариулт доорх хариултад байхгүй бол бусад гэсэн хэсэгт хариулж бичнэ үү.

Олон хариулт сонгох боломжтой.

- Орон нутагт дахь ажилгүйдэл, орлогын эх үүсвэргүй байдал;
- Иргэд малаа бэлчээрт, хөдөө хээр хариулага, маллагаагүй байлгадаг, эзэнгүй
- олон хоног орхидог;
- Махны ченж нарын үйл ажиллагаанд тавих эрх зүйн зохицуулалт дутмаг, мал махыг хараа хяналтгүй татвар, хураамжгүй, борлуулах боломж бүрдсэн;
- Мах, малын гаралтай түүхий эдийн үнийн өсөлт, хөөрөгдөл;
- Гэмт хэргийн улмаас учирсан хохиролыг бүрэн төлүүлж барагдуулдаггүй;
- Ял шийтгэлийг оновчтой оногдуулдаггүйгээс дахин гэмт хэрэг үйлдэх нөхцөлийг бүрдүүлдэг;
- Нийслэл, хот, аймгийн төвтэй холбогдсон авто замын нөхцөл байдал;
- Авто замын шалган нэврүүлэх товчоодын хяналт шалгалт сул байдал;
- Бусад

.....
.....
.....

2. Таны бодлоор мал хулгайлах гэмт хэргийг давтан үйлдэх шалтгаан, нөхцөл юу вэ?

.....
.....
.....

3. Мал хулгайлах гэмт хэрэг нь ихэнхдээ:

- А. Тохиолдлын чанартай үйлддэг;
- Б. Урьдаас бэлтгэсэн байдлаар үйлдэгддэг.

В. Бусад байдлаар

.....

.....

.....

4. Таны хариуцсан аймаг/суманд гарч буй мал хулгайлах гэмт хэргийн онцлог, бусад аймаг/суманд гарч буй мал хулгайлах гэмт хэргээс ялгагдах онцлог юу вэ, нэрлэж бичнэ үү.

.....

.....

.....

5. Шинэчлэн найруулсан 2015 оны Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлд мал хулгайлах гэмт хэргийг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй буюу уг зүйлээр зүйчлэхэд гэмт хэргийн улмаас хохирогчид учрах хохирлын хэмжээнээс үл шалтгаалах байдлаар хуульчилсныг та юу гэж үздэг вэ?

.....

.....

.....

6. Мал хулгайлах гэмт хэргийг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй хуульчилсан нь гэмт хэргийн гаралтад хэрхэн (эерэг/сөрөг) нөлөөлсөн бэ?

.....

.....

.....

7. Мал хулгайлах гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэхэд Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн зохицуулалт хангалттай эсэх?

А. Үр дүнтэй. Учир нь

Б. Үр дүнгүй. Учир нь

8. Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэгт заасан “Гойд ашиг шимт мал” хэмээх ойлголтыг та хэрхэн ойлгож байна вэ? Уг зүйл, заалтаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээн, ажиллагаа явуулахад хүндрэл бэрхшээл тулгардаг эсэх, тийм бол ямар? Мөн уг хэсгийн хэрэгжилтийг та хэрхэн үнэлэх вэ?

.....

.....

.....

9. “Гойд ашиг шимт мал” хэмээх ойлголтод хурдан морийг багтаах шаардлагатай эсэх талаар та юу гэж бодож байна вэ?

А. Шаардлагатай. Учир нь.....

Б. Шаардлагатай. Учир нь.....

10. Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан “байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон” хэмээх ойлголтыг та хэрхэн ойлгож байна вэ? Уг зүйл, заалтаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээн, ажиллагаа явуулахад хүндрэл бэрхшээл тулгардаг эсэх, тийм бол ямар?

.....

.....

.....

11. Мал хулгайлах гэмт хэргийг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон гэдгийг тодорхойлоход гэмт хэрэг үйлдсэн тоо болон давтамж чухал уу, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон орлого, түүний зарцуулалтын зориулалт чухал уу?

.....

.....

.....

12. Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 2.4 дэх хэсэгт заасан “машин механизм” ашиглан мал хулгайлсан тохиолдолд ялыг хүндрүүлэхээр хуульчилсан нь шаардлагатай зохицуулалт мөн үү? Уг хэсгийн хэрэгжилтийг та хэрхэн үнэлэх вэ?

А. Шаардлагатай. Учир нь.....

Б. Шаардлагагүй. Учир нь

13. Гэмт этгээд машин механизм ашиглан гэмт хэрэг үйлдэхдээ ихэнх тохиолдолд ямар төрлийн машин механизм ашиглан үйлддэг вэ?

А. Суудлын;

Б. Бага оврын ачааны;

В. Мотоцикл;

Г. Бусад.

14. Гэмт этгээд гэмт хэрэг үйлдэхдээ зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай эд зүйл ашиглан үйлдэхийг Эрүүгийн хуульд уг гэмт хэргийн ял, шийтгэлийг хүндрүүлэх нөхцөл байдал болгож оруулах шаардлагатай юу?

А. Шаардлагатай. Учир нь

Б. Шаардлагагүй. Учир нь.....

15. 2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар энэ зүйлд заасан “олон тооны мал” гэж 24 бог, 8 бодоос дээш малыг ойлгодог байсныг 8 бог, 2 бод, түүнээс дээш малыг ойлгохоор, богийг бодод шилжүүлэхдээ 1 бодыг 3 богоор тооцдог байсныг 4 богоор тооцдог болгож цөөрүүлэн өөрчилснийг та юу гэж бодож байна вэ?

.....

.....

.....

16. Дээрх өөрчлөлт (15 дахь асуулт) нь гэмт хэргийн гаралтад хэрхэн нөлөөлж байгаа вэ? Уг хэсгийн хэрэгжилтийг та хэрхэн үнэлэх вэ?

.....

17. 2020 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйл буюу “Мал хулгайлах” гэмт хэргийн зохицуулалтад оруулсан өөрчлөлтөөр нийтэд тустай ажил хийлгэх ялыг хассан нь зөв гэж та үзэж байна уу?

А. Тийм. Учир нь.....

Б. Үгүй. Учир нь.....

18. Мал хулгайлах гэмт хэргийг бүлэглэн үйлдэх гэдэгт та юуг ойлгож байна вэ?

Урьдаас үгсэн тохиролцож...

А. Бүлэглэн хулгайлах

Б. Хулгайн малыг нядлах, төхөөрөх

В. Хулгайн мал, махыг тээвэрлэх худалдан борлуулах

Г. Ашиг орлого хуваалцах

19. Мал хулгайлах гэмт хэргийг бүлэглэн үйлдэхэд бусад төрлийн гэмт хэргийг бүлэглэн үйлдэхээс ялгаатай эсэх, ялгаатай бол ялгагдах тодорхой шинжийг дурдана уу.

.....

20. 2020, 2021 онд Улсын болон аймгийн Онцгой комиссоос “COVID 19” цар тахлын улмаас тодорхой хугацаанд хөл хорио тогтоосонтой холбоотой мал хулгайлах гэмт хэргийн гаралт буурч байгаа гэсэн урьдчилсан дүгнэлттэй та санал нийлж байна уу?

А. Тийм

Б. Үгүй

21. Мал хулгайлах гэмт хэргийн гаралт буурахгүй байсан шалтгааныг та юу гэж үзэж байна вэ?

.....

22. Таны бодлоор мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хамгийн үр дүнтэй арга юу вэ?

.....

23. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэдийн оролцоо чухал уу? Хэрэв тийм бол иргэд ямар үйл ажиллагаа явуулах шаардлагатай гэж та үзэж байна вэ?

А. Тийм.

.....

Б. Үгүй.

.....

24. Үнэн бодитой мэдээллийг үнэлгээтэй болгох, мэдээлэгчтэй харилцан тохиролцох тохиолдол байдаг уу?

А. Тогтмол

Б. Хааяа

В. Бараг үгүй

Г. Огт үгүй

Яагаад?

.....

.....

25. Малын хулгайн гэмт хэргийн хохирлын хэмжээг тогтоохдоо дараах нөхцлөөс алийг нь харгалзан үздэг вэ?

А. Тухайн орон нутгийн зах зээлийн үнэ ханш

Б. Хохирогч алдсан малаа хайхад зарцуулсан зардал

В. Хулгайд алдсан мал хээлтэй, нялх төлтэй

Г. Ашиг шим ихтэй байсан эсэх

Д.

Бусад.....

26. Та мал хулгайлах гэмт хэргээр хэрэг бүртгэлт нээж мөрдөн шалгах явцдаа малын шилжилт хөдөлгөөний хяналт, малын бүртгэл, им тамга, малын индексжүүлсэн бүртгэл, мал, махны гарал үүслийн гэрчилгээтэй холбоотой асуудлыг зохицуулсан доорх хуулиудаас хэрэглэдэг үү?

А. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль;

Б. Малын генетик нөөцийн тухай хууль;

В. Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль;

27. Дээрх хуулиудын хэрэгжилт мал хулгайлах гэмт хэргийн гаралтад хэрхэн нөлөөлдөг гэж та үзэж байна вэ?

А. Шууд нөлөөтэй. Учир нь

Б. Нөлөөлдөггүй. Учир нь

28. Мал хулгайлах гэмт хэргийг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд төрөөс ямар бодлого, арга хэмжээ авах шаардлагатай гэж та үзэж байна вэ?

.....

.....

.....

29. Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн хэрэгжилтийг сайжруулахын тулд хэрхэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?

.....
.....
.....

30. Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн хэрэгжилтэд өөрийн зүгээс тодорхой үнэлэлт, дүгнэлт өгнө үү?

.....
.....
.....

ТАВ. МӨРДӨХ АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ СУДАЛГАА

Судалгааг удирдсан: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.Jur.) Х.Эрдэм-Ундрах

Судалгааны багийн бусад гишүүд:

Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор (LL.D) С.Сүхбаатар
Эрдэм шинжилгээний ажилтан Х.Буянбат
Эрдэм шинжилгээний ажилтан О.Энххүслэн
Эрдэм шинжилгээний ажилтан Д.Дэмидханд

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Өнөөгийн байдлаар Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тагнуулын байгууллага, авлигатай тэмцэх байгууллага, цагдаагийн байгууллагууд нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргүүдэд мөрдөн шалгах ажиллагааг явуулах эрх хэмжээтэй байгаа. Тухайлбал, тагнуулын байгууллага нь Эрүүгийн хуулийн 14.5 /Иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх/, 14.6 /Сонгууль, ард нийтийн санал асуулгад илүү санал өгөх/, 14.7 /Сонгууль, ард нийтийн санал асуулгад хууль бусаар нөлөөлөх, санал хураалтын дүнг буруу гаргах/, 14.8 /Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах/, 14.9 /Сонгуулийг хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулах/, 19.1 /Эх орноосоо урвах/, 19.2 /Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, саатуулах/, 19.3 /Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах/, 19.4 /Гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах/, 19.5 /Зэвсэгт үймээн дэгдээх/, 19.6 /Хорлон сүйтгэх/, 19.7 /Хорлон сүйтгэх ажиллагаанд бэлтгэх/, 19.8 /Экстремист үйл ажиллагаа явуулах/, 19.9 /Үндэсний эв нэгдлийг бүснүүлэх/ гэх мэт гэмт хэргүүд болон өөрөө илрүүлсэн тохиолдолд 13.1 /Хүн худалдаалах/, 18.2 /Валют, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшид нөлөөлөх/, 18.5 /Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх/, 18.6 /Мөнгө угаах/ дугаар зүйл, 20.7 дугаар зүйлийн 3.3-т заасан гэмт хэргүүдэд, авлигатай тэмцэх байгууллага нь Эрүүгийн хуулийн 22.1 /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/, 22.3 /Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах/, 22.4 /Хахууль авах/, 22.5 /Хахууль өгөх/, 22.6 /Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах/, 22.7 /Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх/, 22.8 /Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/, 22.9 /Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/, 22.10 /Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/, 22.11 /Дураараа аашлах/, 22.12 /Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах/ гэмт хэргүүд болон мөрдөн шалгах ажиллагааны явцад илрүүлсэн 18.6 /Мөнгө угаах/ дугаар зүйлд заасан гэмт хэрэгт, цагдаагийн байгууллага нь дээрх хоёр байгууллагын харьяалан шалгах гэмт хэргээс бусад гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг явуулахаар хуульчилжээ.

Анх 2002 онд Мөрдөх албаны тухай хууль батлагдсанаар Монгол Улсын Ерөнхий Прокурорын дэргэд тусгай субъектүүдийн үйлдсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг илрүүлэх чиг үүрэг бүхий мөрдөх алба анх байгуулагдаж байсан бөгөөд 2013 онд тус хууль хүчингүй болсноор мөрдөн байцаах алба татан буугдаж, чиг үүргийг нь холбогдох бусад байгууллагууд руу хуваасан¹ байна. Мөн үүнээс гадна 2002 онд байгуулагдсан Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба Улсын Их Хурлын 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 22 дугаар тогтоолоор татан буугдсан ба Монгол Улсын Их Хурал 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, мөн хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцож тус албаны орон тоо, төсөв, эзэмшиж байгаа үл хөдлөх болон бусад эд хөрөнгө, техник хэрэгслийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлсэн². 2013 оны 7 дугаар

1 <http://www.mongolianlawyer.mn/c/99>.

2 Монгол Улсын Ерөнхий прокурорын газар, Улсын ерөнхий прокурорын дэргэд мөрдөн байцаах албыг байгуулах хэрэгцээ, шаардлага, үндэслэл, 2017, <http://www.prokuror.mn/blog/ON/1164>.

сарын 5-ны өдрийн Тахарын албаны тухай хуулиар байгуулсан Тахарын алба байгуулагдсан хэдий ч 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар хүчингүй болгосон байна. Дээрх байдлаар тодорхой төрлийн гэмт хэргүүдийг мөрдөн шалгах эрх бүхий бие даасан байгууллагууд тухайн үеийнхээ хэрэгцээ, шаардлагатай уялдан байгуулагдаж байжээ.

2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 87-д Мөрдөх албаны тухай хуулийг хуулийг батлах чиглэлийг өгсөн байна. Ийнхүү мөрдөх алба байгуулах үндэслэлийг тодорхой хэмжээгээр эрх зүйн баримт бичигт тусгасан байна. Иймд гүнзгийрүүлэн судалж, мөрдөх албаны байгууллага бий болгох хэрэгцээ, шаардлага бий эсэхийг тандан судлах шаардлагатай байна.

Энэхүү судалгаагаар дээрх мөрдөх албаны байгууллага бий болгох үндэслэл, шаардлагад үндэслэн Мөрдөх албаны тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай эсэхийг 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу гүйцэтгэв.

Судалгааны аргачлал

Тус судалгааг гүйцэтгэхдээ Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэв. Үүнд:

1. Асуудалд дүн шинжилгээ хийх
2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томьёолох
3. Тухайн асуудлуудыг зохицуулах хувилбаруудыг тогтоож тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах
4. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах
5. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх
6. Зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгааг хийх
7. Зөвлөмж боловсруулах.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 87-д Мөрдөх албаны тухай хуулийг хуулийг батлах тухай чиглэлийг зааж өгчээ. Ингэхдээ хууль санаачлагч нь Засгийн Газар, хариуцан боловсруулах байгууллага нь Хууль зүй, дотоод хэргийн яам байхаар тодорхойлсон. Тус хуулийн төслийг боловсруулах үндэслэл, зохицуулах харилцааны товийн тухайд “Шинэ төрлийн зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий бие даасан бүтэц бүхий мөрдөх албыг байгуулах, тогтолцоо, чиг үүрэг, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох, хяналт тавих, алба хаагчдын эрх зүйн байдлыг тодорхойлох” гэсэн хүрээг тогтоож өгсөн байна³. “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийг 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан “Хууль тогтоомжийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 7 дугаар зүйлийн 7.1-д үндэслэсэн байна. Тус хэсэг буюу 7.1-д “Үндсэн чиглэлийн төслийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хэлэлцэн батална” гэж заасан байх ба мөн 7.1, 7.2, 7.3-т Засгийн газар тухайн бүрэн эрхийнхээ хугацаанд санаачлах хууль тогтоомжийн талаар урьдчилан төлөвлөж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох Үндсэн чиглэлд тусгах, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох байгууллагын саналыг авч, нэгтгэн судалсны үндсэн дээр Үндсэн чиглэлийн төслийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн боловсруулах, Үндсэн чиглэлийн төсөлд санал өгөх байгууллага нь нийгмийн тухайн харилцааг зохицуулж байгаа хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр уг асуудлаар шинээр хууль гаргах, эсхүл хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагыг тодорхойлох харилцаануудыг мөн зохицуулжээ.

Өмнө дурдагдсан Үндсэн чиглэлээс хамаарах харилцааг тодруулбал, шинэ төрлийн зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй мөрдөх албыг байгуулах тухай тодорхой байна. Тиймээс агуулгын хувьд дараах байгууллага нь нэгдүгээрт шинэ төрлийн зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, хоёрдугаарт үндэсний аюулгүй байдлыг хангах гэсэн хоёр чиг үүргийг хэрэгжүүлж байхаар тодорхойлогдсон. Шинэ төрлийн зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэргийн тухайд Монгол Улсын соёрхон баталсан “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц”-оор тус агуулгын хүрээ тодорхойлогдоно. Үндэсний аюулгүй байдлыг хангах агуулгын хүрээнд тус мөрдөх алба нь тус гэмт хэрэгтэй тэмцсэнээр үндэсний аюулгүй байдлыг хангах болон бусад үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлыг шийдвэрлэх чиг үүрэгтэй байхаар байна.

Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэргийн хувьд Монгол Улсын 2008 оны 5 дугаар сарын 16-ны өдөр соёрхон баталж, 2008 оны 6 дугаар сарын 27-ны өдөр хүчин төгөлдөр болсон НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас гаргасан 2000 оны

3 Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралт: “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл” <https://www.legalinfo.mn/annex/details/11551?lawid=16009>.

11 дүгээр 15-ны өдрийн “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц”-оор тус гэмт хэргүүдийг тодорхойлсон байдаг. Уг конвенцын зорилго нь үндэстэн дамнасан зохион зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх хамтын ажиллагааг үр дүнтэй болгох юм⁴. Конвенцод хамаарах гэмт хэргүүдийг 3 дугаар зүйлд дурдсан эдгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн байцаах, яллах үйл ажиллагаанд тус конвенц хамаарч байхаар зохицуулсан.

Үүнд:

- Конвенцын 5, 6, 8, 23 дугаар зүйлд заасны дагуу тогтоосон гэмт хэрэг буюу конвенцод заасан зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэрэг, мөнгө угаах гэмт хэрэг, авлигын гэмт хэрэг, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахтай холбоотой гэмт хэрэг
- Үндэстэн дамнасан шинж чанартай бөгөөд зохион байгуулалттай гэмт бүлэглэл үйлдсэн конвенцын 2 дугаар зүйлд заасан хүнд гэмт хэрэг буюу 4 жилээс дээш хугацаагаар хорих ял оноох гэмт хэрэг хамаарна.

Үндэстэн дамнасан гэмт хэргийн үндэстэн дамнасан гэж үзэхийн тулд конвенцод зааснаар дараах шинжийг агуулсан байх ёстой.Үүнд:

- Нэгээс олон улсад үйлдэгдсэн байх;
- Нэг улсад үйлдэгдсэн боловч бэлтгэлт, төлөвлөлт, чиглэл, хяналтын нэлээд хэсэг нь өөр улсад явагддаг байх;
- Нэг улсад үйлдэгдсэн боловч нэгээс олон улсад гэмт хэргийн үйл ажиллагаа явуулдаг зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн оролцоотой байх;
- Нэг улсад үйлдэгдсэн боловч өөр улсад мэдэгдэхүйц нөлөө үзүүлсэн байх.⁵

Тодорхой төрлийн гэмт хэргийн төрлөөр ангилбал дараах гэмт хэргүүд хамаарахаар байна. Үүнд:

- Мансууруулах бодисын хууль бус худалдаа;
- Галт зэвсгийн хууль бус худалдаа;
- Хүн болон хүний эд эрхтнийг худалдах гэмт үйл ажиллагаа;
- Эмэгтэйчүүдийг сексийн зорилгоор худалдах;
- Цацраг идэвхт бодисын хууль бус наймаа;
- Зэрлэг ургамал, амьтны хууль бус худалдаа;
- Авилга;
- Мөнгө угаах гэмт хэрэг⁶.

Дээрх гэмт хэргүүдийн тухайд, Монгол Улс уг конвенцыг соёрхон баталснаас хойш 2002, 2015 оны Эрүүгийн хуульд гэмт хэрэг байхаар хуулийн тусгай ангид тусгаж хуульчилсан. Тухайлбал, Хүн худалдаалах гэмт хэрэг, Мансууруулах бодис хил давуулан худалдаалах гэмт хэрэг, Мөнгө угаах гэх мэт гэмт хэргүүдийг тусгасан байна.

4 United Nations Convention against Transnational Organized Crime, Article 1.

5 General Assembly resolution 55/25 of 15 November 2000 United Nations Convention against Transnational Organized Crime, Article 3.

6 Үндэсний тагнуулын академийн доктор, дэд хурандаа Д.Тунгалаг, Мөнгө угаах гэмт хэрэг, түүнтэй тэмцэх зарим асуудал, https://docs.google.com/presentation/d/1wmzFDNStXevFSbrG5cU3z_gbd21zJ_lpkUVnbUmUJw4/htmlpresent

Хүн худалдаалах гэмт хэргийн гаралтын хувьд 2018 онд 10, 2019 онд 14, 2020 онд 10, 2021 оны эхний 10 сарын байдлаар 4 тус тус бүртгэгдсэн байна⁷. Мансууруулах бодис хил давуулан худалдаалах гэмт хэргийн тухайд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг 2018 онд 195, 2019 онд 257, 2020 онд 202, 2021 оны эхний 10 сарын байдлаар 148 бүртгэгдсэн⁸ ба үүнээс тодорхой хувийг нь тус гэмт хэрэг эзлэхээр харагдаж байна. Тодруулбал 2014 оны эхний хагас жилийн байлаар энэ төрлийн гэмт хэргийн улмаас гадаад улсад Монгол Улсын 37 иргэн ял эдэлж байгаагаас, эмэгтэй 15, эрэгтэй 21 байна. Үүнийг ял шийтгэлээр нь ангилж үзвэл, хугацаагүй хорих ялаар 9, хорих ялаар 22, цаазаар авах ялаар 5 иргэн тус тус шийтгэгдсэн байна. Дээрх тоо баримт бусад орнуудынхтай харьцуулахад харьцангуй цөөн мэт боловч олон улсын жишгээр 1 хэргийн ард 10 тохиолдол байдаг гэж үзвэл энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдал хүндрэх төлөв ажиглагдаж байна⁹. Үүнээс гадна хар тамхи, мансууруулах бодис хууль бусаар улсын хил нэвтрүүлэхийг завдсан 15 удаагийн үйлдлийг 2019 онд илрүүлсэн байна¹⁰. Мөнгө угаах гэмт хэргийн тухайд нийт 2018 онд 24, 2019 онд 54, 2020 онд 27, 2021 оны эхний 10 сарын байдлаар 45 бүртгэгдсэн байна¹¹. Дээрхээс үзвэл тус гэмт хэргүүдийн гаралт нь тогтвортой байгаа нь харагдаж байна. Мөн үүнээс гадна нуугдмал гэмт хэргүүд тус гэмт хэргүүдийн хувьд их байдаг нь ажиглагдаж байна.

2019 оны 6 дугаар сард нэмэлт, өөрчлөлт орсон “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт” ФАТФ-ын зөвлөмжийн 27 дахь зөвлөмжид “Улс орнууд МУТСТ үндэсний бодлогын хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг зохих ёсоор шалгах үүрэг бүхий хууль сахиулах байгууллагатай байна. Хамгийн багадаа их хэмжээний орлого олж байгаа гэмт хэрэгт хууль сахиулах байгууллага нь мөнгө угаах, түүнтэй холбоотой суурь гэмт хэрэг, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөж шалгахдаа идэвхтэй (pro-active) “санхүүгийн зэрэгцээ мөрдөн шалгалт” (“parallel financial investigation”) хийнэ. Үүнд суурь гэмт хэрэг өөр улс оронд үйлдэгдэх тохиолдол ч хамаарах шаардлагатай. Улс орнууд эрх бүхий байгууллагад гэмт хэргийн гаралтай буюу гэмт хэрэг үйлдэж олсон байж болзошгүй гэж сэжиглэгдэж байгаа, хураан авч болох, хураан авбал зохих хөрөнгийг нэн даруй илрүүлэх, мөшгих, царцаах, битүүмжлэх, хураах үйл ажиллагааг явуулах үүрэг оногдуулна. Улс орнууд шаардлагатай тохиолдолд санхүүгийн болон хөрөнгийн мөрдөн шалгалтаар мэргэшсэн байнгын эсвэл түр зуурын байгууллага хоорондын ажлын хэсгүүдийг ашиглана. Шаардлагатай тохиолдолд бусад улс орнуудын эрх бүхий байгууллагатай хамтарсан мөрдөн шалгалт хийнэ”¹² гэсний дагуу Монгол Улсад тухайлсан мэргэшсэн мөрдөх алба байгуулах шаардлагатай болох нь харагдаж байна. Түүнчлэн ФАТФ-ын 2020 оны

7 2018, 2019, 2020, 2021 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл.

8 Мөн тэнд.

9 Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт Монгол Улсын иргэд холбогдож буй нөхцөл байдал, шалтгаан, <https://www.customs.gov.mn/2012-03-14-03-21-37/2014-03-24-06-25-31/2015-02-04-06-28-11/526-2015-02-06-07-21-57>.

10 Гаалийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн 2019 онд зохион байгуулагдаж байна, <https://www.customs.gov.mn/news/daily/latest/1466-200019>.

11 Мөн тэнд.

12 ФАТФ, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт, 26 дахь тал, www.fatf-gafi.org/recommendations.html, <https://www.mongolbank.mn/documents/cma/20180531F2.pdf>.

Монгол Улсын дахин үнэлгээний тайланд “Монгол улс 2017-2019 оны хооронд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой а)Хууль сахиулах, хяналтын байгууллагын нөөцийг нэмэгдүүлэх, б)Эрсдэлд суурилсан шалгалт хийх, в) хяналт шалгалт, хяналтыг сайжруулах чиглэлээр хяналт тавьж буй байгууллагууд санамж бичигт гарын үсэг зурах, г) Бусад талуудын дунд мэргэжил дээшлүүлэх сургалт явуулах арга хэмжээнүүдийг авсан. Мөн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд эерэг үзүүлэлт үзүүлсэн. Гэхдээ Монгол Улсын урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилт эхний шатанд байна”¹³ гэж тусгасны дагуу Монгол Улс эрх зүйн зохицуулалтаа улам төгөлдөржүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн тус конвенцын 18 дугаар зүйлийн 13-т зааснаар “оролцогч улс бүр эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтийг хүлээн авах, гүйцэтгэх эсвэл эрх бүхий байгууллагад гүйцэтгүүлэхээр дамжуулах бүрэн эрх бүхий төв байгууллагатай байна. Эрх бүхий төв байгууллага нь хүлээн авсан хүсэлтийг түргэн шуурхай, зохих ёсоор гүйцэтгэх буюу дамжуулах үүрэг хүлээж ажиллана. Эрх бүхий төв байгууллага нь хүсэлтийг эрх бүхий байгууллагад гүйцэтгүүлэхээр дамжуулж байгаа тохиолдолд тийнхүү дамжуулахаас гадна эрх бүхий байгууллагын хүсэлтийг зохих ёсоор, хурдан шуурхай гүйцэтгэхийг дэмжиж ажиллах үүрэгтэй”¹⁴ байхаар зохицуулжээ.

Дүгнэвэл Монгол Улсад шинэ төрлийн зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мөрдөх алба байгуулах хэрэгцээ, шаардлагатай байна.

Иймд аргачлалын 3-т заасны дагуу асуудалд дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж түүний мөн чанар, цар хүрээ, шалтгаан, нөхцөлийг тогтоож эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийн эрхэд тухайн асуудал хэрхэн нөлөөлж буй талаар авч үзсэн болно.

1.1. Асуудлыг тодорхойлж шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоох

Дээр дурдсан нөхцөл байдлыг дүгнэж үзвэл дараах асуудал голлон анхаарал татаж байна. Үүнд:

- Монгол Улсад мөрдөх албаны тухай хуулийг бий болгож мөрдөх албыг байгуулах хэрэгцээ, шаардлага нь Монгол Улсын олон улсын гэрээний үүргийн нөхцөл байдлаас урган гарч байна.
- Монгол Улсад мөрдөх албаны тухай хуулийг бий болгож мөрдөх алба байгуулах хэрэгцээ, шаардлага нь зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэргийн нөхцөл байдлаас бий болж байна.

13 ФАТФ-ын дахин үнэлгээний тайлан, 2020, 5 дахь тал, <http://www.frc.mn/frc/muta/d/pc/8814>.

14 General Assembly resolution 55/25 of 15 November 2000 United Nations Convention against Transnational Organized Crime, Article 18, https://www.unodc.org/documents/middleeastandnorthafrica/organised-crime/UNITED_NATIONS_CONVENTION_AGAINST_TRANSNATIONAL_ORGANIZED_CRIME_AND_THE_PROTOCOLS_THERETO.pdf.

Тус асуудлын хүрээнд мөрдөх албыг бий болгох цар хүрээг “шинэ төрлийн зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мөрдөх албыг мөрдөх албаны тухай хуулийг баталж байгуулах” гэж тодорхойлов.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох¹⁵

Дээр тодорхойлсон цар хүрээтэй холбоотойгоор дараах нийгмийн бүлэг, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байна гэж үзлээ.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг		Нөлөөлж буй хэлбэр
1.	Мөрдөх албаны харьяалалд хамаарах гэмт хэргийн хохирогч	Мөрдөх албаны харьяалалд хамаарах гэмт хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагууд мөрдөн шалгах нь тусгайлсан мөрдөх алба мөрдөн шалгаххаас үр дүн муутай байгаа нь гэмт хэргийн хохирогчийн эрх зүйн байдлыг дордуулдаг. Тухайлбал гэмт этгээдийг ял завшуулах, хохирлыг бодит байдалд нийцүүлэн тодорхойлохгүй байх гэх мэт үйлдлүүдийг гаргах боломжтой.
2.	Мөрдөх албаны харьяалалд хамаарах гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан	Мөрдөх албаны харьяалалд хамаарах гэмт хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагууд мөрдөн шалгах нь тусгайлсан мөрдөх алба мөрдөн шалгаххаас үр дүн муутай байгаа нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанг хэлмэгдүүлэх эрсдэлтэй.
3.	Мөрдөх албаны харьяалалд хамаарах гэмт хэргийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогчид	Мөрдөх албаны харьяалалд хамаарах гэмт хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагууд мөрдөн шалгах нь тусгайлсан мөрдөх алба мөрдөн шалгаххаас үр дүн муутай байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох бусад оролцогчийн эрх зүйн байдлыг дордуулах боломжийг бий болгодог.
4.	Хүн ам	Мөрдөх албаны харьяалалд хамаарах гэмт хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагууд мөрдөн шалгах нь тусгайлсан мөрдөх алба мөрдөн шалгаххаас үр дүн муутай байгаа нь гэмт хэргийн гаралтыг ихэсгэх, гэмт хэргийг нуун дарагдуулах, илрүүлэхгүй байх нөхцөл болж “Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” Эрүүгийн хуулийн зорилго хэрэгжихгүй болсноос хүний эрх, эрх чөлөө хөндөгдөж байна.
5.	Мөрдөх албаны мөрдөгч, албан хаагч	Мөрдөх албаны харьяалалд хамаарах гэмт хэргийг мөрдөн шалгаж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагын мөрдөгч, албан хаагч нь мөрдөх албаны мөрдөгч, албан хаагч биш байгаа нь түүнд эдлүүлэх ёстой баталгааг эдлүүлэхгүй байх үндэслэл болж байна.

15 Аргачлалын 3.1.2-т зааснаар “эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд”-ийг тодорхойлохоор байгаа. Манай судалгааны хүрээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах оролцогчид болон хүн ам зэргээр эрх ашиг нь хөндөгдөх бүлгийг тодорхойлсон тул дээрх бүгд хамаарна.

Эрх ашиг нь хөндөгдөж, нөлөөлөл үзүүлэх бүлгийн хувьд мөрдөх албаны харьяалах гэмт хэргийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан болон бусад оролцогчид бүгд хамаарахаар байна. Учир нь тус гэмт хэргүүдийг мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлэх байгууллагын ажиллагаанаас тус хүмүүсийн эрх зүйн байдал, эрх ашиг их хамаардаг. Үүнээс гадна тус мөрдөн шалгах ажиллагааг хэрэгжүүлдэг байгууллагын мөрдөгч, албан хаагчийн нийгмийн баталгаа, эрх зүйн байдал нь хөндөгдөж байгаа болох нь харагдаж байна. Түүнчлэн цаашлаад тус гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах чиг үүрэг мөрдөх алба байхгүй байгаа нь тус гэмт хэргийн гаралтыг ихэсгэх, гэмт хэргийг илрүүлэхгүй байх нөхцөл байдалд хүргэх учир Монгол Улсын нийт хүн амын эрх, эрх чөлөө, эрх ашгийг хөндөх боломжтой байна.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

Монгол Улсад шинэ төрлийн зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мөрдөх албыг байгуулах тухай асуудлын шалтгаан нөхцөлийг авч үзье.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2013 оны “Мөрдөх алба: Гадаадын зарим орны туршлага” судалгааны ажилд тус асуудлын талаар тусгасан. Тухайлбал, Монгол Улсад Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд заасан харьяаллын дагуу зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг одоогоор цагдаагийн байгууллага, тагнуулын байгууллага, авилгатай тэмцэх газар хэрэгжүүлж байна. Гэтэл сүүлийн жилүүдэд хүний наймаа, мөнгө угаах, хар тамхи, мөн төрийн албан тушаалтай холбогдсон зохион байгуулалтын шинжтэй, нууц, далд аргаар үйлдэгддэг хэргүүд ихээр гарч, гэмт хэргийн гаралт эрс нэмэгдэж, энэ төрлийн гэмт хэргийг үйлдэх арга нь улам нарийсч боловсронгуй болсоор үндэстэн дамнасан шинжтэй болон нарийсч байгаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй байгаа юм. Манай улсад зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байгууллагуудын үйл ажиллагаа тус тусдаа, гэмт хэрэгтэй тэмцэх боломж, хүний нөөц, санхүү, эдийн засаг, техник технологи, илрүүлэх хэрэгсэл, бүтэц мөн зохион байгуулалтын хувьд хангалтгүй байсаар байна. Манай улсад цагдаагийн байгууллага энэ төрлийн гэмт хэрэгтэй бусад “гудамжны” гэмт хэрэг мөрдөн шалгаж буй арга хандлагаар хандаж урьдчилан сэргийлэх, тэмцэх ажиллагаа явуулж байгаа нь энэ ажлын үр дүнг бууруулж байна¹⁶ гэж мөрдөх албаны талаар бичсэн байна.

Сүүлийн үеийн судалгааны хувьд Нээлттэй нийгэм форумын “Мөрдөх албаны талаарх харьцуулсан судалгаа” судалгааны тайланд уг асуудлыг хөндөж бичсэн байна. Тухайлбал, НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталж, 2003 оны 9 дүгээр сарын 29-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын оролцогч талуудын бага хурлын Наймдугаар хуралдаанаас 2016 онд гаргасан “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагааны асуудлаарх төв байгууллагуудын үр нөлөөг дээшлүүлэх тухай” 8/1 тоот тогтоол, Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод үндэслэн Монгол Улс үндэстэн дамнасан зохион

16 Хууль зүйн үндэсний хүрээлэн, Мөрдөх алба: гадаадын зарим орны туршлага сэдэвт судалгааны тайлан, 2013, 26 дахь тал.

байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх асуудлаар эрх зүйн харилцан туслалцаанд Монгол Улсыг төлөөлөн ажиллах эрх бүхий төв байгууллага буюу үндэсний мөрдөх алба оролцох асуудал байгаа гэдгийг илэрхийлсэн. Мөн НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн албаны 2021-2025 оны стратегид “Олон улсын болон бүс нутгийн хэмжээнд хууль сахиулах сүлжээнээс тагнуулын мэдээлэл хуваалцах болон цагдаагийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг дэмжих, гэмт хэрэгтэй тэмцэх хамтарсан болон зэрэгцээ ажиллагаанд оролцогчдын чадавхыг бэхжүүлэх замаар үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлийг амжилттай илрүүлэхэд шаардлагатай арга, хэрэгсэлтэй байх нөхцөлийг хөнгөвчлөх”¹⁷ гэж заасныг үндэслэн мөрдөх албаны чадавхийг сайжруулах асуудал байгааг тодорхойлсон.

Монгол Улсын хувьд мөрдөн шалгах байгууллагын үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх асуудал болон үүнийг мөрдөн шалгах чиг үүрэг бүхий мөрдөх албыг байгуулах талаар салбарын мэргэжилтэн дараах санал, дүгнэлтийг өгчээ.

“Олон нийт хууль зүйн шинэтгэлийн хүрээнд хийж байгаа хуулийн төслүүдийг анхааран сонирхож байх шиг байна. Ялангуяа Мөрдөх албаны тухай хууль нь ямар утга учиртай юм. Ийм албыг байгуулах ямар хэрэг байгаа юм бол гэсэн асуулт байгаа байх. Мөрдөх алба бол гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллага юм. Тодруулбал, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан үүрэг бүхий хууль сахиулах бие даасан байгууллага байна. Иргэд “Цагдаагийн байгууллага чинь мөрдөн байцаах газартай. Энэ газар нь Мөрдөх алба гэдэг нэртэй болоод салах нь” гэж ойлгож магадгүй. Тэгвэл тийм биш. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуульд олон гэмт хэрэг бий. Хуульд заасан гэмт хэрэг дотроос цагдаагийн байгууллагад харьяалуулсан нь 200 гаруй гэмт хэрэг байдаг. Энэ 200 гаруй гэмт хэргийн дийлэнх хувийг эзлэх иргэдийн өмчийн эсрэг гэмт хэргээс эхлээд бусдыг зодож биед нь гэмтэл учруулах зэрэг хүч хэрэглэсэн, хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэргүүдийг цагдаагийн байгууллага шалгана. Харин шалгахад хүндрэлтэй, тусгай мэргэжил мэдлэг шаарддаг, тусгай лабораториос эхлээд мэргэшсэн байгууллага байхыг шаардаж байдаг бий. Үүнийг үгүйсгэхгүй. Цагдаагийн байгууллагын харьяаллын гэмт хэргээс 30 гаруй хувь нь хар тамхи, хүний наймаа, мөнгө угаах зэрэг үндэстэн дамнасан, зохион байгуулалттай шинжтэй, гол төлөв нууц далд аргаар үйлддэг манай улсын хувьд шинэ төрлийн гэмт хэргүүд байдаг. Гэтэл сүүлийн жилүүдэд хүний наймаа, мөнгө угаах, хар тамхины, албан тушаалын зэрэг зохион байгуулалттай, нууц далд аргаар үйлддэг гэмт хэрэг их болсон. Ялангуяа, энэ төрлийн гэмт хэргийг үйлдэх арга улам нарийсч, үндэстэн дамнасан шинжтэй болж байгаа нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд аюул учруулах хэмжээнд хүргэж байгаа юм. Дээрээс нь зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийг хэрэгжүүлж буй байгууллагуудын чиг үүрэг тус тусдаа, гэмт хэрэгтэй тэмцэх боломж хүний нөөц, санхүү, эдийн засаг, техник хэрэгсэл, бүтэц, зохион байгуулалтын хувьд хангалтгүй байсаар байна. Иймд цаашид шинэ түвшинд шинэ арга барил, шинэ бодлогоор энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх шаардлага зүй ёсоор гарч байгаа учраас бие даасан байгууллагыг

17 Нээлттэй нийгэм форум, Мөрдөх албаны талаарх харьцуулсан судалгаа сэдэвт судалгааны тайлан, 2021, 78 дахь тал.

байгуулах шаардлага байна. Нууц далд аргаар үйлддэг, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн тухай мэдээлэл цагдаагийн байгууллагад төдийлөн ирдэггүй. Өөрөөр хэлбэл, иргэд, аж ахуйн нэгжээс ийм төрлийн гэмт хэргийн тухай мэдээлэл ирдэггүй. Үүнийг зөвхөн гүйцэтгэх ажлын арга, хэрэгслээр илрүүлдэг. Урьдчилан мөрдөн шалгаж, гэмт хэргийн шинж байна уу гэдгийг эрэл хайгуул хийж байж олдог гэсэн үг. Хүч, хүн шаарддаг хэрэг. Гэхдээ манай цагдаа энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж ололт амжилт олсон зүйл олон бий. Үүнийг үгүйсгэхгүй. Тухайлбал, Эрүүгийн цагдаагийн газар, УМБГ-ын ажилтнууд байгаа хэмжээндээ энэ төрлийн хэргийг илрүүлж ирсэн, одоо ч илрүүлж байна. Хамгийн гол нь зүй тогтол, хууль зүйн цогц утгаар нь авч үзвэл хууль сахиулах байгууллагын орчин үеийн хөгжлийн чиг хандлагыг л бий болгох зорилготой. Гэмт хэргийн гаралт санаа зовоодоггүй, үндэстэн дамнасан гэмт хэрэг гардаггүй байсан бол Мөрдөх алба байгуулах шаардлагагүй. Байгаа учраас ч хүн, хүч өгч тэмцэх шаардлага тулгарч байгаа юм. Би түрүүн хэлсэн дээ. Далд үйлддэг гэмт хэргийн тухай мэдээлэл ирдэггүй гэж. Харин бусдын эд хөрөнгийг хулгайлах зэрэг гэмт хэргийн мэдээлэл цагдаагийн байгууллагад өдөр тутам ирдэг. Далд үйлддэг гэмт хэргийг өвчнөөр зүйрлэвэл илэрдэггүй далд вирус гэсэн үг¹⁸.”

Дээрхээс үзвэл үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг нь бусад төрлийн гэмт хэргүүдээс үйлдэх аргаар илүү нарийн буюу нууц, далд аргаар үйлдэгддэг ба түүнийг шалгахад хүндрэл бэрхшээлтэй, тусгай мэдлэг шаарддаг болох нь харагдаж байна.

Үүнээс гадна өмнөх хэсэгт дурдсан хүн худалдаалах гэмт хэрэг, Мансууруулах бодис хил давуулан худалдаалах гэмт хэрэг, мөнгө угаах гэмт хэргийн гаралт сүүлийн жилүүдэд тогтвортой байгаа болон нууц, далд гэмт хэргүүд гарах боломжтой байгаа нь эдгээр гэмт хэрэг буюу зохион байгуулалттай, үндэстэн дамнасан гэмт хэргүүдтэй тэмцэх чиг үүрэг бүхий мэргэшсэн байдлаар мөрдөн шалгах мөрдөх албатай болох асуудлын шалтгаан нөхцөл болж байна.

Эдгээр асуудлын шалтгаан нөхцөл нь дээрх асуудлуудад үндэслэсэн 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 87-д Мөрдөх албаны тухай хуулийг хуулийг батлах тухай чиглэл бөгөөд Мөрдөх албаны тухай хуулийг баталж мөрдөх албыг байгуулах заавал дагаж мөрдөх хэм хэмжээ нь мөрдөх албыг байгуулах шалтгаан, нөхцөл болж байна.

18 Ж.Ганбаатар, Үндэстэн дамнасан хэрэг гардаггүй бол мөрдөх алба байгуулах шаардлагагүй, 2013.06.12, <https://gogo.mn/r/mjwmo>.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Шийдвэрлэх зорилгын тухайд өмнөх шатанд хийсэн дүгнэлтэд үндэслэн дараах шийдвэрлэх зорилгыг тодорхойлж байна.

Зорилго: “Монгол Улсад зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мөрдөх албыг байгуулах”

Аргачлалын 4.1-д бичсэнээр Зорилгыг аль болох тодорхой, хэмжих боломжтой, хүрэхүйц, бодитой байдлаар томьёолох хэрэгтэй байдаг. Бидний тодорхойлсон зорилгын тухайд мөрдөн шалгах гэмт хэрэг нь тодорхой, хэрхэн байгуулах нь тодорхой, мөрдөх алба байгуулах шаардлагыг тооцоолох боломжтой байгаа нь тус зорилгыг тодорхой, хэмжих боломжтой, хүрэхүйц, бодитой байгааг харуулж байна. Мөн тус зорилго нь аргачлалын 4.2-т зааснаар ерөнхий зорилгод хамаарна. Учир нь тодорхой тоо, хувь хэмжээ заагаагүй зөвхөн тус мөрдөх албыг байгуулах шаардлагатай эсэхэд хариу өгөх зорилготой юм. Аргачлалын 4.3-т зааснаар хэрвээ зорилгыг ерөнхий байдлаар тогтоосон тохиолдолд түүнийг хэрэгжүүлэх зорилт байгаа эсэхийг судлах нь зүйтэй байдаг. Тус зорилгын хүрээнд зорилтуудыг тодорхойлж болохоор байна. Тухайлбал, Монгол Улсад зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангахад хүндрэл бэрхшээл үүсч байгаа эсэх, үүнийг тусгайлсан чиг үүрэгтэй мөрдөх алба мөрдөн шалгаснаар уг хүндрэл бэрхшээл алга болох эсэх, мөрдөх алба байгуулах эрх зүйн шаардлага бий эсэх, мөрдөх албыг тухайлсан мөрдөх албаны тухай хуулийг баталж байгуулах эсэх гэсэн зорилтуудыг агуулж байна.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу “Монгол Улсад зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мөрдөх албыг байгуулах” зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан дараах дүгнэлтийг гаргалаа.

Хүснэгт 5.2. Асуудлыг зохицуулж болох хувилбаруудын эерэг болон сөрөг тал

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1.	Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Одоогийн тулгамдаж буй асуудлууд хэвээр үргэлжлэх ба зорилгод хүрэх боломжгүй байна.	Нэмэлт зардал гарахгүй бөгөөд тулгамдсан асуудлууд хэвээр үргэлжлэх тул ямар нэгэн үр өгөөжгүй байна.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
2.	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийсэн ч үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэг нь нарийн байдлаар, нууц, далд байдлаар үйлдэгддэг тул зорилгыг биелүүлэхэд нөлөө үзүүлэхгүй байна.	Зардал тодорхой хэмжээгээр шаардагдах хэдий ч тулгамдаж буй асуудлуудыг шийдэх боломжгүй байдалд хүрнэ.	Тодорхой үр дүнд хүрэхгүй

3.	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мөрдөх албыг зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийн байгуулж болохгүй.	Төрөөс их хэмжээний зардал гарах хэдий ч үр өгөөжийн хувьд мөрдөх албыг зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийж байгуулах боломж байхгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
4.	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Асуудал нь аливаа эрх бүхий этгээдийн мөнгө, санхүүгийн дутагдал, хүндрэлтэй холбоогүй, зөвхөн хуулийн зохицуулалттай холбоотой асуудал тул энэ хувилбарыг хэрэгжүүлэх боломжгүй болно.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
5.	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мөрдөх албыг хуулиар байгуулах нь зүйтэй. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-д заасан шударга шүүхээр шүүлгэх эрхийг төрөөс хангаж өгч байгаа учраас төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тус чиг үүргийг гүйцэтгүүлэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй.
6.	Захиргааны шийдвэр гаргах	Захиргааны шийдвэр гаргах буюу захиргааны хэм хэмжээний акт буюу журам, дүрмээр тус мөрдөх албыг зохион байгуулах нь хуулиар зохицуулснаас ач холбогдол муутай бөгөөд зохицуулалтын чанарт муугаар нөлөөлнө.	Үүсээд байгаа шалтгаан нь хуулиар зохицуулагдах нь илүү ач холбогдолтой бөгөөд зардлын хувьд журмаар зохицуулах нь илүү зардал бага гарах ч үр өгөөжийн хувьд муу байна.	Үр дүн муутай
7.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Өмнө дурдсанчлан Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-д заасан шударга шүүхээр шүүлгэх эрхийг төрөөс хангаж байгаа буюу гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг гүйцэтгэж буй учир үүнийг хуулиар зохицуулж эрх зүйн байдал болон бусад асуудлыг зохицуулах нь зүйтэй.	Төрөөс хууль батлагдах болон тус мөрдөх албаны үйл ажиллагаатай холбоотой зардал тодорхой хэмжээгээр гарах хэдий ч тус хувилбар нь зорилгод хүрэхэд илүү тохиромжтой, үр өгөөжтэй байна.	Үр дүнтэй

Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, төрөөс санхүүгийн интервенц хийснээр тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй.

Дээрхээс дүгнэвэл асуудлын мөн чанар, цар хүрээ болон нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн “Монгол Улсад зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангахад хүндрэл бэрхшээл үүсч байгаа эсэх, үүнийг тусгайлсан чиг үүрэгтэй мөрдөх алба мөрдөн шалгаснаар уг хүндрэл бэрхшээл алга болох эсэх, мөрдөх алба байгуулах эрх зүйн шаардлага бий эсэх, мөрдөх албыг тухайлсан мөрдөх албаны тухай хуулийг баталж байгуулах эсэх” зорилтод хүрэхийн тулд одоо байгаа тогтолцооны хүрээнд Монгол Улсад зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мөрдөх албыг хуулийн төсөл боловсруулж зохицуулах нь зүйтэй гэж үзлээ. Үүнээс гадна захиргааны шийдвэр гаргах ажиллагаа нь тухайн зорилтод хүрэх боловч үр дүн муутай болох нь харагдаж байна.

Тиймээс “Монгол Улсад зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мөрдөх албыг байгуулах” зорилгын хүрээнд дараах хувилбаруудыг дэвшүүлж байна.

Хувилбар 1. Монгол Улсад зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мөрдөх албыг хуулиар байгуулах.

Хувилбар 2. Монгол Улсад зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мөрдөх албыг захиргааны шийдвэрээр буюу захиргааны хэм хэмжээний акт болох дүрэм, журмаар байгуулах.

Нэгдүгээр хувилбарын хувьд хуулиар, зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мөрдөх албыг байгуулах агуулгатай юм. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-д заасан шударга шүүхээр шүүлгэх эрхийг төрөөс хангаж байгаа мөрдөх албыг хуулийн дагуу байгуулах нь зүйтэй. Учир нь Улсын Их Хурлаас хууль батлах нь ард түмний хүсэл зоригийг илэрхийлэх нэг хэлбэр болох бөгөөд мөрдөх албыг бие байдлаар зохион байгуулж түүний талаар бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн байдал гэх мэт зохицуулалтыг илүү ерөнхий байдлаар хуульчлах боломжийг олгоно.

Хоёрдугаар хувилбар нь захиргааны шийдвэрээр буюу захиргааны хэм хэмжээний акт болох дүрэм, журмаар зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мөрдөх албыг байгуулах талаар зохицуулах хувилбар юм. Захиргааны хэм хэмжээний акт нь хуулийг нөхөн гүйцээх зохицуулалттай, хуульд заасан, захиргааны байгууллагаас гаргасан зохицуулалт юм. Тиймээс мөрдөх албыг байгуулах тухай тухайн хувилбараар зохицуулсан тохиолдолд өөр хуулиар зохицуулсныг нарийвчилж зохицуулсан зохицуулалтаар тус байгууллага байгуулагдах ба Засгийн газар болон яам, агентлагийн шийдвэрээр батлагдсан журам нь түүний үндэслэл болох талтай.

Дээрх хоёр хувилбар нь судалгаагаар дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжтой гэж үзэж тус хоёр хувилбарын үр нөлөөг зорилгод хүрэх байдал болон зардал, үр өгөөжийн харьцаагаар харьцуулан авч үзье.

Хувилбар 1. Томьёолол

“Монгол Улсад зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мөрдөх албыг хуулиар байгуулах.”

Зорилгод хүрэх байдал:

Асуудлыг шийдвэрлэх зорилт нь Монгол Улсад зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэргийн гаралт үүсч байгаатай холбогдуулах тухайн гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй мөрдөх албыг байгуулах юм.

Хувилбар 1-ийн хувьд хуулиар тус мөрдөх албыг зохион байгуулах нь зорилгод хүрэх байдалд нийцсэн хувилбар гэж үзэж байна. Учир нь тус мөрдөх албыг тусдаа хууль баталж байгуулах нь дараах ач холбогдолтой.

- Хууль нь ард түмний хүсэл зоригийн илэрхийлэл болдог бөгөөд хуулийг батлах үйл явц нь илүү шаардлага өндөртэй байдаг. Үүгээрээ хүлээн зөвшөөрөгдөх байдал нь улам нэмэгдэх юм. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн 20, 23, 25 дугаар зүйлд зааснаар Улсын Их Хурал нь ард түмний элч байж хууль батлах чиг үүргийг гүйцэтгэдэг юм. Мөн Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хэлэлцүүлэг, санал хураалт гэх мэт нарийн процессыг дамжиж хууль батлагддаг учир түүний чанар сайжирна.
- Тус мөрдөх албыг байгуулах шаардлага нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-д заасан шударга шүүхээр шүүлгэх эрхийг төрөөс хангах буюу мөрдөн шалгах ажиллагааны процессыг мэргэшсэн байгууллагад харьяалуулах асуудал учир энэ нь хүний үндсэн эрхийг хязгаарлахтай холбоотой асуудал байна. Тиймээс аргачлалын 5.4.1-т зааснаар “тухайн асуудал нь хүний салшгүй эрхэд буюу Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан хүний эрхийг хязгаарлах бол” тухайн асуудлыг хуулиар зохицуулах шаардлагатай гэж заасны дагуу тус мөрдөх албыг хуулиар зохицуулах шаардлагатай.
- Мөн тус мөрдөх албатай төстэй буюу тодорхой төрлийн гэмт хэргүүдэд мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг байгууллагуудын хувьд хуулиар тус байгууллагуудыг байгуулсан жишигтэй байна. Тухайлбал, Авилгатай тэмцэх газрыг Авлигын эсрэг хуулиар, Тагнуулын ерөнхий газрыг Тагнуулын байгууллагын тухай хуулиар тус тус байгуулсан байна.

Зардал, үр өгөөжийн харьцаа:

Хувилбар 1-д тодорхойлсон байдлаар тус мөрдөх албыг байгуулсан тохиолдолд хууль батлагдах үйл явцад шаардагдах зардлууд нь улсын төсвөөс гарах буюу зардал их гарахаар байна. Мөн ийнхүү тусдаа чиг үүрэг бүхий мөрдөх алба байгуулах нь тус байгууллагад төсөв гаргаж өгөх байдлаар улсын төсвийн хувьд одоо байгаагийнхаас илүү зарлага гаргахаар байна. Учир нь энэхүү байгууллага нь одоо харьяалж буй мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллагаас тодорхой хэмжээгээр баталгаа илүү байх чиглэлтэй учир төсвийн зарлага ихтэй болохоор байна. Гэвч тус мөрдөх албаны чиг үүргээ хэрэгжүүлсний үр дүнд үүсэх үр өгөөж нь зохион байгуулалттай, үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх буюу гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлөх юм. Мөн тус гэмт хэргийг харьяалан мөрдөн шалгаж буй одоогийн байгууллагуудын төсвийг хэмнэх учир зардал, үр

өгөөжийн харьцааны хувьд үр өгөөж нь илүү байхаар байна.

Хувилбар 2. Томьёолол

“Монгол Улсад зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мөрдөх албыг захиргааны шийдвэрээр буюу захиргааны хэм хэмжээний акт болох дүрэм, журмаар байгуулах.”

Зорилгод хүрэх байдал:

Энэхүү хувилбарын хувьд өмнөх хувилбартай харьцуулбал захиргааны шийдвэр буюу захиргааны хэм хэмжээний акт болох дүрэм, журмаар тус мөрдөх албыг байгуулах гэдгээр өөр байна.

Захиргааны шийдвэр гэж Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-т заасан захиргааны акт, мөн 11.3-т заасан захиргааны хэм хэмжээ тогтоосон актаар шийдвэрлэх асуудлыг хамруулан ойлгох бөгөөд эдгээр шийдвэрийг мөн хуулийн 12 дугаар зүйлд заасан журмаар гаргахыг шаардана. Захиргааны хэм хэмжээний актаар тус мөрдөх албыг байгуулах нь хуулиар зохицуулснаас зорилгод хүрэх байдлын хувьд муу байна. Учир нь захиргааны хэм хэмжээний акт нь тухайн баталсан захиргааны байгууллагын хүсэл зоригийг илэрхийлэх боломжтой, батлагдан гарах процесс сул, хүчингүй болгоход хялбар, зохицуулалт нь явцуу гэх мэтээр сул талтай байна.

Зардал, үр өгөөжийн харьцаа:

Зардлын хувьд өмнөх хувилбараас бага хэмжээний зардал гарах хэдий ч өмнө дурдсанаар үр өгөөж муутай байна.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлт гаргалаа.

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх

Юун түрүүнд зохицуулалтын хувилбарыг сонгохдоо практикт тулгарч буй бэрхшээл, тулгамдаж буй асуудлыг тодорхойлохын тулд үүрэг гүйцэтгэж буй цагдаагийн болон бусад алба хаагчид, мэргэжлийн, олон улсын байгууллагын судалгаанд үндэслэн оролцоог хангасан гэдгийг дурдах нь зүйтэй.

Уг судалгааны нэгдүгээр бүлгийн 1.2-т зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлсон. Эдгээр нь мөрдөх албаны харьяалалд хамаарах гэмт хэргийн хохирогч, уг гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогчид, түүнчлэн Монгол Улсын нийт хүн ам болно.

Мөрдөх алба нь хүн төрөлхтөн болоод нийгмийн аюулгүй байдал, хүний амь нас эрүүл мэнд, амьд явах эрх, хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчсөн буюу халдсан гэмт хэргийг таслан зогсоох, илрүүлэх, гэмт халдлагаас хамгаалах

зорилготой тул зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарна.

Зохицуулалтын 1 болон 2 дугаар хувилбар нь дараах Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцод нийцэж байна:

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
- Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм
- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц
- Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенц
- Албадан хөдөлмөрийн тухай 105 дугаар конвенц
- Боолчлол, боолын худалдааг хориглох тухай конвенц
- Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс заншлыг устгах тухай нэмэлт конвенц
- Хүүхдийн эрхийн тухай конвенц
- Хүүхдийн эрхийн тухай конвенцын нэмэлт Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг протокол
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенц
- Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах конвенц
- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц
- “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт” ФАТФ-ын зөвлөмжийн 27 дахь зөвлөмж

Мөрдөх албаны харьяалан шалгах гэмт хэргийг үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хуульд заасан байдаг бөгөөд тус хуулийн 1.2 дугаар зүйлийн 1-т “гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг энэ хуулиар тодорхойлно.” хэмээн заасан байх тул мөрдөх албаны зохицуулалтын хүрээнд хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах боломжгүй.

2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх

ЭХХШТХ-ийн 1.1 дүгээр зүйлийн 1-т эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршдог бөгөөд хуулийн 1.2 дугаар зүйлийн 1-т зааснаар Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь гэмт хэрэг хаана гарсныг үл харгалзан ЭХХШТХ-ийн дагуу явагддаг. Мөрдөх албаны тухай зохицуулалт нь мөрдөх албан харьяаллын гэмт хэрэгтэй холбоотойгоор хүний эрхийг хязгаарлах тохиолдолд тухайн зохицуулалт юун түрүүнд ЭХХШТХ-д нийцсэн буюу заагдсан байна.

Зохицуулалтын зорилго буюу мөрдөх албаны зорилго нь зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг

хангах бөгөөд тийнхүү эл эрхийг хэрэгжүүлэхийн тулд харьяалан шалгах гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтооход хуулийн дагуу хүний эрхийг тодорхой хэмжээгээр хязгаарлах нь зайлшгүй.

3.Эрх агуулагч

Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Мөрдөх албаны харьяалалд хамаарах гэмт хэргийн хохирогч
- Мөрдөх албаны харьяалалд хамаарах гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан
- Мөрдөх албаны харьяалалд хамаарах гэмт хэргийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогч
- Мөрдөх албаны мөрдөгч, албан хаагч
- Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд

Мөрдөх алба нь зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэхэд уг гэмт хэргийн хохирогчдын эрх зүйн байдал, эрх ашгийг дордуулахгүй байх, эрхийг сэргээхэд чиглэнэ.

Зохицуулалтын аль ч хувилбараар мөрдөх албыг байгуулснаар зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэхэд уг гэмт хэргийн хохирогчдын эрх зүйн байдал, эрх ашгийг дордуулахгүй байх, эрхийг сэргээх чиглэлд эерэг нөлөөлөл үзүүлнэ.

Зохицуулалтын аль ч хувилбараар мөрдөх албыг байгуулснаар зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэргийн хохирогчдын эрх зүйн байдал, эрх ашгийг дордуулахгүй байх, эрхийг сэргээх чиглэлд эерэг нөлөө үзүүлэх бөгөөд өөр ангилал тогтоогоогүй болно.

4.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлд төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгааг зохицуулсан байдаг бөгөөд тус зүйлийн 10.1.3 дахь хэсэгт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, авлигатай тэмцэх болон онцгой байдлын байгууллагаас бусад байгууллагын төрийн тусгай албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байхаар заасан байдаг бөгөөд мөрдөх албаны алба хаагчдыг тус зохицуулалтад нийцүүлэн бүрдүүлэх бүрэн боломжтой.

4.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх мөрдөх албыг байгуулснаар ФАТФ-ын зүгээс ямар нэг хорих арга хэмжээ авагдахгүй бөгөөд ингэснээр тус байгууллагын гишүүн орон болохын хувьд хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд эерэг нөлөө үзүүлнэ.

Түүнчлэн үндэстэн дамнасан гэмт хэргээс урьдчилан сэргийлж, таслан зогсоож чадсанаар ФАТФ-ын зүгээс ямар нэг хорих арга хэмжээ авагдахгүй бөгөөд ингэснээр тус байгууллагын гишүүн орон болохын хувьд дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс сэргийлэх боломж бүрдэнэ.

Улсын төсөвт нөлөө үзүүлэх тухайд Мөрдөх алба байгуулагдсанаар түүний бүтэц орон тоог бүрдүүлэх, үйл ажиллагаа зардал гэх мэтээр аль ч зохицуулалтын аргаар мөрдөх албыг байгуулсан улсын төсвийн зардал нэмэгдэнэ.

Зохицуулалтын хувилбар 1-ийн дагуу мөрдөх албыг байгуулах тохиолдолд шинээр төрийн байгууллага байгуулагдана. Харин зохицуулалтын хувилбар 2-ын дагуу захиргааны хэм хэмжээний актын дагуу мөрдөх албыг байгуулах тохиолдолд төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлагатай болно.

Зохицуулалтын хувилбар 2-ын дагуу захиргааны хэм хэмжээний актын дагуу мөрдөх албыг байгуулах тохиолдолд төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгож болох юм.

Зохицуулалтын аль ч хувилбараар мөрдөх албыг байгуулсан макро эдийн засгийн хүрээнд үндэстэн дамнасан гэмт хэрэг болох мөнгө угаах, терроризмын гэмт хэрэгтэй амжилттай тэмцэж чадсанаар гадаадын хөрөнгө оруулагчдад найдвартай бөгөөд аюулгүй таатай орчин бий болгож гадаадын хөрөнгө оруулалтыг татах боломжтой болоод зогсохгүй ФАТФ-ын зүгээс ямар нэг хорих арга хэмжээ авагдахгүй бөгөөд ингэснээр тус байгууллагын гишүүн орон болохын хувьд хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжихэд түлхэц болно. Түүнчлэн ФАТФ-ын зүгээс зөвлөмжийг тусгаагүйтэй холбоотойгоор ямар нэг хорих арга хэмжээ авагдахгүй бөгөөд ингэснээр тус байгууллагын гишүүн орон болохын хувьд эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд эерэг нөлөө үзүүлнэ.

4.3.Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл, стандарт, хөдөлмөрлөх эрхийн хувьд мөрдөх албаны алба хаагчдыг бүрдүүлэхтэй холбоотойгоор чиг үүрэг давхцах болон орон тоог мөрдөх албанд нэгтгэх эсвэл цомхотгохыг үгүйсгэхгүй байна.

Мөрдөх албыг шинээр байгуулах учир шинээр ажилчдыг буюу алба хаагчдыг бүрдүүлэх бөгөөд энэ тохиолдолд шинээр ажлын стандарт гаргах боломжтой. Мөн тус алба нь тодорхой төрлийн гэмт хэргүүдийг харьяалан шалгах бөгөөд үүнтэй холбоотойгоор ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгоно.

Зохицуулалтын 1 болон 2 дахь хувилбарын аль алианаар нь тодорхой төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг бүхий мөрдөх албыг байгуулснаар хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудад нөлөөлөх нь дамжиггүй.

Мөрдөх албыг шинээр бий болгосноор төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлж одоо тус албаны чиг үүргийг хэрэгжүүлж байгаа мөрдөн шалгах чиг үүрэг бүхий төрийн байгууллагын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлнө.

Зохицуулалтын хувилбараас үл хамааран мөрдөх албаны харьяалан шалгах гэмт хэргийн хохирогчдын шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд эерэгээр нөлөөлнө.

Мөрдөх алба нь хүн төрөлхтөн болоод нийгмийн аюулгүй байдал, хүний амь нас эрүүл мэнд, амьд явах эрх, хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчсөн буюу халдсан гэмт хэргийг таслан зогсоох, илрүүлэх, гэмт халдлагаас хамгаалах зорилготой тул зохицуулалтыг бий болгосноор нийгмийн аюулгүй байдлыг хангаж

гэмт хэргийн гаралтыг бууруулахаар байна. Түүнчлэн мөрдөх албаны харьяалан мөрдөн шалгах гэмт хэргийн илрүүлэлт, гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхийг хамгаалахад тус тус эерэгээр нөлөөлнө хэмээн үзэж байна.

Соёлын тухайд 1 болон 2 дахь хувилбар хоёул нэгэн адил Мөрдөх албыг байгуулснаар үндэстэн дамнасан байдлаар үйлдэгдсэн соёлын өвийн эсрэг гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр амжилттай ажилласнаар соёлын өвийг хамгаалахад эерэг нөлөө үзүүлнэ.

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Мөрдөх алба байгуулах нь байгаль орчинд шууд болон дам байдлаар сөрөг нөлөө бий болгохгүй байна. Харин НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас гаргасан 2000 оны 11 дүгээр 15-ны өдрийн “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц”-д зэрлэг ургамал, амьтны хууль бус худалдааг Үндэстэн дамнасан гэмт хэрэг хэмээн үздэг. Иймд мөрдөх алба нь тухайн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Энэ нь байгаль орчинд эерэг нөлөө үзүүлж буй хэрэг юм.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Зохицуулалтын 1 болон 2 дугаар хувилбар нь дараах Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэж байна. Үүнд:

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
- Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм
- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц
- Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенц
- Албадан хөдөлмөрийн тухай 105 дугаар конвенц
- Боолчлол, боолын худалдааг хориглох тухай конвенц
- Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс заншлыг устгах тухай нэмэлт конвенц
- Хүүхдийн эрхийн тухай конвенц
- Хүүхдийн эрхийн тухай конвенцын нэмэлт Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг протокол
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенц
- Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах конвенц
- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц
- “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт” ФАТФ-ын зөвлөмжийн 27 дахь зөвлөмж

Дараах байдлаар хувилбар 1 болон хувилбар 2-ын хүний эрхэд үзүүлэх үр нөлөө, эдийн засагт үзүүлэх үр нөлөө, байгаль, нийгэмд үзүүлэх үр нөлөө, орчинд үзүүлэх үр нөлөөг харьцуулсан байдлаар судалж үзье.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 5.3. Хүний эрхэд үзүүлэх нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар	
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Ялгаварлан гадуурхахыг хориглох тухай зохицуулалт байхгүй.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Тодорхой төрлийн гэмт хэргийг шалгах эрх бүхий мөрдөх албатай болох нь ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэхгүй.
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Мөрдөх албаны тухай эрх зүйн зохицуулалт нь тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ биш болно.
	1.2.Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Дээрх зохицуулалтын хувилбарыг сонгохдоо практикт тулгарч буй бэрхшээл, тулгамдаж буй асуудлыг тодорхойлохын тулд үүрэг гүйцэтгэж буй цагдаагийн болон бусад алба хаагчид, мэргэжлийн болон олон улсын байгууллагын судалгаанд үндэслэсэн оролцоог хангасан.
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Судалгааны нэгдүгээр бүлгийн 1.2-т зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлсон. Эдгээр нь мөрдөх албаны харьяалалд хамаарах гэмт хэргийн хохирогч, Уг гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогчид, түүнчлэн Монгол Улсын нийт хүн ам болно.
	1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Мөрдөх алба нь хүн төрөлхтөн болоод нийгмийн аюулгүй байдал, хүний амь нас эрүүл мэнд, амьд явах эрх, хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчсөн буюу халдсан гэмт хэргийг таслан зогсоох, илрүүлэх, гэмт халдлагаас хамгаалах зорилготой тул зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарна.

1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Зохицуулалтын хувилбар нь дараах Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэж байна: •Хүний эрхийн түгээмэл тунхаглал •Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт •Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм •Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц •Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенц •Албадан хөдөлмөрийн тухай 105 дугаар конвенц •Боолчлол, боолын худалдааг хориглох тухай конвенц •Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс заншлыг устгах тухай нэмэлт конвенц •Хүүхдийн эрхийн тухай конвенц •Хүүхдийн эрхийн тухай конвенцын нэмэлт Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг протокол •Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 182 дугаар конвенц •Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах конвенц •Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц •“Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт” ФАТФ-ын зөвлөмжийн 27 дахь зөвлөмж
1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Мөрдөх албаны харьяалан шалгах гэмт хэргийг үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хуулид заасан байдаг бөгөөд тус хуулийн 1.2 дугаар зүйлийн 1-т “гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг энэ хуулиар тодорхойлно.” хэмээн заасан байх тул мөрдөх албаны зохицуулалтын хүрээнд хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах боломжгүй.

2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	Үгүй	ЭХХШТХ-ийн 1.1 дүгээр зүйлийн 1-т эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршдог бөгөөд хуулийн 1.2 дугаар зүйлийн 1-т зааснаар Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь гэмт хэрэг хаана гарсныг үл харгалзан ЭХХШТХ-ийн дагуу явагддаг. Мөрдөх албаны тухай зохицуулалт нь мөрдөх албаны харьяаллын гэмт хэрэгтэй холбоотойгоор хүний эрхийг хязгаарлах тохиолдолд тухайн зохицуулалт юун түрүүнд ЭХХШТХ-д нийцсэн буюу заагдсан байна.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Зохицуулалтын зорилго буюу мөрдөх албаны зорилго нь зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах бөгөөд тийнхүү эл эрхийг хэрэгжүүлэхийн тулд харьяалан шалгах гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтооход хуулийн дагуу хүний эрхийг тодорхой хэмжээгээр хязгаарлах нь зайлшгүй.
3.Эрх агуулагч[8]	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	•Мөрдөх албаны харьяалалд хамаарах гэмт хэргийн хохирогч •Мөрдөх албаны харьяалалд хамаарах гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан •Мөрдөх албаны харьяалалд хамаарах гэмт хэргийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогчид •Мөрдөх албаны мөрдөгч, албан хаагч •Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Мөрдөх алба нь зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэхэд уг гэмт хэргийн хохирогчдын эрх зүйн байдал, эрх ашгийг дордуулахгүй байх, эрхийг сэргээхэд чиглэнэ.

	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Зохицуулалтын аль ч хувилбараар мөрдөх албыг байгуулснаар зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэхэд уг гэмт хэргийн хохирогчдын эрх зүйн байдал, эрх ашгийг дордуулахгүй байх, эрхийг сэргээх чиглэлд эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм	Үгүй	Зохицуулалтын аль ч хувилбараар мөрдөх албыг байгуулснаар зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэргийн хохирогчдын эрх зүйн байдал, эрх ашгийг дордуулахгүй байх, эрхийг сэргээх чиглэлд эерэг нөлөө үзүүлэх бөгөөд өөр ангилал тогтоогоогүй болно.
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Мөрдөх албаны мөрдөгч, албан хаагчид
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлд Төрийн албан дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгааг зохицуулсан байдаг бөгөөд тус зүйлийн 10.1.3 дахь хэсэгт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, авлигатай тэмцэх болон онцгой байдлын байгууллагаас бусад байгууллагын төрийн тусгай албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байхаар заасан байдаг бөгөөд мөрдөх албаны алба хаагчдыг тус зохицуулалтад нийцүүлэн бүрдүүлэх бүрэн боломжтой.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Зохицуулалтад тус баталгааг бүрдүүлэх боломжтой.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 5.4. Эдийн засагт үзүүлэх нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	ФАТФ-ын зүгээс ямар нэг хорих арга хэмжээ авагдахгүй бөгөөд ингэснээр тус байгуулллагын гишүүн орон болохын хувьд хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд эерэг нөлөө үзүүлнэ.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Үндэстэн дамнасан гэмт хэргээс урьдчилан сэргийлж, таслан зогсоож чадсанаар ФАТФ-ын зүгээс ямар нэг хорих арга хэмжээ авагдахгүй бөгөөд ингэснээр тус байгуулллагын гишүүн орон болохын хувьд дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс сэргийлэх боломж бүрдэнэ.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Мөрдөх алба байгуулагдсанаар өөрийн харьяалан шийдвэрлэх гэмт хэргийн тухай аливаа судалгааг дэмжиж ажиллах болно.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Мөрдөх алба байгуулагдсанаар түүний бүтэц орон тоог бүрдүүлж ажлын байр бий болно.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Мөрдөх албыг байгуулснаар улсын төсвийн зардал нэмэгдэнэ.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Зохицуулалтын хувилбар 1- ийн дагуу мөрдөх албыг байгуулах тохиолдолд шинээр төрийн байгууллага байгуулагдана. Харин зохицуулалтын хувилбар 2-ын дагуу захиргааны хэм хэмжээний актын дагуу мөрдөх албыг байгуулах тохиолдолд төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлагатай болно.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Зохицуулалтын хувилбар 2-ын дагуу захиргааны хэм хэмжээний актын дагуу мөрдөх албыг байгуулах тохиолдолд төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгож болох юм.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	ФАТФ-ын зүгээс ямар нэг хорих арга хэмжээ авагдахгүй бөгөөд ингэснээр тус байгууллагын гишүүн орон болохын хувьд эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Үндэстэн дамнасан гэмт хэрэг болох мөнгө угаах, терроризмын гэмт хэрэгтэй амжилттай тэмцэж чадсанаар гадаадын хөрөнгө оруулагчдад найдвартай бөгөөд аюулгүй таатай орчин бий болгож гадаадын хөрөнгө оруулалтыг татах боломжтой болоод зогсохгүй ФАТФ-ын зүгээс ямар нэг хорих арга хэмжээ авагдахгүй бөгөөд ингэснээр тус байгууллагын гишүүн орон болохын хувьд хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжихэд түлхэц болно.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Хүснэгтийн 1.3.2-дахь хэсэгт энэ талаар авч үзсэн болно.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 5.5. Нийгэмд үзүүлэх нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Мөрдөх албаны алба хаагчдыг бүрдүүлнэ.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Мөрдөх албаны алба хаагчдыг бүрдүүлэхтэй холбоотойгоор чиг үүрэг давхцах орон тоог мөрдөх албанд нэгтгэх эсвэл цомхотгохыг үгүйсгэхгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Цагдаагийн байгууллагын тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэгч алба хаагч нарт нөлөөлнө.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Мөрдөх албыг шинээр байгуулах учир шинээр ажилчдыг буюу алба хаагчдыг бүрдүүлнэ.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Мөрдөх албыг шинээр байгуулах учир шинээр ажлын стандарт гаргах боломжтой.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Мөрдөх алба нь тодорхой төрлийн гэмт хэргүүдийг харьяалан шалгах бөгөөд үүнтэй холбоотойгоор ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгоно.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Зохицуулалтын 1 болон 2 дахь хувилбарын аль алианаар нь тодорхой төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүрэг бүхий мөрдөх албыг байгуулснаар хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудад нөлөөлөх нь дамжиггүй.

	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Мөрдөх албыг байгуулснаар одоо тус албаны чиг үүргийг хэрэгжүүлж байгаа мөрдөн шалгах чиг үүрэг бүхий төрийн байгууллагын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлнө.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Мөрдөх албыг шинээр бий болгосноор төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлнө.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Мөрдөх албаны харьяалан шалгах гэмт хэргийн хохирогчдын шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд эерэгээр нөлөөлнө.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Мөрдөх алба нь хүн төрөлхтөн болоод нийгмийн аюулгүй байдал, хүний амь нас эрүүл мэнд, амьд явах эрх, хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчсөн буюу халдсан гэмт хэргийг таслан зогсоох, илрүүлэх, гэмт халдлагаас хамгаалах зорилготой тул зохицуулалтыг бий болгосноор нийгмийн аюулгүй байдлыг хангаж гэмт хэргийн гаралтыг бууруулна.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эрүүгийн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд нөлөөлнө.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Мөрдөх албаны харьяалан мөрдөн шалгах гэмт хэргийн илрүүлэлтэд эерэг нөлөө үзүүлнэ.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Мөрдөх албыг байгуулснаар тус албаны харьяалан мөрдөн шалгах гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхийг хамгаалахад эерэгээр нөлөөлнө.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Соёлын өвийн эсрэг гэмт хэргийг үндэстэн дамнасан байдлаар үйлдэх тохиолдолд тус гэмт хэргийг Мөрдөх алба илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр амжилттай ажилласнаар соёлын өвийг хамгаалахад эерэг нөлөө үзүүлнэ.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 5.6. Байгаль орчинд үзүүлэх нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Хүснэгт 5.7. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулсан нь.

	Зохицуулалтын хувилбарууд	Хувилбар 1. “Монгол Улсад зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мөрдөх албыг хуулиар байгуулах.”	Хувилбар 2. “Монгол Улсад зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мөрдөх албыг захиргааны шийдвэрээр буюу захиргааны хэм хэмжээний акт болох дүрэм, журмаар байгуулах.”
	Зорилгод хүрэх байдал	Тус хувилбарын хувьд: - Хууль нь батлагдах шаардлага болон агуулгын чанар сайтай; - Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-д заасан хүний шударгаар шүүлгэх эрхтэй холбоотой; - Тус албатай төстэй байгууллагуудыг хуулиар байгуулдаг жишигтэй; тул тус хувилбар нь зорилгод нийцсэн байна.	Тус хувилбарын хувьд захиргааны хэм хэмжээний акт буюу захиргааны шийдвэрээр тус мөрдөх албыг байгуулах нь тухайн баталсан захиргааны байгууллагын хүсэл зоригийг илэрхийлэх боломжтой, шалгуур муу тул уг зорилгод нийцэхгүй байна.
	Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлнэ. Гэхдээ хувилбар 2-оос тухайн хувилбар нь илүү эерэг үр нөлөөг үзүүлж байна. Тухайлбал, хүний эрхийн хувьд.	Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлнэ.
Шалгуур үзүүлэлт	Зардал, үр өгөөжийн харьцаа	Тус мөрдөх албаны чиг үүргээ хэрэгжүүлсний үр дүнд үүсэх үр өгөөж нь зохион байгуулалттай, үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх буюу гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлөх юм. Мөн тус гэмт хэргийг харьяалан мөрдөн шалгаж буй одоогийн байгууллагуудын төсвийг хэмнэх учир зардал, үр өгөөжийн харьцааны хувьд үр өгөөж нь илүү байхаар байна.	Зардлын хувьд өмнөх хувилбараас бага хэмжээний зардал гарах хэдий ч өмнө дурдсанаар үр өгөөж муутай байна.
	Хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх	Хууль тогтоомжтой нийцэж байна. Тухайлбал, 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 87-д “Мөрдөх албаны тухай” хууль батлах гэж тусгагдсан байна.	Тус хувилбарыг сонгосон тохиолдолд хууль тогтоомжтой нийцүүлэх боломжтой.
	Тухайн зохицуулалтаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдийг тогтоох	Мөрдөх албаны харьяалалд хамаарах гэмт хэргийн хохирогч, Мөрдөх албаны харьяалалд хамаарах гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, Мөрдөх албаны харьяалалд хамаарах гэмт хэргийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогч, хүн ам, мөрдөх албаны мөрдөгч, албан хаагч	Мөрдөх албаны харьяалалд хамаарах гэмт хэргийн хохирогч, Мөрдөх албаны харьяалалд хамаарах гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, Мөрдөх албаны харьяалалд хамаарах гэмт хэргийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бусад оролцогч, хүн ам, мөрдөх албаны мөрдөгч, албан хаагч

Дээрх судалгаанд үндэслэн тухайн хоёр хувилбарын эерэг болон сөрөг талыг харьцуулан дүгнэлээ.

Гарч болох эерэг үр дүн

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлт, зардал, үр өгөөжийн харьцаа шалгуур үзүүлэлт, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх шалгуур үзүүлэлт, хүний эрхэд үзүүлэх үр нөлөө гэх шалгуур үзүүлэлтийн хувьд хувилбар 1 нь хувилбар 2-оос эерэг үр дүнг үзүүлж байгаа нь харагдаж байна. Тухайлбал, хувилбар 1-ийг сонгосон тохиолдолд зохицуулалтын агуулга, шаардлага, нийгэмд үзүүлэх нөлөөний хувьд илүү байна. Харин бусад шалгуур үзүүлэлтийн хувьд ижил байна.

Гарч болох сөрөг үр дагавар

Гарч болох сөрөг үр дагаварын хувьд хувилбар 2 нь хувилбар 1-ээс сөрөг үр дагавар ихтэй болох нь дээрх хүснэгтээр тодорхойлогдож байна. Харин тус хоёр хувилбарт нийтлэг байх гарч болох сөрөг үр дагаврын тухайд Монгол Улсад зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мөрдөх албыг өмнөх хэсгүүдэд дурдсан асуудал, түүний шалтгаан нөхцлийг арилгах байдлаар зохион байгуулж ажиллуулахгүй бол аль ч хувилбар нь сөрөг үр дагаврыг бий болгоно.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Үндэстэн дамнасан гэмт хэргийг мөрдөхөд олон улсын хамтын ажиллагаа чухал үүрэгтэй. Олон улсын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох ажлыг хөнгөвчлөхийн тулд нэн шаардлагатай мэдээллээр хангах, тэдэнд санал болгож буй тагнуулын мэдээллийн дагуу ажиллах найдвартай хамтрагчдыг бий болгох явдал юм.¹⁹ Ингэхдээ олон улс орон үндэстэн дамнасан мөрдөх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг байгууллагуудыг байгуулах эсвэл АНУ-ын Холбооны мөрдөх товчоо, Хар тамхитай тэмцэх газар, Их Британийн Үндэсний гэмт хэрэгтэй тэмцэх агентлаг зэрэг одоо үйл ажиллагаагаа явуулдаг байгууллагуудын бүрэн эрхийн хүрээнд багтаахыг шаарддаг байна.²⁰

Өөрөөр хэлбэл олон улсад зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх дотоодын хууль тогтоомжийн хэрэгжилт стандартчилагдаагүй²¹ бөгөөд зарим улсад зохион байгуулалттай гэмт хэргийг мөрдөн шалгах тусгай алба байдаг бол зарим улсад байдаггүй. Гэсэн ч зохион байгуулалттай гэмт хэргүүд нь нарийн төвөгтэй бөгөөд тодорхой мэргэшил шаарддаг тул хүн худалдаалах, мансууруулах бодисын наймаа, зэрлэг ан амьтдын эсрэг гэмт хэрэг, эмнэлгийн бүтээгдэхүүнийг хуурамчаар үйлдэх, санхүүгийн гэмт хэрэг, цахим гэмт хэрэг гэх мэт гэмт хэргүүдийг харьяалдаг, зохион байгуулалттай гэмт бүлэглэлд анхаарлаа хандуулдаг олон агентлагийн ажлын хэсэг шаардлагатай байна.²²

19 John M. Sellar OBE, A police officer's guide to UNTOC, 2018, <https://globalinitiative.net/analysis/a-police-officers-guide-to-untoc/>.

20 Мөн тэнд.

21 Investigators of organized crime, <https://www.unodc.org/e4j/en/organized-crime/module-8/key-issues/investigators-of-organized-crime.html>.

22 Мөн тэнд.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр баталж, 2003 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр хүчин төгөлдөр болсон Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцыг Монгол Улс 2008 оны 5 дугаар сарын 16-ны өдөр соёрхон баталсан билээ. Түүнчлэн Монгол Улс тус конвенцын нэмэлт болох “Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай” 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн протокол, “Шилжин суурьшигчдыг газраар, далайгаар болон агаараар хууль бусаар оруулахын эсрэг” 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн протокол, “Галт зэвсэг, бүрдэл хэсэг, эд анги, галт хэрэгслийг хууль бусаар тээвэрлэх, үйлдвэрлэхийн эсрэг” 2001 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн протоколыг тус тус соёрхон баталсан.²³

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын 18 дугаар зүйлийн 13-т зааснаар оролцогч улс бүр хууль эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх хүсэлтийг хүлээн авах, гүйцэтгэх, эсвэл эрх бүхий байгууллагад гүйцэтгүүлэхээр дамжуулах эрх, үүрэгтэй төв байгууллагыг томилно. Оролцогч улс нь эрх зүйн харилцан туслалцааны тусдаа тогтолцоотой тусгай бүс нутаг, эсвэл нутаг дэвсгэртэй бол тухайн бүс нутаг, эсвэл нутаг дэвсгэрт ижил чиг үүрэгтэй, тусдаа эрх мэдэл бүхий төв байгууллагыг томилж болно. Эрх бүхий төв байгууллага нь хүлээн авсан хүсэлтийг зохих ёсоор гүйцэтгэх буюу түргэн шуурхай дамжуулах ажлыг хариуцна. Төв байгууллага нь хүсэлтийг эрх бүхий байгууллагад дамжуулж байгаа тохиолдолд уг байгууллагын хүсэлтийг зохих ёсоор, хурдан гүйцэтгэх тал дээр дэмжиж ажиллана²⁴ гэж төв байгууллагын чиг үүргийг дурджээ.

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын оролцогч талуудын бага хурлын Наймдугаар хуралдаанаас 2016 онд “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагааны асуудлаарх төв байгууллагуудын үр нөлөөг дээшлүүлэх тухай” 8/1 тоот тогтоол гаргасан. Уг тогтоолын 13-т оролцогч улсууд олон улсын хамтын ажиллагааны хүрээнд гаргасан хүсэлтийг эрх бүхий байгууллагад гүйцэтгүүлэхээр шилжүүлэх, тэдгээр хүсэлтийн хэлбэр, эрх зүйн үндэслэл, хүсэлт шийдвэрлэх хугацаа зэргийг багтаасан статистикийн мэдээлэл боловсруулах, цуглуулахад нь дэмжлэг үзүүлэх зэргээр гаргасан хүсэлтийг хэрэгжүүлэхэд хяналт тавих зохих тогтолцоог бий болгох, бэхжүүлэх чиглэлээр конвенцын оролцогч улсуудын холбогдох төв байгууллагуудыг дэмжихийг хүссэн.²⁵

Энэ нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн асуудлаар бусад улстай хамтран ажиллах төв байгууллага бий болгох, үйл ажиллагааг нь бэхжүүлэх шаардлагыг тогтоосон хэдий ч тэрхүү төв байгууллага нь улсын хэмжээний нэгдмэл Мөрдөх алба байх эсэхийг тухайн улс бие даан шийдвэрлэх боломжтой. Энэхүү төв байгууллагын талаар НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх ёстой

23 Signatories to the United Nations Convention against Transnational Crime and its Protocols, <https://www.unodc.org/unodc/en/treaties/CTOC/signatures.html>.

24 United Nations Convention against Transnational Organized Crime and the Protocols Thereto, <https://www.unodc.org/documents/treaties/UNTOC/Publications/TOC%20Convention/TOCebook-e.pdf>.

25 Enhancing the effectiveness of central authorities in international cooperation in criminal matters to counter transnational organized crime, The Conference of the Parties to the United Nations Convention against Transnational Organized Crime, Resolution 8/1: https://www.unodc.org/documents/treaties/Resolutions_and_Decisions/Resolution_8_1.pdf.

бөгөөд Монгол Улсын хувьд энэ талаар мэдэгдээгүй байна.²⁶ Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 42.4 дүгээр зүйлийн 4-т “Хүсэлтийг биелүүлэх боломжгүй дараах тохиолдолд олон улсын гэрээ, хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Улсын ерөнхий прокурорын газраар дамжуулан хүсэлт явуулсан гадаад улсын байгууллагад биелүүлээгүй шалтгааныг зааж, хүлээн авсан баримт бичгийг буцаана” гэж зааснаас харахад үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн асуудлаар бусад улстай хамтран ажиллах төв байгууллагыг Улсын ерөнхий прокурорын газраар төлөөлүүлсэн гэж ойлгож болохоор байна.

Олон оронд хууль сахиулагчид буюу дипломат нэр томъёогоор хэлбэл, «хууль зүйн холбооны ажилтан» ('legal liaison officers') гэх мэт албан тушаалтнууд, ялангуяа хар тамхи, хүний наймаа зэрэг асуудалтай холбоотой улс орнуудад Элчин сайдын яаманд байрладаг. Эдгээр ажилтнууд жишээлбэл, INTERPOL, WCO болон мэдээлэл солилцох бусад сувгуудтай харилцах замаар хамтын ажиллагааны хүндрэлийг арилгаж итгэлцлийг бий болгоход туслах боломжтой.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэргийн асуудал эрхэлсэн албаны 2021-2025 оны стратегид “Олон улсын болон бүс нутгийн хэмжээнд хууль сахиулах сүлжээнээс тагнуулын мэдээллийг хуваалцах болон цагдаагийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг дэмжих, гэмт хэрэгтэй тэмцэх хамтарсан болон зэрэгцээ ажиллагаанд оролцогчдын чадавхыг бэхжүүлэх замаар үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлийг амжилттай илрүүлэхэд шаардлагатай арга, хэрэгсэлтэй байх нөхцөлийг хөнгөвчлөх” талаар тусгажээ.²⁷ Энэ нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд тухайн улсын хэмжээнд нэгдмэл зохион байгуулалт, бүтэцтэй байх нь чухал болохыг харуулж байна.

Мөн “Улс төрийн хамгаалалтын шүхэрийг авч хаях” хэрэгтэй талаар Орон нутгийн болон үндэстэн дамнасан гэмт хэргийн эсрэг цагдаагийн шинэчлэл хийх шаардлагатай байна²⁸ гэсэн нийтлэлд тусгагджээ. Үүний дагуу “мөрдөгчдийн сайн ажиллагааг яллах ажиллагаа сул байдал, эсвэл улс төрийн хөндлөнгийн оролцоо ихэвчлэн үгүй болгодог. Иймд онц хүнд зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тусгай мөрдөн байцаах албадад хөрөнгө оруулалт хийж, прокурор, авлигатай тэмцэх газрын албан тушаалтнуудад хууль дүрмийн хүрээнд ажлаа хийхэд шаардлагатай бие даасан байдал, нөөц бололцоог олгох цаг болжээ. Энэ нь тэднийг хамгаалдаг улс төрийн шүхэр дэх гэмт хэргийн бүлэглэлүүдийг няцаах болно” гэжээ.

Эдгээрээс үзэхэд бие даасан мөрдөх алба нь үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагааг хөнгөвчилж, үр нөлөөг сайжруулдаг бөгөөд үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргүүд нь нарийн мэргэшил, үр чадвар шаардагддаг тул эдгээр боловсон хүчнийг багтаасан мөрдөх алба байгуулах нь чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Харьцуулсан судалгаа

Мөрдөн шалгах тогтолцооны үр нөлөөтэй байдлын үзүүлэлтийн дагуу дэлхийн 128 улсын дунд 2020 онд “маш сайн” буюу эхний аравт орсон болон Монгол Улстай

26 Depositary Notifications (CNs) by the Secretary-General: Mongolia, Treaty Reference, XVIII-12, <https://treaties.un.org/doc/Publication/CN/2008/CN.456.2008-Eng.pdf> https://treaties.un.org/Pages/CNs.aspx?cnTab=tab2&clang=_en.

27 UNODC Strategy 2021-2025, <https://www.unodc.org/unodc/strategy/index.html>.

28 Walter Kemp, Mark shaw, Police reform needed for local and transnational crime, 2020, <https://globalinitiative.net/analysis/police-reform/>.

адил ардчилсан улсуудаас сонгож үзвэл Бүгд Найрамдах Финланд Улс, Бүгд Найрамдах Сингапур Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсыг харьцуулан авч үзэх нь зүйтэй байна. Түүнчлэн Монгол Улсын адил НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын оролцогч улсууд болох Япон улс, Оросын Холбооны Улс болон Бүгд Найрамдах Швед Улс зэргийг нэмж судаллаа.

I. Бүгд Найрамдах Сингапур Улсын мөрдөн шалгах газар

Сингапур Улсын 2012 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр бүлгийн 2 дахь хэсгийн 1-д “цагдаагийн газар” гэдэгт Эрүүгийн хэрэг мөрдөн шалгах газар, түүний салбар, Сингапурын цагдаагийн байгууллагын Радио хэлтэс, Цагдаагийн комиссар, Дотоод хэргийн сайдын зүгээс цагдаагийн газар гэж тодорхойлсон аливаа газрыг ойлгоно гэж, 4 дүгээр бүлгийн 18 дахь хэсэгт цагдаагийн албан хаагч хэрэг мөрдөн шалгах эрхийг хэрэгжүүлнэ гэж зааснаас өөрөөр Сингапурын Эрүүгийн хэрэг мөрдөн шалгах газрын харьяалан шалгах гэмт хэргийн талаар тухайлан заагаагүй, цагдаагийн байгууллагын чиг үүргийг ерөнхий байдлаар тусгасан байна.

Сингапур Улсын цагдаагийн байгууллагыг цагдаагийн комиссар нь цагдаагийн бодлого хариуцсан орлогч комиссар, мөрдөн шалгах ажиллагаа, тагнуул хариуцсан орлогч комиссар, ажиллагаа хариуцсан орлогч комиссарын хамт удирдах бөгөөд цагдаагийн байгууллага нь үндсэн газар, тусгай газар, бусад тусгай нэгжээс бүрддэг.²⁹

Үндсэн газарт Эрүүгийн хэрэг мөрдөн шалгах газар харьяалагддаг бөгөөд тус газар нь хүн амины болон хүчингийн хэрэг, кибер, бөмбөг дэлбэлэх, казино, зохион байгуулалттай, синдикат зэрэг хүнд, ноцтой гэмт хэргийг мөрдөн шалгах үүрэгтэй.³⁰ Мөн тус хэлтэс нь хууль бус, нууц нийгэмлэг, зөвшөөрөлгүй мөнгө зээллэг, оюуны өмчийн эрхийн зөрчлийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох ажлыг хариуцдаг. Мөрдөн шалгах газар нь эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагаа явуулах, хууль сахиулах чиг үүргээс гадна мөрдөн шалгах чиг үүрэг бүхий нэгжүүдэд бодлогын удирдамжаар хангах, мөрдөн шалгах ажиллагааны чанарыг сайжруулах, шинэ чадавхийг хөгжүүлэх зэрэг мөрдөн шалгах бүхий л асуудал дээр ажилладаг эрх бүхий байгууллага юм. Энэхүү байгууллага нь Үндсэн гэмт хэргийн хэлтэс, Төрөлжсөн гэмт хэргийн хэлтэс, Технологи, Шүүхийн шинжилгээ, Мөрдөн шалгах үйлчилгээ, дэмжлэгийн, Ажиллагаа, мөрдөх бодлого, сургалтын, Судалгаа, төлөвлөлт, хөгжлийн хэлтэс зэрэг 8 хэлтсээс бүрддэг. Эдгээрийн чиг үүргийг авч үзвэл:

1) Үндсэн гэмт хэргийн хэлтэс

Үндсэн гэмт хэргийн хэлтэс нь Тусгай мөрдөн шалгах тасаг, Бэлгийн хүнд гэмт хэрэгтэй тэмцэх салбар, Бөмбөг, тэсэрч дэлбэрэх бодисын салбар гэсэн гурван салбараас бүрддэг.

Тус хэлтэс нь хүн амины болон хүн хулгайлах, галт зэвсэгтэй холбоотой хэрэг, бэлгийн хүчирхийлэл, бэлгийн халдашгүй байдлын эсрэг хэрэг, хүчирхийлэл, бөмбөг, тэсрэх бөмбөгтэй холбоотой хүнд гэмт хэрэг, бусад томоохон, ноцтой хэргийг шалгадаг.

29 Singapore Police Force (SPF), <https://www.police.gov.sg/Who-We-Are/Organisation-Structure/Organisational-Chart>.

30 <https://www.police.gov.sg/Who-We-Are/Organisation-Structure/Specialist-Staff-Departments>.

2) Гэмт хэргийн тусгай хэлтэс

Гэмт хэргийн тусгай хэлтэст хууль бус мөрийтэй тоглоом, хүний наймаа, тусгай зөвшөөрөлгүй мөнгө зээлэх, нууц нийгэмлэгийн үйл ажиллагаа, оюуны өмчийн эрхийг зөрчих, казиногийн гэмт хэрэгт холбогдсон этгээдүүдийг мөрдөн шалгадаг. Түүнчлэн Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх салбарын хувьд зохион байгуулалттай бүлэгт чиглэсэн мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг. Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу Санхүүгийн мөрдөн байцаах салбар нь нягтлан бодох бүртгэлд шүүхийн шинжилгээ хийх, гэмт хэрэг үйлдэж олсон орлогыг хайж олох, хураах үүрэг гүйцэтгэнэ.

3) Технологийн хэлтэс

Технологийн хэлтэс нь Технологийн гэмт хэргийн бодлогын, Технологийн гэмт хэргийг мөрдөн шалгах, Технологийн гэмт хэргийн шүүхийн шинжилгээний гэсэн гурван салбартай ба уг хэлтэс кибер гэмт хэрэгтэй тэмцэхэд төвлөрч ажиллана.

4) Шүүхийн шинжилгээний хэлтэс

Шүүхийн шинжилгээний хэлтэс нь Сингапурын цагдаагийн байгууллага дахь хэргийн газрын шүүхийн шинжилгээний асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллага бөгөөд Эрүүгийн хэрэг мөрдөн шалгах газрын явуулсан мөрдөн шалгах ажиллагаанд хурууны хээ, хэргийн газрыг баримтжуулах, мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх зэргээр хэргийн газарт шүүхийн шинжилгээ хийнэ.

5) Тагнуулын хэлтэс

Тагнуулын хэлтэс нь эрүүгийн тагнуулын хэрэгцээт мэдээлэл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх, түгээх замаар Эрүүгийн хэрэг мөрдөн шалгах газрын нэгжүүдэд тагнуулын дэмжлэгийн үйлчилгээ үзүүлдэг.

6) Мөрдөн шалгах үйлчилгээ, дэмжлэгийн хэлтэс

Эрүүгийн хэрэг бүртгэх газар, Байцаалт авах, Байгууллагын үйлчилгээний, Ажиллах хүчний, Үйлчилгээний чанарын гэсэн таван салбараас бүрддэг. Тус хэлтэс нь Эрүүгийн хэрэг мөрдөн шалгах газарт онц чухал ар талын үйлчилгээ, мөрдөн байцаалтын дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

7) Ажиллагаа, мөрдөх бодлого, сургалтын хэлтэс

Ажиллагаа, мөрдөх бодлого, сургалтын хэлтэс нь Ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, Ажиллагааг хөгжүүлэх, Мөрдлөг, Харилцаа холбоо, сургалтын салбараас бүрддэг. Тус хэлтэс нь бүх ажиллагаа, томоохон осол аваар, дасгал сургуулалтын зохицуулалт, командлал, хяналтыг хариуцдаг. Мөн тус хэлтэс нь Эрүүгийн хэрэг мөрдөн шалгах газар болон тус газрын бүх хэлтэс, тусгай нэгжүүдийн мөрдөн байцаалтын бодлогыг хариуцсан баг юм.

8) Судалгаа, төлөвлөлт, хөгжлийн хэлтэс

Судалгаа, төлөвлөлт, хөгжлийн хэлтэс нь Эрүүгийн хэрэг мөрдөн шалгах газрын стратеги, байгууллагын хөгжлийн асуудлыг хариуцна. Энэ хэлтсийн ажлын гол чиглэлд стратегийн болон байгууллагын төлөвлөлт, бодлого боловсруулалт, хууль тогтоомжийн хяналт, чадавх хөгжүүлэлт, мэдээллийн менежмент хамаарна.

Мөн бусад тусгай нэгжид хамаарах Арилжааны асуудал эрхэлсэн хэлтэс нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэсэг, Санхүүгийн мөрдөн шалгах хэсэг, Тагнуул, админ групп гэсэн гурван хэсэгтэй бөгөөд Санхүүгийн мөрдөн шалгах II хэлтэс нь Терроризм (санхүүжилтийг таслан зогсоох) хууль³¹-ийн дагуу терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгадаг.

II. Япон Улсын гэмт хэрэг мөрдөх товчоо

Япон Улсын “Цагдаагийн тухай хууль”³²-аар үндэсний төв цагдаагийн газар (цаашид Цагдаагийн ерөнхий газар гэх)-ыг үүсгэн байгуулах эрх хэмжээ тодорхойлогддог. Цагдаагийн ерөнхий газрын дарга нь ерөнхий комиссар байх бөгөөд түүнийг Ерөнхий сайдын зөвшөөрөлтэйгээр Олон нийтийн аюулгүй байдлын үндэсний хороо томилж, чөлөөлнө.³³ Мөн цагдаагийн ерөнхий комиссарын орлогч ерөнхий комиссарын харьяалан шийдвэрлэх үйл ажиллагаанд туслах үүрэгтэй байна. Цагдаагийн тухай хуулийн 19-р зүйлд заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын харьяанд Ерөнхий комиссарын ажлын алба болон дараах таван товчоог байхаар заажээ. Үүнд:

- Олон нийтийн аюулгүй байдлын товчоо
- Гэмт хэрэг мөрдөх товчоо
- Тээврийн товчоо
- Аюулгүй байдлын товчоо
- Мэдээлэл, харилцаа холбооны товчоо зэрэг орж байна.

Гэмт хэрэг мөрдөх товчоо нь Эрүүгийн хэрэг төлөвлөлтийн хэлтэс, Мөрдөн шалгах 1-р хэлтэс, Мөрдөн шалгах 2-р хэлтэс, Тагнуулын дэмжлэг хариуцсан захирал, Гэмт хэрэг илрүүлэх захирал зэргээс бүрдэх бөгөөд мөн Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс харьяалагддаг. Уг хэлтэс нь Зохион байгуулалттай гэмт хэргийн бодлого төлөвлөх хэлтэс, Япон улсын зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Мансууруулах бодис болон галт зэвсэгтэй тэмцэх хэлтэс болон Олон улсын мөрдөн шалгах ажиллагаа хариуцсан захирал зэргээс бүрддэг. Харин Аюулгүй байдлын товчоонд Гадаад харилцааны тагнуулын хэлтэс, Аюулгүй байдлын ажиллагааны хэлтэс тус тус харьяалагддаг ба олон улсын терроризмтой тэмцэх хэлтэс нь Гадаад харилцааны тагнуулын хэлтсийн харьяанд байна.

Гэмт хэрэг мөрдөх товчоо нь Цагдаагийн ерөнхий газрын харьяаллын дагуу дараах асуудлыг хариуцна.³⁴

1. Эрүүгийн цагдаад холбогдох асуудал;
2. Эрүүгийн шүүхийн шинжилгээний асуудал;
3. Гэмт хэргийн статистикийн тухай;
4. Зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн эсрэг авах арга хэмжээний тухай;
5. Хар тамхи, галт зэвсэгтэй холбоотой гэмт хэргийг таслан зогсоох;

31 Terrorism (Suppression of Financing) Act, 2003, <https://sso.agc.gov.sg/Act/TSFA2002>, сүүлд үзсэн: 2021.12.07

32 Police Law, Showa 29 Law No. 162, <https://elaws.e-gov.go.jp/document?lawid=329AC0000000162>

33 Мөн тэнд, 16-р зүйл

34 Police Law (Showa 29 Law No. 162), 23-р зүйл, <https://elaws.e-gov.go.jp/document?lawid=329AC0000000162>.

6. Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх (бусад газрын харьяалахаас бусад);
7. Гэмт хэргийн улмаас олсон орлого шилжүүлэхээс урьдчилан сэргийлэх асуудал;
8. Олон улсын мөрдөн шалгах ажиллагаанд харилцан туслалцаа үзүүлэх;
9. Хүнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах.

Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс нь Олон улсын эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаатай холбогдох асуудлууд болон Олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллагатай харилцах асуудлыг хариуцан ажилладаг байна. Ингэхдээ гадаадын мөрдөх байгууллагууд Интерполоор дамжуулан гишүүн орнуудтай мэдээлэл солилцох, мөрдөн шалгах ажиллагаанд хамтран ажиллахаас гадна Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний үндсэн дээр дипломат шугам болон төв байгууллагын шугамаар харилцан туслалцаа үзүүлэх замаар эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах боломжтой байдаг³⁵ байна.

III. Оросын Холбооны Улсын холбооны аюулгүй байдлын алба

ОХУ-д Хууль сахиулах гол байгууллагууд нь ОХУ-ын Дотоод хэргийн яам, Холбооны гаалийн алба, Холбооны аюулгүй байдлын алба, Холбооны хамгаалалтын алба, Холбооны хар тамхитай тэмцэх алба, түүнчлэн Ерөнхий прокурорын газар, ОХУ-ын Хууль зүйн яам зэрэг багтдаг.³⁶

Хууль сахиулах ажлыг хэд хэдэн агентлагууд хариуцдаг бөгөөд Орос улсын цагдаа нь хууль сахиулах үндсэн байгууллага бол Оросын Холбооны мөрдөх товчоо нь гол мөрдөн шалгах байгууллага гэгддэг, харин Холбооны аюулгүй байдлын алба (хуучнаар КГБ) бол дотоодын аюулгүй байдлын гол байгууллага юм.

ОХУ-ын Холбооны аюулгүй байдлын алба (Federal Security Service of the Russian Federation (Russian Федеральная служба безопасности Российской Федерации) уг байгууллагын үндсэн үүрэг нь улс орны хэмжээнд сөрөг тагнуул, дотоод болон хилийн аюулгүй байдал, терроризмтой тэмцэх, тандалт хийх, түүнчлэн бусад төрлийн хүнд гэмт хэрэг, холбооны хууль зөрчсөн үйлдлүүдийг мөрдөн шалгах зэрэг юм.³⁷

Холбооны аюулгүй байдлын алба (ХАБА):

Холбооны аюулгүй байдлын алба (ХАБА) нь төрийн аюулгүй байдлын хорооны нэгэн адил Орост зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг ажилладаг. Ихэнхдээ дотоод хэргийн яам болон холбооны аюулгүй байдлын алба нар гэмт хэргийг таслан зогсоохын тулд гар нийлэн ажилладаг. ХАБА-ын үндсэн үүрэг нь Оросын төрийн дотоод аюулгүй байдал, сөрөг тагнуул, зохион байгуулалттай гэмт хэрэг, терроризм, хар тамхины хууль бус наймаатай тэмцэх ажлыг голлон хариуцдаг. ОХУ-ын бүх хууль сахиулах, тагнуулын байгууллагууд шаардлагатай бол ХАБА-ын удирдлаган дор ажилладаг.

35 https://www.npa.go.jp/english/Police_of_Japan/2020/poj2020_full.pdf.

36 <https://polis.osce.org/country-profiles/russian-federation#federal-security-service-10477>.

37 <https://polis.osce.org/country-profiles/russian-federation#federal-security-service-10477>.

Экспортын хяналт

ХАБА нь Оросын экспортын хяналтын стратеги боловсруулах ажилд оролцож, давхар хэрэглээний болон цэргийн бараа, технологи шилжүүлэхтэй холбоотой олон улсын гэрээний төслүүдийг шалгадаг. Цөмийн зэвсгийг түгээн дэлгэрүүлэхгүй байх салбар дахь түүний үндсэн үүрэг бол хяналттай цөмийн технологи, материалыг хууль бусаар экспортлохоос урьдчилан сэргийлэх мэдээлэл цуглуулах явдал юм.³⁸

Холбооны аюулгүй байдлын албаны тухай хууль³⁹-ийн 8 дугаар зүйлд Холбооны аюулгүй байдлын албаны үйл ажиллагааны чиглэлийг тусгасан. Холбооны аюулгүй байдлын албаны үйл ажиллагаа дараах үндсэн чиглэлээр явагдана. Үүнд:

- » сөрөг тагнуул;
- » терроризмтэй тэмцэх;
- » гэмт хэрэгтэй тэмцэх;
- » тагнуул
- » хилийн үйл ажиллагаа;
- » мэдээллийн аюулгүй байдлыг хангах гэж тус тус орно.

Гэмт хэрэгтэй тэмцэх: Холбооны аюулгүй байдлын алба нь хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагаа харьяаллын дагуу хуулиар тогтоосон журмаар явагдсан ОХУ-ын аюулгүй байдалд заналхийлж буй тагнуул, зохион байгуулалттай гэмт хэрэг, авлига, галт зэвсэг, хар тамхины хууль бус худалдаа, хууль бусаар хил давуулах ажиллагаа болон ОХУ-ын үндсэн хуулийн тогтолцоог хүчээр өөрчлөх зорилготой хууль бус зэвсэгт бүлэглэл, гэмт бүлэглэл, хувь хүн, олон нийтийн холбоодын үйл ажиллагааг илчлэх, эдгээр гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор шуурхай/эрлийн ажиллагааг хэрэгжүүлнэ.⁴⁰

Тагнуул: Тагнуулын үйл ажиллагааг «Гадаад тагнуулын тухай» Холбооны хуульд заасны дагуу аюулгүй байдлыг хангах холбооны гүйцэтгэх байгууллагын дэргэдэх гадаад тагнуулын байгууллага гүйцэтгэдэг.

Терроризмтэй тэмцэх: Холбооны аюулгүй байдлын алба ба (эсвэл) тэдгээрийн салбар нэгжүүд нь тухайн байгууллага, салбар нэгжийн албан тушаалтан тусгай ажиллагаа явуулах замаар терроризмын үйлдлийг таслан зогсоох, илрүүлэх, урьдчилан сэргийлэх мөрдөн шалгах болон бусад арга хэмжээг хэрэгжүүлдэг.⁴¹

2006 оны зун ХАБА-д ерөнхийлөгчийн тушаалаар хилийн чанадад терроризмын сэжигтнийг онилон устгах хууль ёсны эрхийг олгосон.⁴² 2008 он гэхэд тус агентлаг нэг дарга, хоёр Тэргүүн дэд дарга, 5 дэд даргатай болсон бөгөөд дараах 9 хэлтэстэй. Үүнд:

38 Status of the State Licensing System of Control over Exports of Nuclear Materials, Dual-use Commodities and Technologies in Russia: Manual for foreign associates in Russia, International Business Relations Corporation, Department of Nuclear Energy and Nuclear Fuel Cycle, 2002.

39 Federal law on the federal security service, 1995, https://www.legislationline.org/download/id/3708/file/RF_law_fed_security_service_1999_am2011_en.pdf.

40 Federal law on the federal security service, 1995, https://www.legislationline.org/download/id/3708/file/RF_law_fed_security_service_1999_am2011_en.pdf, Article 10.

41 Мөн тэнд, Article 9.1.

42 Finn, Peter In Russia, A Secretive Force Widen", 2007.

- I. Сөрөг тагнуул
- II. Үндсэн хуулийн дэг журмыг хамгаалах, терроризмтой тэмцэх алба
- III. Хилийн алба
- IV. Эдийн засгийн аюулгүй байдлын алба
- V. Одоогийн мэдээлэл ба олон улсын холбоосууд
- VI. Зохион байгуулалт, боловсон хүчний алба
- VII. Хяналтын хэлтэс
- VIII. Шинжлэх ухаан, техникийн үйлчилгээ
- IX. Байгууллагын аюулгүй байдлын алба.

IV. Швед улсын цагдаагийн газар, үндэсний төв товчоо

Цагдаагийн ажиллагааг Цагдаагийн газар, Аюулгүй байдлын цагдаа гүйцэтгэдэг.⁴³ Аюулгүй байдлын цагдаагийн чиг үүрэг нь Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, террорист гэмт хэрэг зэрэг гэмт хэргийн шинжтэй үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх болон эдгээр гэмт хэргийг мөрдөн шалгах⁴⁴ зэрэг болно. Швед улсын цагдаагийн газрыг үндэсний цагдаагийн комиссар тэргүүлдэг.⁴⁵ Швед улсын цагдаагийн газар нь бүс нутгаар харьяалсан 7 нэгж болон Үндэсний ажиллагааны газар, Шүүхийн шинжилгээний үндэсний төв, Харилцаа холбооны хэлтэс, Санхүүгийн асуудал хариуцсан хэлтэс, Хүний нөөцийн хэлтэс, Мэдээлэл технологийн хэлтэс, Хууль зүйн асуудал эрхэлсэн хэлтэс болон Тусгай мөрдөх хэлтэс зэрэг бүрэлдэхүүнтэй.

Шведийн Үндэсний ажиллагааны газар (Nationella operativa avdelningen (YAG))⁴⁶ нь Үндэсний цагдаагийн комиссарт шууд харьяалагддаг ба Комиссар удирддаг. YAG нь Шведийн зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг үндэсний болон олон улсын түвшинд удирдаж, зохион байгуулдаг. Мөн хямралын нөхцөл байдал, үндэсний хэмжээнд анхаарал татсан үйл явдлын үед цагдаагийн үйл ажиллагааг зохицуулах үүрэгтэй.⁴⁷

Үндэсний ажиллагааны газар нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг.⁴⁸ Үүнд:

- » Өөрийн санаачилсан аливаа үйл ажиллагаа явуулдаггүй, харин бүс нутгийн цагдааг төрөл бүрийн үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;
- » Ажиллагаанд хяналт тавьдаг бөгөөд улс даяар ажиллагаа явуулах, нөөцийг бэхжүүлэх асуудлыг шийдвэрлэх;
- » Шведийн Аюулгүй байдлын алба, Шведийн Зэвсэгт хүчин, Үндэсний Батлан хамгаалахын Радио Байгууллагын үндэсний холбоо барих цэг бөгөөд терроризм, дохионы тагнуул гэх мэт нууц мэдээллийг удирдах;

43 Polislagen, 1984, 387, 1-р зүйл, <https://lagen.nu/1984:387>.

44 Security Protection Act, 2018, <https://lagen.nu/2018:585#K2R9>.

45 <https://polisen.se/en/the-swedish-police/the-swedish-police-authority/>.

46 Цагдаагийн тухай хуулиар Цагдаагийн газар нь Үндэсний ажиллагааны газартай байх эрх хэмжээ олгогдсон байдаг. Polislagen, 1984, 2b.1-р зүйл, <https://lagen.nu/1984:387>.

47 <https://www.interpol.int/en/Who-we-are/Member-countries/Europe/SWEDEN>.

48 <https://polisen.se/en/the-swedish-police/the-swedish-police-authority/>.

- » Хүнд, зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг хэд хэдэн эрх бүхий байгууллагаас авч буй тусгай арга хэмжээг зохицуулах, төлөвлөх, хянах зэрэг үүрэгтэй.

Түүнчлэн Швед дэх Стокгольм хотын ИНТЕРПОЛ Үндэсний төв товчоо (ҮТТ) нь Швед улсад холбогдох үндэстэн дамнасан гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, урьдчилан сэргийлэх зорилгоор Шведийн хууль сахиулах байгууллагууд болон цагдаагийн газартай хамтран ажиллах тэргүүлэх байгууллага юм.⁴⁹ Стокгольм дахь цагдаагийн үндэсний төв байранд байрлах Шведийн ҮТТ нь Үндэсний ажиллагааны газрын дэргэдэх Олон улсын харилцааны хэлтсийн олон улсын хэсэгт харьяалагддаг.⁵⁰

Зохион байгуулалттай, хүнд гэмт хэргүүдийн олон улсын шинж, дэлхий даяарх гэмт хэргийн сүлжээнүүдтэй уялдаа холбоотой байдаг зэрэг нь Швед дэх ИНТЕРПОЛ-ын ҮТТ-г үндэсний болон бүс нутгийн хэмжээнд аюулгүй байдлыг хангахад чухал үүрэгтэй байгууллага болгодог байна. Энэ байгууллага нь дэлхийн бүх тивийн ИНТЕРПОЛ-той хамтран ажиллаж, олон улсын шинжтэй гэмт хэргийн нөхцөл байдалд хяналт тавьж, шаардлагатай үед Шведэд уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг гүйцэтгэдэг. Тэнд 24 цагийн турш ажилладаг Олон улсын хэлтэст эрэгтэй, эмэгтэй 55 хүн ажилладаг. Тэд бүс нутгийн зохион байгуулалттай гэмт хэргийн талаарх дэлхийн эх сурвалжтай мэдээлэл солилцох замаар Швед даяар цагдаагийн ажилтнуудад тус улсын нутаг дэвсгэр болон эргэн тойрон дахь наймааны маршрутын дагуу хууль бус барааны урсгалыг илрүүлж, мөрдөн шалгахад тусалдаг.

V. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Холбооны Эрүүгийн цагдаагийн газар

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад олон нийтийн аюулгүй байдал, дэг журмыг сахиулах үүргийг холбооны 16 муж болон тэдгээрийг хариуцдаг холбооны түвшинд хэрэгжүүлдэг. Холбооны түвшинд Холбооны цагдаа (Бундесполизей, ХЦ) болон Холбооны Эрүүгийн цагдаагийн газар (Бундескриминаламт, ХЭЦГ) ажилладаг. Үүн дээр нэмэгдэн Холбооны тагнуулын газар (Bundesnachrichtendienst,) болон Холбооны Үндсэн хуулийг хамгаалах газар (Bundesamt für Verfassungsschutz,) зэрэг өөр хоёр агентлаг аюулгүй байдлын асуудал дээр хамтарч ажилладаг.

ХБНГУ-ын Холбооны Эрүүгийн цагдаагийн газар нь тус улсын эрүүгийн хэрэг мөрдөн шалгах төв байгууллага бөгөөд холбооны болон муж улс хоорондын цагдаагийн мөрдөн шалгах ажиллагааг уялдуулан зохицуулдаг.⁵¹ Олон улсын болон хүнд гэмт хэргийн тодорхой хэсэгт тус газар нь бие даан хариуцлага хүлээх үндсэн дээр буюу өөрийн нэрийн өмнөөс хууль сахиулах чиг үүргийг гүйцэтгэж, мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг.⁵² ХБНГУ-ын Холбооны Эрүүгийн цагдаагийн газар нь Холбооны Дотоод хэргийн яамны харьяанд байх ба үйл ажиллагааг нь

49 <https://www.interpol.int/en/Who-we-are/Member-countries/Europe/SWEDEN>.

50 Мөн тэнд.

51 Federal Ministry of the Interior, Building and Community - The Federal Criminal Police Office, <https://www.bmi.bund.de/EN/topics/security/federal-criminal-police-office/federal-criminal-police-office-node.html>.

52 https://www.bka.de/DE/UnsereAufgaben/Aufgabenbereiche/Ermittlungen/ermittlungen_node.html;jsessionid=7BB_49369E7E1733F07661B0979CD817E.live302?fbclid=IwAR0bt3MEzCqOP4mMjclmoDMNzzPwFk2HIJSirVcA-EeRYHM5TMZICQGETFc.

ХБНГУ-ын Үндсэн хууль болон “Холбооны Эрүүгийн цагдаагийн газар ба Эрүүгийн хэргийн асуудлаар холбооны болон муж улсын эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагааны тухай” хууль⁵³-иар тус тус зохицуулсан байдаг.

Холбооны Эрүүгийн цагдаагийн газрын бүтцийг авч үзвэл ХЭЦГ-ыг ерөнхийлөгч болон гурван дэд ерөнхийлөгч удирдаж Мэргэшсэн 11 хэлтэс ХБНГУ-ын аюулгүй байдлыг баталгаажуулдаг.⁵⁴ Эдгээр нь Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Мэдээллийн технологийн хэлтэс, Олон улсын хамтын ажиллагаа, боловсрол, судалгааны төв, Исламын үзэлтэй терроризм / экстремизмтэй тэмцэх хэлтэс, Шүүхийн шинжилгээний хүрээлэн, Ажиллагааны даалгавар болон мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хэлтэс, Төрийн аюулгүй байдлын хэлтэс, Онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Хууль сахиулах сургалт, судалгааны хүрээлэн, Арын алба, Төв захиргаа болон Мэдээлэл, хайлтын төв алба гэсэн нэгжүүдээс бүрдэж байна.⁵⁵

Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс

Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс нь үндэсний болон олон улсын түвшинд кибер гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд холбооны болон муж улсын цагдаагийн хүчин болон бусад үндэсний болон олон улсын түншүүдтэй хамтран ажилладаг.

Мэдээллийн технологийн хэлтэс

Мэдээллийн технологийн хэлтэс бол цагдаагийн байгууллагын мэдээллийн системийн тулгуур хэсэг юм. Мэдээллийн технологийн ажилтнууд цагдаагийн мэдээлэл солилцох үйл ажиллагааг жигд явуулж, ХЭЦГ болон мужийн цагдаагийн газарт мэдээллийн технологийн хөгжүүлэлт хийдэг.

Олон улсын хамтын ажиллагаа, боловсрол, судалгааны төв

Уг хэлтэс нь дэлхий даяар ХЭЦГ-ын хамтын ажиллагааны байгууллагуудын холбоо барих цэг болдог. Энэ нь үндэсний болон Европын хууль эрх зүйн асуудлаар зөвлөгөө өгөх төв бөгөөд ХЭЦГ-ын боловсрол, судалгааны төв юм.

Исламын үзэлтэй терроризм / экстремизмтэй тэмцэх хэлтэс

Энэхүү хэлтэс нь шашны сэдэлтэй/Исламын терроризмтэй тэмцэх үүрэгтэй. Энэхүү талбарыг бие даан хариуцах хэлтэс байгуулснаар Холбооны болон муж улсын аюулгүй байдлын бусад байгууллагуудтай хамтран Исламын терроризмтой илүү үр дүнтэй тэмцэхийн тулд ХЭЦГ-т үйл ажиллагаа, дүн шинжилгээ хийх, туслах чадварыг өргөжүүлж байна.

Шүүхийн шинжилгээний хүрээлэн

Холбооны Эрүүгийн цагдаагийн газрын Шүүхийн шинжилгээний хүрээлэн нь холбооны аюулгүй байдлын байгууллагуудын шүүхийн шинжилгээний төв байгууллага юм. Төрөл бүрийн материаллаг нотлох баримтыг хадгалж, шинжилж, үнэлж, шаардлагатай бол холбогдох мэдээллийн сан дахь нотлох баримтуудтай харьцуулдаг. 60 гаруй мэргэжлээр ажилладаг 400 гаруй мэргэжилтэнтэй салбар дундын өргөн бүтэцтэй байгууллага юм.

53 Холбооны Эрүүгийн цагдаагийн газар ба Эрүүгийн хэргийн асуудлаар холбооны болон муж улсын эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагааны тухай хууль, 2017, https://www.buzer.de/BKAG_Bundeskriminalamtgesetz.htm.

54 https://www.bka.de/DE/DasBKA/OrganisationAufbau/organisationaufbau_node.html.

55 https://www.bka.de/DE/DasBKA/OrganisationAufbau/Fachabteilungen/fachabteilungen_node.html.

Ажиллагааны даалгавар болон мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх хэлтэс

Уг хэлтэс нь ажиллагааны болон мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиглэлээр ХЭЦГ-ын үр нөлөөг нэгтгэж, нэмэгдүүлдэг. Үүнд гар утасны ажлын хэсэг гэх мэт «сонгодог» эрэн сурвалжлах туслах үйлчилгээ, мөн техникийн төвлөрсөн үйлчилгээ зэрэг багтана.

Төрийн аюулгүй байдлын хэлтэс

Төрийн аюулгүй байдлын хэлтэс нь улс төрийн сэдэлтэй гэмт хэрэгтэй тэмцэх үүрэгтэй бөгөөд энэ хүрээнд аюулаас урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах үүргийг гүйцэтгэдэг. Төрийн аюулгүй байдлын хэлтэс нь Терроризмтой тэмцэх нэгдсэн төвүүдэд үндэсний хэмжээнд ХЭЦГ-г, олон улсын түвшинд ХБНГУ-ын төрийн аюулгүй байдлыг төлөөлдөг.

Онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс

Зохион байгуулалттай гэмт хэрэг болон бусад төрлийн онц хүнд гэмт хэрэгтэй тэмцэхэд эрүүгийн тусгай мэдлэг, дотоод болон гадаадын эрчимтэй хамтын ажиллагаа шаардлагатай. Энэ нь Онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газрын үндсэн үүрэг юм.

Арын алба

Холбооны Эрүүгийн цагдаагийн албаны тухай хуулийн 6-р хэсэгт заасны дагуу Аюулгүй байдлын бүлэг нь холбооны үндсэн хуулийн байгууллагуудын аюулгүй байдал, шаардлагатай хамгаалалтыг хариуцдаг бөгөөд онцгой тохиолдолд тэдний гадаадын зочдыг хариуцдаг.

Мэдээлэл, хайлтын төв алба

Мэдээлэл, хайлтын төв алба нь ХЭЦГ-ын урт хугацааны гэмт хэргийн алба, таних алба, хайлтын үйл ажиллагаа, түүнчлэн оффисын хэмжээнд үйлчилдэг үйлчилгээний байгууламжуудыг багтаадаг.

Төв захиргаа

7000 гаруй ажилтантай байгууллага нь орчин үеийн, мэргэжлийн удирдлага шаарддаг. Боловсон хүчнийг сонгон шалгаруулах, дэмжих, төсвийн асуудал, хууль эрх зүйн асуудал бол Төв захиргааны хэлтэст хэлэлцдэг сэдвүүдийн зөвхөн нэг хэсэг юм.

ХЭЦГ-ын хариуцах гэмт хэргийг дээр дурдсан хамтын ажиллагааны тухай хуулиар зохицуулжээ.⁵⁶ Үүнд заасанчлан ХЭЦГ нь Зэвсэг, сум, тэсэрч дэлбэрэх бодис, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх шинэ бодис, эмийн бэлдмэлийг олон улсын хэмжээнд зохион байгуулалттайгаар хууль бусаар худалдаалах, хуурамч мөнгө олон улсын хэмжээнд зохион байгуулалттайгаар үйлдвэрлэх, тараах, түүнчлэн үүнтэй холбогдуулан үйлдсэн гэмт хэрэг, түүний дотор олон улсын хэмжээнд зохион байгуулалттай мөнгө угаах гэмт хэрэг, терроризм зэрэгт мөрдөн шалгах үүрэгтэй оролцдог байна.

56 Холбооны Эрүүгийн цагдаагийн газар ба Эрүүгийн хэргийн асуудлаар холбооны болон муж улсын эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагааны тухай хууль, 2017, 1.4, 1.5-р зүйл, https://www.buzer.de/BKAG_Bundeskriminalamtgesetz.htm.

Эдгээр харьяа байгууллагуудын тусламжтайгаар ХЭЦГ нь ХБНГУ-ын Холбооны Эрүүгийн цагдаагийн газар дараах гэмт хэргийн хүрээнд харьяалан мөрдөн шалгадаг.⁵⁷ Үүнд:

- Хүүхдийг садар самуунд оролцуулах гэмт хэрэг;
- Авлигын гэмт хэрэг;
- Хуурамч валютын гэмт хэрэг;
- Интернэтийн гэмт хэрэг/кибер гэмт хэрэг;
- Хар тамхитай холбоотой гэмт хэрэг;
- Зохион байгуулалттай гэмт хэрэг;
- Хууль бус мотоциклийн бүлэглэлийн гэмт хэрэг;
- Хүн худалдаалах гэмт хэрэг;
- Зэвсэг хууль бусаар худалдаалах гэмт хэрэг.

Эцэст нь Гаалийн байгууллагын онцгой үүргийг бас дурдах хэрэгтэй. 1992 оны 7 дугаар сарын 15-ны өдөр Төсвийн удирдлага болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон. Ийнхүү хуулийн актаар Холбооны дээд байгууллага болох Германы Гаалийн Мөрдөн шалгах алба байгуулагдсан. Уг алба нь үндэсний бусад эрх бүхий байгууллага, ялангуяа холбооны болон муж улсын цагдаагийн газар, санхүүгийн болон эдийн засгийн байгууллагууд болон шүүхийн байгууллагуудтай хамтран ажилладаг (жишээлбэл, хар тамхины хууль бус наймаатай тэмцэх зорилгоор гааль, цагдаагийн хамтарсан 27 мөрдөн шалгах бүлэг байдаг).

Гаалийн Мөрдөн шалгах алба нь харьяалах эрх хэмжээнийхээ хүрээнд цагдаагийн байгууллагатай адил эрх мэдэлтэй гэдгийг анхаарах нь чухал. Ийнхүү гаалийн байцаагчид шүүх ажиллагаа эхлэх хүртэл мөрдөн шалгах ажиллагаа явуулах боломжтой байна.

VI. Бүгд Найрамдах Финланд Улсын Үндэсний мөрдөх товчоо

Финландын төвлөрсөн цагдаа нь орон нутгийн хэмжээнд дүүргийн цагдаа, мужийн цагдаагийн газар, үндэсний хэмжээнд цагдаагийн дээд газар гэсэн гурван түвшинд хуваагддаг ба Финландын цагдаагийн байгууллагад Үндэсний цагдаагийн зөвлөл, орон нутгийн цагдаагийн газрууд, Үндэсний мөрдөх товчоо, Цагдаагийн их сургууль болон Финландын Аюулгүй байдал, тагнуулын алба багтдаг.⁵⁸ Дотоод хэргийн яамны дэргэдэх Цагдаагийн газарт харьяалагддаг Үндэсний мөрдөн шалгах товчоонд Олон улсын хамтын ажиллагааны эрх хэмжээ харьяалагддаг.

Уг товчоо нь хүнд, зохион байгуулалттай, мэргэжлийн гэмт хэргүүдийг илрүүлж, мөрдөн шалгах, цаашлаад гэмт хэргээс сэргийлэх буюу мөрдөн шалгах нууц ажиллагааг хариуцдаг.⁵⁹ Финландын шүүхийн шинжилгээний цор ганц лаборатори нь Үндэсний мөрдөх товчоонд харьяалагддаг. Лаборатори нь цагдаагийн бүх анги, гадны зарим байгууллагад үйлчилгээ үзүүлэх бөгөөд шүүхийн шинжилгээ хийж, шинжилгээний аргуудыг боловсруулж уялдуулах, цагдаагийн байгууллагад нэвтрүүлсэн шүүхийн шинжилгээний арга, тоног төхөөрөмж, материалыг

57 https://www.bka.de/EN/OurTasks/AreasOfCrime/areasofcrime_node.htm.

58 <https://intermin.fi/en/police/agencies-and-responsibilities>.

59 <https://poliisi.fi/en/national-bureau-of-investigation>.

боловсруулж, туршиж батлах ажил эрхлэн явуулдаг байна. Үндэсний мөрдөх товчоонд мөн Кибер гэмт хэрэгтэй тэмцэх төв байрладаг.⁶⁰

Үүнээс гадна нь олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, ялангуяа бусад орноос Финланд руу чиглэсэн онц хүнд, зохион байгуулалттай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор гадаадад томилогдон ажиллаж буй холбооны ажилтнуудад (liaison officers) хяналт тавих ажиллагааг хариуцдаг ба ХБНГУ-ын ХЭЦГ-ын нэгэн адил үндэсний мөрдөх товчоо нь мөн Интерпол, Европол, Шенгений үндэсний төвийн үүрэг гүйцэтгэдэг.⁶¹

Финланд улсын Эрүүгийн хэрэг мөрдөн шалгах тухай хууль⁶²-ийн 2 дугаар бүлгийн 1-р зүйлд заасанчлан эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагааг цагдаагийн байгууллага хэрэгжүүлэх бөгөөд цагдаагийн байгууллагаас гадна хил хамгаалагч, гаалийн болон цэргийн байгууллагууд холбогдох хуульд заасан харьяаллын дагуу эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагаа явуулна. Мөн прокурор нь эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд оролцохоор байна.

Тус товчоо нь Финландад олон улсын эрүүгийн цагдаагийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэх төвийн үүрэг гүйцэтгэдэг ба тэднийг улсынхаа хууль сахиулах эрх бүхий байгууллагуудтай холбох чиг үүрэгтэй ажилладаг. Хууль сахиулах эрх бүхий байгууллагууд Үндэсний мөрдөх товчооноос зөвлөгөө авах, мэдээлэл хайх, солилцох чиглэлээр арга зүйн туслалцаа авах боломжтой. Үндэсний мөрдөх товчоонд Харилцаа холбооны төв харьяалагддаг бөгөөд энэ төв нь олон улсын шифрлэгдсэн мэдээлэл солилцооны үндсэн оролцогч юм. Тухайлбал, тус төвөөр дамжуулан Финланд Улсад явагдах баривчлах ажиллагааны талаар нэмэлт мэдээлэл өгдөг.⁶³ Мөн Санхүүгийн мэдээллийн албаны тухай хууль (445/2017) болон Терроризмтой тэмцэх зорилгоор хөрөнгө царцаах тухай хуульд (325/2013) заасан арга хэмжээг хэрэгжүүлэх үүргийг Үндэсний мөрдөх товчоо хүлээдэг.⁶⁴

60 <https://intermin.fi/en/police/agencies-and-responsibilities>; http://www.poliisi.fi/en/national_bureau_of_investigation/nbi_organisation.

61 <https://www.coe.int/t/dg1/legalcooperation/economiccrime/organisedcrime/BestPractice5E.pdf>.

62 Criminal Investigation Act, <https://www.finlex.fi/fi/laki/kaannokset/2011/en20110805.pdf>.

63 <https://poliisi.fi/en/international-cooperation>.

64 <https://poliisi.fi/etusivu>.

ДҮГНЭЛТ

Швед, Япон, Финланд, Сингапур улсуудын мөрдөх албаны дотоод бүтцэд нийтлэг байдлаар дараах нэгжүүд багтжээ. Үүнд, зохион байгуулалттай, хүнд гэмт хэргийн төрөл бүхий нэгж, олон улсын болон дотоод хамтарсан ажиллагаа хариуцсан нэгж, тагнуулын ба шүүхийн шинжилгээний нэгж, лаборатори, кибер гэмт хэрэгтэй тэмцэх нэгж багтсан. Хэдий холбооны улсууд ч гэсэн ОХУ болон Герман улсын мөрдөх албаны үйл ажиллагаа нь дээр дурдсан улсуудын мөрдөх албаныхтай төстэй байх бөгөөд нийтлэг байдлаар мансууруулах бодис, галт зэвсэг, хүний наймаа зэрэг үндэстэн дамнасан, хүнд гэмт хэргүүдийг мөрдөн шалгах чиг үүрэгтэй байна. Мөн зарим оронд гаалийн байгууллага нь эдгээр гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааг явуулах эрхтэй байх бөгөөд судалсан улсуудад гаалийн байгууллага болон шүүх, цагдаагийн бусад байгууллага хамгийн гол нь INTERPOL зэрэг олон улсын байгууллагуудтай харилцах хамтын ажиллагааг дэмжсэн тодорхой бүтэц, чиг үүрэгтэй байна. Мөн ихэнх оронд мөрдөн шалгах газрууд нь Цагдаагийн ерөнхий газрын харьяанд нэг бие даасан нэгж болон үйл ажиллагаагаа явуулж байх бөгөөд мөрдөх албаны бие даасан хуулиар эрх хэмжээг нь олгожээ.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

“Мөрдөх албаны тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа”-ны хүрээнд 6 бүлэг бүхий аргачлалыг үндэслэн Мөрдөх албаны тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг тандан судаллаа. Энэхүү үе шатуудыг дүгнэн үзвэл дараах үр дүнд хүрч байна.

Асуудлын гол шалтгаан нөхцөл буюу мөрдөх албыг байгуулах хэрэгцээ, шаардлага нь ерөнхийдөө хоёр нөхцөл байдлаас үүдэлтэй байна. Нэгдүгээрт Монгол Улсад мөрдөх албаны тухай хуулийг бий болгож мөрдөх албыг байгуулах шаардлага нь Монгол Улсын олон улсын гэрээ болон дотоодын эрх зүйн зохицуулалтаас үүдэлтэй байна. Хоёрдугаарт, Монгол Улсад мөрдөх албаны тухай хуулийг бий болгож мөрдөх албыг байгуулах шаардлага нь Монгол Улсын зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэргийн нөхцөл байдлаас бий болж байна. Дээрх хоёр нөхцөл байдалтай холбоотой судалгааг өмнөх хэсгүүдэд оруулсан ба аргачлалын дагуу эрх ашиг нь хөндөгдөх этгээдүүдийг тодорхойлсон.

Үүнээс гадна тус хэрэгцээ, шаардлагад үндэслэн хувилбар буюу зохицуулах аргуудад дүгнэлт хийн, тэдгээрээс хоёр хувилбарыг сонгож хооронд нь харьцуулсан. Нэгдүгээр хувилбарын хувьд “Монгол Улсад зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мөрдөх албыг хуулиар байгуулах” хоёрдугаар хувилбарыг “Монгол Улсад зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мөрдөх албыг захиргааны шийдвэрээр буюу захиргааны хэм хэмжээний акт болох дүрэм, журмаар байгуулах” гэж тодорхойлсон.

Улмаар тус хоёр хувилбарыг зорилгод хүрэх байдал, хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, зардал, үр өгөөжийн харьцаа, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх гэсэн шалгуур үзүүлэлтээр эерэг үр дүн болон сөрөг үр дагаврыг нэг бүрчлэн, нарийвчлан тодорхойлсон. Үүний үр дүнд зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлт, зардал, үр өгөөжийн харьцаа шалгуур үзүүлэлт,

хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх шалгуур үзүүлэлт, хүний эрхэд үзүүлэх үр нөлөө гэх шалгуур үзүүлэлтийн хувьд хувилбар 1 нь хувилбар 2-оос эерэг үр дүнг үзүүлж байгаа нь ажиглагдсан. Тухайлбал, хувилбар 1-ийг сонгосон тохиолдолд зохицуулалтын агуулга, шаардлага, нийгэмд үзүүлэх нөлөөний хувьд илүү байна. Харин бусад шалгуур үзүүлэлтийн хувьд ижил байх үзүүлэлт гарсан. Нийтлэг сөрөг үр дагаврын хувьд Монгол Улсад зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мөрдөх албыг өмнөх хэсгүүдэд дурдсан асуудал, түүний шалтгаан нөхцлийг арилгах байдлаар зохион байгуулж ажиллуулахгүй бол аль ч хувилбар нь сөрөг үр дагаврыг бий болгохоор байв.

Дүгнэж үзвэл хувилбар 1 буюу “Монгол Улсад зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мөрдөх албыг хуулиар байгуулах” хувилбарын тухайд Мөрдөх албаны тухай хуулийн хэрэгцээ, шаардлагад илүүтэй нийцтэй, шийдвэрлэх арга зам болж чадахаар байна.

Харьцуулсан судалгааны хувьд Швед, Япон, Финланд, Сингапур, Оросын Холбооны Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман улсын эрх зүйн зохицуулалтууд болон олон улсын гэрээний зохицуулалтыг тус тус судалсан. Швед, Япон, Финланд, Сингапур улсуудын мөрдөх албаны дотоод бүтцэд нийтлэг байдлаар дараах нэгжүүд багтдаг байна. Үүнд, зохион байгуулалттай, хүнд гэмт хэргийн төрөл бүхий нэгж, олон улсын болон дотоод хамтарсан ажиллагаа хариуцсан нэгж, тагнуулын ба шүүхийн шинжилгээний нэгж, лаборатори, кибер гэмт хэрэгтэй тэмцэх нэгж багтжээ. Хэдий холбооны улсууд ч гэсэн ОХУ болон Герман улсын мөрдөх албаны үйл ажиллагаа нь дээр дурдсан улсуудын мөрдөх албаныхтай төстэй байх бөгөөд нийтлэг байдлаар мансууруулах бодис, галт зэвсэг, хүний наймаа зэрэг үндэстэн дамнасан, хүнд гэмт хэргүүдийг мөрдөн шалгах чиг үүрэгтэй байна. Үүнээс дүгнэвэл, улс орнуудад зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мөрдөх алба эсвэл түүний нэгж байдаг нь тодорхой байна.

Эцэст нь, дээрх судалгаанаас дүгнэвэл Монгол Улсад зохион байгуулалттай, үндэстэн дамнасан шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий мөрдөх албыг бий болгох, тэр тусмаа хуулиар бий болгох хэрэгцээ, шаардлага байна. Мөн энэхүү хэрэгцээ, шаардлага нь гадаад, орнуудын эрх зүйн зохицуулалт болон олон улсын гэрээний зохицуулалтаар давхар дэмжигдэж байна.

НОМ ЗҮЙ

I. Монгол хэл дээрх эх сурвалж

Хууль тогтоомж:

1. Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/, 2015
2. Эрүүгийн хууль, 2002
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017
4. Эрүүгийн байцаан шийтгэх хууль, 2002
5. Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, УИХ-ын тогтоол, №12, 2021
6. Монгол Улсын Засгийн газрын тогтоол, №59, 2016.

II. Гадаад хэл дээрх эх сурвалж

1. United Nations Convention against Transnational Organized Crime, 2000.
2. Enhancing the effectiveness of central authorities in international cooperation in criminal matters to counter transnational organized crime, Resolution 8/1, The Conference of the Parties to the United Nations Convention against Transnational Organized Crime.
3. Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол, 2000.
4. Шилжин суурьшигчдыг газраар, далайгаар болон агаараар хууль бусаар оруулахын эсрэг” протокол, 2000.
5. Галт зэвсэг, бүрдэл хэсэг, эд анги, галт хэрэгслийг хууль бусаар тээвэрлэх, үйлдвэрлэхийн эсрэг протокол, 2001.
6. Signatories to the United Nations Convention against Transnational Crime and its Protocols.
7. Бүгд Найрамдах Финланд Улсын Гэмт хэрэг мөрдөх тухай хууль, 2011.
8. Бүгд Найрамдах Сингапур Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2012.
9. Бүгд Найрамдах Сингапур Улсын Терроризмын санхүүжилтийг таслан зогсоох тухай хууль, 2003.
10. Оросын Холбооны Улсын Холбооны аюулгүй байдлын албаны тухай хууль, 1995.
11. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хууль, 1949.
12. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Холбооны Эрүүгийн цагдаагийн газар ба Эрүүгийн хэргийн асуудлаар холбооны болон муж улсын эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагааны тухай хууль, 2017.
13. Эрүүгийн цагдаагийн албаны тухай хууль.
14. Шведийн Хаант улсын Цагдаагийн тухай хууль, 1984.
15. Шведийн Хаант улсын Аюулгүй байдлыг хамгаалах тухай хууль, 2018.
16. Япон Улсын Цагдаагийн тухай хууль.

Ном, өгүүлэл нийтлэл:

1. Үндэсний тагнуулын академийн доктор, дэд хурандаа Д.Тунгалаг, Мөнгө угаах гэмт хэрэг, түүнтэй тэмцэх зарим асуудал сэдэвт илтгэл.
2. Цагдаагийн байгууллагын улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл (2018, 2019, 2020, 2021).
3. ФАТФ (2012-2019), Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт.
4. ФАТФ-ын дахин үнэлгээний тайлан 2020.
5. Хууль зүйн үндэсний хүрээлэн, “Мөрдөх алба: гадаадын зарим орны туршлага” судалгааны тайлан, 2013.

Гадаад хэлээр

1. John M. Sellar OBE, A police officer's guide to UNTOC, 2018.
2. Depositary Notifications by the Secretary-General: Mongolia, Treaty Reference, XVIII-12.
3. UNODC Strategy 2021-2025.
4. Walter Kemp, Mark shaw, Police reform needed for local and transnational crime, 2020.
5. Finn, Peter In Russia, A Secretive Force Widens, 2007.

Цахим эх сурвалж

1. Соёмбо Легал Партнерс ХХН, Мөрдөх албаны тухай хуулийн төсөл боловсруулан, хүлээлгэж өгөв, <http://www.mongolianlawyer.mn/c/99>.
2. Монгол Улсын Ерөнхий прокурорын газар, Улсын ерөнхий прокурорын дэргэд мөрдөн байцаах албыг байгуулах хэрэгцээ, шаардлага, үндэслэл, 2017, <http://www.prokuror.mn/blog/ON/1164>.
3. Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт Монгол Улсын иргэд холбогдож буй нөхцөл байдал, шалтгаан, <https://www.customs.gov.mn/2012-03-14-03-21-37/2014-03-24-06-25-31/2015-02-04-06-28-11/526-2015-02-06-07-21-57>.
4. Гаалийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн 2019 онд зохион байгуулагдаж байна, <https://www.customs.gov.mn/news/daily/latest/1466-200019>.
5. Ж.Ганбаатар, Үндэстэн дамнасан хэрэг гардаггүй бол мөрдөх алба байгуулах шаардлагаргүй, 2013, <https://gogo.mn/r/mjwmo>.
6. <https://poliisi.fi/en/international-cooperation>
7. <https://poliisi.fi/en/etuvu>
8. <https://intermin.fi/en/police/agencies-and-responsibilities>
9. <https://poliisi.fi/en/national-bureau-of-investigation>
10. <https://www.coe.int/t/dg1/legalcooperation/economiccrime/organisedcrime/BestPractice5E.pdf>
11. <https://poliisi.fi/en/about-the-police>

12. https://www.bka.de/EN/OurTasks/AreasOfCrime/areasofcrime_node.html
13. https://www.bka.de/EN/OurTasks/AreasOfCrime/areasofcrime_node.html
14. https://www.bka.de/DE/DasBKA/OrganisationAufbau/Fachabteilungen/fachabteilungen_node.html
15. <https://www.bmi.bund.de/EN/topics/security/federal-criminal-police-office/federal-criminal-police-office-node.html>
16. https://www.bka.de/DE/UnsereAufgaben/Aufgabenbereiche/Ermittlungen/ermittlungen_node.html;jsessionid=7BB49369E7E1733F07661B0979CD817E.live302?fbclid=IwAR0bt3MEzCqOP4mMjcLmoDMNzzPwFk2HIJSrVcA-EeRYHM5TMZICQGETFc
17. https://www.bka.de/DE/DasBKA/OrganisationAufbau/organisationaufbau_node.html
18. <https://polisen.se/en/the-swedish-police/the-swedish-police-authority/>
19. <https://www.interpol.int/en/Who-we-are/Member-countries/Europe/SWEDEN>
20. <https://polisen.se/en/the-swedish-police/the-swedish-police-authority/>
21. <https://polis.osce.org/country-profiles/russian-federation#federal-security-service-10477>
22. https://www.dcaf.ch/sites/default/files/publications/documents/Japan%20Police_Eng_13-10-11.pdf
23. https://www.npa.go.jp/english/Police_of_Japan/2020/poj2020_full.pdf
24. <https://www.police.gov.sg/Who-We-Are/Organisation-Structure/Specialist-Staff-Departments>
25. <https://www.police.gov.sg/Who-We-Are/Organisation-Structure/Organisational-Chart>
26. <https://globalinitiative.net/analysis/police-reform/>
27. <https://globalinitiative.net/analysis/a-police-officers-guide-to-untoc/>
28. <https://www.unodc.org/e4j/en/organized-crime/module-8/key-issues/investigators-of-organized-crime.html>
29. <https://www.unodc.org/unodc/en/treaties/CTOC/signatures.html>